

Улсын бүртгэлийн дугаар: Нууцын зэрэглэл: Б
Аравтын бүрэн Төслийн гүйцэтгэх
ангилалын код: гэрээний дугаар: ШуСс_2017/38

Гүйцэтгэгч байгууллага: Нүүдлийн соёл иргэншлийг
судлах олон улсын хүрээлэн

Тайлангийн нэр: "Цаг уурын өөрчлөлтөд дасан зохицох
нүүдэлчдийн уламжлалт мэдлэг"

Ботийн дугаар: I боть (1)

Төслийн удирдагч агсан: Д.Пүрэвжав захирал, доктор (Ph.D)
...../гарын үсэг/
...../гарын үсэг зурсан огноо/

Төслийн гүйцэтгэгчид: М.Дорждагва, Н.Хатанбаатар, Г.Мандахбаяр
Судалгааны арга зүй: Нийгэм, Хүмүүнлэгийн ухаан

Гүйцэтгэгчийн хаяг: Улаанбаатар хот, СБДүүрэг, 8-р хороо,
СТӨргөө, 7-р давхар.Утас: 31-51-00,
88086854

Цахим шуудан: d_tenger@yahoo.com
Хот: Улаанбаатар
Тайлан бичсэн он: 2019 он

АГУУЛГА	Тал
ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ	10
СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ БА ДҮГНЭЛТ, САНАЛ, ЗӨВЛӨМЖ	17
УДИРТГАЛ	35
1. СҮРГИЙН БҮТЭЦ, МАЛЫН ТОО ТОЛГОЙГ БЭЛЧЭЭРИЙНХЭЭ ОНЦЛОГТ ТОХИРУУЛЖ ИРСЭН МЭДЛЭГ	
1.1 Сүргийн бүтэц, малын тоо толгой, бэлчээр судлалын тойм	44
1.2 Бэлчээрийн байдал: өнөө үе	53
1.2.1 Архангай аймгийн бэлчээрийн байдал	56
1.2.2 Дорнод аймгийн бэлчээрийн байдал	59
1.2.3 Сүхбаатар аймгийн бэлчээрийн байдал	61
1.2.4 Завхан аймгийн бэлчээрийн байдал	62
1.2.5 Говь-Алтай аймгийн бэлчээрийн байдал	63
1.2.6 Бэлчээрийн тухай нүүдэлчдийн уламжлалт ойлголт	65
1.3 Сүргийн бүтэц, тоо, толгой ба бэлчээр ашиглаж буй байдал (хээрийн судалгаа)	69
1.3.1 Архангай аймгийн Өгийнуур сумын Тоглох багийн малчин Н.Жагардамба	69
- Нутгийн бэлчээр, отор, улирлын нүүдлийн онцлог	
- Бэлчээрийн даац	
- Өвөлжилт	
- Бэлчээрийн зарим асуудал	
- Зуданд үрэгдсэн малын сэг зэмийн цэвэрлэгээ	
- Малчны залгамж, малын тоо	
- Бэлчээртэй холбоотой уламжлалт зан үйл	
1.3.2 Архангай аймгийн Өгийнуур сумын Тоглох багийн залуу малчин Д.Нэргүй	71
- Сүргийн бүтэц, малын тоо, толгой	
- Өвөлжилт ба улирлын бэлчээр	
1.3.3 Архангай аймгийн Өгийнуур сумын залуу малчин	

Д.Ганбаатар	72
-Бэлчээрийн онцлог, тулгамдаж буй асуудалд	
- Улирлын нүүдэл ба бэлчээр	
- Мал маллагааны арга	
- Малын түүхий эд, ашиг шим	
- Эцэг мал сонгох арга	
- Мал эмнэлгийн хүртээмж	
1.3.4 Архангай аймгийн Өлзийт сумын Байшир багийн малчин	
П.Анхболд	77
-Мал маллагаа, ашиг шим	
-Малын эрүүл мэнд	
1.3.5 Архангай аймгийн Батцэнгэл сумын Хөнөг багийн малчин	
Ц.Доржсүрэн	80
-Бэлчээрийн өвс усны тохируулга	
-Нүүдэл суудал ба бэлчээрийн даац	
-Залуу малчдад зөвлөх нь	
1.3.6 Архангай аймгийн Батцэнгэл сумын Хөнөг багийн малчин	
А.Батболд	83
-Бэлчээрийн даац ба отор нүүдэл	
-Хадлан тэжээлийн бэлтгэл	
-Малчдад тулгамдсан асуудал	
1.3.7 Архангай аймгийн Батцэнгэл сумын Дайрбор багийн малчин	
Г.Энхбаатар	86
-Бэлчээрийн онцлог, мал маллагаа, арчилгаа	
-Бог малын бэлчээрийн зохицуулалт, тоо толгой	
1.3.8 Архангай аймгийн Батцэнгэл сумын Дайрбор багийн малчин	
О.Гансүх	88
- Сүргийн бүтэц, тоо толгой, отор нүүдлийн байдал	
-Малчны залгамж	
- Залуу малчдын бэлэнчлэх үзэл	
1.3.9 Архангай аймгийн Батцэнгэл сумын Хөнөг багийн малчин	

И.Чингэлтэй	91
-Бэлчээрийн даац, экологийн зарим асуудал	
-Монгол малчин бэлтгэх асуудалд	
-Өвөлжөө, хаваржаа сэлгэлт	
-Бэлчээртэй дасан зохицох уламжлалт ёс	
1.3.10 Архангай аймгийн Өлзийт сумын Бодонт багийн малчин	
Д.Норовсүрэн	93
-Бэлчээр ба бэлтгэл ажил, сэлгэлт	
1.3.11 Архангай аймгийн Батцэнгэл сумын Хөнөг багийн малчин	
Л.Золжаргал	95
-Бэлчээрийн даац ба мал маллагаа	
-Сүргийн бүтэц, тоо толгой	
-Залуу малчдад тулгамдаж буй зарим асуудалд	
-Бэлчээрт засан зохицох уламжлалт зан үйл	
1.3.12 Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын малчин	
Д.Даваа, Д.Энхтуяа	98
-Бэлчээрийн өөрчлөлт	
- Үлийн цагаан огтоно намнах энгийн арга	
- Сүргийн бүтэц, малын тоо толгой ба амжиргаа	
1.3.13 Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын залуу малчин	
Б.Санчирынхан	100
-Бэлчээрийн байдал	
-Малын тоо, толгой	
-Залуу малчдад тулгамдсан асуудалд	
1.3.14 Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын 1-р багийн П.Батдорж	102
-Бэлчээрийн даац, тохиромж	
-Бэлчээр цөлжилт	
-Бэлчээр дэх хадлангийн асуудалд	
-Сүргийн бүтэц, алсын хараа	
-Монгол малчны залгамж	
-Малчны зөгнөл	

1.3.15 Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын малчин Ц.Оёо	106
- Бэлчээрийн даац, цөлжилт	
- Бэлчээр дэх сүргийн бүтэц, малын тоо толгойн тохиромж	
- Залуу малчин ба монгол малчны залгамжийн асуудал	
1.3.16 Завхан аймгийн Ургамал сумын 4-р багийн малчин М.Сүхгэрэл	108
- Нутгийн хуучны том малчид	
- Малчид ба малын тоо толгойн өөрчлөлт	
- Бэлчээрийн тохиромж	
- Өвлийн улирлын бэлчээр	
- Хаврын улирлын бэлчээр	
- Зуны улирлын бэлчээр	
- Намрын улирлын бэлчээр	
1.3.17 Говь-Алтай аймгийн Шарга сумын малчин З.Дамдиндорж	117
- Сүргийн бүтэц, тоо, толгой	
- Отор нүүдлийн асуудал	
- Тэмээн сүрэгт буур сонгох туршлага	
- Тэмээн сүргийн бэлчээр сонголт	
- Аргал түлээ бэлтгэх уламжлалт арга	
- Гаргалгаа	

2. БЭЛЧЭЭРИЙГ ХАМГААЛЖ, НӨХӨН СЭРГЭЭЖ ИРСЭН

УЛАМЖЛАЛ (түүх нийгмийн судалгаа)

2.1 Судалгааны тойм байдал	122
2.2 Ган ба зуд	146
2.2.1 Ган, зудын тухай ерөнхий ойлголт	146
2.2.2 Ган, зудын талаарх түүхчилсэн тэмдэглэл	149
2.2.3 Зудтай үед мал ямар шалтгаанаар хоргоддог вэ?	157
2.2.4 Цасан шуурга	160
2.2.5 Ган, зудын шалтгааны орчин үеийн ойлголт буюу уур амьсгалын өөрчлөлт	163

2.2.6 Ган, зуднаас урьдчилан хамгаалах, учирсан хохирлыг нөхөх нь	166
2.2.7 Бэлчээрийн түймэр	171
2.3 Үлийн цагаан огтоготой тэмцэх нь	173
2.4 Мал сүргийн усан хангамж	174
2.4.1 Уст цэг тогтоох, худаг гаргах монгол малчны уламжлалт арга ухаанаас	176
- Энгийн уурхайн (гар) худаг гаргах уламжлалт арга	
- Цас, мөс нөөцөлж мал усалдаг уламжлалт аргаас	
2.4.2 Булаг шандны эхийг өвөл ашигладаг арга	179
2.4.3 Газрын гүний усыг шинжиж олдог арга ухаанаас	180
2.5 Хадлан тэжээл	181
2.5.1 Хадлан бэлтгэх арга	183
2.5.2 Ургац нэмэгдүүлэх арга зам	184
3. ДӨРВӨН УЛИРЛЫН НҮҮДЭЛ БА ОТОР: УЛАМЖЛАЛ, ШИНЭЧЛЭЛ	
3.1 Малчдын нүүдэл ба отор	186
3.1.1 Нүүдэл нутагшил	190
-Бүсчилсэн отор, нүүдэл	
3.2 Мал сүрэг, ашиг шим	195
3.2.1 Мал сүргийн тоо	195
3.2.2 Малын төрөл, ашиг шим	199
- Адуун сүрэг	
- Үхэр сүрэг	
-Тэмээн сүрэг	
-Хонин сүрэг	
- Ямаан сүрэг	
3.3 Мал аж ахуйн үндсэн нэгж өрх гэр-хот айл	223
3.3.1 Хот айлын үүсэл	224
3.3.2 Хот айлын бүрдэл	225
3.3.3 Хот айл, нутагшил	225

4. МОНГОЛ МАЛЧИН: ОДОО БА ИРЭЭДҮЙ

4.1 Мал аж ахуйн одоогийн байдлын товч тойм	236
4.2 Мал аж ахуй ба зах зээл	238
4.3 Бэлчээр ба зах зээл	245
4.4 Хоршоо бол бэлчээрийн мал аж ахуйн оновчтой	
бүтэц, хэлбэр мөн	249
4.4.1 Хоршооны өнгөрсөн түүхээс хийх дүгнэлт, сургамж	250
4.4.2 Шинэ маягийн хоршоо	252
4.4.3 ӨМӨЗО-ны хоршооны туршлагаас	254
4.5 Фермерийн аж ахуй	255
4.6 XXI зууны монгол малчин	260
4.6.1 Шинэ зуунд манай орны мал аж ахуйн бүтэц	260
4.6.2 Малчны төрөл зүйл	260
4.6.3 Монгол малчны ирээдүйн тухай төсөөлөл	260
4.7 Мал аж ахуй ба орчин үе, шинжлэх ухааны дэвшил	263
4.7.1 Биотехнологи бол мал аж ахуйг эрчимжүүлэх, шийдвэрлэх арга мөн	265
4.7.2 Генийн инженерчлэл	266
4.7.3 Нанотехнологи	269
-Гаргалгаа	

5. НҮҮДЭЛЧДИЙН УРТЫН ДУУ ДАХЬ БАЙГАЛЬ АРГАДАХ

ЗАН ҮЙЛИЙН УЛАМЖЛАЛ (урлагийн зан үйл-аман сурвалж)

5.1 Зан үйлийн уртын дууны гарал, өнөөгийн үр өгөөж	272
5.2 Зан үйлийн уртын дууны төрөл, зүйлийн тойм	276
5.2.1 Төрийн дуу	276
5.2.2 Айзам дуу	277
5.2.3 Шасдир дуу	279
5.2.4 Гүр дуу	280
5.1.5 Цоор дуу	281
5.2.6 Цээр дуу	282

5.2.7 Дуурьлаг дуу	282
5.3 Зад шүтлэг ба уртын дуу	284
5.3.1 Задын дуу дуулж цаг агаартай дасан зохицох ёс	285
-Задын дуу "Иш гарьдын хур"	
-Задын дуу "Хүдрэн гарах үүл"	
5.3.2 Овоо тахилгын дуу дуулж цаг агаартай дасан зохицох ёс	291
-Хурын дуу "Өргөн үүл"	
-Лусын дуу "Уяхан замбуу тивийн нар"	
5.4 Тэнгэр шүтлэг ба уртын дуу	296
5.4.1 Салхины эзэнд дуу өргөж цаг агаартай дасан зохицох ёс	297
-Салхи аргаддаг "Хуур магнай"	
-Салхи догшируулдаг "Сэнсийн цагаан үүл"	
5.4.2 Уулын савдагт уртын дуу өргөж шинэ гэрийг даатгах ёс	301
-Савдагийн дуу "Зээ Баян Хөхий"	
5.4.3 Долоон борын дуу дуулж Тэнгэртэй дасан зохицох ёс	303
-Хийморын дуу "Өндөр сайхан бор"	
-Хүч цатгалан морины дуу "Хоёр бор"	
-Энэрэл хайрын дуу "Сэвхэт бор"	
5.4.4 Төрийн дууны овоо шүтэж Тэнгэртэй дасан зохицох ёс	306
-Хавт Хасарынхны төрийн дууны овоо	
5.5 Сүнс шүтлэг ба уртын дуу	308
5.5.1 Сүнс аргаддаг сангийн дуу	308
5.5.2 Хиймор, сүнс доройтоход дуулдаг дуу	310
5.6 Дөрвөн улирал ба уртын дуу	311
5.6.1 Дөрвөн улиралд зохицуулан уртын дуу дуулах ёс	311
5.6.2 Бэлчээрээ магтан аргадах дуу	312
5.6.3 Намрын төгсгөлд дуулдаггүй "Өвгөн шувуу хоёр"	313
5.6.4 Намар цагт найр эхлүүлдэг "Тэнгэрийн агаар"	313
5.7 Мал сүрэг, ан ав ба уртын дуу	315
5.7.1 Ботго авахуулахад дуулдаг "Өнчин цагаан ботго"	315
5.7.2 Бух догиоход дуулдаг "Нарийн саарал морь"	317

5.7.3 Анчны дуу "Илийн шар тохой"	319
5.7.4 Буга дууддаг "Урьхан хонгор салхи"	320

АШИГЛАСАН НОМ ХЭВЛЭЛ, ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ 321-332

ХАВСРАЛТ

Хавсралт-1: ШУССТөслийн үндсэн даалгавар

Хавсралт-2: ШУССТөслийн үр дүнгийн биелэлт

Хавсралт-3: Боловсруулж тараасан ЗӨВЛӨМЖ

Хавсралт-4: Зөвлөмжийн хариу хүсэлт

Хавсралт-5: Улсын төсвөөс санхүүжүүлэн хэрэгжүүлж 2017-2019 онд дуусгасан зардлын зарцуулалт

Хавсралт-6: Малчдаас сурвалжилсан дуу бичлэг-сангийн тоон дүн

Хавсралт-7: НСИСОУХ-ийн Эрдмийн Зөвлөлийн тайлан эцэслэх ТОГТООЛ

Хавсралт-8: ШУА-ийн бага чуулганы хурлын ТЭМДЭГЛЭЛ, ШИЙДВЭР

Хавсралт-9: Бага чуулганы итгэмжлэгдсэн шинжээчдийн САНАЛ, ДҮГНЭЛТ

ДАГАЛДУУЛАЛ – CD (дуу бичлэгийн сан)

ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт:

1-р хүснэгт	Дэлгэрэнгүй тайлан (ном)-гийн хураангуй мэдээ
2-р хүснэгт	Зөвлөмжийн хураангуй мэдээ
3-р хүснэгт	Аудио-дуу бичлэгийн сангийн хураангуй мэдээ
4-р хүснэгт	Малдын гарын авлагын хураангуй мэдээ
5-р хүснэгт	Бүсийн хэмжээнд тохиолдсон аюулт үзэгдэл, ослын тоон мэдээлэл (2015-2017 он)
6-р хүснэгт	Таван хошуу малын хоногт уух усны хэмжээ (литрээр)
7-р хүснэгт	1923 оны мал тооллогын үр дүн
8-р хүснэгт	Малчдаас сурвалжилсан дуу бичлэг-сангийн мэдээ

Зураг:

1-р зураг	Нүүдэлчид ба бэлчээр ашиглалт өнөөдөр(эмхэтгэл)
2-р зураг	Соёл хоорондын яриа хэлцэл: Төв Азийн нүүдэлчид ба бусад соёлын харилцан үйлчлэл, эмхэтгэл
3-р зураг	Монгол орны бэлчээрийн тогтвортой байдалд нөлөөлөх үндсэн хүчин зүйлүүд, (эмхэтгэл)
4-р зураг	Нүүдэлчин байдал, нэг сэдэвт зохиол
5-р зураг	Монголын нүүдэлчид ба нүүдлийн мал аж ахуй, зохиол
6-р зураг	Бэлчээр судлал 50 жилд, эмхэтгэл
7-р зураг	Монголын нүүдлийн соёл иргэншил, бэлчээрийн мал аж ахуй, зохиол
8-р зураг	Монголын бэлчээрийн мал маллагааны арга туршлага, зохиол

9-р зураг	Дэлхийн нүүдлийн мал аж ахуйн хөгжлийн асуудлууд, зохиол
10-р зураг	"Монголын бэлчээрийн мал аж ахуй" 20 боть цуврал зохиол
11-р зураг	2018 оны бэлчээрийн төлөв байдал
12-р зураг	2017-2018 оны өвөл, хаврын бэлчээрийн даац
13-р зураг	Архангай аймгийн бэлчээрийн даац, 2017 оны байдлаар
14-р зураг	Архангай аймгийн бэлчээрийн сэргэх чадавхийн ангилал
15-р зураг	Дорнод аймгийн бэлчээрийн байршил, бүтэц
16-р зураг	Сүхбаатар аймгийн 2018-2019 оны өвөл, хаврын бэлчээрийн даац
17-р зураг	Сүхбаатар аймгийн бэлчээрийн даацыг сумын нутгаар тооцоолж гаргасан дүн
18-р зураг	Завхан аймгийн 2017-2018 оны өвөл, хаврын бэлчээрийн даац
19-р зураг	Говь-Алтай аймгийн 2017-2018 оны өвөл хаврын бэлчээрийн даац
20-р зураг	Ойт хээрийн бэлчээр
21-р зураг	Хуурай хээрийн бэлчээр
22-р зураг	Цөлөрхөг хээрийн бэлчээр
23-р зураг	Архангай аймгийн Өгийнуур сумын малчин Н.Жагардамба, судлаач Г.Мандахбаяр
24-р зураг	Архангай аймгийн Өгийнуур сумын залуу малчин Д.Нэргүй
25-р зураг	Архангай аймгийн Өгийнуур сумын малчин Д.Ганбаатар
26-р зураг	Архангай аймгийн Өлзийт сумын малчин П.Анхболд
27-р зураг	Архангай аймгийн Батцэнгэл сумын Ц.Доржсүрэн, Д.Мэндбаяр
28-р зураг	Архангай аймгийн Батцэнгэл сумын залуу малчин А.Батболд

29-р зураг	Архангай аймгийн Батцэнгэл сумын малчин Г.Энхбаатар
30-р зураг	Архангай аймгийн Батцэнгэл сумын малчин О.Гансүх
31-р зураг	Архангай аймгийн Батцэнгэл сумын И.Чингэлтэй
32-р зураг	Архангай аймгийн Өлзийт сумын малчин Д.Норовсүрэн
33-р зураг	Архангай аймгийн Батцэнгэл сумын залуу малчин Л.Золжаргал
34-р зураг	Хангай нутгийн орчин цагийн үхэр тэрэг
35-р зураг	Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын ахмад малчин Д.Даваа, Д.Энхтуяа
36-р зураг	Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын залуу малчин Б.Санчирынхан
37-р зураг	Б.Санчирынхны өвсөн тэжээлийн нөөц
38-р зураг	Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын Улсын сайн малчин П. Батдорж
39-р зураг	Монголын барга нарын тэмээн тэрэг
40-р зураг	Монголын барга нарын малын аргал, хөрзөн түлш
41-р зураг	Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын ахмад малчин Ц.Оёо
42-р зураг	Завхан аймгийн Ургамал сумын дунд үеийн малчин М.Сүхгэрэл
43-р зураг	М.Сүхгэрэл сар шинийн золголт
44-р зураг	Завхан аймгийн Ургамал сумын зуны улирын бэлчээрийн байдал, орон зай
45-р зураг	Завхан аймгийн Ургамал сумын өвлийн улирлын малчны байдал
46-р зураг	Завхан аймгийн Ургамал сумын хаврын улирлын шөнийн зураг
47-р зураг	Завхан аймгийн Ургамал сумын 4-р багийн зуны улирлын бэлчээрийн орон зай

48-р зураг	Завхан аймгийн Ургамал сумын зуны улирлын завсрын бэлчээрийн байдал, орон зай
49-р зураг	Завхан аймгийн Ургамал сумын хаврын улирлын бэлчээр, орон зай
50-р зураг	Завхан аймгийн Ургамал сумын тэмээн сүрэг
51-р зураг	Завхан аймгийн Ургамал сумын хаврын үдэш, нар жаргаж буй байдал
52-р зураг	Говь-Алтай аймгийн ахмад малчин З.Дамдиндорж
53-р зураг	Говь-Алтай аймгийн ахмад малчин З.Дамдиндоржийн аргал боловсруулах уламжлалт технологийн байдал
54-р зураг	Говь-Алтай аймгийн ахмад малчин З.Дамдиндоржийн аргал боловсруулах уламжлалт технологийн байдал, хатаалт, хадгалалт
55-р зураг	Хот айл, 1967 он
56-р зураг	Төв халхын саальчдын байдал, 1965 он
57-р зураг	Говийн бүсийн хаваржаа, XX зууны дунд үе
58-р зураг	Говийн бүсийн өвөлжөө, XX зууны дунд үе
59-р зураг	Говийн бүсийн намаржаа, XX зууны дунд үе
60-р зураг	Хангайн бүсийн зуслан, XX зууны дунд үе
61-р зураг	Дорнодын тал нутаг дахь отор нүүдэл, XX зуун
62-р зураг	Чингис хааны хүндэтгэлийн өргөө дэх төрийн дууны шогол
63-р зураг	Айзам дууны үзэл онолтой холбогдох 13 цацаг бүхий хиригсүүр
64-р зураг	Долоон борын дууны үзэл онолтой холбогдох 7 цацагт хиригсүүр
65-р зураг	Айзам дууны үзэл онолтой холбогдох 13 овоо

66-р зураг	Гүр дууны яг-ег бичиг
67-р зураг	Задын дууны төлөөлөгч Увс аймгийн Түргэн сумын Т.Лхамжав
68-р зураг	Задын дууны төлөөлөгч Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын Ж.Дорждагва
69-р зураг	Хурын дууны төлөөлөгч Говь-Алтай аймгийн Төгрөг сумын Т.Цэвэл
70-р зураг	Хурын дууны төлөөлөгч Төв аймгийн Сэргэлэн сумын Ц.Чунаг
71-р зураг	Хурын дууны төлөөлөгч Дундговь аймгийн Дэрэн сумын Г.Дадьсүрэн
72-р зураг	Хурын дууны төлөөлөгч Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын Д.Пунцагдаржаа
73-р зураг	Салхины дууны төлөөлөгч Төв аймгийн адаацаг сумын Д.Адзана
74-р зураг	Савдагийн дууны төлөөлөгч Увс аймгийн Цагаанхайрхан сумын Г.Даваагомбо, О.Нямсүрэн, Ж.Жанчив
75-р зураг	Долоон борын дууны төлөөлөгч Хөвсгөл аймгийн цэцэрлэг сумын Д.Цэрэнпэлдэр
76-р зураг	Долоон борын дууны төлөөлөгч Завхан аймгийн Цагаанчулуут сумын Ж.Равданжамц
77-р зураг	Төрийн дууны овоо шүтлэгийн төлөөлөгч Дээд монголын уртын дуучин Говь
78-р зураг	Хавт Хасарынхны төрийн дууны овоо
79-р зураг	Сүнс аргаддаг дууны төлөөлөгч Ховд аймгийн Чандмань сумын Д.Даржаа
80-р зураг	Намар орой цагт дуулах цээртэй дууны төлөөлөгч Завхан аймгийн Эрдэнэ-Хайрхан сумын Ц.Бамбадорж
81-р зураг	Намар цагт найр эхлүүлдэг дууны төлөөлөгч Ховд аймгийн Мянгад сумын Д.Түвшин

82-р зураг	Ботго авахуулах зан үйлд дуулдаг дууны төлөөлөгч Дээд монголын Жинхуайр ээж
83-р зураг	Ботго авахуулах зан үйлд дуулдаг дууны төлөөлөгч Завхан аймгийн Ургамал сумын Д.Цэрэнхүү
84-р зураг	Бух догиодог дууны төлөөлөгч Ховд аймгийн Мөнххайрхан сумын С.Бүрнээ
85-р зураг	ШУССТөсөлт ажлын үндсэн даалгавар (хавсралтаар)
86-р зураг	Боловсруулж тараасан зөвлөмжийн албан тоот(хавсралтаар)
87-р зураг	Зөвлөмжийн албан тоот хавсралт (хавсралтаар)
88-р зураг	Зөвлөмжийн дагуу ирсэн хариухүсэлт (хавсралтаар)
89-р зураг	Улсын төсвөөс санхүүжүүлэн хэрэгжүүлж 2017-2019 онд дуусгасан зардлын зарцуулалт (хавсралтаар)
90-р зураг	Эрдмийн Зөвлөлийн тогтоол (хавсралтаар)
91-р зураг	ШУА-ийн бага чуулганы тэмдэглэл, шийдвэр (хавсралтаар)
92-р зураг	Бага чуулганы итгэмжлэгдсэн шинжээчдийн санал, дүгнэлт (хавсралтаар)

СУДАЛГАА ГҮЙЦЭТГЭГЧДИЙН ОВОГ НЭР, АЛБАН ТУШААЛ (БИЧСЭН ХЭРЭГ)

Гүррагчаагийн Мандахбаяр, Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэн, магистр (I бүлгийн 1.3.1-1.3.11, 1.3.17)

Доржжүгдэрийн Пүрэвжав, Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэн, доктор (Ph.D) (I бүлгийн 1.2-ийн 1.2.1-1.2.5)

Мягмарсүрэнгийн Дорждагва, Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэн, докторант (I бүлгийн 1.1, 1.2.6, 1.3.12-1.3.16, V бүлэг)

Нацагдоржийн Хатанбаатар, Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэнгийн гэрээт ажилтан, доктор (Ph.D), (Удиртгал, II, III, IV бүлэг)

Товчилсон нэр

НСИСОУХ	Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэн
ШУССТ	Шинжлэх ухааны суурь судалгааны төсөл
ШУТСан	Шинжлэх ухаан, технологийн сан
ӨМӨЗО	Өвөр монголын өөртөө засах орон
МАА	Мал аж ахуй

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ БА ДҮГНЭЛТ, САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Уг суурь судалгааны төслийг хүрээлэнгийн захирал асан Д.Пүрэвжав санаачлан эхлүүлээд удирдан зохион байгуулж байсан авч 2018 оны эхээр хорвоогийн мөнх бусыг үзүүлсэн. Бидэнд тооцоолоогүйгэнэтийн саад бэрхшээл тохиолдсон ч тухайн судалгааны ажлыг зогсоолгүй үргэлжлүүлж, эцэслэхийг зорин ажиллав.

Зорилго: Дэлхий даяар уур амьсгалын өөрчлөлт эрчимжин тогтворгүй болж хэт дулаарах, хүйтрэх зэргээр хэлбэлзэлтэй байна. Цаашид ч дулаарал явагдахыг ихэнх судалгаа харуулж байгаа төдийгүй бүс нутаг, улс оронд харилцан адилгүй байгаа ч сөрөг нөлөө нь адил байна. Уур амьсгалын өөрчлөлт далайд гарцгүй орнуудын хувьд цөлжилт, газрын доройтол нэмэгдэх, хур тунадас багасах, цас мөс хайлах зэргээр явагдаж байгаа бол арлын жижиг улсуудад далайн түвшин нэмэгдэн хуурай газрын хэмжээ багасч байгаа нь нийтлэг үзэгдэл болжээ.

Байгалийн энэхүү хувирамтгай дүр төрх нь хуурай сэрүүн уур амьсгалтай, эх газрын Монгол орны бэлчээрийн зүй тогтолд нөлөөлж, нүүдэлчдийн мал сүргийн бүтэц, тоо толгойд уламжлал түшиглэсэн шинэлэг зохицуулалт хийхийг шаардах боллоо. Зарим бүс нутгийн малчдын мал маллагааны арга туршлага уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр өөрчлөгдөж байгаа нь тэдний дунд хийсэн судалгаагаар мэдэгдэж байна. Тиймээс бид монгол нүүдэлчдийн байгаль, цаг агаартай дасан зохицох олон мянган жилийн туршлагыг түүхэн сурвалж болон өнөөгийн малчдын аман баримтаас судлан цуглуулж, мэдээллийн нэгдсэн сан хөмрөг бүрдүүлж, дүгнэх зорилготой.

Судалгааны арга: Нийгэм, Хүмүүнлэгийн ухаан: түүх, угсаатан, соёл иргэншил, урлагийн зан үйл судлал

Үр дүн, шинэлэг зүйл: Уг суурь судалгааны ажлын үр дүнд 25х.хэрдэм шинжилгээний дэлгэрэнгүй буюу эцсийн тайлан үүгээр бэлэн болж байна. Нэг үгээр хэлбэл, монгол нүүдэлчдийн цаг агаартай дасан зохицох уламжлалт мэдлэгийг бид чадах чинээгээрээ цуглуулан мэдээллийн цогц сан бүрдүүлэхийг хичээв. Нөгөөтэйгүүр, урьд өмнө системтэйгээр хэрэглээнд нэвтэрч амжаагүй цаг агаартай оюун санаа, сэтгэл зүйгээрээ дасан зохицоход чиглэгдсэн ахуй, байгалийн зан үйлийн 18-н уртын дууг илрүүлж, хэрэглээний дэг горимыг нь тодруулав.

Түлхүүр үг:

Сүргийн бүтэц, малын тоо-толгой, бэлчээр хамгаалах, нөхөн сэргээх, дөрвөн улирал, нүүдэл ба отор; монгол малчин, задын дуу.

Суурь судалгааны үр дүнгийн хураангуй мэдээ

ШУССТөслийн үр дүнг дараах байдлаар биелүүлэв. Үүнд:

НЭГДҮГЭЭРТ: ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН (номын эх хэрэглэгдэхүүн)

№	Сэдэвт ажлаар бий болох үр дүн	Тоо хэмжээ	Үр дүнгийн үзүүлэлт	СУДАЛГААГААР БИЙ БОЛСОН ҮР ДҮН
1	<p>“Цаг уурын өөрчлөлт ба нүүдэлчдийн арга ухаан” хамтын бүтээл туурвих. Ерөнхий бүтэц:</p> <p>1. Сүргийн бүтэц, малын тоо толгойг газар нутгийнхаа онцлогт тохируулж ирсэн нүүдэлчдийн уламжлалт мэдлэг</p> <p>2. Бэлчээрийг хамгаалж, нөхөн сэргээж ирсэн нүүдэлчдийн уламжлалт мэдлэг</p> <p>3. Дөрвөн улирлын нүүдэл ба отор: Уламжлалт, шинэчлэл</p> <p>4. Монгол малчин: Одоо ба ирээдүй</p>	<p>25х.х</p> <p>Нийт 300 ш.</p>	<p>Нүүдэлчдийн цаг уурын өөрчлөлттэй тэмцэж ирсэн уламжлалт аргуудыг судалснаар цаашид Ногоон хөгжлийн үндэслэлийг боловсруулна. Монгол малчны өмнө одоо тулгарч буй асуудлын талаарх нарийвчилсан судалгаа байна.</p>	<p>Үр дүнгийн нэгдүгээр даалгавараар өгөгдсөн судалгааны үндсэн 4 сэдэв чиглэлээр, хээрийн судалгаа, сурвалж судлалын ажил гүйцэтгэж тус бүрээр нь эрдэм шинжилгээний тайлан бичиж 2019 оны 12 дугаар сарын эхээр нэгтгэсэн. Нийт 25 х.х. Одоогоор хэвлэгдээгүй. Тайлан хэлбэрээр бичигдсэн (Энэхүү эцсийн тайлангийн эхний 4 бүлгээс үзнэ үү) Бүтэц: Нийт 5 бүлэг; 68 зүйл; 88 мөрийн гарчигтай; Гэрэл зураг: Нийт 83 ширхэг; Хүснэгт: 10 ширхэг; Ишлэл: нийт 88</p>

(1-р хүснэгт)

ХОЁРДУГААРТ: ЗӨВЛӨМЖ

№	Сэдэвт ажлаар бий болох үр дүн	Тоо хэмжээ	Үр дүнгийн үзүүлэлт	СУДАЛГААГААР БИЙ БОЛСОН ҮР ДҮН
1	Зөвлөмж /Экологийн соёлд суурилсан хөгжлийн бодлогыг тодорхойлоход чиглэгдэнэ/	1.5 х.х Нийт 100 ш.	3-аас доошгүй бодлогын яам, агентлаг, Ерөнхийлөгчийн тамгын газар, 21 аймагт хүргүүлж, санал авсан байх	Монгол улсын 21 аймаг, Монгол улсын Ерөнхийлөгчийн тамгын газар, Боловсрол Соёл Шинжлэх Ухаан Спортын Яам, Хүнс Хөдөө Аж Ахуйн Хөнгөн Үйлдвэрийн Яам, Уул Уурхай Хүнд Үйлдвэрийн Яамдуудад тус зөвлөмжийг 2018.10.28, 19/46 албан тоот бүхий хавсралтаар хүргүүлсэн.Зарим орон нутгаас хариу санал хүсэлт ирсэн.

(2-р хүснэгт)

ГУРАВДУГААРТ: АУДИО-ДУУ БИЧЛЭГИЙН САН

№	Сэдэвт ажлаар бий болох үр дүн	Тоо хэмжээ	Үр дүнгийн үзүүлэлт	СУДАЛГААГААР БИЙ БОЛСОН ҮР ДҮН
1	Орон нутагт тулгамдаж буй экологийн өөрчлөлтийн цогц мэдээллийн видео болон аудио бичлэгийн сан бүрдүүлэх	40 орчим цагийн бичлэгээр нэмж баяжуулан бүрэн мэдээллийн санг захиалагчид хүлээлгэн өгнө	Орон нутагт тулгамдаж буй экологийн өөрчлөлтийн цогц мэдээлэл байна. Үүнд: Дундговь, Говь-Алтай, Дорнод, Архангай аймгийн тус бүр 2 сумын экологийн өөрчлөлт /гол ус, бэлчээрийн ургамлын бүтцэд гарч буй өөрчлөлт, бэлчээр доройтолт, цөлжилтийн түвшин/-ийг	Нийт 5 аймгийн 7 сумын 25 малчинд хүрч сурвалжилсан. Нийт 19 ширхэг, 85цагийн, 162 MEGABIT дуу бичлэг (Audio) цуглуулж сан бүрдүүлсэн.

			малчидтай бүрдүүлнэ.	хамтран	
--	--	--	-------------------------	---------	--

(3-р хүснэгт)

ДӨРӨВДҮГЭЭРТ: МАЛЧДЫН ГАРЫН АВЛАГА

№	Сэдэвт ажлаар бий болох үр дүн	Тоо хэмжээ	Үр дүнгийн үзүүлэлт	СУДАЛГААГААР БИЙ БОЛСОН ҮР ДҮН
1	“Монголчуудын мал маллах ухаан: бэлчээрийн даац ба сүргийн бүтэц”-гарын авлага бэлтгэн хэвлүүлж, Дундговь, Говь-Алтай, Дорнод, Архангай аймгийн судалгаа хийсэн сумдын малчдад тараах ажлыг зохион байгуулах	3 х.х Нийт 200 ш.	Уг гарын авлага нь хашир туршлагатай малчид болон эрдэмтэн судлаачдын зөвлөгөөнөөс бүрдэх бөгөөд мэдээллийн сангаас авсан бэлчээрийг хамгаалах, нөхөн сэргээх, сүргийн бүтцийг зохицуулах аргачлал бүхий CD дагалдуулна	В5-ын хэмжээтэй, нийт 91 нүүр хуудас буюу 7,5 (1/12)^{хх} гарын авлага номын эхийг бэлтгэсэн. Агуулга нь: 1. Ган, зуд буюу уур амьсгалын өөрчлөлтийн тухай ойлголт 2. Нутаг нутгийн малчдын туршлагаас... 3. Судлаачдын гаргалгаа 4. Хавсралт-дээд монгол ба тува малчдын аж байдал г.м зүйлүүдээс бүрдсэн.

(4-р хүснэгт)

ТАВДУГААРТ: ЗАВСРЫН ТАЙЛАН

Төслийн үр дүнгийн үндсэн дөрвөн даалгавраас гадна 1 ширхэг завсрын тайлан 2018 онд бичсэн. Уг тайлан нь **“Нүүдэлчдийн уртын дуу дахь байгаль аргадах зан үйлийн уламжлал”** сэдэвтэй юм. Судлаач, уртын дуучин М.Дорждагвын бичсэн тус тайлан нь нүүдэлчин малчдын зан үйлийн уртын дууны өвийг түшиглэсэн. Нийт 50 орчим нүүр хуудастай энэхүү завсрын тайлангийн агуулгыг хураангуйлбал дараах байдалтай байна. Үүнд:

Монголчуудын зан үйлийн уртын дууны өв сан нь дөрвөлжин булш, буган чулууны соёл (НТӨ X зуунаас III зуун)-ын эзэд буюу өвөг монголчуудын бөө мөргөлийн зан үйл, үзэл онолд суурилсан аман уриа дуудлагаас улбааланбие даан хөгжиж урлаг болсон гэж үзэлтэй. Түүхийн урт хугацааны явцад буддын шашны зан үйл, үзэл онолоор сэлбэгдэн шинэ төрлүүдээр баяжсан байна. Бас өрнөдөхний тайзны урлагийн орчинд ч дэвшсэн байна. Тиймээс зан үйлийн уртын дуу нь өнөөгийн монгол туургатны хэмжээнд төрийн дуу, айзам дуу, шасдир дуу, гүр дуу, цоор дуу, цээр дуу, дуурилаг дуу гэсэн үндсэн 7 төрөл зүйлээс бүрдэж байна. Энэхүү төрлүүд дотор, "задын дуу", "лусын дуу", "хурын дуу", "салхины дуу", "савдгийн дуу", "долоон борын дуу", "хийморын дуу", "дөрвөн улирлын дуу", "ботго авахуулдаг дуу", "бух догиодог дуу", "анчны дуу", "бугын уриа дуу" г.м байгаль, цаг агаартай сэтгэл зүйгээр дасан зохицож аргадах ёсны уртын дуунууд өнөө хэр өвлөгджээ. Зан үйлийн уртын дууны эдгээр төрөл, зүйлүүд нь **монголчуудын байгаль хамгаалах уламжлалт оюун санааны нэгэн төрлийн хэрэглүүр, мөн цагаар агаар уур амьсгалын өөрчлөлттэй сэтгэл зүйгээр дасан зохицох өвөрмөц арга, хэлбэр байсаар XX зууны эхэн үетэй золгожээ**. Бас энэ нь байгаль орчны юмс үзэгдэлд дуу авиан физик долгионы давтамжаар нөлөөлдөг эртний аргын улбаа аж. Улмаар энэхүү хачирхалтай уламжлалт мэдлэг нь нийгэм цагийн аясаар зан үйл, урын сангаас бүдгэрэн гээгдэж XXI зуунд хагас хугасхан шиг, гэхдээ бодитой залгамжлагджээ. Тиймээс уг завсрын тайлан суурь судалгааны төслийн явц дахь нэгэн бодит үр дүн мөн гэж үзээд энэхүү эцсийн тайлан(эрдэм шинжилгээний дэлгэрэнгүй тайлан)-гийн V бүлэг болгож оруулав.

ЗУРГААДУГААРТ: ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЭЛ

Суурь судалгааны үр дүнгийн даалгаварт эрдэм шинжилгээний өгүүлэлийн тухай тусгагдаагүй ч судлаачид 2017 онд явцын үр дүнгээр 2 ширхэг өгүүлэл англи хэлээр бичиж хэвлэсэн. Тодруулбал, эхний өгүүллийг төслийн санаачлагч, удирдагч Д.Пүрэвжав хээрийн судалгааны үр дүнгээр **“Цаг уурын өөрчлөлтөд дасан зохицох уламжлалт мэдлэг: Төвийн бүсийн жишээн дээр”**, удаах өгүүлэлийг ажилтан М.Дорждагва **“Задын дуу ба бороо дуудах ёсон”** сэдвээр тус тус бичжээ. Эдгээр өгүүлэл нь суурь судалгааны явцын үр дүнд тооцогдох тул төслийн эцсийн тайланд ийндурдах нь зүйтэй гэж үзэв.

Өгүүлэлийнхэвлэгдсэн байршил: “NOMADICSTUDIES” сэтгүүл, VOLUME 17 | NUMBER 24 DECEMBER 2017. ISSN-2412-4222, **12 ба 81**-р тал.

ДҮГНЭЛТ

Суурь судалгааны төслийн эрдэм шинжилгээний үр дүнгүүдэд түшиглэх замаар дүгнэлт өгөх боломж бүрдэв. Үүнд:

1. Судалгаанаас үзэхэд, лавтай “Хүннү нарын нутагт их цас орж, нэг өдрийн хоёр алд илүү зузаан болоод хүн, мал их хөлдөж үхэв. Арван хувиас нэг хувь харин эс эгэв” хэмээн түүхэн сурвалжид тэмдэглэжээ. Мөн зарим судлаачид **НТӨ 72-71, 68** онуудад ихэнх нутгийг хамарсан их цас орж Хүннү гүрний хүн амын гуравны нэг нь мөхөж, мал их хорогдож байсныг, мөн **НТӨ 50, 49, 48, 47** онуудад 5 жил дараалан ган, зуд болсныг, түүний дотор **НТӨ 48** онд ган болж, царцаа их дэлгэрч, өвчин тахал гарсанаас хүннүчүүдийн 20 жилийн дайнд алагдсанаас их хүн үхсэн тухай тэмдэглэжээ. Харин XIII зуунаас хойших Монгол орны цаг агаарын гэнэтийн өөрчлөлтийн тухай цөөнгүй сурвалжид тэмдэглэн үлдээжээ. Үүнд:

- **1248 онд** улаан ган, асар их зуд болж, мөн хээрийн түймэр гарч, гол горхи ширгэснээс 10 үхэр, морины 8-9 нь үхсэн нь 1247 оны 5-р сард Санчирын нөлөөлөл, мөн 1 дүгээр сарын 1-нд Охин гаригт гаригсийн бөөгнөрөл болж, Санчир, Ангараг гаригууд тохиосонтой холбоотойг дурджээ;
- **1254 оны** өвөл Хархорум орчимд зуд болжээ.
- **1308, 1340** онуудад Монгол нутагт их цас орж мал олноороо үрэгджээ;
- **1308-1440** онд бүрэн бус мэдээгээр дөрвөн удаа хүчтэй зуд тохиолдсоныг тэмдэглэжээ;
- **1372 он** их шуурга, хүчтэй бороо оржээ;
- **1450 он** буюуцагаан морин жил хүйтэн салхины тухай тэмдэглэжээ;

Монгол орны Дорнод хэсгийн Түшээт хан, Сэцэнхан аймгийн 43 засаг хошуу, 28 харуул, Дарьгангын нутаг буюу Эрэнгийн голын сав, Хангайн нурууны Дорнод хэсэг, Гурван сайхнаас зүүн тийших нутагт буюу одоогийн Булган, Сэлэнгэ, Төв, Дундговь, Хэнтий, Дорноговь, Дорнод, Сүхбаатар аймаг бүхэлдээ, Өмнөговийн ихэнх хэсэг, Архангай, Өвөрхангайн нутаг, нийт 159 сумын нутгийг хамруулан 1740-1939 он буюу 200 жилийн ган, зудын байдлыг Монголын түүхийн баримт бичгээс түүвэрлэн авч ган,

зудын каталоги болонгазарзүйн давтагдлын график тооцоо хийх зэрэг ажлыг Р.Мижиддорж, А.Намхай, Д.Энхбат нар /1998/ хийсэн байна.

Дээрх судлаачдын судалгааны дүнгээс харахад Монголын зүүн талын аймаг, сумдын нутагт дээрх 200 жилийн 72-д нь ган, 110-д нь зуд болж аль нэг нутгийг хамарсан ган ойролцоогоор 3 жилд 1 удаа, зуд 2 жилд 1 удаа тохиолдон, **1820-1920** онд ган, зудын тоо нэмэгдсэн байдалтай, дээрх нутгийн 50 хувиас дээш хэсгийг хамарсан ган **1727, 1854, 1860, 1884, 1885, 1925** онуудад, зуд **1727, 1839, 1884, 1885, 1894, 1903** онуудад болсон байна. **1740-1940** оны хооронд тохиолдсон гангийн 15-20 хувь нь Өмнөговийн зүүн хагас, Дундговь аймгийн нутгаар, хамгийн цөөн нь Сэлэнгэ, Булган нутгаар (2-5 хувь), нийт 112 удаагийн зудын 15-20 хувь нь говь, хээрийн бүсийн зааг нутагт болсон байна.

1900-1911 оныг дуустал хур тунадасны хэмжээ, тохиолдлын тоог тодорхойлсон мэдээ тогтмол гаргаж, түүнийг саатуулсан гэм буруутанд хариуцлага хүлээлгэдэг болжээ.

Б.Жамбаажамцын тогтоосноор манай орны уулархаг хээрийн нутагт 15-20 см, хээрийн бүсэд 10-15 см, говьд 10 см зузаан цастай бол бог мал бэлчээх нөхцөлгүй болдог. Гэвч мал бэлчих боломжгүй болох, өөрөөр хэлбэл “цагаан зуд” болох цасны зузааны хэмжээ тухайн өвлийн өвс бэлчээрийн байдалтай уялдаж өөр, өөр байдаг. Тал газар цасны зузаан 30 см хүрвэл хонь, ямаа, 40 см хүрвэл тэмээ, 60 см хүрвэл адуу бэлчээрлэж чадахгүй болдог ба цас их хатуурсан цагт цасны зузаан бараг 2 дахин багасдаг ч мал бэлчээрлэх боломжгүй болдог.

Ардын хувьсгалаас хойш манай орны мал аж ахуйд асар их хохирол учруулсан томоохон зудаас дурдвал:

- **1922-1923** оны нохой-гахай жилийн,
- **1944-1945** оны мичин жилийн,
- **1954-1955** оны морин жилийн,
- **1956-1957** оны мичин жилийн,
- **1967-1968** оны хонь, мичин жилийг дамнасан,
- **1976-1977** оны луу, могой жилийг дамнасан,
- **1993** оны тахиа жилийн хаврын,
- **1996-1997** оны хулгана жилийн,

- **1999-2000** оны луу, морин жилийн,
 - **2001-2002** оны морь, хонь жилийн,
 - **2009 2010** оны үхэр, барс жилийн зудыг судлаачид онцлон тэмдэглэсээр иржээ. Хамгийн хүнд зарим нэг зудын хохирлыг тодруулбал ХХ зууны **1921-2010 онд 38 удаа** их, бага хэмжээний зуд болсны дотор хамарсан нутаг, орсон цасны хэмжээ, цасны нягтрал, хүйтний эрчээр хамгийн хүчтэй зуд нь: дээр дурдсан **1944-1945** оны луу жилийн зуд бөгөөд хамгийн хүнд нь **1976-1977** оны, дараа нь **1967-1968** оны зуд орно. Мөн **2000-2003** оны дараалсан, бас **2010** оны үхэр-барс жилийн зудыг нэрлэж болохоор байна.
2. Судалгаанаас үзэхэд, **ГАН** гэдэг нь хур тунадас хэвийн байдлаас багасаж, хэт халуун өдрүүд үргэлжилж, хөрсний чийг эрс багасч, өвс ургамал гандан хатаж, мал аж ахуй, газар тариаланд их хэмжээний бэрхшээл учруулах цаг агаарын нөхцөл гэж тодорхойлж болохоор байна.

Гангийн шалгуур нь байгаль, цаг уурын бүс бүрт ялгаатай төдийгүй хамрах хүрээ, үзүүлэх хор хөнөөлөөрөө ч өөр байдаг. Гантай жилүүдэд бэлчээрийн ургац 12-60 хувиар буурснаас болж мал сүрэг дулааны улиралд авбал зохих тарга хүчээ бүрэн авч чадаагүйгээс өвөл, хаврын улиралд, ялангуяа зуд тохиолдвол олноороо хорогдох шалтгаан болдог.

Ганг дотор нь:

- **Гандуу;**
- **Гантай;**
- **Улаан ган;** гэж ангилан нэрлэж ирсэн уламжлалтай байна.

3. Судалгааны үр дүнгээс үзэхэд, **ЗУД** гэдэг нь цас их орох, эрс хүйтрэх гэсэн хоёр үзэгдэл хүчтэй салхи, шуургатай хавсарсан цасгүй ч гэсэн тухайн нутгийн бэлчээрийн даац хэтэрч, бэлчээр их талхлагдсан зэргээс үүдэн идэх өвсгүй болж, мал сүрэг ихэнхдээ өлгүйдэж, осгох, хөлдөх зэргээр олноороо хорогдохыг хэлдэг.

Зудыг дотор нь:

- **Цагаан зуд;**
- **Харын зуд;**
- **Төмөр зуд** буюу **шилэн зуд;**
- **Туурайн зуд;**

- **Шуурган зуд”**
- **Хүйтний зуд;**
- **Залхуугийн зуд;**
- **Удирдлагын зуд;**г.м 8 янзаар нэрлэдэг уламжлалтай бөгөөд ерөнхийд нь:
- **Зудархуу;**
- **Зудтай;**
- **Асар их зудтай;**гэхээс гадна:
- **Зудын хүйс;**гэх уламжлалт нэршил ч хадгалагджээ.

Малын хорогдолд тухайн жилд тохиолдсон зудын хамрах нутаг дэвсгэрийн хэмжээ чухал аж. Жишээ нь, 1940-2000 онд Монгол орны нутаг дэвсгэрийн талаас дээш хувийг хамарсан зуд 10 удаа болсон бөгөөд 1970 оноос хойш ихээхэн нутаг дэвсгэрийг хамарсан зудын давтамж нэмэгдсэн байна. 1999-2000 оны өвөл 13 аймгийн 157 сумын нутаг буюу нийт нутгийн 70 хувийг хамарсан зуд болжээ. Нэг үгээр хэлбэл, Монгол нутагт ган, зудны давтамж хурдассаар байгааг судалгаа харуулж байна.

Ган, зудыг нөхцөлдүүлдэг экологийн сөрөг хүчин зүйлсийн дотор:

- **Зун, намар нь бороо хур орохгүй;**
- **Аагим халуун удаан үргэлжлэх;**
- **Өвөл, хавар зузаан цас орж, нягтарч хатуурах;**
- **Тэсгим хүйтэн удаан үргэлжлэх;**
- **Хүчтэй салхи, цасан болон шороон шуурга шуурах;**
- **Зарим үед хүйтэн болон аадар бороо орох;** зэрэг цаг агаарын бэрхшээлт үзэгдэлүүд гол байр эзэлсээр иржээ.Манай орны уламжлалт **ГАН, ЗУД** гэх уламжлал нь орчин цагийн ойлголтоор УУР АМЬСГАЛЫНӨӨРЧЛӨЛТ гэх нэр томъёотой дүйж байгаа тухай судлаачид тэмдэглэсэн байна. Бид ч түүнийг зарчимлан судалгаагаа гүйцэтгэв.

Энэ бүхнээс дүгнэхэд, монгол нүүдлийн соёл иргэншил үүсэн бүрэлдсэн цагаасаа хойш өнөө үе хүртэл газар зүйн нэг байршилд оршин тогтнож байна. Ингэж олон мянган жил байгалийн нэг бүслүүр, зүй тогтолд дасан зохицсон бэлчээрийн мал аж ахуйн нөхөн үржэхүй, дахин сэргэлт хурдтай явагддаг аж. Түүхийн турш ган, зуд хэдий хүнд бөгөөд ойрхон давтамжтай

тохиолдсон ч, дараа нь монгол мал сүргийн бүтэц, тоо, толгой хурдтай сэргэн өндийсөөр байжээ. Тиймээс монгол нутгийн ган, зуд буюу уур амьсгалын түүхэн өөрчлөлтүүд нэгдүгээрт: монгол нүүдлийн сонгодог соёл иргэншил бүрэлдэн тогтоход ямар нэгэн давшгүй саад тотгор учруулаагүй; хоёрдугаарт: сонгодог нүүдлийн соёл иргэншил түүхийн явцад тасалдан мөхөх шалтгаан болоогүй; гуравдугаарт: малчны туршлага, эрдэм мэдлэг улам зузаарч, монгол малын байгалийн саадыг даван туулах чанар нэмэгдсээр өдий хүрсний үндсэн шалтгаан нь ган, зудны дараах дахин сэргэлт гэж дүгнэж байна. Тиймээс “зудтай өвлийн зун нь зулаг болдог” гэх аман хэлц нэн эртнээс нааш малчдын оноч үг, урам зориг байсаар иржээ.

4. Дэлхийн уур амьсгалын өөрчлөлт, дулаарлын улмаас үүсэж буй үр дагавар нь хүн төрөлхтөнд тун хүндээр тусч байна. Үүнд:

- Байгалийн аюулт үзэгдлүүдийн давтамж ойртож, далайн хар салхи, ган, зуд, үер, тахал хэлбэрийн төрөл бүрийн халдварт өвчин байнга шахам тохиолдох боллоо. Монгол улсад ч ялгаагүй үзэгдээгүй их халуун жил дараалан олонтоо давтагдах болов.
- Далайн усны түвшин өнгөрсөн зуунд 15 см-ээр нэмэгдсэн бол XXI зуунд 50 см-т хүрэх төлөвтэй гэж үзэцгээж байна. Өндөр уулын мөнх цас, мөс, хойд, өмнөд туйлын хайлалт зэргээс болж далайн түвшин магадгүй метрт хүрч нэмэгдэж болох аж. Зарим газар үер, бороо, нөгөөд нь ган гачиг тохиолдож, үүнээс болж хүнсний хомсдол бодитойгоор нүүрлэж буй нутаг, газар орон цөөнгүй байгаа билээ.

Монгол орны хувьд 1940-2015 оны хооронд жилийн дундаж агаарын температур +2,0°С дулаарсан байна. Энэ нь дэлхийн дулаарлын дунджаас гурав дахин их гэсэн үг. Алтайн уулын дагуух нутаг, Алтайн чанад говь, Дарьгангын өндөрлөгөөс бусад бүх нутагт зуны хур тунадасны хэмжээ буурч, өвлийн тунадас бараг бүх нутгаар нэмэгджээ.

Дулаарлын нөлөөгөөр Алтай, Хөвсгөлийн уул, нуруунуудын мөнх цэвдэг, мөсөн голууд ширгэх үзэгдэл эрчимтэй явагдаж байна. Мөнх цэвдэг нь Монгол орны усны эргэлтийг зохицуулагч гол хүчин зүйл бөгөөд ой тайгын эко системийн оршин байх

нөхцөлийг бүрдүүлдэг. Хархираа, Түргэн, Цамбагарав, Таванбогд уулын мөстөлтийн талбай 30 хувиар багасчээ.

Манай оронд хаврын улирлын хур тунадасны хэмжээ 20 хувиар багасаж, цасан бүрхүүлийн эзлэх талбай болон тогтох хугацаа нь богиносож, малд идэмжтэй хиаг, хялгана, монгол өвс бүхий ургамлын зүйлийн тоо цөөрч, ургацын хэмжээ буурчээ. Ургамал ургаж эхлэх хугацаа 1-2 сараар хойшилсон нь мал ногоонд цадах, улмаар тарга хүч авахад сөргөөр нөлөөлж байна.

Мөн ойн талбай ихээхэн багасаж, олон зуун нуур цөөрөм, булаг шанд ширгэжээ. Энэ байдал ирэх 100 жилд хадгалагдана, дулааралт нэмэгдэнэ, өвлийн тунадас ихэснэ гэж эрдэмтэд үзэж байна.

Бас ган, зуд болон нийтийг хамарсан өвчин тахал дэлгэрэх явдлыг нарны идэвхжлийн жилтэй холбон тайлбарладаг. Наран дээр тэсрэлт болж, хий гарч, толбоны тоо олшрох үзэгдэл ойролцоогоор 11-12 жил тутамд давтагдаж, дээд цэгтээ хүрээд уг үзэгдэл буурсаар дараагийн тэсрэлтэд хүрдэг байна. Үүнийг “Нарны идэвхжлийн цуврал” гэх ба энэ нь нарны аймгийн бүх гаригт нөлөөлдөг тухай Т.Намжил дурджээ.

5. Ган, зуднаас хамгаалах гэдэг нь:

- а) Ган, зуднаас сэргийлэн хамгаалах;
- б) Ган, зуд нэгэнт тохиолдсон үед тэдгээртэй тэмцэж ажиллах;
- в) Учирсан хохирлыг нөхөх арга зам; гэсэн үндсэн 3 хэсэг арга хэмжээ авахыг шаарддаг байна.

6. МАА-н үйлдвэрлэлийг шинжлэх ухааны үндэслэлтэй, мэдлэгт суурилсан хөгжлийг чиг баримжаатай эрхэлж, инновацийг нэвтрүүлж, бүтээмжийг нэмэгдүүлэх замаар:

- Үхэр, хонины аж ахуйг махны чиглэлээр эрчимтэй хөгжүүлж, махны экспортын нөөцийг нэмэгдүүлэх,
- МАА эрхлэх уламжлалт хэв маяг, мэдлэгийг хадгалах, баяжуулах,
- Малын тоо, төрөл, сүргийн бүтцийн зохист харьцааг баримтлах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, эрсдэл даах чадавхыг бэхжүүлэх,
- Бүс нутгийн онцлогт тохирсон шинэ үүлдэр, омгийг бий болгож генийн санг хамгаалах, нөхөн үржүүлгийг сайжруулахад биотехнологийн ололтыг ашиглах зэрэгт хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Ерөнхийд нь авч үзвэл, XXI зууномонгол малчид уламжлалт өв соёлыг хадгалсан, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон бэлчээрийн мал аж ахуйгаа эрхэлнэ. Харин хот суурин орчимд болон газар тариалангийн бүс нутагт ашиг шимийн чиглэлээр төрөлжин эрчимжсэн МАА-г хөгжүүлэхээр төр засгийн холбогдох баримт бичгүүдэд тодорхойлсон байна. Мөн мал аж ахуй эрхлэгчид орчин үеийн шинжлэх ухааны ололтыг түлхүү ашиглах шинжтэй байна. Энэ үзэгдэл цаг агаарын өөрчлөлттэй дасан зохицох уламжлалт мэдлэгийн зарим хэсгийг нэг мөсөн өөрчлөх нь дамжиггүй байна.

7. Малын тоо, толгой хэт олшорсоны улмаас бэлчээр цөлжиж, үлийн цагаан огтоно элбэгшсэн. Ялангуяа, Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын нутагт үлийн цагаан огтоно элбэг үзэгдэх болсон нь малчдын санааг зовоож байна. Үлийн цагаан огтоны явдаг жимийн дагууд элдэв хуванцар сав суулга булж агнах нь гарын дор өгөөжтэй арга байх магадлалтайг туршиж үзсэн хашир малчид сануулж байна. Тэр булсан сав руу үлийн цагаан огтоно дээр дээрээсээ орж олноороо устаж байгааг туршиж үзсэн малчид ч байна. Энгийн атлаа өгөөштэй энэ аргыг дэлгэрүүлвэл зохино.
8. Зүүн бүсийн нутагт адуун сүрэг хэт элбэгшиж өвлийн улирлын бэлчээр талхлагдаж байгаа байдал ажиглагдав. Үүнийг малчид “Хотын баян дарга нарын адуун сүрэг” гэж нэрлэж байна. Ингэж адууны соёл хэт давамгайлснаар залуу малчид адуу маллах, уяхаас өөр мал маллах уламжлалт эрдэмдээ сонирхолгүй байгааг ахмад малчид шүүмжилж байна. Нөгөөтэйгүүр, орчин үеийн малчид мал сүргээ зөвхөн мөнгө олох хэрэгсэл гэж харж байгаа тул бэлчээрээ хамгаалан тордох, монгол малчны уламжлалт мэдлэг, ёс суртахуун, залгамж чанар алдагдаж байгааг ч хэлэх аж. Тиймээс монгол малчны залгамж чанар чиглэсэн тусгай хөтөлбөр хэрэгтэй байна.
9. Хэт бага насны хүүхдийг сургуульд суулгах нь тухайн айл гэр бүл салж сарних, нөхөр нь өвөл цагт ганцаараа мал маллаж, улмаар архи дарсанд орох, элдэв хэрэг төвөгт орооцолдох үндсэн шалтгаан болж байгааг ахмад малчид шүүмжилж байна. Ерөнхий боловсролын сургалтын системийг Монгол орон, монгол хүний амьдралд тохирсон хувирбараар зохион байгуулж болох эсэх тухай малчид асууж байна. Үүнийг бас үл тоон орхиж болохгүй бодитоор бий болсон асуудал мөн.

10. Отор нүүдэл ихсэж, өөр аймаг орон нутгаас олон тооны сүрэг мал ирж байгаа нь зарим талаараа сөрөг нөлөө үзүүлж байна. Жишээ нь уугуул, ирүүл малчдын бэлчээрийн хүрц, хуваарьлалтаас болж хүн аминий хэрэг ч гарсан тохиолдол байна. Малчид үүнийг нэгдүгээрт: хөдөө орон нутгийн бэлчээрт эрх зүйн зохицуулалт сул байгаатай, хоёрдугаарт: малын тоо, толгой хэт ихссэнтэй, гуравдугаарт: улс орны хэмжээнд байгальтай зүй бусаар харьцсантай, дөрөвдүгээрт: монгол хүний хүнлэг энэрэнгүй ёс суртахуун орчин цагийн үүсмэл, олдмол соёлын шууд нөлөөгөөр эвдэрсэнтэй холбон тайлбарлаж байна.
11. Нүүдэлчин монголчуудын байгал, цаг агаар-уур амьсгалтай дасан зохицох уламжлал нь төрт ёс, засаглал, мал аж ахуйн өдөр тутмын өргөн хүрээний арга ажиллагаа, мэдлэг чадварт хадгалагдаж байна. Үүнээс гадна ахуй хийгээд байгалийн зан үйл, ардын урлагийн өв, түүний дэг горим дотор оюун санаа, сэтгэл зүйнх нь дасан зохицлын өргөн мэдлэг сүндэрлэж байгаа нь судалгаагаар мэдэгдэв. Жишээ нь, монгол туургатны хэмжээний уртын дууны өвөөс үүнийг бодитоор мэдэх боломж энэ удаагийн судалгааны явцад бүрдэв. Нүүдэлчин малчдын энэ далд ухамсрын шинжтэй эко уламжлал нь байгаль дэлхий, цаг агаар-уур амьсгалын гэнэтийн өөрчлөлт, орчин нөхцөлд дасамтгай монгол хүний дотоод шинж чанарынх нь нэг хэсгийг бүрдүүлдэг онцлогтой шиг санагдана. Нөгөө талаас, зан үйл, язгуур урлагийн төрлүүдээр дамжуулж дөрвөн улирлын бэлчээрээ хамгаалан аргаддаг энэ хэлбэр лавтай ХХ зууны эхэн үе хүртэл олон мянган жил тасралтгүй оршин тогтножээ гэж үзэх боломжтой аж.

САНАЛ

Зарим нутгийн томоохон малчид нэгэн зөгнөлийн тухай ярьж байна. Тэр зөгнөл төсөөлөл нь мухар сүсэг бус малчдын нийгмийн амьдралд тохиолдсон үйл явдалтай холбоотой тул бодит үндэс байна гэж үзүүштэй санагдана. Тодруулбал, мал сүрэг, түүний тоо, толгой, бэлчээр ашиглалт, сэргээлт, хамгаалалт болон малчны амьдралд сүүлийн 100 гаруй жилийн дотор хувиралт багагүй явагджээ. Тэр хувиралт бэлчээрийн мал аж ахуйн эрх зүйн орчин хийгээд зохион байгуулалт нь чангарах, сулрах г.м давтамжаас шалтгаалдаг юм байна. Нэг үгээр хэлбэл, ХХI зууны эхэн буюу өнөө цаг бол мал аж ахуйн эрх зүйн орчин, зохион байгуулалт сул үе дээрээ таарч буй аж. Одоогийн байдлаар энэ сулавтар цаг үе дээд цэгтээ тулах шинжтэй

байгааг хашир малчид хэлж байна. Харин XXI зууны дунд үе гэхэд XX зууны дунд үеийн зохион байгуулалттай төслөг загвар руу бэлчээрийн мал аж ахуйн тогтолцоо шилжих байх гэж малчид зөгнөн төсөөлж байна. Энэ давтамж нь монгол нүүдэлчдийн бэлчээрийн мал аж ахуйн нас уртсаж оршин тогтноход чухал нөлөөтэй байж болно гэж малчид үзэж байна. Бидний судалгааны үр дүн ч энэ санал, төсөөлөлтэй хол зөрөхгүй байна. Тиймээс дараах хэдэн саналыг бид малчидтайгаа хамтран дэвшүүлж байна. Үүнд:

Нэгдүгээрт: Сүргийн бүтэц, малын тоо, толгой, бэлчээр ашиглалт, хамгаалалтын эрх зүйн орчин, зохицуулалтыг чангатгах замаар нүүдлийн соёл иргэншлээ авран хамгаалах цаг болжээ. Мал аж ахуйн амьдралын орчин нөхцөлд эмх замбараагүй байдал хэт газар авч дээд цэгтээ хүрсэн гэж үзэж болно. Энэ тухай бидний дэлгэрэнгүй тайлангийн агуулгад багагүй тусгагдсан. Жишээ нь, зүүн бүс нутаг чинээлэг баян улс төрчдийн хурдан морины наймааны цөм сүргүүдийн орон зай болон хувирсан байна. Тиймээс уг нутагт энгийн монгол малчин таван хошуу малаа адгуулан амар тайван амьдрах орон зай удахгүй үгүй болж мэдэхээр байна. Хэдэн адуучин залуучуудаас өөр малчингүй боллоо гэж ахмад малчид халаглаж байна. Улмаар “малчин өрх айл” гэж үгүй болоод, “малчин хүн” гэсэн сүбъект давамгайлах тухай ч хэлэлцэж байна. Энэ бодит байдал ялангуяа ахмад малчдын санааг маш ихээр зовоож, сэтгэл зүйн дарамт учруулан, өвчлөх, эрт насан эцэслэх нэг шалтгаан болж байж болзошгүйг дурдалгүй өнгөрч боломгүй санагдана. Ерөнхийдөө бэлчээрийн мал аж ахуйн тогтолцоонд тулгарч буй эмх замбараагүй байдал монгол малчны амьдралын сөрөг талын гол үндэс болж байна. Үүнийг цаг алдалгүй засаж залруулах учиртай биз ээ.

Хоёрдугаарт: Нүүдэлчин малчдын амьдралд нөлөөлж байгаа сөрөг хүчин зүйлсийн бас нэг нь хөдөөд хүрч буй ерөнхий боловсролын сургалтын систем аж. Малчдын зүгээс ерөөсөө ойлгохгүй, тэдний амьдрал, хүсэл тэмүүлэлд тохирохгүй байгаа зүйлийн нэг нь энэ гэж хэлж болохоор байна. Тиймээс ахмад малчид орчин үеийн техник, технологийн дэвшил, цаг хугацааг хураангуйлсан хурдыг сургалтанд түлхүү ашилаж болох эсэхийг асууж лавласаар байна. Нэг үгээр хэлбэл, уламжлалт монгол нүүдэлчин малчны хүүхэд богино хугацаанд ерөнхий суурь боловсролыг эзэмших арга бий юу гэж асуугаад, одоогийн энэ байдлаар дахиад 2-оос 3 үе явбал бидний

залгамж чанар нэг мөсөн тасрана гэж үзэж байна. Энэ асуудлын цаана монгол үндэстний соёл хийгээд тусгаар тогтнолын аюулгүй байдал байгааг ч сануулж байна. Бидний бодоход, энэ асуудал, санал нь монгол малчны залгамж чанарт цаг алдалгүй тууштай, тогтвортой арга хэмжээ авах шаардлага тулгарсаныг илтгэж байх шиг. Тодруулбал, ирээдүйд “малчин өрх айл” байх юм уу, эсвэл “малчин хүн” л гэж байх юм уу гэсэн сонголт аж. Нөгөөтэйгүүр, манай улсын боловсролын системийг уян хатан, төрөлжсөн байх ёстойг малчид өөрсдийн бодит амьралаар туршилт хийн байж харуулж байх шиг. Жишээ нь, суурин амьдралтай иргэдийн хүүхдийн боловсрол, нүүдэлчин амьдралтай иргэдийн хүүхдийн боловсрол хоёр нэг тогтолцоо байх боловч амьдралын хэв маяг, ирээдүйд нь тохирсон зааг ялгаатай байхыг малчид минь үүгээр дамжуулан санал болгож буй юм байна.

ЗӨВЛӨМЖ

Монголын нүүдэлчдийн биет бус соёлын өвийн нэгэн томоохон хэсэг нь оюун санаа, сэтгэл зүйгээр байгаль цаг агаартай дасан зохицох уламжлалт мэдлэг юм. Уг мэдлэг нь мухар сүсэг төдий бус монголчуудын олон мянган жил туулсан амьдралын туршлага, шашин соёлын үзэл онолд суурилжээ. Тиймээс энэ төрлийн уламжлалт мэдлэг нь монгол үндэстний олон угсаатны бүлэг тус бүрийн зан үйл, бэлгэдэл, цээрийн ёс, урлагийн өргөн агуулгаар дамжин илэрсээр ирсэн байна. Монголын нүүдэлчдийн энэхүү уламжлалт мэдлэг орчин үед залгамж чанараа алдан бүдгэрч байгаа нь судалгаагаар мэдэгдэв. Үүнийг үндэстний соёлын аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны хүрээнд ард нийтэд сурталчлан таниулах, байгаль экологийн салбарын гадаад, дотоодын хамтарсан ажилд зарчимлан баримтлах, энэ чиглэлийн хууль, дүрэм журамд тодорхой тусгах замаар баталгаажуулах хэрэгцээ байна. Үүнд:

- 1.** Уул хайрхан, гол мөрөн, малын бэлчээр зэрэг байгалийн заяагдмал бүрэн бүтэн тогтоцтой олдмол хэлбэрээр харьцахдаа үндэстний уламжлалт соёлын ёс суртахууныг гол зарчмаа болгох цаг болсныг төрийн дээд түвшинд хүлээн зөвшөөрч албан ёсоор тунхаглах;
- 2.** Монгол хүн болон төлөвшиж буй өсвөр насныханд гэрийн хүмүүжил болон боловсролын системээр дамжуулан цаг уурын өөрчлөлт, байгалийн гэнэтийн үзэгдэлд дасан зохицох уламжлалт соёлын ёс суртахууныг эзэмшүүлэх;

3. Аймаг, сумдын нутагт амьдарч буй ард иргэдээс биет бус соёлын уламжлалт ёс суртахууны өвлөн залгамжлагчдыг тодруулан урамшуулж, тэднийг орон нутгийн ардын мэргэжилтнээр өргөмжлөн баталгаажуулж сургалт, семинарын багшаар ажиллуулах;
4. Ерөнхий арга зүйн сургалт, семинар зохион байгуулж, хамтран ажиллахад бэлэн байна.

Судалгааны сэдэв, үндсэн нэр томъёоны хураангуй тайлбар

Цаг агаарын өөрчлөлтөд дасан зохицох уламжлалт мэдлэг гэж юу вэ? Монголын нутаг дэвсгэрт 300-500 мянган жилийнтэртээ хүмүүс амьдарч байсан хэмээн ном бүтээлд тэмдэглэсэн байна. Харин сүүлийн үеийн зарим олдвор баримтыг үндэслэн уг хугацаа улам цаашилж, 700-850 мянган жил болж сунгагдах магадлалтай байж болзошгүй гэсэн таамаг хандлага гарах төлөвтэй байна. Хэрэв ингэж үзвэл, Монгол нутгийн байгаль, цаг агаарын өөрчлөлтөд дасан зохицох нүүдэлчдийн уламжлалт мэдлэг лавтай 800 мянга гаруй жилийн настай гэж тооцогдоно. Тиймээс цаг агаартай дасан зохицох уламжлалт мэдлэг нь монголчуудын сонгодог нүүдлийн соёл, иргэншлийг бүтээх үндсэн шалтгаан, нөхцөл болсон гэж үзэж болно. Энэхүү уламжлалт мэдлэг, монгол мал аж ахуйн бүтэц, төрөл зүйл, удирдлага-мал маллагаа, ашиг шим, эдийн засаг, залгамж чанарт шууд нөлөөлсөөр ирсэн тул нэлээд өргөн хүрээний нэр томъёо, ухагдахуунгэж ойлгож судалгаа гүйцэтгэв.

Сүргийн бүтэц, малын тоо, толгой гэж Нэн эртнээс монгол нутагт зэрлэг амьтныг гаршуулж, аажмаар өнөөгийн монгол мал сүргийн бүтэц, төрөл зүйл бүрэлджээ. Улмаар байгаль, газар зүй, уур амьсгалын нэг

юу вэ?

орчин, аж ахуйн нэг нөхцөлд олон мянган жилийн турш тасралтгүй амьдарсан нүүдэлчдийн цаг агаартай дасан зохицох үйл явц нарийсан нарийссаар сүргийн бүтэц, малын тоо, толгойн нутаг нутагт өөр өөрийн онцлогтой болж уламжлагджээ. Орчин цагийн монгол малчид 1000-аас дотогш толгой малтай байхад бэлчээрийн даац болон өрхийн амжиргаанд элбэг хүрэлцээтэй гэж үзэж байна. Харин залуу малчид малын тоо толгойг 2000, 3000 мянгад хүргэж өсгөөд, эд хөрөнгө, хуримтлалыг бий болгож байгаа байдал ажиглагдаж байна. Тэдэнтэй уулзаж ярилцахад ингэж малын тоо толгойгоо өсгөж өрхийн эдийн засгийн хуримтлал үүсгээд, улмаар малын тоо толгойг багасган 500-аас 1000 орчим хүртэл бууруулах зорилготой гэнэ. Малын тоо толгойг ихэсгэж хөрөнгө чинээгээ хуримтлуулаад, буцаан зохист хэмжээнд хүргэж багасгадаг энэ үзэгдэл нийт малчдын дунд түгээмэл арга болон тогтжээ гэж үзэж болохоор байна.

**Бэлчээрийг хамгаалж,
нөхөн сэргээж ирсэн
уламжлалт мэдлэг гэж
юу вэ?**

Түүх, сурвалжаас үзэхэд, Хүннү нарын нутагт их цас орж, нэг өдрийн хоёр алд илүү зузаан болоод хүн, мал их хөлдөж үхэв. Арван хувиас нэг хувь харин эс эгэв” гэж, Юань улсын сударт 1248 онд улаан ган, асар их зуд болж, мөн хээрийн түймэр гарч, гол горхи ширгэснээс 10 үхэр, морины 8-9 нь үхсэн нь 1247 оны 5-р сард Санчирын нөлөөлөл, мөн 1 дүгээр сарын 1-нд Охин гаригт гаригсийн бөөгнөрөл болж, Санчир, Ангараг гаригууд тохиосонтой холбоотойг дурджээ. Мөн 1254 оны өвөл Хар Хорум орчимд зуд болж 1308, 1340 онуудад Монгол нутагт их цас орж мал олноороо үхсэн тухай, 1308-1440 онд бүрэн бус мэдээгээр дөрвөн удаа хүчтэй

зуд тохиолдсоныг тэмдэглэжээ. Ингэж нутаг бэлчээр доройтож, ган, зуд нүүрлэхээс хамгаалах хамгийн оновчтой уламжлал нь отор нүүдэл хийх, мал сүргийн бүтэц, тоо, толгойг тохируулах, байгальтай зүй бусаар харьцахгүй байх, хүн-байгаль-мал гуравын харилцан шүтэлцээ, тэнцвэрт байдлыг алдагдуулахгүй байхад чиглэгдсэн сэтгэлзүй, үзэл онол бүхий шашин шүтлэгийн зан үйл байсаар иржээ.

**Дөрвөн улирлын
нүүдэл ба отор гэж юу
вэ?**

Монголчуудын дөрвөн улирлын отор, нүүдлийн талаарх хийсэн шинжлэл судалгаанаас үзэхэд, А.Д.Симуков монгол малчдын нүүдлийг хангайн ба тал хээрийн, баруун хэсгийн Өвөрхангай, Дорнод говийнх, Н.И.Денисов хангай, тал хээр, говь, Н.Жагварал Хэнтий, Хангай, Говь, Өрнөд, Дорнод гэсэн таван хэсэгт ангилсан байна. И.Ф.Шульженко малчдын нүүдэллэх шалтгааныг тайлбарлахдаа, мал сүрэгт өвс тэжээл дутагдах, зун нь урсгал ус, өвөл нь цас ундгүй болох бэлчээрийн ургамалын шимт чанар, мал сүрэгт таарахгүй болох, урин дулаан, сэрүүн хүйтнийг харгалзах, мал хужирлах, малын хэвтэр бууц хуучирч шавхайрах, хүн малын элдэв өвчин эмгэг гарах, үхэл зовлон учрах, бусад аж ахуйтай айлсах, саахалтлах шаардлага гарах зэрэг малчдын нутаг сэлгэхтэй шууд, шууд бус холбоотой олон зүйлийг авч үзсэн байна. Бидний бодоход, отор, нүүдэл нь мал аж ахуйн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны хэлбэр бөгөөд нөөц баялгийг ашиглах, бэлчээрийг ариг гамтай эдлэх арга бөгөөд байгаль, цаг уур, бэлчээрийн нөхцөлд хүмүүсийн хөдөлмөрөө нэгтгэх үйл явц гэж үзэх үндэстэй юм.

УДИРТГАЛ¹

Монголын мал аж ахуйн олон мянган жилийн тэртээ үүсч бий болсон бөгөөд ялангуяа Монголын янз бүрийн нутаг орноос олдсон хүрэл зэвсгийн үеийн элдэв төрлийн олдвор, дурсгалт зүйлсийг судалсан байдлаас үзэхэд мал аж ахуй дэлгэрэн хөгжиж байсан, тэр үйл явц нь эцгийн эрхт орх гэрийг бэхжүүлж байсан хэмээн манай Монгол улсын түүхийн нэгэн ботид тэмдэглэн бичсэн байдаг билээ.

Монгол орны археологийн олдвор дотор одоогоос 3000 жилийн өмнө буюу МЭӨ I мянган жилийн тэртээх төмөр эдлэл зүйлс элбэг байдаг ажээ. Ялангуяа зэр зэвсэг, гоёл чимэглэлийн зүйлсээс гадна морины тоног хэрэгсэл олонтой тааралддаг явдал нь тэр үед мал аж ахуй хөгжиж байсныг гэрчилдэг. “Тухайн үедээ дэвшилттэй аж ахуйн хэлбэр болох нүүдэл-мал аж ахуй, техникийн бүхий л чухал амжилтыг тусгасан нүүдэлчдийн ахуй соёл, тэдний давтагдашгүй яруу сайхан урлаг энэ үед бүрэн төгс хэлбэржин тогтсон билээ” хэмээн Монгол улсын түүхийн нэгэн боть зохиолд тэмдэглэн бичсэн байдаг юм.

Манай эриний өмнөх III зууны үед хүрч ирэхэд Монгол оронд иймгуудын холбоо, нэгдсэн төр улс бүрэлдэж Хүннү гүрэн буй болсон үед үхэр, адуу, бог малыг олноор өсгөн үржүүлдэг, мөн тэмээ, илжгийг цөөвтөр тоогоор малладаг байсан хэмээн ном сударт тэмдэглэн бичсэнээс үзвэл тэр үед мөн л таван хошуу малтай байжээ. Хүннү болон бусад аймгууд дээл хувцас, хоол хүнснийхээ хэрэгцээг мал аж ахуйн бүтээгдэхүүнээр үндсэнд нь хангадаг, мөн малын бүгээгдэхүүн, ангийн арьс үсийг хөрш орны газар тариалан, гар үйлдвэрийн эд зүйлсээр сольж наймаалдаг байсан ажээ.

Хүннү гүрний үед аймаг тус бүр нүүдэл суудал хийх хуваарьтай нутаг бэлчээртэй байсан бололтой. Энэ тухай сурвалж бичигт: “Аймаг бүхэн тусдаа зурвас газартай, нутаг сольж буухдаа өвс, усны аясыг дагадаг” хэмээн тэмдэглэсэн байдаг ажээ².

Хүннүгийн дараах үеийн Сяньби, Жужан, Түрэг, Уйгурын хаант улс, Кидан гүрний үед ч хэдийгээр газар тариалан гар урлал хөгжиж байсан боловч эдийн засаг, ахуй амьдрал, арилжаа наймааны гол үндэс нь бэлчээрийн мал аж ахуй байжээ.

¹Мал аж ахуйн тухай түүхэн тэмдэглэлийн тойм

²Д.Цэвээндорж. “Монголын мал аж ахуйн гарал үүслийн асуудлыг хадны зургаар судлах нь”, УБ. 1992. Тал 45.

Тухайлбал, Сяньби нар нь нүүдэлчин малчид, анчин гөрөөчин байсан, Жужаны үед жилийн дөрвөн улиралд нүүдэллэн нутаг сэлгэж, үхэр, адуу, хонь өсгөн амьдардаг тухай, Түрэгийн үеийн мал аж ахуй нь нүүдлийн мал аж ахуй, ан гөрөө байсан, Уйгурын ахуйн чухал салбар нь урьдын адил нүүдлийн аж ахуй хэвээр байжээ. Харь оронд мал аж ахуйн бүтээгдэхүүн, үнэт ноос үс гаргаж, тэндээс торго, гоёл чимэглэлийн бусад зүйлс авдаг байсан гэх мэтээр МЭӨ хэдэн зууны үеэс эхлэн манай тооллын эхний 1000-аад жилд монгол нутагт солигдож байсан удаа дараагийн хаант улсуудын аж ахуйн шинж байдлыг тодорхойлсон түүхэн тэмдэглэлээс үзвэл бэлчээрийн мал аж ахуй зонхилох байр эзлэсээр байсан нь тодорхой билээ.

Дараа нь X-XII зууны, хамаг монгол улсын түүхэн үед ч мал аж ахуй нь монгол түмний ажил хөдөлмөрөө оруулж амьдрал залгуулж ирсэн үндсэн салбар байсан нь ойлгомжтой билээ.

Гагцхүү малын төрөл, тоо хэмжээ, бүтээгдэхүүн үйлдвэрлэх талаар тодорхой, дэлгэрэнгүй бичсэн сурвалж бичгийн мэдээ баримт хомсхон байдаг ажээ. Манай түүхчид Монголын нууц товчоо, Рашид-Ад-Дины судрын чуулган болон мөн бусад зарим сурвалж бичигт тун ерөнхий байдлаар алаг цоог байдаг мэдээг иш үндэс болгон тухайн үеийн монголчуудын эрхлэн байсан аж ахуйн талаар ийн бичиж ирсэн тухай манай нэрт түүхч эрдэмтэн тэмдэглэн бичсэн байна. Хамаг Монгол улсын үед Монголын ханлиг аймгууд тусдаа тодорхой эзэмшил нутагтай байж, жилийн дөрвөн улирлын аясаар нутаг бэлчээрээ хуваарилан ашиглаж мал сүргээ өсгөн үржүүлсээр байжээ.

Монголчууд овгийн зохион байгуулалттай байх үед мал аж ахуй эрхлэн хүрээгээр нүүдлэж буух арга хэлбэр алгуурхнаар хот маягийн хэлбэрээр солигдсон ажээ. Энэ үйл явц нь зарим малчид нь олон мал хөрөнгөтэй баян чинээлэг болохын хамт маш олон тооны гэрээс бүрэлдсэн нэгэн хүрээний дотор багтах аа больж мал сүргээ тусгаарлан маллах болжээ. Рашид-ад Дины сурвалж мэдээгээр бол нэг хүрээнд мянгаад өрх байсан бололтой. Монголчуудын дундэцгийн эрхт ёс, феодалын шинэ харилцаа үүссэн үед хот айлаар мал аж ахуйгаа эрхлэх явдал нь хүрээний хэлбэрээс илүү давуутай болсон ажээ³.

³Д.Гонгор. “Халх товчоон”, II боть, УБ. 1978. Тал 64.

Хэдийгээр түүхэн баримт бичгүүдэд Монголчууд үхэр, адуу, олонтой байсан тухай бичсэн явдал нэлээд тааралдах боловч эрт үеэсээ л таван хошуу малтай байжээ. Энэ тухай түүхийн ном судруудад янз бүрээр бичигдсэн баримт мэдээ байдаг ажээ. Тухайлбал “Монголын нууц товчоо”-нд ...”ордны орчим явах орд гэрийн хөвүүд адуучин, хоньчин, тэмээчин, үхэрчнийг ордны дараа ард явах Додай Черби захиртугай⁴” хэмээн тэмдэглэсэн байдаг билээ.

Татарын (монгол) эзэн Хятадын хаанд 924 онд 3 түмэн хонь, адуугаар барьц барьсан, мөн тэрээр Тан улсын хаантай ууиах үедээ 400 адуу, 20 тэмээ, тодорхой тооны хониор барьц өргөсөн тухай мэдээг эрдэмтэн Ч.Далай өөрийн номондоо хятад судраас иш татаж оруулжээ. Тэрээр бас Монголын Жалайр аймаг 7 түмэн бодтой, мянган тэрэг хөллөж нүүдэг байсан, мал аж ахуйн салбарт “хоньч”, “агач”, “буурч” гэх мэтийн нэр томъёо сурвалж бичигт гардаг талаар дурьдсан байна.

Энэ бүхэн нь язгууртан монголчууд 10-р зууны үеэс л лавтай таван хошуу мал сүрэг олонтой, хөдөлмөрийн хуваарь нь ч нарийссан гадагш арилжаа наймаа хийдэг, өргөл барьцанд өгдөг, амьжиргааны гол үндэс болж байсныг харуулах ажээ.

Чингис хааны эмхлэн байгуулсан Их Монгол улсын үед ч мал аж ахуй эдийн засаг, аж ахуйн үндсэн салбар байсан нь бүрч ойлгомжтой байдаг билээ. Тэр үеийн ном сударт Монголын мал аж ахуйн талаар тэмдэглэн бичсэн зүйлс нилээд байдаг ажээ. Жишээ нь “очсон газар болгонд л адуу, үхэр хариулсан хүн”, “тэнд гэрийн малаас тэмээ, үхэр, хонь, ямаа арвин байх ба адуу хамгийн олон”, “Тэдний (Монголын) гол мал гэвэл үхэр, адуу, хонь, тэмээ”, “тус оронд нэг моринд 6-7 хонь оногдох жишээтэй байдаг. Өөрөөр хэлбэл 100 адуутай айл 600-700 толгой хоньтой гэсэн үг”, “Тэд тэмээ, үхэр, хонь, ямаа, адуугаар тун баян” гэх мэтээр бичсэн мэдээ сэлт тааралддаг байна.

Энэ бүхэн нь Их Монгол улсын үед монголчууд таван хошуу мал сүрэг олонтой, мөн бод, бог малын тооны харьцаа ямаршуу байсныг үзүүлж буй хэрэг юм.

Францын гэлэн Плано Карпини 1246 онд Монголд ирсэн тухай аяны тэмдэглэл номондоо монгол таван хошуу малтай хэмээн бичиж үлдээсэн болой.

Гагцхүү Чингис хаан, Их Монгол улсын үед хичнээн сая толгой малтай байсан тухай түүхэн баримт мэдээ байдаггүй тул эрдэмтэд тэр үеийн Монголын мал сүргийн

⁴Монголын нууц товчоо. УБ., 1990. Тал 68.

тооны талаар таамаглал дэвшүүлэх оролдлого хийсээр ирсэн ажээ. Чингэхдээ адууны талаар түлхүү анхаардаг байна. Монголын их гүрний үед адуун сүрэг нь тооны хувьд хоёрт орж байсан, улмаар мал сүрэг адгуулах, ан гөрөө, аян дайн хийх, алс замд харилцааны алба залгуулах зэрэг үүрэг, ач холбогдолоороо тэргүүн зэргийн байр эзлэж байсан тул адуун сүргийг өсгөнөрчлэн хамгаалах явдал төрийн бодлого хараанд байсан хэмээн эрдэмтэд ном сударт бичсэн байх нь элбэг тохиолдоно Яагаад гэвэл тэр үед адууны олон цөөн, агт морьдын тарга хүчээр дайнбайлдааны бэлтгэл, хүч чадлын гол хэмжүүр болгож байсан ажээ. Рашид-Ад-Дины судрын чуулган хэмээх номонд “Монголчууд мориноосоо салбал юуг ч хийж үл чадна” хэмээн тэмдэглэсэн нь адуу үнэхээр чухал ач холбогдолтой байсны гэрч мөн.

Басхүү Их Монгол улсын үед сайн хөлөг морьдыг ойр зуурын хэрэгцээнд эдлэхгүй, аян дайнд явах, ан гөрөө хийх журам тогтсон байжээ. Хэдийгээр тэр үеийн адууны нийт тооны талаар тэмдэглэгдсэн баримт байдаггүй боловч аян дайн, өртөөний албандхэрэглэж байсан бодит байдлаас үзэхэд адууны тоо тунолонбайсаннь мэдээжийн хэрэг юм. Тухайлбал, монголын морин цэрэг аяндайндаа явахдаа хүн бүр 3-4, мөн 5-6 морьд авчявдаг тэмдэглэлнэлээдгүй байдаг ажээ. Тэгэхээр Чингис хаан 1219 онд Дундад Азийн Хорезм улсыг дайлаар мордохдоо 15 түмэн цэрэгтэй /зарим тэмдэглэлд 20 түмэн цэрэг гэсэн байх) мордсон гэдэг. Хамгийн багаар бодвол Чингис хааны цэрэг тэр тэр аян дайнд 45 түмэн агтморьд авч явсан байх ёстой. Тэхдээ цэргийн хэрэгцээ нь нийт улс орны аж ахуй, адуун сүрэгт төдийлөн их хувийн жин эзэлж байгаагүй тул нийт адууны тоо хичнээн байсныг барагцаалж болох талтай. Тэр үед үхэр сүрэг нь бод малын дотор адууны дараа ордог, хүнзоны хоол хүнсэнд мах, сүүний хэрэгцээг хангахадзонхилохбайрэээлж байсан хэмээн үздэг юм. Тэр үеийн сурвалж бичигт голдуу үхэр өсгөдөг, үхрийн мах идэж, сүүг нь уудаг талаар тэмдэглэсэн байдаг ажээ. Нууц товчооны хэд хэдэн зүйлд шар үхрийг заримтөрлийн тэргэнд хөллөж байсан тухай тэмдэглэн бичсэн байдаг билээ.Мөн “Монгол үхэр бол бүр шар үхэр юм...Анжисанд хөллөхгүй, харин тэргэнд л хөллөх юм”, “үхэр морь ба тэмээгээр тэргээ чирүүлж, тэрэгний дээрх гэрт нь сууж хэвтсэн ч болно. Үүнийг хам тэрэг гэнэ” гэж “Хар татаарын тухай хэргийн товч”-д тэмдэглэсэн.

Мөн Их Монгол улсын үед ч мал аж ахуйд хонин сүрэг хамгийн олон тоотой байсан бололтой байдаг. “Тэдний улсад нэг мориндноогдуулан харьцуулахад зургаа, долоон хонь байх ёстой” гэж “Монгол татарын тухай бүрэн тэмдэглэл”-д бичсэн байдаг. Адуу, хонины тооны иймэрхүү харьцаа өнөө үед ч хадгалагдсаар иржээ. Жишээ нь, 1990 оны байдлаар 2 сая 2 бум, 6 түм, 2 мянган адуутай байхад 15 сая 8 түм 3 мянган хонь байсан нь 1:6.7 гэсэн харьцаатай байлаа. Хонин сүрэг нь мах, сүү, ноос, арьс гээд олон зүйлийг өгдөг, хэвтэр бууц нь хүртэл хөрзөн болж гол түлшний хэрэгцээг хангадаг тул манай монголчууд хонийг онцлон анхаарч, өсгөн үржүүлж ирсэн нь ойлгомжтой юм.

Тэмээн сүргийн талаар Монголын нууц товчооны хэдэн ч зүйлд тэмдэглэсэн байдаг билээ. Мөн “Хар татаарын тухай хэргийн товч” номд тэмээ нь хос бөхтэй, ганц бөхтэй, бөхгүй ч бас буй гэж тэмдэглэсэн байдгаас үзвэл Араб, Энэтхэгээс нэг бөхтэй тэмээ Монголд авч ирж байсан ч байж магадгүй байна.

Ямаа бол тооны хувьд цөөвтөр байсан гэж зарим эрдэмтэд таамаглан бичсэн байдаг. “Монголын нууц товчоо”-нд Ван хан таван ямаа сааж амьдарч байсан гэсэн тэмдэглэл нь эрдэмтдээс ямаа цөөхөн байсан хэмээн үзэх болсон таамаглалд хүргэсэн байж болох юм. Ямаа бол хэзээнээсээ хонин сүрэгтэй хамт байсан болохоор тусгайлан тоймлосон тэмдэглэл ховор байдаг бололтой. Гэхдээ ямааны онцлогийн талаар “хонин сүрэг бүрт хэд хэдэн ямаа байдаг, тэдгээр ямаа нь зоригтойгоор сүргийн манлайд явж, ус тохиолдмогц түрүүнд нь хөтлөхөд олон хонь дагаж гарна”, “ямаа цөөхөн байдгийн учир гэвэл ямааны мах хийтэй болохоор түүний махыг ер иддэггүй” гэх мэтээр “Хар татаарын тухай хэргийн товч” сурвалж бичигт бас тодорхой бичсэн байдаг ажээ.

Их Монгол улсын үед Өгөдэй хаан мал аж ахуйд ихээхэн анхаарал байжээ. Тухайлбал, адууны талаарх төрийн бодлогыг үргэлжлүүлж, адууг улсын хяналтад байлгадаг, мөн тэмээг ч тусгай данс бүртгэлтэй болгосон ажээ. Түүгээр ч барахгүй Алашаан удмын улаан тэмээг Монголын говь нутагт өсгөж үржүүлэх ажлыг хийж байсан бололтой.

Өгөдэй хаан Монголын говь нутагт худаг ус гаргаж, тэнд малчин олон түмэн мал хунараа адгуулан аж төрөх аятай боломжийг бий болгох бодлого хэрэгжүүлсэн байжээ. “Монголын нууц товчоо”-нд энэ тухай бичигдсэн байх аваас: “Бас цөл говь

нутагт гөрөөснөөс өөр амьтангүй байна. Ард иргэд хуран суухыг хүснэ. Чанай, Уйгартай хоёр тэргүүтэй нутагчдыг явуулж, цөл говьд худаг малтаж хошуулья”¹¹ гэсэн байна. Тийнхүү Монголын дээд төр, Өгөдэй хаанаас зарлиглан нутаг орноо бүхэлд нь эзэмдэн говь нутагтаа монголын малчин түмэн мал сүргээ адуулан амьдрах боломжийг бий болгох нь улс орныхоо үйлдвэрлэх хүчний үндэс болсон хүн амаа зохистой байршуулах, мал аж ахуйгаа тэнцвэртэй хөгжүүлэх гэсэн алсын бодлого, чиглэлтэй чухал ажил байжээ.

Монголын эзэнт гүрний их хааны ор суурийг Хувилай эзэгнэн сууснаас хойш төр улсаа Юан гүрэн хэмээн нэрлэж байсан 13 дугаар зууны хоёр дахь хагасаас бараг 14 дүгээр зууныг дуусталх үед ч монголчууд мал аж ахуйгаа эрхлэн амь зуулгаа залгуулсаар байжээ. Энэ нь Юан гүрний үеийн сурвалж бичигт, ялангуяа “Юань улсын судар”, “Шинэ Юан улсын судар”-т “Монгол нь нүүдлийн ахуйн орон ...зунаас өвөл хүртэл өвс, ус даган нүүж, арван сард тогтоосон нутагтаа ирнэ”, “Юан гүрний үед мал сүрэг өсгөх 14 зам байж, тэнд адуу, үхэр, тэмээ, луус, хонь өсгөн малладаг байсан”, “мал сүрэг нь тоо томшгүй үхэж хорогдовч дараа үед дахин олширно”, “Монгол хүнд үхэр, морины хэрэгцээ нэн их, 20 лан, нэг морь 30 лан” гэх мэтийн малын тухай дурдсан тэмдэглэлүүдийг академич Чулууны Далай “Монголын түүх” /1260-1388/ хэмээх номондоо⁵ иш татан өгүүлснээс тодорхой байна.

Чингэхдээ тэр үеийн Монголын малын тооны талаарх түүхийн тодорхой баримт хэрэглэгдэхүүн өнөө хүртэл олдоогүй байгаа ажээ. Юан гүрний хаад нь мал сүргийг дассан сурсан монгол газар нутагтөсгөн үржүүлэх, монгол хүнээр маллуулах, эзэн хаан, ноёд, язгууртны мал сүргийг адуулан хариулахад бэлчээр нутгийг ашиглих, ахуйн ажлыг дагнан эрхлэх төрийн байгууллага бий болгохээрэг ажиллагаа явуулдаг байжээ. Жишээ нь зарим ном сударт тэмдэглэснээр бол “1323 онд Монголд мал аж ахуйн хэрэг эрхлэх мал сүргийн хүрээлэн” байгуулсан, улмаар түүнийг 1327 онд өөрчлөн мал сүргийн эрхэм түшмэдийн газар болгов”, “1328 онд 16 түшмэлээр ахуйн хэрэг эрхлүүлэх болгосон” хэмээн тэмдэглэсэн байдаг ажээ⁶. Энэ бүхэн нь гол төлөв улсын буюу албаны мал аж ахуйг эрхлэх газрууд байсан бололтой хэмээн зарим эрдэмтэд үздэг бөгөөд дээдсийн сүрэг, ихсийн сүрэг, цэргийн агт, ноёдын

⁵Ч.Далай. “Юан улс 1260-1388”, УБ. 1992. Тал 124.

⁶Ч.Далай. “Юан улс 1260-1388”, УБ. 1992. Тал 112.

хангамжийн мал гэх мэтийн ангилалтай тусгай бүртгэл данстай мал сүрэг байсан ажээ. Албаны малын асуудал эрхлэх түшмэлийн газраас тэдгээр малыг үе үе тоолж дутууг гүйцээдэг, им тамга тавьж дансалдаг, данс бичгийг монгол, уйгур, хятад гурван хэлээр үйлддэг байжээ.

Оросын эрдэмтэн Б.Я.Владимирцов Юан гүрний үед “Хороогоор нүүж” мал маллаж байсан тухай хятад сурвалжид байдаг гэсэн ойлгомж муутай эргэлзээтэй нэр томъёоны тухай дурьджээ. Монголд 13-14-р зууны үед хуучны нэр томъёоны тухай хүрээгээр нүүх явдал нэгэнт халагдаж байсан тул хороогоор нүүх гэж чухам юуг хэлсэн, зарим үед малчид нилээн хэдэн гэрээрээ бөөндүүхэн нүүж нутаглаж байсныг хятадууд сайн ялгаж мэдэхгүй хороогоор нүүх гэж хэлсэн байж болох юм. Уг нь тэр үед хот айлын хэлбэр нэгэнт тогтсон байх ёстой билээ.

Юан гүрний үед ч янз бүрийн ном сударт Монголын малын төрлийн талаар хонь голдуу өсгөж байсан, үхрийн хэрэгцээ их байж, адууны засгийг тогтоосон, монгол хүн тэмээ өсгөн унаж эдлэнэ гэх мэтээр янз бүрээр бичиж байснаас ч үзсэн мөн л таван хошуу малтай байсан нь ойлгомжтой юм. Монголын их гүрэн задарсан бага хаадын үед болон дараах Манжийн ноёрхлын хэдэн зуун жилийн туршид ч мал аж ахуй бол улс орны эдийн засаг, ахуй амьжиргааны үндэс байсаар ирсэн ажээ. Гагцхүү тэр үед Монголд хамжлагын ёс горим тогтож феодал ноёдын эзэмшлийн аж ахуй, жирийн малчдын аж ахуй, сүм хийдийн жасын аж ахуйн ялгарал ангилалтай байсан нь тодорхой билээ. Тэр баяцуулын малыг ядуучууд нь малладаг, хөрөнгө чинээний ялгаа ихтэй болсон байжээ. Чингэхдээ бүхэлдээ Монголын мал аж ахуй мөн таван төрлийн малаас бүрэлдсэн хот айлын хэлбэртэй, малын ноос, арьс шир зэрэг илүүдэл бүтээгдэхүүнээ гадаадын худалдаачид, пүүст наймаалдаг, алба гувчуур төлдөг уламжлалт байдалтай л 20 дугаар зууны үед хүрч ирсэн ажээ. Монгол оронд олон зуун жилийн өмнөөс бүрэлдэн тогтсон феодалыннийгмийн сүүлийн жилүүдэд буюу 1920-иад оны үед ч мал аж ахуй бүхэлдээ эдийн засаг, хүн ардын аж амьдралын үндэс нь болж, үндэсний орлогын үйлдвэрлэлийн 90 орчим хувь, үндсэн фондын 96 хувь нь мал аж ахуйгаас бүтэж, нийт ачаа тээвэрлэлтийн ажлыг ердийн хөсгөөр, шуудан харилцааг морин өртөөгөөр гүйцэтгэж байв. Өөрөөр хэлбэл энэ үе хүртэл Монголын ард түмэн нийтээрээ мал аж ахуй эрхэлдэг байсан, ерөөсөө улс орны эдийн засагт бэлчээрийн мал аж ахуй зонхилох салбар хэвээр үлдсэн явдал нь

дэлхий дахинаа XX зууны нөхцөлд онцгой содон гоц үзэгдэл болсон юм. Энэ тухай Монгол орноор 1919-1920 онд аялан судалгаа хийсэн Оросын нэрт эрдэмтэн, академич И.Майский хэрхэн тэмдэглэн үлдээснийг⁷ үзэж болно.

Биднийдээр өгүүлснээр мал аж ахуйн төрөл, байдлын талаар түүхийн янз бүрийн сурвалж, ном сударт элдэв мэдээ сэлт их байдаг талаар заримыг дурьдсан билээ.

Харин Монгол орны малын тоо толгойн тухай зөв мэдээ нь гадаадын ажил хэргийн хүмүүсийн сонирхлыг ихээхэн татаж байжээ. Ийм учраас гадаадын судлаачид, худалдаа, наймааны хүмүүс Монголын мал сүргийн баялгийг тооцох оролдлогыг аль хэдийнээс хийж байсан ажээ. Тийм үйл явц нь XX зууны эхээр, Монгол орон Манжаас тусгаарлан, тусгаар тогтнолоо зарласан үеэс ихээхэн идэвхтэй байсан юм.

Мал сүргийн тоо: Хэдийгээр Их Монгол улсын үеэс эхлэн, хожим хойно ч гэсэн түмт, мянгат, аймаг отгоороо малынхаа тоог гаргаж, их хаанд мэдээлэн алба гувчуур төлдөг журам байсан боловч мэдээлж тараадаггүй байсан бололтой.

Богд хаант Монгол улсын Засгийн газраас 1918 онд мал тооллого явуулахаас өмнөх Монголын малын тоог тодорхойлох гэсэн оролдлогууд нь ихээхэн хийсвэр, үндэслэл муутай байсан нь тун илэрхий байдаг билээ. Энэ талаар хэдэн тодорхой жишээ дурдаж болох юм.

Жишээ нь, XX зууны эхэн үед Хиагтын төмөр замын тухай болсон зөвлөлгөөнд оролцогчид Монголын малын тоог барагцаалахдаа адуу 25 сая, үхэр 20 сая, тэмээ 2 сая, хонь 75 сая, бүгд 1222 сая гэжээ. Э.Циндель гэдэг хүний хэвлэлийн газраас нийтлүүлсэн өөр нэг мэдээгээр бол мөн тэр үед Монголын малын тоог авч үзэхдээ адуу 12,5 сая, үхэр 7.5 сая, тэмээ 1 сая, хонь 25 сая бүгд 46 сая гэжээ. Түүнчлэн 1910 онд Монголд байсан Москвагийн худалдааны экспедицийнхэн гадаад монголд адуу 7.5 сая, үхэр 10 сая, тэмээ сарлаг 2 бум, 2 түм, 5 мянга, хонь, ямаа 20 сая, бүгд 37 сая 7 бум, 2 түм, 5 мянган толгой малтай хэмээн тооцоолжээ.⁸ Мөн Оросын судлаач

⁷И.М.Майский. “Современная Монголия”, Иркутск. 1921. Тал 158.

-И.М.Майский. “Монголия на кануне революции”, Москва. 1959. Тал 124.

⁸Ц.Насанбалжир. “Монголын мал аж ахуй хөтлөлтийн уламжлалт шинэтгэл” (XIX зууны эцэс XX зууны эхэн), УБ. 1978.

А.П.Беннигсен “Орчин үеийн Монголын тухай зарим нэг тоо баримт» хэмээх номондоо 1912 онд Ар Монголын малын тоог адуу 1 сая, 4 бум, 5 түм, үхэр 1 сая, 3 бум, 5 түм, тэмээ 3 түм, хонь, ямаа 11 сая, бүгд 14 сая, 1 бум толгой гэж тодорхойлжээ. Түүнчлэн монгол судлаач А.П.Болобан “Монгол, түүний орчин үеийн худалдаа, эдийн засгийн харьцаа” гэдэг номондоо болохоор адуу 2 сая, үхэр 1 сая, тэмээ 1 бум, 2 түм, 5 мянга, хонь, ямаа 10 сая, бүгд 13 сая, 1 бум 2 түм, 5 мянга гэсэн нь нилээд ойролцоо байж болох тоо оруулсан байх юм. Тэгэхээр Монголын малын тооны тухай дээрх тоо баримтуудын дээд, доод хязгаарын хооронд бараг 10 дахины зөрүү байгаа нь сонирхолтой санагдана.

Богд хаант Монгол улсын Засгийн газар 1918 онд малын тооллого явуулсан явдал нь тус оронд анх удаагаа малын тоог илүү бодитойгоор тоймлох боломж олгосон хэрэг юм. Гэхдээ мал тооллогонийг хязгаар нутгийг хамарч чадаагүй тул дахин нэмэлт тооцоо хийх шаардлагатай болсон байжээ. Уг тооллогыг явуулахдаа эхлээд малаа биечлэн тоолоогүй, хүмүүсээс асууж бүртгэж авах журмаар хийсэн учраас анхны дүнгээр ердөө л 5.3 сая малтай гэсэн тоо гарсан байжээ. Үүнийг илэрхий ташаа болсон, их хэмжээний мал дутуу тоологдсон гэж үзээд хоёр дахь удаагаа тооллого явуулахад малын тоо 7.7 сая болжээ. Гэвч энэ нь бас л дутуу тоо байжээ. Нэгд, Богдын шавь нар албан татвараас чөлөөлөгдөж байсан тул халх 4 аймгийн шавь нарын болон Хөвсгөлийн их шавийн мал хүн тоологдоогүй. Хоёрт, Ховдын хязгаар нутаг нь хэдийгээр тус орны нэг хэсэг нь байсан боловч Автономит Засгийн газраас явуулж байсан арга хэмжээнд тэр болгон хамрагддаггүй, бие даасан байдалтай байсан тул малын тооллогод хамрагдалгүй үлджээ.

Ийнхүү монголчуудын бэлчээрийн мал аж ахуйн амьдрал, түүнийг дагасан олон талт өвөрмөц мэдлэг, соёл нэн эрт цагаас нааш тасралтгүй хөгжсөөр орчин цаг буюу XX зууны эхэн дунд үетэй золгожээ. Улмаар социалист нийгмийн нэгдэлжих хөдөлгөөнд шилжиж, нүүдэлчин монголчууд урьд өмнө тулгарч байгаагүй шинэ хэв маягаар мал аж ахуйгаа хөтлөх болжээ. Нэгдэлжсэн зохион байгуулалтаас капиталист өмч хөрөнгийн нээлттэй зах зээлийн орчин нөхцөлд алхан орж, ийнхүү XXI зуунд түүхийнхээ нэгэн шинэ гарааг эрчимтэй эхлээд байна.

1. СҮРГИЙН БҮТЭЦ, МАЛЫН ТОО ТОЛГОЙГ БЭЛЧЭЭРИЙНХЭЭ ОНЦЛОГТ ТОХИРУУЛЖ ИРСЭН МЭДЛЭГ

1.1 Сүргийн бүтэц, малын тоо толгой, бэлчээр судлалын тойм

Судлаачдын үзэж байгаачлан маш эрт цагт бэлчээрийн мал аж ахуй бүрэлдэн тогтжээ. Энэ тухай Академич О.Шагдарсүрэн өөрийн олон жилийн судалгааны үр дүнд үндэслэсэн үзэл баримтлал дэвшүүлжээ. Тэрээр “Түүх судраас үзэхэд бэлчээрийн мал монгол угсаатныг ХХ зуунаас өмнөх бүх түүхийн турш (МТӨ IV-III мянган жил) хүнс хоол, хувцас хунир, наймаа арилжааны төлбөр зэрэг амьдралын үндсэн гурван уг сурвалжийн үүсвэр болж иржээ. Эзэн Чингисийн алс холын аян дайнд уналга, ачлагын зүтгүүр, хүнс тэжээлийн амьд нөөц, өмсгөл хувцас, бие хамгаалах ширэн хуяг дуулга, айраг цэгээг зөвхөн бэлчээрийн малын ач тус, үр шим гэж мэдэх монгол хүн олон бий”⁹ гэжээ.

Олон мянган жил газар зүйн нэг орчинд тасралтгүй амьдарсаар ирсэн монголчууд нутаг бэлчээр, уур амьсгалдаа зохицсон мал сүргийнтогтолцоог бий болгосноор нүүдлийн сонгодог соёл, иргэшил цогцлох нөхцөл бүрджээ. Академич Ш.Нацагдорж: "Мал аж ахуй зах зээлтэй холбогдсоноор (XIV-XVI зуун) нэлээд өөрчлөлт гарч, чухамдаа энэ үед Монголын мал аж ахуй хөгжлийнхөө дээд цэгт хүрсэн"¹⁰ гэж үзжээ. Тэрхүү дээд цэгтээ хүртэл хөгжсөн мал аж ахуйт нүүдлийн сонгодог соёл, иргэншил дараа дараачийн үед залгамжлагдсаар Монголын орчин цагтай золгожээ.

Доктор Д.Гонгор: МЭӨ-х 3-4 мянган жилийн тэртээд...хүний нийгмийн балчир неолитийн (шинэ чулуун зэвсгийн) үед Төв Ази, Хойд Америк, Өмнөд Европын оронд үүссэн..."¹¹ гэжээ.


Нүүдлийн соёл, иргэншлийг судлах олон улсын хүрээлэн уламжлалт сүргийн бүтэц, тоо толгой, бэлчээрийн хүрээнд олон арван бүтээл англи хэлээр хэвлэж дэлхий дахинаа танилцуулсаар байна. Түүнээс түүвэрлэн танилцуулбал:

⁹О.Шагдарсүрэн. Монгол улсын шинжлэх ухаан, цуврал. 93а-р боть.УБ., 2006. Тал 10.

¹⁰М.Төмөржав. Эрдмийн гайхамшигаас. УБ., 2009. Тал 239.


¹¹Д.Занданшатар. Монголын бэлчээрийн мал маллагааны арга. УБ., 2006. Тал 13.

2000 онд "Nomads and use of Pastures today" ("Нүүдэлчид ба бэлчээр ашиглалт өнөөдөр") сэдэвт Олон улсын хурал зохион байгуулж, ном хэвлэж нийтийн хэрэглээнд оруулсан юм. Монголын нүүдэлчдийн уламжлалт бэлчээр, түүний зохион байгуулалт хийгээд нүүдлийн соёл иргэншлийг бүрдүүлэгч олон талт байдлын арга технологи, ёс, зан үйл, ардын мэдлэг зэрэг өргөн хүрээг хамарсан уг бүтээлд дотоод, гадаадын нийт 59 эрдэм шинжилгээний илтгэл өгүүлэл хэвлэгдсэн. Уг хурал, түүний үр дүнгийн эмхэтгэл ном нь нүүдлийн соёл иргэншлийг олон улсад тогтолцоотойгоор судлах, сурталчлан таниулахад шинжлэх ухааны өргөн ач холбогдолтой болсныг ЮНЕСКО онцлон тэмдэглэжээ.




(1-р зураг)

2001 онд "Dialogue among Civilizations: Interaction between Nomadic and Other Cultures of Central Asia" (Соёл хоорондын яриа хэлцэл: Төв Азийн нүүдэлчид ба бусад соёлын харилцан үйлчлэл) сэдэвт бичиг баримтыг хэвлэж нийтийн хэрэглээнд оруулсан. Бүс нутгийн олон үндэстний соёл хоорондын ойлголцол, олон талт байдлыг үнэлэх замаар нүүдлийн соёл иргэншийн байр суурийг тодруулсан уг бүтээл нь дотоод, гадаадын нийт 99 эрдэмтэн судлаачдын эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэл болно. Уг бүтээл нь ЮНЕСКО-ийн соёл, шинжлэх ухааны үзэл баримтлалыг сурталчлан таниулахад чиглэгдсэн бөгөөд бүс нутгийн орчин цагийн соёлын харилцан ойлголцол, соёлын боловсролын тунхаглалд өөрийн ач холбогдлыг үзүүлсэн юм.



(2-р зураг)


2001 онд Т.Чулуун, Д.Ожима нарын "Fundamental Issues Affecting Sustainability of the Mongolian Steppe" (Монгол орны бэлчээрийн тогтвортой байдалд нөлөөлөх үндсэн хүчин зүйлүүд) бичиг баримтын эмхэтгэл номыг хэвлэж судалгаа, бодлогын хэрэглээнд оруулсан. Дотоод, гадаадын нийт 45 эрдэмтний судалгааны бүтээл. Уг ном нь даяаршлын эрин үед уламжлалт мал аж ахуйн бэлчээрийн нөөц, боломжийг хэрхэн тогтвортой байлгах тухай олон улсын эрдэмтэн судлаачид оюун бодлоо уралдуулж, аргын талаар зөвлөмж гаргаж ЮНЕСКО болон холбогдох бусад албан байгууллагад уламжилжээ.



(3-р зураг)


2008 онд Ф.Шолцын "Nomadism" (Нүүдэлчин байдал) зохиол хэвлэгдэж олон улс, нийтийн хэрэглээнд шилжсэн. Ази, Европ, Африкийн нүүдэлчдийн соёлын бүс нутгийг хамарсан уг судалгааны бүтээл үндсэн 3 бүлэг 11 зүйлээс бүрдсэн. уг

бүтээлд нүүдэлчдийн соёлын нийгмийн экологийн загварыг дээрх бүс нутгуудын хэмжээнд хөндөж, нийтлэг төстэй болон ялгаатай шинж чанаруудыг нь тодруулжээ.



(4-р зураг)

2011 онд Академич Б.Энхтүвшин, М.Төмөржав нар "MONGOLIAN NOMADS AND NOMADIC ANIMAL HUSBANDRY" (Монголын нүүдэлчид ба нүүдлийн мал аж ахуй) сэдэвт хамтын бүтээл хэвлүүсэн. Уг бүтээл нь үндсэн 2 бүлэг, 10 зүйлээс бүлдсэн. Зохиогчид монголын нүүдэлчид ба нүүдлийн мал аж ахуйг судалсан олон жилийн судалгааны үр дүнгээ дэлхий даяарх нүүдэлчдийн амьдралаас өгсүүлээд монголын нүүдэлчдийн гарал, газар нутаг, түүхэн хөгжил, даяаршил ба монголын нүүдэлчид, нүүдлийн сонгодог мал аж ахуйн тухай г.м өргөн хүрээнд томъёолон бичсэн билээ. Энэхүү суурь судалгааны бүтээл нь энэ чиглэлийн судлаач, сонирхогчдод онолын түвшний өндөр мэдлэг олгох чухал ач холбогдолтой билээ. Тиймээс уг номыг дотоодын гэхээсээ илүүтэй ахмад монгол эрдэмтэд өөрсдөө бичсэн гэдэг утгаар нь гадаадын судлаачид илүү сонирхон судалгаа шинжилгээний ажилд суурь судалгааны эх хэрэглэгдэхүүнээр ажиглаж байна.



(5-р зураг)

Тус байгууллагын зүгээс дээрх бүтээлүүд (өөр олон бүтээл бий)-ийг хэвлэж олон улсын тавцанд гаргаснаар монголчуудын нүүдлийн соёл, иргэншил нь энэ төрлийн соёл, иргэншил дотроос хамгийн өндөр түвшинд хүрч хөгжсөн сонгодог нүүдлийн соёл иргэншлийн төрөл гэж үзэх нөхцөл бүрдэж, олон эрдэмтэн судлаачид хүрээн зөвшөөрсөөр байна.

Харин Монгол улс дахь зарим судалгааны байгууллагууд нүүдлийн соёл, иргэншлийн тогтолцоог бүрдүүлэгч эд эс болсон мал сүргийн бүтэц, тоо толгой, бэлчээрийн чиглэлээр арвин мэдээлэл хуримтлуулж, чамгүй үр дүнд хүрсээр байна.


Лавтай 3500-4000 орчим жилийн настай монгол нүүдлийн соёл иргэншлийн үндэс нь бэлчээрийн мал аж ахуй мөн аж. Бэлчээрийн мал аж ахуйн тогтолцооны үндэс нь газар нутаг буюу бэлчээр болно. Монголын нүүдэлчдэд бэлчээрийг сонгох, ашиглах, хамгаалах арвин их туршлага хуримтлагджээ. Нүүдэлчдийн тэрхүү уламжлалт мэдлэгийг орчин цагийн шинжлэх ухааны арга зүйд түшиглэн судлаад 60 шахам жил болж байна. Тэдгээрийн заримаас тоймлоход:

Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгээс **2011** онд "Бэлчээр судлал 50 жилд" сэдэвт номыг хэвлүүлэн нийтийн хэрэглээнд оруулсан. Уг бүтээлийг доктор (Sc.D) С.Цэрэндаш, Н.Лхагважав, Ц.Алтанзул нар зохиож, Ц.Билэгт, Т.Лхагвасүрэн нар хянан тохиолдуулжээ. Тухайн номын бүтцийг тоймлоход, үндсэн 5 бүлэг, 29 зүйл, 32 дэд зүйл, хураангуй дүгнэлтээс бүрджээ. Энэхүү номонд бэлчээр судлах арга зүйгээс эхлээд цаг уурын нөхцөл, хөрс, ургамалжил, түүний бүтэц, бүрэлдэхүүн, байгалийн бэлчээрийг хуваарьтай ашиглах уламжлал, шинэчлэлд хийсэн судалгааны үр дүнгүүд багтжээ.



(6-р зураг)

Хөдөлмөрийн Баатар, нэрт хөдөө аж ахуйч Ү.Аварзэд, биологийн ухааны доктор (Sc.D) Т.Содной нар **2008** онд "Монголын нүүдлийн соёл иргэншил, бэлчээрийн мал аж ахуй" ном бүтээжээ. Онол, практикийг гүнзгий хослуулан монголын уламжлалт нүүдлийн соёл иргэншлийн бүтэц, бэлчээрийн мал аж ахуйн үүсэл хөгжил, байгалийн шалгарал, газар зүйн байршил, экологийн нөхцөлд монгол малын түүхэн зохицолдоо, малчин нүүдэлчдийн ёс, зан үйл, арга технологи зэрэг өргөн хүрээний агуулгатай уг ном нь нийт 22 бүлэг, 242 зүйл, хавсралт, 3 зөвлөмжөөс бүрджээ. Энэхүү бүтээл нь тухайн үедээ нийгмээс өндөр үнэлгээ авч байсан бөгөөд цаашид ч энэ салбарыг сонирхсон хэн бүхэнд үнэт хэрэглэгдэхүүн болно гэж найдна.



(7-р зураг)

2006 онд профессор Д.Занданшатар "Монголын бэлчээрийн мал маллагааны арга туршлага" сэдэвт, нийт 12 бүлэг бүхий зохиол бичжээ. Уг зохиолын хянан тохиолдуулагчаар доктор, профессор Х.Буяндэлгэр, улс төрч Г.Занданшатар нар ажилласан бөгөөд номын ач холбогдлыг дараах байдлаар үнэлжээ. Үүнд:

- Залуу мал маллагааны арга барилыг сайжруулан байгалийн эрсдэлтэй нөхцөлд ажиллаж сурна;
- Залуу малчид, тэр тусмаа мал аж ахуйн салбарт шинээр гарч ажиллах хүмүүст мал маллагааны арга туршлагад бие дааж суралцах үндсэн нөхцөл бүрдэнэ;

- Шинээр малчин бэлтгэх, мал аж ахуйн мэргэжилтэнг бэлтгэхэд гарын авлага болно;
- Малчдын асуудлыг судалж оновчтой шийдвэр гаргахад нь туслана;
- Бэлчээрийн мал аж ахуйг байгал-цаг уурын эрсдэлтэй үед ч хохирол багатай эрхлэн хөтлөх чадамж, арга, туршлага сайжирч мал сүргийн тоо, толгой, чанар, ашиг шимийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлнэ;
- Бэлчээрийн мал маллагааны арга туршлагыг сайжрууснаар малчдын амьжиргааны түвшинг дээшлүүлэх, улмаар улс орны эдийн засгийн чадамжийг нэмэгдүүлэх, үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд зохих хэмжээний түлхэц болно; гэж үнэлэн дүгнэжээ. Нэг үгээр хэлбэр уг ном нь залуу, шинэ малчид болон энэ чиглэлийг сонирхогчдод гарын авлагын үүрэг гүйцэтгэх зорилготой бүтээл ажээ.



(8-р зураг)

2004 онд ахмад эрдэмтэн судлаач Б.Мягмаржав "Дэлхийн нүүдлийн мал аж ахуйн хөгжлийн асуудлууд" цуврал бүтээлээ эхлүүлсэн. Уг бүтээлийн ерөнхий редактороор Академич Б.Энхтүвшин ажилласан. Энэхүү цувралын судалгаа нь нүүдлийн мал аж ахуйн үндсэн хүчин зүйлээс өгсүүлээд байгаль газар зүйн нөхцөл, дэлхийн мал аж ахуйд нүүдлийн мал аж ахуйн эзлэх байр суурь, нүүдлийн мал аж ахуйн малын тоо, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, төрөлжилт, дагналт, хэтийн төлөв, эдийн

засгийн асуудлуудын харилцан уялдаа г.м өргөн сэдвийг хамарчээ. Тиймээс судлаачид уг бүтээлийн өмнөтгөл хэсэгт дараах байдлаар дүгнэжээ. Үүнд:

1. Олон мянган жилийн турш нүүдлийн мал аж ахуйн эрхлэж ирсэн Ази, Африкийн нүүдлийн мал аж ахуйн өнөөгийн байдлыг орон, тив бүрээр судалж гаргаснаар шинжлэх ухаан төдийгүй, практикийн чухал ач холбогдолтой(Б.Энхтүвшин).
2. Дэлхийн мал аж ахуйн тухай энэ бүтээл биеэ даасан том хэмжээний, дэлхийд бага судлагдсан, асуудлыг олон талаас нь цогц шинжлэх нэгтгэн дүгнэсэн шинжлэх ухааны болон практикийн ихээхэн ач холбогдолтой өвөрмөц хэлбэрийн бүтээл (В.В.Грайворонский).



Б.Мягмаржав

Дэлхийн нүүдлийн мал аж ахуйн хөгжлийн асуудлууд




Улаанбаатар, 2004 он.

(9-р зураг)

2008 оноос эхлэн Шинжлэх Ухааны Академийн салбар байгууллагуудын эрдэмтэн судлаачид нэгдэж "Монголын бэлчээрийн мал аж ахуй" 20 боть цуврал номыг хэвлүүлж, нийтэд өргөн хүрээтэйгээр ашиглаж байгаа билээ. Энхүү цуврал боть нь монголын нүүдлийн соёл, иргэншлийн сонгодог тогтолцоог бүрдүүлэгч олон арван төрөл зүйлийн ардын мэдлэг, технологи, ур чадвар, хэрэглээний гоо сайхны сэтгэлгээний уламжлалыг орчин цагийн шинжлэх ухааны арга зүйн дагуу судалж, нэгтгэн дүгнэснээрээ туйлын ач холбогдолтой гэж үздэг. Тиймээс уг 20 боть цувралын редакцийн зөвлөлөөс "Монголын бэлчээрийн мал аж ахуй нь тус орны

дотоод гадаад олон талын чухал хэрэгцээг хангахад эдүгээ чамгүй их тус хүргэж буйг монголын олон нийт сайн мэднэ. Ийм үед монгол мал аж ахуйнхаа түүхэн өв санг шинжлэх ухааны онол, арга зүйд түшиглэн судалсан эрдэмтдийн цуврал бүтээл болгон хэвлэн нийтлэх ажлыг зохион байгуулж байна. Энэ ажил уншигч олон нийтийн анхаарал, сонирхлыг зүйн ёсоор татна гэж үзэж байна" гэж дүгнэжээ.




(10-р зураг)

Ийнхүү мал сүргийн бүтэц, тоо толгой, бэлчээр судлалын хүрээнд хэвлэгдэн өндөр амжилт олсон бүтээлүүдээс цөөхөн хэдийг нь тоймлон авч үзлээ. Юуны түрүүнд монголын ахмад эрдэмтэд монгол нүүдлийн соёл иргэншлийг энэ төрөлдөө дахин давтагдашгүй, биеэ даасан, систем, функцийн хувьд сонгодог тогтолцоо бүхий амьд оршин буй соёл иргэншил мөн болохыг нь ЮНЕСКО зэрэг олон улсын түвшинд хүлээн зөвшөөрүүлж чаджээ. Мөн нүүдлийн мал аж ахуй, бэлчээр, монгол мал сүргийн бүтэц, тоо толгой зэргийн харилцан шүтэлцээг нарийвчилсан үр дүнгээр тодруулж, бодит байдалд түшиглэн хэтийн төлөвийг нь ч төсөөлжээ.

1.2 Бэлчээрийн байдал: өнөө үе

Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн монгол орны бэлчээрийг "ойт хээрийн бэлчээр", "хээрийн бэлчээр", "цөлөрхөг хээрийн бэлчээр" гэж үндсэн гурван хэсэгт хуваан томъёолох замаар газарзүйн байршил, хөрс, ургамалжил зэргийг нарийвчлан шинжилсээр иржээ[4]. Жишээ нь, Ойт хээрийн бэлчээр нутагт Орхон, Сэлэнгэ; хээрийн бэлчээр нутагт Туул, Хэрлэн, Завхан, Ховд гол болон Онон голын урсгал сав газар; цөлөрхөг хээрийн бэлчээрт монгол орны говийн бүсийн нутаг дэвсгэр хамрагддаг аж.

Тэгвэл, 2018 онд Төрийн болон Төрийн бус байгууллагууд хамтраад "Монгол орны бэлчээрийн төлөв байдал" сэдэвт өргөн хүрээтэй судалгаа гүйцэтгэж "Үндэсний тайлан"-г хэвлүүлэн нийтийн хэрэглээнд шилжүүлсэн. Уг төслийн хүрээнд судлаачид бэлчээрийн төлөв байдлын үнэлгээ, мониторинг, менежментийн аргачлалыг боловсруулж, байгалийн бүс бүслүүрийг тодруулжээ.




(11-р зураг.Зургийг "Монгол орны бэлчээрийн төлөв байдлын үндэсний тайлан 2018"-ын 16-р талаас аваг)

Тэрхүү аргачлалаар бэлчээрийн төлөв байдлын үндэсний түвшний үнэлгээ, мониторинг, орон нутгийн нөхцөлд бэлчээр ашиглалтын үр нөлөөг хянан үнэлжээ.

Эцэст нь зөвлөжээ. Тэрхүү зөвлөмжийн 5.4 дүгээр заалтад: "Бэлчээрийн доройтлын явц маш богино хугацаанд эрчимтэй нэмэгдэж, харьцангуй соргог байсан мониторингийн цэгийн тоо 10 хувиар багассан, хүчтэй болон цөлжсөн ангилалд хамаарагдах цэг 4.3-5.9 хувиар өсчээ. Бэлчээрийн төлөв байдлыг соргог түвшинд хүргэн сэргээх, тогтвортой хадгалах чиглэлээр менежментийн өөрчлөлт хийх хойшлуулшгүй шаардлага тулгарч ирлээ. Бэлчээрийн төлөв байдлыг сайжруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, бэлчээр ашиглалтыг зохистой болгох, хариуцлагажуулах замаар Монгол орны бэлчээрийн мал аж ахуйн ирээдүй, хүнсний аюулгүй байдлыг хангахад бодлого ба менежментийн ухаалаг өөрчлөлт хийх бүх талын боломж бүрэн байна. Хамгийн гол нь эдгээр боломж алдагдахаас өмнө амжиж шийдвэртэй, шуурхай ажиллах чухал" [5] гэж сануулжээ.

2017-2018 оны өвөл, хаврын бэлчээрийн даац, %
(багийн нутгаар)



(12-р зураг)

Бэлчээрийн талхлагдал. Тус улс 112.1 сая га байгалийн бэлчээртэй, малын тоо толгой сүүлийн хориод жилийн дотор бараг хоёр дахин өссөн буюу 66 саяд хүрчээ. Малын тоо толгойн хэт өсөлтөөс үүдэн, ялангуяа сумын төв, уст цэг орчимд малын хэт төвлөрөл үүсч, бэлчээр талхлагдах боллоо. 2016 онд 70 орчим толгой малыг

149.7 мянган малчин өрхийн 293.6 мянган малчин маллаж байна[6].Мөн бэлчээрийн голлох газруудад цэцэгт ургамалын тоо цөөрч байна.

Цөлжилт, газрын доройтол. Уур амьсгалын өөрчлөлтөөс улбаалан цөлжилтийн үйл явцэрчимжиж байгаа нь мөнх цас хайлах, нуур гол горхи ширгэх, бэлчээрийнургамлын гарч эрс муудах, хөрс ус давсжих, элэгдэл эвдрэлд орох, үржил шимээалдах, элсний нүүлт хөдөлгөөн ихсэх, байгалийн элдэв гамшгийн давтамжнэмэгдэх зэргээр илэрч байна. Монгол улсын нийт нутаг дэвсгэрийн 77.8 хувь нь их, бага ямар нэг хэмжээгээр цөлжилтөд өртсөн бөгөөд үүнээс 35.3% нь сул, 25.9% нь дунд, 6.7% нь хүчтэй, 9.9% нь нэн хүчтэй цөлжижээ. Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Дорноговь, Дорноговь, Өмнөговь аймгийн 30 сумдад буюу бидний судлаж байгаа тал хээрийн бүс нэн хүчтэй цөлжилтөнд хамрагдаж байна. Цөлжилтийн үйл явц сүүлийн 40 шахам жилд өмнөөс хойш тасралтгүй тэлж байгаа ба 2090 он гэхэд Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулсад хүрнэ гэсэн судлаачдын тооцоо байна.. [7]. Цөлжилтөнд хүний үйл ажиллагааны нөлөө хамгийн их байна. Үүнд: газрын тос, уул уурхайн үйлдвэрлэл , замын сүлжээ, бэлчээрийн ба газар тариалангийн эдлэн газрын доройтол, хот суурингийн газар ашиглалт, тохижилтын өнөөгийн байдал хамгийн сөрөг нөлөөтөйд (Д.Сайнбаяр, Бао Юу Хай нар болон бусад тооцоо)тооцогджээ. Сүүлийн жилүүдэд ашигт малтмалын хайгуул ашиглалтын хэмжээ эрс нэмэгдэж, одоогийн байдлаар газар нутгийн 27%-д ашигт малтмал, газрын тосны хайгуулын тусгай зөвшөөрөл олгогдоод байгаа бөгөөд цаашид 47%-д хүрэх төлөвтэй байна.


Өргөн уудам байгалийн бэлчээрийг зүй зохистой ашиглах хамгийн энгийн бөгөөд шалгарсан арга нь байгаль-газарзүйн нөхцөл болон бэлчээрийн өөрийнх нь онцлогт тохируулан мал сүргийн бүтэц,иоо толгой, нас хүйс, ашиг шимийн чиглэлийг харгалзан бэлчээр нутгийг ээлж дараатай, амраах өнжөөх, нөөцлөх системтэй хуваарь-сэлгээ ашиглах явдал юм.

Бэлчээрийн газрыг урьдаас бодож төлөвлөсөн тодорхой хуваарьгүй сэлгээгүйгээр улирлын аясыг даган нүүдэллэх маягаар ашиглахыг зохицуулалтгүй буюу дурын чөлөөт ашиглалт зохицуулалттай ашиглах гэж бэлчээр нутгийг янз бүрийн цаг хугацаанд ашиглахаар бодож хуваарилсан хувиарт хэсгийг дотор нь малын

төрөл, нас хүйсний онцлог мал аж ахуйн үйлдвэрлэлийн мөчлөг зэрэгт уялдуулан ашиглахаар төлөвлөсөн, түүнчлэн бэлчээрийн ургамлын өсөлт хөгжилтийн үе шат, биомассын сэргэлтийг харгалзан янз бүрийн хугацаанд давтан ашиглахаар бодож боловсруулсан төлөвлөгөөг баримтлан ашиглахыг бэлчээрийг зохицуулалттай ашиглах гэнэ.

1.2.1 Архангай аймгийн бэлчээрийн төлөв байдал


Архангай аймаг нийт 55,3 мянган хавтгай дөрвөлжин км газар нутагтайгаас 67 хувь нь бэлчээр. Бэлчээрийн мониторингийн дүнгээр Архангай аймгийн нийт бэлчээрийн 75 орчим хувь нь байгалийн унаган төлвөөсөө өөрчлөгдөж, харилцан адилгүй түвшинд доройтсноос нийт нутгийн хэмжээнд бэлчээрийн чанар, бүтээмж буурсан байна. Тус аймаг нь сүргийн тоогоор улсдаа тэргүүлдэг аймгуудын нэг бөгөөд 2017 оны байдлаар нийт 5,2 сая мал тоологдсон. Бэлчээрийн даац аймгийн хэмжээнд 3,2-12,2 дахин хэтэрсэн. Үүнийг сум тус бүрээр нь үзүүлье.



(13-р зураг)

Бэлчээр сэргэх чадавхийн ангиллаар, Архангай аймгийн нийт бэлчээрийн 25% харьцангуй соргоогоороо байгаа бол бага зэрэг доройтсон бэлчээр 43%-ийг эзэлж байгаа бөгөөд нийт нутгийн хэмжээнд жигд тархсан байна.

Нийт бэлчээр нутгийн 32 хувь, нутгийн баруун хэсэг, уулархаг бүсийн сумдын бэлчээр дунд зэргийн доройтолтой. Энэ нь харамсалтай мэдээ хэдий ч одооноос малын хүлийн ачааллыг цаг алдалгүй тохируулж чадвал 5-10 жилийн дотор сэргэх боломж байгаа гэсэн сайн мэдээ бас бий.



(14-р зураг)

Бэлчээрийн доройтол гэдэг богино хугацаанд бий болдог гэнэтийн өөрчлөлт бус, урт хугацаанд үргэлжилсэн үйл явцын үр дагавар аж. Бэлчээрийг доройтлын түвшин болон сэргэх чадавхиар нь таван түвшинд хуваадаг. Сэргэх чадавхийн аль

түвшинд байгаагаас хамааран бэлчээр ашиглалтын хугацаа, горим, ачааллыг тааруулах нь чухал.

Нэгдүгээр түвшин: Байгалийн унаган төлөв байдлаа алдаагүй, соргог бэлчээр. Ургацын хэмжээ бага зэрэг буурсан.Энэ нь 1-3 жилийн дотор эргээд сэргэх боломжтой.

Хоёрдугаар түвшин: Байгалийн унаган төлөв байдал нь өөрчлөгдөж бага зэрэг доройтсон. Малд идэмжтэй нарийн өвсний эзлэх хувь болон ургацын хэмжээ буурсан. Ашиглалтын горим, ачааллыг цаг алдалгүй тохируулж чадваас харьцангуй богино буюу 3-5 жилийн дотор сэргэх боломжтой.

Гуравдугаар түвшин: Бэлчээр дунд зэрэг доройтсон, ургамлын бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдөн, малын идэмж муутай зүйл ургамлын хэмжээ нэмэгдэнэ. Хөрсийг ус, салхины элэгдлээс хамгаалах, байгаль дахь ус, энергийн эргэлтийг зохицуулах чадвар нь буурч алдагдсан.Ашиглалтыг зохистой түвшинд оруулснаар сэргэх боломжтой.Дундажаар 5-10 жил шаардагдана.


Дөрөвдүгээр түвшин: Бэлчээр хүчтэй доройтож, байгалийн унаган зүйл ургамлууд лууль, шарилж зэрэг идэмж муутай ургамлаар солигдсон. Байгалийн аясаар сэргэх боломж муу, нөхөн сэргээлтийн арга хэмжээ авах шаардлагатай.

Тавдугаар түвшин: Бэлчээр маш хүчтэй доройтсоноос хөрсний өнгөн хэсэг ус, салхиар алдагдаж, гуу жалгууд үүсгэн эвдэрдэг. Байгалийн аясаар эргэж сэргэх боломжгүй, нөхөн сэргээх арга хэмжээ авах шаардлагатай.

1.2.2 Дорнод аймгийн бэлчээрийн төлөв байдал

Гамшгийн ангилал	Гамшгийн төрөл	Гамшгийн нэр	Дорнод	Сүхбаатар	Хэнтий	/Бүсийн хэмжээ
Байгалийн гаралтай	Цаг агаарын гаралтай аюулт үзэгдэл	Хүчтэй салхи, шуурга	13	36	21	70
		Цас, зуд	1	1	5	7
		Үер	3	14	7	24
		Ой, хээрийн түймэр	442	242	263	947
		Аянга, мөндөр	4	8	2	14
	Геологийн гаралтай аюул	Газар хөдлөлт	8	2	5	15
	Биологийн гаралтай аюул	Хүний гоц халдварт өвчин	3	1	3	7
		Мал, амьтны гоц халдварт өвчин	28	18	59	105
Хүний үйл ажиллагаатай холбоотой	Объектын гал түймэр		844	236	543	1623
	Усны осол		34	8	32	74
	Тэсэрч, дэлбэрэх, шатамхай, химийн бодисын осол		7	7	4	18
	Үйлдвэрийн осол		5	3	10	18
НИЙТ /аймгийн хэмжээнд/			1392	576	954	2922

(5-р хүснэгт)



(15-р зураг)

Дорнод, Сүхбаатар аймагт шүлхий өвчний 12 голомт байна. 2016 оны байдлаар Дорнод аймгийн Матад суманд хоёр, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан, Асгат суманд тус бүр гурав, Сүхбаатар суманд нэг, Баруун-Урт суманд гурав, нийт 12 голомтүүсээд байна. 81 өрхийн 365 үхэр, 70 хонь, 117 ямаа нийт 552 мал өвчилсний 199 үхэр, 32 хонь, зургаан ямааг зориудаар устгажээ.


Эдийн засгийн ерөнхий төлөв: Дорнод монголын тал хээрд байршиж байгаа гол аймгууд нь Хэнтий, Сүхбаатар, Дорнод аймгууд болно. Эдгээр аймгууд тус улсын нутаг дэвсгэрийн 18 хувийг эзэлж байгаа боловч хүн амын 6 гаруйхан хувь, ДНБ-ий 3,9 хувийг үйлдвэрлэж байгаа нь эдийн засгийн эрчимжилт төдийлэн сайн бус байгааг илтгэж байна. Дээрхи аймгуудаас Хэнтий аймаг МАА, ГТ голлосон бол, Сүхбаатар аймаг МАА, уул уурхайн үйлдвэрлэл зонхилсон, Дорнод аймаг аж үйлдвэр, барилга, эрчим хүч голлосон эдийн засгийн бүтэцтэй байгаа юм.

Ургамлын бүрхэвч: Цөлөрхөг хээр бүсэд олон наст өвс голлох боловч тэдгээрийн зүйлийн тоо цөөрч бүх ургамлын зүйлийн 43-54%ийг эзэлнэ. Хээрийн бүсэнд ч зонхилогч хялганы төрлөөс шивээт хялганы оронд говийн хялгана буюу монгол өвс,

цагаан өвс, дорнодын хялгана, Клеменцийн хялгана ургадаг.Өвс сийрэг бөгөөд тачир болж нүцгэн өвс энд тэндгүй гардаг.Хааяа заг хайлс зэрэг модлог ургамал ургадаг.

1.2.3 Сүхбаатар аймгийн бэлчээрийн төлөв байдал

2018-2019 оны Сүхбаатар аймгийн өвөл, хаврын бэлчээрийн даац, %



(16-р зураг)

Бэлчээрийн даацыг сумын нутгаар тооцоолж гаргасан дүнгээс үзвэл:

Бэлчээрийн даац Сумдын нэр	Нөөцтэй	Хүрэлцээтэй	1-3 дахин хэтэрсэн	3-5 дахин хэтэрсэн	Олон дахин хэтэрсэн
Баруун-Урт					100%
Эрдэнэцагаан	25%	37%			38%
Баяндэлгэр		50%	33%		17%
Дарьганга		25%	75%		
Асгат	75%				25%
Халзан	25%	50%			25%
Сүхбаатар	40%	20%	20%		20%
Мөнххаан		20%	60%		20%
Түмэнцогт		33%	33%		34%
Түвшинширээ	40%	40%			20%
Наран	67%				33%
Онгон		50%	25%		25%
Уулбаян		20%	40%		40%

(17-р зураг)


1.2.4 Завхан аймгийн бэлчээрийн байдал

Судлаачдын 2017 онд хийсэн судалгааны үр дүнд: "Завхан аймгийн хадлан бэлчээрийн нийт талбай 7850.3 мянган га бөгөөд үүний хамгийн их 72,8% буюу 5712.722 мянган га талбайд хээрийн бэлчээр, хамгийн бага талбайг 8,2% буюу 650.669 мянган га талбайг өндөр уулын ургамалжил эзлэж байна.

Завхан аймгийн хадлан бэлчээр нь биологийн үнэлгээгээр чанарын IV, V, VI бүлэгт хамрагдаж байна. Тэжээлийн эдэлбэр нутгийн жилийн нийт багтаамж 5660.9 мянган хонин толгойд байна. Бэлчээр нь зуны дээд ургацаар бодоход 55975.15 мянган цн ургацын нөөцтэй бөгөөд үүнээс тэжээлийн өндөр ургацтай чанарын I

бүлэгт голыг сав, нуурын хөвөөний, нуга, нуга-намгийн, харьцангуй өндөр ургацтай чанарын III бүлэгт татмын нутаг, нуга-намгийн тэжээлийн эдэлбэр ордог" [8] байна.

2017-2018 оны Завхан аймгийн өвөл, хаврын бэлчээрийн даац, % (багийн нутгаар)




(18-р зураг)

1.2.5 Говь-Алтай аймгийн бэлчээрийн төлөв байдал

Говь-Алтай аймгийн хувьд нийт нутаг дэвсгэрийн 73.5%-ийг бэлчээр(2010 оны байдлаар) эзлэх ба үүний 34.3%-ийг дундаж болон нам, бэсрэг уулын бэлчээр, 21.1%-ийг цүлийн бэлчээр, 18.2%-ийг цөлөрхөг хээрийн бэлчээр, 9.2%-ийг өндөр уулын бэлчээр, 6.1%-ийг хээрийн бэлчээр, 5.6%-ийг голын хөндий, нам, хотос нугын бэлчээр, 0.3%-ийг өндөр уул хоорондын нугын бэлчээр тус тус эзлэх ба 5.2% нь бэлчээрт тохиромжгүй газар эзэлж байна.

Гэвч сүүлийн жилүүдэд бэлчээрийн ургац, тэжээлийн шимт чанар буурах, ургацад малын тэжээлийн ургамлын эзлэх хувь багасах, бэлчээрийн газарт хортон

шавьж, мэрэгчид тархах, зам болон уул уурхайн үйл ажиллагаанд өртөх, хог хаягдлаар бохирдох зэргээр бэлчээр доройтолд нэрвэгдэх нь улам бүр нэмэгдэж байна. Бэлчээрийн төлөв байдал, чанарын улсын хянан баталгаагаар (2010) Говь-Алтай аймгийн нийт бэлчээрийн 14.4% буюу 1556127.4 га бэлчээр дунд зэрэг, 0.82% буюу 88385.6 га нь хүчтэй доройтсоны дээр 40016 га бэлчээр автогений нөлөөнд, 62843 га нь техногений нөлөөнд тус тус өртөж, 297719.1 га бэлчээрт хортон мэрэгчид тархаж, 230 га бэлчээр ахуйн хог хаягдалд бохирдсон байна.



(19-р зураг)

Бэлчээрийн доройтлын хэмжээг сумдаар авч үзвэл, Халиун, Цээл, Алтай, Бугат, Жаргалан сумдын нийт бэлчээрийн 10 хүртэл хувь нь дунд зэрэг доройтсон байгаа бол Есөнбулаг, Тайшир, Төгрөг, Чандмань сумын нийт бэлчээрийн 20 хүртэл хувь, Тонхил, Цогт, Дэлгэр, Дарви, Хөхморьт, Шарга, Эрдэнэ сумын бэлчээрийн 20-25%, Баян-Уул, Бигэр сумын нийт бэлчээрийн 40-50% нь тус тус дунд болон хүчтэй доройтсон байна.

Ийнхүү бэлчээр доройтож байгаагийн нэг шалтгаан нь бэлчээр ашиглаж ирсэн уламжлалт болон шинжлэх ухааны үндэслэлтэй менежментийн аль аль нь алдагдаж, зөвхөн малын тооны өсөлт, малын ашиг шимийн нэмэгдлийг эн тэргүүнд тавьсны улмаас бэлчээрийн даац хэтэрсэн, сүргийн бүтэц алдагдсан, бэлчээрийн усан хангамж эрс муудсаны зэрэгцээгээр дэд бүтцийн хөгжлийн түвшин зэргээс улбаалан төв, суурин газар, уст цэгийн орчим болон зам дагуу хүн, мал ихээр төвлөрсөн, бэлчээрийг зохистой ашиглах арга туршлагатай хүмүүс ховордсон, бэлчээрийн менежментийн талаархи мэргэжилтэн, малчдын мэдлэг чадавхи сул, орон нутгаас бэлчээрийн ургамалжил, түүний төлөв байдал, ашиглалтанд тулгуурлан зохистой ашиглах, сайжруулах, хамгаалах ажлыг удирдан зохион байгуулж, хэрэгжүүлэх, хэрэгжилтэнд хяналт тавьж, зохицуулах, малчдыг бэлчээрийн менежментийг хэрэгжүүлэхэд татан оролцуулах ажил хангалттай хийгдэхгүй, төрийн бодлого зохицуулалт сул, хөрөнгө санхүүжилт хүрэлцээгүй зэрэгтэй шууд холбоотой.

1.2.6 Бэлчээрийн тухай нүүдэлчдийн уламжлалт ойлголт

Дэлхийд уур амьсгалын өөрчлөлт хэт дулаарах, хүйтрэх зэргээр хэлбэлзэлтэй байна. Цаашид ч дулаарал явагдахыг ихэнх судалгаа харуулж байгаа төдийгүй бүс нутаг, улс оронд харилцан адилгүй байгаа ч сөрөг нөлөө нь адил байна. Уур амьсгалын өөрчлөлт далайд гарцгүй орнуудын хувьд цөлжилт, газрын доройтол нэмэгдэх, хур тунадас багасах, цас мөс хайлах зэргээр явагдаж байгаа бол арлын жижиг улсуудад далайн түвшин нэмэгдэн хуурай газрын хэмжээ багасч байгаа нь нийтлэг үзэгдэл болжээ.

Байгалийн энэхүү хувирамтгай дүр төрх нь хуурай сэрүүн уур амьсгалтай, эх газрын Монгол орны бэлчээрийн зүй тогтолд нөлөөлж, нүүдэлчдийн мал сүргийн бүтэц, тоо толгойд уламжлалт түшиглэсэн шинэлэг зохицуулалт хийхийг шаардсаар байна. Зарим бүс нутгийн малчдын мал маллагааны арга туршлага уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр өөрчлөгдөж байгаа нь тэдний дунд хийсэн судалгаагаар мэдэгдэж байна.

Олон мянган жилийн өмнөөс монголын нүүдэлчид дэлхийн цаг агаар уур амьсгалын жам ёсны өөрчлөлт, бэлчээрийн тогтуун удаан хугацааны хувиралттай

өнөө үеийнх шиг цаг ямагт дасан зохицсоор иржээ. Тиймээс монголын нүүдэлчин малчид бэлчээрийг тухай дараах уламжлалт ойлголттой байна. Үүнд:

1. Хангайн бэлчээр;
2. Тал хээрийн бэлчээр;
3. Говийн бэлчээр; гэж ерөнхийлөн ангилж, түүнд сүргийн бүтэц, малын тоо толгойгоо тохируулсаар иржээ.

Монгол нүүдэлчдийн хангайн бэлчээрт аль ч бүс нутгийн уулархаг, нөмөрлөг хэсэг нь тооцогдсоор ирж. Нутаг нутгийн малчид хангайн бэлчээртээ голлон өвлийн улирлыг өнгөрөөдөг уламжлалтай. Хээрийн бэлчээр нь нам дор бөгөөд бартаа саад багатай, бас дов толгодоор элбэг нөмөрлөгдсөн бэлчээр зонхилох аж. Ийм хээрийн шинжтэй бэлчээрт хавар мал төллүүлэх "үндсэн бэлчээр" болон "завсрын бэлчээр" болдог.

Говийн бэлчээр нутаг нутагт тийм ч түгээмэл биш бөгөөд ялангуяа Монгол Хангайн нуруу, Хэнтий нурууг арлан нутагладаг нүүдэлч малчдад бараг байхгүй төрлийн бэлчээр юм. Харин Алтай нурууны малчдад говийн бэлчээр түгээмэл байна. Хангай нурууны өвөр хийгээд баруун бүсийн малчдад говийн бэлчээр элбэг аж. Жишээ нь, Завхан аймгийн баруун бүсийн ихэнхи нутагт хангай, хээр, говийн бэлчээр хосолсон уламжлалт тогтоцтойгоороо онцлог билээ.

Тэгвэл Өмнөговь аймгийн баруун хойд болон төвийн бүсийн бэлчээр нь говь зонхилж байгаа хэдийг Алтай нурууны зүүн үзүүр учир тэнд "хангайн бэлчээр" гэх үзэл малдын оюун санаанд удамшчээ. Нэг үгээр хэлбэл, монгол орны байгаль газар зүйн аль ч бүсийн малчид уул хангайн бэлчээртэй байгаа нь сонирхолтой юм. Тиймээс хангай нутгийнхан говь, тал нутгийнхныг дов толгодоо уул, хангай, хайрхан гэж нэрлэлээ, ингэж зааж байна гэж гайхдаг билээ.

Нутаг нутгийн энэхүү бэлчээрийн зүй тогтолын тухай уламжлалт ойлголт, үзэл баримтлал нь сүргийн бүтэц, малын тоо толгой, хариулга маллагаанд үндсэн хүчин зүйл болсоор иржээ.


Судлаачид монгол орны малын бэлчээрийг дараах байдлаар нарийвчлан ангилжээ.

- Өндөр уул

- Тайга
- Ойт хээр
- Хуурай хээр
- Цөлөрхөг хээр г.м.


Эдгээрээс өндөр уул, тайга зэрэг байгалийн тогтоц нь малын бэлчээрээр ашиглагдах тохиолдол ховор билээ. Харин Ойт хээр, хуурай хээр, цөлөрхөг хээрийн бүс нутагт монгол орны нүүдэлчдийн малын бэлчээр зонхилж байна.

Ойт хээрийн бэлчээр




(20-р зураг.Зургийг "Монгол орны бэлчээрийн төлөв байдлын үндэсний тайлан 2018", 34-р тал)

Хуурай хээрийн бэлчээр



(21-р зураг.Зургийг "Монгол орны бэлчээрийн төлөв байдлын үндэсний тайлан 2018", 45-р тал)

Цөлөрхөг хээрийн бэлчээр



(22-р зураг.Зургийг "Монгол орны бэлчээрийн төлөв байдлын үндэсний тайлан 2018", 56-р тал)

Бид хээрийн судалгаагаа Монгол орны бэлээчээрийн мал аж ахуйн дээрх үндсэн гурван бүсийн хүрээнд гүйцэтгэх зорилго агуулсан билээ. Тодуулбал, ойт хээрийн бүс буюу Архангай аймаг, хуурай хээр буюу Дорнод аймаг, цөлөрхөг хээрийн бэлчээр буюу Завхан аймгийн Ургамал сум, Говь-Алтай аймгийн Шарга сумдын малчидтай ярилцаж, цаг уур амьсгалын өөрчлөлт, сүргийн бүтэц, тоо толгойг бэлчээртэй хэрхэн зохицуулан адгуулж ирсэн тухай судалгааны эх хэрэглэгдэхүүн цуглуулав.

1.3 Сүргийн бүтэц, тоо, толгой ба бэлчээр ашиглаж буй байдал

(хээрийн судалгаа)

1.3.1 АРХАНГАЙ АЙМГИЙН ӨГИЙНУУР СУМЫН ТОГЛОХ (1-РБАГИЙН МАЛЧИН БОРЖИГИН НАВГАНЫ ЖАГАРДАМБА



(23-р зураг)

- Нутгийн бэлчээр, отор, улирлын нүүдлийн онцлог?

Таван хошуу малаас тэмээнээс бусдыг маллаж байна. Адуу, үхэр, хонь, ямаа бүгд л байна. Манай нутаг эртнээсээ хонь, ямаанд их сайхан тохиромжтой. Үхэр маллахад хэцүү. Цаг үеийн байдал нь ч хүнд байна. Адуу, хонь хоёрт бол яах вэ, гайгүй. Отор нүүдэл нэг их хийдэггүй, ууланд өвөлжөөд, цөөн хэдэн малтай болохоор

отор нүүдэл хийгээд явдаггүй. Жилдээ бол 3-4 нүүдэг, өвөлжөөнөөс хаваржаандаа буугаад, зусландаа гардаг. Өвөлжөө, хаваржаа хоорондоо ойрхон 10 км гаран л зайтай даа. Отор нүүдэл хийх боломжтой. Цэнхэрээр \Цэнхэр сум\ манай нэг хүргэнийх байдаг, хааяа тийшээ отор хийдэг юм. Хадлан яахав дээ, хадлангийн талбай гээд тусгай газар байхгүй, өөр сумдаас хадсан өвс худалдаж авдаг.

-Бэлчээрийн даац

Бэлчээрийн даацын асуудал хүнд байна. Үлийн цагаан оготно их байна, өвс ногоо юу ч байхгүй. Өвс ногоо муу ургаж байна. Энэ жил харин жаахан гайгүй байна. Энэ хавар бол муу гарсан шүү дээ.

-Өвөлжилт

Сумынхаа төвөөс өвс хадлан аваад л, өнгөрсөн жилийн хувьд бол нэг тонн шахуу өвс худалдаж аваад хэдэн малаа үхүүлэхийг нь үхүүлээд лонд оруулсан.

-Бэлчээрийн асуудал

Энэ асуудал бол үнэхээр хүнд байна. Гол ус ширгэж байна. Үнэхээр хэцүү байна. Ундны ус ч бас асуудалтай л байна. Үхсэн малын сэг зэмд бузартдаг юм уу?, гол ус ширгээд хэцүү байна. Уул уурхай манай энэ хавьд байхгүй, харьцангуй гайгүй. Харин бэлчээрийн гарцаас л шалтгаална.

-Зуданд үрэгдсэн малын сэгний цэвэрлэгээ

Цэвэрлэх ажлыг хийсэн. Манай сум орон нутгийн удирдлагаас үхсэн малын сэг зэмийг булж нэлээд цэвэрлэсэн. Энэ хавар манай энд мал их үхсэн л дээ. Багуудаар яваад, тэр малын сэг зэмийг трактор, газар ухдаг техниктэй ирээд булуулсан.

-Малчны залгамж, малын тоо

Би 3 хүүхэдтэй, нэг банди, хоёр охинтой. Ганц хүүгээ бараадаад л мал дээр байна. Хүү тусдаа гараагүй цуг амьдардаг. Хоёр охин айлын хүн болоод тусдаа гараад явсан. Хонь, ямаа нийлсэн 300 гаран малтай, үхэр 30 гаран байна.

-Бэлчээртэй холбоотой уламжлалт зан үйлийн уламжлал

Уул усаа тахьдаг юм байхгүй, тахиж тайдаг хүн ч байхгүй, уул нь тахиж тайдаг байсан юм гэдэг. Одоо тэгээд мартагдаж байна. Уул нь манай энэ арын уул, Сантын нарийн хошууг тахиж байсан гэдэг.

1.3.2 АРХАНГАЙ АЙМГИЙН ӨГИЙНУУР СУМЫН ТОГЛОХ БАГИЙН САНТЫН НАРИЙН ХОШУУГААР НУТАГТАЙ ЗАЛУУ МАЛЧИН ДАВААСАМБУУГИЙН НЭРГҮЙ.

/БОРЖИГИН, 1985 ОНЫ ҮХЭР, ЭРЭГТЭЙ/



(24-р зураг)

Намайг Даваасамбуугийн Нэргүй гэдэг. Энэ нутагт тусдаа айл өрх болоод ирсэн, 7, 8 жил болж байна. Урьд нь Тоглохын ар шилээр нутагладаг байсан.

-Сүргийн бүтэц, малын тоо, толгой

Үхэр, адуу, хонь, ямаа гэсэн 4 төрлийн мал маллаж байна, тэмээ байхгүй. 300-аад мал маллаж байна. Манай энэ нутаг хонь ямаа маллахад их тохиромжтой. Өвөл зуд зурхан болоод хэцүү л байна.

-Өвөлжилт ба улирлын бэлчээр

Энэ хавиасаа хадлан авдаг. Өвс тэжээл худалдаж авдаг даа. Сүүлийн үед отор нүүдэл хийсэнгүй ээ. Жилдээ нэг, хоёр нүүдэллэдэг дээ. Зуслангаасаа хойшоо өвөлжөө рүүгээ буугаад, хавар өвөлжөөнөөс хаваржаанд буугаад зусаад буцдаг даа. Тэжээлийг голдуу худалдаж авдаг. Өвөлжөө хойшоо 5,6км, хаваржаа нь өвөлжөөнөөс 6,7 км зайтай, өөр нүүдэл суудал хийдэггүй. Өвөлжөө хаваржааны тогтсон нэг газартаа, өөр газар хаварждаггүй. Малаа хойшоо уул руугаа лав гаргаж тарга хүч авахуулдаг даа.

1.3.3 АРХАНГАЙ АЙМГИЙН ӨГИЙНУУР СУМЫН ТОГЛОХ БАГИЙН ЗАЛУУ МАЛЧИН ДЭМБЭРЭЛЖАМЦЫН ГАНБААТАР \ӨӨЛД\ 1970 ОНЫ НОХОЙ ЖИЛТЭЙ, ЭРЭГТЭЙ.



(25-р зураг)

Намайг Дэмбэрэлжамцын Ганбаатар гэдэг. Архангай аймгийн Тоглох багийн малчин. Мал маллаад 27 жил болж байна. 1988 онд цэрэг явж ирээд, түүнээс хойш мал маллаж байна. Цэрэгт явахаасаа өмнө мал маллаж байгаагүй. Сургууль соёлд яваагүй. Манайх Өгийн буудал, манай ээж тэнд тогооч хийдэг байсан. Хувьчлалаас хойш мал маллаад байж байна.

Би голдуу хонь маллаж байсан, нэг хэсэг 2 тэмээтэй байсан. Тэмээгээрээ бургас мургас зөөж байсан, хэр хэмжээний л юм хийж байсан. Тэгээд хоёр тэмээгээ алдсан.

-Бэлчээрийн онцлог, тулгамдаж буй асуудалд

Бэлчээрийн даац хонь ямаанд бараг шулуун юм байна даа. Би чинь цөөхөн хэдэн адуутай байсан, хэдэн адуугаа зуданд алдахыг нь алдаад, хулгайд алдахыг нь алдаад дууссан. Одоо хэдэн хонь ямаа л өсгье гэж бодож байна. Ерөөсөө, үхэр ч гэсэн өсгөж болмоор л юм байна. Өвс нь гарахгүй юм байна шүү дээ. Цагийн байдал тун төвөгтэй байна. Өвс хивэг авчих юм бол гаднаа ч гэсэн тэжээж болохоор л юм. Хадлан тариагаа бол одоо яах вэ?, нэг их хадаад байх газаргүй, манайхан чинь голдуу хивэг, будаа худалдаад авчихдаг. Би хоёр морь тэжээгээд л, хивэг будаагаар л онд оруулчихдаг шүү дээ. Үхрийг ч гэсэн хивэг будаагаар тэжээгээд л оруулчихдаг. Малыг нэг үхүүлье гэж бодохгүй, болвол онд оруулчихья л гэж боддог л юм.

-Улирлын нүүдэл ба бэлчээр

Манайх жилдээ хоёр нүүдэг. Хаваржаа дээр буугаад, өвөлжөө дээр буугаад л болдог. Нэг их нүүдэггүй дээ манайх. Нүүгээд ч өвсгүй газар хаа явах вэ?, тээр жил Хайрхан \сум\ руу отроор явж байсан. Бэлчээрийн даацхэцүү байна. Манайхан бол амраадаг юм. Манайхны мал өвөл болохоор гарч ирнэ үү гэхнээс одоохондоо гарч ирэхгүй шүү дээ. Тэгээд өвөл болохоор чинь хүн, хүн тал талаас шавчих юм байна шүү дээ. Адуу мал бол энд тэндээс гарч ирнэ шүү дээ, адуу, үхэр, хонь гээд л, адуу голцуу отроор орж ирнэ дээ, манайхны ийшээ. Тэгээд газар шаллах \талхлаж\ юм байна шүү дээ. Айл айлын адуу нийлсэн овоо адуу орж ирэх юм байна шүү дээ. Багцаа хараад байхад.

Өнгөрсөн жилих хүнд өвөл болсон, энэ өвөл будаа хивэгт яваад л таарах шүү дээ. Жаахан ноолуурыг чинь хивэг, будаандаа өгөөд л таарлаа. Энэ өвөл овоо юм олж авсандаа л аяыг нь даалаа. Өвс, тэжээлийг худалдаж л авсан. Өвс гэхэд нэг боодлыг нь 12 000 төгрөгөөр авсан. Нэг боодол өвсийг үхэр, хонь, ямаанд тавьж өгөхөд юм болохгүй юм байна лээ, 2 боодлыг л тавьж өгөхөд л яахав гайгүй дээ нэг өдөрт. Өглөө оройд нэг, нэг боодол тавьж өгдөг. Жижиг өвс бол дэмий юм байна лээ,

сүүлийн үед боодол нь жижигхэн болсон юм байна лээ. 8000, 9000-р ч өвс авсан, 12000-аар ч авс авсан Батцэнгэл сумаас.

-Мал маллагааны арга

Манай хонь байнгийн л энэ хойд уулаараабайдаг даа. Голоор ч шивээ нь ихэдчихээд, жаахан шивээ багатай газраар билчээрлүүлэхгүй бол мундаг байна. Шивээ бол хонь малд зоогдчихдог, хурга ишигний бол нүдэнд нь зоогдчихдог. Уул нь бол шивээ их гарахаар өвөл мал их иддэг. Өвөлдөө шивээ, дэрс хоёр чинь л малын хоол болж байна шүү дээ. Бургас байна, бургасны намиаг чинь үхэр иддэг. Харз их сайн, харзын усаар услах их сайн. Өвөлд өнжөөд нэг юм уу, дулаан үеийг нь харж байгаад нэг услачих бол харзны ус хамаагүй илүү байдаг. Мал тарган орох чинь харзны устай холбоотой. Өвөл нь харзны усаар усалдаг, манайхны үхэр чинь байнга л харз уудаг. Цасны ус малд ус болдоггүй, унд болдоггүй. Ус их чухал, дээр үед намайг хүүхэд байхад ёнгис \усны төмөр сав\-оор ус зөөж услаад байдаг байсан, тэр чинь их зөв юм байсан байна лээ. Цасны усанд бол мал ундаашихгүй. Хужрыг бол манайх машинаар татаад авчихдаг юм. Манай энэ хавиар бол хужиртай, хойноос ч авдаг, дор Цайдамаас ч авчихдаг. Эндээс 40, 50 км зайтай. Өвс хужир, сэвстэй холиод малд өгөхөд сайн байдаг. Идэшний үеэр, идсэн адууныхаа сэвстэй холиод, том том тогоо, саванд хийгээд тавьчихвал дараа нь ховхлоод, ховхлоод авчихдаг. Адуу, үхэр гээд бүх малд өгч болно. Тэгээд тавьчихаар мал их сайн иддэг.

Гол нь энэ залуу малчид байна, эд нарыгаа сайхан дэмжээд явбал их л өөдрөг байхсан. Энэ жил цаг агаар их хүнд байсан, малчдын сэтгэл санаа жаахан унасан. Харин одоо бол их сайхан байна. Өвс ногоо нь гарчихаар. Ноос нэхий нь үнэд ороод ирэхээр улсууд их өөр, өөдрөг байна шдээ. Энэ өвчин энээ тэрээ гараад, морь мал уяхгүй болохоор улсууд нэг их явж мэдэгдэхгүй юм. Тэрнээс энэ морь мал уяад, найр наадмаа хийвэл ч сайхан л байна. Сайхан сайхан наадам болдог шүү дээ манай Батцэнгэл.

Ер нь байгаль дэлхий хүнд байна даа. Хивэг, будааг хотоос олж ирнэ, хөдөө ирэхээрээ үнэ нь өснө, нэг нь 15000 болчихно, 15000 нэг шуудай хивэг аваад малд өгөхөд 2 хонохгүй, өдөртөө л дуусаж байгаа юм чинь. Тийм болохоор хивэг, будаа

зэрэг тэжээлийг өөрсдөө гардаж хийвэл болмоор юм уу гэж дотроо бодох юм. Техник технологи хөгжсөн үед орон нутагтаа өөрсдөө тариа будаагаа тариад байвал болмоор, будааг чинь 6-р сард бороо оронгуут л таривал болдог. Хоёр морь тэжээж унадаг болохоор хивэг будаа их л орох юм. 1 тонн будаа юм болохгүй юм байна лээ. Хавар 4,5-р сар хүртэл өгөхөөр чинь.

-Малын түүхий эд, ашиг шим

Энэ жил харин ноолуур үнэд орж хивэг будааны өрийг овоо дарж өглөө дөө. Арьс нэхий ч гэсэн үнэд ормоор байна. Хонины ноос энэ жил бол 3000 төг, бас ч болж байна. Энэ бол хэн хэндээ, авч байгаа улсууддаа ч гэсэн ханасан үнэ байна. Хараад байхад тонн ноос өгөхгүй айл байхгүй. Ноосноосоо 2-3 сая төг авч байгаа айлууд ч байна. Тэгэхээр бол болж байна л байна. Хэзээ хонины ноос ийм үнэтэй байлаа даа. Одоо бол эсгий 120 000 төгрөгтэй л болсон байна лээ. Болж л байна л даа, нэг эсгий тийм үнээр авна гэдэг чинь. Эсгийг үйлдвэрээр хийлгээд авчихна. Дээр үед бол гар эсгий хийдэг л байсан. Гар эсгий хийж чадахгүй байхаа одоо.

Хөөвөр мөөвөр ч ерөөсөө авахгүй юм байна. Харин сарлагын хөөвөр л авдаг юм байна лээ. Сарлагийн хөөвөр чинь кг нь 7-8000 төг байдаг юм байна лээ. Тэмээний ноос ч гэсэн 10 000 орчим л байдаг юм байна лээ. Би сая нэг айлд хэдэн тэмээ хяргаж өгсөн тэгж ярьж байсан. Уул нь бол хонины нэхийг л жаахан үнэд оруулж өгмөөр байхын, одоо тэгээд бас шивээтэй болчихдог юм даа. Манайд бол өөрсдөө нэхий боловсруулдаг газар байхгүй, чадахгүй юм чинь, одоо яахав. Уул нь бол өөрийнхөө суманд боловсруулдаг, тэрийгээ өгдөг бол зүгээр юм.

-Эцэг мал сонгох арга

Би хотоос үзэсгэлэн худалдаанаас нэг ухна авч байсан, 150 мянга гэдэг юм байна лээ. Сэлэнгэ аймгийн гаралтай ухна. Тухайн хуц, ухнаасаа л хамаардаг юм байна лээ үнэ нь. Ноолуурын гарц, бие хаа нь өөр болдог юм байна лээ. Манайх бол алаг ямаа овоо болсон. Төл сайтай. Би бас Хэнтийгээс нэг азарга авч ирж байсан. Төв аймгаас ч нэг азарган үрээ авч л байсан. Залуу малчдыг л их дэмжвэл зүгээр байна.

-Мал эмнэлгийн хүртээмж

Энэ мал эмнэлэг хувьд гарах гээд байна уу?, улсадаа үлдэх гээд байна уу?. Мал эмнэлгийн хүртээмж бол бас боломжийн байна. Улсдаа байвал зүгээр л байна, маньд л хэрэгтэй. Даатгал энээ тэрээ гээд. Хувьд гараад бол нэмэр байхгүй ээ. Вакцин энээ тэрээг хийхгүй, мань тэр вакцины мөнгө төгрөгийг хүчрэхгүй шүү дээ. Одоо вакцин хийнэ гэхэд л өөрсдөө авч хийж байна, өөрсдөө явж хийж байна. Айлд очиж тарихаар бүл хүч муутай улсууд яах вэ?. уул нь хонийг нэг угаадаг, одоо угаана л гээд байгаа, хэзээ угаах юм бүү мэд. Шүлхий гарлаа л гэхэд тэр малыг чинь кардин \мал ариутгах шингэн\-аар л угааж байсан гэж манай эмээ ярьдаг байсан. Батцэнгэл сумаас 2,3 хүнээс асуухад тэгж л ярьж байна лээ. Одоо угааж байгаа нь их чанар муутай, усаар шүршээд хаячихдаг, их бүтэмжгүй харагдаад. Уул нь тэрийг нэгэнтээ л зардал гарч байгаа юм чинь дөмөгхөн хийвэл их сайн юм уу л гэж бодоод байгаа юм.

Манай сумын мал эмнэлэг чинь хувьдаа гарсан мал эмнэлэг. Тэр болгонд хүрч ирээд байдаггүй, дуудлага өгвөл ирэх байх, дуудлага өгөхгүй бол ирэхгүй шүү дээ. Нэг бол улсдаа байгаа гэдэг, улсдаа байгаа, хувьдаа байгаа нь сайн мэдэгдэхгүй, ер нь бол мал эмнэлгийн хариуцлагыг өндөржүүлэх шаардлагатай байна. Энэ жил гэхэд малд хордлогын тариа хийсэнгүй шдээ, энэ тариаг 2 жил хийсэнгүй. Нодлин жил нэг хийгээд байсан энэ жил бүр хийхээ байлаа. Юмыг хийе, бүтээе гэсэн залуу малчид байна, тэд нарыг улсаас туслаж, дэмжээд өөд нь татаад явбал их зүгээр байна. Мал эмнэлэгийн тал дээр дэмжлэг шаардлагатай байна малчдад. Энэ ойр хавийн, голын орчмын малын сэг зэмийг булж янзалмаар байна. Хоёр, гурван удаа багийн даргад хэллээ, “очиж булна” гэж хэлчихээд яваад өгдөг, байхгүй. Малчид санаа гаргаад тэр техник энээ тэрээгээ авч ирээд өгчих өө, өөрсдөө булъя гэсэн одоо болтол байхгүй. Бид тэр сэг зэмийг булах гээд Мөөгөө \саахалтын малчин\ -тэй хамт өтөг хүртэл аваачиж асгасан. Одоо дулаан болохоор үнэр нь үнэртээд хэцүү байна. Энэ бол өнгөрсөн хаврын зуднаар үхсэн малын сэг зэм, нэг газар бөөгнүүлээд овоолсон юм. Сум орон нутгийн удирдлагууд үүнийг анхааралдаа ерөөсөө авахгүй юм. Орон нутгаар явж малчдынхаа санал, сэтгэлийг ер сонсохгүй, нэг үзэгдээд алга болдог. Малчдынхаа төлөө ерөөсөө явдаггүй, заримдаа даргатай эсэхээ ч мартаж юм даа.

Манайх Хэрэм, Улаан талаар нутаглаж байсан, сүүлийн хэдэн жил бэлчээр үнэхээр доройтож байна.

Тамир голын хойд эрэгт зусаж байхад, гэрт нь хүрч сурвалжлав.

**1.3.4 АРХАНГАЙ АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН БАЙШИР \3-Р\ БАГИЙН
МАЛЧИН ПҮРЭВДОРЖИЙН АНХБОЛД \УРГИЙН ОВОГ ӨӨЛД\ 1978 ОНЫ МОРЬ
ЖИЛТЭЙ, ЭРЭГТЭЙ.**



(26-р зураг)

-Мал маллагаа, ашиг шим

Би Архангай аймгийн Өлзийт сумын малчин Пүрэвдоржийн Анхболд гэдэг хүн байна. Манай тэр нутаг ус унд багатай, булаг шанд тиймэрхүү газар болохоор их ус бараадаж гол руугаа оторлоод орж ирсэн юм энэ жил. Энэ жилийн хувьд зун нь оройхон ч гэсэн сайхан болж байна. Энд хэдэн малаа таргалуулж аваад л нутаг буцна даа.

Малчид бол хамгийн эхэнд байгалийн эрхшээлд л амьдардаг улсууд шүү дээ. Тэгээд л байгалийн аяыг л дагаж яваа хүн байхгүй юу. хамгийн тулгамдсан асуудал бол хүүхэд 6 настай сургуульд орж байгаа, сургуульд хүүхэд орохоор үндсэндээ гэр бүл салалт болоод явчихаж байгаа юм. 6 настай гэдэг чинь бараг өлгийтэй шахуу

хүүхэд шүү дээ. Бид нар 8 настай сурч байхад хэцүү л байсан. Тэгэхээр энэ чинь төв рүү эхнэр нь хүүхдээ авч явж таарна, нөхөр бол хүүхдээ харна гэж юу байхав, эхнэр хүн морь малдаа явах биш. Ер нь сонсож байхад малчдын хүүхдийг 6-8 насны хооронд өөрсдийн боломжоор нь сургуульд оруулах асуудал яригдаад байгаа юм байна лээ. Тэр бол бас их таалагдаж байгаа шүү дээ. Тэгэхийн бол энэ жил 6 настай хүүхдээ оруулахаа болиод ирэх жил 7 настай оруулъя гэдэг юм уу, нэг иймэрхүү байдал байж болно нэгдүгээрт ийм байна.

Хоёрт, тулгамдаж байгаа асуудал гэвэл одоо отрын бүс нутаг гэж байхаа ерөөсөө больсон. Үнэндээ тийм газар байхгүй, худлаа. Яагаад гэхээр тэр ч манай өвөлжөө, энэ ч манай зуслан гээд бүгд эзэнтэй болоод хөөж туугаад хэцүү, ийм л байгаа шүү дээ. Би бол хадмуудын нутагт ирсэн болохоор намайг яах ч үгүй л байна даа. Энэ голоос хөөх хүн байхгүй. Ер нь бол малчдад хамгийн наад захын тулгамдаж байгаа асуудал бол энэ юм. Энийг ард иргэд, засаг захиргаа зохицуулаад явах хэрэгцээ шаардлага байна. Нэг газарт буухад л манай өвөлжөө гэдэг, нөгөө талаар бол өвс ногоо ургаж байгаа өвөлжөө, хаваржаагаа сайхан хамгаалах ёстой. Энийг л төрөөс зохицуулах хэрэгтэй байна. Мал төрийн хамгаалалтанд байдаг гэсэн болохоос биш малчин төрийн хамгаалалтанд байна гэсэн юм байхгүй. Ингэхээр их сонин. Би өнгөрсөн хавар Улаанбаатар хотод болсон “Мянган малчны зөвлөгөө”-нд оролцоод ирсэн. Тэнд бол их сайхан юм яригдаж л байна. Бэлчээр хамгаалах тал дээр бол зөвхөн төр биш малчид өөрснөө хамгаалчихаж болмоор юм байгаа юм. Байнга нэг л газарт өвөлжөөд, хаваржаад, зусаад байвал яах вэ?. нэг морийг байнга унаад байвал нуруугаа авна шдээ, үүнтэй л адилхан юм байхгүй юу. Малчид өөрсдөө нэгдэж чадвал боломж байна. Жишээлбэл, Булганы Могод сумын зөвхөн Хужиртад нутагладаг улсууд Хужиртын голоо сэргээе гэсэн аян зохиогоод, тэр голоороо нутаглахгүйгээр айл амьтны зай завсраар нутаг сэлгэж 3 жилийн элс болсон байсан Хужиртын гол 3 жилийн дараа ирэхэд морины өвдгөөр татсан өвс ногоо ургадаг л юм байна лээ. Энэ мэтийг болвол малчид өөрснөө бодож, зарим газрынхаа нурууг нь амраах ёстой. Тэгээд одоо нурууг нь амраая гэхээр малчин нь олон болсон. Малчид өөр өөрийн нутагтай болсон. Тийм учраас өөрсдийн нутгаа сэргээхийн тулд малчид хоорондоо зөвлөлдөөдхийх юм бол үнэхээр нутаг ус нь сэргэж байна.

Өвс хадлан тэжээлийн хувьд бол байгалийн бэрхшээлд байдаг улсууд чинь, дөнгөж 4 хуруу ургаж байгаа өвсөн дээр төө цас орлоо гэхэд идэх юм байхгүй, ингээд отор нүүдэл хийх гэхээр өөрийн хэдэн малаа онд оруулах гэж байгаа хүн чинь бид нарыг очихоор хажиглана. Өнгөрсөн жил 20 кг хүрэхгүй шахуу боодол өвс 10 гаран мянган төгрөг болж байна. Тав, зургаан зуун малтай ч хүн байна, тавь, жаран малтай ч хүн байна, хоёр, гурван мянган малтай ч хүн байна, нэг боодол өвсийг хаана нь тавьж өгөх вэ?, хэцүү байгаа биз дээ. Тэгэхээр чинь малынхаа тоогоор өвс өгнөө гэхэд өдөрт хэдэн боодол өвс өгөх вэ?. Зүгээр жишээ бодоод үзэхэд, өдөрт малынхаа амных нь завааг гаргъя гэж бодоод 10 боодол өвс тавьж өгөхөд зуун гучин мянган цаасаа тэр хүн өглөө гаргаад л шидэж байна гэсэн үг байхгүй юу. Малчин гэдэг чинь зовлонтой амьдрал байхгүй юу. хотын улсууд яриад байгаан, 60 сая малтай байж бид нар махаа үнэтэй авч байна гэж, тэгэхэд 60 сая мал гэдгийг чинь маллаж байгаа хүн нь хэд байгаа билээ, тэр хүмүүсийн амьдрал юу байгаа вэ, тэд малаа их үнэтэй зараад байгаа зүйл биш шүү дээ. Өглөө зурагт харахад ерөнхийлөгч ярьж байна, 1 кг махыг 15 доллар болгох боломж байна гэж. Тэр нь хэзээ болохын, бид нар яаж хүлээхийн хэцүү л байна. Тэрийг нь авч иддэг улс нь Монголдоо байна уу, үгүй юу бас хэцүү л байна.

Ер нь бол нэг л юм боддог юм. Монгол улс чинь газар тариалан, мал аж ахуйгаа түшиглээд яваад ирсэн юм. Газраа ухаад баяжлаа гэж сонсоогүй. Тэгэхэд 60 сая малд чинь вакцин хийлээ гэхэд хаана нь хүрэх вэ?, энэ жил гэхэд манай нутагт оторлож ирсэн малд хордлогын тариа гэж нэг ч хийсэнгүй. Одоогоороо л хонь нь хордоод үхээд байна шүү дээ. Монголыг 20 сая малтай байхад босгосон биокомбинат чинь одоо 60 сая малд хордлогын тариаг хийж гүйцэхгүй байна гэж байна. Малын тоо 3 дахин нэмэгдсэн. Тэгэхээр бид нарт тэр хувьцаа энээ тэрээ гэж худлаа хэлж байхаар, малчдад 5 тийм Биокомбинат барьчихвал хөрсөн дээр үлдэх юм байхгүй юу. Монгол хүн малаараа амьдарч чадна шүү. Тэгсэн чинь амьд явах баталгаа нь энэ мал дээр чинь яригдаж байна шүү дээ. Малдаа өчнөөн тариа, тарилгаа энээ тэрээ хийж байснаас эхнээс нь эрүүл болгочих юм бол мал эрүүл, хүнс эрүүл. Малчин хүнд тулгамдаж байгаа асуудал зөндөө байгаа шүү дээ. Малчдыг нийгмийн даатгалд хамруулах хэрэгтэй байна. Малчин өрхийн эхнэр, нөхөр хоёрын хоёуланг нь биш юм аа гэхэд, нэгийг нь нийгмийн даатгалыг төлөөд, нөгөөг нь

өөрөө төлөг л дээ. Газрыг нь ухаж байна гэдэг чинь малчин хүний малын бэлчээрийг устгаж байгаа л хэрэг биз дээ, ялгаа юу байна. Хүн хүүхдийнхээ төлөө яьдаг шиг, төр засаг нь ард түмнийхээ төлөө явах хэрэгтэй биз дээ. Ард түмний амьдрал хүнд байна шүү.

-Малын эрүүл мэнд

Төрийн ордонд болсон хурал цугдаан дээр нь үг хэлэх гэсэн цаг дууслаа, үүгээр тасаллаа гээд намайг үг л хэлүүлээгүй. Би ганцхан үг л хэлэх гэж орсон. Тэр бол “малаа эрүүл болгоочээ” л гэж хэлэх орсон. Би та нараас ганцхан л юм хүсье. Малчид чинь та нараас өдөр бүр нэмнээ, тэжээл гуйгаад байдаг улс биш шүү дээ гэж. Тэр Таван толгой энээ тэрээгээ ухаж төнхөх нь яах вэ, үүнээсээ таван хошуу малдаа зориулж 5 биокомбинат бариачээ л гэж хэлэх гэсэн юм. Санаагаа бүрэн гүйцэд хэлж чадаагүй. Малчид гэдэг чинь боловсрол дорой улсууд биш ээ, өмнөх ерөнхийлөгч нэг сайхан зүйл хийсэн нь “Малчин үнэмлэх” гаргасан. Малчин бол мянган боловсролын эзэн шүү. Одоо ард түмэн сонголтоо хийж чаддаг болсон шүү.

1.3.5 АРХАНГАЙ АЙМГИЙН БАТЦЭНГЭЛ СУМЫН ХӨНӨГ БАГИЙН МАЛЧИН ЦЭГМЭДИЙН ДОРЖСҮРЭН \УРГИЙН ОВОГ АРАВДАН\ 1950 ОНЫ БАР ЖИЛТЭЙ, ЭРЭГТЭЙ. ДАМДИНСҮРЭНГИЙН МЭНДБАЯР \ЭХНЭР\ 1957 ОНЫ ТАХИА ЖИЛТЭЙ



(27-р зураг)

Би 1950 онд төрсөн. 1970 онд Дорноговийн Зүүнбаянд 3 жил цэргийн алба хаасан. Гал командад гал сөнөөгч хийж байсан. 1973 он цэргээс халагдаж ирээд дараан жилээс нь адуу малласан. Адуу голцуу малласан, ер нь таван хошуу мал малласандаа, сүүлд нь тэмээ ч маллаж байлаа. Манай ах засгийн тэмээ малладаг байсан, нэгдлийн тэмээг цэрэгт явахаасаа өмнө ахтайгаа цуг харж байгаад л цэрэгт явсан. Тэгээд сүүлд нь адуу авсан.

-Бэлчээрийн өвс усны тохируулга

Адууг бол соргог сайхан бэлчээрт маллавал сайн өвс, ус сайтай бэлчээрийг сонгох хэрэгтэй. Тарга тэвээрэг сайн авахуулчихвал нэг их турж эцдэггүй. Нэг нутагт байраншсан, тогтсон мал бол их сайхан тарга авдаг. Дээр үед нэгдлийн малд би арваад азарга адуу аваад л, эхэндээ айл айлын мал чинь тогтохгүй бэрх шүү. Батцэнгэл сумын Улаантуг нэгдэл гэж байлаа. 1950 хэдэн онд л байгуулагдсан байх даа. Эхлээд гурван зуу гаран адуутай байсан сүүлдээ таван зуу гаран болсондоо. Адуугаа нэгдэл тартал маллаж л байсан.

Адууны өөхөн таргыг хавар сайхан ногоо идүүлээд л авахуулдаг даа. Зун гүү барьдаг байлаа. Номхоноос нь 2-3 азарга адуу барьдаг байсан. Намар болсон хойно гүүгээ тавьдаг, нэгдэл чинь хэдэн литр айраг авна гээд төлөвлөгөөтэй байлаа, тэрийг нь биелүүлдэг байлаа шүү дээ. Одоо яах вэ, хонь, ямаа, үхэр, адуу дөрвийг л маллаж байна, хувьдаа байсан тэмээ дууссан.

-Нүүдэл суудал ба бэлчээрийн даац

Уул нь ч нүүдэл суудал овоо хийдэг байлаа. Сүүлийн үед ер хийхээ байсан, хавар хаваржаа дээрээ бугаад хаварждаг, зун болохоор эндээ зусдаг, өвөл ч хойт уул руу ойрхон өвөлжөөтэй. Манай хаваржаа чинь энэ урд харагдаж байгаа, тэр \зуслангаас 5 орчим км зайтай\, өвөлжөө ар руу 6,7 км зайтай. Уул нь ч сэлгэж буудаг байсан юм аа, харин сүүлийн үед нэг л газар байна. Манай хүргэнийх энэ Ар-Үзүүрт өвөлждөг. Тэнд айлын бараа харж бууж байна. Бэлчээрийн гарц их муудаж байна. Дээр үед чинь дөрөө зураад л, өвс чинь үнэгэн зоо шиг халиурч шаргалтаад л байдаг байсан. Одоо ч их муу болжээ. Энэ жил харин өмнөхөө бодвол жаахан гайгүй байна.

Түүнээс биш ойрын хэдэн жил үлий идээд л, хулгана ихтэй шороо босоод л байдаг байсан. Энэ жил их сайхан гарах байхаа.

Ган авна, бүх л юм аа бэлдэнэ. Манайхан чинь голоосоо өвсөө хадчихдаг юм. Бургасны чөлөө завсраар хадаад авчихдаг. Голын өвс чинь шивээ багатай, өргөсгүй их сайхан байдаг. Өвсөө жижиг мал, ядарч доройтсон үхэр адуунд өгнө. Нэмэлт тэжээл авна. Ноднин бол өвс ногоо их муу байсан, өнгөрсөн хавар өвс ногоо их худалдаж авсан шүү. Манай хүүхдүүд өвстэй газар руу отроор явсан. Хойд уул руугаа. Нутгийнхан зөвшөөрөлгүй ирлээ, барилаа гэдэг бололтой байна лээ, Дээр үед бол их сайхан байсан.

Дээр үед чинь хаяагаа тойрч буучихаад л, хонь малаа саахалчихаад саадаг байлаа, одоо ч хонь малаа саахаа байжээ, манайх чинь адуутай байсан болохоор гүүний саальчин байлаа шүү. 30 гаран жил л саальчин хийлээ. Одоо бол амины хэдийгээ л уяж саана уу гэхээс, дээр үеийнхтэй адил нэгдэл энээ тэрээ гэж байхгүй шүү, өөрсдийн малаа саагаад идээ будаагаа зарж борлуулж болдог л юм шиг байна. Маньд бол тийм юм байхгүй, үр хүүхдүүдтэйгээ хувааж идээд л, одоо бол ааруул ээзгий, сүү, тараг хурууд л хийж байна. Энэ жил цаг зүтгүү орсон болохоор сүү цагаан идээ арвин биш гэхдээ хэдэн хүүхдүүдээ цагаан идээнээс нь салгачихаагүй л байна. Энэ жил сүү тарагны хэдэн малтайгаа л хоцорсон доо. Одоо бас малын чанар, дагаад сүү цагаан идээний чанар ч бас муудсан шиг байна. Өрөм, хусам нь ч шингэвтэр байх шиг санагдаад байдаг. Энэ ургамал, өвс ногоотой нь л холбоотой байдаг байх даа. Дээхэн үед сайхан л байдаг байсан, өдийхөн жаахан мах амруугаа хийсэн ч пэл пал, өдийхөн жаахан өрөм амруугаа хийсэн ч өөг л байдаг байлаа. Одоо ч өөр болсон шиг байна.

-Залуу малчдад зөвлөх нь

Малаа сайхан маллаад, сэргэг сайхан бэлчээрт маллах хэрэгтэй. Нутгаа сайхан сэлгэж байвал мал их сайхан тарга авдаг шүү л гэж хэлмээр байна.

2018.08.01-ний өдөр Тамирын голын эрэгт зусаж бүхүйд гэрт нь хүрч
сурвалжлав.

1.3.6 АРХАНГАЙ АЙМГИЙН БАТЦЭНГЭЛ СУМЫН ХӨНӨГ БАГИЙН МАЛЧИН АЮУРЫН БАТБОЛД \УРГИЙН ОВОГ БОРЖИГИН\ 1983 ОНЫ ГАХАЙ ЖИЛТЭЙ, ЭРЭГТЭЙ. ДАЙРБОР ИХ БУЛГААР НУТАГТАЙ.



(28-р зураг)

Намайг Аюурын Батболд гэдэг. 2001 оноос эхлээд мал маллаж байна. 2001 онд цэрэгт явж ирээд, түүнээс хойш тасралтгүй мал маллаж байна. Үхэр, адуу, хонь, ямаа гэсэн 4 төрлийн мал маллаж байна. Мал маллах арга ухаан гэхийн бол, өвсний соргог, бэлчээрийн сайныг дагаж л бэлчээрлүүлнэ дээ. Өнгөрсөн жилийн хувьд зуншлаг муу байсан болохоор мал тарга тэвээрэг аваагүй, өвөл нь ган гачиг болоод хэцүү л байлаа. Өвсийг уулнаас 2,3 машинаар нь хадаж авсан, тухайлсан өөрийн гэсэн хадлангийн газар байхгүй, уулын жалга, гуу дамжиж байгаад л хадаж авдаг. Манайх бог мал дөрвөн зуу гаран таван зуугаад юм бий, бод мал бол дөч, тавин юм бий, гэхдээ энэ жилийн хувьд бол нэлээд хорогдсон.

-Бэлчээрийн даац ба отор нүүдэл

Тэнгэр хангай ингээд сайхан байгаад, бороо ороод байх юм бол отор нүүдэл хийгээд байх шаардлага их бага л даа, хэрвээ тэгэхгүй бол аль бороо хур орж байна, аль өвс ногоо сайтай байна тэр газарт л нүүж, мал хуйгаа таргалуулж өвөлд бэлдэхгүй бол болохгүй. Тэгэхээр отор нүүдэл хийх боломжтой газар бол нодлингийн хувьд энэ хойшоогоо уул руугаа их гайгүй байсан л гэсэн. Манай энд 7-р сарын арван

хэдэн гэхэд бороо ороогүй, ногоо ургаагүй л байсан, тэгээд л 7-р сарын 20-дын үеэр бороо орж жаахан ургасан даа.

Ноднингийн хувьд манай энд отор нүүдэл зөндөө орж ирсэн. Цэнхэрээс чиг л орж ирсэн. Ерөнхийдөө өвс ногоо муутай болоод ирэхээр гол руугаа их шахдаг юм байна лээ. Манайх зунд нь голын энээдээ байж байгаад өвөлдөө дээшээ Хөнөг рүүгээ 30-аад км яваад өвөлждөг.

Сүүлийн үед мотоциклээр их хариулах болсон, би ч гэсэн мотоцикл унадаг, морьтой чиг л холиод л хариулж байна. Хавар цагт мотоциклээр хариулах тийм ч тохиромжтой биш юм. Хээлтэй мал мотоциклын явдал гүйцэхгүй, ихэвчлэн мориор хариулахыг л эрмэлзэж байна. Зун ч гэсэн мотоцикл тийм тохиромжтой биш юм. Тарга тэвээрэгт нь муу, ширүүн туувал хайлна, дэмий л байх. Морь бол дээр үеэсээ хонь хариулахад зориулагдсан унаа шүү дээ.

Манайх бол нүүдлийг хийнээ хийнэ. Хавартаа бол Хөнөг \20 хэдэн км зайтай\ ийн тэндээс Загастай ус руу ирнэ. Хаврын малд Засагтайн ус нь илүү хэрэгтэй байдаг болов уу, ядарсан малд ус, өвс нь хэрэгтэй болов уу гээд энэ рүүгээ орж ирээд байдаг. Зундаа бол ингэсгээд энэ хавиараа зусна, намартаа бол дээшээ жаахан хөдөө хээр, ургамал нь нарийн ногоо агь, таана ургадаг тэр рүүгээ явбал малын тарга хүчинд сайн бэлчээрт гаргадаг. Манайх бол 7-р сарын өнгөрөөд 8-р сарын эхээр өвөлжөөнийхөө тэр рүү гараад намаржаад явчихдаг л даа. Дээшээ 20 хэдэн км зайтай. Бэлчээрийн хүрэлцээ ерөнхийдөө бол болж байна, зундаа айлууд гол усаа бараадаад явахаар жаахан чихэлддэг. Намар, өвөл бол дээшээ жаахан задгайраад буучихдаг болохоор гайгүй. Өвөлжөө, хаваржааг амрааж байгаа л гэж бодож байгаа шүү дээ, хавар нь бол ингээд хүрээд ирчихэж байна, зун нь энд зусаж байна, ганцхан өвөл нь л очиж өвөлжиж байгаа юм чинь сайхан амрааж чадаж байна л гэж бодож байна. Ерөнхийдөө манай тэндэхийн айлууд иймэрхүү байдлаар нүүдэллэдэг. Зундаа гол руугаа орж усан дээрээ байж байгаад намар тийшээ дээшээ гардаг. Тэгэхээр өвөлжөө, хаваржаа бол амралттай л байгаагаар гэж боддог.

-Хадлан тэжээлийн бэлтгэл

Уулнаас өвсөө хадаж авчираад хуурайгаар нь байран дээрээ маш нарийнхан доороосоо илжирч муудахгүйгээр хураадаг. Дээр доороосоо чийг авахгүйгээр, доороосоо салхи орж байхаар хураадаг даа. Тэрнээс биш тэжээлийг нарийн ширийн бэлдээд байгаа юм бол байхгүй байна.

-Малчдад тулгамдсан асуудал

Малчдад тулгамдаж байгаа асуудал бол, манай тийшээ худаг усны асуудал байна даа. Худаг ус байхгүй, нэг худаг дээр 2-3, 5-6 айл бөөгнөрөх ч юм уу, нөгөө худаг нь шавхрах ч юм уу, тийм л асуудал байна даа. Мотортой худаг л даа. Элдэв янзын төсөл энээ тэрээгээр манай тэнд нэг худаг гаргасан, тэр нь шавхардаг, бөөнөөрөө овоордог л асуудал байна даа. Энэ жил сайхан зун болж байна, хавартаа бол их л зулгааж орлоо, нодниншиг дахих нь уу гэсэн, бороо ороод сайхан зун болж байна, бороо ус нь л орвол байгаль ч дороо сэргэх юм аа. Одоо тэгээд намар эхлэлээ, одооноос эхлээд л бэлтгэхгүй л бол болохгүй. Сайн л бэлтгэхгүй бол цаг эвгүйрхэх юм бол хэцүү. Энэ жил бол уулаас нэлээд сайн өвс авья гэж бодож байна.

Манай энд бол Дайрбор хайрхан, Лүнгийн овоог тахьдаг даа. Намрын дунд сард бол өнтэй сайхан өвөл болохоо даатгаад Хөнөгийн хайрханыг тахидаг, зундаа бол энэ хоёрыг тахидаг. Би нэг, хоёр удаа л тахилгад оролцож байсан, лам нар ном уншиж, морь уралдуулж тиймэрхүү л зан үйл болдог доо.

Тамир голын хойд эрэгт, малын бэлчээрт сурвалжлав.

**1.3.7 АРХАНГАЙ АЙМГИЙН БАТЦЭНГЭЛ СУМЫН ДАЙРБОР \6-Р БАГ\ БАГИЙН
МАЛЧИН ГОМБОДОРЖИЙН ЭНХБААТАР \УРГИЙН ОВОГ ХАЛХ\ 1966 ОНЫ МОРЬ
ЖИЛТЭЙ, ЭРЭГТЭЙ.**



(29-р зураг)

Би Гомбодоржийн Энхбаатар гэдэг хүн байна. 1991 оноос 2018 он хүртэл 20 гаран жил мал маллаж байна. Мал ч яахав дээ, одоо ч олон малын хэрэггүй болчлоо. Мал маллагаа, өвс ургамал, цаг төр ч нь ч гэсэн, ус бороо орохгүй, өвөлдөө болохоор хүйтрээд, зундаа ган гачиг болоод, нодлин ч хэцүүхэн жил боллоо шүү дээ. Энэ жил хүний амаар ярьхад бол мал 200-300 толгой малтай байхад болохоор л байна. 15, 16 жил ажиллаа, малаар явах сайхан байдаг юм аа. Мал дагасан хүн хоосон хонохгүй шүү. Зуны хувьд бол идээ цагааг нь идэж уугаад л, өвлийн цагт бол малаа идэж уугаад л, заримыг нь өсгөж үржүүлээд л байна. Одоо адуу, үхэр, хонь, ямаа гээд тэмээнээс бусдыг нь маллаж байна.

-Бэлчээрийн онцлог, мал маллагаа, арчилгаа

Одоо ер нь тэгээд л, хүн болгон машин механизмтай болсон бэлчээр ус гарахгүй бол нүүдэл сайн л хийх хэрэгтэй. Ах нь жилдээ 5-6 нүүдэг. Ер нь сар болоод л бэлчээр сольдог. Нэг нүүхдээ 15-20 км зайтай нүүдэг. Тэгж нүүснийх ч юм уу мал их сайхан таргалдаг. Одоо тэгээд таана, агь ургахаа байж, уул нь өдийд таана, агьтай газраар л бэлчээвэл мал их сайхан таргална даа.

Энэ жилийн хувьд бол тийм маргаан гарсан. Манайх чинь Дайрбор, энэ цацаад гарахаар чинь аргагүй юм даа, Батцэнгэл чинь мал сайтай болоод тэгдэг байх, баг багаараа бол нутаг дотроо тийм асуудал байна, сумаасаа суманд бол мэдэхгүй.

Одоо ер нь тэгээд л хадлангийн газар гэж байхгүй дээ, бэлдүү газар болохоор, тэгээд уулаадаа гардаг даа. Сумынхаа, багийнхаа хойд уулаадаа л гардаг юм даа, Улаанчулуу, Цацаадаа, аль ургамал сайн ургасан газраас л хадлан тариа бэлтгэнэ дээ. Өвс хадлан авахад тухайн орон нутгийнхан гайгүй шүү, отор нүүдэл хийгээд очиход л жаахан хажигладаг болохоос хадлангийн үеэр бол зүгээр шүү, боллоцоо боллоцоогоороо л авдаг. Хадлангаас өөр халгай байна даа, дээхэн үед бол агь зэргийг зулгаагаад мушгидаг байсан. цахилдаг, агь, таана зэргийг зулгаагаад, мушгиад давс цацаж авдаг байсан.

Мал эргүүлдэг унаа ньзаа даа одоо ч машин тэрэг болчлоо доо, бидний залуу үед машин мотоцикл байхгүй байлаа, хээрээр морио сольж унаад л давхидаг байлаа. Одоо ч бүгд машүйн мотоцикл болоод тэрэндээ мал нь ч дасчихлаа даа. 20-иод жилийн өмнө бол хужаа мотоцикл анх гарч байсан бид нарыг мотоциклоор мал үргээлээ гэдэг байсан, одоо мотоциклийн дуугаар мал явахаа байсан. Одоо хааяа морь унаад, шилбүүр бариад явавах морь нь зүгээр юм уу гэсэн юм бодоод л байж байна. Хүүхдүүд явган, дугуйгаар л хариулж байна даа.

-Бог малын бэлчээрий зохицуулалт, тоо толгой

Бог мал нарийн малыг хэлж байна. Нарийн мал яахав бэлчээрийг нь сайхан тааруулах хэрэгтэй, манай урд руу хужир мараатай, ер нь өдийд малыг эр өвсөнд нь сайн бэлчээрлүүлвэл зүгээр дээ.

Ах нь 270-д мал маллаж байна, тэрнээс их бол хүч хүрэхгүй байх гэж боддог.

Залуучууд хөдөө гарахгүй байна. Аав ээжүүд нь ч гэсэн сургууль гэдэг болж, гэтэл төгсөөд ажил байхгүй байна, тэгээд хий дэмий Солонгос энээ тэрээ гээд, настай хүний хувьд хэлэхэд малчдыг уриалж үр хүүхдээ, хэдэн хүүхэд байдгийн тэрний заримыг нь малчин болгоорой л гэж уриалмаар байна.

**1.3.8 АРХАНГАЙ АЙМГИЙН БАТЦЭНГЭЛ СУМЫН ДАЙРБОР 16-Р БАГ БАГИЙН
МАЛЧИН ОЙДОВСАМБУУГИЙН ГАНСҮХ 10-Р СУМЫН ОВОГ БЭХБАТ 1962 ОНЫ БАР
ЖИЛТЭЙ, ЭРЭГТЭЙ.**



(30-р зураг)

Заа би чинь энэ нутагт ирээд 18 жил мал маллаж байна, тэрний 10 жил нь адуу малласан. Сүүлийн үед адуу, аль ч мал өвс ногоо ургамал сайхан гарвал түүргүй, ган гачиг, цас зудтай бол бас л хэцүү, энэ жил бол сайхан зусаж байна. Газрын гарц сайтай иймэрхүү байхын бол ер нь боломжийн, газрын гарц муутай, цас зудтай, хүйтэн шамраг ихтэй байхын бол адуу мал чинь сум дамжаад алга болж өгдөг, энд чинь модтой биш тогтохгүй шдээ, тэгээд хаа байсан Өлзийт, Өгийнуур, Хотонт, Хашаат гээд алга болоод өгнө. Бог мал бол яах вэ, газрын гарц гайгүй бол хаа ч нутагшаад, юмаа олоод идээд байна. Ус бол манайх Тамирын гол сайхан задгай устай, өвөл бол голын харз байна, нуур тойром шүү, хужир сайтай. Өнгөрсөн жил л их ширүүн боллоо. Бод мал их үхсэн, үхэр их үхсэн. Бог бол гайгүй, бусад жилүүд бол гайгүй, энэ жил л их ширүүн байлаа.

-Сүргийн бүтэц, тоо толгой, отор нүүдлийн байдал

Адуу, үхэр, хонь, ямаа гэсэн 4 хошуу малтай, бог 200 гаран юм бий, адуу бол 250-иад юм байгаа байх, багцаа тоогоор. Отор гээд ч нэг их явдаггүй ээ. Ер нь урт хөлийн мал Өлзийт, Өгийнуур, доошоо Хөнөг мөнөгөөр ингэж аль өвстэй газар руу явна, тэр хавьд нь бөөгнүүлж хараад л. Өвс ихтэй бол эндээ тогтдог юмаа, өвсгүй бол сум сумдын нутаг руу оруулаад, оторлоод, тэнд бөөгнүүлж хараад л байна.

Өвстэй газрын улс чинь ийм шал болчихсон газраас очиход чинь нэг их хөөж туугаад байхгүй л дээ, зайлуул. Тэр чинь бас юу ч үгүй газраас очвол гайгүй, цөөн тооны малыг гайгүй, хоёр, гурван мянган толгой малыг бол жаахан тээр үзэх нь байдаг.

Бэлчээрийн даац гэх юм бол ойрын хэдэн жил сайн гараагүй, тэгээд аль ногоотой аятайхан газар байна тэр рүүгээ баг, бригадаас ороод ирнэ, нэг нутагт усны улс чинь хөөгөөд байх хэцүү, идүүлээд суугаад байх хэцүү, аль болох эвтэйхэн зохицоод л болох болохоороо л, аль болох бага шиг шаллахыг бодоорой, ногоо ургавал нутаг руугаа яваарай л гээд тоглоом шоглоомоор хэлээд суудаг шүү дээ. Энэ жил бол сайхан л байна, отор нүүдэл хийсэнгүй, хавартаа л жаахан чангаасан.

Жилдээ 3-4 удаа нүүнэ дээ. Хаваржаад, зусаад, намаржаад, өвөлжөөд 4 удаа л нүүнэ дээ. Өвөлжөө, хаваржаагаа жил өнжөөж чадахгүй, өвөлжөө болгон эзэнтэй юм чинь. Цас зудтай бол тэндээ өвөлжихөөс өөр яах вэ дээ. Мандалын Хүнүйн гол, Хайрханы Жарантай энээд л өвөлждөг шүү дээ. Манай өвөлжөө Дулааны ард байна даа. Зуслан бол сумынхаа араад ингээд \гараар заав\ төв рүүгээ усаа бараадаад ороод ирнэ. Энэ жил бол ийшээ орж ирэх гэхээр хавардаа газрын гарц муу, гандуу байсан. Мөн нөгөө айхтар өвчин чинь \шүлхий\ гараад, “ийш тийшээ битгий нүү, байран суурин байдаг байдагтаа бай” гэж захиргаанаас шийдвэр өгсөн л дөө. Тэр нь ч дээр л байх, хаа саагүй нүүгээд өвчин тараагаад байж болохгүй, тэгээд л сууриндуу байна даа. Одоо тэгээд хорио цээр нь тавигдсан, намаржаад л орж ирдэг байхдаа.

Хяраадаа 40-50 км явж өөрийн талбайгаас 4 машин өвс авдаг. Муудсан малдаа өгдөг дөө. Өвсөөрөө мушгиа хийдэг байсан, одоо хийхгүй байгаа, голцуу бэлэн тэжээл өгч байна. Мөн адууны халтар хомоол өгдөг. Халгай их хадаж авдаг.

-Малчны залгамж

Би эхээс 7-уулаа, одоо хоёр нь малчин. Гурван ах сэхээтэн, нэг нь өнгөрсөн, нэг эгч аймагт байдаг. Үр хүүхэд бол тав. Би өөрөө хонио хариулна, тэгээд бусад нь хотод байх шив дээ. Хүүхдүүддээ байгаль орчин, нар сар хиртэх зэргийг ажиглаж байгаарай гээд л хэлнэ. Байгаль өөрөө хэлээд өгнө дөө. Нар, сар хиртэхээр чинь нар, сараа угааж тэнгэр 2-3 хоног муухайрч хур бороо ордог. Мөн оддын тохиол, хүйтрэх зэрэг чинь бүгд мэдэгдэнэ.

-Залуу малчдын бэлэнчлэх үзэл

Бэлэнчлэх сэтгэлгээтэй л холбоотой болов уу гэж боддог. Мөнгөөр байр, машин авах хүсэлтэй, тэрнээс тэр байр, машин авах малаа өөрсдөө маллахгүй байна шүү дээ. Ер нь ний нуугүй хэлэхэд хөгшчүүд л зүтгэж байна, аав ээж нь. Тэгэсгээд алга болоод өгөх юм даа. Хот суурингаа л бараадах юм байна шүү дээ. Соёл нь ч тийм байдаг юм уу мэдэхгүй. Мал маллах чинь сайхан шүү дээ, жаргалын ажил, аль нэг компани пүүст ороод хэн нэгэн даргад загнуулаад байхгүй. Амрах үедээ сайхан амарчихна, өвөл, хавар л жаахан зүтгэдэг болохоос гайгүй шүү дээ. Цаг агаар сайхан, өвс ургамал сайтай бол, хавар мал төллөх гэж жаахан ядардаг л байх тэрнээс бусад улиралдаа бол сайхан шүү дээ. Мал бол явж явж эцсийн эцэст амьдрал юм шүү дээ. Амьдралын баталгаа. Мал бол өснө, ирээдүйн баталгаа. Мал аж ахуйн орон гэдэг чинь тэр шүү дээ.

Малын бэлчээрт уулзаж сурвалжлав.

1.3.9 АРХАНГАЙ АЙМГИЙН БАТЦЭНГЭЛ СУМЫН ХӨНӨГ БАГИЙН МАЛЧИН ИШБАНЖИЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ҮРГИЙН ОВОГ БОРЖИГИН 1969 ОНЫ ТАХИА ЖИЛТЭЙ, ЭРЭГТЭЙ.



(31-р зураг)

Би Архангай аймгийн Батцэнгэл сумын Хөнөг багийн иргэн хүн. Дээхэн үед би засгийн тэмээ маллаж байлаа, тэрнээс хойш одоо болтол үхэр, адуу, хонь гээд дандаа хувийн юм л маллаж сууна даа. Ийшээ тийшээ отор нүүдэл хийж , хойд уул руу ч явдаг л байлаа, сүүлийн хэдэн жил энэ хавиасаа гараагүй ээ. Энд тэндээс жаахан жаахан өвс хадлан аваад тэгээд л бордоо хивэг тэжээл авчих юм даа, одоо ч мөнгө нь байвал ч амар болж дээ. Манай энэ гол яахав дээ энэ жил сүрхий гандуу байсан, 7-р сарын 1-ээс бороо ороод сайхан болчлоо. Хадлан тэжээл энд тэндээс жаахан, жаахан юм гармаар маягтай болсон байна. Гол ус л жаахан яггүй болох гээд байх юм. Бороо хур орохгүй болохоор усны л ажилтай болох гээд байх юм. Отор нүүдлийн улсууд урд, хойноосоо их гарч ирэх юм даа. Тиймэрхүү л байна.1988 онд

нэгдэл байхад илгээлтээр гарч мал маллаж байсан. Батцэнгэл сумын Улаан туг нэгдэлд манай хүн бид хоёр тэмээ хариулж “Алтан ботгоны эзэн” болж байсан, адуу ч харж байсан, мал ч тууж байсан. Одоо бол хувийн хэдхэн юмтай болж л байна.

-Бэлчээрийн даац, экологийн зарим асуудал

Бэлчээрноднин жил их муу байсан, энэ жил яах вэ, одоо бороо хур орж байна, гайгүй болох байх аа. Нодлин бол яггүй орсон, сүрхий гандаж муудаад байсан. Нүүдэл нэг их хийхгүй, манайх өвөлжөө, хаваржаа холгүй ээ, энүүгээрээ эргэлдээд л тойроод буучих юм даа.

-Монгол малчин бэлтгэх асуудалд

Би ээж, ааваас 12-уулаа, 4,5 нь малчин, манайх 2,3 эгч энэ хөдөө байна, 2 охин дүү, 1 эрэгтэй дүү байна. Манайх 2 хүүхэдтэй. Хоёулаа хотод байна. Нэг нь уул уурхайд ажил хийж байгаа, нэг нь оюутан. Манай охины ач энэ байна \2 орчим настай хүү\ . Охины ачийг л авч үлдэх гэж гал голомтой залгуулах гэж үзээд байна. Манай энд хужир сайтай шүү, тэрийгээ хааяа жаахан авч хэрэглэдэг. Ус л хэцүү байна, хавар бол усгүй болчих гээд, мал нь их болохоор бэлчээрийн даац гэдэг чинь яггүй юм аа, хуучин бол ийм олон малтай айл байдаггүй байлаа, одоо мянга хүрэхгүй малтай айл цөөхөн болсон байна. Адуу мал ч ихтэй болсон байна. Манай нутаг чинь гурван \Өгийнуур, Өлзийт, Батцэнгэл\ сумын залгаа болохоор хойно урдаасаа отор нүүдэл их гарч ирдэг. Хавар 2,3 сарын эхээр халзалж аваад л алга болцгоодог юм даа. Манайх чинь гурван сумын залгаа болохоор нэг нутгийн улсууд биенээ хөөж, туугаад байдаггүй.

-Өвөлжөө, хаваржаа сэлгэлт

Өвөлжөө сэлгэх арга алгаа, өвөл болохоор доод руугаа Өгийн айл, хойшоо Өлзийтийн айл болчихдог, манайх өөрийн цөөхөн юмтай болохоор яахав тэгээд болоод л байх юм даа. Отор нүүдэл сүүлийн үед ер нь хийгээгүй. Энэ жил харин хийдэг юм уу гэж байсан бороо хур ч ороод больсон, одоо бол нүүхгүй ээ.

Бороо хур орохгүй, цаг агаар хүндрэхээр л жаахан бэршээлтэй байх юм даа. Энэ жил бол их л хүнд орлоо манай энд, үхэр, адуу ялангуяа их мундаг орлоо, нэлээн ч хорлоо, нэлээн ч зүтгүүллээ, их ч тэжээл бордоо авлаа даа.

-Бэлчээртэй дасан зохицох уламжлалт ёс

Манай Батцэнгэл чинь Дайрбор, Лүнгийн овоо, Цацийн овоо гээд хэд хэдэн овоог тахьдаг юм аа, тахиад сүртэй ч ороогүй байсан, сүүлдээ сүрхий орлоо. Уул ус тахидаг лам нар, лусын лам нар ирж тахидаг юм даа. Хавар зуны эхэн сард багтааж тахьдаг, идээ будаа засаж, морь хар уралдаж л тахидаг даа.

Хөнөг багт зусаж байхад гэрт нь очиж сурвалжлав.

1.3.10 АРХАНГАЙ АЙМГИЙН ӨЛЗИЙТ СУМЫН БОДОНТ БАГИЙН МАЛЧИН ДАШЗЭВЭГИЙН НОРОВСҮРЭН ҮРГИЙН ОВОГ ЦОРОС\ 1992 ОНЫ БИЧ ЖИЛТЭЙ, ЭРЭГТЭЙ.



(32-р зураг)

Намайг Дашзэвэгийн Норовсүрэн гэдэг. Би 1992 оны 3-р сарын 17-нд төрсөн. Өлзийт суманд 10-н жилээ төгсөөд мал маллаж байгаа. Адуу, үхэр, хонь, ямаа гэсэн 4 төрлийн мал маллаж байна, тэмээ байхгүй. Адуу 40 гаран, бог 400 гаруй малтай. Отор нүүдэл гайгүй хийнэ, хойшоо Бодонтын гол руу зусдаг, намар нь ийшээгээ гарч ирдэг дээ, бэлчээр нь арай гайгүй сийрэгдүү, өвс нь урд руугаа нарийн, мал бэлчээрлэхэд тохиромжтой. Бодонтын гол эндээс 30-аад км. Манай аавынх тэнд байдаг, зунд нь морь мал уяад тэнд зусчихаад намартаа наашаа гарч ирдэг.

-Бэлчээр ба бэлтгэл ажил, сэлгэлт

Бэлчээрийн даац ийшийгээ бол нэлээд хомсдуу, хүнд л байна. Намарт нь урдаас айл их гарч ирнэ, Өгийнуураас нэлээд айл гарч ирнэ.

Хойшоо уул руу явна, газрын гарц гайгүй жил бол энэ хавиараа, хойд уул руугаа л гарч хадлангаа авдаг, голцуу троктараар авчихдаг, 4, 5 хот айл нийлж байгаад л 10-аад машин өвс авчихдаг.

Ерөнхийдөө нэг л газраа өвөлжинө дөө, ийш тийшээ явахаар айл амьтан ихтэй, гадны сум руу, хаяа хойшоо уул руу отроор гардаг, цаг гайгүй бол эндээ л өвөлждөг дөө.

Мал маллах сайхан л даа. Залуу үеийнхэндээ хэлэхэд, мал маллаад хөдөө цэвэр агаарт амьдраарай, малын ашиг шим их л гэж хэлмээр байна. Өвсөө сайн хадаад, отор нүүдэл хийгээд, малынхаа тарга хүчийг сайн авахуулвал мал маллахад гайгүй дээ.

1.3.11 АРХАНГАЙ АЙМГИЙН БАТЦЭНГЭЛ СУМЫН ХӨНӨГ БАГИЙН МАЛЧИН ЛХАГВАЖАВЫН ЗОЛЖАРГАЛ /1989 ОНЫ МОГОЙ ЖИЛТЭЙ, ЭРЭГТЭЙ/



(33-р зураг)

Намайг Лхагважавын Золжаргал гэдэг, би нэг хэсэг хотод байж байгаад хөдөө гарч ирээд 8, 9 жил болж байна, тэмээнээс бусад 4 хошуу мал маллаж байна. Оорцогийн хөндий энэ хавиараа л жилийн дөрвөн улиралд байдаг.

-Бэлчээрийн даац ба мал маллагаа

Отор нээх ч хол явахгүй юм даа, ойрын хэдэн жил сайхан л байлаа, ойрын хэдэн жил отор нүүдэл хийж хол явсангүй, өнгөрсөн жил л хэцүүхэн байлаа. Манай энэ нутаг уснаас айлууд хойшоо нүүцгээсэн. Зарим цөөхөн малтай нь ч суугаад үлдээд л, олон малтай нь уул руугаа нүүсэн. Ер нь тэгээд отор хийгээд хойшоо гарахаар л хөөгдөнө шүү дээ, уул руугаа сайн шахаад л буучихвал гайгүй юм байна лээ. Уул нь баг нь өөр болохоос нэг л сумын нутаг шүү дээ, айлууд нь өвөлжөө, хаваржаа идчихлээ гээд бөөн л юм болдог юм байна лээ. Мод руугаа шахаад буучихвал гайгүй л юм шиг байгаа юм.

Манайх сумаасаа 25 орчим км яваад уул руугаа очоод модны хаяагаар л хаддаг даа. Яг өөрийн гэсэн хашаалсан газар байхгүй, 2,3 жил хадсан газар байгаа,

хэн түрүүлж очсон нь хадаад авдаг шүү дээ. Одоо ер нь тэгээд л 8-р сарын дундуураас гардаг, бороо хур элбэгтэй бол жаахан хойшилдог, бороо гайгүй бол 20-д хүргээд л гарна, эрт авчихаад хатааж чадахгүй бол илжрээд мууддаг. Хадлангаас өөр бас халгай аваад ишнээс нь зулгааж навчийг нь түүж аваад хивэгтэй холиод ихэвчлэн үхэрт өгдөг. Үхэрт өвөл цас ороод эхлэнгүүт л өгдөг. Оройтвол үхэр тэжээл авахдаа муу, 11-р сарын 20-д эхлээд тэжээл өгч эхэлдэг, тэгээд тэжээгээд гурван ес дуустал тэжээсэн байхад тэрнээс хойш гайгүй шүү.

-Сүргийн бүтэц, тоо толгой

Манайх чинь 40 гаран 50-иад л үхэртэй, голдуу үнээ, тугал, бяруугаа тэжээдэг. Хавар эрт таанатай газарт идүүлнэ, ингэх нь хонинд их сайн, хавар махан тарга авахуулдаг, махан тарга авахуулсан байхад өөхөн тарга сайн суудаг. Өлөн рүү орж л өөхөн тарга авахуулдаг.

-Залуу малчдад тулгамдаж буй зарим асуудалд

Манай энд ус их хүндрэлтэй шүү, энд худаг байдаг, гэхдээ энэ худагт хүссэн хүн болгон услаад байдаггүй, уул нь сумаас нэг хүнд хариуцуулаад өгсөн юм байна лээ, ойрхон байдаг айлд мотор энээ тэрийг нь хариуцуулаад өгсөн чинь нөгөө хүн нь хувьдаа эзэмших маягтай болсон. Тэр хүн нь мотороо худагтаа хийгээд түгжээд, түлхүүрээ аваад явчихдаг, тэгээд бусад нь малаа услаж чаддаггүй. Манай энд гол ус нь өвөл хөлдчихдөг болохоор худаг усны хүрэлцээ бол тааруухан шүү. Бэлчээрийн даац ер нь их тааруухан шүү, өвөлжөө, хаваржаа нь хоорондоо 2,3 км зайтай. Бэлчээрийн даац хүндхэн талдаа, хур бороо ихтэй, бэлчээрийн гарц гайгүй бол бас болно, ёстой нэг хазаар багтахаараа идэж, хаяа багтахаараа бууна гэдэг шиг.

-Бэлчээртэй засан зохицох уламжлалт зан үйл

Уул тахидаг. Намар 8-р сарын сүүлээр 9-р сар гаргаад ч юм уу, намартаа тахьдаг шүү, Сахалт хайрхан л гэдэг. Жилд нэг айл хариуцаж аваад төрөл садан, удмаараа даагаад тахилга хийдэг. Жил болгон тахилга хийдэг.

Би залуу малчин хүн учраас одоогоор туршлага багатай. Мал маллах сайхан шүү, цэвэр агаарт сайхан. Залуу улсуудад халуунд халж, хүйтэнд хөрөх хэцүү байдаг

болов уу, хотын соёлд л их татагддаг шиг байна. Хөдөө ч сайхан шүү өөрийн эрх дураар, хотоос дутаад байх юм алга боллоо шүү, бүх л юм байна. Жилийн дөрвөн улиралд сайхан шүү, тэмээнээс бусдыг нь л маллаж байна. Сүүлийн үед мотоцикл, машинаар малаа их малладаг болсон байна. Мотоцикл малдаа их л муу байдаг, мориор явахад их сайхан, малаа туугаад явсан ч амар л байдаг. Малаа их сайн ажигладаг, мал үргэхгүй, морьтой явган хослуулаад туугаад явахад сайхан шүү.



(34-р зураг)

**1.3.12 ДОРНОД АЙМГИЙН ХӨЛӨНБУЙР СУМЫН МАЛЧИНСАЛХИН ОВГИЙН
Д.ДАВАА(1962 ОНД ТӨРСӨН), Д.ЭНХТУЯА(ЭХНЭР)**



(35-р зураг)

-Бэлчээрийн өөрчлөлт

Шалтгаан нь малын тоо, толгой ихэссэн. Малын тоо, толгой ихсэхээр бэлчээр талхлагдаад цөлжиж байна. Ялангуяа Хэрлэн голын хөвөө, тохойталдаа бэлчээр талхлагдаад, улмаар үлийн цагаан огтоно ихсэж байна. Удахгүй хээрийн бэлчээр рүү огтоны нүүдэл тэлж ирэхвий гэж санаа зовох юм. Малын тоо толгой ихсэхээс гадна бүх айлууд голын тохой талдаа хавар, зун, намрын улирлыг өнгөрөөж байна. Учир нь хөдөө талдаа усны хомсдолтой. Тиймээс эртхэн цас орвол голоос гарч завсрын бэлчээрт бугаад, их хүйтрэхээр өвөлжөөлдөг.

-Үлийн цагаан огтоно намнах энгийн арга

Төр засгаас маш их зардал гаргаад огтоны хор тарааж байна. Заримдаа тэр нь хүрэлцэхгүй. Тэгэхээр малчид болон сумын төвийн ажилгүй хүмүүсээр үлийн цагаан огтоно агнуулах аян өрнүүлмээр байна. Тэгээд 1 огтоно намнахад 100 төгрөгийн урамшуулал өгч яагаад болдоггүй юм. Жишээ нь, огтоно сүлжиж явдаг зам дээр нь томоохон хуучин муу сав суулга булчихаар тэр дотор ороод үхээд байх юм. Энэ аргаар маш олныг хороож болохоор байна. Ундааны сав ч байсан болж байна. Бидний хувьд энэ аргыг туршиж үзсэн маш сайн болж байна. Хангай талыг бодвол

манай нутаг бэлчээр зөөлөн хөрстэй учир газарт урхи сав булахад төвөг алга. Огтоно улам ихсэхээс өмнө энэ аргыг ашиглавал зүгээр гэж итгэж байна.

-Сүргийн бүтэц, малын тоо толгой ба амжиргаа

Маш олон тоо толгой мал хэрэггүй. Нэг айл 1000-аас доош толгой малтай байхад амьдралд хангалттай хүрэлцэхээр байна. Харин хөрөнгөжиж баяжих хүсэлтэй нь 2000-3000 хүргээд хөрөнгө сангаа хуримтлуулж аваад малын тоо, толгойгоо бууруулах тохиолдол байна. Энэ нь зөв гэж бодно. Нутаг бэлчээрт таарсан тоо, толгой гэвэл, 100 орчим үхэр, 100 орчим адуу, тэгээд 500-600 орчим бог малтай байхад болно. Бодын тоо толгой үүнээс ч цөөхөн байхад амьдралд хүрэлцэж байна. Сүргийн бүтцийн хувьд бог, үхэр, адуу элбэг байна. Харин тэмээ ховордсон. Үндсэндээ манай нутгийн сүргийн бүтэц нь 4 хошуу малаас голлон бүрдэж байна. Адууг хэт ихдүүлж болохгүй. Хатуу, хурдан хөлтэй мал учраас бэлчээр талхлаад дуусгачихдаг юм.

-Малчны залгамжийн асуудал, монгол малчны ирээдүй

Малчин айлууд хүүхэд цөөхөнтэй байна. Малчны бүл хүчинд саад болж буй нэг том асуудал байна. Тэр нь 6 настай хүүхдийг сургуульд сургаж байгаа явдал болж байна. Тэгээд аав нь ганцаараа мал маллана. Малаа хүчрэхгүй зарим нь туйлдаж ядрана, зарим нь архи дарс ууна. Ингээд гэр бүл салах үзэгдэл ч гарч байна. Энэ учиртай ийм хачин боловсролын тогтолцоо нэвтрүүлснийг нь хэлж мэдэхгүй юм. Боловсролын энэ тогтолцоо лав манай улсын бэлчээрийн мал аж ахуй эрхлэгчдэд тохирохгүй байна. Үүнийгээ засах байлгүй. Олон малтай, эсвэл бид нар шиг бүл хүч хомс айл малчин авч ажиллуулж байна. Залуучууд сумын төв дээр зүгээр гараа хумхиж суугаад байх санаатай. Айлын мал маллаад цалингаа аваад амьдрах хүсэлтэй залуу хүн цөөхөн байна. Мал маллалаа гэхэд зарим нь хариуцлага алдана. Тиймээс цаашид жинхэнэ монгол малчингүй болох юм байна. Тэр 6 настай хүүхдийг ямар юмаа хийж сумын төвд элдэв янзын номоор дарамтлаад монгол хөрснөөс нь холтгоод байгаа юм. Малын захад нь байлгаж унаган монгол малчин эрдэм, боловсролд нь ойртуулах хэрэгтэй.

2019.11-р сар.

**1.3.13 ДОРНОД АЙМГИЙН ХӨЛӨНБУЙР СУМЫН ЗАЛУУМАЛЧИН
Б.САНЧИРЫНХАН(1994 ОНД ТӨРСӨН)**



(36-р зураг)

-Бэлчээрийн байдал

Манай нутаг бэлчээр бог малд илүү тохиромжтой. Үүний дээр цөөхөн үхэр, адуу байхад болно. Малын тоо толгойг нэг хэсэг олшруулж байгаад жаахан хөрөнгө хуримтлал үүсгэнэ. Дараа нь цөөлж нутаг бэлчээртэй тохируулахгүй бол бэлчээрийн даац ихсэх шинжтэй байна. Бэлчээрийн даац ихсэхээр бэлчээрийн дахин сэргэлт удааширч цөлжилт явагдана. Жишээ нь, манай нутгийн хавар, зун намрын бэлчээр буюу голын тохойд бэлчээр муудаж, үлийн цагаан огтоно үзэгдэх болсон.

-Малын тоо, толгой

Малчид хангалттай мал хөрөнгөтэй байна. Хамгийн багадаа 1000 орчим толгой малтай байна. Тэгээд түүнээс дээш 2000, 3000-аас ч илүү толгой малтай айл байна.

-Залуу малчдад тулгамдсан асуудал

Залуу малчид бид ганц ганцаараа мал маллахаас илүүтэй найз нөхдөөрөө нийлээд хөдөөгийн нэг айлдаа малаа төвлөрүүлээд маллах сонирхолтой. Манайх ч энэ зарчмаар явж байна. Яахав сул тал нь нэг сүрэгт олон мал тоологдоно. Эдийн засгийн хувьд аль аль талдаа өгөөжтэй, хэмнэлттэй юм. Бас хэд хэдэн айл бүл хүчээ нэгтгэхээр малын хариулга, арчилгаанд хүртээмж боломжийн байна. Манайх л гэхэд 2 найзтайгаа хамтарч байна. Бидэнд нэг тулгамдсан асуудалд бол нутаг орны хэмжээнд малын төвлөрсөн томоохон хашаа хэрэгтэй байдаг. Тал хээрийн бэлчээр учраас шуурга салхинд мал уруудаж алдагдаж, хойноос нь яваад эрсдэлд орох нөхцөл байдал үүсдэг. Тиймээс баг, айл өрхүүд дундаа нэлээн том хашаатай болмоор санагддаг. Тэнгэр эвгүйрхэд, холын хөлийн малаа хураан хашаад цаг агаарын саад бэрхшээлийг гайгүй шиг давах боломж харагддаг. Бас зөөврийн хашаа ч хэрэгтэй л юм байна. Яагаад хашаа яриад байна гэхээр манай тал нутагт хэн дуртай нь мод татаад хашаатай болох арга алга. Бас төмөр сараалжин хашаа ч байж болмоор санагдана.



(37-р зураг. нөөц өвс)

1.3.14 ДОРНОД АЙМГИЙН ХӨЛӨНБУЙР СУМЫН УЛСЫН САЙН МАЛЧИН ГАЛЗУУД ХАЛТАЙ ОВГИЙН ПЭРЭНГЭЛЭЙНБАТДОРЖ

(1960 ОНД ТӨРСӨН, 1-Р БАГ)



(38-р зураг)

-Бэлчээрийн даац, тохиромж

2002 онд Улсын Сайн малчин болсон. Манай нутагт өөр аймаг сумдаас бэлчээр хөөсөн малчид их ирж байна. Тэр малчид нь дунджаар 2000, 3000 орчим малтай ирэх юм. Ялангуяа адуу ихтэй ирдэг. Сум орон нутгаараа яриад ийм отрын төрлийн малчдыг нутгаас гаргаж байсан удаа ч бий. Гэвч бас адилхан монгол хүн болохоор яаж ч болохгүй юм билээ. Жишээ нь манайхны өвөлжөө хавиар өөр сум, аймгийнхан ирээд худаг гаргаад нутаглаж байна. Тэгэхээр бид нар уламжлалт өвөлжөөгүй болчихож байна. Тэгээд бэлчээрийн отор хийж яваа хүнийг хөөж болохгүй гээд дүрэм гарчихсан. Бид нар бол өвөлжөөний хол, ойрын хоёр бэлчээртэй. Одоо бол хоёуланг нь отор нүүдлийнхэн идэж байна даа. Манай энэ хавьд лав 20 гаруй өөр аймаг, сумын малчин айл нэмэгдсэн. Бас АПУ-гийн Батхүү гэдгийн мал их байна. Үйлдвэр энэ тэрдээ хэрэглэдэг юм байлгүй. Угтаа энэ нутагт

бол 1000 орчим, 700,800-н малтай айл хангалттай амьдарч байна. Манай нутаг бэлчээр эртнээсээ бог малд илүү тохиромжтой.

-Бэлчээр цөлжилт

Бэлчээрийн даац хэтрээд, цөлжилт эрчимжиж явагдаж байна. Урьд зэрлэг сонгино, хялгана, хаага, тариа, агь, мангир г.м 20 орчим төрлийн бэлчээрийн өвс ургадаг байсан. Одоо нэлээд цөөрсөн байгаа. Энэ бол манай нутгийн бэлчээрийг харахад өвс нь өндөр боловч төрөл зүйл нь хомсдон цөлжиж эхэлсний нэг тэмдэг болно.

-Бэлчээр дэх хадлангийн асуудалд

Манай сум орон нутгийн удирдлагууд хол хөлийн малынхаа бэлчээрийг хадуулчих юм. Би эд нарт хэлээд л байгаа юм. Тэр хадсан бэлчээр чинь манай нутгийн малчдын адууны бэлчээр шүү гэж. Тэгэхээр тэр хадаж халцалсан газар нь адуу эргэлдэж л байгаа юм. Яг энэ янзаараа удах юм бол одоо тэр хадлан аваад байгаа бэлчээр нь удахгүй цөлжиж мэднэ.

-Сүргийн бүтэц, алсын хараа

Манай нутагт тэмээ ховордсон. Гэхдээ бас бий. Би бол хэдэн тэмээн тэрэг хөллөдөг. Хуучин нэгдэл гэж байхад тэмээ олонтой байв. Хувьчлалаар тараагдсан. Тэгээд тэмээ цөөрсөн. Тэмээ угтаа өөрөө яваад хоолоо олоод идчихдэг мал шүү дээ. Адуу элбэгшиж байна. Энэ бэлчээрт тийм ч тохиромжгүй. Хэдэн үхэр бол болж байна. Хонь, ямаанд бол аргагүй тохиромжтой нутаг. Уг нь тэмээнд тэрэг болон ердийн хөсгийг устгаж болохгүй гэж боддог. Одоо бензин шатахуунгүй болбол яах вэ? Малчин хүн бол байгалаас бусад зүйлээс хараат бус юм. Энэ чанарыг хадгалж байх нь чухал гэж боддог юм.

-Монгол малчны залгамж

Залуучууд яахав мал маллах нэг нь сонирхоод явж л байна. Лавтай над мэтийн настайчуудаас үг авдаг хорвоо өнгөрсөн. Өөрсдөө мэдэж байгаа юм байлгүй гэхээр малын тоо толгойгоо бэлчээртэй тохируулж чадахгүй, малынхаа боол болж

байгаа харагдах юм. Мал маллах сонирхолтой залуучууд байна. Мал маллана гэдэг чинь өдөр болгон нэг ажлаа уйгагүй давтахыг хэлж байгаа юм. Гэхдээ мал маллах хавар, намар, өвөл, зун гэсэн ерөнхий 4 өөр хувилбар маллагаа байдаг.

-Малчны зөгнөл

Манай барга нар ХХ зууны эхэн дунд үед энд нүүж ирсэн. Дээр үед хөгшчүүл нэг үг хэлдэг байсан юм. Тэр нь юу вэ гэхээр, "Мал аж ахуй нэг хумигдаж нэгдэлжээд, туйлдаа хүрэхээр буцаж задраад, задарсан нь эцэстээ хүрээд эмх замбараагүй байдал газар авахаар эргэж нэгдэл шиг базагдаж эмх цэгцэнд орно" гэж ярьдаг байлаа. Тэгэхээр одоо бол нутаг бэлчээрийнхээ даацыг тооцохгүйгээр малаа өсгөж байна. Бэлчээрийн даац хэтрэхээр эргээд өөрийг нь төдийгүй нутаг орон даяар муу нөлөө үзүүлж байна. Энэ бол зарим малчид хэтэрхий дураараа, бас соёлгүй бүдүүлэг байгаагийн л үр дүн байх. Малын тоо толгойгоо нутаг бэлчээртэй тохируулахаас гадна, нутаг усны ерөнхий малчдын байдлыг ч бас харгалзан үзэх учиртайсан. Тэгж байж л зах зээлийн нийгэмд малчид харилцан ойлголцож амьдрах бололтой юм.



(39-р зураг. барга нарын тэмээн тэрэг)



(40-р зураг. Малын аргал, хөрзөн түлш хадгалалт)

2019.11-р сар.

**1.3.15 СҮХБААТАР АЙМГИЙН ТҮМЭНЦОГТ СУМЫН МАЛЧИН ХАТАГИН
Ц.ОЁО (1950 ОНД ТӨРСӨН, 1-Р БАГ)**



(41-р зураг)

-Бэлчээрийн даац, цөлжилт

Бэлчээрийн даац хэтэрсэн. Яагаад хэтрэв гэхээр нэг өрх айлын малын тоо, толгой хэт өссөн. Бас манай нутаг адууны отрын бүс болчихоод байна. Адуун сүргийн хөлд бидний өвөлжөөний бэлчээр талхлагдаж байна. Ялангуяа манлай уяачдын сүрэг хэт олон байна. Нэг том уяач байхаар түүнд хотын баячууд адуугаа авч ирж маллуулж адгуулж байдаг бололтой. Жишээ нь, 2000, 3000 мянган адуутай манлай уяач байна. Тэдний адуу бол хол хөлийн мал учраас жилийн дөрвөн улиралд бидний өвөлжөөг талхалдаг. Энэ бол нэгдсэн зохион байгуулалт сул байгаатай холбоотой гэж харж байна. Бэлчээрийн даац хэтрэх, цөлжих нэг шалтгаан нь энэ болно. Нөгөө шалтгаан нь даац хэтэрсэн бэлчээр үлийн цагаан огтоны өсөн үржих таатай орчин болдог бололтой. Сум орон нутгаас хор өгөөд устга гэх л юм. Тэр хор нь хаанаа ч хүрэлцэхгүй байна.

-Бэлчээр дэх сүргийн бүтэц, малын тоо толгойн тохиромж

Малын тоо толгой хэтэрсэн. Тиймээс манайх бол малаа цөөлөөд 1000-аас дотогшоо оруулсан. Бэлчээр хүрэлцээний хувьд одоохондоо 1 айл өрх 500-600

хоньтой, нийт 100 орчим бод малтай байхад амьдрал ахуй, бэлчээрийн даацад хүрэлцэж байна. Бэлчээрт бас нэг нөлөөлж байгаа зүйл бол зохисгүй хадлан. Хаа байсан хотоос хүртэл ирээд бидний өвөлжөөнд хадлан хийгээд аваад явчих юм. 2004 оны орчмоос хойш энэ мэтээр бэлчээр сүйдсээр өнөө хүрлээ. Одоо энэ нутгийн бэлчээр цөлжиж эхэлсэн. Олон төрлийн өвс ургамал ургадаг байсан нь багасаад 1 наст ургамал зонхилох боллоо. Тэр нь хазаар, шивээ өвс мэт чанар тааруу, хийсч тарж бутраад алга болох нь их юм. Манай нутагт тэмээ цөөхөн. Харин 2-р баг тийшээ тэмээтэй. Тэмээ бол маллагаа хөнгөнтэй мал.

-Залуу малчин ба монгол малчны залгамжийн асуудалд

Энэ нутагт залуу малчид маш ховордсон. Учир нь адууны соёл хэт давамгай хөгжиж байна. Тиймээс залуучууд баян хүмүүсийн адууг маллах сонирхол их байна. Тэгэхээр залуучууд бог мал, үхэр, тэмээ зэргийг маллах уламжлалт аргыг сонирхохгүй байна. Маллахыг ч хүсэхгүй байна. Энэ бол маш эрчимтэй дэлгэрч байгаа үзэгдэл. Адуу л гээд байхаас хонь яаж маллахыг залуучууд орхисон. Нөгөөтэйгүүр, ганцхан мөнгө бодож мал маллавал бэлчээрийн мал аж ахуй эрхлэх боломжгүй гэдэг нь ажиглагдаж байна. Эмгэн бид хоёр олон малтай байхдаа хэд хэдэн малчинтай байсан. Харин одоо 1 малчинтай. Ерөнхийдөө сумын төвийн ажилгүй залуучуудад 1 сард 300-400-н мянган төгрөгний цалин өгөөд, хоол унд, гэр хороог нь даагаад ажиллуулъя гэхэд мал маллах залуу олдохгүй байна. Сумын төвдөө л ажилгүй, бие амар гар хумхиад, бусдаар тэжээлгээд хэвтэж байх залхуугийн сонирхол нь хэт өндөр байна. Харин ирээдүйн жинхэнэ монгол малчны сэтгэлгээтэй боловсон хүчнийг багаас нь бэлтгэж байхгүй л бол алс хэтдээ мөнгөний хэдэн адуучинтай л үлдэх бололтой. Тэр хэдэн адуучид нь адуугаа маллана гэхээсээ илүүтэй морь л уядаг, малчин гэхэд хэцүү, малчин биш гэхэд бас хэцүү хүмүүсээр монгол дүүрч магадгүй байна. Бас нэг зүйл нэмж хэлэхэд, ганц бие залуу малчин маш их боллоо. Сум, хөдөө гэж гэр орон нь хоёр тасраад энэ шүү дээ. Энэ байдлын шалтгааныг зөв олж байж шийдэхгүй бол манай нүүдлийн соёлтой монгол улс ирээдүйд малчин айл гэж байхгүй, малчин хүн л гэж байдаг болох вий гэж санаа зовох юм.

2019.11-р сар.

**1.3.16 ЗАВХАН АЙМГИЙН УРГАМАЛ СУМЫН 4-Р БАГИЙН ДУНД ҮЕИЙН МАЛЧИН
АЛАГ АДУУН МАГСАРЖАВЫН СҮХГЭРЭЛ (1974 ОНД ТӨРСӨН)**



(42-р зураг)

-Нутгийн хуучны том малчид

Баян-Улаан багийн нутагт цараатай том малчид цөөнгүй байжээ. Дурдвал, Хөвхөгөр Дорлигжав, Дачинсүрэн Шаагаа, Цэрэндорж, Магсаржав, Гунгаа, Баянхүү г.м. Тэдний үеэс хойш залуу сайн малчид улам орширч байна.



(43-р зураг)

-Малын тоо толгойн өөрчлөлт ба малчид

Ялангуяа XX зууны дунд үед малчин айл өрх элбэг байж. Хаяа хаяагаа дарж буудаг, нягтаршил их байжээ. Гэвч ч бие биенийгээ ад үздэггүй айраг цагаагаа гаргаад дуулж хөөрч найрлаад сайхан байдаг байв гэнэ. Харин орчин үеийн малчин залуучууд бие биенийгээ ад үздэг, бэлчээрээ булаацалдах нь түгээмэл үзэгдэл болсон байна. Яагаад ингээд байгааг ахмад малчид тайлбарлаж мэдэхгүй байна. Гэхдээ малчин айл цөөхөн болсон хэдий ч малын толгой олшрохоор ингэдэг байж болох тухай ярьж байна. Урьд цагт буюу XX зууны эхэн дунд үеэс хойш XXI зуун гартал дээд тал нь 700-800, доод тал нь 50-60 малтай айл элбэг байсан аж. Тэр үед малчид бие биенийгээ ад үзэх зүйл огт байдаггүй байсан тухай ахмад малчин М.Бадамдорж ярив. Харин одоо 500-2000 орчим малтай айл олон байна. Гэхдээ мал олон болсон ч малчид цөөрсөн байна.

-Бэлчээрийн тохиромж

Уг нутаг бэлчээрт таван хошуу мал дотроос зудны ариг даадаг нь бог мал байсаар иржээ. Адуу болон үхэр сүргийг элсэн бөөрөг, нөмөр бараадуулж оторлох аргаар маллахгүй бол тун хэврэг мал гэж үзсээр иржээ. Сүүлийн үед ямаа олшроод ямаанаас болж бэлчээрийн даац муудаж байна гэх ойлголт түгээмэл болсон гэнэм. Харин ахмад малчин ямаанд буруу өгөхгүй байна.



(44-р зураг)

-Өвлийн улирлын бэлчээр



(45-р зураг)

Завхан аймгийн Ургамал сумын нутаг дэвсгэрт хээрийн болон говийн бэлчээр зонхилдог Уг сумын "Баян улаан" баг (4-р баг)-ийн малчид өвлийн сэрүүн улиралд "хангай талаа бараадах" буюу Сарт Таван толгой, Буурал, Аргалын Хар уулс, түүний ар хондлой, сээрийг түшиж өвөлжинө. Тэдний хангай талын бэлчээр нь уулархаг хад цохио элбэгтэй, харгана, хөх шаваг, ортууз зэрэг бутлаг ургамал зонхилно. Тиймээс ямаа голдуу сүргэд илүү тохиромжтой. Харин хадархаг цахир уулын бэл хормой, тал хөндийгөөр нь хялгана, ортууз, таана, мангир, шар шаваг, хазаар, чөдөр өвс зонхилохын сацуу баглуур г.м олон зүйлийн нарийн өвс ургадаг. Тиймээс уул хангайнхаа бэл талд хонин сүргээ тусад нь хариулна. Бас монгол үхэр сүрэг нь тэрхүү бэл, талаар бэлчиж хээрийн өндөр сахлаг өвс ургамалаар хооллож өвөлжинө. Тэмээн сүрэг нь нөмөрлөг уулсын дундах өргөн, урт хөндий хоолойн бэлчээрт харгана (ямаан, тэмээн, үхэр харгана), шаваг зэрэг модлог ургамалаар хооллоно. Энэ нутагт ямаанаас гадна адуун сүрэг зонхилно. Адуу нь өвөлдөө уулсын бэл, толгод хийгээд Хомын талаар дамжин Завхан голын бургасан шугуй руу шургаж өвөлжих тохиолдол байдаг. Уг нутаг өвөлдөө баруун зүгээс хүйтэн салхи үлээх нь элбэг бөгөөд нутгийнхан "салхины хуугаан" гэж нэрлэнэ. Бас өвлийн оргил үед Их

нууруудын хотгорын цан хүүрэг татаж манан будантах үе багагүй тохиолдоно. Хэдийгээр салхирхаг, хур хундас багатай ч өвөлдөө 20-25 хэм, зарим үед 28 орчим хэм хүртэл хүйтрэх тохиолдол байдаг тухай сумын аварга малчин М.Сүхгэрэл хуучилж байна. Энэ нутгийнхан өвөлжөөндөө малын хашаа хороо бараг байхгүй. Уул хадны нөмөрлөг задгай хоттой. Их хүйтэрсэн үед хотны бууц хэрзэнг ухаж малтан нүх гаргаад, түүнд жижиг сул дорой малыг шөнөдөө оруулан хонуулдаг уламжлалтай байна.

-Хаврын улирлын бэлчээр



(46-р зураг)

Завхан аймгийн Ургамал сумын Баян-Улаан багийнхан өвлийн улирлын шувтрага, хаврын улирлыг угтан хангайнхаа өндөр уулын бэлчээрээс бууж Худгын цахир, Цагаан овоо, Баглуурт, Их, Бага хайрхан уул, толгодоор нутаглана. Энд цагаан сарын шинэлэх зан үйлээ гүйцэтгэнэ. Үүнийг зарим жил "Завсрын бэлчээр" гэж нутгийнхан үзнэ. Завсрын бэлчээр нь өвлийн бэлчээрээс нам дор газар байх бөгөөд давслаг хужирхаг баглуур г.м өвс ургамал элбэгтэй. Уул, толгодын хавцал, жалга, судаг, гуугаар өвлийн цасны үлдэгдэл буюу малын ундны цас тохиромжтой хэмжээнд байвал завсрын бэлчээрт хаврын улирлын нэлээд цаг хугацааг өнгөрөөж,

мал төллүүлэх цагтай золгоно. Энэхүү бэлчээрт төллөх дөхсөн хээлтэй малаа цатгаж, нам газрын уул толгойн нөмөрт төл малаа хүлээн авч буй нь энэ юм. Ингээд малын ундны цас хүрэлцэхээ больж бэлчээр бүрэн бараантвал худаг усалгаанд шилжинэ. Их, Бага хайрханы худаг, бас Ногоон өндрийн өвөр, ар худаг зэрэг ундны эх үүсвэр нь төлөлсөн малын усны гол эх үүсвэр болно. Хаврын улирлын гол ажил болох мал төллөж, төл мал хөрвөөд нүүдэл тууврын ая даах болоход завсрын бэлчээрээс хойшлон нүүж хаврын үндсэн бэлчээртээ суурьшина. Хэрвээ хавар салхи шуурга багатай, өвс элбэгтэй, мал тарган орсон бол хаврын үндсэн бэлчээрт малаа төллүүлэх тохиолдол ч байдаг. Хаврын үндсэн бэлчээр нь угтаа Хүнгүйн голыг бараадсан дэнж, талын бор толгодын нөмөр газрын бэлчээр юм. Энэ бэлчээрт модон хавтангууд бүхий хашаа хороо ч бий. Цас эрт хайлах, завсрын бэлчээрийн өвс хаврын дэнж газраас сийрэг, тачирхан байвал уг дэнж, хотгор, гүдгэр газрын бэлчээрт ирж малаа төллүүлэх нь элбэг аж. Ингээд төл хөрвөж, жалга судаг, харгана бутны нөмрөөр шинэ ногоо үзэгдэх үед ямаагаа самнаж дуусгаад "голын бэлчээр"-т суурьших буюу зуншлага эхэлдэг билээ.

-Зуны улирлын бэлчээр



(47-р зураг)


Зуны улирлын бэлчээр нь Хүнгүйн голын сав дагуух зуслан юм. Ургамал сумын 4-р багийнхан үнээ, ямаа, ингэ голдуу ялгах, саах зөрүүлэх г.м хэлбэрээр саалинд хэрэглэнэ. Дээхэн үед гүү уяж айраг исгэж уудаг байв. Харин өнөө цагт нутгийн уугуул иргэд зүүн зүгт ихээхэн нүүж суурьших болсноор нэгдүгээрт: хүний бүл хүчгүйдэж, хоёрдугаарт: малчин өрхийн тоо цөөрсөн хэдий ч 1 айлд дунджаар 1000-1500 орчим мал ноогдох болсноор малчдын ачаалал ихэсчээ. Ихэвчлэн нэг айл 3 хүүхэдтэй байхад 1 хүүхэд нь малчин мэргэжлээрээ дагнаж байна. Эсвэл бүх хүүхдүүд нь хот суурин газар бараадаж их, дээд сургуульд суралцан малчин бус өөр мэргэжил эзэмшсэнээр зөвхөн аав ээж нар нь мал маллан, хүүхдүүдийнхээ санхүүгийн эх үүсвэрийг хариуцах тохиолдол түгээмэл байна. Нүүдлийн иргэншил, суурин иргэншил хоёрын харилцан уялдаа нь энэ мэтээр илэрч байгааг малчид ярьж байна. Тэдний амьдралаас ч бодитоор харагдах аж.



(48-р зураг)

Завхан аймгийн Ургамал сумын 4-р багийн малчид гол усны бэлчээрт зун цагийг өнгөрүүлж, малдаа шинэ ногооны өөхөн тарга авахуулахдаа сүргийн бүтэц, тоо толгойг ялган зүйлчлэх хэд хэдэн аргатай. Жишээ нь, бог малыг голын урд хөвөө, эрэг дэнж газар бэлчээрлүүлэхээс гадна, голын хойд тал, элсний хаяа, манхан дамжуулж бэлчээдэг. Элсэн манхан бараадуулж бэлчээрлүүлэх нь голын урд талын эрэг дэнж газрын өвс ургамлаас ялгаатай гэж үздэг аж. Учир нь элсэн манхан, манханы хөвөөгөөр туулайн тагнай, агь, ганга, суль, хиаг, таана мангир зэрэг сийрэг боловч амт чанар сайтай "торгон өвс" ургадаг гэнэ. Энэ төрлийн бэлчээр нь ялангуяа ямаан сүрэгт илүү тохиромжтой. Мөн Хүнгүйнголын ширэг дагуу түнгэ, дов газрын хужир мараа элбэгтэй тул мал өөхөн тарга хуримтлуулах, махны амт чанар сайжрахээрэг өгөөжтэй. Баян-Улаан багийнхан 9-р сарын дунд хүртэл зуны бэлчээр дээрээ суурьшин цагаан идээ зэрэг малын ашиг шимээ хуримтлуулна.

-Намрын улирлын бэлчээр



(49-р зураг)

Ингээд 9 дүгээр сарын дунд, 10 дугаар сарын эхээр зарим хэсэг нь Монголын элс рүү орж Бор хяр зэрэг элсэн хөндийд отор хийнэ. Учир нь элсэн манхан, хөндийн ногооны сөл тал газрынхаас хавьгүй орой онгодог /сөл буудаг/ билээ. Ингэж элсэнд отор хийхдээ зөвхөн бог малыг оторлоно. Харин бод мал нь голоос гараад намартаа хуурай хээрийн бэлчээрт шилжинэ. Зарим тохиолдолд хээрийн бэлчээрээс 10 орчим келометрийн зайд Хүнгүйн гол байх тул малыг 2-3 хонуулаад туувраар усална. Эсвэл моторт худаг, гар худгаар усны хэрэгцээгээ хангана. Үндсэн намрын бэлчээрт буухгүйгээр "завсрын бэлчээр"-т бууж малаа тууврын аргаар Хүнгүйн голд услах тохиолдол элбэг юм. Харин намрын үндсэн бэлчээр нь тэрхүү худаг бараадаж бэлчээрлэх хэлбэр билээ. Намар цагт тэмээ холын бэлчээртээ гарна. Адуу уулсын дундах том, том хөндий хоолойгоор бэлчээрлэн шинэхэн хэнзэлсэн таана хөмүүлээр хооллох тохиолдол элбэг юм. Бог мал мөн адил 10 сарын эхээр хэнз ногоонд бэлчээрлэж, худгийн хүйтэн усаар ундаалснаар тарга хүч жигдэрнэ. Энэ нутгийнхан намар цагт "ямааны элгэн тараг" бүрж ууна. Бас гүзээ, сав суулганд хийж нөөцлөнө. Эм ямааг, эсвэл ишигээ ялгаж уул хаданд тусад нь бэлчээнэ. Өдөрт нэг удаа ямаагаа шувтарч чанарлаг, гайхалтай амттай элгэн тараг бүрж намрын хүнсэнд хэрэглэнэ. Мөн суль, сульхирын үрээ хуурч тээрэмдээд цагаа идээтэй хольж иднэ. Ингээд намрын улирлын бэлчээрт анхны цас ортол малын тарга тэвээргээ гүйцээн тогтооно. Малын унданд хүрэлцэхүйц цас орвол өвөлжөөндөө бууна. Цасны хэмжээ бага байвал цаг агаарын байдлыг харж байгаад өвөлжөөндөө бууж өвлийн худаг усалгаанд шилдэг уламжлалтай.



(50-р зураг)



(51-р зураг)

2018 он

**1.3.17 ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ШАРГА СУМЫН БАЯНГОЛ БАГИЙН МАЛЧИН
ЗУНДУЙГИЙН ДАМДИНДОРЖ /УРГИЙН ОВОГ УРИАНХАЙ, 1957 ОНЫ ТАХИА
ЖИЛТЭЙ, ЭРЭГТЭЙ/**



(52-р зураг)

-Сүргийн бүтэц, тоо, толгой

Намайг Зундуйн Дамдиндорж гэдэг. Би 1957 онд төрсөн. Манайх Говь-Алтай аймгийн Шарга сумын Баянгол бригадаар нутагтай. Манай өвөлжөө Хармагтад, зуслан Шаргын гүүр, энэ хавиар дээшээ 10-аад км зайтай. Ууланд өвс муутай бол энэ тал руугаа намаржиж өвөлждөг. Энэ голд бог байдаггүй ээ, дан бод байдаг, их хүйтэн, өнгөрсөн өвөл гэхэд -54 градус хүрч хүйтэрсэн. Өвс тэжээл өөрсдөө бэлтгэдэг. Жилд 3-4 тонн өвс айл болгон бэлтгэдэг. Энэ тал өөрөө хужиртай болохоор хужир шүү бэлтгэдэггүй.

Тэмээ бол тааваараа бэлчдэг мал, нэг их хариулаад байх хэрэггүй. Өглөө бэлчээгээд орой хураагаад сургачихдаг. Заг, бударгана л байж байвал гайгүй, зунд нь таананд оторлоно. Манай энд бэлчээрийн даац хүрэхгүй байна гэх юм байхгүй. Ус л байвал болно. Айлууд хоорондоо зай ихтэй, зүүншээ л гэхэд 30-аад км зайд айл байхгүй. Отроор явбал нутаг зөндөө. Амны ус гар худагтай.

Хувьчлалд гараад 40-өөд тэмээ аваад үлдсэн. 1957 онд байгуулагдсан “Говийн хөгжил” нэгдлийн анхны гишүүн нь манай аав байсан. Тэр нэгдэлд 300-аад тэмээ хариулж байсан, ер нь 300-аас доош буулгаагүй дээ, чавганцтайгаа хоёулаа. Сард нэг тэмээ 1 төг, сард 208 тэмээнээс 208 төг л авна. Нэг хүний 1 сарын норм нь 80 тэмээ байсан. тэгээд би 160-ыг хариулах ёстой, тэгээд тэмээг маллах хүн олдохгүй би нэмээд авчихдаг. Тэмээг их л сургасан даа. Гурван наснаас нь сургаад л, ачлагад хэрэглэнэ. Дандаа тэмээгээр нүүдэг байлаа, харин ойрын 3, 4 жил энэ портер гээд машинаар л нүүж байна. Надад бол одоо нүүдэг тэмээ байна, түүндээ ачаад л явна.

Хүргэнийхтэй нийлвэл зуу хүрнээ манай тэмээ, өөрийнх бол 40-өөд тэмээ байна. Гаднаа арван дөрвөн ботго уясан байна. Бог малын хариулга бол би сайн мэдэхгүй, говьд ямаа ихтэй. Ямаа бол энд болоод л байна.

Тэмээ уядаг, “Тэмээний баяр”-т тэмээг гүйлгэж услаад 20-иод хоног уядаг. Би урьд нь морь уяж байсан, сумын алдарт уяач. 10 гаруй айраг түрүүтэй. 1982 онд цэргээс ирээд 2000 он болтол морь уясан. Шүдлэн уяж 7, 8 удаа аман хүзүүдсэн. Энэ нутгийнхаа унаган адууг л уядаг. Суманд л уралдаж байсан, аймгийн ойд очиж уралдаж үзсэн, айраг, түрүү барьж байгаагүй.

-Отор нүүдлийн асуудал

Манай баг руу бол гайгүй, өөр багууд руу бол орж ирдэг л юм. Манай ийшээ бог бол орж ирэхгүй, харин тэмээ, адуу зэрэг бол орж ирдэг л юм. Төгрөг сум руу их орж ирдэг. Манай сум 4000 тэмээтэй, аймагтай ахалдаг шүү. Тэмээний арьсаар сур хийдэг, суран бугуйл, суранногт хийнэ. Манайх суран бугуйл их хэрэглэнэ, манай ийшээ ус ихтэй болоод суран чөдөр хийхгүй, хазаар ногт хийнэ. Тэмээг бол 3 настайд нь сургана, тавалгаа хийнэ, буйл хийнэ. Тэмээ бол адуу мал шиг булгиад тонгочоод байхгүй.

Тэмээчний зөвлөгөөнд Ховд руу оролцож байсан, саяхан сумын сайн малчин болсон.

-Тэмээн сүрэгт буур сонгох туршлага

Тэмээнд буурыг тавихдаа ноосыг нь хардаг, сайн ноостой, сүүтэй ингэний ботго, бөх нь тэгш сайхан зэргийг харна, бас зүсийг нь харна даа. Манайх чинь Төгрөгөс л буур авдаг. Энд тэмээний үүлдэртэй болсон. Манай ийшээ жил болгон 11-р сард тэмээний баяр хийнэ. Тэмээний таргаг бөх нь босоо болж, хоно сууж, гуя нь бүдүүрдэг.

-Тэмээн сүргийн бэлчээр сонголт

Тал дээр тэмээг явуулж бэлчээрлүүлдэг, заг, улаан бударгана зэрэг чинь жинхэнэ тэмээний хоол шүү, ингэж бэлчээхээр махан тарга суудаг. Мал тэгээд чацраад ирдэг. Хос мосонд нь өөх сууж байгаа гэсэн үг.

Тэмээ өнөжиж ботголно, 13 сар цаана нь бас 15 хоног ботгоо тээж байх шиг байна, тэгээд бүтэн жил ботгоо хөхүүлнэ. Буурын ороо 12-р сарын 20-д гэж ороод 2 сар гартал орно. Олон ингэтэй буур бол 4-р сар гартал орно. Ноос энэ жил гайгүй шиг байлаа, бараг 3000 хүрсэн.

Энэ жил их чанга жил боллоо. Манай энэ голоор 1000-аад үхэр, тэмээ байсан 800 нь үхсэн, тэмээ л үлддэг юм байна. Зудыг бол тэмээ л даадаг юм байна. Энэ зуух шиг \50-70 см\ өндөр цас орсон шүү дээ.

Тэмээг чинь өөрийн дураар л явуулж байвал болно, тэгээд л явж байвал тэжээл бордоо орох нь гайгүй. Ботголохын үед нь их анхаарахгүй болохгүй. Ботголохдоо шилрэнэ, арчилгаа их шаардана. Гаднаа аваад л анхаарч байхгүй бол болохгүй, хүнээр бол их удаан өвдөнө, болтголох гээд 6 цаг гаран болно, тэгээд ботголж чадахгүй бол ботгыг нь татаж гаргана, ботгыг нь амлуулна. Тэгэхгүй бол ботго нь хөхөж чадахгүй. Тэр тал дээр нь их анхаарах хэрэгтэй. Ботгыг манай энд хөллөнө. Буур ингэнд гарах үед сайн харна, тэгэхгүй бол буур нь асаад ингээ уул руу шахаад явчихдаг. Буур орж байгаа үед тэмээгээ хариулна. Тэгэхгүй бол хөөгөөд нэг тийшээ явна. Энэ хавар ботголсон ингийг 4-р сар гээд л ботгыг нь уяад зунжин, намаржин, өвөлжин саагаад тавьдаг.

Манай энэ хавийнхан дан тэмээчин, аав тэмээчин байсан, өвөөг мэдэхгүй ямар малтай байсныг. 1993 онд хувьчлагдаад 40 орчим тэмээтэй байсан, тэгээд

хүүхдүүддээ тасалж өгөөд л таардаг. Манай энэ голоос улсын аварга тэмээчин байс хийгээд л гардаг.

Нэг хэсэг оторлоод хойшоо Хүйсийн говь, Ховдын Дарви гээд явдаг байсан, жин тээж байгаагүй ээ, нэг удаа 100 тэмээтэй аймаг орсон. 1977 онд Октябр 60 жилийн ойн баярын жагсаалын араас орох гэж 100 тэмээнд хужир ачаад аймаг орж байсан.

Мал маллах бол цаг заванд баригдаад байхгүй, хоёр нарны хооронд эрүүл агаарт сайхан л байна.

-Аргал түлээ бэлтгэх уламжлалт арга



(53-р зураг)

Гадаа хоносон үхрийн нойтон баасыг өглөөд цуглуулж аваад, нийлүүлж зуурч базаад гараараа хэсэг хэсгээр нь бөөрөнхий болгоод газарт тавьж алгаараа дарж хавтгайлдаг. Мөн аргалдаа, нүүрсний хог, модны үртэс зэргийг хольж болно. Ингээд хавтгай болгосон баасыг хурууны үзүүрээр дарж хонхойлдог, тэгвэл хурдан хатдаг. Ингээд 2-3 өдөрт эргүүлж, хоёр талаар нь ээлжлэн эргүүлж нар, салхинд хатаадаг.

Ойр ойрхон эргүүлэхгүй бол аргалын хорхой идчихдэг. Хатсан хойно нь хурааж нөөцөлдөг. Өвөл түлэхэд их элч сайтай. Энэ нутгийн гол түлээ нь болдог.



(54-р зураг)

-Гаргалгаа

Малчид 1000-аас дотогш толгой малтай байхад бэлчээрийн даац болон өрхийн амжиргаанд элбэг хүрэлцээтэй гэж үзэж байна. Харин залуу малчид малын тоо толгойг 2000, 3000 мянгад хүргэж өсгөөд, эд хөрөнгө, хуримтлалыг бий болгож байгаа байдал ажиглагдаж байна. Тэдэнтэй уулзаж ярилцахад ингэж малын тоо толгойгоо өсгөж өрхийн эдийн засгийн хуримтлал үүсгээд, улмаар малын тоо толгойг багасган 500-аас 1000 орчим хүртэл бууруулах зорилготой гэнэ. Малын тоо толгойг ихэсгэж хөрөнгө чинээгээ хуримтлуулаад, буцаан зохист хэмжээнд хүргэж багасгадаг энэ үзэгдэл нийт малчдын дунд түгээмэл арга болон тогтжээ гэж үзэж болохоор байна.

2. БЭЛЧЭЭРИЙГ ХАМГААЛЖ, НӨХӨН СЭРГЭЭЖ ИРСЭН УЛАМЖЛАЛ

2.1 Судалгааны тойм байдал

Монголчууд эртнээс эхлэн цаг уурын эрс тэс уур амьсгалд зохицон байгалийн бэлчээрийг нүүдлийн хэлбэрээр ашиглаж ирсэн түүхэн уламжлалтай билээ.

Нүүдэллэн амьдрах энэхүү аж ахуйн арга нь хөдөлмөр эрхлэлтийн хувьд болон бусад хүчин зүйлээс шалтгаалан нэгдмэл байдлыг арга буюу шаардаж байдаг.

Нутаг сэлгэн нүүж бэлчээрийг зөв ашиглах, шинэ нутагт мал сүргийг хуваарьтай бэлчээх, малын ашиг шимийг авах болон бусад хамтын хөдөлмөр, баяр ёслол тэмдэглэх зэрэг нь хэд хэдэн өрх гэрээр нэг нутагт бууж, хот айл болох орчин нөхцлийг бүрдүүлдэг байна.

Хот айлын энэхүү хэсэг бүлгээр хамтран амьдрах хэв маягийг эртнээс үүсэлтэй хэмээн эрдэмтэд үздэг. “Монголчууд Хүннү гүрний үед зэрлэг амьтныг гэрийн тэжээмэл болгон өсгөөд, овог тус бүр хүрээгээр нүүж суухаас гадна айл өрхөөр нүүж суух явдал аажмаар ихэссэн билээ”¹².

Хүрээгээрээ нүүж байсан уламжлал Монголын эзэнт гүрэн байгуулагдах хүртэл хадгалагдан үлдсэн ба харин ангит нийгмийн үед хот айлын тогтолцоонд бүрэн шилжсэн байна. “Монголын нууц товчоо”-нд Ойрад монголчуудын өвөг Дува сохор нэгэн өдөр Добу мэргэн дүүтэйгээ Бурхан халдун ууланд гарав. Дува сохор бурхан халдан дээрээс харвал Түнхэлэг горхин уруу нэгэн бүлэг иргэн нүүж айсуу¹³ гэсэн тэмдэглэлээс харахад эртний монголчууд хэсэг бүлгээрээ нүүдэллэн амьдарч байжээ.

Амь зуух амьдралын хэв маяг (*хөрөнгө хогшлын ялгаа адилавар, бие биесийг сайн мэдэж, санаа нийлэх зэрэг*), овог угсаа (*нэг овгийн, худ ургийн барилдлагатай, түрүүчийн өтгөс биесээ мэдэн ойр дотно байцгаасан зэрэг*), эрхлэх аж ахуйн

¹²БНМАУ-ын түүх. Тэргүүн боть. Улаанбаатар, 1966, 226

¹³Дамдинсүрэн, Ц., Монголын нууц товчоон. Улаанбаатар, 2008, 22

онцлогтой (малын тоо толгой, аль төрлийн малыг зонхилон адгуулдаг зэрэг) зохилдуулан хот айлаараа амь зууцгаана.¹⁴

Нүүдэлч-малчид хот айлын хэлбэрээр төвлөрч буух ба малын бэлчээр нь эргэн тойрон ойролцоогоор 30 км орчимд байна. Малчин хүн бэлчээрийн газар хэмээх ойлголтыг малын бэлчээрлэх зайг баримжаалан тоймлон тогтоож заншсан аж. Үүнд таван хушуу малын хол, ойр бэлчээрлэн явах чадварыг харгалзан адуу, тэмээ, үхрийг урт хөлийн бод мал, хонь, ямааг богино хөлийн бог мал гэж ялгана.

Хөвсгөл аймгийн Дархад ардын дунд "Морины аргамжааны газар (25-30 м), хонины бэлчээрийн газар (1-2 км), үхрийн бэлчээрийн нутаг (2- 2,5 км), тугалын бэлчээр (нэг км орчим), хурганы бэлчээр (500 м-ээс нэг км), адууны бэлчээр (4 км) орчмоор тус тусыг тоймлосон байдаг¹⁵ бол бусад бүс нутгийн хувьд ч иймэрхүү¹⁶ /хол, ойрын зай/ төсөөлөлтэй билээ.

Хот айл нь жилийн дөрвөн улирлын туршид нутаг сэлгэн нүүдэллэсэн ч өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржааны нэгэнт тогтсон эргэлт нутагшлыг бий болгохоос гадна цагийн байдлаас үүдэн отор нүүдэл хийдэг. Эдгээрийн хоорондын зай, тооны хувьд бүс нутаг, улирлын байдлаас шалтгаалан харилцан адилгүй. Тухайлбал, Алтайн нуруу дагасан малчдын хувьд жилд 10-15 удаа нүүж, хаваржаанаас зуслан буюу "хяр өөд гарах нүүдэл" хийхэд талдаа 100 гаруй км явж байгаа бол, Хангай нурууны салбар уулс Тарвагатайн нурууны малчид ихэвчлэн улирлын тоогоор 3-4 удаа нүүж, хол нүүдлийн зай нь 10-15 орчим км-т багтаж байгаа юм.

Аль ч бүс нутгийн хувьд жилийн дөрвөн улиралд малчин айлын хамгийн удаан хугацааны нутагшин суух газар бол өвөлжөө, хаваржаа юм. Өвөлжөө, хаваржааны газрыг хангайн бүс нутгийн жишээгээр авч үзвэл, Мал бэлчээрт гарах болон буцахдаа хөндийн жавар огтлохгүй, цас ихтэй жил тоншуурга¹⁷ сайн гарах, малын хээл хөндөллөсөн¹⁸ үед ойрын нөөц бэлчээртэй, нар эрт тусаж орой жаргадаг, цас шуурахгүй бууцтай, алсын салхи хагалсан хөндлөн хяр зоотой, морины

¹⁴Цэрэнханд, Г., Монгол ахуй- угсаа соёлын судалгаа. /Бүтээлийн түүвэр/. Улаанбаатар, 2015, 360

¹⁵Бадамхатан, С., Хөвсгөлийн дархад ястан. Улаанбаатар, 1965, 86

¹⁶Говийн бүс нутгийн хувьд уг хэмжээсүүд харилцан адилгүй байна.

¹⁷Ботиул бүхий нарийн өвстэй цас төдийлөн тогтдоггүй хамар, энгэр газрын бэлчээр.

¹⁸Малын хээл томорсон үе.

аргамжааны өлөн борог сайтай зэргийг бодолцон өвөлжөөгөө гаргадаг байна. Хаваржааны хувьд, аль болох цагаалж¹⁹ бүхий, задгай устай бэлчээрийг эрхэмлэх ч хавсарга шуургатайд гаргах нөмөр хонхыг бас бодолцоно. Мөн энэ бүс нутгийн малчдын хувьд сарлаг үхэр ихтэй тул цасны хайлуур ус их тогтдог дов сондуул бүхий дэвтсэн хур борог өвстэй бэлчээрт нутагладаг нь хаврын үхэр тогтвортой идэшлэдэгт байна. Хаваржааны хашааг шар усны үер дайрахгүй өргүүлсэн²⁰ мал бэлчээхэд харууц сайтай газар барихыг чухалчилдаг.

Ийнхүү хот айлын бэлчээр нутаг ашиглах байдал өөрийн тогтсон зүй тогтолтой байхаас гадна нэг газар хотлон буухдаа ч гэсэн өөрийн гэсэн дараалалтай байдаг байна. Тухайн хот айлын хамгийн ахмад юм уу ураг төрлийн хүндтэй айлаасаа эхлэн баруун урд талаасаа аваад малынхаа хашаа хороог тойрох хэлбэртэй буудаг байна. Ихэвчлэн зуны улиралд ингэж буух бөгөөд хээрийн амьтны дам гүйдлээс сэргэмжилж буй нэгэн арга юм. Малын хашаа барих нь ч гэсэн мал маллагааны арга ажиллагаатай нягт холбогддог.

Хот айлын байршлын өвлийн улирлын зураглалыг мөн хангай нутгийн жишээгээр тоймлож үзвэл, ихэвчлэн хоёроос дөрвөн гэрээр айлсан буух бөгөөд бог малынхаа хашааг ямар нэгэн байдлаар тойрсон хэлбэртэй гэрээ барьдаг. Харин үхрийн хашааг хонины хашааны газрын доод талд барьдаг нь үхэр өөрөөсөө өтөг гаргадаггүйтэй холбоотой юм. Газрын дээд талд барьсан хонины өтөг цагийн аясаар гулсан үхрийн хашааг өтгөжүүлдэг байна. Энэ тухай малчид *“үхрийг мөсөн сүүжтэй, хонийг булган сүүжтэй”* хэмээн зүйрлэн хэлдэг билээ. Адууг төдийлөн хашаад байхгүй ч зарим шаардлагатай²¹ үед хотны зүүн урд талд тусгайлан барьсан “цагаан үе хашаа”-нд²² зогсоодог.

Улмаар хот айлын нэгэнт тогтсон байршилтай зүйлсүүдэд морины уяа, нохойн уяа, түлээ бэлдэх газар, өвлийн идэш хийх сав, үнс асгах газар зэргийг дурдаж болох юм.

¹⁹Бартаа багатай бэлчээр. Хаврын бэлчээр бартаатай байвал ялангуяа бог малын төл гээгдэж хоцорч үрэгдэх гэмтэй.

²⁰Хур тарга хүчээ барж, тэжээлгэж онд орж буй мал. Ийм мал төдийлөн олон биш байх тулд тэр бүр дагнан хариулахгүй тул нүднээс далд бэлчээвэл өөдөх (босож чадахгүй болох) гэмтэй.

²¹Хээрийн амьтан отлох буюу орооноосоо буусан үе, намрын цагаар алсын сойлго авахуулах зэрэгт түр хашдаг байна.

²²Аравсай тавиагүй тойруулган хашаа.

Ийнхүү монгол малчдын аж ахуй эрхлэлтийн агуулга хийгээд онцлогийг тодруулахын тулд бэлчээр ашиглалт буюу нүүдлийн талаар авч үзэх шаардлагатай билээ. Энэ удаад нүүдлийн мал аж ахуй, түүнд гарч байгаа зарим өөрчлөлт, нөлөөллийн талаар хэд хэдэн бүс нутгаар жишээлэн авч үзэх юм.

Говь-Алтай аймгийн Бугат сумын бэлчээр хамгаалалтын жишээ

Говь-Алтай аймгийн Бугат сум нь мал аж ахуй, газар тариалан эрхлэн амьдарч, алс дөрвөн баг болон сумын төвд төвлөрч ажил үйлчилгээ явуулдаг нэг багтайгаа нийлсэн үндсэн таван багтай, газар нутгийн хувьд Монгол Алтайн нуруу дамнан оршдог сум юм.

Сумын ихэнх газар нутаг нь өндөр хянган уулсаар хүрээлүүлсэн хад асга чулуу бартаа ихтэй, өвс бэлчээрийн хувьд тачир сийрэг ургамлын бүтэцтэй ч эртнээс нааш нутгийн малчид таван хошуу малаа адгуулан малласаар өдийг хүрчээ. Газрын хөрс нь нэлэнхүйдээ хайрга дайрга бүхий хатуулаг хөрснөөс бүрдэх ч Биж болон Гаханч багийн нутгаар говийн тэгш талархаг бэлчээр бүхий баян бүрдтэй, Алаг хайрхан, Бугын даваа зэрэг уулсын суга хөлөөс эх авсан задгай ус элбэгтэй, Алаг нуур, Могойн толгой гээд хужир борзон элбэгтэй нь малын тарганд ташуур болдог байна. Малчдын өгүүлж байгаагаар, хангай нутаг шиг өтгөн сахлаг ургахгүй ч гэлээ Хөвчийн нурууны агь шавагт газар нь хаврын туйлдсан малыг эрт тэвээрүүлэх, намрын таргыг тогтооход нэн тохиромжтой газар нутаг гэх бөгөөд намар тавагласан агийн сөл нь татраагүй байхдаа цасанд дарагдаж, хаврын чийгэнд үндэс нь хөөж, амь чигээ алдаагүй байхад нь идэхэд мал амархан сэхэл авдаг байна.

Дээр өгүүлсэнчлэн чулуурхаг хөрс, тачир сийрэг ургамалтай учир төдийлөн хадлан тэжээл авалгүйгээр жилийн дөрвөн улирлын туршид нутгийн сонорт отор нүүдэл хийж цаг улирлын хатууг давдаг нь малаа онд оруулахаас гадна бэлчээрийг зөв зохистой ашиглах нэгэн хэлбэр юм. Социалист нийгмийн үед малыг төрөл зүйлээр нь ангилан дөрвөн багийн нутагт өсгөж байсан нь өдгөөг хүртэл хадгалагдаж үлдсэн нь гуравдугаар баг буюу Гаханчийн нутаг Алаг нуурын говь орчмын газарт нэгдлийн тэмээний суурь байсан бөгөөд одоо ч уг нутагт Х. Чогсом, Н. Нэргүй, Н. Галбадрах зэрэг малчид тэмээ голчлон маллаж байна. Дөрөвдүгээр баг буюу Сүжид

голлон маллаж ирсэн нь ямаа дийлэнх хоньтой бол, нэгдлийн үед хонь үржлийн фермтэй байсан хоёрдугаар баг нь бусад багуудаа бодвол бог малын дийлэнх нь одоо ч хонь хэвээр байгаа нь Г. Жанчив, Б.Адьяа зэрэг малчдын жишээгээр харагдаж байна. Эдгээр айл өрхүүд нь нэгдэл тарахад тухайн хариулж байсан малаа голдуухан авч үлдсэн бөгөөд нутаг бэлчээрээ төдийлөн солиогүй байгаа нь хувийн аж ахуйтан байхаас л малынхаа бэлчээрийг даган төрөл зүйлээр нь маллаж байсантай холбоотой. Гэхдээ социализмын үед дөрвөн улирлын бэлчээр илүү нарийн хуваарьтай байсныг малчид ярьж байна.

Нэгдлийн мал маллаж байхад нутаг бэлчээрийн хуваарь ёстой яс байсан шүү. Хярд зусаад намаржааны нутагт есөн сард орж, өвөлжөөний нутагт цас ихтэй бол арван сард, гайгүй бол арван нэгэн сард тэгээд л бусад үед хярдаа зусландаа байж байна. Манай энд бол намаржаа Хөшөөтийн гол, өвөр лүү бол Дардант, Дэрсэнэ тэгээд л тэр Хоолой хутаг Гашуун, Тамга гээд л байна. Манайхан чинь Мааньтын хөтлөөс нааш урагшаа ингээд л өвөлжинө. Хувийн аж ахуйтан байхад бол тийм нарийн хуваарь байгаагүй ээ. Манай Сүж тал бол мал цөөтэй ядарсан баг байсан шүү дээ, цөөхөн хэдэн малтайгаа өөр өөсрдийнхөө бууцан дээр л бууна, өмчлөөгүй ч гэсэн тэдний буудал эдний бууц гээд мэднэ²³ хэмээн ярьж байна.

Малчдын ярьж тайлбарлаж байгаагаар мал тухайн өөрийн дассан нутаг бэлчээрээсээ өөр газар шинээр идээшиж, нутагшихгүй хий явдал орон, холхиж тогтворгүй болох, буцаж гүйх зэргээс гадна угаасаа тухайн бэлчээр ус таардаггүй байна. Тухайлбал, Гаханч багийн малчин Т. Гаравсүрэн ярихдаа:

Өөдөөгөө тэмээний бэлчээр муутай. Богийн идэш бол сайн л даа. Гэхдээ дээшээгээ байвал бог мал даарах нь ихдээд тэгээд таргалахгүй, харин хуучин нутгаадаа бол арай дээр таргалах нь. Хоосон ч байсан эндээ дээр, сайхан ногоотой газар яваад ирэхэд гэдэс нь тавигдахаас өшөө

²³Энхбаатар, М., Говь-Алтай аймгийн Бугат суманд ажилласан хээрийн шинжилгээний ажлын тайлан, эх хэрэглэхүүн I боть, Улаанбаатар, 2014, тал 93. Бугат сумын Сүж буюу дөрөвдүгээр багийн малчин Олхонууд овогт Гончигсүрэнгийн Сэр-Одоос (1946 онд төрсөн нохой жилтэй, эр) 2014 оны 8 дугаар сарын 25-нд тэмдэглэн авав.

*зүйлгүй байдаг. Манайх ноднин уржнан бас малаа туугаад энэ Төгрөгийн нутгаар явсан онцтой гавихгүй байна лээ*²⁴ хэмээн өгүүлж байна.

Бугат сумын малчдын дунд хувийн аж ахуйтан болон социалист нийгмийн үеэс тодорхой хэмжээний бэлчээр ашиглах хуваарь, малын төрөл зүйлээр ангилсан нутаг усны зааг ялгаа байсан ч энэ бүс нутгийн хувьд хүний оролцоотой гэхээсээ илүүтэйгээр цаг агаар, байгалийн хүчин зүйлээс шалтгаалан нутаг бэлчээрээ ашиглаж байна хэмээн урьдчилсан байдлаар үзэж байгаа болно. Тухайлбал, Хангайн бүс нутагт дараа улиралдаа бяруу тугалаа бэлчээх, хонь хургалах, морь аргамжих зэргээ бодолцон ойрын бэлчээрээ нөөцлөх юм уу, цагийн хатууд мал гаргах нөмөр нөөлөгтэй, цастайд хурдан бараалах тоншуургатай (хярт ч гэх) газраасаа зөрүүлж бэлчээх зэргээр тохируулдаг бол, Бугат сумын хувьд ямар нэгэн малчин өөрийн оролцоо, засаг захиргаа нэгжийн хяналт шахалтаас төдийлөн шалтгаалахгүй өвс ургамал, байгалийн хүчин зүйлээс хамаарч аандаа дөрвөн цагийн бэлчээрийн хуваарь гарч байна.

Сумын малчид нь хэдэн үеэрээ Хөвчийн нурууныхаа ар өврөөр нутаглаж нүүхийн хүчинд л таван хошуу малаа адгуулан малласаар өнөөг хүрчээ. Байгалийн эрс тэс уур амьсгал, өвс ургамлын гарц нь ч нүүхээс өөр аргагүй байдалд хүргэдэг бөгөөд жилийн дөрвөн улирлын туршид отор нүүдэл хийж хүн малгүй түүндээ дасан зохицсон байдаг байна. Цаг тавиун жил байлаа гэхэд л энгийн айл арван таваас хорин удаа бууц буудлаа сэлгэн товшин нүүж, зарим нь түүнээс илүү хорь гаруй удаа ч нүүдэг нь жирийн нэгэн аж ахуйн хэв дадал болжээ. Өвлийн хүйтэнд шөнөөр тэмээ малаа сөгнүүлэн гэрээ ачаалан нүүх нь хэвийн зүйл байсан хэмээн өндөр настнууд дурсан ярихдаа, *тоононы нүх үзэгдэхгүй харанхуйд тооноо цасан дээгүүр өнхрүүлж байгаад нүхэнд орсон цасаар баримжаалан униа өлгөдөг байсан* зэргээр хуучлах нь бий. Одоогоор сумын хэмжээнд тэмээн хөсгөөр нүүж байгаа айл цөөхөн ч машин явахгүй хад асга бүхийн өвөлжөөндөө буухдаа хэд хэдэн айл тэмээгээр нүүж байна. Хаваржаанаас зусланд буух, зуслангаас намаржаанд буух зэрэг уртын нүүдэлд зам

²⁴Энхбаатар, М., Говь-Алтай аймгийн Бугат суманд ажилласан хээрийн шинжилгээний ажлын тайлан, эх хэрэглэхүүн I боть, Улаанбаатар, 2014, 82. Бугат сумын Гаханч буюу гуравдугаар багийн малчин Бат овогт Тангадын Гаравсүрэнгээс (1948 онд төрсөн үхэр жилтэй, эм) 2014 оны 6 дугаар сарын 27-нд Баянголын дэнжид зусч байхад нь тэмдэглэн авав.

бартаа багатай тул айл бүхэн машинаар нүүж байгаа ч жилийн туршид тэмээгээрээ нүүж байгаа нэг, хоёрхон айл өрх үлджээ.

Айлууд өмнө нь сарлаг болон тэмээн хөсгөөр очдог байсан бууцандаа машинаараа бууж байгаа ч зарим нэг бууц буудалд машин хүрэхгүй тул очиж нутаглаж чадахгүйд хүрсэн, мөн адил шалтгаанаар эзэмшиж чадахгүй байгаа цөөнгүй отрын бууц буудлуудын хашаа хороо нурж, тарахад бэлэн болжээ.

Нүүдлийн хөсөгт л өөрчлөлт гарсан ч нүүдлийн тоо буураагүй, харин сарлаг болон тэмээгээр газар тэвчиглэн нүүдэг байсан нь машинаар замын аясыг даган гэр ачсан хөсөг унаа тойрч байгаа боловч нийт мал сүргийн хувьд нүүдлийн үеэр өмнө нь явдаг байсан тэвчиг нутгаараа л явдаг байна.

Малчдын дийлэнх нь хувьдаа машинтай бөгөөд өөрийн машиндаа багтах хэмжээгээр нь тааруулан том, жижиг гэртэй байх ба зарим айлууд цагаан сар гаргасан бууцан дээрээ том гэрээ барьж орхиод, жижиг гэрээр хаваржаалаад зусландаа гарч ирэх нь бий. Мөн хаваржаанаас зусланд гарахдаа бууцан дээрээ ямар нэгэн гэр орхиж нүүж байгаа нь хоёр гэр нүүлгэх хөдөлмөрөө хөнгөвчилж байгаа боловч малчдын өөр хоорондоо энэ талаар өгүүлж байгаагаас үзэхэд намар буцаж буух бууц буудал, бэлчээр усаа өмчилж байгаагийн нэгэн хэлбэр юм.

Сумын хамгийн хол нүүдэг баг нь Биж бөгөөд зуд турхан болсон үед Тахийн шар нуруунд гарч өвөлжих тохиолдол цөөнгүй гардаг. Ферм багийн хувьд мөн холын нүүдэлтэй ч Хөвчийн нуруугаа давж, хилийн наад тал руу Хонин ус, Сухайтын аман тал руу орж өвөлжиж байна. Бусад дөрвөн багаа бодвол Гаханч баг нь харьцангуй бэлчээр нутаг сайтай Хөвчийн нурууны ар өвөр, Алаг нуурын говиор хүйтний улиралд нутаглаж, эртнээс Аж богд, Даянгийн нуруу гээд хөндлөн сумдын нутгаар бэлчээр ус сэлгэдэг аж. Сүж багийн хувьд сумын төвийн орчил хэсэг Сүжийн энгэрээр тойрон өвөлжиж, бусад багуудтай харьцуулахад газар нутаг жижиг, жилд хийх нүүдлийн тоо нь цөөн ч багийн нийт нутгаар өвлийн улиралд хур тунадас бага унадаг байна.

Дөрвөн баг нь өвөл, намрын улиралд л тус тусын нутаг руугаа салан буух бөгөөд хавартаа дийлэнхдээ Хөвчийн нуруугаа түшин хаваржиж, зундаа зүүн, баруун хярдаа бөөгнөрөн зусаж байна. Дөрвөн багийн нүүдлийн тоог дундажлан үзвэл жилдээ арван

тав, зургаан удаа нүүх бөгөөд жил хатуурсан үед түүнээс ч олон нүүдэл хийдэг байна.

Боржигин халхчуудын бэлчээр ашиглалтын уламжлалт жишээ

Боржигин халхын малчдын бэлчээр ашиглалтыг Төв аймгийн Баянцагаан, Говьсүмбэр аймгийн Сүмбэр, Дундговь аймгийн Баянжаргалан, Цагаандэлгэр, Говь-Угтаал гэсэн таван сумдын жишээгээр оруулав.

Тухайлсан сумдад угсаатны зүйч С. Бадамхатан аbugай халхын угсаатны зүйг судлах ажлын хүрээнд хуучин Сэцэн вангийн хошуунд угсаатны зүйн судалгаа хийсэн байна. Судалгааг 1968-1970 оны хооронд нийт 5 сарын хугацаатай Дорноговь аймгийн Даланжаргал, Их хэт, Говьсүмбэр, Айраг, Дундговь аймгийн Цагаандэлгэр, Говь-Угтаал, Хэнтий аймгийн Дархан, Төв аймгийн Баянцагаан, Баянжаргалан гэсэн сумдад явуулжээ²⁵.

Уул хошууны засаг захиргааны зохион байгуулалт хэдийгээр Манж Чин улсын төрөөс тогтоогдсон цэрэгчилсэн системтэй байсан авч нутаг хошуунд зохиогдож байсан албан хэрэг нь монголчуудын эртний отгийн байгуулалтаар явж, тэдгээр отгууд нь эртний овог ясны улбаанд тулгуурлагдан нэрлэгдэж байсан нь уг хошууны ард олны овгийн бүрэлдэхүүнийг судлах хэрэглэгдэхүүн болж болох юм хэмээн тодорхой дүгнэлтүүдийг хийсэн байна.

Тухайн бүс нутгийн хувьд “отог тус бүр өөрийн баримжаалан нутагладаг нутагтай, тахидаг овоо, уултай байсан”²⁶ хэдий ч энэ удаагийн судалгааны явцад энэхүү уламжлалт бэлчээрийн хуваарийн талаар мэдээлэл өгөх хүн ховор байв. Төв аймгийн Баянцагаан сумын зарим иргэд хуучин отгийн нутаг бэлчээрийн зарим мэдээ өгч байлаа. Харин социалист нийгмийн үеийн бэлчээр ашиглалтын тухай өгүүлэх нь илүүтэй байв. Цас зуд ихтэй цагийн хатууд аймаг, сум дундын отрын бүс нутаг болох Хэрлэнбаян-Улааны нутагт тусгай отрын штаб байгуулан нүүдэл хийдэг байсан байна.

²⁵Тус угсаатны зүйн хээрийн судалгааны ажил нь ШУА-ийн Түүх Археологийн Хүрээлэнгийн Баримт мэдлээллийн төвийн Хөм-7, Д-3, ХН-6-д хадгалагдаж байгаагаас гадна 2011 онд мөн тус хүрээлэнгээс эрхлэн гаргасан МУЗХСЭХ-ний I ботид хэвлэгдсэн болно.

²⁶Бадамхатан, С., Халх. ШУАХҮ, Tomus IV, Fasc 7, Улаанбаатар, 1972, 10

Мөн “талаа хадгалах”, эсвэл “тал бэлчээр” гэж өвлийн цагт чөдөртэй морио тавих, хаврын улиралд төл мал гаргах зэрэгт нөөцөлсөн бэлчээрийг ийн нэрийддэг байж. Малчдын ярьж буйгаар ийнхүү “талаа хадгалах” бэлчээр ашиглалтын энэ арга өөрчлөгдөж байгаа тухай өгүүлж байлаа. Учир нь тухайн малчин өөрийн өвөлжөөний ойролцоох морь тавих, төл мал бэлчээх зэрэгт тохиромжтой нөмөр нөөлөгт өвөр, энгэртээ бусад улиралд тураг малаа гаргахгүй байсан ч өөр айлын мал тэрхүү нөөцөлсөн бэлчээр рүү нь орчихдог. Үүний улмаас өвөлжөөний бэлчээрээ хамгаалахын тулд бараг дөрвөн улирлын туршид бууц буудлаа тойрон ойрхон нутаглах шаардлагатай болдог.

Энэ нь монгол орны хамгийн түгээмэл ургамлын хэв шинж бүрдсэн хээрийн ургамлын “хуурай болон цөлжүү ургамалжил”²⁷ зонхилон тархсан уг бүс нутгийн хувьд дөрвөн улирлын туршид мал бэлчээрлэх нь ургамлын нөмрөг нөхөн сэргэж чадахгүйд хүргэдэг байна. Тодруулбал, ургамлын үр нь унахаас өмнө мал идэшлэхдээ ургамлаа сорчлон түүж иддэг учир бэлчээрийн ургамлын бүтцэд мал амьтан идэх шимт ургамлын эзлэх хувь багасаж байгаа гэж ойлгож болох юм. Ингэж үзвэл, энэ бүс нутгийн бэлчээр ихэд талхлагдаж байгааг хүн амын нягтаршлын улмаас, малын тоо толгой нэмэгдсэнтэй холбоотой гэж үзүүштэй. Мөн үлийн цагаан оготно талын хөрсийг суллан, энд тэндгүй шороон овоолго үүсгэж байгаа зэрэг нь малын бэлчээрт зонхилох нарийн бутлаг ургамлын бүтцэд өөрчлөлт орж, хялгана, шарилжит өвс ургамал их ургах болсон байх талтай байна. Бэлчээрийн өвс ургамал нь байгалийн бүс, улирал, малын төрөл зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан хэлбэлзэх учир бусад төрлийн судалгааны үр дүнтэй харьцуулан үзэх шаардлагатай юм.

Хэрлэнбаян-Улааныг “мянган бууц, зуун булаг”-тай хэмээн эртнээс хэлэлцэж ирсэн нь учиртай. Ягааны ам, Бургалтайн ам, Ханзатын ам зэрэг өвөр цээж өөдөө бага малын нөмөр нөөлөгт бэлчээртэй, хяр зоо өөдөө адуу малд зохицох тэгш тагд малаа бэлчээж, нар эрт мандаж, орой жаргах цохионуудын энгэрийн бууцанд малчид өвлийн хатууг давдаг өгөмжит нутаг юм. Гэхдээ хавар эрт мал төллөхөөс өмнө Хэрлэн гол руугаа гарахгүй бол цөн түрсэн үед нялх төлтэй мал хаврын усаар гэтэлж

²⁷Түвшинтогтох И. Монгол орны хээрийн ургамалжил. Хянан тохиолдуулсан Ч. Санчир, Улаанбаатар, 2014,

чадахгүйд хүрэх, мөс нимгэрсэн үед бол харуун цувааны²⁸ сүүлчийн адуу мал цөмрөх зэрэг малын эндэгдэл гардаг байна. Усны хор гарахыг харж, хаврын сүүл сар хүртэл нутаглавал хад бартаа ихтэй учир сүргээс хоцорсон нялх төл олдохгүй болох мөн чоно, шилүүсэнд бариулах зэрэг аюултай аж. Ийм учраас өвлийн дүн хүйтэнд өвөлжөөд, хавар эрт голын мөсний зузаанд буцаж ирдэг байна. Одоогийн байдлаар малчид төдийлөн олон удаагийн отор нүүдэл хийх нь багассан бөгөөд ихэвчлэн өвөлжөөгөө тойрсон байдалтай нутаглаж байна.

Дунговь аймгийн Мандах сумын бэлчээр хамгаалалт, нөхөн сэргээлтийн жишээ

Говийн бүс нутгуудаас Дорноговь аймгийн Мандах сумын жишээг тухайлан оруулж байгаа юм.

Дорноговь аймгийн нутаг нь хойд хэсгээрээ бэсрэг уулархаг, төвөөрөө тэгш тал хээр, өмнүүрээ говь цөлийн экосистемийн олон янз тогтоцтой. Байгалийн ийм олон янз тогтоц, экосистемийн өвөрмөц иж бүрдлийг дагаж ургамлын нөмрөг, бэлчээрийн төрөл, ургац, тэжээлийн нөөц, даац, тэжээллэг чанар нь нутаг бүрт харилцан адилгүй бүрдэлтэй²⁹ байдаг. Мандах сум нь аймгийн газар нутгийнхаа баруун зах Дундговь аймгийн Өлзийт, Өндөршил, Өмнөговь аймгийн Манлай сумдын нутагтай хил залгах бөгөөд “сумын нутаг ургамал газар зүйн мужлалын Евроазийн хээрийн мужийн Умард говийн цөлийн хээрийн провинц, Дорнод говийн цөлийн хээрийн тойргийн Сайншанд, Өлгий хийдийн районд хамаардаг”³⁰ билээ.

Сумын нутгийн төв хэсгээр Буянт уул, хойгуур Хүрэн хайрханаас гадна Гялгар тойром, Шар Модны тойрмуудтай бол баруунаа Батсуурь уул, Аргалын нуруу, Улаан уул, өмнүүр Ац богд, Хараат, Хорго зэрэг уулсаар хүрээлүүлсэн. Эдгээр “уулын ургамлан нөмрөгийн бүлгэмдлээс гадна хээрийн болон цөлөрхөг хээрийн бүсийн ургамалжилтын олон хэв шинж тархжээ. Эндхийн бэсрэг ба нам уулсын орой, бэл

²⁸Мал хальгирхаас сэргэмжилж гаргасан мөсөн дээрх шороон зам харуу гэдэг. Асгасан харуун дээгүүр мал цуван гарахад эхэн үедээ мөс цөмрөх аюулгүй мэт боловч мал сүрэг сүргээр явсаар сүүлийн хэсэгт

²⁹Цэнджав, Д., нар, Дорноговь аймгийн биологийн баялаг, Амьтан ургамал (ШУА-ийн Биологийн Хүрээлэн, Хөхтний Экологийн лаборатори, Улаанбаатар, 2004, 424

³⁰Юнатов, А. А., Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хадлан билчээр дэх тэжээлийн ургамлууд, Улаанбаатар, 1968, 281

хажуугаар монгол өвс, хазаар өвс, харгана, бударгана, баглуур, таана, тэсэг, буйлс, зонхилсон ургамлан бүлгэмдэлтэй”³¹ байна.

Энэ бүс нутгийн малчид монгол орны бэлчээрийн мал аж ахуйн нийтлэгийг харуулах зуслан, намаржаа, өвөлжөө, хаваржааны бууц буудлуудтай бөгөөд жилийн дөрвөн улиралд тухай бүрт нь сэлгэн нутаглаж байна. Энэ нь ган, зуд нүүрлэж холын отор хийгээгүй тохиолдолд нэгэнт тогтсон нүүдлийн хэлбэр юм. *Нэг буудал, хаваржаа гэж бас байгаа. Өвөлжөөнийхөө араад Цайдам гэдэг газар, хоорондоо ойрхон 4,5 км л зайтай*³². Дөрвөн улирлын буудлуудын хоорондох зай нь ойрхон өвөлжөөний бэлчээрээ тойрсон тул зайны хувьд нүүдэл гэхээсээ илүүтэй “бууц арилжих”³³ зөөврийн хэлбэртэй болж байна. *Бууцны хавь орчимд (өвс) гарсан гараагүй байж байна*³⁴. Өвөлжөөгөө тойрсон бусад улирлын нутагшил байгаа нь нутаг сэлгэн нүүдэл хийх бэлчээрийн хүрэлцээ муутайгаас гадна бэлчээрээ хамгаалах нэгэн арга хэлбэр гэж үзүүштэй. Учир нь өвлийн бууцнаасаа холдож алс нутаглавал бусад айлын урт хөлийн [бод] голдуу мал нөөцийн бэлчээрт гарах тохиолдол бий. Харин богино хөлийн мал [бог] дагнасан хариулгатай байдаг тул бусдын өвлийн бэлчээр рүү малчин хүн төдийлөн малаа оруулахгүйг хичээх ёстой билээ.

Үүнчлэн хаваржаан дээрээ жил болгон тогтмол буухыг хичээдэг байна. *Хаваржаанд бол холын оторт л явчихаагүй байвал өвстэй байсан өвсгүй ч байсан бууна.*³⁵ Учир нь “*хаврын хавсарга хавирга нэвт*” гэдэг болохоор нөмөр нөөлөгтэй, хэвтрээсээ хайрч жиндээхгүй нэгэнт тохижсон дулаан өтөг бууцанд буудаг. Тодруулбал “*төлийн үед хэвтэр бууцыг сайн дулаалах хэрэгтэй. Тэгсэн бол малд [ялангуяа богд] их хэрэгтэй төл мал баас, шээс алдана гэж байхгүй*³⁶. Өвөл хаврын

³¹Цэнджав, Д., нар, Дорноговь аймгийн биологийн баялаг, Амьтан, ургамал (ШУА-ийн Биологийн Хүрээлэн, Хөхтний Экологийн лаборатори, Улаанбаатар, 2004, 437

³²Дорноговь аймгийн Мандах сумын гуравдугаар багийн иргэн Боржгин овогт Дулмаагийн Магсармаа, 1943 онд төрсөн, эмэгтэй.

³³Бог малд шивтэр суухаас сэргийлж хотны шавхайнаас зайлж ойр ойрхон бууц сэлгэхийг хэлнэ. Дулааны улиралд бууц арилжилгүй удсанаас шарлаж шивтэртсэн хонь тарга авах нь муу байдаг.

³⁴Дорноговь аймгийн Мандах сумын дөрөвдүгээр багийн иргэн Довжирол овогт Цээнпэлийн Маам, 1950 онд төрсөн, эмэгтэй.

³⁵Дорноговь аймгийн Мандах сумын дөрөвдүгээр багийн иргэн Довжирол овогт Цээнпэлийн Маам, 1950 онд төрсөн, эмэгтэй.

³⁶Дорноговь аймгийн Мандах сумын дөрөвдүгээр багийн иргэн Довжирол овогт Цээнпэлийн Маам, 1950 онд төрсөн, эмэгтэй.

улиралд бууц, хашаа тохигүй бол бог мал тэр дундаа ямаа хээл хаях, самнасан үедээ даарч бээрэх, хэвтэр муугаас төл малын гэдэс өвдөх зэргээс үүдэн нэгэнт тохижуулсан хаваржаан дээрээ бууж малаа төллүүлэхийг хичээдэг. Ямааны хээл хэврэг хэмээн малчид өгүүлдэг нь ийн учиртай.

Тиймээс ч эртнээс нааш *“дунд идэш, дулаан хэвтэр”* хэмээн ялангуяа бог малын хэвтэр бууцыг ихэд анхааран мал аж ахуйгаа хөтлөн явуулсаар ирсэн нь тус сумын дөрөвдүгээр багийн малчин Довжирол овогт Цээнпэлийн Маамын *“мал чинь хүйтэн, хөлдүү газар хэвтвэл заавал хөлөө нугалж хэвтээд өвдөг борви нь хөрсөн байдаг. Хүйтэн байхаараа мал зутардаг. Ганцхан хэвтэрийг л дулаан байлгаж байвал болох нь тэр”* хэмээн өгүүлж байгаагаас мэдэж болно.

Ийнхүү нутгийн малчдын ярианаас үзэхэд өвөлжөөгөө тойрсон бусад улирлын нутагшилд ойрхон байгаа нь хэд хэдэн шалтгаантай байна. Үүнд: Өвөлжөө, бууцыг өмчилсөн учраас малчдын ихэнх нь ойр орчмын бэлчээрээ хувийн эзэмшил мэтээр үзэх хандлага илэрч байлаа. Жишээ нь, дурдан буй сумын гуравдугаар багийн иргэн Боржгин овогт Дулмаагийн Магсармаа(1943 онд төрсөн, эмэгтэй) гуайгаас

- *“Бэлчээрийн хөөлөг гэдэг юм байхгүй байсан уу?”* гэж асуухад, *“Байхгүй одоо л харин айлын бууцанд ойрхон буувал хөөгдөнө”* хэмээн хариулж байв.

Малчид өөрийнхөө өвөлжөөний ойролцоо ямар ч цаг улиралд айл буулгах, айлын мал бэлчээх төдийлөн дуртай биш байх нь тодорхой юм. Ийм учраас өөрийн болон залгаа сумандаа отор, нүүдэл хийхэд малчдын хэлж буйгаар *“хөөлгө”* ирдэг байна. Үүнийг тодруулсан мэдээ гэвэл: *“хөөлгө туулга болох юм билээ. Бууцанд нь өвөлжсөн айлд хөлс мөнгө нэхдэг бололтой, мал хуй нэхэж л байна гэсэн. Манайхаас тэгээгүй манайх ч нэг их удаагүй, сүрхий бууцанд буугаагүй нэг хондонд буусан. Гэхдээ бас хүн ирж хэдэн малтай вэ гэж л байсан. Багийн иргэдийн хурлын дарга нь ирсэн. Малчид ирээгүй, манайхнаас бол малчид нь очиж тэдэн мал өг гэж байна гэж дуулдаж байсан. Нэг дулаан бууцан дээр өвөлжихөд арван хургатай хонь өг гэж байна гээд дуулдаж л байсан”*³⁷ хэмээн ярьж байлаа. Энэ ярианд 2014 онд

³⁷Дорноговь аймгийн Мандах сумын нэгдүгээр багийн иргэн Амар овогт Дашдоржийн Амгалан, 1941 онд төрсөн, эмэгтэй.

Мандах сумын нутагт зуд болоход залгаа сум болох Дорноговь аймгийн Сайхандулаан сумын нутаг руу нүүдэл хийсэн тухай өгүүлж байгаа юм. Гэхдээ энэ мэдээ нь нийт монголчуудын бэлчээрийн мал аж ахуйд өвөлжөө бууцан дээр нь нэг жил буухад л хөлсөнд нь арван хургатай хонь авдаг гэсэн нийтлэг ойлголт бус, харин зарим тохиолдолд ийм зүйл гардаг байна гэдгийг хэлэх гэсэн хэрэг билээ. Нэг ус, сав нутгаас гадна зэргэлдээх сум аймгийн малчид өөрсдөө тохирох, биестээ тусын сэтгэлээр хандаж, зуншлага сайтай газраа өвөлжиж, цагийн хатууг даваад урин дулаан болохоор нутагтаа ирдэг. Мөн сум орон нутгийн удирдлагын албан ёсны тохиролцооны үндсэн дээр тодорхой тооны өрхийг орон нутагтаа өвөлжүүлдэг арга хэлбэр буйг ч дурдаж болно.

Ийнхүү төдийлөн холын отор нүүдэл хийхгүй учраас жилд нүүх нүүдлийн тоо эрс цөөрсөн байгаа нь социалист нийгмийн үеийг дурсан ярих малчдын ярианаас мэдэгдэнэ. Тухайлбал, *Хавсарга ихтэй байвал айлууд нь хоргодно, тэгэхгүй бол нүүмээр байна унаа аль, тэрүүгээр очвол ямар вэ гээд сумын удирдлагад хэлнэ, өөрсдөө ч явна. Тэр улс чинь яваад тэнд тийм байна, энд ийм гээд хэлнэ. Манайх чинь Өехий бригадад байсан айл тэндээсээ нүүгээд л Дундговийн нутгийн наад тал ногоо идэш л хаана байна тийшээ явдаг байсан. Тэгээд намар л нөгөө бууцандаа бууна. Бидний үе одооны үе хоёр чинь хоёр өөр болчихоод байна*³⁸. Энэ нь малчдыг нэгтгэж байсан мал аж ахуйн улсын хоршоо- нэгдэл тарснаас хойш малчдын өвөлжөө “*хороо нь хувьчлалд ирсэн, тэрэндээ байцгааж байгаа*”³⁹ гэсэн нь дийлэнх ч төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойш сумын нийт нутгийн өвөлжөө гаргах боломжтой нөмөр, нөөлөгт газар бүрт шинээр өтөг бууц гаргаж байна. Улмаар сумын төвд суудаг иргэд ч хөлсний малчин аваад өөрсдийн нэрийн өвөлжөөн дээрээ байлгах нь ч бий. Эдгээр нь шинээр гэрлэж, малчин болсон өрхүүдийн мал ахуй өсөхийн хэрээр бэлчээрийн хүрэлцээ муудахаас үүдэн тусдаа өвөлжөө гаргаж байгаа ч аль нэгэн жалга аманд хашаа, хороо барьж тэр хавийн бэлчээрийг эзэмших хандлага анзаарагдаж байгаа юм.

³⁸ Дорноговь аймгийн Мандах сумын дөрөвдүгээр багийн иргэн Довжирол овогт Цээнпэлийн Маам, 1950 онд төрсөн, эмэгтэй.

³⁹ Дорноговь аймгийн Мандах сумын хоёрдугаар багийн иргэн Амар овогт Амарын Рэнцэн, 1936 онд төрсөн, эмэгтэй.

Малчдын бэлчээр ашиглалтын байдлаас үүдэн жилд нүүх нүүдлийн тоо харьцангуй цөөрсөн бол хөсөг тээврийн хувьд ердийн хөсгөөр нүүдэллэж байгаад социалист нийгмийн буюу 1950-иад оны дунд үеэс эхлэн машин техник хэрэглэх болсныг Мандах сумын иргэн Тогтохын Цэвэгдорж зэрэг хүмүүсийн “1958 оноос хойш л ганц нэг машин тэрэгтэй болсон. Тэмээн тэрэг чинь дээр үед байсан”⁴⁰ хэмээн ярьж байгаагаас мэдэж болно.

Мандах сумын малчид бэлчээрээ уламжлалт байдлаар нөөцлөн ашиглах арга нь өөрчлөгдөж байгаа тухай өгүүлж байлаа. Учир нь тухайн малчин өөрийн өвөлжөөний ойролцоох "морь тавих"⁴¹, төл мал бэлчээх зэрэгт тохиромжтой өвөр, энгэртээ бусад улиралд тураг малаа гаргахгүй байсан ч өөр айлын мал тэрхүү нөөцөлсөн бэлчээр рүү нь орчихдог. Үүний улмаас өвөлжөөний бэлчээрээ хамгаалахын тулд бараг дөрвөн улирлын туршид бууц буудлаа тойрон ойрхон нутаглах шаардлагатай болдогоос үүдэн отор нүүдлийн тоо цөөрсөн. Мөн нүүдлийн тоо цөөрсөн нь төрөөс хэрэгжүүлж буй бодлого, нийгэм соёлын олон хүчин зүйлээс шалтгаалж байна.

Хуурай болон цөлжүү ургамалжил⁴² зонхилон тархсан уг нутгийн хувьд дөрвөн улирлын туршид мал бэлчээрлэх нь ургамлын нөмрөг нөхөн сэргэж чаддаггүй байна. Тодруулбал, ургамлын үр нь унахаас өмнө мал идэшлэхдээ ургамлаа сорчлон түүж иддэг учир бэлчээрийн ургамлын бүтцэд мал амьтан идэх шимт ургамлын эзлэх хувь багасаж байгаа гэж ойлгож болох юм. Иймээс бэлчээрээ сэргээх буюу амраалгүй дөрвөн улирлын туршид “шалж”⁴³ буусан хэвээр байвал бэлчээрийн даац хэтэрч болзошгүй билээ.

Тухайлсан бүс нутгуудын хувьд нүүдэл, бэлчээр ашиглалттай нь холбоотойгоор малчдыг ангилан, одоогийн байдлаар тоймлон дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

⁴⁰Дорноговь аймгийн Мандах сумын гуравдугаар багийн иргэн Амар овогт Тогтохын Цэвэгдорж, 1949 онд төрсөн, эрэгтэй.

⁴¹Чөдөртэй морь тавих газраа ийн нэрлэнэ.

⁴²Түвшинтогтох, И., Монгол орны хээрийн ургамалжил, ШУА, Биологийн Хүрээлэн, Хянан тохиолдуулсан Ч. Санчир, Улаанбаатар, 2014, 17

⁴³ Нэг газарт ойрхон ойрхон давтан буухыг ийн нэрлэнэ.

А. Нүүдлийн сонгодог хэлбэрээр аж төрж буй малчид: Хэдэн үеэрээ нутаглаж ирсэн өтөг бууц, хаваржаа, намаржаа, зуслан гэсэн тогтсон буудлуудтай, байгалийн онцгой хүнд үзэгдэл болохгүй тохиолдолд нэгэнт тогтсон нүүдлийн чиглэлтэй малчид.

Б. Хөдөөнөөс сум руу нүүж байгаа малчид:

- Ихэвчлэн зуданд малаа барж сумын төвд суун ойр зуур (гар аргаар алт олборлох зэрэг) ажил хийн амьдрах малчид

- Бага насны сургуулийн хүүхдээ даган малаа хүнээр маллуулаад өөрсдөө суманд амьдрах болсон малчид.

- Мал маллахад биеийн чадал тэнхээ нь гүйцэхгүй болсон өндөр настангууд мөн хамаарна.

В. Отрын малчид: Өөрийн гэсэн өтөг бууц өвөлжөөтэй ч газрын гарц, бэлчээрийн даацаас болж төдийлөн тогтмол өвөлжөөд байдаггүй, зэргэлдээх сум, багийн залгаа нутгаар отор хийж цагийн хатууг даваад зуны улиралд тогтсон зусландаа зусч байгаа малчид.

Г. Холын нүүдэлт малчид: Өөр аймаг сум руу ах дүүгээрээ нүүж тэндээ очиж суурьшин мал маллаж байгаа бүлэг малчид, гэсэн дөрвөн үндсэн хэсэгт хуваан үзэж болохоор байна. Энэ бүлэгт хамруулж буй малчдыг шилжих хөдөлгөөнд хамруулан үзэж болох ч цөөн жилийн дараа тодорхой хувь нь буцаж өөрийн нутагтаа ирэх тохиолдол байдаг. Учир нь өөрийн нутгийн бэлчээртээ нэгэнт идээшиж дассан мал ус, бэлчээр сайтай өөр нутагт байсан ч тарга тэвээргээ бүрэн гүйцэд авдаггүйн дээр өвөлжөөний бууцаа малчид эзэмшиж байгаа тул бэлчээр нутгийн хөөлгө гардаг зэрэг шалтгааныг дурдаж болно.

Нийгэм соёлын өөрчлөлтөөс үүдэн монголын бэлчээрийн мал аж ахуйд нөлөөлж байгаа олон хүчин зүйл байна. Тэдгээрийн дотроос монголчуудын хурдан морины уяа засалд гарч байгаа зарим хувирлыг тодруулах шаардлагатай юм.

Энгийнээр бодож үзэхэд, хурдан морь уяа засалд тодорхой ахиц гарч, хөгжиж байгаа мэт ч нийт улсын хэмжээнд аваад үзэхэд адуу эдлэх уламжлалт соёлын цогц байдалд зарим сөрөг нөлөө илэрч байгаа нь судалгааны тодорхой үр дүнгээс мэдэгдэж байна. Учир юун гэхүл, малаа адгуулан маллаж байгаа малчид унаа морио нэмэлт тэжээлгүйгээр цагаан өвсөөр уяад нутагтаа наадахаар айраг түрүү, шөвгийн бариа бүү хэл цулбуурт орж чадахгүйд хүрээд байна. Малчид бүгд адилхан тэжээгээд уях гэхээр цаг завдал, эдийн засгийн бэрхшээлтэй тулгардаг. Тиймээс байран суурин газарт байлгаж, хүн хүч, хөрөнгө бололцоо, тэжээлийн давуу байдлаар давамгайлсан хэсэг бүлэг уяачдын давхарга нэгэнт бий болсон нь бидний Өлзийт хороололд хийсэн судалгааны зарим үр дүнгээс харагдана. Гэхдээ энэ хэсэг уяачдын монгол адууны төлөө хийж байгаа нөр их ажил, хөдөлмөрийг үнэгүйдүүлэх сэдэлгүй болно. Чингээд хурдан морины уяа засалд гарч байгаа зарим нөлөөллийн талаар лавшруулан авч үзье.

Монголчууд байгаль газар зүйн онцлогоос үүдэн эртнээс адууг гаршуулж мал хариулах, тээвэр, уналга, өртөө, цэрэг дайн, баяр наадам, гоёлд хэрэглэж ирсэн түүхэн уламжлалтай ард түмэн юм. Адуу эдлэх чиглэлүүдээс хурдан морины уяа сойлгод гарч байгаа зарим өөрчлөлтийн талаар өгүүлэхийн учир нь байгаль цаг уур, нийгмийн хүчин зүйлээс шалтгаалан тэжээл тариагаар уях арга барил зонхилох болов. Эндээс малчид унаган адуугаа цагаан өвсөөр уяж, сум орон нутагтаа наадах байдал хумигдаж байгаа нь судалгааны тодорхой үр дүнгээс харагдаж байна.

Тухайн сэдвийн дагуу цуглуулсан угсаатны зүйн эх хэрэглэхүүнээс үзэхэд жилийн дөрвөн улирлын туршид нэмэлт тэжээл шаарддаг эрлийзжүүлсэн адуу нийт монгол нутгаар тархвал уналга эдэлгээний зориулалттай бэлчээрийн монгол адууны удмын санд нөлөөлж болзошгүй талаар, мөн адуу эдлэх уламжлалт аргаас өгүүлэхийг оролдоно.

Монголчууд байгаль газар зүйн онцлогоос үүдэн эртнээс адууг гаршуулж уналга эдэлгээ, хөсөг тээвэр, цэрэг дайн, ан ав, өртөө улаа, баяр ёслол болон гоёлд хэрэглэж ирсэн түүхэн уламжлалтай ард түмэн юм. Гэвч нүүдлийн мал аж ахуйн эрчимтэй хувьсалыг дагаад монголчуудын адуу малаа унаж эдлэх соёл, тэр дундаа

хурдан морины уламжлалт “цагаан өвсний уяа”⁴⁴ алдагдаж байгааг зайлшгүй тодруулах шаардлагатай болж байна.

Монголчууд адуу малыг адгуулан маллах явцдаа түүний аль нэгэн давамгайл чанарыг нь танин мэдэж, улмаар ашиг шимийг авах буюу уналга эдэлгээ, ан ав, цэрэг дайнд сургах, уяж хурдлуулж байдаг нь уламжлалт аман соёл болон бичгийн зүйлд тэмдэглэгдэн үлджээ. Үүний нэгэн жишээ нь монгол газар орноо ихэд тархсан “Сайн морины шинжийн судар” юм.

ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Х. Лувсанбалдан “Морины шинж” нэртэйгээр 13 судрыг 1978 онд, “Хүлгийн шинж” нэртэйгээр 1989 онд 28 судрыг Үндэсний номын сан, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн, зарим аймаг сумын орон нутгийн музей, эрдэмтэн судлаачдын хувийн номын санд хадгалагдаж байгаа ховор ном судруудыг эрэн сурвалжилж эмхтгэн хэвлүүлсэн байна.

Хурдан морийг говь цөл, тал хээр, хангай газар уяхаас шалтгаалан өвөрмөц арга ажиллагаа, уяа засал шаардагддаг байна.

Уламжлалт цагаан өвсний уяа сойлго хурдацтай өөрчлөгдөж, тэжээл тариагаар голлон уяж байгааг удмын малчин, уяачид өөр хоорондоо өгүүлэвч энэ чиглэлийн судалгааны өгүүлэл болон нэг сэдэвт бүтээл төдийлөн гараагүй байна.

Иймээс монгол оронд сүүлийн жилүүдэд (2000-аад оноос хойш) газар аваад буй хурдан морины уралдаан, түүнд гарч буй зарим нөлөөлөл буюу тэжээлийн уяаны тухай тодорхой хэмжээнд өгүүлэхийг зорьж байна.

Монголчууд мал аж ахуй дотроо адууг гол болгон үздэг. Ардын аман үлгэрт морийг магтан дуулсан нь маш олон. Хүннү улсын үеэс монголын хаад ноёд нь хамгийн хайрт морио алж, цэргийн тангараг өргөдөг байжээ. Адууг онцлон үздэг нь монгол хүний амьдралтай нягт холбоотойг⁴⁵ ч эртний түүхийн тулгар бүтээлд

⁴⁴ Жилийн дөрвөн улирлын турш ямар нэгэн нэмэлт тэжээл өгөлгүй, зөвхөн байгалийн бэлчээрээр уяж сойхыг ийн нэрийднэ.

⁴⁵ Далай, Ч., Монголын бөөгийн товч түүх. *Studia Ethnographica, Instituti Historica Comitetti Cientiarum et Educationis Altai Republicae Populi Mongoli.* Tomus I. Fasciculus 5. Улаанбаатар, 1959, тал 8.

тэмдэглэхдээ “Хүннүгийн адуу бие бялдар сайтай тэсвэртэй бөгөөд Монгол орны эрс тэс цаг уурт зохилдсон”⁴⁶ хэмээн дүгнэжээ.

Мөн бусад сурвалж бичигт эртний нүүдэлчдийн мал ахуйн тухай өгүүлэхдээ “тэд адуугаа бэлчээрлэхээс биш амуу даршаар бордохгүй. Зургаан сард ногоонд цадаад сая бүдүүрэн таргалдаг. Хязаалан дээр нь эмнэг сургадаг болохоор бузгай бөгөөд хүчтэй, номхон ... бөгөөд муу аашгүй, хүйтэн салхийг тэсч хол явах чадвартай”⁴⁷ гэсэн зэргээс үзэхэд бэлчээрийн адуу нь уналга эдэлгээнээс гадна эрт үедээ цэрэг дайны зориулалттай байсан нь тодорхой юм. Тийм ч учраас дундад зууны үед “Монголчууд адууг бусад малаас их эрхэлж төрийн бодлого болгон үржүүлж, Юань гүрний үед Адууны засгийг тусгайлан тогтоож, хааны их адуун сүргийг дээдсийн сүрэг хэмээн нэрлэж”⁴⁸ байжээ.

Улмаар адууны хурдан шинжийг цохон тэмдэглэж, эрхэмлэн үздэг байсан нь Монголын нууц товчоо, Лувсанданзаны Алтан товч зэрэг түүхийн тулгар сурвалжид тусаж үлдсэн нь бий. Үүнд дөч орчим удаа морьдын тухай дурдагдах боловч “хурдан” гэж онцолсон морьд гарч байгаа нь Чилэдүгийн хурдан ухаа морь, Чуу мэргэний олзолсон зээрд халзан морь зэргийг дурдаж болно. Мөн Лу. Алтан товчид “*Үрээ морь хурдан боловч, хөгшин морин холч буй*”⁴⁹ гэж байгаа нь адууг нас болон онцлогоор нь ямар ажил, эдэлгээнд хэрэглэхээ тохируулж байсныг харуулах юм.

Ийнхүү мал аж ахуйн үүргээс гадна цэрэг дайнд чухал үүрэг гүйцэтгэж байсан адууг тухайн нийгэм цаг үеийн байдлаас үүдэн олон үүрэг зориулалтаар ашиглаж ирсний нэг нь баяр наадмын чанартай хурдан морины уралдаан юм.

XVI зууны үед “Долоон хошууны наадам” үүссэн бөгөөд XIX зууны II хагас хүртэл их нас, соёолон, хязаалан насны морь уралдуулдаг байснаа нэлээд хожим азарга, шүдлэн, жороо морь нэмж уралдуулах болжээ⁵⁰.

⁴⁶ Сүхбаатар, Г., Монголчуудын эртний өвөг. Улаанбаатар, 1980, 22

⁴⁷ Баясах, Ж., Их монгол улсын түүхэнд холбогдох хятад хоёр сурвалж бичиг. (Хоёр дахь хэвлэлт) Улаанбаатар, 2006, 263

⁴⁸ Далай, Ч., Монголын түүх (1260-1388). Гутгаар дэвтэр, Улаанбаатар, 1992, 91-92

⁴⁹ Хаадын үндсэн хураангуй Алтан товч. Монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж, харгуулан тайлбар хийсэн Ш. Чоймаа. Улаанбаатар, 2006, 85

⁵⁰ Бадамхатан, С., БНМАУ-ын угсаатны зүй. I боть. Улаанбаатар, 1987, 377

Монгол орны байгаль цаг уурын хатуу ширүүн нөхцөлд адуу төдийгүй нийт мал сүргээ маллахад ган гачиг, зуд турхан ихээхэн хохирол учруулдаг. Ялангуяа ойрын жилүүдэд⁵¹ монгол орны дийлэнх газар нутгаар бэлчээрийн гарц муудаж байгаа нь малчид таван хошуу малаа адгуулан маллахад бэрхшээлтэй болж, цаашлаад хурдан морины уяа сойлгын үед нэмэлт тэжээл өгөх шаардлагатай хэмээн үзэх болжээ. Нөгөө талаас, хурдан морины уралдааныг төрөл бүрийн байдлаар сонирхогчдын тоо нэмэгдэж, жилийн дөрвөн улирлын туршид уралдаан болдог болсон нь уяачид морьдоо байнгын тэжээлтэй байлгаж уяа заслыг нь хангах болсон байна.

Адуу эдлэх чиглэлүүдээс хурдан морины уяа сойлгод гарч байгаа зарим өөрчлөлтийн талаар өгүүлэхийн учир нь өнөөгийн нийгмийн олон хүчин зүйлээс шалтгаалан тэжээл тариагаар уях арга барил зонхилж, улмаар малчид унаган адуугаараа сум орон нутагтаа наадах байдал хумигдаж байгаа нь судалгааны тодорхой үр дүнгээс харагдаж байна. Тухайлан жишээ болгож, Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын алдарт уяач П. Бадралын ярианаас эшилбэл,

“Өнөө үед давхиж буй тэжээл тарианы морьд дээхнэ үед давхиж байсан морьдоос ондоо болчихож, хөнгөн шингэн явдалтай морьд олон байна. Дээх нь үеийн морьдтой харьцуулахад зүтгэж байгаад суугаад үлдэх морь нь тэжээл таринанаасаа болоод давхидаг болчихож... Ноднин нэг тэжээгээд үзсэн олигтой болохгүй байсан, ядахдаа л тангайтал хөөгөөд л мань мэт нь тэжээлийн хордлогоны тариаг нь хийж чадахгүй юм билээ. Тариа хийж чадахгүй болохоор жаахан урам хугарас гээд л байгаа юм. Түүнээс биш ногоо бороогоор уядаг байсан үед олон уяачид байдаг байсан. Одоо энэ сумын ерэн жилийн ой болох гэж байгаа, тэрэнд тариа хийгээд л уячихдаг. Цөөхөн улсууд л ирнэ, өмнө нь бол бороогоор уяад л адуун дотроо арай дөнгүүрээ уяад л, олон уяачид ирээд нааддаг, наадам өтгөн сайхан л болдог байсан. Сүүлийн үед хангайд тэжээж байсан нь говь руу орж ирээд байна, газар муу байсан ч тэжээгээд хаа сайгүй ачигдаж ирээл уралдаж байна л даа...

⁵¹ Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгээс гаргасан судалгаагаар сүүлийн 73 жилийн дундаж температур нь зундаа 1.4% нэмэгдэж дулаарсан, өвөлдөө 24% -иар нэмэгдэж цас ордог хэдий ч зундаа 7%-иар буурч хуурайшсан байна. www.icc.mn

*тэжээлийн морьтой дөмөг морь уралдуулж үзсэн тэжээлийн тамиртай моринд чинь тэжээгээгүй морь хүрдэггүй юм байна лээ*⁵² хэмээн өгүүлж байгаа бол Өлзийт хорооллын уяачдын ярианаас түүвэрлэн эшилбэл,

*“Өвөл зунгүй адилхан шахуу л тэжээдэг зундаа бол арай бага. Өвсөөр уяна гэж байхгүй шүү дээ хүн болгон л тэжээж байна”*⁵³ гэх юм уу *“тэжээлийн адуу бол олон наадамд уралдана өвсөөр уяж байгаа адуу бол зун л уралдана шүү дээ”*⁵⁴ гэж ярьж байгаагаас үзэхэд “Өлзийт хороолол”⁵⁵ зэрэг газарт тэжээлийн уяа нийдэмдээ тархсан нь илэрхий байгаа юм.

Гэхдээ дан ганц төв суурин газарт л хурдан морийг тэжээгээд байгаа бус, угсаатны зүйн судалгаа хийсэн Улаанбаатар хотоос алс хол баруун хязгаар болох Говь-Алтай аймгийн Бугат суманд ч тэжээж эхлээд байгааг ахмад уяач Дамдинсүрэнгийн Бааст гуай учирлахдаа,

“Тэжээлийн уяаг би нэг сайн мэдэхгүй л байгаа юм. Манай эндэхийн улсууд тэрийг ер нь эзэмшиж чадахгүй байна. Дуулаад байхад байгалийн ургамал ер нь өгдөггүй юм биш үү. Манайд сүүлийн хоёр гурван жилээс өгөөд байгаа ч арга ажиллагааг нь тааруулахгүй, тэр нь үндсэндээ хор болно л доо. Зүүн тийшээ морьд чинь янз бүрийн тарилгаар л давхидаг гэх юм. Цөөхөн жил давхидаг гэнэ, тэр тэжээлийн мал чинь. Өөрөө хурдтай

⁵²Энхбаатар, М., Дорноговь, Хэнтий, Өмнөговь зэрэг аймгуудын зарим сумдад явуулсан угсаатны зүйн судалгааны тайлан эх хэрэглэгдэхүүн. Улаанбаатар, 2015, 142. Өмнөговь аймаг Баян-Овоо сумын Могой багийн малчин сумын алдарт уяач Пүрэвийн Бадралаас /1965 онд төрсөн могой жилтэй/ Могой багийн нутаг Шороотын Ухаа бууцанд 2014 оны 4 дүгээр сарын 27-нд тэмдэглэн авав. ШУА-ийн ТАХ-ийн Баримт мэдээллийн төв. Хөмрөг - 10, Данс - 1, Хадгаламжийн нэгж - 37.

⁵³ Энхбаатар, М., Дорноговь, Хэнтий, Өмнөговь зэрэг аймгуудын зарим сумдад явуулсан угсаатны зүйн судалгааны тайлан эх хэрэглэгдэхүүн. Улаанбаатар, 2015, 190. Дундговь аймгийн Гурвансайхан сумын уугуул Тайж овогт Доржхандын Галсандоржоос (1979 онд төрсөн эрэгтэй) 2014 оны 12 дугаар сарын 15-нд Улаанбаатар хотын Хан уул дүүргийн Өлзийт хороололд тэмдэглэн авав. ШУА-ийн ТАХ-ийн Баримт мэдээллийн төв. Хөмрөг - 10, Данс - 1, Хадгаламжийн нэгж - 37.

⁵⁴ Энхбаатар, М., Дорноговь, Хэнтий, Өмнөговь зэрэг аймгуудын зарим сумдад явуулсан угсаатны зүйн судалгааны тайлан эх хэрэглэгдэхүүн. Уб., 2015, 191. Авзага Трейд ХХК-ийн уяач Дундговь аймгийн Дэрэн сумын уугуул Боржигон овогт Батсүхийн Хэнчбишээс (1980 онд төрсөн эрэгтэй) 2014 оны 12 дугаар сарын 12-нд Улаанбаатар хот Хан уул дүүргийн Өлзийт хорооллын уяачийн гудамжны 5-32-т тэмдэглэж авав. ШУА-ийн ТАХ-ийн Баримт мэдээллийн төв. Хөмрөг - 10, Данс - 1, Хадгаламжийн нэгж - 37.

⁵⁵ Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нэгэн хороо. Цөөн тооны малтай айлууд байх боловч морь тэжээж уяж буй уяачдын төвлөрсөн газруудын нэг юм.

амьтанд чинь тамир л суулгаад байх шиг байгаа юм. Би ч Алтайн өвс ногоогоор л нааддаг байсан. Амьтны ярианаас дуулж байхад тэр сүрхий хурдтай морьд чинь хашаа саравчинд л байж байдаг гээ биз дээ. Байнга л тэжээдэг юм байна. Манай энд бол баяр дөхөөд ирэхээр арван хэд хоног тэжээл өгсөн болоод л бусад үед эдлэхгүй. Морь гэдэг чинь эр хүний арга ажиллагаанаас шалтгаална. Цагаан өвсний адуу чинь насаараа л давхина. Тэжээл тарилга чинь бөөн хор”⁵⁶

хэмээн дөрвөн цагийн эдэлгээтэй адууг цагаан өвсөөр уяж сойдог байсан тухайгаа өгүүлж байлаа. Энэ тухай олон газрын уяачид ярьдаг. Энд нэмэлт жишээ болгох үүднээс Дорноговь аймгийн Мандах сумын уяач Т. Цэвэгдоржийн яриаг оруулж байна.

“Би морь уядаг л байсан сумын алдарт уяач. Тэжээлээр уяад байхаар уралдаж болохгүй цагаан адуу бол хүрэхгүй ялгараад байгаа юм. Адилхан тэжээвэл бас ч гэж уралдахаар юм билээ. Тэрэн дээр чинь баячууд нь тэжээнэ, маниус морио тэжээвэл бараг хоосон хонох болно. Нэг тэжээвэл хоёроос гурвыг тэжээнэ тэгээд дусал хийнэ, тариа хийнэ учрыг нь олохгүй юм билээ”⁵⁷.

Ийм утга агуулга бүхий жишээ баримтыг өнгөрсөн хугацаанд угсаатны зүйн судалгаа хийсэн сум⁵⁸ бүрээс эшилж болох ч давхардуулахгүйн үүднээс үл оруулав.

Сум аймагт зохиогдож байгаа наадам бол нутгийн уяачид орон нутагтаа наадаж адууныхаа давхил чансааг үзэж, уяачид эрдэм ухаанаа сорин нөхөрлөж, нийлэн нягтарч, цаашлаад өндөр төрийн наадамд бэлдэж буй бэлтгэл сорилго юм.

⁵⁶ Энхбаатар, М., Говь-Алтай аймгийн Бугат суманд хийсэн угсаатны зүйн судалгааны тайлан, эх хэрэглэгдэхүүн. Уб., 2014, I боть, 27. Тус сумын Ферм багийн малчин Дамдинсүрэнгийн Баастаас /1932 онд төрсөн, тахиа жилтэй, эрэгтэй/ Төгрөг булгийн зусланд 2014 оны 7 дугаар сарын 20-нд тэмдэглэн авав. ШУА-ийн ТАХ-ийн Баримт мэдээллийн төв. Хөмрөг - 10, Данс - 1, Хадгаламжийн нэгж - 11.

⁵⁷ Энхбаатар, М., Дорноговь, Хэнтий, Өмнөговь зэрэг аймгуудын зарим сумдад явуулсан угсаатны зүйн судалгааны тайлан эх хэрэглэгдэхүүн. Уб., 2015, 42. Дорноговь аймгийн Мандах сумын гуравдугаар багийн иргэн Амар овогт Тогтохын Цэвэгдоржоос /1949 онд төрсөн, үхэр жилтэй, эрэгтэй/ тэмдэглэн авав. ШУА-ийн ТАХ-ийн Баримт мэдээллийн төв. Хөмрөг - 10, Данс - 1, Хадгаламжийн нэгж - 37.

⁵⁸ Өмнөговь аймгийн Ханбогд /2014/, Хэнтий аймгийн Биндэр, Дадал /2015/, Дорнод аймгийн Хөлөнбуйр /2015/, Баянхонгор аймгийн Баацагаан, Жаргалант /2015/, Хөвсгөл аймгийн Цагааннуур /2016/, Дундговь аймгийн зарим боржгин сумд /2016/, Архангай аймгийн Цахир, Хангай /2017/ гэх мэт.

Гэтэл суурин газарт тусгай байр саванд байрлуулан, тэжээл тариагаар тордож уясан морьд орон нутаг, бүсэд очиж наадаж байгаа нь малаа адгуулан маллаж, морио уяж буй нутгийн уяачдын урам зоригийг мохоох, мал дагах зүтгэлийг зарим талаараа хөсөрдүүлэх талтай байна.

Цагаан өвсний уяа бол дөрвөн улирлын туршид эдэлгээтэй байсан морьдыг уядаг уяа юм. Эдлэхгүйгээр сул гүйлгэж байгаад тарган морь уяна гэж байдаггүй.

Тухайлбал, Хөвсгөл аймгийн халх сумдад уях морьдоо өвөлд нь хүүрэгтүүлж, онгойлгон хорыг нь гаргаж, намар тосон тарга хүч шимийг нь бүх бие ясанд нь шингээж, хавар нь алсын салхи сөргүүлж уян, дотор өөхийг барах зэргээр унаж эдлэн, зуны уяа сойлгонд бэлддэг байна. Энэ мэтчилэн дөрвөн цагийн эргэлтэд эдэлгээтэй байгаа морь алсаас зөв нимгэрэхийн дээр бэлчээрээ мэддэг мал, малаа мэддэг малчин хоёрын зүй зохист харилцааг хадгалж байгаа юм. Одоогийн тэжээлийн уяаны үед голдуухан хурдан удам угшилтай, заавал шөвгийн барианд орох морь уяахыг хичээдэг болсон бөгөөд энэ цагт цээжинд давхиж байгаа морьд гол төлөв суурин газар байран байж уягдаж байгаа нь адуу малаа унаж эдлэхгүй байх нэгэн шалтгаан болж байна.

Монголчуудын адуу эдлэх соёлд морийг шөвгийн бариагаар давхисан ч, цулбуурт орохгүй байсан ч ялангуяа бага насанд нь үсэргэж тарлаж байх нь амьсгаа задгайрч, бие нь буларч няцарч тамир суудаг учраас “унаж эцээхээр уяж эцээ” гэсэн мал аж ахуйгаа эрхлэхэд заан сургасан цэцэн үгэнд журамлагдан иржээ. Ерөөс хуучин цагийн уяачдаас өвлөгдөн ирсэн аман хууль бол сайн уяач гэдэг нь цөөн морь эндүүлж, цөөн морины хөл гэмтээсэн, холоос зориод наадамд ирсэн ч морь жаахан өө согогтой байвал уралдуулахгүй тэвчиж чаддаг хүнийг бүтэлтэй уяачийн зэрэг зиндаанд тооцдог байж. Одоогийн улс бүсийн том жижиг наадамд хэдэн морь осолдож эндэж байгаа албан ёсны тоо баримт байхгүй ч уяачид энгүүн ярих нь:

“Тэжээл тарианы уяаны үед сайн хатгаж цусыг нь шингээлэх эмчилгээ хийж хүчээ тааруулж байхгүй бол морь малын хөл доголох нь их байна. Одоо үед моринд чинь хүчтэй хүчтэй тариа хийж байна. Тэгээд морийг бол тухайн үедээ нэр алдараа олохын тулд богинохон

*хугацаанд ашиглаад хаяж байна*⁵⁹ гэх юм уу “Тэжээлийн морь ханиалгах өвчин тусах нь амархан байдаг... өвсний малыг бодвол дороо л өвчин авна... тэжээлийн морь цусны хөөрөлт ихтэй тэгсгээд л доголох гээд байгаа юм”⁶⁰ гэж байгаа бол, мөн Өлзийт хорооллын уяач Б. Хэнчбиш: “Нутагтаа бол өвсөөр уяж байсан. Энд чинь бас уяа засал нь өөр юм шиг байгаа юм. Нээх ажил хийхгүй байж байгаад ханагар ханагар сунгадаг юм байна лээ. Цагаан өвсний адуу чинь арай зөөлөн уяатай, тэжээлийн адуу чинь тордлого ажил ихтэй их таргалахаараа хөл гараа авчих гээд байдаг хорыг нь гаргана гээд дусал тарианаас эхлээд ажил ихтэй юм”⁶¹ гэх зэргээр судалгаа хийсэн сум багийн малчдын дунд хэлэлцэгдэж байгаа тул аман баримтын түвшинд үзүүштэй.

Адууг тэжээж, байнгын хүч тамирыг нь баруулж, түүндээ таарсан хатуу уяаны ажил хийхээр уяа хэтэрч цөмөрчих гээд байдаггүй, уяаны ая даадаг ч их хурд орохоор тэжээлийн тамир тэнхээгээр харайж, түүнийгээ хөлийн хурд нь гүйцэхгүй доголох гэмтэй байдаг байна. Цагаан өвсний адуу таргалахаараа цус нь өтгөрдөг бол тэжээлийн морь шууд туранхай байсан ч цус нь өтгөрч, дотор талаас гол нь өөхлөх гээд байдаг тухай малчид, уяачид ярьдаг.

⁵⁹ Энхбаатар, М., Дорноговь, Хэнтий, Өмнөговь зэрэг аймгуудын зарим сумдад явуулсан угсаатны зүйн судалагааны тайлан эх хэрэглэгдэхүүн. Уб., 2015, 8. Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын Могой багийн малчин сумын алдарт уяач Хурган овогт Дамирандоржийн Ганхуягаас /1959 онд төрсөн гахай жилтэй эр/ 2014 оны 4 дүгээр сарын 28-нд тэмдэглэн авав. ШУА-ийн ТАХ-ийн Баримт мэдээллийн төв. Хөмрөг - 10, Данс - 1, Хадгаламжийн нэгж - 37.

⁶⁰ Энхбаатар, М., Дорноговь, Хэнтий, Өмнөговь зэрэг аймгуудын зарим сумдад явуулсан угсаатны зүйн судалагааны тайлан эх хэрэглэгдэхүүн. Уб., 2015, 201 “Монгол Базалт” компанийн уяач Архангай аймгийн Өлзийт сумын уугуул Чойжив овогт Доржийн Баасангаас /1959 төрсөн гахай жилтэй эр/ 2014 оны 12 дугаар сарын 16-нд Улаанбаатар хот, Хан уул дүүргийн Өлзийт хороололд тэмдэглэн авав. ШУА-ийн ТАХ-ийн Баримт мэдээллийн төв. Хөмрөг - 10, Данс - 1, Хадгаламжийн нэгж - 37.

⁶¹ Энхбаатар, М., Дорноговь, Хэнтий, Өмнөговь зэрэг аймгуудын зарим сумдад явуулсан угсаатны зүйн судалагааны тайлан эх хэрэглэгдэхүүн. Уб., 2015, 8. Авзага Трейд ХХК-ийн уяач Дундговь аймгийн Дэрэн сумын уугуул Боржигон овогт Батсүхийн Хэнчбишээс (1980 онд төрсөн эрэгтэй) 2014 оны 12 дугаар сарын 15-нд Улаанбаатар хот, Хан уул дүүргийн Өлзийт хорооллын уяачийн гудамжны 5-32- т тэмдэглэж авав. ШУА-ийн ТАХ-ийн Баримт мэдээллийн төв. Хөмрөг - 10, Данс - 1, Хадгаламжийн нэгж - 37.

Тухайн сэдвийн дагуу цуглуулсан эх хэрэглэхүүний хүрээнд дүгнэж үзэхэд, Өлзийт хорооллын малчид уяачид тэжээлийн уяагаар дагнаж байгаа бол, сум орон нутагт сүүлийн дөрөв таван жилээс хурдны морийг тэжээж эхэлж байгаа бөгөөд морь маландаа гэм согог суулгаж болзошгүй нь анзаарагдаж байна. Энд тэжээлээр дагнасан уяачид төрөн гарч, улс бүсийн наадамд айраг түрүү авч байгаагаараа амжилт мэт боловч адуу эдлэх соёлын цогцолбор байдал алдагдаж байгаа нь орон нутгийн уяачдын морь уях урам зориг мөхөх, хурдан моринд осол эндэл гарах нь элбэг болсон зэргээс харагдаж байна.

Энэ мэт байдлаар ямар нэгэн зохицуулалт хийхгүй бол дөрвөн улирлын туршид нэмэлт тэжээл шаарддаг адуу нийт монгол нутгаар тархвал уналга эдэлгээний зориулалттай, бянтай чадалтай мал маллагааны монгол адууны удмын санд нөлөөлж болзошгүй юм.

Орчин үеийн нөлөөлөлд эрчимтэй автагдаж байгаа нэгэн зүйл бол уламжлалт хурдан морины уяа засал гэдэг нь энэ бүхнээс харагдах бөгөөд хуучин цагийн "цагаан өвсөөр" уяж сойгоод нутаг орондоо наадаж наадамладаг байсан уламжлал нэлээд алдагдаж, одоо цагийн⁶² ихэд дэлгэрээд буй нэмэгдэл тэжээл, тариа, бордоо сэлтийг өгч, хүч тамир сэлбэн уралдуулах болсон нь дамжиггүй байна.

Монголын бэлчээрийн мал аж ахуй агуулгын хувьд өөрчлөгдөөгүй ч нийгэм соёлын олон хүчин зүйлүүдээс шалтгаалан зарим нөлөөлөлд автаж байна. Энэ нь нэг талаараа төрөөс хэрэгжүүлж байгаа бодлоготой шууд болон дам байдлаар холбогдоно. Тухайлбал, малчдын өвөлжөөнд эзэмшлийн гэрчилгээ олгосон явдлыг иргэд тэр хавийн бэлчээртээ авсан өмчлөлийн гэрчилгээ мэтээр ойлгож, бэлчээрийн маргаан гарах бодит шалтгаануудын нэг болсон нь судалгааны явцад ажиглагдаж байлаа.

⁶²2000-аад оны орчмоос хойш нийт монгол нутгаар тархаад буй тэжээлийн уяаг малчид өгүүлж байна.

2.2 ГАН БА ЗУД

2.2.1 Ган, зудны тухай ерөнхий ойлголт

Ган гэдэг нь хур тунадас хэвийн байдлаас багасаж, хэт халуун өдрүүд үргэлжилж, хөрсний чийг эрс багасч, өвс ургамал гандан хатаж, мал аж ахуй, газар тариаланд их хэмжээний бэрхшээл учруулах цаг агаарын нөхцөл гэж тодорхойлж болно.

Гангийн шалгуур нь байгаль, цаг уурын бүс бүрт ялгаатай төдийгүй хамрах хүрээ, үзүүлэх хор хөнөөлөөрөө ч өөр байдаг. Гантай жилүүдэд бэлчээрийн ургац 12-60 хувиар буурснаас болж мал сүрэг дулааны улиралд авбал зохих тарга хүчээ бүрэн авч чадаагүйгээс өвөл, хаврын улиралд, ялангуяа зуд тохиолдвол олноороо хорогдох шалтгаан болдог.

Ганг дотор нь **гандуу, гантай, улаан ган** гэж ангилж болно. Монгол оронд сүүлийн 60 гаруй жилд тохиолдсон гантай жилүүдэд бог малын дулааны улиралд авсан тарга хүч, зүй бусын хорогдлыг гангийн эрчимжилтийн байдалтай холбон, гангийн индекс (8), хоорондох хамаарал (K-0.70) гэсэн үзүүлэлтээр авч үзэхэд зун, намрын гангийн индексийн утга хоёроос их байсан 1944,1946,1999,2001 оны дараагийн жилүүдийн малын зүй бус хорогдол хэвийнүеэсээ 2-10 дахин их гарч байжээ (Л.Нацагдорж. 2002).

Зуд гэдэг нь цас их орох, эрс хүйтрэх гэсэн хоёр үзэгдэл хүчтэй салхи, шуургатай хавсарсан цасгүй ч гэсэн тухайн нутгийн бэлчээрийн даац хэтэрч, бэлчээр их талхлагдсан зэргээс үүдэн мал идэх өвсгүй болж, мал сүрэг ихэнхдээ өлдөж, осгох, хөлдөх зэргээр олноороо хорогдохыг хэлдэг.

Цас их орж, нягтран хатуурч, бэлчээрийг дарснаас мал бэлчээх боломжгүй болохыг “цагаан зуд”, өвөл цас орохгүй усгүйдэж, их хүйтрэн газрын хөрс зузаан хөлдсөнөөс бэлчээрлэн идээшлэх боломжгүй болохыг “**харын зуд**”, намар орой тийш цас дангаар заримдаа бороотой холилдон орж, дутуу хайлан хөлдөж, улмаар цасан дор мөсөн ул, цасанд мөсөн үе тогтсоноос мал бэлчээрийн өвс ургамал идэх

боломжгүй болж, малын хөлийн арьс зулгарч, өвөлжөө, бууц хэвтэр хөлдөхийг **“төмөр зуд”** буюу **“шилэн зуд”** гэж нэрлэдэг.

Зун нь ган болж, өвөл нь хүйтрэхэд зарим нэг боломжтой гэх нутаг, бэлчээрт нэг дор хэт олон айл, малтайгаа бөөгнөрөн өвөлжиж, хаваржсанаас бэлчээр хомсдож, мал нь зутарч, олноороо хорогдон, жилбэгүй төллөхийг **“туурайн зуд”** гэдэг.

Хүйтний улиралд удаан хугацаагаар шуурч, малын бэлчээрт идээшлэх боломжийг алдагдуулснаас хашаа, саравч, нөмөр газар, ялангуяа тэжээл дутагдан мал өлсөж дааран олноороо үхэх нөхцөл бүрдэхийг **“шуурган зуд”** гэнэ. Хүйтний улиралд нэг секундэд арван метрээс илүү хурдтай салхи хангайн бүсэд таван хоног, хээрийн бүсэд дөрөв хоног, говийн бүсэд гурван хоног шуурвал дан бэлчээрийн мал бэлчээр ашиглаж чадахгүй үхэхэд хүрдэг.

Өвөл, хаврын цагт ихэвчлэн цас орж байхад буюу цас орсны дараа хүчтэй шуурдаг. Цасан шуурганд мал туугдан уруудаж осгох, цасанд дарагдах, хот хороондоо овоорч бие биенээ дарах, бэлчээрт идээшилж чадахгүй өлдөх зэргээр үхэж, ихээхэн хохирол учруулдаг.

Ихэвчлэн цагаан зуд их хүйтэнтэй хавсарч тохиолддог. Энэ зудны онцлог нь урьд орсон цас их хатуурч, хунгарладаг явдал юм. Өвлийн улиралд мал бэлчээрлэж чадахгүй болтол хэдэн хоногоор хүйтэрч, өвс тэжээл, байр хашаа дутагдсанаас бэлчээрийн мал өлсөж дааран, олноороо осгож үхэх нөхцөл бүрдэхийг **“хүйтний зуд”** гэдэг. Мал салхигүй тогтуун -40С-д бэлчээрлэж чаддаг боловч хүйтэн салхитайд -30°С хүртэл хүйтрэхэд бэлчээрт идээшилж чаддаггүй.

Хүйтний зуд дангаараа цөөн тохиолдох боловч ихэвчлэн цас, шуургатай хавсарч малын хөл, чих, сүүл хөлдөх, хатгалгаа тусах, осгох, хөлдөх, хээл хаях, ялангуяа төлд муугаар нөлөөлж ихээхэн хохирол учруулдаг.

Их цас орж хүйтрэх, мөн хараар хүйтрэх, цасаар шуурч, цаг агаарын байдал хүндрэхийг **“хавсарсан зуд”** гэнэ.

Зудыг ерөнхий төлөв байдлаар нь **зудархуу, зудтай, асар их зудтай** гэж ангилж болно. Нүүж зайлах боломжтой бага нутаг хамарсан зуд байдаг бол нүүгээд гарах гарцгүй ихэнх нутгийг нэлэнхүйд нь хамарсан зуд байдаг. Ихээхэн нутаг бэлчээр хамарсан зуданд **“зудын хүйс”** гэж байдаг. Энэ голомтод хамгийн их хохирол гардаг.

Үүнээс үзэхэд малын хорогдолд тухайн жилд тохиолдсон зудын хамрах нутаг дэвсгэрийн хэмжээ чухал юм. 1940-2000 онд Монгол орны нутаг дэвсгэрийн талаас дээш хувийг хамарсан зуд 10 удаа болсон бөгөөд 1970 оноос хойш ихээхэн нутаг дэвсгэрийг хамарсан зудын давтамж нэмэгдсэн байна. 1999-2000 оны өвөл 13 аймгийн 157 сумын нутаг буюу нийт нутгийн 70 хувийг хамарсан зуд болжээ.

Ган, зуд нь бороо, цас, салхи, шуурга, халуун, хүйтэн зэрэг байгалийн, нутаг бэлчээр, өвс ургамлын ургац зэрэг амьд байгалийн зарим хүчин зүйлс болон бэлчээр талхлагдах, гол ус ширгэх, малын хариулага, маллагаа, тарга хүч авахуулах, заазлах, өвчин эмгэгээс сэргийлэн хамгаалах ажил, хашаа хороо, хэвтэр бууц, усны хангамж зэрэг хүний үйл ажиллагаатай холбоотой хүчин зүйлс, тэдгээрийн харилцан хамаарал нөлөөг хамруулан багтаасан цогц ойлголт юм.

Ган, зудыг нөхцөлдүүлдэг экологийн сөрөг хүчин зүйлсийн дотор:

- Зун, намар нь бороо хур орохгүй
- Аагим халуун удаан үргэлжлэх
- Өвөл, хавар зузаан цас орж, нягтарч хатуурах
- Тэсгим хүйтэн удаан үргэлжлэх
- Хүчтэй салхи, цасан болон шороон шуурга шуурах
- Зарим үед хүйтэн болон аадар бороо орох зэрэг цаг агаарын бэрхшээлт үзэгдлүүд гол байр эзэлдэг.

Ган, зуд нь эдгээр хүчин зүйлсийн нөлөө, үр дагавар, малчин хүний малч ажиллагааны шалгуур, малын тарга хүчний хэмжүүр юм. Ган, зудыг ажилч хичээнгүй малчид шаргуу ажил, хөдөлмөрийнхөө дүнд амжилттай давж гардаг. Харин малдаа анхаарал тавьдаггүй залхуу малчин ган, зуданд хамгийн түрүүнд өртөж, их хохирол

амсдаг. Үүнээс улбаалан түүнийг **залхуугийн зуд** ч гэж нэрлэдэг. Ер нь ийм малчны хотонд хэвийн жилүүдэд ч ган, зуд болсоор байдаг.

Ган, зуд нь мал өвс тэжээл, усаар гачигдаж, өлбөрч цанган, турж доройтон осгож хөлдөж, мөн өвчилж үхэх үндсэн шалтгаан, мал, малчин хоёрт тохиолдож буй хамгийн хүчтэй байгалийн шалгуур юм.

Зудтай тэмцэх оюун санааны болон материалын бэлтгэлийг хангасан үед хохирол багатай давж гарч болно. Аж ахуйн бэлтгэл дутсан айл илүү их хохирол амсдаг.

Холбогдох байгууллага, удирдах нөхдийн цаг алдсан, мөн оновчгүй шийдвэр, буруу арга ажиллагааны уршгаар үүсдэг, тэр нь асар их хохирол учруулдаг зуд ч байдаг.

Тодруулбал, залхуу, урагшгүй цөөн тооны малчин хэдэн арав, цаашилбал хэдэн зуун мал хорогдуулаад өнгөрдөг зуд байдаг бол шат, шатны дарга нарын удирдлагын зохион байгуулалтын алдаа дутагдлаас болж тухайн баг, сум, бүр аймаг хамрах хэмжээний хохиролд хүргэдэг зуд байдаг. Ийм зуд цаг таатай жилүүдэд ч ялгаагүй болсоор ирсэн түүнийг **“удирдлагын зуд”** гэж нэрлэж болно.

Ийм зуд гол төлөв тухайн шатны дарга, мэргэжилтэн нар малчдынхаа өвөлжих, хаваржих, улмаар зусаж, намаржих нутаг бэлчээрийг хугацаанд нь оновчтой шийдэж өгөөгүй байр, өвс тэжээл, өтөг бууцны бэлтгэл болон мал эрүүлжүүлэх, мал таргалуулах, оторлох, хадлан тэжээл бэлтгэх ажлыг шаардаж хийлгэдэггүй, өвөл, хаваржааны бэлтгэл ажлыг шаардаж хийлгэдэггүй, өвөлжөө хаваржааны бэлтгэлийг нэгдсэн журмаар зохион байгуулдаггүй, зун, намрын сайхан улиралд найр наадам ихэссэн газарт олонтоо тохиолдсоор ирсэн.

2.2.2 Ган, зудны талаарх түүхчилсэн тэмдэглэл

Монголын түүхэн сурвалж бичиг болон гадаадын жуулчид, судлаачдын тэмдэглэлд бэлчээрийн мал аж ахуйд үлэмж хэмжээний хохирол учруулсаар ирсэн байгалийн гамшгийн талаар зарим баримт, мэдээ үлдсэн байдаг. БНМАУ-ын түүхийн I боть, Нэвтэрхий толь зэрэг бүтээлд манай эриний өмнөх 72, 68 он, манай эриний 46 онд ган, зуд болсон тухай, Ц.Доржсүрэн “Умард Хүннү” (1961) бүтээлдээ “Хүннү

нарын нутагт их цас орж, нэг өдрийн хоёр алд илүү зузаан болоод хүн, мал их хөлдөж үхэв. Арван хувиас нэг хувь харин эс эгэв” гэж, Юань улсын сударт 1248 онд улаан ган, асар их зуд болж, мөн хээрийн түймэр гарч, гол горхи ширгэснээс 10 үхэр, морины 8-9 нь үхсэн нь 1247 оны 5-р сард Санчирын нөлөөлөл, мөн 1 дүгээр сарын 1-нд Охин гаригт гаригсийн бөөгнөрөл болж, Санчир, Ангараг гаригууд тохиосонтой холбоотойг дурджээ. Мөн 1254 оны өвөл Хархорум орчимд зуд болж 1308, 1340 онуудад Монгол нутагт их цас орж мал олноороо үхсэн тухай, 1308-1440 онд бүрэн бус мэдээгээр дөрвөн удаа хүчтэй зуд тохиолдсоныг тэмдэглэжээ.

Түүхч Лувсанданзан “Алтан товч”-доо ХIY-ХY зууны үед болж байсан цагийн гачаалаар олон тооны агт морь, эр цэрэг үхүүлсэн 1372 оны их шуурга, хүчтэй бороо, цагаан морин жил буюу 1450 оны хүйтэн салхины тухай тэмдэглэсэн байна.

Цасны зузааныг хуруу, сөөм, төө, мухар гохой, тохой, алд, бог, бодын хар туруу, морины сагаг, бодын өвдөг, гэдэс, хээл, цүн, ямх, чий гэх мэтээр, хур тунадасыг хөрсөнд нэвчсэн чийгийн гүнээр нь дээр дурдсан хэмжигдэхүүнээр тодорхойлдог байжээ.

Түүхч Б.Балжинням “Монголчуудын бүрэн түүхийн товчоон (3 дэвтэр, 2005 он)” бүтээлдээ 1159-2004 онуудыг хамарсан 845 жилийн хугацаан дахь Монгол нутагт тохиолдсон ган, зуд, цасан болон шороон шуурга, өвчин тахал, газар хөдлөл, үер усны аюул, элдэв шавьж хорхойн тархалт, хэт хүйтрэлт, нарны идэвхжилтийн өндөр, нам, нарны хиртэлт болсон зэрэг онцгой үзэгдэлүүдийг 282 жилийг хамруулсан цаг тооллын дарааллаар түүвэрлэн гаргажээ. Эдгээр цагийн гачаалтай байсан 282 жилийн дотор дорно дахины цагийн тооллоор нь авч үзэхэд, барс, бич жил тус бүр 27, луу жил 25, туулай жил 26, үүний дотор хөхөд 35, хөхөгчинд 33, шард 29, шарагчинд 24, улаанд 25, улаагчинд 24, цагаанд 32, цагаагчид 28 удаа гэх мэтээр ган, зуд зэрэг гамшиг илүүтэй тохиолдсон жилүүдийг тодорхой заажээ⁶³.

Тэрээр НТӨ 72-71, 68 онуудад ихэнх нутгийг хамарсан их цас орж Хүннү гүрний хүн амын гуравны нэг нь мөхөж, мал их хорогдсон байсныг, мөн НТӨ 50, 49, 48, 47 онуудад 5 жил дараалан ган, зуд болсныг, түүний дотор НТӨ 48 онд ган болж,

⁶³ Б.Балжинням. Монголчуудын бүрэн түүхийн товчоон. УБ., 2004. Тал 320.

царцаа их дэлгэрч, өвчин тахал гарсанаас Хүннүчүүдийн 20 жилийн дайнд алагдсанаас их хүн үхсэн тухай тэмдэглэжээ.

Дээрх судлаачийнхаар XIY жарны хулгана (1864), XY жарны усан морин жил (1882)-д аюултай зуд болсон тухай малчин ардын дотор ам дамжсаар ирсэнтэй яг тохирч байгаа аж.

Монголын нүүдэлчид адгуусан амьтан, жигүүртэн мэрэгчдийн амьдралд гарч байдаг өөрчлөлт, ургамал, нар, сар, салхины байдал зэргийг байнга ажиглан сар, улирал, жилийн цаг агаарын байдлыг урьдчилан таамаглаж тодорхойлох талаар ихээхэн мэдлэг, баялаг туршлага хуримтлуулсан байна.

Сэцэн хан аймгийн Засаг ноён Тогтохтөр XIX зууны дундуур бичсэн бүтээлдээ, “Ер зуд болох шинж нь халуун намраас хүйтэн бороо, цас элбэг, салхи зүүнтээ болно. Өвөл цас дараа дараа их унаж, огторгуй тулалдан олон солонго наран мэт гаран анх цас орсон тэр газарт өн болох нь элбэг тул түүнийг ажигла” гэж бичжээ. 1839 онд орчуулж, барлуулсан цаг агаарын байдлыг жишин мэдэх тухай тэмдэглэл “Хан хуурцаг” хэмээх бичигт ган, зудын тухай тодорхой бичжээ. Үүнд:

- Өглөө үдэш баруун өмнө харлавал (үүлшвэл) үдийн урд хуртай, орой нар шингэх зүг гийвэл маргааш магад гийх, эрээн хар үүл гарвал улам чилрэх, орой хойт зүгт гийвэл маргааш магад гийх, сиймхий үүл нүүвэл өнө гийх, эрээн усан үүл ургавал салхин хур цаг болно.
- Дорноос салхилж хойд зүгт хандан явбал даруй магад хур орно. Туулай цагт баруун өмнө үүлээр бахарч гарахул могой цагт хур орном.
- Баруун уул үүлээр бүрхвэл эрт салхин хур болно. Наран гарч үүлэнд учирваас хургүй атал бас даруй бүрхэнэ. Салхи дагаж хурдан хааваас хур салхин цагт зогсоно. Үүнийг салхи сөрвөөс хур салхи даруй ирдэг.
- Хар үүлэнд халхан нар шингэсээр одвоос хур ахин их болном. Уулын бэлд тэр буувал шөнө дөл хур орно.
- Баруунаас үүл ургавал хур бөгөөд салхин шамдана. Зүүн хойноос үүл гарвал догшин хур орох, шөнө үүл хойш нүүвэл яршиг төвөг болдог ажгуу. Үүрмэг үүл гарвал салхин хур элбэг ирнэ хэмээн дурджээ.

Энэ мэтээр “Салхийг шинжих нь”, “Арван сарын улирал шилжих нь”, “Дөрвөн цагийн улирлыг шинжих нь” гэх мэт хэсгүүдэд олон шинжийг заасан байна /Д.Мижиддорж. 2002/

Монгол орны Дорнод хэсгийн Түшээт хан, Сэцэнхан аймгийн 43 засаг хошуу, 28 харуул, Дарьгангын нутаг буюу Эрэнгийн голын сав, Хангайн нурууны Дорнод хэсэг, Гурван сайхнаас зүүн тийших нутагт буюу одоогийн Булган, Сэлэнгэ, Төв, Дундговь, Хэнтий, Дорноговь, Дорнод, Сүхбаатар аймаг бүхэлдээ, Өмнөговийн ихэнх хэсэг, Архангай, Өвөрхангайн нутаг, нийт 159 сумын нутгийг хамруулан 1740-1939 он буюу 200 жилийн ган, зудын байдлыг Монголын түүхийн баримт бичгээс түүвэрлэн авч ган, зудын каталоги болонгазарзүйн давтагдлын график тооцоо хийх зэрэг ажлыг Р.Мижиддорж, А.Намхай, Д.Энхбат нар /1998/ хийсэн байна.

Дээрх судлаачдын судалгааны дүнгээс харахад Монголын зүүн талын аймаг, сумдын нутагт дээрх 200 жилийн 72-д нь ган, 110-д нь зуд болж аль нэг нутгийг хамарсан ган ойролцоогоор 3 жилд 1 удаа, зуд 2 жилд 1 удаа тохиолдон, 1820-1920 онд ган, зудын тоо нэмэгдсэн байдалтай, дээрх нутгийн 50 хувиас дээш хэсгийг хамарсан ган 1727, 1854, 1860, 1884, 1885, 1925 онуудад, зуд 1727, 1839, 1884, 1885, 1894, 1903 онуудад болсон байна. 1740-1940 оны хооронд тохиолдсон гангийн 15-20 хувь нь Өмнөговийн зүүн хагас, Дундговь аймгийн нутгаар, хамгийн цөөн нь Сэлэнгэ, Булган нутгаар (2-5 хувь), нийт 112 удаагийн зудын 15-20 хувь нь говь, хээрийн бүсийн зааг нутагт болсон байна.

1900-1911 оныг дуустал хур тунадасны хэмжээ, тохиолдлын тоог тодорхойлсон мэдээ тогтмол гаргаж, түүнийг саатуулсан гэм буруутанд хариуцлага хүлээлгэдэг болжээ.

Б.Жамбаажамцын тогтоосноор манай орны уулархаг хээрийн нутагт 15-20 см, хээрийн бүсэд 10-15 см, говьд 10 см зузаан цастай бол бог мал бэлчээх нөхцөлгүй болдог.

Гэвч мал бэлчих боломжгүй болох, өөрөөр хэлбэл “цагаан зуд” болох цасны зузааны хэмжээ тухайн өвлийн өвс бэлчээрийн байдалтай уялдаж өөр, өөр байдаг. Тал газар цасны зузаан 30 см хүрвэл хонь, ямаа, 40 см хүрвэл тэмээ, 60 см хүрвэл

адуу бэлчээрлэж чадахгүй болдог ба цас их хатуурсан цагт цасны зузаан бараг 2 дахин багасдаг ч мал бэлчээрлэх боломжгүй болдог.

Ардын хувьсгалаас хойш манай орны мал аж ахуйд асар их хохирол учруулсан томоохон зудаас дурдвал:

- 1922-1923 оны нохой-гахай жилийн,
- 1944-1945 оны мичин жилийн,
- 1954-1955 оны морин жилийн,
- 1956-1957 оны мичин жилийн,
- 1967-1968 оны хонь, мичин жилийг дамнасан,
- 1976-1977 оны луу, могой жилийг дамнасан,
- 1993 оны тахиа жилийн хаврын,
- 1996-1997 оны хулгана жилийн,
- 1999-2000 оны луу, морин жилийн,
- 2001-2002 оны морь, хонь жилийн,
- 2009 2010 оны үхэр, барс жилийн зудыг онцлон тэмдэглэж болно⁶⁴.

Хамгийн хүнд зарим нэг зудын хохирлыг тодруулбал XX зууны 1921-2010 онд 38 удаа их, бага хэмжээний зуд болсны дотор хамарсан нутаг, орсон цасны хэмжээ, цасны нягтрал, хүйтний эрчээр хамгийн хүчтэй зуд нь: дээр дурдсан 1944-1945 оны луу жилийн зуд бөгөөд хамгийн хүнд нь 1976-1977 оны, дараа нь 1967-1968 оны зуд орно. Мөн 2000-2003 оны дараалсан, бас 2010 оны үхэр-барс жилийн зудыг нэрлэж болно.

1923 оны гахай жилд том зуд болж улсын нийт малын 12 хувь үхсэн гэсэн баримжаа тооцоо гаргасны дотор, Хантайшир уулын аймгийн Цэцэн ван Жалцангомбоцэдэн, Цогтой Дамдиннавшаа нарын хоёр хошууны ард малаа дуусгаж, елбөрөн үхэхэд хүрчээ. Ийм байдал бусад зарим аймаг, хошуудад ч тохиолджээ. Үүнээс хойш 1927, 1929, 1931, 1932 онд мал сүргийн 10 орчим хувь үрэгдсэн зуд болсон байна. Үүний дотор Дорнод Монголыг хамарсан зуднаар Егүзэр, Дарьганга зэрэг хошуунд малын 50-70 хувь нь хорогдсон мэдээ гарчээ.

⁶⁴Т.Намжим. Монголын мал аж ахуй, эдийн засаг. УБ., 2000 тал 140.

1944-1945 оны мичин жилийн зуд Дэлхийн II дайны сүүлчийн жил буюу дайны нэн хүнд хэцүү үед болж, манай орны эдийн засгийн цорын ганц эх сурвалж болсон мал аж ахуйг урьдах бүх зудтай харьцуулахын аргагүй сүйтгэж хохироосон аж. Энэ удаагийн зуд нь жирийн нэг тохиолддог цас ихтэй зуд биш, бусад олон хатуу нөхцлүүд бүрдсэн зуд байлаа.

Зун нь ихээхэн гандсанаас мал тарга хүч бүрэн аваагүйн дээр мөн оны 11-р сараас эхлэн урьд үзэгдээгүй ихээр хүйтэрч, үе үе цасан шуурга болж, мал, хүний хамуу тархсанаас уг зуд туйлын хүнд болж өнгөрчээ. Тэр үед малчид зөвхөн ардын хувийн аж ахуйтай байсан бөгөөд малын өвс тэжээл, хашаа байрны хангамж бараг үгүй, малчин ард өмсөх дулаан хувцас, идэх гурил будаа, цай зэрэг өргөн хэрэгцээний бараа, эм хэрэглэлээр гачигдсан тийм үе байв.

Энэ зуднаар оны эхний малын 33 хувь буюу 8,1 сая том мал, төл хорогдох, хээл хаях, сувайрах зэрэг шалтгаанаар 9,2 сая мал хорогдож, энэ хохирлыг 11 жилийн дараа л нөхсөн байна.

1967-1968 оны хонь, мичин жилийн зуд нь бүх нутгийн 80 хувийг хамарч, 165 хоног үргэлжлэн 60-82 өдөр ямар нэг хэмжээгээр цас орон цасны зузаан хэвийн хэмжээнээс 25-30 см-ээр давж, цасны нягтрал 0,33-0,35 см³, хүйтний эрч 45-50С⁰-д хүрсэн байна. Хэдийгээр улс аймгаас 5,6 сая тонн өвс тэжээл гаргаж зарцуулсан боловч үүнээс үүдэн 1,7 сая том мал, бусад төрлийн шалтгаанаар 4,2 сая мал хорогджээ.

1976-1977 оны луу, могой жилийг дамнасан зуд 17 аймаг, нутгийн 60 хувийг хамарч, малын 6,1 хувь хорогджээ. Энэ зудын онцлог нь зун нь гандаж, цас эрт орон дутуу хайлснаас “мөсөн зуд” болсон юм. Тэр үед өвс тэжээл, машин техникийн хангамж сайжирч байсан ч хүчтэй зудын өмнө хүчин мөхөсдөж, ихээхэн хохирол үзсэн билээ. Тэр өвөл Завханы Тосонцэнгэлд -52С⁰, Улаангомд -51С⁰, Мөрөнд -49С⁰ хүрч хүйтэрчээ. Энэ зуд хамарсан нутгуудад 59-85 өдөр ямар нэг хэмжээний цас орж, цасны зузаан хэвийн хэмжээнээс 25-20 см-ээр давж, нягтрал нь 36-40 см³ болж, эрс хүйтрэн, энэ байдал 180 хоног үргэлжилсэн байна. Тухайн үед ХАА-н нэгдэл, сангийн аж ахуй их хүч, хөрөнгө зарцуулснаас гадна зөвхөн улс, аймгаас 7,3 сая тонн өвс

тэжээл зарцуулсан ч том мал 1,9 сая, төл хорогдох, хээл хаях зэрэг шалтгаанаар 4,3 сая мал хорогдсон байна. Энэ хохирлыг 4 жилийн хугацаанд нөхсөн байна.

Цаг уурч эрдэмтэн Л.Нацагдорж 1976-1977 оны зудыг 1940-1950-иад оны үеийнхтэй харьцуулахад мал хоргодохооргүй нөхцөлд мал олноороо хорогдсон нь малын байгаль орчиныг тэсвэрлэх чадвар доройтсон, бэлчээрийн талхдал, цөлжилт ихэсч, бэлчээрийн ургац хомсдсон, дээр нь мал маллагааны уламжлалт арга ажиллагаа алдагдаж байгаатай холбоотой гэжээ. Зун, өвлийн температурын зөрөө их байх тусам малын хорогдол төдий чинээ их гардаг нь батлагдсан байна.

Зудыг зөвхөн цаг агаарын нөхцөл талаас бус, нийгэм, эдийн засгийн хүчин зүйлийг нэмж тооцох нь зүйтэй гэж С.Сангидансранжав, З.Батжаргал нарын судлаачид тэмдэглэсэн байдаг. 2000, 2001, 2002 онд ган, зуд болж, 2001 оны 11-р сарын сүүлчээр цас орж, нийт нутгийн 70 орчим хувьд цасан бүрхүүл тогтож, 12-р сарын эхээр ихэнх нутагт хүйтэрч, цас олон жилийн дундажаас их орж, Баян-Өлгий, Увс, Завхан аймгийн ихэнх, Ховд, Хөвсгөл, Говь-Алтай, Баянхонгор, Архангай, Өвөрхангай аймгуудын зарим сумдын нутгаар цасны зузаан 27-30 см, хунгарласан газраа 40-130 см, нягт нь 0,16-0,34 г/см³ –т хүрч нийт нутагт мал өвөлжилт хүндэрч эхэлжээ.

Гэтэл ихэнх нутагт 2002 оны 1-р сарын эхээр сүүлийн 20 жилд тохиолдоогүй дулааралт ажиглагдаж, агаарын температур олон жилийн дундажаас 5-9C⁰ –ээр дулаарч, өдөр, шөнийн агаарын температурын хэлбэлзэл ихэсч, цас нягтран өнгөн хэсэг нь хайлмагтан мөстөж, “Цагаан зуд” маань “Мөсөн зуд”-д шилжсэн байна.

2000, 2001, 2002 онуудад жил дараалан нийт нутгийн хамгийн ойрхон давтамжтай, хамгийн урт удаан үргэлжилсэн ган, зуд байсан бөгөөд хүчтэй шороон болон цасан шуурга, салхи, үер, аадар бороо, гэнэтийн цочир хүйтрэл /45C⁰-50C⁰/ зэрэг байгалийн онц аюултай үзэгдэл олонтоо тохиож байлаа. Зөвхөн 2002 онд л гэхэд ус, цаг уурын аюултай үзэгдэл 55 удаа тохиолдсоны 19 нь гамшигийн хэмжээнд хүрч, 60 хүний амь нас эрсдэж, мал аж ахуй, газар тариаланд 2001-2002 оны зуд, 2002 он гантай байсны улмаас тэр үеийн ханшаар 150,5 тэрбум төгрөгний хохирол учирчээ.

2009-2010 оны үхэр, бар жилийн зуд нь зундаа олон аймаг, сум гантай, намар 10-р сарын дундаас эхлэн нутгийн 70 хувийг хамарсан олон жилийн дундажаас их цас орж, хүчтэй цасан шуурга байнга тавьж, 11-р сараас эрс хүйтрэн бэлчээрийн цас хатуурч, хунгарлан зузаарч, бас их хүйтэрсэнээс олон газар мал бэлчээрээс өвс олж идэх бололцоогүй болсон билээ.

Дээрх онцгой хүнд байдал хавар хүртэл үргэлжилж, зам даваа хаагдан сум, аймаг, улмаар улсын өвс тэжээлийн нөөц бүрэн дуусч, малчин түмэн ер нь хөдөөгийн хүн амыг үнэнхүү туйлдуулсан зуд байв. Тухайн жилийн зуд нь: “ган+цас+хүйтэн+цасан шуурга+бэлтгэл, зохион байгуулалт муу” бүгд хосолсон зуд байлаа. Энэ зуд нь урьд жилүүдэд тохиолдож байснаас “байнга шахам тавьж байсан цасан шуургаараа, цасны зузаанаараа, хүчтэй хүйтнээрээ” ихээхэн өвөрмөц, онц аюултай байв. Энэ зуднаар нийт малын 23,4 хувь буюу 10, 3 сая мал хорогдож, олон арван тэрбум төгрөгийн хохирол гарч, 8100 малчин өрх огт малгүй үлдэж, 32756 малчин малынхаа 50 хувиас илүү хорогдуулжээ. Сүүлийн 62 жилийн судалгаанаас үзэхэд, жилийн дундаж агаарын температур $1,56^{\circ}\text{C}$ хэм, өвлийн улиралд $3,6^{\circ}\text{C}$ хэм, хавар, намарт $1,4-1,5^{\circ}\text{C}$ хэм, зун $0,3^{\circ}\text{C}$ хэмээр тус тус дулаарсан байна.

Дээр дурдсанаар сүүлийн үед жил дараалан ган, зуд болох давтамж ойртож, гамшигт үзэгдлийн тоо, хохирлын хэмжээ нэмэгдэх болсоноор байгаль, цаг уурын нөлөөн дор байдаг мал аж ахуй, газар тариалан төдийгүй ан амьтан, араатан жигүүртэн, ой мод, гол ус, булаг шанд, ургамлын аймгийн биологийн төрөл зүйл устах аюулд өртөж, бэлчээр хомсдож, цөлжилт нүүрлэх болов.

“Нээлттэй нийгэм” форумас манай орны байгаль, цаг уурын өөр, өөр бүсийн малчидын дунд байгаль, цаг уурын өөрчөлтийн талаар явуулсан судалгаанаас үзэхэд, судалгаанд хамрагдсан, малчидын 84,3 хувь нь ургамлын бүтээгдэхүүн муудсан, 86,8 хувь нь бэлчээрийн ургац муудаж, талхлагдсан, 72,3-77, 6 хувь нь цаг агаар муудсан, 67 хувь нь гол горхи, булаг шанд ширгэж байна гэжээ.

Зөвхөн 2000-2003 онд тохиолдсон ган, зудын улмаас тухайн үеийн зах зээлийн ханшаар даруй 300 тэрбум төгрөгийн хохирол учирчээ.

Түүнчлэн хэвийн жилд гарсан төлийн 3,8-6,4 хувь нь хорогддог бол ган, зудтай жилүүдэд гарсан төлийн 17-23 хувь нь хорогдож байсан баримт бий. Энэ жилүүдэд 30 мянган өрх малгүй болж, олон ч өрх малынхаа дийлэнхийг хорогдуулснаас тэдгээр гэр бүлүүдийн орлого тун багасч, төв суурин бараадан ажилгүйчүүдийн эгнээг өргөтгөсөн билээ.

Энэ бүхнээс үзэхэд Монгол орны мал сүрэг чанарын хувьд 1990 оныхоос өсөөгүй нь дээрх олон удаагийн ган, зуд дээр нь бэлчээр нутагт хамгийн халтай ямаа их өсөж, нутгийн таван хошуу малын хот айл, аймаг, улсад барьж зохицуулдаг сүргийн зохистой бүтэц алдагдсантай холбоотой юм.

2.2.3 Зудтай үед мал ямар шалтгаанаар хоргоддог вэ?

“Намаржин наргивал, өвөлжин зовно /Ахмад малчны сургаал/

Дээр дурдсан олон арван удаагийн ган, зуднаар хорогдсон малын шалтгааныг судалсан дүнгээс үзэхэд дараах нийтлэг шалтгаанаар мал хорогдсоор иржээ. Үүнд:

1. Зун, намар нь гантай байсан, бас хэвийн байсан ч тухайн малчны малдаа тарга хүчмуу авахуулсан, зузаан цас орж, бэлчээргүй болж, өвс тэжээлийн дутагдалд орсоноос мал олноороо турж үхдэг. Хэт хүйтрэлт, бэлчээрийн хомсдол зэргээс болж мал алдсан дулаанаа нөхөж чадахгүй болмогц зун, намарт бага хуримтлуулсан өөх, тосоо задлан дулааны алдагдалыг нөхдөг. Ер нь тураалыг гурван үе шат болгон ангилна.

Нэгдүгээр үе. Амьдын жингийнхээ 15-20 хувийг алдах үе юм. Энэ үед мал амархан ядарч, шээмхий болох, ховдоглох, гэдэсний хөдөлгөөн суларч, баах нь цөөрч, зовхины салст бүрхэвч шар туяатай, цайвар өнгөтэй болж, биеийн байдал нь доройтож, өнгө зүсээ алддаг. Энэ үед сайн тордвол засал авдаг.

Хоёрдугаар үе. Жингийнхээ 20-30 хувийг алдахаас эхэлнэ. Арьс нь хуурайшинхолцруутаж, салст бүрхүүл хөхөвтөр туяатай цайвар болж, явахдаа гуйвах, биеийн халуун буурч, амьсгал цөөрч, зүрхний цохилт түргэснэ. Энэ үед үнэнхүү уйгагүй ажиллаж, эмчилж сувилж, тэжээвэл засрал авдаг.

Гуравдугаар үе. Жингийнхээ 30-аас дээш хувийг алдахад эхэлнэ. Халуун нь буурч, сүүлдээ босож чадахгүй өргүүлнэ. Тэжээл усанд дурамжхан болж, элэг, зүрх зэрэг зэрэг гол эрхтэнд гүнзгий хувиралт гарснаас шалтгаалан үхдэг. Энэ үед тэжээл авч сэхдэггүй, малын биед эргэж засаршгүй гүнзгий өөрчлөлт орсон байдаг. Дундаас доош тарга хүчтэй мал олноороо хээл хаяна, жилбэгүй төллөнө, гарсан төлийн амьдрах чадвар сул байдгаас амархан осгож, өлдөж үхдэг. Энэ үед ямарч засрал авдаггүй.

2. Элдэв өвчтэй мал зуданд эхний ээлжинд үхнэ.
3. Нэг настай мал, тором, сарваа, бяруу, төлөг, борлон мөн тухайн өвөл гарсан хэнз төл, түүний эх хамгийн түрүүнд хорогддог. Энэ нь биеийн хөгжил гүйцээгүй, анх удаа хахир өвөл, хавартай тулгарч байгаагаас цасан дорх бэлчээр ашиглах, хүйтнийг тэсвэрлэх чадвар муу байдгаас амархан осгож, турж, өлдөж үхдэг.
4. Эцэг мал ялангуяа хуц, ухна зуданд илүү нэрвэгддэг. Хээлтүүлэгч малыг намрын хайлган цагт уяж, сойхгүйгээр нийлүүлэгт оруулснаас тарга хүчээ амархан алдаж эхний хүйтэн цас зуданд илүүтэй нэрвэгддэг. “Зэм ирвэл ах, захад, зуд ирвэл хуц, ухнад” гэдэг ардын мэргэн үг байдаг. 2000-2001 оны өвөл Баянхонгор аймгийн хэмжээнд оны эхэнд байсан хуц, ухны 81,7 хувь нь буюу 9566 нь хорогдсоны дотор Бөмбөгөр сумын хэмжээнд дөрвөн хуц, гурван ухна, Баацагаан суманд найман хуц, таван ухна амьд үлдсэн нь зудын дараах намар бог малын нийлүүлгийн ажлыг явуулахад ихээхэн бэрхшээл учирч байжээ. Зарим хүн хэцүү жилд эх малыг эрт төллүүлэх, эсвэл нийлүүлэгт оруулалгүйгээр сувайгаар нь өвөлжүүлж, хаваржуулах нь онд ороход тустай хэмээн үздэг. Энэ нь харин ч буруу номлол юм. Яагаад гэвэл эх амьтан өөрийгөө болон хээлээ (үр төлөө) хамгаалах биологийн төрөлх зохилдлогоороо хээлтэй мал нь төллөсөн малыг бодоход цагийн хатууг даван туулах чадвараар илүү, нөгөө талаар малчин хүн эх, төл гэсэн хоёр малд хүч, анхаарлаа хандуулах шаардлага гардаггүйгээрээ цас, зуданд эх мал хээлээ тээж байх нь ач холбогдолтой.

Энэ байдлыг ч харгалзан ахмад туршлагатай малчид мал нийлүүлэг, төллөх хугацааг нарийн тооцон төлөвлөж хэрэгжүүлдэг.

Малыг хэт эрт төллүүлбэл хавартаа эхийн сүү татарч, төл нь сэнсрэх, эсвэл бүр орой төллүүлэх нь гарсан төл давжаарч, ирэх өвөл, хавар олноороо хорогдох шалтгаан болдог.

Зузаан цас, тэсгим хүйтэн, цасан шуурганаар мал хэд хоногоор бэлчээрт гарах боломжгүй болсоноос өл, хоолгүйдэж, өлбөрч үхэх нь олон. Өлбөрч үхсэн мал туранхай байх боловч турж үхсэн малыг бодвол хар махаа бараагүй, зарим үед өөхөн таргатай байх тохиолдол ч байдаг. Ходоод, гэдсэнд нь баас, сэвсний үлдэгдэл бараг үгүй болсон байдаг.

Зудтай, цас багатай, огт цасгүй жил ч гэнэт их хүйтэрч удаан үргэлжилбэл мал олноороо осгож үхдэг. Малыг бэлчээрт хонуулах, хашаа саравч нь дулаалга муутай, хот хэвтэр нь норж, хөлдсөн тохиолдолд нэг настай, хөгшин, туранхай, өвчин эмгэгтэй мал хамгийн түрүүнд бээрч, осгодог.

Залхуу, муу ажиллагаатай, эсвэл мал маллах дадлага туршлагагүй, хариуцлагагүй малчны мал илүү олноороо хорогддог. Гэтэл ойр хавийн нэг ижил бэлчээр, устай малчид цагийн хатууд ч мал нь намрынхаараа байдаг, бага зэрэг муудсан ч арчилгаа, маллагааны хүчинд онд бүрэн ордог.

Хунгарлаж хатуурсан их цасанд малын хөл, шилбэ, өвчүү, хошуу, шанааны үс халцрах, туруу нь цоорох, ханзрах зэргээр гэмтэхэд түүнийг арчилж тордохгүйгээр бэлчээрт явуулснаас улам хүндэрч, мал явж чадахгүй болтлоо ядарч доройтдог. Зарим малчин хонь, ямаагаа байнга дагаж хариулдаг атлаа үхэр, адуу, тэмээг бэлчээрт нь найдан зөнд нь орхисноос шуурганд уруудах, гол, нуурын усанд унах, гуу жалганд цасанд дарагдах, осгох, өлбөрөх зэргээр хорогддог. Дулаалга, хэвтэр муутай хашаа, хороонд даарсан мал шахцалдан нэг нэгэндээбөөнөөр дарагдаж үхэх, хүчит тэжээлийг хуурайгаар хэт их өгсний дараа усалснаас гэдэс нь дүүрч, чихэлдэж түгжрэх, хашаа хорооны байршлыг буруу сонгосон, цасны хаалт, халх бариагүй зэргээс мал хашаатайгаа цасанд дарагдах зэргийг тухайн малчны малч арга шшлагаатай холбож үзэхээс өөр аргагүй.

Бэлчээрийн монгол мал бол малчдын олон мянган жилийн турш хэрэглэж ирсэн ардын селекци, шаргуу ажиллагааны дүнд цаг агаарын эрс тэс, хүнд бэрх

нөхцлийг даван туулах, дасан зохицох талаар биологийн асар их чадавхтай мал юм⁶⁵.

Энэхүү биологийн чадавхийг бүрэн дүүрэн ашиглах, хадгалах, нэмэгдүүлэхэд хүний үйл ажиллагаа чухал. Энэ нь бэлчээрийн мал аж ахуй бол хүний ухамсартай, чиглэсэнзорилготой, уйгагүй үйл ажиллагааны дүнд явагддаг нийгэм, биологийн нөхөн үйлдвэрлэл мөн гэсэн үг. Энэ талаас нь авч үзвэл, зуданд хорогдсон малын ихэнх нь зун, намарт олигтойтарга хүч авч чадаагүй, төл байхдаа эхийн уурагт бүрэн цадаагүй, хур тарга авч, тосон чөмөг суугаагүй, элдэв өвчин эмгэг, гадаад, дотоод шимэгч хорхойтой, дунд, дундаас доош тарга хүчтэй байдаг.

2.2.4 Цасан шуурга

“Баян хүн шуурганд, Баатар хүн суманд /Ардын сургаал/

Малчдын олонхи нь хаваржаанаас гарч, ил задгай газарт буусан үед буюу 1964 оны зургаадугаар сарын 3-4-нд Дундговь аймгийн бүх нутгийг хамарсан гэнэтийн цасан шуурга болж, гурав хоногийн дотор 60,000 мал хорогдож долоон малчин амь насаа алдсан. 1993 оны хавар Архангай аймагт 24-28 м/сек-ийн хурдтай цасан шуурга тавьж, олон мянган том мал хорогдож, хэд хэдэн хүний амь нас сүйдсэний дотор гэр бүлийн хоёр залуу малынхаа хойноос явж амиа алдсан ба гэрт нь үлдсэн хүүхэд мөн үрэгдсэн эмгэнэлт явдал болж байв.

Гэнэтийн цасан шуурга мал сүрэгт янз бүрийн хор хохирол учруулдаг. Тамир тэнхээ суугаагүй мал олноороо уруудаж, нэг хэсэг нь сүргээс хоцорч, цасанд дарагдаж үхэх, гэссэн нуур, цөөрөм, голд болон шаварт унах, хадан хясаа руу нисэх, гуу жалга, хаа нэгтээ нөмөрлөж байсан бод, бог мал тэр чигээрээ хунгарт даруулах зэргээр хорогддог.

Дээрх аймгуудад тэр үед тэмээ, үхэр олноороо цасанд дарагдаж, түүнээсээ гарч чадахгүй, халуун амьсгалаараа цоолсон нүхнүүдээр нь мэдэгдэж байжээ. Нэгэн цасан шуурганаар Говийн Улаан нууранд 2000-аад хонь, Архангайн Цайдамын нууранд 1000 гаруй мал орж, үхсэн тохиолдол байдаг. Өвөг дээдэс “Хаврын тэнгэр

⁶⁵Т.Намжим. Монголын мал аж ахуй, эдийн засаг. УБ., 2000 тал 144.

хартай” гэдэг. Хаврын улиралд цасан шуурганаас гадна их цас, хунгар дарж, аюул учруулдаг. 1993 оны хавар Баянхонгор, Завхан, Говь-Алтай аймагт өвлийн цас бараг хөлдөөгүй байхад Алтайн нурууны өврөөр голлож сүүлийн 60 гаруй жилд тохиолдоогүй асар их цас орсон билээ. Үүнийг нутгийн өтгөс, буурлууд 1927 оны мичин жилийнхээс хойш 65 жилийн хугацаанд ороогүй их цас унаж, зуд боллоо гэж ярьцгааж байв.

Баянхонгор аймгийн хэд хэдэн суманд гэр жилийн гуравдугаар сарын дөрвөнд бороо орж, бэлчээрийн цас мөстөөд байтал гуравдугаар сарын 14-өөс эхлэн нуггийн 70 орчим хувь буюу 14 суманд эхний удаа долоо хоног цас орсноос хойш дахин хэд хэдэн удаа цас орж даржээ.

Баянбулаг, Гурванбулаг, Хүрээмарал, Бууцагаан, Баян-Өндөр зэрэг суманд 50-120 см зузаан цас орж, мал бэлчээрлэх ямар ч аргагүй болсноос 1650 өрхийн 720 мянган мал хотноос гаралгүй, 13-23 хоногт дээрх хот айлуудын малын ихэнх нь хорогдож, олон айлын хот харлаж, огт малгүй үлджээ.

Баян-Өндөр сумын нэг хот айлаас 500 метрийн зайд буусан нисдэг тэрэгнээс сэтгүүлч, шүхэрчин хэдэн хүн цасан дээгүүр хоёр цаг мөлхөн байж арай ядан уг хот айлд хүрсэн байдаг. Сумын төвөөс нэг км зайд байсан айлын 600-гаад хониноос 500, гарсан төл бүгд үхжээ.

Баянбулаг суманд нэг өрх айл малаа бэлчээрт гаргаж чадахгүй 13 дахь хоног дээрээ 500 төл малынхаа 400-г нь алдсан байв. Тэр орчимд 1-1,5 м зузаан цасанд мал бүү хэл, ямар ч амьтны мөр үзэгдэхгүй, яг л “цасан далай” мэт байсан гэж одоо болтол нүдээр үзсэн хүмүүс сэтгэл шимшрэн ярьцгаадаг. Баянбулаг, Бууцагаан сумдад их цасны уршгаар хүний амь нас эрсдэж, аймгийн дүнгээр 180 хот айлтай дөрөвдүгээр сарын 10-ныг хүртэл цасанд боогдсоноос харилцаа холбоо тасарч байжээ.

Завхан аймагт дээрх цасан шуурган зудын уршгаар тавдугаар сарын 20-ыг хүртэл хэдхэн хоногт 200 мянган мал хорогдож, 60 хот айл огт малгүй, 500 гаруй малчин өрх малынхаа 50 гаруй хувийг хорогдуулжээ.

Говь-Алтай аймгийн гурван суманд энэ үеэр зуд гэхээс илүүтэй байгалийн гамшиг болсон байна. Тус аймгийн гурван суманд цас 18 хоног үргэлжлэн орсон бөгөөд дөрөвдүгээр сарын сүүлчээр гэхэд л 104 өрх айл огт малгүй болж, 1300 гаруй малчин өрх малынхаа 70-аас дээш хувийг хорогдуулж, тавдугаар сарын 20-н гэхэд 840 мянган мал хорогдуулж, цас нурах, шар усны үер буух зэргээр зудын муу үр дагавар удтал үргэлжилжээ. Энэ цасан зудны үед бод, бог мал цасанд дарагдаж үхэх, идэх өвс, тэжээлгүйгээс юу тааралдсаныг идэх буюу гэрийн бүрээс, хаяа, үхсэн малын мах, уналгын морины сүүлний хялгасыг ясан сүүлний үзүүрт нь тултал зулгаан идэж бөөнтөж, өлбөрч, усаар дутагдаж өдий төдий мал хорогдсон байдаг.

Малчид түлшгүй болмогц сандал ширээ, ор, авдар савнаасаа эхлэн гэрийн унь зэргээ түлж дуусаад, гал алдаж, аймаг, сумын төвөөс малын өвс, тэжээл, түлш, хувцас, хоол хүнсний зүйл ачсан машин, унаа хөсөг замдаа давааны цасанд сууж байжээ.

Энэ мэтээр хаврын улиралд, ялангуяа говь, тал хээрийн бүсийн аймгуудад цасан шуурга болж, (олон удаа) мал аж ахуйд үлэмж хэмжээний хохирол учруулаад зогсоогүй, төдийгүй олон хүний амь нас сүйдсэн тохиолдол олон удаа болсон билээ.

Ган, зуд хэдэн жилийн зайтай болдог бол цасан ба шороон шуурга жилд хэдэн ч удаа болох нь бий. Өвлийн турш ядарч доройтсон мал өвлийн сүүл, хаврын эхээр гардаг хүчтэй салхи шуурганд олноороо хорогддог. Жишээ нь, 1962 оноос хойш зөвхөн нэг удаад 50,000- 800000 мал хорогдуулсан 2-5 хоног үргэлжилсэн хүчтэй салхи шуурга 15 удаа болсон байна. Эдгээр шуурга нь ихэвчлэн хавар гурваас тавдугаар сард болсон бөгөөд хамгийн нх хорогдол гарсан нь 1980 оны дөрөвдүгээр сарын 17-21-нд 800.000 мал хорогдож, 43 хүний амь эрсэдсэн байна.

Үүнээс үзэхэд малчин айл өрх бүр хоол хүнс, аргал, түлш хангалттай бэлтгэж, нэг бог малыг өдөрт дор хаяж 2-3 кг-аар 20 хоног тэжээхэд хүрэлцэх өвс, тэжээлийн аюулгүйн нөөцтэй байхыг байгаль шаарддаг. “Баатар хүн нэг суманд, баян хүн нэг шуурганд” гэдгийг мартаж болохгүй.

2.2.5 Ган, зудны шалтгааны орчин үеийн ойлголт буюу уур амьсгалын өөрчлөлт

“Газар хөдлөн хилээнэх

Галт аянга ниргэх

Галав юүлтэл үерлэх

Энэ бүгд хүний гэмт үйлийн гэсгээл буюу /Чингис хаан-Алтан товч/

Байгаль, нийгмийн өөрчлөлт, хөгжлийн түүхээс үзвэл, хэсэг хугацаанд өнтэй, тайван жилүүд үргэлжилж байгаад зарим үед нь газар хөдлөлт, далайн хар шуурга болох, галт уул дэлбэрэх, цөлжих, ган, зуд, хүчтэй аадар бороо, үер, салхи, шуурга, ой хээрийн түймэр, аянга, хүн, малын өвчин, тахал зэрэг гэнэтийн аюул, байгалийн гамшиг тохиолдсоор иржээ.

Манай гариг дээрх амьдрал бол зөвхөн өөрийнх нь хүчин зүйлээс гадна нар, түүнийг тойрсон орчлонгийн од гаригсын нөлөөнд байдгийг шинжлэх ухаан нэгэнт тогтоосон.

Сүүлийн 20 жилд дэлхийн уур амьсгалын өөрчлөлт нь шинжлэх ухааны таамаглал бус, бодит үнэн болж хувирлаа. Энэхүү өөрчлөлтийг хязгаарлаж, түүнд дасан зохицож амьдарч чадах эсэхээс дэлхийн соёл иргэншлийн хувь заяа хамаарах болчихоод байна. Дэлхийн дундаж агаарын температур сүүлийн 100 жилд 0.74°C -ээр дулаарсан нь сүүлийн 1000 жилд тохиолдоогүй үзэгдэл аж. Судлаачид ингэж дулаарч байгаагийн үндсэн шалтгаан нь хүний үйл ажиллагааны улмаас нүүрс, газрын тос зэрэг малтмал түлшийг их хэмжээгээр шатааснаас агаарт үлэмж хэмжээний хүлэмжийн хий ялгарч, түүнээс озоны хомсдол үүсэж байгаа явдал гэж үзэж байна.

Нийт хүлэмжийн хийний 76,7 хувийг нүүрсхүчлийн хий (CO_2), 14,037 хувийг намгийн хий буюу метан (CH_4), 7,9 хувийг азотын дутуу исэл (N_2O), 1,1 хувийг фторт нүүрс устөрөгчийн хий (фтор, хлор болон бром) бүрдүүлж байна.

Хүлэмжийн хий нь нарнаас ирэх богино долгионы цацрагийн туяаг бараг шингээлгүйгээр газар руу нэвтрүүлдэг атлаа дэлхийгээс цацарч байгаа дулааны урт долгионт цацралыг өөртөө их хэмжээгээр шингээн, газрын гадарга руу буцаан

цацруулж, газар орчимд ихээхэн нэмэлт дулаан үүсгэдэг байна. Өөрөөр хэлбэл, хүлэмжийн хий ихэссэнээр дэлхийн гадарга, агаар мандалд шингэсэн дулааны цацрагийг үл үзэгдэх хөшиг мэтээр хааснаас дэлхийн агаармандал, газрын гадарга нэмэлт байдлаар халахад хүрч, манай гаригийн байгаль орчин, амьд организм, хүн төрөлхтөний аж амьдралд аюул занал учруулж байна. Хүн төрөлхтөн нүүрс, газрын тос зэрэг малтмал түлш их шатааснаас хүлэмжийн хийн хэмжээ эрс нэмэгдэж, харин тэрхүү хүлэмжийн хийг шингээдэг ургамал ногоог сүйтгэж, ой модыг хядаж устган, бэлчээрийг талхалж, газрын хөрсийг (зүй бусаар) сэндийчиж хагалан, газраас дэгдэх хүлэмжийн хийг нэмэгдүүлснээс уур амьсгал өөрчлөгдөх шалтгаан болж байгаа аж.

Чухамдаа энэхүү үзэгдлийг **дэлхийн дулаарал** хэмээн нэрлэж байна. Дэлхийн дулаарал нь дэлхийн хуурай газар, далайн гадаргуу орчмын агаарын дундаж температур ихсэх үзэгдлийг хэлж буй.

1980-аад оноос хойш өнөө үеийн уур амьсгалын өөрчлөлтийн хурд эрчимтэй нэмэгдэж, дэлхийн олон улс оронд байгалийн элдэв гамшигт үзэгдлийн давтамж ойртжээ. Наад зах нь далайн усны түвшин нэмэгдэж, шүрэн арлууд усан дор орж, хойд туйлын мөс хайлж, хэмжээ нь ихээхэн багасчээ. Энэ хэвээр байвал 2030 он гэхэд хойд мөсөн далай мөсгүй болно гэж үздэг эрдэмтэд ч байна. Озоны давхарга цоорсны улмаас нарны хэт ягаан туяа газрын гадаргад шууд тусаж, энэ туяа нь хүн, мал, ургамал амьтанд олон өвчин үүсгэнэ гэж үздэг.

Дэлхийн уур амьсгалын өөрчлөлт, дулаарлын улмаас үүсэж буй үр дагавар нь хүн төрөлхтөнд тун хүндээр тусч байна. Үүнд:

1. Байгалийн аюулт үзэгдлүүдийн давтамж ойртож, далайн хар салхи, ган, зуд, үер, тахал хэлбэрийн төрөл бүрийн халдварт өвчин байнга шахам тохиолдох боллоо. Монгол улсад ч ялгаагүй үзэгдээгүй их халуун жил дараалан олонтоо давтагдах болов.
2. Далайн усны түвшин өнгөрсөн зуунд 15 см-ээр нэмэгдсэн бол XXI зуунд 50 см-т хүрэх төлөвтэй гэж үзэцгээж байна. Өндөр уулын мөнх цас, мөс, хойд, өмнөд туйлын хайлалт зэргээс болж далайн түвшин магадгүй метрт хүрч нэмэгдэж болох аж. Зарим газар үер, бороо, нөгөөд нь ган гачиг тохиолдож,

үүнээс болж хүнсний хомсдол бодитойгоор нүүрлэж буй нутаг, газар орон цөөнгүй байгаа билээ.

Монгол орны хувьд 1940-2015 оны хооронд жилийн дундаж агаарын температур +2,⁰С дулаарсан байна. Энэ нь дэлхийн дулаарлын дунджаас гурав дахин их гэсэн үг. Алтайн уулын дагуух нутаг, Алтайн чанад говь, Дарьгангын өндөрлөгөөс бусад бүх нутагт зуны хур тунадасны хэмжээ буурч, өвлийн тунадас бараг бүх нутгаар нэмэгджээ.

Дулаарлын нөлөөгөөр Алтай, Хөвсгөлийн уул, нуруунуудын мөнх цэвдэг, мөсөн голууд ширгэх үзэгдэл эрчимтэй явагдаж байна. Мөнх цэвдэг нь Монгол орны усны эргэлтийг зохицуулагч гол хүчин зүйл бөгөөд ой тайгын эко системийн оршин байх нөхцлийг бүрдүүлдэг. Хархираа, Түргэн, Цамбагарав, Таванбогд уулын мөстөлтийн талбай 30 хувиар багасчээ.

Манай оронд хаврын улирлын хур тунадасны хэмжээ 20 хувиар багасаж, цасан бүрхүүлийн эзлэх талбай болон тогтох хугацаа нь богиносж, малд идэмжтэй хиаг, хялгана, монгол өвс бүхий ургамлын зүйлийн тоо цөөрч, ургацын хэмжээ буурчээ. Ургамал ургаж эхлэх хугацаа 1-2 сараар хойшилсон нь мал ногоонд цадах, улмаар тарга хүч авахад сөргөөр нөлөөлж байна.

Мөн ойн талбай ихээхэн багасаж, олон зуун нуур цөөрөм, булаг шанд ширгэжээ. Энэ байдал ирэх 100 жилд хадгалагдана, дулааралт нэмэгдэнэ, өвлийн тунадас ихэснэ гэж эрдэмтэд үзэцгээж байна.

Бас ган, зуд болон нийтийг хамарсан өвчин тахал дэлгэрэх явдлыг нарны идэвхжлийн жилтэй холбон тайлбарладаг. Наран дээр тэсрэлт болж, хий гарч, толбоны тоо олшрох үзэгдэл ойролцоогоор 11-12 жил тутамд давтагдаж, дээд цэгтээ хүрээд уг үзэгдэл буурсаар дараагийн тэсрэлтэд хүрдэг байна. Үүнийг “Нарны идэвхжлийн цуврал” гэх ба энэ нь нарны аймгийн бүх гаригт нөлөөлдөг ажээ⁶⁶.

Манай оронд болсон 1899-1900 оны гахай жил, 1923 оны бар жил, 1944-1945 оны мичин жилийн их зуд нарны идэвхжил явагдахын яг өмнөх жилүүдэд болжээ.

⁶⁶Т.Намжим. Монголын мал аж ахуй, эдийн засаг. УБ., 2000 тал 144.

Ган, зуд, элдэв өвчин тахал зэрэг нь нарны идэвхжилтэй шууд холбоотойг эрдэмтэн судлаачид баталж байна. “Малын хорогдол нь идэвхжлийн оргил үед тохиолддог нь илт бөгөөд тэр үед хорогдол ихсэж байна” (Г.Ганбат, Р.Индра, Л.Энхбаатар, 2005). Гэтэл малын халдварт өвчин, царцааны нүүдэл мэтийн гамшиг нь нарны идэвхжилтэй урвуу хамааралтай буюу идэвхжил буурах үед, эсвэл өгсөх үед тохиолдож байна (Л.Энхбаатар, 1999, Л.Энхбаатар, Эдгээр эрдэмтдийн судалгаагаар, малын шүлхий өвчин Монгол оронд 1933, 1941, 1952, 1965 оны нарны идэвхжлийн үед 0.89 урвуу хамааралтай дэгдэж байснаа 24-26 жил вакцинхийгээгүйн улмаас 2000-2001 онд нарны идэвхжлийн өндөр үед дахин дэгдэлтийн байдалд орсон байна.

Анагаах ухааны доктор Л.Энхбаатарын судалгаагаар 1955-1991 оны хооронд малын галзууөвчний гурван удаагийн тахал хэлбэрийн дэгдэлт ажиглагдсан нь нарны идэвхжлийн нам үед -0.84 урвуу хамааралтай байжээ. Үлийн цагаан оготно 11 жилийн хэмнэлтэйгээр асар их өсөж үрждэг байна. Дээрхээс үзэхэд, манай оронд нарны идэвхжил өндөр үед улам олон мал хорогдож иржээ.

2.2.6 Ган, зуднаас урьдчилан хамгаалах, учирсон хохирлыг нөхөх

“Мал бол мөнгөний машин”(Өнөөгийн эзэн малчны үг)

“Барагдахад өдөр, шөнө хоёр

Баяжихад өвөл, зун хоёр”(Ардын мэргэн үгсээс)

Ган, зуднаас хамгаалах гэдэг нь,

- а) Ган, зуднаас сэргийлэн хамгаалах
- б) Ган, зуд нэгэнт тохиолдсон үед тэдгээртэй тэмцэж ажиллах
- в) Учирсан хохирлыг нөхөх арга зам гэсэн үндсэн 3 хэсэг арга хэмжээ авахыг шаарддаг.

Зун нь гандуу юм уу, гантай байгаа тохиолдолд өвөл, хавар нь хүндрэх магадлал өндөр байдаг.

Дэлхий дулаарч, байгаль, цаг уур эрс өөрчлөгдөж, урьд нь дунджаар 10-12 жил орчмын давтамжтай болдог байсан ган, зуд сүүлийн жилүүдэд ойр, ойрхон болж,

хүчтэй цасан болон шороон шуургатай, хүйтэн хоногийн тоо ихээхэн нэмэгдэх болов. Энэ нь бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг манай орны хувьд ган, зудыг жил бүр тохиолдоно гэж тооцож ажиллахаас өөр аргагүйг харуулж байна.

Үүний тулд өнгөрсөн ган, зудаас сургамж авч, өнөөгийн цаг уурын өөрчлөлт, дулаарал, өөрийн улс орон, аймаг, сумын цаг уурын байдалд дүгнэлт хийж, болзошгүй ган, зуд зэрэг гамшигт үзэгдэлүүдийн нөхцөлд тэдгээртэй дасан зохицож ажиллаж амьдрах, малчин өрх, баг, сум, аймгийн ойрын хугацааны болон хэтийн төлөвлөгөөг оновчтой боловсруулж, түүнийгээ хэрэгжүүлэх шаардлагатай.

Тухайн орон нутагт зун, намарг бэлчээрийн ургац олигтой гараагүй нөхцөлд хаашаа нүүж, өнөлжиж, хаваржих вэ гэдгийг аль эрт намрын налгар цагт л шийдчихсэн байх ёстой. Ийм үед зунаас эхлэн үе шагайгаар холын болон алсын отор хийж, малдаа дээд зэргийн тарга хүч авахуулахын зэрэгцээ отроор өвөлжих, хаваржих нутгаа сонгож, энэ талаар орон нутгийн төр захиргааны байгууллагад хүсэлт гарган гэрээ, хэлцэл байгуулан хатуу тохирч, тэндээ хадлан тэжээл бэлтгэх, хашаа хороо барих, бууц, уст цэг, түлш нөөцлөн бэлтгэх малчин өрхийн хувийн бэлтгэлийн ажлыг чамбай хийвэл болзошгүй зуд, өвөл, хаврыг хохирол багатай даван туулах нөхцөл бүрдүүлж чадна.

Бэлчээрийн мал аж ахуй эрхлэхийн амин сүнс болсон бэлчээр нутгийг сар, улирлаар ээлжлэн сэлгэж, ашиглах хуваарь гаргаж, түүнийгээ ягштал мөрддөг байх нь чухал юм.

Ялангуяа ган, зуд тохиолдсон үед хаашаа хэрхэн нүүж гарах вэ гэдгийг төлөвлөн, өвлийн отрын нөөц бэлчээр нутаг, буурь бууцыг товлон тогтоож, тэнд зохих бэлтгэлийг хангасан байх хэрэгтэй. Хэрэв өөр аймаг, сумын нутагт өвөлжих бол цаг алдалгүй эртнээс отроор явж, тэр газарт аажуу тайван очиж, тэндээ өвлийн бэлтгэлээ хангасан байвал зохино.

Зун нь бэлчээр сайн гарсан нутагт, өвөл нь цас их орсон ч тарга хүч сайн авсан мал зутралгүй онд орох боломжтой.

Малчид бог малд зориулан задгай хашаа, хороо барьж ашигладаг, түүний нөмөрт үхэр, тэмээ хэвтдэг, цасгүй, салхигүй, өдөртөө наранд сайн ээдэг, гүн зузаан өтөг бууц бүхий нөмөр нөөлөгтэй хэвтэр буй болдог. Малдаа мод, чулуу, хөрзөн, цасаар дугуй хэлбэрийн хашаа, хороо барьдаг.

Нэгэнт өвөлжөө, бууцаа зөв сонгосон бол өвөлжөөний нутагт цас их унаж, хүйтний эрч чангарч, бэлчээр хомсдсон ч дүн өвлөөр нүүх нь мал, хүнийг улам их зутраадаг тул цагийн хатууд аль болох тогтвортой байж, өөр шинэ газар нүүхгүйг хичээдэг.

Жил бүрийн намар мал сүрэгтээ нэг бүрчлэн үзлэг, ажиглалт хийж, хөгшин, өвчтэй, дундаас доош тарга хүчтэйг нь заазлан ялгаж, хүнсэнд хэрэглэх, сүрэгт зөвхөн эрүүл, залуу, тарга хүчтэйг нь үлдээж байх, хавраас эхлэн өвөлжөөнд буух хүртэл малаа таргалуулахад болон өвөл, хаварт тарга хүчийг нь алдагдуулахгүйгээр хариулга, маллагаа, тэжээлд анхаарч, хур хүчтэйг нь онд оруулж чадвал малаас авч болох бүхий л ашиг шимийг дүүрэн ашиглах бололцоо бүрдэнэ.

Малчин өрх бүр байгаа малынхаа тоо, сүргийн бүтэц зэрэгт үндэслэн 1, 2, 5 жилийн хугацааны орлого, зарлагаа нарийн тооцсон сүргийн эргэлт зохиож, түүнийгээ ягштал мөрдөж ажиллавал зохино. Голлох төрлийн малынхаа сүргийн бүтцэд эх малын /хээлтэгчийн/ хувийн жинг нь аль болох өсөлттэй байхаар бодож ажиллах нь мал сүрэг төлөөрөө өсдөг зарчимд үндэслэдэг.

Малдаа дээд зэргийн тарга хүч авахуулсан, боломжийн хэмжээнд хадлан, тэжээл, хужир нөөцөлсөн, өвөл, хаврын бэлчээрээ зунаас эхлэн нөөцөлж хамгаалсан, мал сүргээ эрүүлжүүлэх арга хэмжээнд (тарилга, туулгалт, угаалга, боловсруулалт) бүрэн хамруулсан, найдваргүй хөгшинг нь заазалжихсан, хашаа, хороо, байраа дулаалж бууц хэвтэр бэлтгэсэн, бэлчээрт явах болон тэжээлд орох малынхаа усны хангамжийг тооцсон, шаардлагатай үед нүүж буух нөөц бууц, бэлчээр усыг урьдаар төлөвлөсөн малчны хот зуданд төдийлэн нэрвэгдэхгүй, огт хохиролгүй буюу бага хохиролтой даван гарч чаддаг.

Хот айл, тэдний өвөл, хаврын хатууг туулж гарахад шаардагдах хувийн бэлтгэл, тухайлбал, гэр орон дулаан, хоол хүнс, дулаан хувцас, түлш, ус, уналгын

морь, ажлын мал, ажлын багаж хэрэгсэл, эм бэлдмэл зэргийг тооцож жин тан болгосон байхыг шаарддаг.

Мал маллана гэдэг малынхаа аяыг нь дагуулна ч гэсэн үг, бас малаа захирна ч гэсэн үг гэдэг. Чухам ямар үед аяыг нь дагуулж, ямар үед нь захирах вэ гэдгийг орчин нөхцөлтэй нь нягт холбон үзэж хэрэгжүүлэхээс их зүйл шалтгаална.

“Ухаан зарахгүй ажил бүтээнэ гэж үгүй. Мал маллана гэдэг ухааны ажил” (хоньчин Б.Галиндэв). “Усаар дутаана гэдэг бол тэжээлээр өлсгөнө гэсэн үг, цангасан мал цадталаа иддэггүй, өлссөн мал ханатлаа уудаггүй, цангасан мал өлсдөг, өлссөн мал даардаг, даарсан мал турдаг” (хоньчин С.Жамъян). “Мал том жижиг байж болно, харин тарган, эцэнхийн ялгаа байж болохгүй” (хоньчин Б.Дашзэвэг). “Зуны нэг өдрийн бэлчээр алдвал өвлийн гурван өдрийн зуд авч ирнэ. Уургандаа цадаагүй хурга төлгөндөө майлдаг”, “Хужир даарахад дах, таргалахын ташуур, турахын тушаа” (хоньчин С.Цогтгэрэл) гэх зэргээр манай алдарт, нэрт малчид тун ч онч мэргэнээр сургасан нь тэдний бэлчээрийн мал аж ахуй, түүний дотормал маллагааны арга технологийг чанд эзэмшсэнийг илтгэдэг.

Ахмад туршлагатай малчид, малчин хүний ажлын үр дүнг нь зөвхөн малыг онд мэнд оруулснаар биш, хэр зэрэг хур хүчтэй оруулснаар хэмждэг. Үүний тулд малын хариулга, маллагааг улирлаар тохируулахад онцлон анхаарч ирсэн нь тэдний ган, зуд мэтийн аюулаас мал сүргээ хамгаалах үндсэн арга байсаар иржээ.

Зуд малд заазлалт, ангилалт, ялгалтыг хийх шиг хийж, мууг нь авч оддог. Тэсэж үлдсэн нь хамгийн шилмэл тэсвэр хатуужилтай нь байдаг. Чухам үүнд л зуд зулагтай гэдэг үгийн утга учир оршино.

Зуд бол малчдын ажилсаг, хөдөлмөрч, малч ажиллагаа, холбогдох дарга, түшмэд мэргэжилтнүүдийн ажлын тод шалгуур бөгөөд чухам тэдний хэн нь хэн бэ гэдгийг ил тод харуулдаг.

Малчдын мэргэжил олгодог курс, коллеж олноор нь байгуулж, жинхэнэ ёсоор нь малчин бэлтгэдэг болохыг амьдрал шаардаж байна. Эс тэгвээс бэлчээрийн мал

маллагааны арга туршлагыг мэдэхгүйгээр өнө эртнээс уламжлалтай энэ аж ахуйг эрхлэхэд нэн төвөгтэй болжээ.

Цөлжилт гэдэг нь хуурай, хагас хуурай ба гандуу болж өөрчлөгдөх болон хүний үйл ажиллагаатай холбоотой олон төрлийн хүчин зүйлээс үүдэлтэй газар буюу газрын бүрхэвчийн доройтол юм⁶⁷.

Монгол оронд сүүлийн 67 жилд агаарын дундаж хэм дэлхийн дулаарлын бараг түвшингээс гурав дахин буюу 2.1 хэмээр нэмэгдсэн байна. Хур тунадас 20 орчим хувиар багассаны нөлөөгөөр говь, хээрийн зааг бүс нутгаар ургамлын ургах хугацаа 1980 оныхоос нэг сараар хойшилжээ.

Хүний буруу үйл ажиллагаанаас голлон шалтгаалж манай орны ойн талбай 1950 оныхоос хоёр дахин багассан байна.

Тал хээрийн, говийн бүсийн нутгаар шороон шуургатай өдрийн тоо 1960 оныхтой харьцуулахад 4-5 дахин нэмэгджээ. Монгол орны нутаг дэвсгэрийн 70 орчим хувь нь доройтон цөлжилтөд ямар нэг хэмжээгээр өртсөн байна.

Манай орны хувьд элсний нүүлт, хөдөлгөөнд ямар нэг хэмжээгээр өртсөн нутгууд бол Говь-Алтайн Хөх морьт, Завханы Дөрвөлжин, Завханмандал, Увсын Зүүнговь, Өмнөговийн Гурван тэсийн зарим нутаг, Сүхбаатарын Дарьганга сумын төв зэрэг газрууд юм.

Түүнчлэн арав гаруй аймгийн 145 сумын төвийг тойрсон 800-1500 га талбайд цэгэн цөлжилт үүсээд байна. Одоогийн байдлаар 30 мянган га газар шинээр элсэн хурдсаар хучигдаад байгаа аж.

Цөлжилт нь уур амьсгалын өөрчлөлт, байгалийн нөөцийг буруу ашигласнаас голлон үүсч байна. Цөлжилтөд бэлчээрийн талхлагдал, тариалангийн газрын зохистүй ашиглалт ихээхэн нөлөөлж байна.

⁶⁷НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенци.

Бэлчээрийн талхлагдалд бэлчээрийн даац хэтрэлт, бэлчээр нутгийг улирлаар сэлгэн ашиглахаа больсон, мал сүргийн бүтцийн өөрчлөлт, худаг уст цэг орчмын бэлчээрийн талхлагдал, ой модны зохисгүй хэрэглээ зэрэг нь нөлөөлдөг.

Монгол Улсын хэмжээнд явуулсан сүүлийн тооллогын дүнгээс үзэхэд нийт 5121 гол горхины 17,3 хувь, 4232 нуур цөөрмийн 39,3 хувь, 93240 булаг шандны 22,4 хувь нь ширгэжээ.

Одоо ч гэсэн ширгэж, усны нөөц нь багасч байгаа нуур, цөөрөм, гол, булаг шанд тун олон байна. Усны нөөцийг доройтуулахад голын сав газрын мод, бутыг түлшинд хэрэглэх эх булаг орчмын бэлчээрийг байнга, сэлгэхгүй ашиглах, уул уурхайн зохисгүй ашиглалт, алт угаалт, хулгайн мод бэлтгэл ихээхэн нөлөөлж байна.

2.2.7 Бэлчээрийн түймэр

Бэлчээрийн түймэр нь өвс ургамлын хуурай шимтэй үед, ялангуяа хавар цас хагдарснаас хойш их гарч, нэлээд талбайн өвс ургамал шатаж, мал сүргийг бэлчээргүй болгодгоос гадна өвөлжөө, хаваржаа, гэр орон, бэлтгэсэн өвс тэжээл, ой хөвч, мал амьтан, хашаа саравч, өтөг бууц, улмаар хүний амь насыг эрсдүүлэн, үлэмж гарз хохирол учруулсаар иржээ.

Хээрийн гал түймрээс сэргийлэн хамгаал ах талаар монголын нүүдэлчин малчид уламжлалт олон аргатай. Хээр зайлшгүй гал түлэх шаардлага гарвал эргэн тойрны өвс ургамлыг цэвэрлэж, галаа манаж, эцэст нь заавал унтрааж, цогийг нь булдаг. Өвөлжөө, хаваржаа, өвс тэжээл, хот орчмын эргэн тойрны өвс ургамлыг түүж цэвэрлэн, түймрээс хамгаалах шороон зурвас татаж, хүүхэд багачуудад хээр гал түлж болохгүйг хатуу сургамжилдаг байлаа.

Малчид гаансны үнс, тамхи, шүдэнзний галыг бүрэн унтрааж хаях, цаас, даавуу, эсгий мэт шатамхай зүйлээр сумны хонгио бөглөж буудахгүй байх, гэрийнхээ үнсийг салхигүй хонхор, жалганд асгах гэх мэт нарийн дэг журамтай. Хэрвээ хээр гадаа түймэр гарч, утаа харагдвал түрүүлж харсан хүн хэн ч байсан

ялгаагүй хүмүүст мэдэгдэж, бусдын шахалт шаардлагагүйгээр тал бүрээс цугларч бага дээр нь унтраадаг уламжлалтай.

Эх нутаг, эх орон шатаж байхад тайван сууж байх эрх үүрэг, хэн гуайд ч байхгүй билээ. Хээр мал хариулж явтал түймэр гарвал салхины эсрэг тал руу нь малаа хурдавчлан тууж гарах, хэрвээ гэрийнхээ ойролцоо яваа бол хот, хашаа, саравч руугаа малаа тууж оруулдаг. Түймэр нөмрөхөөс өмнө дээр дурдсаныг амжуулж чадахааргүй бол хэсэг газрын өвсийг шатаагаад үлдсэн нурам дээр нь малаа шагай шиг хураана.

Өвөлжөө, хаваржаанаас гарсан хойно гэр, хот руу түймэр орж ирэхээр болбол орчныхоо өвсийг хүрзээр хусаж зулгааж зайлуулан, нойтон эсгий, шир, адсага тойруулан тавьж хамгаалдаг байна.

Түймрийн гал нөмрөх үед мал өөр өөрийн араншинтай болдог. Үхрийг сайн шахахад тугалаа дагуулан гал сөрөн дайрч, бага хохиролтой гарч чаддаг. Адууг авалцсан гал руу шахахад, сүүл рүүгээ өшиглөж, тангарч, нэг газраа байсаар байгаад нүдээ сохолдог бол, бог малд галд туугдан гүйсээр байгаад шатаж, бахардаж унадаг. Түймэрт өртсөн үед малыг маш түргэн галыг сэргүүлэн гаталгаж, гал өнгөрсөн цурман дор гаргаж чадвал харьцангуй бага хохирол амсана.

2.3 Үлийн цагаан огтонотой тэмцэх нь

Төв Ази, Монгол орны тал хээрт өргөн тархсан энэ амьтан одоогоор манай орны нийт 40 гаруй сая га бэлчээрт тархаж, цаашид ч тархац нь улам нэмэгдэж, бүр Монгол Алтайн нуруу үлийн цагаан оготнод эзлэгдэх аюул тун ойрхон байна.

Оготны үржил дөрөвдүгээр сарын эцсээс наймдугаар сарын дунд үе хүртэл явагдаж, эмэгчин оготно 18-21 хоног хээл тээж, 8-14 гөлчгий гаргаж, үржлийнхээ хугацаанд дээд тал нь гурван удаа төрнө. Эмэгчин гөлчгий нь бас тэр жилдээ үржилд орж хоёр удаа төрөх чадвартай.

Энэ хугацаанд нэг эмэгчин 40-66 толгой болох ч гарсан гөлчгийн 41-45 хувь бойжиж, дунджаар 21-24 толгой болж өсдөг байна. Үлийн цагаан оготно хэдхэн жилийн дотор бүх тал, хээр нутагт багтахгүй болтлоо олширч, ургамлын нөмрөгийг бүрмөсөн идэж устгахаар байвч зүй тогтлоороо бас цөөрдөг.

Ингэж олширсон тохилдол сүүлийн 70 жилийн дотор тодорхой нутагт долоон удаа тохиолдож бусад жилүүдэд хэвийн байжээ. Энэ оготны хүнс тэжээлд тал хээрийн бүсийн жар гаруй зүйл ургамал бүртгэгдсэний 50-60 хувийг үетэн, буурцагт ургамал эзэлдэг байна. Оготно хэвийн өсөлтгэй байх үедээ тал хээрийн бүсийн хөрсний гүний ялзмаг багатай торыг ялзмаг бүхий өнгөн хөрсөн дээр гарган хаясаар, яваандаа хөрсний тэжээллэг өнгөн давхарыг зузааруулан, улмаар үржил шимтэй шинэ давхрага үүсгэж, хөрс сийрэгжүүлэн ус агаар, дулааны солилцоог сайжруулдаг сайн талтай.

Оготно олширсон үедээ үлэмжхэн хор хөнөөлтэй. Иймийн тулд үлийн цагаан оготнын тоог хэт олшруулахгүй байх, түүний хор хөнөөлөөс бэлчээрээ хамгаалах нь малчдын эрхэм зорилт юм. Үлийн цагаан оготнотой тэмцэх ажлыг өмнөх олон жилүүдэд зөвхөн химийн аргаар нэг төрлийн хор (фосфорт цайрыг) хэрэглэсэн нь огт буруу байжээ.

Нөгөө талаар хорыг түүний голомтлосон бэлчээр нутгийн төвд нь цацсанаар тархалтыг улам ихэсгэсэн байна. Фосфорт цайр нь байгал орчинд сөрөг нөлөөтэй хор юм.

Үлийн цагаан оготно хэт их олширсон үедээ бэлчээрийн ургамлын 90-95 хувийг хөнөөж, мал аж ахуйд ноцтой хохирол учруулдаг. 1960-аад оноос хор цацахад ихээхэн хөрөнгө зарсан боловч үлийн оготно устаж алга болоогүй, харин ч сүүлийн 40 жилд түүний тархацын хүрээ 2,5 сая га-аар нэмэгджээ.

Орчин үед үлийн цагаан оготнотой байгаль орчинд хоргүй чавх, урхи, сааль болон үлийг эвдэж цооноглох, хөөө нохойг нь авах, утах, нүх мөргүүлэх, ус хийх, хөлдөөх зэрэг механик аргаар тэмцэхийг эрдэмтэн судлаачид зөвлөж байна. Мөн үлийн цагаан оготно ихтэй нутгуудад үнэг, хярс, өмхий хүрэн, үен, солонго зэрэг амьтдыг үргээж айлгалгүй байршуулан өсгөж үржүүлэх биологийн арга ч хэрэглэх шаардлагатай байна. Түүнчлэн оготныг өвчлүүлэх бактерийн бэлдмэлээр устгах арга ч хэрэглэдэг. Үлийн цагаан оготныг устгахдаа орчин үеийн аргуудыг хэрэглэхээсээ илүүтэй уламжлалт аргыг хэрэглэх нь үнэг, хярс, мануул зэрэг амьтдыг хамгаалахад ач тустай болно.

2.4 Мал сүргийн усан хангамж

Өгэдэй хаан “Цөл говьд худаг гаргуулж хашуулъя” хэмээн зарлиг буулган гаргуулсан байдаг. Хожим нь тэрээр хаан эцгээс хойш үйлдсэн дөрвөн сайн үйлсийн нэг нь “Усгүй газарт худаг малтуулж гаргуулаад, улс иргэнийг ус, өвсөнд хүрэлцээтэй болгов” хэмээн дүгнэж хэлсэн байдаг.

Энэ нь нүүдэлчин монголчууд бэлчээрийн усны асуудалд олон зуун жилийн тэртээгээс анхаарч ирсэнийг нотолно. Манай орны хөдөө нутагт бэлчээрийн усан хангамжийг шинжлэх ухаанчаар сайжруулах эхлэл 1930-аад оны сүүлчээс тавигдаж, 1990 он гэхэд энэ талаар ихээхэн амжилт олж чадсан билээ. .

Хүн, малын биеийн жингийн 60-70 хувийг ус эзэлдэг. Түүний 12 хувийг алдвал амьдрах боломжгүй. Тиймээс мал, амьтны бие махбодид ус нэн их ач холбогдолтой. Төрөл бүрийн малын уух усны хэмжээ нь малын нас, арчилгаа, маллагаа, тэжээлийн чанар, цаг агаарын байдлаас нь шалтгаалж харилцан адилгүй.

Манай орны нөхцөлд, ялангуяа өвөл, хаврын тэжээлийн чийг багассан үед малыг бие махбодын физиологийн шаардлагын дагуу услах нь авсан тарга хүчийг

тогтоох, хээл хамгаалах, цаашид төлөрхөг чанарыг хангах үндэс болдог. Малын биед шаардагдах усны хэрэгцээ гурван хэлбэрээр хангагддаг. Үүнд, шууд ус ууна, өвс тэжээлд тодорхой хэмжээний ус агуулагдана, малын өөрийн эд, эсийн дотор явагдах бодисын хувирлын явцад зохих хэмжээний ус үүснэ. Малд ус дутагдвал өвс, тэжээлээ идэх чадвар нь эрс буурна. Үхэр тэжээл идэх, түүнийг хивж боловсруулахын тулд хоногт 50-60 л шүлс ялгаруулах шаардлагатай гэж бодоход хоногт хэдий хэр ус уух хэрэгцээтэй болох нь ойлгомжтой. Хэрэв үхрийг нэг өдөр услахгүй өнжөөхөд тэжээлээ идэх чадвар нь 24хувь, хоёр өдөр услахгүй бол 64 хувь буурна. Хонь хоёр дахь өдрөөс эхлэн тэжээлээс гардаг. Ус дутагдсан мал тэжээлээсээ гарахын хамт биеийн цангааг тайлахын эрхээр биед хуримтлагдсан өөх, нүүрс ус, уургийн бодисыг задлах учир турж, биеийн жингээ алдана. .

Манай орны хувьд өвөл, хаврын улиралд гол горхи, булаг шанд хөлдөж, бэлчээрийн мал усаар ихээхэн гачигддаг. Энэ нь мал тарга хүчээ алдах бас нэг шалтгаан болдог. Говь цөлийн бүсэд ус үргэлж дутагдах ба түүнд нь гайхамшигтай зохицсон амьтан бол тэмээ юм. Тэмээ хэдэн долоо хоногоор ус уухгүй байж чаддаг. Энэ үед түүний шээс өтгөрч, хэмжээ нь 0,5 л хүртэл буурна.

Тэмээний өөр нэг гайхамшигтай сонин зохилдлого гэвэл агаарын температур ихсэх үед хэт хөлөрч, усаа алдахгүйн тулд биеийн температураа нэмэгдүүлж чаддаг. Тэмээ цаг агаар таатай үед бөхөндөө өөх хуримтлуулах бөгөөд тэр нь цөөн хэдэн хоногийн өл зогоох нөөц болох ба түүнийгээ задлан өл залгах явцад нь өдөрт ойролцоогоор 1-3 л ус ялгардаг. Ангасан тэмээ 80 л хүртэл ус ууж чадах ба түүнийхээ тодорхой хэсгийг олон хоногоор гүзээндээ хадгалан, аажим зарцуулдаг.

Төрөл бүрийн малын хоногт уух усны хэмжээ (литрээр):

Таван хошуу мал	Хаварт	Зунд	Намарт
Тэмээ	50-55 л	45-50л	30-35 л
Адуу	30-55 л	25-30 л	25-30 л
Үхэр	3040 л	25-35 л	25-30 л

Хонь, ямаа	4-5 л	3-5 л	4-5 л
------------	-------	-------	-------

(6-р хүснэгт)

Мал услахад анхаарах зүйл. Бог малыг үдийн өмнө, бод малыг үдээс хойш усална. Мал идээшилсний дараа услахгүй бол өлөн дээрээ олигтой уудаггүй. Мал ус уух хамгийн зохистой үе бол өдөрт идэх өвс тэжээлийнхээ хагасаас илүү (50-70 хувийг) идсэний дараах үе юм. Мал зөвхөн нэг удаа ус уугаад ханадаггүй, тиймээс гурваас доошгүй удаа гол, булаг худаг дээр тогтоож, эргүүлэн ханатал нь усалдаг. Орой усалбал хэвтэртээ даарч, хээл хаяж болзошгүй. Олон малыг худгаас услахдаа цөөн цөөнөөр нь тасалж, усалдаг. Ус уусан малыг бэлчээрт аажуу тааваар нь гаргана.

Урсгал уснаас мал услахдаа урсгалыг нь сөрүүлэн явуулахад нэгэн жигд ууж чаддаг. Өвөл, хаврын улиралд төрөл бүрийн мал услах худгийн аманд давхар таглаа хийж, завсар нь зэгс, сүрэл, дэрс хавчуулж дулаална.

Мөн гол, горхи, худаг, булгийн усны орчмын цас, мөсний халтиргааг цэвэрлэж байх шаардлагатай. Мал услах, ус авахаас өөр цагт худгийнхаа амсрыг таглаж байхгүй өол хог, шороо орж бохирдуулахаас гадна цангасан бага мал, амьтан унах магадлалтай.

Малын бэлчээр, ус, хот, бууцныхаа хоорондын зайг зохистой тохируулах нь чухал. Үүнд хээлтэй, тугалтай үнээ, бярууны бэлчээр ус хотноос 4-5 км, нялх ботготой ингэний бэлчээр ус хот хэвтэшнийх нь газраас 1-2 км, ботго хөрвөжиж өвс, усанд орсон бол 3-5 км, хээлтэй буюу нялх төлтэй хонь, ямааны ус бэлчээр 2-3 км, саалийн эм хонь, ямаа 3-6 км, хээлтэй гүү болон нялх унагатай адууны бэлчээр 8-10 км-ээс холгүй байх нь тохиромжтой.

2.4.1 Уст цэг тогтоох, худаг гаргах монгол малчны уламжлалт арга ухаанаас

Уст цэгийг нуур, цөөрөм, тойром, шанд, мөрөн, гол, горхи, булаг, рашаан, суваг, усан сан, ус дамжуулах хоолой, гүн өрмийн худаг, богино яндантхудаг, уурхайн

худаг, энгийн гар худаг, тохижуулсан булаг, шанд гэж ангилж болно. Усны эх булгийн төрлөөс хамаарч ил задгай, худгийн зөөврийн гэнэ.

-Энгийн уурхай (гар) худаг гаргах уламжлалт арга

“Худаг малтвал ус гарна

Худ барилдвал ураг болно” (Ардын сургаал үг)

Энгийн гар худгийн ус нь газрын гадаргууд ойр, өнгөцхөн буюу арван метр хүртэл гүн байдаг. Энгийн уурхайн худгийг гол төлөв гараар ухаж, мод, чулуу, тоосго, төмөр зэрэг усны чанарт үл нөлөөлөх бат бөх материалаар доторлоно. Малчид гар худгийг дараах дэс дарааллаар гаргадаг.

1. Өдрийн сайныг харж худгийн цооног ухах газарт гадас хатгаж шав тавина.
2. Худаг гаргах ажил эхлэхээс өмнө дотор хашлага хийх, мод, чулуу, хайрга, шүүр хийх материалаа бэлтгэнэ.
3. Ажиллах хүч, тэдний байр сууц, хоол хүнс, унаа хөсгийг бэлдэнэ. Энгийн гар худаг гаргахад 4-6 хүн ажилладаг.
4. Шав тавьсан гадсыг тойруулан 2-3 метрийн радиустай тойрог зурна. Тойргийн хэмжээгээр худгийн уурхайн хэсгийг алсаас нь шатлан ухна. Ус илэрсэн үеэс доош нэг метрээс багагүй гүн ухна. Өөрөөр хэлбэл усны ундарга нь шавхагдахгүй, хангалттай болтол ухна.
5. Ундрагын ухсан хэсгийг доод ёроолоос 50-60 см өндөр чулуугаар дугуйруулсан хана өрж хашна.
6. Хашлагын доод талд 20-30 см зузаан шүүрэн үе (нарийн элс+жижиг хайрга+том хайрга) хийнэ.
7. Чулуун хашлагын гадна талаар усанд тэсвэртэй ургамлын (дэрс, хулс, нарийн бургас, сухай, зэгс гэх мэт) гаралтай материалаар (тэдгээрийг сүлжиж, хугалж, мушгиж) хийсэн шүүрээр ороож, гаднаас нь хайргаар манана. Хашлага ханыг энэчлэн усны тогтох түвшингээс дээш гартал өндөрлөж өрнө.
8. Усны доод түвшингээс дээш гарсан энэхүү хашлагын хананы гадна тал шүүрийн материал тавихгүй, шууд том ширхэгтэй хайргаар манана. Хайрганы гаднаас газар ухахад гарсан шороогоор булж, сайн нягтруулна.

9. Их биеийг хашиж дууссаны дараа худгийн хүзүүвчийг барина. Хүзүүвч нь эгц босоо ханатай, хэлбэр хэмжээгээрээ амтай адил байна. Хүзүүвчийг мод, чулуугаар өрж, завсар зайгаар нь шавар ус шүүрч орохооргүй сайтар чигжинэ.
10. Хүзүүвчний гадна талаар 0,7-2 метр хэмжээтэй, 1-1,5 метр өндөртэй шавар цоож хийнэ. Шавар цоожийг наанги шавраар 20-30 см-ээр үелүүлэн барьж, усалж чийглээд сайн нягтруулна. Шавар цоож нь худгийн амсар болон гадар, элдэв усны урсац худгийн хүзүүвч, хашлага даган худагт хөрсөөр нэвчин орохоос хамгаалдаг. Шавар цоожтой хүзүүвчин доор худгийн амсрын овоолгыг газрын гадаргаас дээш 0.7 метр өндөртэй хийнэ.
11. Овоолгын ухлагаас гарсан шороо хийж, сайтар нягтруулна. Овоолго нь худгийн усыг хөлдөхөөс хамгаалахаас гадна худагт гадаргын урсац, асгарсан ус эргэж орохоос хамгаалах давхар зориулалттай тул түүнийг хөлддөггүй худагт ч хийдэг,
12. Овоолгын дээр нь чулуу, зүймэл бетон хавтан зэргээр өнгөлгөө хийнэ. Мөн худгийн довжоог том хавтгай чулуугаар өрнө.
13. Хамгийн сүүлд худгийн амсар ба ус ховоодох тавцан, худгийн таглааг хийдэг. Таглааг зузаан банзаар хийнэ. Өвөл худгийн ус хөлдөхөөс хамгаалж хүзүүвчний доод талд давхар таглаа хийдэг. Доод таглааг уяагаар татаж онгойлгодог байхаар нугастай хийнэ.

-Цас, мөс нөөцөлж мал усалдаг уламжлалт аргаас

Ил задгай усны эх булаггүй, худаггүй соргог сайхан бэлчээрийг хаврын улиралд цөөхөн хоног ч болов ашиглахын тулд цас, мөс нөөцлөн хадгалж, услах нь их үр дүнтэй байдаг. Цас, мөс нөөцлөх ажлыг арван хоёрдугаар сараас эхэлж хоёрдугаар сард багтааж дуусгана. Үүгээрээ малыг гуравдугаар сарын сүүлчээс тавдугаар сарын дунд үе хүртэл 50 гаруй хоног ашиглан усалж болдог. Нягтруулан дарж нөөцөлсөн нэг ам метр цаснаас 250-300 литр ус, нэг тонн мөснөөс 1000 литр ус хайлуулан гарган авч болдог. Цас нөөцлөхдөө тусгайлсан зоорь бэлтгэж, эсвэл байгалиасаа өвөл, хавар цас их хунгарлаж хуримтлагддаг жалгын мухар, гуу газрыг сонгоно. Цас хуримтлагдан нягтарч хадгалагдах жалгын мухар, гав гуу нь өндрөөрөө

гурван м, өргөнөөрөө арван м, уртаараа 15 м байхад л 450-500 бог, төлтэйгээ 40 хоног усаар бүрэн хангагдах бололцоотой байдаг.

Монгол малчид их цастай гуу, жалгыг адгаар нь, эсвэл нарийн хилээр нь мод, чулуу, шавар, шороогоор далагнан хаалт барьж, хаврын цасны усыг тогтоон багахан нуур цөөрөм байгуулж, түүнээсээ олон хоног малаа усалж, бэлчээр ашигладаг туршлага ч байдаг.

2.4.2 Булаг шандны эхийг өвөл ашигладаг арга

“Ус булгаа цус шигээ хайрла

Уул толгодоо удам шигээ дээдэл” (Өвгөдийн сургаал)

Булаг шандыг хамгаалж, дулаалснаар ойр орчмыг нь бохирдохоос хамгаалж өвлийн хүйтэнд ашиглах бололцоо бүрдүүлдэг. Үүний тулд тухайн булаг, шандны усны ундраганы эхийг цэвэрлэж, ундрагыг нь ил гарган, дээр нь таван см зузаантайгаар жижиг том хайрга асгаад хамгаалалт барина. Зааж углуургадсан дүнг, бүдүүн шургааг, чулуу буюу цементэн хавтангаар гурван тал хашлага хийж, ундраганы оргилтой нь зэрэгцүүлэн зооно. Дараа нь тийш хөтлөх явган зам тавина⁶⁸.

Булгийн ус шүүрэн гарах талд хучлагын модны нэг үзүүрийг тавьж тогтооход зориулан шургааг хөндлөн тавина. Хашлагын битүүталд усны цорго бэхэлнэ. Хашлагын дээд онгорхойг шургааг буюу зузаан банзаар таглаж битүүлнэ. Энэ таг, хучлаганд агааржуулагч яндан хийсэн байх шаардлагатай. Үүний дараа дөрвөлжин бүхээгний гадуур зузаан шавардлага хийж хатаана. Булаг, шандны оргил газар бүрэн орсон байхаас гадна усны цоргыг бага зэрэг цухуйлган шороогоор хучиж өгнө.

Цоргыг төмөр, мод, бетоноор хийнэ. Өвлийн улиралд цоргыг эсгийгээр ороох зэргээр нэмэлт дулаалга хийнэ. Энэ ажлыг есдүгээр сарын 20-ны дотор хийж гүйцэтгэнэ. Өвөл тухайн булаг шандны ус задгайран хөлдөж мөсөн тошин үүсдэг учир мал услахдаа, ялангуяа хээлтэй мал хальтирч унах, хээл гэмтээхээс сэргийлж шороо асгана.

⁶⁸М.Төмөржав. “Монголын бэлчээрийн мал аж ахуй (уламжлал, шинэчлэл, эрчимжүүлэлт)”, УБ. 2004. Тал 186.

2.4.3 Газрын гүний усыг шинжиж олдог арга ухаанаас

- Говирхог юм уу, нам газарт заг, дэрс, сондуул, ширэг арвинтай бол ус төдий л хол бус.
- Өвлийн цагт тонолжлон хагарсан газрын тонолж дээр нь худаг ухвал ундарга сайтай булаг гарна.
- Харгана, дэрс хэсэг хэсгээр дугуйрч ургасан, алсаас ихэд зэрэглээтэн харагдаж байвал тэнд ус их буйн шинж.
- Газрыг тохой хэртэй ухаад, жижиг сав хөмөрч хонуулан маргааш нь авахад түүний дотор ус, шүүдэр ихэд суусан байвал тэнд ус байхын шинж.
- Гол байсан газарт ус байдаг гэж үздэг.

-Малд усны ач холбогдлын тухай алдарт малчдын зарим сургамжаас

“Усаар дутаана гэдэг

Тэжээлээр өлсгөнө гэсэн үг”

“Цангасан мал өлсдөг

Өлссөн мал даардаг

Даарсан мал турдаг”

“Хонь задгай аглуун баасаар баавал

Ус, өвс тохирч байгаа шинж

Нэг талдаа үзүүртэй

Жижиг хоргол гаргавал

Ус дутаж цадаагүйнх.”

“Хавар яргуй, хонгорзулын цэцгээр дотрын гэмнийг ариулан, ерхөг, навч, нахиа, өвсний үзүүр идүүлж, худгийн хүйтэн ус уулгавал маш хурдан сайн таргална.”

“Худаг бараадуулж хашаа барихаар

Хашаа бараадуулж худаг гарга”

“Дүүрэн идүүл, дүнхийтэл усал” .

“Нутгийг шинжье гэвэл усыг нь шинж”

“Үхэр усаар таргалж, усаар турдаг”

“Усгүй тэжээл хоол болохоосоо хоргол болох нь их”

“Мангирлахууд бороогүй бол гурван өдөр, бороотой бол 4-5 өдөр усгүй ангаваасайхан таргална.”

“Хонийг таслан байж сайн усал.”

“Цасны шар ус үхэрт сайн.”

2.5 Хадлан тэжээл

Малд шаардлагатай шимт бодисыг өөртөө агуулсан ургамал, амьтан, эрдэс, биологийн гаралтай төрөл бүрийн бүтээгдэхүүнийг малын тэжээл гэдэг. Төрөл бүрийн тэжээлийг найрлага, шингэц, шимт чанар, идэмж, өөрийн өртөг, хадгалах чадвар зэргээр нь түүнд агуулагдаж буй чийг, иротейн, ислэг, органикхүчил болон гадны хольцоор нь үнэлж ангилна. Бүх төрлийн тэжээлийг ургамал, амьтан, эрдсийн гаралтай тэжээл гэж ангилдаг. Эдгээрээс ургамлын гаралтай тэжээлийг бүдүүн, шүүст, хүчит гэж гурав хуваадаг.

Бүдүүн тэжээлд өвс, сүрэл, лай багтана. Эдгээр нь манай оронд бэлтгэж байгаа тэжээлийн ихэнх хувийг эзэлдэг. Өвс нь малын бие махбодын шаардлага хангах шимт бодисоор баялаг байдаг бөгөөд ид цэцэглэх үед нь хадаж, наранд шаралгүй, бороонд норгож муутгалгүй зохих чийгтэй бэлтгэсэн өвс хар ногоон өнгөтэй, анхилам сайхан үнэртэй, уян хатан, навч цэцэг элбэгтэй байдаг. Ахмад малчид мал өвсөөр цаддаггүй, шимээр нь цаддаг гэж үздэг.

Манай оронд өвсийг уламжлалт ёсоор хадлангийн байдлаар хадаж бэлтгэдэг. Хадсан өвсийг аль болох богино хугацаанд хатааж бэлтгэх нь шимт чанарыг нь муутгахгүй байх ач холбогдолтой. Өвсийг оройтуулж хадах, бороонд норгох, хадсаны дараа тарлаж бухалдалгүй удсанаас шимт бодис нь их алдагддаг.

Хадлангийн талбайд буурцагт, үет ургамал зонхилж байвал сайн чанарын өвс бэлтгэж болно. Ид цэцэглэх үед нь хадаж, сүүдэр газарт хатаасан ногоон өнгөтэй, анхилам үнэртэй өвсийг амин дэмт өвс гэдэг. Нойтон ногоон өвсийг 3-4 метр урттайгаар, 10-15 см орчим бүдүүн хэмжээтэйгээр дээс шиг мушгиж, сүүдэрт өлгөж хатааж, хадгалахыг мушгиа гэдэг.

Таримал тэжээл гэж царгас, эрдэнэ шиш, наранцэцэг, хошуу будаа, арвай, хөх тариа, вандуй зэрэг таримлыг дангаар нь буюу хольж тариалж, хадаж бэлтгэхийг

хэлнэ. Үр тариа хураасны дараа үрэл, лайг цуглуулж бэлтгэх ба энэ нь өвсийг бодоход уураг, тослог, амин дэм, эрдэс бодисоор дутмаг, ислэг ихтэй байдаг тул дунд зэргийн чанартай тэжээлд тооцогдоно.

Сүрлийг өвөл саам багатай үнээ, хөнгөн ажлын морь, шаранд зохих бүдүүн тэжээлийн хагастай тэнцэх хэмжээгээр өгч болдог. Сүрлийг зөв боловсруулж, эсвэл төрөл бүрийн дарш, өвсөн дарш зэрэг шүүслэг тэжээл, багсармал, холимог тэжээлтэй хольж хэрэглэхэд илүү тохиромжтой. Сүрлийг хэрчиж жижиглэх, халуун усаар дэвтээх, уураар үлээлгэх, исгэх, даршлах аргаар дахин боловсруулж, малын тэжээлд хэрэглэх нь бүр ч үр дүнтэй. Лай нь тариа цайруулахад гардаг хальс юм. Шимт чанараараа сүрлээс илүү. Лайг чийглэх буюу шүүслэг тэжээлтэй хольж малд өгнө.

-Шүүслэг тэжээл

Үндэс үрт ба гуагийн төрлийн ногоо нь үр тариаг бодвол нэгж талбайгаас авах ургацын хэмжээ нь их учир тэдгээрээр шүүст тэжээл бэлтгэх нь эдийн засгийн хувьд ач холбогдолтой. Түүгээр өвлийн улиралд саалийн үнээ, бас гахай тэжээнэ. Шүүст тэжээлийг мал дуртай идэхээс гадна амархан шингэж, боловсордог.

Шүүст тэжээлийн чанар нь хадгалалтаас ихээхэн шалтгаална. Хадгалах хамгийн тохиромжтой температур нь $+0.5^{\circ}\text{C}$ -аас $+3^{\circ}\text{C}$ юм. Ногоо 0°C -аас -3°C хэмд хөлдөнө, $+3^{\circ}\text{C}$, $+4^{\circ}\text{C}$ -д чийгээ алдах, соёолох зэргээр чанараа алддаг тул ногоо хадгалах байр салхивчтай, агааржуулалт сайтай, чийг багатай байх шаардлагатай.

-Дарш, өвсөн дарш бэлтгэх арга

Тэжээлийн ургамлыг сүүний хүчлийн бактерийн нөлөөгөөр исгэж, чанарыг нь алдагдуулахгүй хадгалсаныг дарш гэнэ. Дарш нь төрөл бүрийн шимт бодисоор баялаг, амт, үнэр сайтай, төрөл бүрийн малд ихээхэн тохиромжтой тэжээл юм. Байгалийн хадлан, бэлчээрийн ногоо, таримал ургамлыг амт, шимт чанар сайтай үед нь хураан авч, даршилж, богино хугацаанд хийж дуусгах, хучих шаардлагатай.

Шүүст тэжээлийн үндсэн төрөл нь технологийн дагуу зөв бэлтгэсэн дарш болон өвсөн дарш юм. Дарш, өвсөн дарш бэлтгэх ажлын аргачлал, дараалал нь

даршлах ургамлаа хадаж эврээх, хураах, тээвэрлэх, пүүлж буулгах, тарааж тэгшлэх, давслах, нягтруулах, бүтээж хучих зэрэг шат дамжлагаас бүрднэ. Энэхүү дамжлагын аль ч шатанд ямар нэг үйл ажиллагааг зөрчвөл даршны чанар муудна.

Таримал нэг наст ургамал болох хошуу будаа, хөх тариа, арвай, вандуй, байгалийн хадлангаар өвсөн дарш бэлтгэнэ. Эдгээр ургамлыг хольж хоёр ба гурвалсан холимог тэжээл тариалж, өвсөн дарш бэлтгэж болно. Бас наранцэцэг, эрдэнэшиш, рапс зэргээр болон дээр дурдсан үетэн ургамлуудтай хольж тариалан, даршинд хэрэглэж болно.

Хүчит тэжээлд төрөл бүрийн үр тариа, хивэг, багсармал, хорголжин тэжээл орно. Эрдэст тэжээлд хоолны давс, жамц давс зэрэг орон нутгийн давс, хужир, ясны гурил, шохой, цэрд, бусад эрдсийн бэлдмэлүүд хамаарна.

Хужир нь шороон, тосон, мөсөн гэж байдаг. Мал долоогоод үлдсэн нь бурзайдаг хужирыг малчид тосон хужир гэдэг. Энэ нь малд илүү ач тустай. Хужир идсэн мал өлчир байдаг учир малаа байнга хужирлаж байх хэрэгтэй. Манай малчид хужирын ач холбогдолын тухай “Хужир ерэн есөн эрдэмтэй, нэг гэмтэй”, “хужир даарахад дах, таргалахад ташуур, турахад тушаа”, “хужир бол махны амт”, “Дөрөө нуурын хужир дөрвөн цагаа даадаг”, “намрын хужир өвлийн дах, өвлийн хужир хүйтний хучлага” гэх мэтээр онч мэргэнээр сургасан байдаг. Малаа бэлчээрлүүлж, цадсаны нь дараа услаад хужирлана.

-Амьтны гаралтай тэжээл нь

Их хэмжээний төгс чанарын уураг, эрдэс бодис, амин дэмтэй. Амьтны гаралтай тэжээлд мах, яс, сүү, сүүн бүтээгдэхүүн, загасны тос, хүнсний хаягдал зэрэг хамаарна⁶⁹.

2.5.1 Хадлан бэлтгэх арга

“Нэг намар гурван хавраас үнэтэй”,

⁶⁹М.Төмөржав. “Монголын бэлчээрийн мал аж ахуй (уламжлал, шинэчлэл, эрчимжүүлэлт)”, УБ. 2004. Тал 287.

“Хадуургүй хүн хадахгүй

Хадахгүй хүн хазахгүй” хэмээх онч үгс бий.

Манай улс нийтдээ 4,9 сая га газраас хадлан хадах бололцоотойгоос 1,6 сая га-аас нь байнга хадлан бэлтгэх бололцоотой. Хадлангийн талбайн зонхилох хэсэг нь ойт хээр, хээрийн бүсэд оршдог. Дундаж ургац нь 7,2 ц/га байдаг. Өвс хадах хугацааг зөв тогтоох нь чанар сайтай арвин их өвс бэлтгэх гол нөхцөл юм. Манай орны ихэнх нутагт наймдугаар сарын хоёрдугаар хагаст өвс ургамал үрлэж, навч, иш, найлзуур нь гандан ургац нь буурч эхлэх тул өвс хадах хамгийн тохиромжтой үе бол долоодугаар сарын дундаас наймдугаар сарын дунд хүртэл юм. Нугын хадланг газрын гадаргын байдал, ургалтын өндрөөс хамааруулан 5-7 см-ийн өндөр хадна.

Задгай өвс бэлтгэхдээ “хадах, тармах, бухалдах, нуруулдах”, “хадах, тармах, эргүүлэх, бухалдах, нуруулдах”, “хадангуут тармах, бухалдах, нуруулдах”, “хадах, бухалдах, нуруулдах”, өвсийг боож бэлтгэх бол “хадах, тармах, боох, нуруулдах”, “хадангууттармах, боох, нуруулдах”, “нидэрч хадах, бухалдах, боох, нуруулдах” гэсэн дарааллын арга технологийн хувилбаруудаас сонгоно.

2.5.2 Ургац нэмэгдүүлэх арга зам

Хадлангийн талбайг тордож сайжруулах, үндсэн сайжруулах буюу таримал хадлан бий болгох гэж хувааж үзнэ. Хадлангийн талбайг цэвэрлэж, засаж тэгшилсний дараа сайжруулах шаардлагатай.

-Тордож сайжруулах

Талбай хашаалах, хөрс сийрэгжүүлэх, олон наст ургамлын үр нэмж тариалах, талбай услах ажлуудыг дэс дараатай хийнэ. Ингэснээр хадлангийн ургац эрс нэмэгдэнэ.

Тордож сайжруулахааргүй болсон талбайн газрыг хагалж, нэг ба олон наст ургамлын үр тариалж, таримал хадлан бий болгоно.

Хадлангийн талбайг цэвэрлэж, тэгшилснээр ургацыг 20 хувь хүртэл нэмэгдүүлж болно.

Хадлангийн талбайг гол горхиноос шуудуу татах, өвөл тошин халиаж гүйлгэх, цас мөс тогтоох зэргээр усалж, ургацын хэмжээг нэмэгдүүлж болно.

-Тошин халиаж услах

Голын харзалдаг өндөр эрэг бүхий нарийссан хэсэгт намар эрт модон шонг 20-30 см зайтай зэрэгцүүлэн зооно. Шон нь голын усны түвшингээс 70-80 см өндөр байна. Ус хөлдөж эхлэх үеэр урсгалын дээд талд шонгоос 15-20 см-ийн зайд мөсийг цоолж, өвс, сүрэл, модны үртэс, бууц зэргийг хийх ба энэ чигжээс нь модон шонтой барьцалдан хөлдсөнөөс урсгал боогдож, мөсний цоорхойгоор ус оргилон гарч тошин үүсдэг.

Мөсийг эргээс холдуулж, усыг өргөн тархаах зорилгоор ховил гарган, хальж буй усыг залж өгнө. Ингэж хөлдөөсөн мөс удаан хугацаанд хайлах тул хадлангийн талбайг хавар аажим усална,

-Талбайд цас тогтоох арга

Намар өвс хадахдаа зонхилохсалхины хөндлөн чигт хоорондоо 20 метрийн зайтай нэг метр өргөн дэл үлдээж хадна. Энэ нь өвөл цас тогтоох нөхцөл бүрдүүлнэ. Цас их орсон жилд салхины хөндлөн чигт хөнгөн дампууг чирж 30-50 метрийн зайтай цасыг хамарлана.

Хадлангийн талбайг бордохдоо бордоог усалгаатай хослуулбал ургац эрс нэмэгдэнэ. Талбайг бууц болон эрдэс бордоогоор бордоно. Хонины бууц хамгийн их үр дүнтэй. Манайд хадлангийн талбай бордоход азотын бордооноос шивтрийн шүү, фосфорын бордооноос суперфосфат, калийн бордооноос ихэвчлэн хлорг калийн давс хэрэглэдэг. Хадлангийн талбайг сайжруулах нэг арга нь түүнийг хадахгүйгаар өнжөөж сэлгэх явдал юм. Ахмад малчид:

*“Зун ургасан нь өвөлд тустай
Намар ургасан нь хаварт тустай”
“Хадлангүй малчин өвөлдөө зүдэрнэ
Ханьгүй хүн өтлөхдөө ядарна ”
“Алгын чинээ газраас арван бухал авах
Хормойн чинээ газраасхорин бухал авах”*гэхчлэн сургасаар иржээ.

3. ДӨРВӨН УЛИРАЛ БА ОТОР: УЛАМЖЛАЛ, ШИНЭЧЛЭЛ

3.1 Малчдын нүүдэл ба отор

Малчдын нүүдэл нь байгаль, цаг уурын эрс тэс нөхцөлд эрхлэх мал аж ахуйн арга ажиллагаатай холбоотой үүсч хөгжжээ. Монголчуудын нүүдлийн талаархи хийсэн шинжлэл судалгаанаас үзэхэд А.Д.Симуков (9, 19) монгол малчдын нүүдлийг хангайн ба тал хээрийн, баруун хэсгийн Өвөрхангай, Дорнод говийнх, Н.И.Денисов (1, 34) хангай, тал хээр, говь, Н.Жагварал (11, 15) Хэнтий, Хангай, Говь, Өрнөд, Дорнод гэсэн таван хэсэгт ангилсан байна. И.Ф.Шульженко (12, 23) малчдын нүүдэллэх шалтгааныг тайлбарлахдаа, мал сүрэгт өвс тэжээл дутагдах, зун нь урсгал ус, өвөл нь цас ундгүй болох бэлчээрийн ургамалын шимт чанар, мал сүрэгт таарахгүй болох, урин дулаан, сэрүүн хүйтнийг харгалзах, мал хужирлах, малын хэвтэр бууц хуучирч шавхайрах, хүн малын элдэв өвчин эмгэг гарах, үхэл зовлон учрах, бусад аж ахуйтай айлсах, саахалтлах шаардлага гарах зэрэг малчдын нутаг сэлгэхтэй шууд, шууд бус холбоотой олон зүйлийг авч үзсэн байна.

Бидний бодоход нүүдэл нь мал аж ахуйн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны хэлбэр бөгөөд нөөц баялгийг ашиглах, бэлчээрийг ариг гамтай эдлэх арга бөгөөд байгаль, цаг уур, бэлчээрийн нөхцөлд хүмүүсийн хөдөлмөрөө нэгтгэхээс үүссэн гэж үзэх үндэстэй юм.

Малчдын нүүдэл нь мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх, бэлчээр ашиглах, мал маллагаа (малчин-мал-бэлчээр) гэсэн гурван салшгүй холбоог илэрхийлэх билээ.

Монголчуудын нүүдлийн чиглэл нь дэлхийн бөмбөрцгийн уртраг, өргөрөгийн дагуу, өөрөөр хэлбэл, умраас өмнө, эсвэл өрнөөс дорно руу гэсэн хоёр үндсэн ангид хувааж болох юм. Нүүдлийн чиглэлийг хээрийн судалгааны хэрэглэгдэхүүнд тулгуурлаж үзэхэд уул нурууны болон усны байршил, газрын хөрсний онцлог, хур тунадас, урь дулааны байдал, цаг уурын нөхцөл, өвс ургамалын гарц зэргээс шалтгаалж малчдын нүүдлийн тодорхой чиглэл бүхий сонгомол хэлбэр бий болжээ. Малчдын нүүдлийн сонгомол хэлбэрийг хооронд нь харьцуулан үзэхэд холынх, ойрынх гэсэн үндсэн хоёр хэсэгт үзэж болох бөгөөд үүнд, тус орны уул нуруурхаг ба ойт хээрийн бүсэнд аж төрөх малчдын нүүдлийн ойрын нүүдэлд, харин хээр тал

хангай нутаг хосолсон газар холын нүүдэл юм. Малчдын малын бэлчээр ашиглах арга холын ба ойрын үндсэн хоёр хэлбэр нь сэлгэх, товших, өртөөлөх гэсэн нутаг сэлгэлтийг дамжих уламжлалтай юм.

Малчдын нүүдэл нь зарим хүмүүсийн үздэг шиг ердийн нэгэн дадал заншил бус, нийгмийн эдийн засгийн амьдралаас ургаж гарсан зүйл тухайлбал, байгалийн бэлчээрийг түшиглэн мал аж ахуйг эрхлэх нэгэн арга бөгөөд нийгмийн үйлдвэрлэх хүчний хөгжлийн хэр хэмжээ, байгаль, цаг уурын нөхцөлтэй шууд холбоотой түүхэн үзэгдэл юм.

Нүүдэл нь малчин хүний амьдралын үндсэн сурвалж мал аж ахуй эрхлэх гол арга, амьдралын зайлшгүй хэрэгцээтэй учир тэд нүүдлийг төвөгшөөхгүй, харин ч бие махбодыг эрүүл чийрэг, сэтгэл санааг өөдрөг золбоотой болгож, баяр цэнгэл авчирдаг гэж үздэг байв. Үнэхээр ч олон хоног нэгэн буйранд байгаад шинэ нутаг сэлгэн бууж төвхнөхөд хүмүүс тавлан, мал сүрэг налайн идээшилж малчин хүн амарч баясдаг ажээ.

Хангайд бол малчид зуны улиралд уул нурууны хөндий, голын захад зусаад, өвөл уулын мухар мужгаар өвөлжих ба харин говьд бол худаг, булаг, шанд тойром бүрдийг бараадан ойр зуур нүүдэг байна. Хангайд, говьд нутаглах зарим малчид тал хээрийн малчидтай адил зунд нутаг өгсөх намар говь руу нүүж нутаг уруудах зэргээр цаг уурын нөхцөлд бэлчээрийн байдлыг зохицуулан ашигладаг байжээ.

Малчид нь өвөлжөө зуслангийн тодорхой нэг газартай байдаг атал харин хаваржаа, намаржаа хоёр тогтмол нэг нутагт байдаггүй нь бэлчээр сэлгэхтэй холбоотой. Жишээ нь: тал хээрийн бүсийн малчид хаврын эхэн сараас эхлэн бог мал, адуу хоёр эрэн борог идэх, төрөл бүрийн мал ногооны бүрэн цадах зэрэг нөхцлөөс болж олон дахин бэлчээр сэлгэж нүүдэг учир хаваржаа тогтмол нутагт байх боломжгүй юм. Намар болоход малын тарга хүчийг зузааруулж тогтоохын тулд ногооны сөл, агь хөөж, сэрмүүн бэлчээрийг сорчлох зорилгоор бас олон удаа бэлчээр сэлгэх тул намаржаа бас байнга нэг газар байдаггүй. Тус орны өргөн удам нутаг дэвсгэрийн дотроос мал аж ахуйг нүүдлийн аргаар эрхлэхэд байгаль, цаг уурын талаар хамгийн тааламжтай нутаг нь тус орны тал хээрийн ба ойт хээрийн бүс юм.

Газар зүй, цаг уурын судалгааны хэрэглэгдэхүүнээс үзэхэд тал хээрийн бүс нь халуун, хүйтний дундаж нэг градусын изотермийг, хамарч тус орныг хангай, говь гэсэн хоёр хэсэгт хуваадаг байна. Тэг градусын изотермээс хоёр тийш 20 градусын дундаж температуртай нутаг дэвсгэрийг тал хээрийн бүсэнд хамаардаг аж. Энэхүү нутагт нутаглах малчид зундаа сэрүүн уур амьсгалтай хангай өөд нүүж, намрын сэрүүний дохиогоор дулаавтар уур амьсгалтай тал хээр-говийн бэлчээр хосолсон нутагтаа эргэж нүүдэг уламжлалтай ажээ.

Хангай, говь, хээр талын бүсэнд нутагладаг малчин ардууд улирал ба бэлчээрийн эрхшээлд зохицон нүүдэл хийхийн зэрэгцээ хар, шар феодал, хүрээ хийдийн захиргаа болон тэдний элдэв албан болон хувийн хэрэгцээг залгуулахын тулд зун, намрын улиралд тусгай заагдсан тодорхой нутагт нүүдэллэдэг байсан явдал хуучин Сайн ноён хан аймгийн Эрдэнэ бандид хутагтын сүрэгчдийн нүүдэлд харагдаж байна. Эрдэнэ бандид нутагт хорин мянган хавтгай дөрвөлжин километр нутагтай гучин мянга гаруй толгой мал эзэмшсэн байжээ.

Сүрэг хариулах гэдэг бол феодалуудын малыг ардууд тодорхой хугацаатай, оноосон болзлын дагуу хариулахыг хэлэх бөгөөд албан бичиг дансанд сүрэг маллах тухай “сүрэг хариулах”, “сүрэг хадгалах” гэж хэд хэдэн янз тэмдэглэсэн байдаг.

Сүрэг хариулахаар томилогдсон өрх айлууд нь 5-6 жилийн хугацаагаар сангийн ба жасын мал хариулдаг бөгөөд тэдгээр нь гол төлөв дунд зэргийн хөрөнгө чинээтэй, мал маллах туршлагатай, хувийн аж ахуйтан ардууд байсан байжээ.

XIX зууны 40-өөд оны үеийн нэгэн дансанд гэгээн сангийн ба жасын малыг 363 өрх (2, 21) хариуцан маллаж байсны дотор тэмээн сүргийг 65 өрх, үхэр сүргийг 34 өрх, бог малыг 200 өрх, адуун сүргийг 64 өрх тус тус маллаж байсан мэдээ байна. Тамгын газраас харьяат нутгийн малын бэлчээрийг ерөнхийлөн хувааж ардуудыг нүүдэллэхэд зохион зааварлах сүрэгчдийн зун, намрын нүүдлийг заан тогтоон, тэд сүрэгчдэд нутгийн аль тохиромжтой сайн бэлчээрийг өгч нутаглуулдаг байсан ажээ. Ийнхүү нүүдэллэхийг зааварлахын учир бол зун цагийн шашны хурлын үеэр нийт ард олныг хүрээ хийдэд ойртуулах, мөн лам нарт малын ашиг шим, сүү цагаан идээгээр үйлчлүүлэх зорилготой байв. Хүрээ хийдэд шавилан суугаа лам нарыг хоол хүнс,

хурлын зардал хүргэн нийлүүлэх, түүний сан, аж ахуйд биеийн хүчээр зүтгэн хөдөлмөрлөх, түлээ түлш, орон сууцны хэрэгцээт зүйлийг тасралтгүй залгуулж байх, шаардсан цагт эд юмсыг хүрээ хийдийн газрын тушаалын дагуу гүйцэтгэх зэрэг эдгээр хүнд нүсэр ажлууд нь сүрэгчдийн нүүдэллэн явахад саатал учруулж, тэдний нүүдэллэх явдал нь феодалын захирамжийн хүрээнд байсныг харуулж байна. Жишээ нь: Гэгээн сангийн сүргээс тэмээ хариулагч хүн намар сангийн тариаг хийдэд буулгах, түлээ түлш татах, гэрийн хана үдэх, тэмээний буйл, ачааны татлага, дээс бурантаг, хужир давс, зос, шир зэрэг эд материал жил тутам тушаах ёстой байжээ.

Хоньчид цагаан идээ, шар, цагаан тос, сүү, өрөм, аарц, ааруул, архи зэрэг болон гэрийн оосор, хошлон, дээврийн зээг, хурганы арьс, хонины нэхий, эсгий тушаах, үхэрчид цагаан идээ, сур чөдөр, ногт, чагтага, эргүүлэг, унины сагалдрага, сүхний иш мод, улаан цай (хар модны холтос), сонгино, арц, мөөг, тэмээний шат, үхрийн ширэн хөм бэлтгэх бөгөөд адуучид гүүний айраг, чөдөр ногт, бусад олон зүйлийг тушаадаг байжээ. Эдгээр албан үүргийг заавал гүйцэтгэхийн тулд сангийн ба жасын сүрэг хариулсан ардууд газрын холоос нүүж хүрээ хийдийн ойр ирэн, зааж цохсон газар нүүдэллэн байжээ. Мөн Майдар эргэх, Маанийн бүтээл, ганжуур ерөөл гэх зэрэг шашны томхон хурлын үе болон мал тооллогын үеэр сүрэгчид бүх ардуудыг нэг газар бөөгнөрүүлдэг байжээ.

Эрдэнэ бандид хутагт нь олон мянган толгой мал өмчилж байсан учир жил бүр сангийн мал сүргийг тоолж, нас хүйсээр нь ялган тамгалах, имнэх, сүргийн шинэ суурь байгуулах, малыг нэг өрхөөс нөгөөд шилжүүлэх зэрэг дотоод данс тооцооны ажил хийдэг байв. Иймийн тулд тамгын газраас зарлагч хүмүүс томилон сангийн ба жасын сүрэг хариулсан айл бүрд албан ёсоор нүүхийг мэдэгдүүлдэг байжээ. Тахар нар нүүхийг залхуурсан айлын өрхний баруун талын оосрыг суллан өрхийг зүүн зүг эргүүлэн хуулж “Өргөн нутгийн хил, өндөр тушаалт тайгам, өргөө гэрийн өрх залав” гэж хэлдэг байжээ. Ингэж зарлагч хүмүүсийн шууд тушаалаар сүрэгчид нутаг хөөлөг гэдэг байсан ба сүрэгчид хавар намар тус бүр 1-2 удаагийн нутаг хөөлгөөр говиос хээрийн бүс, хангайд хүртэл хангайгаас буцан мөн говь руу нүүдэллэдэг байжээ. Тэгж нүүдэллэн явахад малчин ардууд чирэгдэлд учирч байсан нь мэдээж юм. Сангийн мал тооллого явуулахдаа эхлээд бог мал дараа нь адуу, хамгийн сүүлд

тэмээн сүрэг тоолдог журамтай байсан байна. Жишээ нь: Тамгын газрын зайсан, сангийн нярав нар жил бүрийн зуны долдугаар сард бог мал хариуцсан сүрэгчдийг Түй, Өвгөн Шаргалжуут, Нарийн гол, Бийр зэрэг нутгаар нүүдэллүүлэн ирүүлж тооллого бүртгэл явуулдаг байв.

Намрын 8-9-р сард адуун сүргийн тооллого болохоор бог мал тоолуулсан өрхүүдийг нутаг уруудуулан Түйн голын Өргөн ширэг, Өндөр Эрэгцэг, Нарийн Эрэгцэг, Булган, Шивээн гэзэг зэрэг нутгаар адуун сүргийнхнийг уул нутагт нутаглуулах бөгөөд 9-р сарын сүүлч, аравдугаар сарын дундуур сангийн ба жасын тэмээн сүргийн тоо авах болоход бүх тэмээн сүргийнхнийг говь нутаг уруудуулан хөөж (одоогийн Баянхонгор аймгийн Богд, Баянлиг сум) Ар гурван гол, Орог нуур, Цутгалан зэрэг нутагт нүүдэллүүлдэг байжээ. Ийнхүү сүрэгчдийн нүүдэл нь тамгын газраас тусгайлан зохиогддог байсан, тул тэдний нүүдлийн нүүх чиглэл, нүүдлийн тоо нь үндсэндээ гурван хэсэгт хуваагдаж тус бүр сүргийн бүтэц, нүүдлийн хувьд хангай, хээр, говийн гэсэн гурван бүсэнд тохирч байжээ.

3.1.1 Нүүдэл нутагшил

1. Сүрэгчдийн нэг хэсэг нь Түйн голын эхнээс аваад мөн голын дагуу болох Цагаан эрэг гэдэг нутаг хүртэл 80-120 км-т нүүдэг байв. Тэд зуны цагаар Түйн голоор зусч, өвөлд голын эх, хажуу салбар, өндөрлөгийн хавьд өвөлждөг ажээ.

2. Сүрэгчдийн нөгөө хэсэг нь Цагаан эргээс Хавцгайтын ам хүртэл сав нутгаар нүүдэллэж Хавцгайтын ам, Тэмээн хүзүүний гол, Өвгөн Шаргалжуутын адгаар зусан, Хар нүдэн, их, бага Хүрэн толгой, Байн хөндий, Шийрийн гэзэг, Сартах зэрэгт 40-90 км-т нүүж өвөлждөг байжээ.

3. Гуравдугаар хэсэг сүрэгчид Их богд уулын ар хөндийгөөр өвөлжин Шаргалжуут голын хавиар зусдаг байсан байна. Үүнээс харахад сангийн сүрэгчдийн нутаглах нутаг нь Их ба баруун Богдын ар хөдийгөөс Түйн эхэн хүртлэх өргөн удам газрыг эзлэж байжээ.

-Бүсчилсэн отор, нүүдэл

а. Хангайн бүс. Хангайн бүсэнд нутаглаж байсан сүрэгчин ардууд нь зунд нутаг уруудан өвөлд нутаг өгсөж байжээ. Зунд Баянзүрхийн хийдийн хавиар зусж тэндээс намрын сүүлчээр буцан нүүж хангайд гарч өвөлждөг. Жишээ нь: Хангайн бүсийн сүрэгчид зунд хангайн нуруунаас Цагаан эрэг (Ламын гэгээний хийдийн зэрэгцээ) гэдэг нутагт нүүдэллэдэг байсан бөгөөд үүний шалтгаан гэвэл: Хангайн нуруунд зун бороо ус элбэг сэрүүвтэр уур амьсгалтай, нөгөө талаар тэндэх байгалийн нөхцөл байдалд тохирсон сарлаг зонхилон өсгөдөг байжээ. Энэ нүүдлийнхний хамгийн хол нь 30-40 км, нэг буудлаас нөгөөд хүрэхэд 5-8 км бөгөөд бүтэн жилд хангайн бүсийнхэн 4-8 удаа нүүж жилд 50-104 км-д нүүдэллэдэг байсан нь хангайн бүсийн сан, жасын мал хариулагчид бусдыг бодвол ойр нүүдэг ажээ. Хангайн бүсийн урд биеэр хээрийн бүс залган оршино (15, 35).

б. Хээрийн бүс. Энэ бүсийн сүрэгчид өвөл нь Гурван Богдын ар хөндийгөөр өвөлжиж тэндээс хаврын адаг сарын хуучаар нутаг өгсөн нүүж Баянзүрх уул (Ламын гэгээний төв хийд байрших газар) ба Цагаан эрэг хэмээх нутгаар очин зусдаг. Мөн тэндээс зуны сүүл сараас буцан нүүж Түй ба Өвгөн Шаргалжуут голуудын бэлчээрээс доош Улаан эрэг гэдэг газраар намаржина. Уул нутгаас нүүж Гурван Богдын ар орж өвөлждөг байжээ. Тийнхүү нүүдэллэхийн шалтгаан нь зуны цагт говьд хэт халуун, ялаа шумуул ихтэй, мөн мал сүрэг тарга тэвээрэг авах нь муу байжээ. Бас ламын гэгээний сан, жасын мал аж ахуйг тоолуулах, хүрээ хийдийн алба залгуулах зэргээс болж сүрэгчид нэн холоос нүүдэг байлаа. Тэдгээр нь одоогийн Богд сумын нутгаас Эрдэнэцогт сумын нутаг хүртэл нэг чиглэлд 160-180 км, бүгд 320-360 км, нэг талдаа 5-6 хоногийн турш нүүдэг байжээ. Үүнээс үзэхэд хээрийн бүсийнхэн жилд 12-16 удаа нутаг сольж 22-28 хоног нүүдэг байжээ (15, 35).

в. Говийн бүс. Шавь нутгийн хамгийн урд талаар тэмээн сүрэгчид нутагладаг байсан ба тэд өнөөгийн Баянхонгор аймгийн Баянговь Их Богд, Баруун Богд уулаас урагш буй говь нутаг Бүлээн, Алтан уул, Нимгэт зэрэг зүүн өмнө зүг нүүдэллэн явж өвөлждөг байжээ. Их Богд, баруун Богд уулын саваар өвөлжиж, хаварт тэр уулын ар хөндий ба Ар гурван голоор хаваржиж, улмаар нутаг өгсөж Түй, Өвгөн Шаргалжуут хоёр голын бэлчир хүртэл нүүж зусдаг. Чингэж одоогийн Баянговь сумын нутгаас

Өлзийт сумын нутаг хүртэл нүүдэллэхэд жилд ойролцоогоор 500-600 км нүүдэг байсан байна.

Эрдэнэ бандидын сүрэгчдийн нүүдлийн тухай товч дурьдахад ийм байна. Үүнээс үзэхэд Эрдэнэ бандид хутагт нь халхын томхон феодалуудын нэг байсны хувьд үйлдвэрлэлийн үндсэн хэрэгсэл болох газар, малыг өмчлөн шавь ард сүрэгчдээр мал сүргээ хариулуулж, нутаг орны аль үржил шимтэй хэсгийг өөрийн сүрэгт тасдан авч, сүрэгчдийн нутаглах нутаг, нүүдэллэх замыг тусгайлан зааж байсан явдал сүрэгчдийн нүүдэлд өвөрмөц хэлбэр буй болгож нүүдлийн тоо, урт, чиглэлийн хувьд зэргэлдээ хошуу, орон нутгийнхны нүүдлээс ялгагдаж байжээ.

Засагт хан аймгийн Дайчин ван Жалчин Гомбодоржийн хошуу гэгдэж байсан өнөөгийн Говь-Алтай аймгийн Тонхил, Шарга, Төгрөг, Бугат, Цээл, Дарви зэрэг сумдын малчдын нүүдлийн зарим байдлаас авч үзье (12, 44-47). Тонхил сумын малчдын Алтайн нурууны өвөр биеэр нутаглагчид зуны улиралд хойт, дунд, урд Хулдаар зусаж, намар Хүртэд, Хужирт зэрэг нутгаар намаржаад, Аргалант, Ам булаг, Хөндлөн, Сэртэн, Хөх дэл, Өвчүүт зэрэг нутагт өвөлжиж, Өвчүү, Шийрийн голоор хаварждаг ажээ. Мөн өнөөгийн Оргил бригадын дэвсгэрт нутаглагчид Хараат, Ямаат, Хөх морьтын нуруу, Агуйт зэргээр өвөлжиж байгаад Алтайн угалзын даваагаар урд Хулд руу, мөн Алтайн Цагаан чулуутын даваагаар дунд Хулд руу, Алтайн нам даваагаар хойт Хулд руу тус тус зунд хоёр дахин, хавар нэг удаа давж нүүн нутагладаг ажээ. Алтайн нурууг ийнхүү хэд дахин давж нүүдэг нь энэ нутгийнхны онцлог юм. Тэд нүүдлийн нэг чиглэлд 60-70 км, жилд дунджаар 100-130 км хүртэл нүүдэг байжээ. Мөн зарим малчид цагаан сар (хаврын эхэн сар) гаргаад Алтайн хойт руу даван хаваржиж, зуны эхэн сараар буцаж Алтайг давж нутагладаг. Харин Алтан соёмбо бригадын дэвсгэрт нутаглагчид Алтайн нурууны өвөрт, цөөн нь 7-8 удаа, олон нь 20 гаруй удаа нутаг сэлгэдэг ажээ.

Алтайн өвөрт нутаглагчид Тахийн шар нуруу, Аргалант, Хөндлөн зэрэг нутагт өвөлжиж, Өвчүү, Гурван Хулдын амаар хаваржин, түүний эхэнд зусаад, буцаж Гурван Хулдын ам нутгаар хаварждаг аж. Мөн Тонхил сумын Бүс бригадын дэвсгэрт нутаглагчид Хатан худаг, Бөөн чулуут зэрэг Алтайн ард өвөлжиж, Дэл, Цахирын орчимд хаварждаг байжээ. Тамчийн нутгаар аж төрөгсөд Хөх морьт, Бамбагар,

Ямаат зэрэг нутгаар өвөлжиж, Ацын эх, Баян цагаан, Шанд орчмоор хаваржиж, Алтайн Шанд, урд Баян хөндийгөөр зарим малчид даван Наран, Шарантай, Хужир орчмоор хаваржих бөгөөд тэд Алтайн өврөөр өгсөж Цахир булаг, Дунд цагаан царам орчмоор зуны эхэн сарыг өнгөрөөж, Алтайн ар руу давж Асгат Хойт, Урд Шандаар зусах, тэндээс уруудан Хөндлөн Ацын голоор намарждаг аж. Мөн сумын Алтайн оргил бригадын дэвсгэрт нутаглах малчид Агуй, Хараат зэргээр өвөлжиж, Алтайн Хязгаар өгсөн нутаглаж, Угалзын ам, Хар Ямаатаар хаваржиж, Алтайн өврөөр өгсөж Угалзын эх, Мөст зуслангийн голоор зусаж, Угалзын ам, Хойд Баян хөндий, Хулмын голоор намаржин өвөлжөөндөө нүүж очдог ажээ.

Мөст зуслангийн малчид Алтайн нуруунд буюу хоёр давааны хооронд нутаглах учир урд Хулд, Хойд Баян хөндийгөөр Алтайн ар руу намар орох, үлдэх улирлуудад нь Алтайн нуруунд нутагладаг онцлогтой билээ.

Тонхил сумын Усан зүйлийн нутгийн малчид сарлаг зонхилж малладагаараа өвөрмөц онцлогтой бөгөөд өвөлжөө нь гурван ихэр (нэг дор гурван өвөлжөөтэй), зуслан нь Зүйлийн голын эх, хавар болоход Зуун бугат, Гурван хашаат, Улаан нуруу, Хашаат зэрэг нутагт хаваржиж, Цахир тохой, Овоот булаг, Улаан ганга, Хөшөөтийн бэлчир зэрэг Зүйлийн голын дагуу нутагладаг ажээ.

Говь-Алтай аймгийн зарим сумдын малчдын нүүдлийг авч үзвэл Бугат, Төгрөг сумдын малчид Дарвийн нурууг нааш, цааш, даван нүүх, Алтай сумын малчид Ажийн нуруунд түшиглэн нутаглах, Чандман сумынхан Алтайн нурууны ар бие, Бигэрийнхэн Сэрхийн нуруу, Бурхан буудай хоёр уулын хооронд нутаглах, Тайшир сумын малчид Тайширын нурууны ар, өвөр, Завхан гол хүртэл нүүх байдлыг хураангуйлан дүгнэхэд:

Нэгдүгээрт, Алтайн нуруунд нутаг сэлгэх хэсэг, Хоёрдугаарт, Алтайн араас өвөр рүү давж нутаглах, мөн Алтайн өврөөс ар руу давж нүүх, Гуравдугаарт, Алтайн нурууг жилд хоёроос доошгүй давж нутаглагчид, Дөрөвдүгээрт, урсгал голын дагуу нутаглах хэсэг, Тавдугаарт, Алтайн өвөрт нутаглах хэсэг, Зургадугаарт, Алтайн ард нутаглах гэсэн 6 төрөлд ангилан ялгаж болох ба энд уулын, тал хээрийн болон говийн нүүдлийн гурван үндсэн чиглэл харагдаж байгаа юм.

Увс аймгийн Зүүнхангай, Өндөрхангай, Цагаанхайрхан сумдын элжгэн халхчуудын нүүдлээс товч өгүүлэх нь: (12, 52-53). Өндөрхангай сумын Цагаан нуурын бригадын малчид Хан Хөхийн Хорин бугат, Жаргалантаар даван нүүж, Хойт элсний өвөр, Шадын ар, Сэрвэн, Ар Уянга, Хэв, Хар, Цагаан усны бэлчирээр зусаж 7-р сарын сүүлчээр Улаан чулуу, Могойн билчирээр нутаглаж Боомын Сэрвэнгийн Ар улаан, Эрэг, Буурал, Жанжин, Тахилт, Сэрвэнгийн өвөрт нутаглаад Маргадын ар, Өлзийт нуруу, Шивээт зэргээр гарч өвөлжих, 3-4-р сард Хан Хөхийн нуруу өөд өгсөх, 5-р сард түүнийг даван нүүж нутаглах ажээ. Зарим малчид нь Хан Хөхийн Хорин бугатаар даван Чигжийн гол, Наран мандал, Цагаан нуурын зах, Тахилт, Цагаан нуурын урд араар болон Туулайт, Үнэгт, Маргад, Сангарга зэргээр хаваржин Хорин бугатаар дахин даван Баян айраг, Уст, Тугарын эрүү орж зусах, зарим нь Хангил цагийн гол, Есны аараг, Хонгор олом, Хойт булгаар орж намаржаад буцан Хан Хөхийгөөр даван Уушигт, Баруун Хөхийн өврөөр өвөлждөг ажээ. Ийнхүү малчид нэг чиглэлд 200 км урт замд нүүдэллэх бөгөөд бэлчээр товших аргаар жилд 25-27 удаа, дунджаар 20 удаа нутаг сэлгэдэг байжээ.

Халхын ястны төв, баруун нутгийн малчдын нүүдэл, суудлын чиглэлийг дээр дурьдсанаас товчлон дүгнэхэд:

XIX-XX зууны эхэн үеийн халхчуудын нүүдэллэх нүүдлийн өвөрмөц хэлбэр нь байгаль орчин, мал аж ахуйн маллагааны өвөрмөц арга барилаас үүдэн төрөл бүрийн хэлбэр үүссэн болохыг харуулж байна.

Ламын гэгээний шавийн харьяа байсан малчдын нүүдэл нь дэлхийн уртрагийн дагуу буюу хангай, тал, хээр, говь гурван бүсийг дамнан нүүх, тууш нүүдлийн чиглэлтэй мөн Жалчин Гомбодоржийн хошууны малчдын нүүдэл нь уртраг, өргөрөг хосолсон уулын нүүдлийн чиглэлтэй бөгөөд малчдын нутаг сэлгэлт нь товших аргаар малын бэлчээр ашиглах онцлогтой. Элжигин халхын малчдын нүүдэл нь Хан Хөхийг, өөрөөр хэлбэл уул нурууг давах нүүдлийн чиглэлтэй буюу малын бэлчээрийг өртөөлөн ашиглах өвөрмөц онцлог тус тусын ялгаатай ажээ. Малчдын нутаглах бүс нутгийн дотор нүүдэллэх байдлыг хураангуйлан авч үзвэл нэгдүгээрт: Алтайн нурууны өвөрт нүүгчид, хоёрдугаарт: Алтайн нуруунд нутаглагчид, гуравдугаарт: Алтайн нуруу, Хан Хөхийн нурууг даван нүүгчид, дөрөвдүгээрт: өндөр уул нурууг

жилд хэд дахин даван нутаглагчид, тавдугаарт:голын урсгал дагуу нутаглагчид, зургадугаарт, булаг, горхи, шанд худаг зэргийн ойролцоох малын бэлчээр нөөцлөн нүүгчид гэж задлан дүгнэж болох байна.

3.2 Мал сүрэг, ашиг шим

Биднийдээр өгүүлснээр мал аж ахуйн төрөл, байдлын талаар түүхийн янз бүрийн сурвалж, ном сударт элдэв мэдээ сэлт их байдаг талаар заримыг дурьдсан билээ.

Харин Монгол орны малын тоо толгойн тухай зөв мэдээ нь гадаадын ажил хэргийн хүмүүсийн сонирхлыг ихээхэн татаж байжээ. Ийм учраас гадаадын судлаачид, худалдаа, наймааны хүмүүс Монголын мал сүргийн баялгийг тооцох оролдлогыг аль хэдийнээс хийж байсан ажээ. Тийм үйл явц нь XX зууны эхээр, Монгол орон Манжаас тусгаарлан, тусгаар тогтнолоо зарласан үеэс ихээхэн идэвхтэй байсан юм.

3.2.1 Мал сүргийн тоо

Хэдийгээр Их Монгол улсын үеэс эхлэн, хожим хойно ч гэсэн түмт, мянгат, аймаг отогоороо малынхаа тоог гаргаж, их хаанд мэдээлэн алба гувчуур төлдөг журам байсан боловч мэдээлж тараадаггүй байсан бололтой.

Богд хаант Монгол улсын Засгийн газраас 1918 онд мал тооллого явуулахаас өмнөх Монголын малын тоог тодорхойлох гэсэн оролдлогууд нь ихээхэн хийсвэр, үндэслэл муутай байсан нь тун илэрхий байдаг билээ. Энэ талаар хэдэн тодорхой жишээ дурдаж болох юм.

Жишээ нь, XX зууны эхэн үед Хиагтын төмөр замын тухай болсон зөвлөлгөөнд оролцогчид Монголын малын тоог барагцаалахдаа адуу 25 сая, үхэр 20 сая, тэмээ 2 сая, хонь 75 сая, бүгд 1222 сая гэжээ. Э.Циндель гэдэг хүний хэвлэлийн газраас нийтлүүлсэн өөр нэг мэдээгээр бол мөн тэр үед Монголын малын тоог авч үзэхдээ адуу 12,5 сая, үхэр 7.5 сая, тэмээ 1 сая, хонь 25 сая бүгд 46 сая гэжээ¹⁶. Түүнчлэн 1910 онд Монголд байсан Москвагийн худалдааны экспедицийнхэн гадаад монголд адуу 7.5 сая, үхэр 10 сая, тэмээ сарлаг 2 бум, 2 түм, 5 мянга, хонь, ямаа 20 сая, бүгд

37 сая 7 бум, 2 түм, 5 мянган толгой малтай хэмээн тооцоолжээ.¹⁷ Мөн Оросын судлаач А.П.Беннигсен “Орчин үеийн Монголын тухай зарим нэг тоо баримт» хэмээх номондоо¹⁸ 1912 онд Ар Монголын малын тоог адуу 1 сая, 4 бум, 5 түм, үхэр 1 сая, 3 бум, 5 түм, тэмээ 3 түм, хонь, ямаа 11 сая, бүгд 14 сая, 1 бум толгой гэж тодорхойлжээ. Түүнчлэн монгол судлаач А.П.Болобан “Монгол, түүний орчин үеийн худалдаа, эдийн засгийн харьцаа” гэдэг номондоо¹⁹ болохоор адуу 2 сая, үхэр 1 сая, тэмээ 1 бум, 2 түм, 5 мянга, хонь, ямаа 10 сая, бүгд 13 сая, 1 бум 2 түм, 5 мянга гэсэн нь нилээд ойролцоо байж болох тоо оруулсан байх юм. Тэгэхээр Монголын малын тооны тухай дээрх тоо баримтуудын дээд, доод хязгаарын хооронд бараг 10 дахины зөрүү байгаа нь гайхалтай санагдана.

Богд хаант Монгол улсын Засгийн газар 1918 онд малын тооллого явуулсан явдал нь тус оронд анх удаагаа малын тоог илүү бодитойгоор тоймлох боломж олгосон хэрэг юм. Гэхдээ мал тооллогонийг хязгаар нутгийг хамарч чадаагүй тул дахин нэмэлт тооцоо хийх шаардлагатай болсон байжээ. Уг тооллогыг явуулахдаа эхлээд малаа биечлэн тоолоогүй, хүмүүсээс асууж бүртгэж авах журмаар хийсэн учраас анхны дүнгээр ердөө л 5.3 сая малтай гэсэн тоо гарсан байжээ. Үүнийг илэрхий ташаа болсон, их хэмжээний мал дутуу тоологдсон гэж үзээд хоёр дахь удаагаа тооллого явуулахад малын тоо 7.7 сая болжээ. Гэвч энэ нь бас л дутуу тоо байжээ. Нэгд, Богдын шавь нар албан татвараас чөлөөлөгдөж байсан тул халх 4 аймгийн шавь нарын болон Хөвсгөлийн их шавийн мал хүн тоологдоогүй. Хоёрт, Ховдын хязгаар нутаг нь хэдийгээр тус орны нэг хэсэг нь байсан боловч Автономит Засгийн газраас явуулж байсан арга хэмжээнд тэр болгон хамрагддаггүй, бие даасан байдалтай байсан тул малын тооллогод хамрагдалгүй үлджээ.

Монголын олон тооны мал худалдан авч байсан Оросын “Центрсоюз” хэмээх худалдааны байгууллагын Эрхүү дэх салбараас зохион байгуулж, 1919-1920 онуудад Монголд ажиллуулсан экспедицийн ахлагч, сүүлдээ Оросын монгол судлаач, нэрт эрдэмтэн, академич болсон И.Майский 1918 оны мал тооллогын материалыг ашиглан малын тоог дараахи байдлаар тодорхойлсон тухайгаа өөрийн зохиолд тэмдэглэсэн ажээ²⁰. Тухайлбал:

1. Халх дөрвөн аймгийн ноёд тайж, лам нар, сүм хийдийн болон жирийн малчин ардуудын мал тооллогын тоог гол үндэслэл болгосон.
2. Мөн халх дөрвөн аймаг дахь Богд гэгээний шавь нарын мал тооллогод хамрагдаагүй байсан тул жирийн малчдын нэг хүнд ноогдох малын дундаж тоог дөрвөн аймаг дахь шавь нарын тоогоор үржүүлэх аргаар тооцсон.
3. Хөвсгөл нутгийн Богд гэгээний шавь хошуу, Дархадын малын тоог газар дээр нь материал цуглуулах аргаар тодорхойлсон.
4. Баруун талын Ховдын хязгаарт бол ноёд, сүм хийдийн малын тоог мэдэх хүмүүсээс нь шууд асуух замаар нийт жирийн малчдын малын тоог болон Богдын шавь нарын малын тоог тооцооны аргаар тогтоосон байжээ.

Тийнхүү 1918 оны мал тооллогын материал болон тооллогод хамрагдаагүй Богдын шавь нар, Ховдын хязгаарын малыг дээрх аргаар нэмж тооцоолоход нийт малын тоо 9 сая 6 бум 4 түм 5 мянга 5 з|уун 63 (9,645,563) толгой, үүнээс адуу 1 сая, 1 бум, 5 түм, 5 мянга /1,150, 511), үхэр 1 сая, 7 түм, 8 мянга (1,078,407), тэмээ 2 бум, 2 түм, 8 мянга /228,640/ гаруй, бог мал 7 сая, 1 бум, 8 түм, 8 мянга (7,188,005) байсан хэмээн үзэж, уг тоог албан ёсны бүртгэл материалд баримталдаг болсон байна.

Бидний дээр дурьдсан И.Майский Монголын мал тооллогын дүнгээр гарсан тоо нь бодит тооноос ойролцоогоор 30 хувиар доогуур болсон гэж үзээд гадаад Монголын малын тоо 1918 онд 12.7 сая, үүнээс адуу 1.5 сая, үхэр 1.4 сая, тэмээ 300 мянга, хонь, ямаа 9.5 сая байсан хэмээн тооцоолжээ.²¹

Монгол улсад тус орны эдийн засгийн хэтийн хөгжлийн асуудлыг боловсруулах тусгай комисс 1923 онд томилогдон ажиллаад “Эдийн засгийн үндсэн бодлого” хэмээх баримт бичиг боловсруулахдаа малын тоог төрөлжүүлэн гаргажээ.

Дээрх малын тоог тэр үеийн аймгаар үзүүлбэл:

Аймаг	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь, ямаа
1. Цэцэн хан	24,929	191,913	165,724	1.182,341
2. Түшээт хан	70,101	286,304	229,345	1,921,062

3. Сайнноён хан	60,996	307,912	327,890	1,942,255
4. Засагт хан	20,645	117,290	118,444	1,098,121
5. Ховдын хязгаар	25,625	102,972	89,350	711,700
6. Сүм хийдийн жас	24,932	114,620	114,620	770,950
7. Хөвсгөл дэх Их шавь	1,412	29,500	33,034	61,576
Бүгд	228,640	1,150,511	1,078,407	7,188,005

(7-р хүснэгт)

Монголд автономитын үед 13 сая малтай байсан гэж үзэж байжээ. Үнэхээр тэр үеийн гаалийн бүртгэлээр жилд дунджаар 7 түмэн адуу, 1 бум үхэр, 6 бум, 6 түм, 7 мянган хонь, 1 бум, 3 түм, бүгд 9 бум, 6 түм, 9 мянга буюу бараг л 1 сая мал экспортод гаргаж байсан мэдээ байдаг юм. Түүнчлэн И.М.Майскийн экспедицийн гаргасан Монголын өрхийн төсвийн мэдээг үндэслэн үзвэл, нэг хүн амд 97 кг мах буюу улсын хэмжээгээр 1.3 сая малыг хүнсэнд хэрэглэж байсан бололтой. Тэгэхээр гаалийн мэдээ болон өрхийн төсвийн судалгаагаар жилд даруй 2 сая, 3 бум мал зарлагдаж, малын тоо 9.6 сая биш, 12-13 сая байсан гэдэг нь илүү үндэслэлтэй байж болохоор байгаа юм.

Монгол оронд 1921 онд үндэсний хувьсгал болж хэмжээг Богд хаант улс тогтсон үед орон нутгийн засаг захиргааг зохион байгуулах, албан татварыг тэгшитгэх, эдийн засгийн арга хэмжээг хэрэгжүүлэхийн тулд хүн ам, малын тоог байршилаар нь үнэн зөв гаргах явдал чухал болсон ажээ. Тийм учраас юуны өмнө 1918 оны тооллогын материалыг судлан үзэх шаардлага гарч байсан нь ойлгомжтой хэрэг юм. Энэ зорилгоор Ардын газраас Дотоод яамнаа тусгайлан албан бичиг толилуулж байсныг доор сийрүүлбэл: *“Монгол Ардын Засгийн газраас Монгол Ард Улсын Дотоод яамнаа хуудас явуулах учир мөнөөхөн олноо өргөгдсөний наймдугаар онд Дотоод яамнаас байцаан тодорхойлуулсан олон аймаг, хошуу, шавийн хүн ам, хөрөнгө малын тооны бичиг данс ба бас энэ жилийн хавар цаг Барон Фитенгээс хөрөнгө малын тоогоор алба татах санал гаргаж өргөсөн орос, монгол бичгийг*

байцаан үзэх хэрэг бий тул үүнийг эрхэм яамнаа хуудсаар явуулав. Эдгээр бичиг данс зүйлийг манай газар хүргэн ируулнэ үү” гэжээ.

Ямар ч байсан энэхүү мэдээ баримт нь Монгол улс нь 1918 оны улмаар 1920-иод оны эхэнд буюу феодалын нийгмийн сүүлийн үед лавтай 13-14 сая малтай байжээ гэдэг дүгнэлт саналыг бататгаж байгаа болно.

3.2.2 Малын төрөл, ашиг шим

Монголын нэг гол онцлог бол таван хошуу малаа тал дүүрэн бэлчээсэн орон гэж нэрлэгддэг явдал мөн. Монгол орон олон мянган жилийн өмнөөс л адуу, үхэр, тэмээ, хонь, ямаа хэмээх таван төрлийн өсгөн адуулж байсан нь зүйлүүдээс нэн тодорхой билээ.

Тийм болохоор малын төрөл тус бүрийн онцлог, ашигт чанарын талаар тоймлон өгүүлье.

-Адуун сүрэг

Адуу бол хэдэн мянган жилийн өмнөөс гэршсэн малын нэг бололтой байдаг юм. Жирийн амьдралын нэгэн цицдоос эхлэн өгүүлэх аваас, номын зохиогч хүмүүн Японы их сургуульд хичээл зааж байхдаа оюутнуудаас Япон оронд хэдий үеэс малтай болсон бэ гэсэн асуулт тавихад тэрхэн үедээ тоймтой хариу хэлэх оюутан байгаагүй бол дараачийн хичээл дээр оюутан Накамура: анх 3000 жилийн өмнө Монгол гаралтай адуу Японд ирсэн тухай “Японы хөдөө аж ахуйн түүх” гэдэг номонд бичсэн байна хэмээн хариулж байсан билээ. Үүнэс үзэхэд адуу анх Монгол оронд бий болж, тэндээс бусад оронд тархсан ч байж магадгүй бололтой.

Монголчууд бид өөрсдөө Монгол адуугаа бусдаас илүүтэй сайн мэддэг, олон талын дэлгэрэнгүй зүйл бичиж болох авч, эхлээд гадаадынхан манай адууны тухай хэрхэн бичсэн байдаг талаар зарим нэгэн баримтыг дурьдсу.

Оросын эрдэмтэн В.Васильев Монголын тухай бичсэн номондоо хятадын сурвалж бичигт монгол адууны тухай хэрхэн өгүүлснийг иш татсан нь: “Тэд адууг унага, даага байхаас нь дасган сургаж, гурван жил дараалан унаж эдлээд дараа нь алив хэрэгт

хэрэглэнэ. Анхны үед өшиглөж хазахгүй болгож дасгадаг. Мянган адуу нэг сүрэг болох бөгөөд түүний дотроос ганц ч морь дэмий янцгаахгүй. мориноос буугаад аргамжих хэрэггүй, сул тавьсан ч морь нь холддоггүй юм. Морины чанар онцын гайхамшигтай: өдөржин өл авахгүй, гагцхүү шөнө ногоотой, халцгай ч хамаагүй аль тохиолдсон газарт бэлчээрлүүлэн сул тавьж хоноод үүрээр дахин эмээллэн мордмуй. Морио вандуй, шар будаагаар тэжээхийг огт мэддэггүй. Хүн бүхэн аян дайнд мордохдоо хэд хэдэн морьтой явж, өдөр өдрөөр сэлгэж унадаг. Үүний учир нь морь нь эцэж цуцаж үхдэггүй болой”²² гэжээ. Энд тухайн үед монголд адууг хэрхэн сургаж унаж эдлэдэг талаар ажиглалтаа илэрхийлэн бичсэн болох нь ойлгогдож байна. Ийнхүү бичсэн шиг морь болгон ч чөдөрлөхгүй, эсвэл аргамжихгүй сул тавихад нэг байрандаа байгаад байдаг биш гэдэг нь Монгол хүнд бол мэдээжийн хэрэг билээ.

Түүнчлэн гадаадынхан монгол адууг жижигхэн биетэй, тэгэхдээ ихээхэн даамгай, тэсвэртэй гэж тодорхойлох нь элбэг байдаг. Жишээ нь бидний нэгэнт дурьдсан Оросын монголч эрдэмтэй И.Майский бичихдээ: “Монгол адуу бол жижигхэн биетэй, миний хэмжилтээр тэдгээрийн дундаж өндөр нь 126-130 см толгой томтой, богинохон хүзүүтэй, шулуухан нуруутай, хөл нь урт биш ч гэсэн хүчтэй, туурай нь хатуу, шүд нь сайн, биеийн галбирын хувьд тийм ч гоё сайханбиш боловч чадал тэнхээ, хатуужил тэсвэрийн хувьд гайхалтай сайн юм” гэжээ.

Монгол адуу бол маллагааны хувьд жилийн дөрвөн улиралд бэлчээрийн өвс ногоогоор хооллодог, зун намартаа тарга тэвээрэг авдаг, өвлийн цагт цас ихтэй болсон үед алсын отор бэлчээрт хэдэн төө сөөм зузаан цасан дороос ч өвс гарган идэж чаддаг онцлогтой юм.

Адуу хэдэн зуугаараа, заримдаа мянгаараа сүрэглэн бэлчээрлэнэ. Тэхдээ адууны бусад төрлийн малаас ялгагдах нэг өнөрмөц азрагаараа сүрэглэн тоологдоно. Нэг азраганд 15-20 гүү хураалгадаг бөгөөд нэг азрага адуу бол унага даага, бусад морьдтой нийлээд 40-50-иад адуу байдаг. Малчин ардууд ихэвчлэн төдөн азрага адуутай гэж ярьдаг юм.

Монгол адууны ашигт чанар олон талтай байна. Нэгдэх гол ашигтай тал нь унааныхэрэгсэл болдог явдал юм. Монголчууд хэдэн мянган жилийн өмнөөс аян дайнд явах, ан гөрөө хийх, хариулах, айлчин гийчнээр зочлох, өртөө улааны албыг залгуулах зэрэг нүсэр их хэрэгцээг адуун сүрэг, агт морьдын хүчээр л гүйцэтгэж ирсэн ньтодорхой билээ. Манай эрин тооллын өмнөх баларэртнийүеэс эхлэн энэ ХХ зууны эхэн үед ч гэсэн дэлхий дахинд болж байсан олон удаагийн дайн байлдааны ажиллагааг авто техникийн хэрэгсэл гараагүй байх үед агт морины хүчээр хийж билээ.

Агуу их Чингис хаан, түүний залгамжлагч их хаад Их Монгол улсыг, улмаар Монголын эзэнт гүрнийг эмхлэн бүрэлдүүлэх үйл хэргийг адуун сүргийн хүчээр гүйцэтгэсэн нь тодорхой юм.

Эдүгээ авто тээврийн хэрэгсэл элбэг болсон боловч манай малчин түмний өдөр дутмын унааны хэрэгцээг хангасаар байна.

Адуунсүргийн хоёрдахьашиг шим нь айрагсүү юм. Монголчуудэрт үеэс гүүгээ сааж айрагаа эсгэн ууж ундаалдаг байжээ. Монголын нууц товчоонд айраг, хөхүүр, бүлүүрийн тухай нэг биш удаа тэмдэглэн бичсэн байдаг билээ. Монгол хүмүүс айргийг өдөр тутмын хүнс ундаа болгож, өтгөс буурлуудаас эхлэн хүүхэд багачууд цөм л ууж хэрэглэдэг жирийн зүйл мөн боловч бас хурим найр, наадам цэнгээний нэг гол идээ ундаа болгодог бөгөөд хэрвээ найр наадамд айраг байхгүй бол нэг л томоохон юм дутаад байх шиг болдог юм.

Манай зарим эрдэмтэд айрагны чанар найрлагыг тун сайтар судалж, айраганд хүний биед чухал ач холбогдол бүхий олон янзын амин хүчил А,Д,Е,К зэргийн төрөл бүрийн витамин, 1.8-2 хувийн тос, тосны олон төрлийн сул хүчил, 1.5-2 хувийн спирт, сүүний хүчил, янз бүрийн язгуур махбодь байдгийг тогтоожээ. Ийм учраас гүүний сүү, айраг бол жирийн ундаа төдий бус, мөн эмчилгээний чанартайбайдаг тул айрагны эмчилгээ, сувилгааны газрууд болон жирийн айл хунарт гүүний айраг, сүүг эмчилгээний журмаар ууж хэрэглэнэ. Ялангуяа сүүлийн үед цагаан гүүний бүлээн саамыг зэлэн дээр нь шууд уух явдал элбэг болоод байна. Манай монголчууд зун,

намрын цагг гүүгээ барьж, унагаа зэллэхдээ гүүний үрс хэмээх ёслол найр хийх заншилтай байдаг.

Гүүг өдөрт 5-7 удаа саах бөгөөд оройдоо унагаа тавьж адуугаа бэлчээрт гаргадаг, нэг гүүнээс саалийн хугацаанд дунджаар 50 орчим хувин сүү саадаг юм.

Монгол улсад нэн сайхан айраг эсгэдэг тодорхой зурвас бүс нутаг байдаг билээ. Түүнд Булган аймаг, Архангай, Өвөрхангайн зүүн талын сумд, Төв аймаг, Дундговь аймгийн хэсэг сумд багтдаг ажээ.

Адууны гуравдахь сайн тал бол махны хэрэглээ юм. Монголчууд эрт дээр үеэс адууны махыг хоол хүнсэндээ хэрэглэж ирсэн ажээ. Халх монголчууд бол адууны махыг өвлийн цагт идшиндээ гол төлөв бүхэл мах чанаж идэх хэлбэрээр хэрэглэдэг юм. Адууны мах өвөл хүйтэнд царцахгүй онцлог чанартай байдаг тул хөргөж идэхэд аятайхан байдаг. Харин эрт үеийн гадаадынхны тэмдэглэлд “адууны махыг эрхэмлэж ёслолын хурим, хүлээн авалт, найр наадамд хэрэглэдэг байв”²³ гэсэн байдаг ажээ.

Эдүгээ цаг үед бол адууны махыг найр хуримын идээ, зоог болгон тавих явдал ер тааралддаггүй юм. Адууны мах монголчуудын махны хэрэглээнд нилээн хувь хэмжээг эзэлдэг, бас янз бүрийн аргаар боловсруулдаг бөгөөд мөн адууны махыг хүний биенд сайн, даралт ихэсгэхгүй сайн чанартай хэмээн үздэг тал бий.

Манайд адууны махны чанар найрлагыг эрдэмтэн Ж.Гунгаа судалж адууны маханд уураг 21.4 хувь, тос 13.5 хувь, чийг 64.3 хувь, үнс 0,85 хувь байдаг, 1 кг махны илчит чанар 2186.4 ккал, мөн олон янзын амин хүчлүүд, фосфор, кальц зэрэг химийн язгуур махбодь байдгийг тогтоосон ажээ. Адууг урьд нь Зүүн Европ, хуучны ЗХУ-д экспортонд олон мянгаар нь гаргадаг байсан бол эдүгээ Япон улсад адууны махыг гаргадаг болоод байна. Гадаадын цэвэр цусны үүлдрийн адууны амьдын жин 470-490 кг байдаг бол монгол адуунаас 360-380 орчим кг байдаг юм.

Адууны дөрөвдэх ашиг шимт чанар бол хөөвөр, хялгас нь үйлдвэрийн болон аж ахуйн чухал түүхий эд болдог, олон арван жилийн турш экспортын бүтээгдэхүүний нэгэн төрөл болсоор ирсэн юм. Гадаадынхан адууны их биений үсээр гуа сайхны бийр будгийн багс хийдэг юм билээ.

Адуун сүргийн тавдахьондлог чанар бол хурдан морины уралдаан, найр наадам, спорт тэмцээний нэгэн гол төрөлбайдаг явдал юм. Манай монголчууд эрт дээр үеэс эрийн гурван наадам хийж, хурдан морьдоо уяа сойлгыг нь тааруулан уралддаг сайхан уламжлалтай билээ. Монголын морин уралдааны гол онцлог болб насны төрлөөр хол зайнд бага насны хүүхдүүд унаж уралддаг юм Монгол морины өвөрмөц шинж нь нэгд, алс уналгын сайн чанартай, хоёрт, уралдааны хурдан шинжтэй байна. Сайн унаарынморь бол алс замд явахад өдөрт 200 км замыг туулах, хэдэн өдрийн уналгыг даах чадвартай байдаг. Монголын малчин түмэн маань хурдан морийг шинжээр нь танин мэдэх, уяа сойлгыг тааруулануралдуулах онгой авьяас мэдлэгтэй, түүгээрээ баясал цэнгэл, бахархалтаашаал болгож, алдар нэрээ дуурсгаж ирсэн өнө эртний өгөөмөр сайхан уламжлалтай.

Монголын морины уралдааны бусдаас ялгагдах онцлог нь хол зайнд хүүхэд багачууд унаж уралддаг явдал юм. Их насны морьдыг 28-30 км зайнд уралдахад түрүү морьд барианд ортол 40-өөд минут давхидаг юм. Энэ байдлаас үзвэл, цагт 45-50 км-ын дундаж хурдтай, гарааныхаа үед 70-80 км цагийн хурдтай давхисан байдаг билээ. Монгол адуу ч бас хурдны төрөлхийн шинж, удам угсаагаараа нутаг нутагт өөр өөр байдаг. Жишээ нь Зүүн Монголд бол Галшарын адуу, баруун монголд Тэсийн голын адуу хурдан хэмээн алдаршсан байна. Түүнчлэн хуучны Цэцэнхан аймгийн Далай вангийн хошууны нутаг одоогийн Сүхбаатар аймгийн Уулбаян сумаас гаралтай Орлойн удмын хурдан адууны тухай сүүлийн үед их яригдаж байна. Энэ нь тус суманд Орлойнхон гэж асар их хөрөнгө малтай ах дүү гурван баян хүмүүс алдартай хурдан адуутай байсан юм. Нугалааны үеэр буюу 30-аад оны эхээр мал хөрөнгө нь хураагдахад адуун сүрэг нь одоогийн Сүхбаатар аймгийн эргэн тойрны сумд, Хэнтий аймгийн өмнөт талын болон Дорноговийн зүүн талын сумдаар тарж, энэ бүс нутгийг хурдан удамшлын адуутай болгосон хэрэг байжээ.

-Үхэр сүрэг

Монголын үхэр сүрэг бол аж ахуйн ихээхэн ач холбогдолтой халуун хошуутай малын нэг юм.

Үхрийн тухай Монголын нууц товчоо болон бусад эртний сурвалж бичигт Монголчууд голдуу үхэр өсгөдөг, хонь, үхрийн мах идэж, сүүг нь уудаг, шар (эр) үхрийг гагцхүү тэргэнд зүтгүүлнэ, үхрийг хоёр аралтай тэргэнд хөллөж байсан, Монгол үхэр бол бие томтой, явах тэнхээгээр асар их гэх мэтээр бичсэн явдал нилээд тааралддаг. Энэ бүх бүх байдлаас үзвэл үхрийн аж ахуйн хэрэгцээ дээр үеэс их байсан, эртний уламжлалтай болох нь тодорхой байна.

Монгол үхэр бол мөн л жилийн дөрвөн улиралд бэлчээрт өөрсдөө идээшлэнэ. Өвлийн цагт нилээн турж эцдэг бөгөөд жингээ 20 хувь хүртэл алдана.

Үхрийн сүү үйлдвэрлэл 1940-1990 оны хооронд 186.8-273.8 мянган тонн байсан мэдээ гарсан байдаг юм. Хамгийн дээд тал нь 1956 онд 5730 тонн цөцгийн тос үйлдвэрлэсэн байжээ. Харин 1991 оноос эхлэн цөцгийн тосны үйлдвэрлэл багассаар 1995 он гэхэд бараг байхгүй болжээ.

Үхэр сүрэг нь дотроо ердийн монгол үхэр, сарлаг гэсэн хоёр янзын өвөрмөц төрөлтэй байна. Сарлаг бол гол төлөв хангайн бүсэд өндөрдуултай газар илүү нутагшсан байдаг. Сарлаг нь монгол үхрээс арай өндөр боловч жингээр бага, үс хөөвөр ихтэй, хүйтэнд ихээхэн тэсвэртэй мал юм. Сарлагийн сүүний гарц монгол үхрийнхээс бага боловч тослог ихтэй байдаг.

Монгол үхрийн бух, сарлагийн үнээний дундаас хайнаг гардаг бөгөөд хэд хэдэн давуу талтай байдаг юм. Хайнагийн шар бол ердийн монгол эр үхрээс илүү том, ялангуяа тэргэнд хөллөхөд хүчтэй байна. Хэрэв сарлагийн мах шаравтар өөхтэй, нилээн хатуу байдаг бол хайнагийн мах чанарын хувьд монгол үхрийн махтай адил, амт чанар сайтай байдаг. Хайнагийн үнээ сүүний гарцын хувьд сарлагаас бараг 2 дахин, монгол үнээнээс бараг 30-аад хувиар их бөгөөд сүүний тослог нь монгол үнээнийхээс дээгүүр, сарлагийнхад хүрэхгүй, дундаж хэмжээнд байна. Харин сарлагийн бух, монгол үнээний дундаас гарсан эрлийзийг ортом гэж нэрлэдэг бөгөөд ерөнхийдөө цөөвөр тоотой байдаг ажээ.

Үхэр сүргийн аж ахуйн ашигт чанар олон талтай байна. Нэгдэхчанар нь үхэр бол сүү, цагаан идээнийгол эх үүсвэр юм. Монгол үнээг хавар төллөх үеэс эхлэн намар нилээн орой хүртэл өдөрт 2 удаа саадаг.

Монгол үхэр задгай бэлчээрт, байгаль цаг уурын нөхцөлд зохицсон мал болохоор угаасаа сүү махны чиглэлээр бий болгосон цэвэр үүлдрийн үхэртэй адилгүй, сүү, махны гарцаар бага байдаг. Монгол үнээний сүүний гарцыг хэмжилтийн аргаар судлан үзвээс жилдээ 60 хувин сүү саасан байдаг юм. Түүнчлэн манай улсад 1940-өөд оноос 1990 он хүртэл цөцгийн тос бэлтгэж байх үед нэг үнээнд саалийн хугацаанд 400 литрээр бодож сүү, тосны тасагт сүү нийлүүлэх норм ноогдуулж байсан юм. Тийнхүү манай үнээниисүүний гарцыг хувингаар болон литрээр гаргасан хэмжээ нь үндсэндээ тохирч байгаа нь ажиглагдана.

Монгол үхрийн хоёрдахь гол ашигт чанар бол махны хэрэгцээг хангахад чухал үүрэгтэй байсаар ирсэн явдал юм. Эр үхэр, сувай үнээний амьдын жин 300-400 кг хүрдэг. Нядлагааны жин буюу махны гарц нь амьдын жингийн 50 орчим хувьтай тэнцдэг ажээ. .

Үхрийн мах бол монголын нийт махны хэрэгцээний 30 орчим хувийг хангаж ирсэн уламжлалтай юм. Монголчууд эрт дээр үеэс эхлэн зуны дэлгэр цагт сүү цагаан идээгээр дагнан хооллодог заншилтай байсан тул хөдөө нутагт бол ХХ зууны сүүлийн хагас хүртэл зундаа үхэр нядлах явдал огт байхгүй байлаа.

Аж ахуйн гуравдахь ашигтай тал бол үхрийн ширний уламжлалт хэрэглээ юм. Манай малчид хэзээнээсээ үхрийн ширийг өөрсдөө шүүлэн элдэж, улмаар сур, аж ахуйн хэрэгцээний хазаар ногт, татлага хийхээс гадна гутлын ул, эмээлийн гөлөм, дэвс хийдэг уламжлалтай юм. Мөн энэ өнгөрч буй зууны 30-аадоноос эхлэн үхрийн шир боловсруулах үйлдвэр байгуулж, дотоод хэрэгцээний болон экспортын олон нэр төрлийн бүтээгдэхүүн хийдэг болсон явдал нь өндөр үр ашигтай хөнгөн аж үйлдвэрийн нэгэн чухал төрлийг хөгжүүлсэн ихээхэн ач холбогдолтой үйл хэрэг байлаа.

Үхрийн аж ахуйн дөрөвдэх ашигтай чанар нь хөөвөр, хялгасны бэлтгэл юм. Хавартаа үхрээ хөөвөрлөж, сарлагийн савагүсийг бэлтгэлд өгдөг уламжлалтай билээ. Монголд жилдээ 1300-1595 тонн бодын хөөвөр бэлтгэж ирсэн уламжлалтай бөгөөд түүний 60-65 хувь нь үхрийн хөөвөр байлаа. Бод малын хөөвөр, хялгас нь

дотооддоо үйлдвэрийн түүхий эд болдогоос гадна, экспортонд гардаг нэгэн төрлийн бүтээгдэхүүн юм.

Үхрийн тавдахь үр ашигтай тал нь хөсөг,унааны хэрэгсэл болж ирсэн явдал юм. Монголчууд эрт үеэс эр үхрийг нүүдэл суудал хийх, ачаа бараа зөөхдөө тэргэнд хөллөдөг, унаж эдэлдэг уламжлалтай билээ.

Түүхийн лавтай сурвалж мэдээгээр дундад зуунд монголчууд гэрээ тэргэн дээр байнгалан байрлуулсан байх үед гэр тэргээ хоёр эгнээгээр тус бүрт 11, бүгд 22 шар үхэрт хөллөн нүүдэг байсан ажээ. Тэгвэл энэ өнгөрч буй 20 дугаар зууны дунд үеэс л элдэв машин техник элбэг болсон, мөн мах бэлтгэл нэмэгдэж эр үхэр ховордсон зэрэг шалтгаанаар ердийн хөсөг тээвэр хэрэглэх явдал эрс багассан юм. Ер нь 1950-иад оны дунд үе хүртэл үхэр тэрэг хэрэглэх явдал хаа сайгүй элбэг байсан бол эдүгээ хангайн бүс нутагт багахан хэмжээтэй үлдсэн, харин тал хээр, говийн аймгуудад тун ховорджээ.

Үхэрсүргийн зургаадахь ашигтай зүйл бол баас нь аргал түлшний хэрэгцээг хангадаг явдал мөн билээ. Манай улсын мод түлээ ховор тал хээр, говийн бүс нутагт үхрийн аргал нь түлшний хэрэгцээг голчлон хангадаг юм. Ялангуяа нүүрс ашиглахгүй байсан үед үхрийн аргал, хонины бууцны хөрзөн л түлш болдог байлаа. Одоо ч зарим нутагт үхрийн аргал л гол түлш болж байна. Хангайн бүсд ч гэсэн ой модыг түлш болгон сүйтгэж байхын оронд үхэр олонтой аймаг, иий үхрийнхээ аргалыг түлж байвал тун зохистой болохсон билээ. Түүнчлэн үхрийн бааснаас шатдаг хий ялгаруулан түлшинд хэрэглэдэг дэлхий дахины туршлага ч байгаа, манайд ч зарим эрдэмтэн тийм туршилт хийж үр дүнтэй болохыг тогтоосон юм.

-Тэмээн сүрэг

Монголчууд мөн л эрт үеэс эхлэн тэмээ маллаж ирсэн уламжлалтай байна. Манай монгол нутагт одоогоос 4000-5000 жилийн өмнөөс тэмээ гаршуулсан хэмээн нилээд эрдэмтэд үздэг байна²⁴.

Чингэхдээ Монголын хоёр бөхт тэмээний өвөг бол манай говь нутагт байдаг зэрлэг тэмээн гөрөөс хавтгайг гэж үзэх болжээ. Эртний судар бичиг, ялангуяа

Монголын нууц товчооны хэд хэдэн зүйлд тэмээний тухай тэмдэглэн бичсэн байдаг билээ.

Тэмээ бол говийн бүс нутагт гойд зохицсон мал бөгөөд бараг 70 орчим хувь нь говь нутагт идээшилж ирсэн уламжлалтай юм.

Тэмээ бол говийн бут бударгана, харгана шаваг зэрэг ургамлаар хооллодог. Хэд хоног өнжиж ус уудаг, өвлийн цагт олон хоногоор өл хоолгүй алс холын аян жинд явдаг өвөрмөц, гойд тэсвэртэй олон талын ашиг шимтэй мал юм.

Тэмээн сүргийн нэгдэхашиг шимт чанар нь ноос бөгөөд дотоодын хэрэгцээний болон экспортын ихээхэн ач холбогдолтой, уг аж ахуйн нийт орлогын 70 гаруй хувийг эзэлдэг юм. Манай тэмээний ноосны гарц нь нас, хүйсний байдлаас шалтгаалдаг нь ойлгомжтой хэрэг билээ. Тухайлбал, тэмээ судлаач эрдэмтэн Б.Лувсан судалгааныхаа үр дүнд нэг настай тэмээ 2,647-2,814 грамм, хоёр настай нь 2,697-3,928 г, гурван настай нь 4,595-4,703 г, дөрвөн настай нь 4,701-5,162 г, зургаа болон түүнээс дээш настай ат 5,285 г, ингэ 5,228 г, нас гүйцсэн буур 8,135 г ноостой байдгийг тогтоосон байна.

Чингэхдээ монгол тэмээн сүргийн дотор их хэмжээний ноостой шилмэл омгийн тэмээ бас байдаг юм. Жишээ нь Галбын улаан тэмээ, Хэцийн хүрэн, Төгрөгийн хар зэргийн зарим омгийн 10-аас дээш кг, заримдаа 16-18 кг ноостой байх тохиолдол байдагажээ. Түүгээр ч барахгүй эрдэмтэн М.Төмөржавын тэмдэглэснээр амьдын жин нь 700 кг хүрдэг, 20-25 кг ноос өгдөг генийнсан бүхий гоц ашиг шим бүхий буур тааралддаг байна.

Тэмээний ноосыг ашиглалт-технологийн шинж байдлын хувьд дотор нь ноолууран ноос, сор үс, завсрын буюу заримдаг үе гэж ангилдаг бөгөөд ноолууран зөөлөн ноосны эзлэх хувь илүүтэй байдаг. Монгол ардын хэлээр тэмээний ноосыг эм ноос, эр ноос гэж ялган хэлдэг юм.

Манай ардын уламжлалт аргаар бол тэмээний эр ноосооргэрийноосор, бүслүүр томж хийх, эм ноосоор утас ээрч, эсгий ширдэг ширэх, гэрийн бүрээсний оосор бүчийг оёх, зулж хөнжил хийх зэрэг олон зориулалтаар ашигладаг билээ.

Хамгийн олон тэмээтэй байсан 1950-иад оны дундуур жилдээ 4000 орчим тонн тэмээний ноос бэлтгэдэг байлаа. Мөн нэлээдхожуухан тэмээний ноосыг боловсруулж янз бүрийн бүтээгдэхүүн хийдэг үйлдвэрлэлтэй болсон билээ.

Тэмээний ноосон эдлэл бол дулаахан, хөнгөн, бөх байдаг учраасдэлхийн зах зээл дээр өндөр үнэтэй байдаг нь тодорхой юм. Манай Монгол улсын үйлдвэрлэлийн туршлагаас үзэхэд тэмээний цэвэр ноосоор 2.5 м ноосон даавуу эсвэл 1 м хөнжил, 1-1.5 ширхэгнэхмэл ноосон цамц, 2-4 ширхэг хүзүүний ороолт, алчуур хийжболдог учраас аж ахуй, эдийн засгийн ихээхэн ач холбогдолтой байна.

Тэмээн сүргийн хоёрдахьчухал ашиг шим бол ингэний сүү юм.Манай говь, тал хээрийн бүсийн тэмээ олонтой нутагт малчидүеэсээ ингээ сааж сүү, цагаан идээгээ базааж ирсэн уламж,туршлагатай билээ. Ингэ хоёр жилд нэг удаа ботголдог учраас саалийнхугацаа нь хамгийн урт байдаг. Тийм учраас гадаадын судлаачидихэд сонирхон ингэний саалийн хугацааны талаар янз бүрээрбичсэнбайх нь тааралддаг юм.

Ингэний сүү саалийн тухай хамгийн анхан тэмдэглэсэнсудлаач бол И.Майский байжээ. Тэрээр ботго эхийгээ 1.5 жил хөхдөг, жилийн саам нь 60-70 хувин хүрдэг хэмээн бичсэн байдаг билээ. Дараа нь ингэний саалийн хугацаа, сүүний саам, гарцын талаар 1930-аад оноос судалж тэмдэглэсэн зүйл нилээд байна.Жишээ нь:

Ингэний саалийн хугацааг Н.А.Долгушина (1933) 12-15 сар, А II Мелешко (1937) 16-18 сар, И.Ф.Шульженко (1954) 16-18 сар үргэлжилдэг хэмээн тэмдэглэсэн байдаг юм.

Ингэний сүү ууж өссөн, ботгоны буйлах дуун чихэнд хоногшсон, бага залуу наснаасаа мал малласан бидний хувьд бол манай малчдын ингээ сааж, өвлийн цагт ч цайны сүүтэй байдаг амьдралын туршлагаас үзвэл, дээр өгүүлсэн гадаадын судлаачид ч тун үнэн бодитой ажиглалт хийсэн байжээ. Манай Монголын тэмээний аж ахуйг судлаач Б.Лувсан өөрийн судалгаагаар ингэний саалийн хугацааг говийн нөхөлд дундажаар 528 хоног буюу 17.6 сар үргэлжилж, хээл авснаас хойш таван сарын дараа ширгэдэг болохыг тогтоожээ.

Бас нэгэн чухал зүйл бол ингэний саалийн нийт сүүний гарцын тухай асуудал юм. Энэ талаар дээр дурьдсан И.Майскийн тэмдэглэсэн хэмжээнээс гадна мөн гадаадын судлаач Х.Наурзбаев нэг ингэнээс саалийн хугацаанд 600-700 л сүү саадаг гэсэн байна. Харин БЛувсан бол ингэний сүүний гарц саалийн 17 сард дунджаар 320 л болдог, түүний 67 хувийг саалийн эхний 6 сард саадаг, тэхдээ арчилгаа маллагааны байдал, бэлчээрийн өвс ургамлын гарц, төрөл бүрэлдэхүүн, шимт чанар, тухайн малын удамшил, хувьсалын онцлог зэрэг хүчин зүйлүүдийн нөлөөнөөс болж ингэний сүүний нийт гарц 175-575 литрийн хооронд ихээхэн хэлбэлзэлтэй байдгийг тогтоожээ. Монголчууд бид ингэний сүүг хөөрүүлж уух, цайгаа сүлэх, ундаа, айраг, хоормог, аарц, ааруул хийх зэргээр хүнсэндээ хэрэглэдэг билээ. Ингэний сүү, ундаа айраг нь хүний эрүүл мэндэд гойд сайн, эмчилгээний чанартай байдаг юм. Жишээ нь ходоодны шархтай урхаг өвчтэй хүн ингэний сүү уусаар байгаад эдгэрсэн тохиолдол байна. Мөн ингэний сүү нялх бага хүүхдэд хамгийн сайн тэжээл болдог, хүний хөхний сүүг орлох онцгой чанартай гэдгийг манай эрдэмтэд тогтоосон байдаг юм.

Ингэний сүү бол тослог ихтэй, гашилах нь удаан, намар оройхон болох тутам улам өтгөрч гашилж муудахгүй тул олон хоногоор хурааж намар, өвөлжингөө хадгалан ууж болно. Ялангуяа 10-11 дүгээр сарын урд ингэний ундаа бол салахын аргагүй сайхан болдог бөгөөд бараг өөр хоол ундны хэрэггүй шахам болно.

Монгол тэмээний сүүний найрлагыг Б.Лувсан, Р.Индра нарын эрдэмтэд судалсан ажээ. Тэд өөрсдийн судалгаагаар ингэний сүүн дэх хуурай бодис, тослог, чихэрлэг, уураг, витамин, фосфор, кальц зэрэг бүтэц найрлагын хувь хэмжээг тогтоосон байна. Мөн ингэний сүүний бактер устгах, хамгаалах чанарын бодис найрлагыг тогтоожээ. Нэг сонирхолтой зүйл бол ингэний сүүн дэх үл орлогдох амин хүчлүүд нь сүүний нийт амин хүчлийн дотор 46.5 хувийг эзэлдэг явдал бөгөөд тэр байдал нь уг сүүний төгс сайн чанарыг бүрэлдүүлдэг ажээ.

Тэмээний гуравдахь ашигт чанар бол махны хэрэглээ юм. Монголчууд бол тэмээний махыг хүнсэнд хэрэглэх нь тун ховор, ихэнх нутагт саяхан болтол тэмээний махыг иддэггүй байлаа. 1920-иод оны гаалийн мэдээ болон И.М.Майскийн экспедицийн гаргасан өрхийн төсвийн материалаар дотоод, гадаадын хэрэглээний маханд 12.0 мянган тэмээ зарлагадсан тухай дурьдсан байдаг юм.

Монголын хоёр бөхт тэмээ бол тарга хүч сайн авдаг, мах өөх арвинтай мал юм. Дээд тал нь том тэмээний амьдын жин 20 хоньтой тэнцдэг байна. Харамсалтай нь энэ байдал тэмээнд туйлын халгаатай болоод байгаа юм. Тэмээний тарга хүч авах чадвар, махны гарц чанар, химийн бүтэц найрлагыг Ш.Цэрэнпунцаг, Б.Лувсан, Д.Цэвээнжав нарын эрдэмтэн судлаачид сайтар судалжээ. Өвөл, хаврын хахир хатуу цагт турж эцсэн тэмээ 5-6 дугаар сард нялхногооны шүүс шимээр тэнхэрч тарга хүчээ сэлбэж эхлэх бөгөөд 10-р сарын эцсээр бүрэн таргалж дуусдаг байна. Монголын малчид малынхаа төрөл тус бүрийн тарга хүчийг тодорхойлдог арга барилтай байдаг. Тэмээний таргыг гуя нь махалж зузаарсан, бөх нь томорч, ширээ бодсон байдлаар мэдэж болно. Тэмээний амьдын жин, нядалгааны гарц мэдээж нас, хүйс, тарга хүчээс шалтгаалж янз бүр байна. Говийн бүсийн зарим аймгуудад хийсэн судалгаанаас үзэхэд, дунд ба дундаас дээш тарга хүчтэй 5-10 настай атны амьдын жин 424-600 кг, гулуузны жин 210-300 кг, бөхний болон дотор өөх 13-43 кг, нядалгааны гарц 54-60 хувь, зарим тохиолдолд 62-64 хувь байжээ. Маханд борлуулсан малын амьдын дундаж жинг тодорхойлсон 1960-1985 оны статистикийн тоо баримтаас үзэхэд тэмээний дундаж жин 1971 онд 801, 1973 онд 808 кг байсан ажээ. Харин бусад төрлийн малтай харьцуулахад тэмээний махны гарцын хувь хэмжээ илүү байдаг ажээ. Манай эрдэмтдийн хийсэн судалгаагаар дундаас дээш тарга хүчтэй атан тэмээний махны чийг дундажаар 60.2 хувь, тослог 21 хувь, уураг бараг 18 хувь, үнс 0.87 хувь, 1 кг түүхий махны илчит чанар 2691 ккал байдаг ажээ.

Тэмээний дагалдан гардаг нэгэн ашигт зүйлбол шир юм. Манаймалчид тэмээний ширээр сур, ханын үдээр, гутлын ул,айрагны хөхүүр зэрэг зүйл хийдэг уламжлалтай бөгөөд мөн үйлдвэрийнгазартширийг боловсруулж, гутлын хром, ул, бусад ширэн эдлэлүйлдвэрлэдэг арга хэлбэрт шилжиж байсан юм.

Тэмээний ширний талбай нь 4 8-5.1 ам метр орчим, нойтон ширний жин 24-27 кг байдаг ажээ. Улсын бэлтгэлд өгч байсан тэмээний шир 1985-1987 онд хамгийн их нь 39-40 мянга хүрч байсан бол хэдийгээр 1990 оноос хойш идшинд хэрэглэсэн тэмээний тоо даруй 2.5 дахин нэмэгдсэн атал статистикийн мэдээгээр тэмээний ширбэлтгэл ихээхэн буурч 1995 онд ердөө 11 мянга хүрэхгүй болсон нь бэлтгэлийн журам байхгүй болсонтой холбоотой байж болох юм.

Тэмээн сүргийн дөрөвдөхшигт чанар бол уналга эдэлгээний чадвар юм. Монгол нутагт тэмээг гэршүүлсэн нь хэдэн мянган жилийн өмнөөсэхлэн улмаар Монголын нууц товчоо мэтийн эртний ном сударт тэмдэглэгдсэн цаг үеийг дамжин уламжлагдсаар 20 дугаар зууны бараг дунд үе хүртэл тэмээн хөсөг нь монгол орноо тээврийн гол хэрэгсэл болсоор ирсэн билээ. Энэ нь тэмээн сүргийн хамгийн чухал буюу нэгдэх ашигт чанар байсан юм. Тэмээ бол тун их тэнхээтэй, өл хоол сайн даадаг, эцэж ядрах нь удаан, онцгой чадвар чансаатай мал юм. Манай монголчууд тэмээг үс ноос нь ургаж гүйцсэнхойно, хүйтэн, сэрүүн цагт, өөрөөр хэлбэл намар 10-р сараас хавар 4-5 сар хүртэл унаж эдэлдэг цаг улирлын онцлогтой байдаг. Тэмээг жирийн унаанд унах, нүүдэл суудал хийх, ачаа бараа зөөх, аян жин тээхэд тэргэнд хөллөх, нуруу ачих хэлбэрээр ашигладаг нь хэн бүхэнд тодорхой билээ.

Тэмээнд нуруулдан ачихад 200-240 кг, тэргэнд хөллөхөд 400-800 кг ачаа ачдаг, хоногт 50 км зам туулдаг нэг жинчин 10-15 хөсөг хөтөлдөг, тун хямд өртөгтэй тээврийн төрөл байсан юм. Нийт аймагт 1954 онд авто тээврийн бааз байгуулагдаж дуусахаас өмнө үндсэндээ ут хоорондын болон дамжлага бааз-аймаг хоорондын ачаа тээвэрлэлтийн ажлыг ердийн хөсгөөр, түүний дотор тэмээн хөсгөөр гүйцэтгэж байсныг манай ахмад үеийнхэн бүгд мэдэх билээ. Зүүн талын Сүхбаатар, Хэнтий, Дорнод аймагт тэмээн тэрэг, Өмнөт баруун, төв хэсгийн аймгуудад тэмээг нуруулдан ачдаг уламжлалтай байна.

Манай тэмээн сүргийг судалсан эрдэмтэд тухайлбал, Ш.Цэрэнпунцаг, Т.Аюурзана нар тэмээний уналга эдэлгээний гоц чадварыг тусгайлан судалсан байдаг юм.

Монгол улсын гавъяат зоотехникч Т.Аюурзана гуайн 1947 онд хийсэн судалгааны дүнгээс үзвэл: Тус бүр нь 226-238 кг ачаа ачсан жингийн тэмээд нь Өмнөговь аймгаас Улаанбаатар хүртэл талын 740 км урт замыг, аян замын үдлэх, хоноглох завсар хооронд тааралдсан бэлчээрийн өвс ургамлаар идэшлэн, цасаар ундалсаар явж 24 хоногийн дотор туулсан байжээ. Харин Улаанбаатар хотоос буцахдаа тэмээ бүрт 238 кг ачаа ачиж, 14 хоног яваад нутагтаа хүрсэн ажээ.

Тэрхүү аянд тэмээнүүд нь өөрийн амьдын жингийнхээ 38-42 хувьтай тэнцэх ачаатай, хоногт 31-53 км замыг туулан явсан байна. Мөн аянд явахын өмнө тэмээний

дундаж жин нь 608 кг байсан бол аяны төгсгөлд 565 кг болж тэмээ болгон 38 кг-аар буюу хоног тутам 760 г-аар тарга хүчээ гээсэн авч, ажлын чадвар нь хэвээрээ байжээ.

Энэ номыг зохиогч хүмүүн өөрөө Монгол орны ердийн хөсгийн тээврийг судлан докторын диссертаци болон “БНМАУ-ын тээврийн системийн хөгжлийн асуудал” (1978) хэмээх номондоо дэлгэрэнгүй бичсэн бөгөөд одоо тэрлэж буй энэ номын тээврийн салбарын тухай өгүүлсэн бүлэгт тусгайлан оруулах тул энэ зүйлийг ийнхүү товч байдлаар хураангуйлсан болно.

Манай оронд тэмээг уналга, хөсөгт хэрэглэж ирснээс гадна говийн малчид бол тэмээ уралдуулах, хурдан тэмээ шалгаруулах спорт тэмцээнийг зохион явуулдаг юм. Эрдэмтэн БЛувсангийн ажиглалтаар тэмээний уралдаанд бүдүүн атан тэмээ 15 км зайг 37-46 минутанд давхиж хурдалсан байжээ.

Монгол оронд авто машин, тракторыг тээвэрт өргөн ашигладаг болсноос хойш тэмээн хөсгөөр алс холын аян жин хийхээ больж, тэмээг уналга эдэлгээнд сургаж аж ахуйн дотоод тээвэрт ашиглах нь ч багассан учраас тэмээг хүнс хоолонд хэрэглэх, энэ чиглэлээр зарж борлуулах явдал ихэссэн нь тэмээн сүрэг хорогдож цөөрсөн ноцтой аюулд хүргээд байна. Тэхдээ тэмээг уналга ачилганд хэрэглэх нь манай говь, зүүн, баруун өмнөт талын аймгуудад нилээн байгаа билээ.

-Хонин сүрэг

Монголчууд нэн эртнээс халуун хошуут хонин сүргийг өсгөн маллаж ирсэн тухай түүхийн судар бичигт нилээдтэмдэглэгдсэн байдаг ажээ. МЭ-ний 924 онд Татарын /Монголын/ эзэн Хятадын хаанд гурван түмэн хонь, адуугаар барьц барив хэмээн “Боржигин овогтны түүх” гэдэг сударт тэмдэглэсэн тухай эрдэмтэн Ч.Далай өөрийн номонд иш татсан байдаг.²⁵

Мөн Монголын нууц товчоонд: “Галд шахан бууя, хургачин нарт хоол болтугай”²⁶ хэмээн нүүдэл хийж байхдаа Тэмүүжин, Жамуха хоёрын ярилцсан үг нь хонины бэлчээрийг татаж, голд бууя гэсэн утгатай үг бололтой байдаг. Мөн нууц товчооны 124 дүгээр зүйлд:

“Алаг сайхан хоньдыг

Ар дүүрэн бэлчээн

Хонин олон сүргийг

Хот дүүрэн өсгөж

Шилдэг иргийг төхөөрч

Шимтэй шөлийг бэлтгэж явъя” хэмээн бичсэн байдаг нь Монгол орон эрт үеэсээ хонин сүрэг олонтой байсныг гэрчлэнэ.

Хонин сүрэг бол уламжлалт таван хошуу малын дотор толгойн тоогоортэргүүн байр эзлэсээр ирсэн ажээ.

Нутгийн монгол хонь бол манай орны байгаль-цаг уурын аль ч бүсийн бэлчээрийн маллагаанд зохицсон байдаг тул нийт аймаг, сумдад тархсан онцлогтой байна. Улсын бэлтгэл мэдээнд тогтсон тоогоор бол Монгол оронд 1918 оны эцэст 7.9 сая орчим хоньтой байсан ажээ.

Хонин сүргийн нэгдэхашигт чанар нь махны хэрэглээ юм. Манай монголчууд хэзээнээсээ хонины махыг амт чанарын хувьд тэргүүн зэрэгт үздэг уламжлалтай юм. Тийм учраас монголчуудын дэлхийн олон улс үндэстнээс ялгагдах нэг онцлог нь хонины махыг хүний биед хамгийн зохимжтой гэж үздэг тэр чанараараа үнэ нь ч бусад малын махны үнэтэй харьцуулбал өндөр байдаг явдал юм.

Энэ бүхэн нь настан буурлууддаа үе үе хонины махаар хоол хийж, шөл уулгадаг тул өвлийн идшиндээ зориуд хэдэн хонь бэлтгэдэг, зуны дэлгэр цагт цагаан идээгээр хооллож, мах идэхгүй заншилтай байсан 40-50-иад жилийн өмнөх уламжлалт үед ч гэсэн төрсөн эхэд заавал хонины шинэ шөл уулгаж биеийг нь тэнхрүүлдэг зэрэг байдлаас ойлгогдох байхаа. Түүнчлэн хонины мах, шөлийг эмчилгээний чанартай хэмээн үзэж, борви тойг, ахар сүүлний шөлөөр ардын эмийг даруулж уух, мөн таван цулын болон ясны шөлийг ч сайн гэж ярьдаг билээ. Ер нь манай монголчуудын шөлний хэдэн хоньтой хэмээн хэлдэг үг нь иймэрхүү учир холбогдолтой юм. Эдүгээ Москва хотноо амьдарч байгаа дорно дахины ардын уламжлалт эмчилгээний аргаар асар их нэр хүндийг олж, Орос гүрний гавъяат эмч цолыг хүртэж шүтэгдсэн Монголын Өвөрхангай аймгийн уугуул иргэн Лувсан хэмээх

эмч хүмүүн саяхны нэг ярилцлагадаа хонины мах шинэ дээрээ хүний биенд сайн, цусны холестрин, даралтанд муу нөлөөгүй, хонины сүүл бол ерөөсөө эм гэсэн үг хэмээн өгүүлсэн байж билээ.

Энэ бүх учир шалтгааны улмаас хонины мах бол монгол орны махныхэрэглээнд 44-45 хувийг эзэлдэг юм. Манай байгаль-газар орны янз бүрийн бүс нутаг дахь монгол хонины махны ашиг шимийн талаар тухайлбал, тарга хүч, жин хэмжээ, махны гарц, бүтэц, чанар найрлага зэргийг дотоод, гадаадын зарим судлаач эрдэмтэд 1930-аад оноос эхлэн эдүгээ хүртэл судалж тодорхойлсон олон бүтээлүүд байдаг юм. Тэр болгоныг нуршин тоочихгүйгээр монгол хонины махны ашиг шимтэй холбогдол бүхий нийтлэг гол үзүүлэлтүүдийг дурдвал: намрын улиралд нас бие гүйцсэн янз бүрийн омгийн эм хонины амьдын жин 42.9-61.5 кг, хуцных 67.5-70.0 м, гарц эр хониных 52.7-55.3 хувь, эм хониных 37.8-52,6 хувь болдог байна. Ерөнхий дундаж байдлыг тоймлобол, дундаас дээштаргахүчтэй монгол хонины биеийн амьдын жин дунджаар 55 орчим кг, нядалгааны гарц 50 хувь, гулууз махны жин 23 кг, дтпр сүүл 1 кг орчим байдаг ажээ. Мэдээж эдгээр үзүүлэлтийн харьцангуй хувь, хэмжээ нь хонины тарга хүч, нас хүйсний байдлаас шалтгаалан ихээхэн хэлбэлзэлтэй байдаг нь тодорхой юм. Түүнчлэн хонины махны идэш хэрэглээний чанарыг гулууз махны бүгцэд ордог булчин, өөх, хальс, ясны эдийн харьцаагаар тодорхойлдог, эл байдал малын нас ахих тутам ихээхэн өөрчлөгдөнө. Жишээ нь 4.5 настай эр хонины гулуузны жин 27 кг байхад зөөлөн мах нь 86.3 хувь буюу 23,4 кг, үүнээс булчин хэсэг нь 57 хувь буюу 15,5 кг, өөх 29 хувь буюу бараг 8 кг, хальс бүлх 1.1 хувь буюу 0.3 кг, яс 12.6 хувь буюу 3,4 кг болдог байна. Хонины махан дахь гадар ба булчин махны завсрын өөх нь чмахыг шимтэй, амтлаг зөөлөн болгодог, бидний дээр дурдсанаар хэрэглээнд тохиромжтой гадар болон сүүлний өөх 70-80 орчим хувийг эзэлдэг байна.

Нутгийн монгол хонины махны найрлага, илчлэг чанар зэрэг асуудлыг эрдэмтэн Г.Батсүх нарийвчлан судалжээ. Түүний судалгаагаар хонины маханд чийг буюу шүүс 63.5 хувь, тос 19,1 хувь, уураг 16.6 хувь, үнс 0.97 хувь байдаг ажээ. Энэ үндсэн дээр дундаас дээш тарга хүчтэй хонины 1 кг махны илч дунджаар 2598 ккал, бүүр тарган хониных бол 3745 ккал хүрч байжээ. Хонины махны найрлагын харьцаа

насны байдлаас өөр өөр байдаг ажээ. Бас нэг сонирхолтой зүйл бол говь нутгийн хонины махны чанар нь харьцангуй их байсан явдал юм. Ер нь говийн таана хөмөлтэй нутгийн хонины мах бол гойд сайхан амттай байдаг юм.

Мөн зарим судлаачдын тогтоосноор хонийг өрлөх аргаар төхөөрч махыг нь нэмэх хэмд байлгаж загсаавал түүнд хэд хэдэн амин хүчлийн хослол хадгалагдаж, махны амт чанарт сайн нөлөөтэй болдог тухай дүгнэлт гаргасан ажээ. Манай монголчуудын эрт үеэс хонины мах, өөхийг тэнцүүлэн долоон хөл болгон үе мөчөөр нь салгаж, эвдэх уламжлалт арга нь ихээхэн сонирхолтой юм. Хонины мах, гуя, ууц, хаа, өвчүү, сүвээ, хүзүү сээр хэмээн долоон хөл болгон хувааж, тэдгээрт тураг махны эзлэх хувь, химийн болон амин хүчлийн найрлагыг тогтоосон судалгааг эрдэмтэн Н.Ишээ хийсэн нь махны чанарыг үнэлэх хэрэглээний чухал ач холбогдолтой бол* >> I судалгаанаас үзэхэд тийнхүү долоон хөл махны дотроосууц, өвчүү, сүвээ нь тос болон илчит чанар ихтэй, идэхэд хурцдуу байдагбол гуяны мах нь шүүслэг, уураг, тосоор тэнцүүхэн, илчлэг чанараар хэвийндүү зэрэг байдлаараа хоол хүнсэнд хамгийн зохимжтой байдаг ажээ. Ер нь хонины гуя нь цул махтай байдаг тул дэлгүүрт худалдахдаа нэг гуяыг хүзүү дагуулж өгдөг байсан юм.

Мөн хонины долоон хөл махан дахь чөлөөт амин хүчлийн хэмжээ, хувийг тодорхойлсон Н.Ишээ гуайн судалгаа нь сонирхолтой үр дүн өгчээ. Жишээлбэл, өвчүү, хаа, гуя, сээр хүзүүнд глютамины хүчил их хэмжээтэй байхад Лейцин+изолейцин нь хаа, хүзүү, сээр, гуя, өвчүүнд ахиухан, аланин гэдэг хүчил сээр хүзүү, өвчүүнд тун их хэмжээтэй байдагажээ. Энэ байдлаас үзвэл, хүзүү, хаа зэрэг махыг бусад хэсгээс нь лоогуур үнэлэх нь тийм ч зохистой биш бололтой юм.

Монгол хонь бэлчээрээр тарга хүч авдаг учраас сайн бэлчээрт оторлон таргалуулбал махан ашиг шим нь нэмэгддэг болох нь манай тэргүүний малчдын туршлагаар нотлогдсон асуудал мөн билээ. Тухайлбал, монгол удмын хонь намар оройхон тарга хүч нь гүйцэх үедээ дунджаар 50 кг жинд хүрдэг байхад улс, аймгийн аврага малчидын хариулга маллагаатай хонин сүргийн дундаж жин 60 орчим кг болдог нь хонины мах, өөхний их хэмжээний нөөц нь бэлчээр, ус, хужир, оторлолт, маллагаа зэрэг хүчин зүйлүүдээс шалтгаалан нэмэгдэх боломжтойг харуулж байна.

Хонин сүргийн хоёрдахь ашиг шим нь ноос юм. Монголын малчид эрт үеэс хонины ноосыг амьдрал ахуйдаа ашиглаж ирсэн уламжлалтай билээ. Хонины ноос бол дотроо уртын ноос, ахар, хурганы ноос гэсэн хэдэн төрөлтэй байна. Хонины уртын ноос бол гүйцэд ургасан ноос бөгөөд хаврын сүүлч, зуны эхээр хөндийрсөн үед нь ихэвчлэн хайчлах, гэдэс хавийн эхлэн хөндийрсөн хэсгийг зулгаах аргаар салгаж авна. Хайчилсан ноосыг үргэлж ноос, зулгааж авсан гэдэс, хоолой, цавь суга хавийн ноосыг бутархай ноос гэдэг. Уртын ноосыг нь салгаж авсны дараа нүцгэрсэн хонины ноос намар хүртэл зуны турш дахин ургаад тачирдуу байх үед нь 9-р сард ахарлан хайчилж авах бөгөөд тийм ноосыг ахарын ноос гэж нэрлэдэг.

Мөн зуны сүүлчээр хургаа хайчлах бөгөөд хурганы ноос зөөлөн цагаан өнгөтэй байна. Манай малчид намар хонио ахарласны дараа уртын болон ахар, хурганы ноосоо савж эсгий хийнэ. Ахар, хурганы ноос, цагаан өнгөтэй байдаг тул өнгөлөн зулж эсгийгээ цайвар цагаан өнгөтэй болгоно.

Монголчууд эсгийгээр гэрийн бүрээс, ширдэг, тохом зэрэг зүйл, мөн ноосоор утас ээрч гар нэхээсийн сүлжмэл эдлэл хийж ирсэн уламжлалтай юм. Мөн хонины ноосыг угааж их хэмжээгээр гадаадад экспортлож байлаа. Сүүлийн 30-аад жилд ноосон нэхмэл, сүлжмэл, хивсний үйлдвэрүүд байгуулж үндсэн түүхий эд болгон ашиглаж байв. Гагцхүү 1990 оноос хойш ноос угаах үйлдвэрүүд, хагас дутуу ажилтай болж, хонины ноосыг угаахгүйгээр бохиороор нь шууд гадаадад гаргадаг болоод байна.

Уг нь монгол хонины 1 кг ноосоор 0.6 метр хиж , 1 м ноосон цэмбэ, хөнжил хийдэг юм. Нутгийн монгол хонь бол холимог ширүүвтэр ноостой, гарцын хувьд байгаль газар зүйн бүс, мөн хонины омог төрлөөс шалтгаалан нилээд хэлбэлзэлтэй байдаг ажээ. Нас гүйцсэн хуцнаас 1.4-2.0 кг, эр хониноос 1.2-1.6, эм хониноос 1-1.4 кг, төлөгнөөс 0.8-1.2 кг уртын ноос гардаг болохыг манай эрдэмтэн судлаачид дундачлан тогтоосон байдаг юм. Монгол хонины ноос дотроо жинхэнэ ноолууран хэсэг, завсарын үс, сор, ямаан үс гэсэн дөрвөн төрлөөс бүрэлддэг бөгөөд 72-77 орчим хувь нь ноолуур, 8-11 хувийг завсарын үс, 4.5-10 хувийг сор, 2.5-15 хувийг ямаан үс тус тус эзэлдэг байна. Хонины гэдэс, өвчүү хавийн ноос нь голдуу ямаан үс байдаг юм.

Хонины ноосыг чанарын хувьд гурван зэрэгт хуваадаг. Ноолуур ихтэй, завсарын болон ямаан үс багатай ноосны зэрэг өндөр байна. Жишээ нь ноолуурын эзлэх хэмжээ 1 дүгээр зэргийн ноосонд 54 хувь, хоёрдугаар зэргийнхэд 46 хувь, 3 дугаар зэргийн ноосонд 43 хувь байдаг ажээ.

Эрдэмтэн Д.Чойжилын судалгаагаар Говь-Алтай, Дорнод, Өмнөговь, Увс, Төв, Ховд аймгийн Монгол хонины дотор нэгдүгээр зэргийн ноостой хонь 16.7 хувь, хоёрдугаар зэргийнх 50,4 хувь, гуравдугаар зэргийнх 32.9 хувь байснаас үндэслэн Монгол орны янз бүрийн бүс нутгийн хонины ноосны чанарын зэрэг дугаарын хувь харьцааг ойролцоогоор төсөөлж болох юм.

Австрали, Шинэ Зеланд зэрэг нарийн ноост үүлдрийн хоньтой харьцуулбал байгаль-цаг уурын эрс тэс экологийн нөхцөлд зохицсон монгол хонь нь ноосон ашиг шим багатай малд тооцогдох талтай билээ. Тэхдээ хонин сүргийг өсвөр наснаас нь эхлэн сайтар арчлан малласан нөхцөлд ердийн дунджаас нилээд илүү ноос авч болохыг манай тэргүүний малчдын туршлага, тэр талаар хийсэн ажиглалт судалгаа нотлон харуулж байна. Жишээ нь, хөдөлмөрийн баатар, төрийн шагналт хоньчин С.Цогтгэрэл гуай хонин сүргээ гойд сайн арчлан маллаж байсны үр дүнд эм хонь бүрээс 2,3 кг, төлөгнөөс 2 кг, хурганаас 815 г ноос авч байжээ. Мөн өөр нэгэн жишээ бол Завхан аймгийн Цэцэн-Уул сумын алдарт хөдөлмөрийн баатар М.Ганболд 1000-1300 төлөг маллан тарга хүч авахуулсны үр дүнд ноос нь жигдхэн ахиу ургаж, төлөг бүрээс дунджаар 2240 г ноос авсан байв. Эрдэмтэн М.Төмөржавын хийсэн судалгааны үр дүнгээс үзэхэд²⁷ хурга, төлөг байхаас эхлэн сайн арчилгаа, маллагаатай байсан нөхцөлд хонины арьсан дахь үсний уутанцарын үс ноос ургуулах чадвар эрс дээшилдэг шинжлэх ухааны үндэслэлтэй байдаг ажээ.

Хонин сүргийн гуравдахь чухал ашигтай чанар бол сүү сааль нь юм. Манай малчид хавар хонио хургалахаар сааж уургийг нь буцалган ууж, агшаан идэж цагаан идээтэй эхлэн залгадаг, чийг бамнаас салдаг уламжлалтай билээ. Тэгээд хонио зунжингаа намар болтол холбож саадаг, хонины сүүгээ хөөрүүлж өрмөө авч тарагаа бүрдэг, ааруул, хурууд, эззгий хийдэг, намар шар, цагаан тосоо бэлтгэдэг юм. Харин 1950-иад оны сүүлээр мал сүрэг нийгэмчлэгдэж, хөдөө аж ахуйн нэгдэл байгуулагдсанаас хойш ихэнх нутагт зундаа хонь холбож саах нь тун ховор болсон

билээ. Уг нь хонины сүү бол тослог ихтэй, хонины сүүгээр бүрсэн тараг их өтгөн, хамгийн сайхан байдаг юм.

Энэхүү номыг тэрлэгч хүмүүн болон бидний үеийн хүмүүс бага залуу насандаа зунжингаа хонины сүү тараг, өрөм хусам, ааруул эззгийгээр дагнан хооллож байсан билээ. Манай эрдэмтэн судлаачид нутгийн монгол хонины сүүн ашиг шимийн талаар судалгаа хийж тогтоосноор бол тал хээр, говийн бүсэнд нэг хонины жилийн саам 36-39 кг болдог байна.

Монгол хонины сүүний найрлага хангай, тал хээр, говийн бүсэнд бага зэрэг ялгаа хэлбэлзэлтэй байдаг боловч ерөнхийдөө дундачлан авч үзвэл хуурай бодис 17 хувь орчим, тос 5.5-5.8 хувь, уураг 5.5-6.5 хувь, саахар 3.7-3.8 хувь орчим агуулагдаж байдаг ажээ.

Мөн монгол хонины сүүнд зарим төрлийн амин хүчлүүд, ялангуяа үл орлогдох амин хүчлүүд саалийн хугацаанд бараг өөрчлөгдөхгүй, нилээд хэмжээтэй байдаг тухай эрдэмтэд тодорхойлжээ.

Хонины дөрөвдэх буюу дагалдан чанарын ашигт зүйл бол хонины арьс юм. Монголчууд хониныхоо арьсаар эртнээс дулаан дээл хувцас хийж өмсдөг уламжлалтай билээ. Хонины арьс хэдийд гарснаасаа шалтгаалан хэд хэдэн янз байна. Зун, намрын арьсыг үзүүрсэг хэмээн нэрлэдэг бөгөөд үс нь тачирхан байдаг тул нимгэндүү дээл болно. Өвлийн идэшний үеийн арьс бол урт үстэй нэхий байдаг. Мөн хурганы бужигардуу үстэй арьсаар гоёлын дээл хийдэг. Малчин хүмүүс хонь, хурганыхаа арьсыг өөрсдөө шүүлж элддэг юм. Манайд дайны дараа 1940-өөд он, 1950-иад оны эхээр эд бараа ховор байх үед ядуувтархан айлын хүүхдүүд даавуун гадаргүй цагаан нэхий дээл, өмд өвөлдөө өмсдөг байлаа. Тэр үеийнхэн бага, дунд сургуульд байх үедээ цагаан нэхий дээл өмсдөг, даалимба, жигүүн зэрэг даавуу гадартай дээл өмсөхсөн гэж мөрөөддөг байж билээ. Тэгсэн 1970-аад оноос үйлдвэрт ялиггүй өнгө будагтай нэхий дээл хийж, хамгийн үнэтэй, ганган хувцас болсон билээ.

Хонины арьсны жин, талбайн хэмжээ нь тухайн малын нас ахихтутам ихэсдэг байна. Жишээ нь: 1.5 настай хонины арьсны жин 3,2 кг, талбай нь 113.0 дцм² байхад 3.5 настай хониных 4.7 кг жинтэй, 125.5 дцм² талбайтай байдаг ажээ. Монгол улсад

1980-аад оныдундуургэхэд жилдээ 4.6 сая хонины арьсыг төвлөрсөн журмаар бэлтгэдэг байлаа. Энэхүү төвлөрсөн бэлтгэлийн арьсыг үйлдвэрт боловсруулж, дээр хэлснээр нэхий дээл, мөн шевро болгон боловсруулж, савхин дээл, цамц, бусад төрлийн эдлэл хийж дотоодын хэрэглээ болон экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүн болдог байв. Ер нь Монгол оронд хонины арьсыг үйлдвэрийн аргаар боловсруулах ажил 1930-аад оны дундуур Аж үйлдвэрийн комбинат байгуулагдсан цаг үеэс эхлэсэн бөгөөд 1950-иад оны эхэнд ч савхин дээл хийж, гадаадад гаргадаг болсон байлаа.

Монгол оронд олон янзын омгийн хонь байдаг билээ. Тухайлбал, баяд, говь-алтай, дархад, барга, баруун монголын ууцан сүүлт, сартуул, үзэмчин омгийн хонь гэж байна. Эдгээр нутгийн монгол хонины янз бүрийн омгууд нь дотроо ашиг шимийн ямар нэгэн ялгаа, давуу талтай байдаг. Баяд хонь бол Увс аймгийн зүүн талын хэдэн суманд нутагшсан мах-өөх-ноосны хэвшилтэй, өөрөөр хэлбэл бие томтой, жирийн монгол хоньтой харьцуулбал, нядалгааны жин нь 6-7,5 кг-аар, махны гарцын хувьд 4.2-4.6 кг-аар илүү, ноос нь өтгөн, зунгаг ихтэй учраас гарц илүүтэй байдаг ажээ. Говь-Алтай омгийн хонь тус аймгийн хэдэн суманд байдаг, ноосны чанар, гарц ахиутай хонь юм. Дархад омгийн хонь бол Хөвсгөл аймгийн Өндөр уул, тайгын бүсэд нутагшсан, бие томтой, махны гарц, ноосны чанараар жирийн монгол хониноос давуутай байна. Барга омгийн хонийг Дорнод аймгийн Хөлөнбуйр, Гурванзагал суманд мах-өөхний чиглэлээр үржүүлж ирсэн юм. Баруун монголын ууцан сүүлт хонь бол голдуу Баян-Өлгий аймагт байдаг, бэлчээрээр тарга хүч сайн авдаг, нуруу, ууц, сүүлэндээ өөх их хуримтлуулдаг онцлогтой байна.

Түүнчлэн байдраг, торгууд үүлдрийн хонь байдаг юм. Байдраг үүлдрийн хонийг Баянхонгор аймгийн Байдрагийн сангийн аж ахуйд үржүүлж байлаа. Байдраг үүлдрийн хонийг бий болгохдоо чамаар омгийн хонийг нутгийн монгол хоньтой эрлийжүүлсэн ажээ. Энэ үүлдрийн хонь 1980-аад оны дундуур 60 шахам мянган толгойд хүрсэн мэдээтэй байсан юм. Байдраг үүлдэр бол нутгийн монгол хоньтой адил жилийн турш бэлчээрийн маллагаанд байдаг, ноосны чиглэлийн хонь бөгөөд ноос нь гарцын хувьд их, чанарын талаар хивсний үйлдвэрийн түүхий эдийн шаардлагыг бүрэн хангадаг, торгомсог, гялалзсан цагаан өнгөтэй, ноолуур, сор нь

урт, ямаан үсгүй байдгаараа онцлог юм. 1970-аад оны сүүлийн хагаст Мал аж ахуйн хүрээлэнгийн эрдэмтэд Төв аймгийн Өндөрширээт суманд хагас суурьшилтай хэсэг байгуулах туршилтын ажил явуулж, тэнд байдраг үүлдрийн хонины сууриудийг бий болгосон билээ.

Бидний дээр дурьдсан баруун монголын ууцан сүүлт хонь нь ноосны гарц бага, чанар нь тааруухан байдаг тул уг дутагдалтай талыг засч сайжруулах зорилгоор 1960-аад оны эхээр Туркмений Сараджин үүлдрийн хуцтай эрлийзжүүлж торгууд үүлдрийн хонины хэсгийг Ховд аймгийн Булган суманд бий болгосон ажээ. Энэ үүлдрийн хонь бие томтой, махны хэмжээ гарц ихтэй, ноосны талаар ихээхэн давуутай болсон байжээ. Түүнчлэн манай эрдэмтэд нарийвтар ноост “Орхон” үүлдэр, нарийн ноост “Хангай” үүлдрийн хэсэг, мөн мах ноосны чиглэлийн нарийвтар ноост “Ерөө” үүлдрийн хэсэг бий болгосон байлаа.

-Ямаан сүрэг

Монгол орноо мөн л эрт үеэс өсгөж ирсэн таван хошуу малын нэгэн төрөл бол ямаа юм. Эртний ном судар Монголын иууц товчоонд ямаан сүргийн тухай тэмдэглэсэн зүйлс байдаг бөгөөд ерөнхийдөө тооны хувьд цөөвтөр байсан бололтой ойлголт төрүүлдэг билээ. Монголын мал сүргийн анхны тоймтой тоогоор бол ямаан сүрэг 1918 онд 1 сая 5 бум гаруй байсан ажээ.

Ямаан сүрэг тархалтын хувьд 60 орчим хувь нь Говийн болон Алтайн уулархаг бүс нутагт байршиж байдаг. Энэ нь угаасаа ямаа бол говийн нүцгэн уулсын сархиаг, хад асга ихтэй хярдүү газарт агь, шарилж, сонгинын төрлийн ааглаг гашуувтар өвс ургамал голдуу ургадаг, хуурайвтар уур амьсгалтай нутагт илүү сайн зохилдсон онцлогтой байна.

Ямаан сүргийн нэгдэхбуюу хамгийн гол ашигт чанар бол ноолуур юм. Монгол оронд 1970-аад оны сүүлч, 1980-аад оны эхээр ноолуурын үйлдвэр байгуулж эхлэснээс хойш ямааны ноолуур хамгийн чухал, өндөр үнэтэй бүтээгдэхүүн болдог түүхий эд болсон юм.

Монгол ямааны ноолуурын гарц, хэмжээ нь ямааны удамшлын чанар, нас хүйс, самнах хугацаа, арга технологи зэрэг байддаас ихээхэн шалтгаалдаг байна. Судалгаанаас үзэхэд, эм ямаанаас 220-225 г, эр ямаа, ухнаас 250-350 г, эр охин борлонгоос 190-250 г ноолуур гардаг дундаж хэмжээтэй байдаг юм. Ямааны махны бэлтгэл, хэрэглээ ахиутай байсан 1970-1980-аад онд сүргийн бүтцэд эм ямаа, шүдлэн борлон зонхилсон, эр ямаа цөөвтөр байсан явдал ноолуурын нийт гарц, хэмжээнд тааруухан нөлөөтэй байв. Хар, улаан зүсмийн ямаа ноолуурын гарцаар хөх, цагаан зүсний ямаанаас 14-27 орчим илүү байдгийг эрдэмтэн Д.Цэдэнсодном, тогтоосон байжээ. Монгол ямааны ноолуурын нарийны хэмжүүр нь 13.09-16.05 микрон/мкм/, урт нь 47.3-66.7 мм байдаг ажээ. Монгол ямааны ноолуурын чанар нь Афганистан, Иран зэрэг орнуудын ямааны 17.5 микрон бүхий ноолууртай харьцуулбал илүү сайн гэдэг нь ойлгомжтой байгаа юм.

Ямаан сүргийн хоёрдахь ашигт чанар нь махны хэрэглээ юм. Монголчууд мөн эртнээс ямааны махыг хоол хүнсэндээ хэрэглэж ирсэн уламжлалтай байна.

Манай монголчууд яргуйнд цадсан ямааны махыг биенд сайн гэдэг боловч ямааны махыг сэрүүн чанартай, амархан царцдаг, тэгээд ч настай хүмүүст ямааны махны шөл уулгах нь төдийлөн зохимжтой бус хэмээн үздэг юм. Ямааны махны нядлагын жин, гарц, найрлага зэргийг эрдэмтэн М.Наваанчимэд, Д.Цэдэв, Д.Цэрэнсоном нар судалсан байдаг юм. Тэдний судалгааны үр дүнгээс тоймлон үзсэн ч мөн манайд олон жилийн турш байсан бэлтгэлийн мэдээгээр ч гэсэн эм ямааны амьдын жин 32.6 кг, нядалгааны гарц нь 39-39,5 хувь, сэрхний амьдын жин 42 кг, махны гарц нь 43.7 хувь байдаг ажээ. Дундаас дээш тарга хүчтэй сэрхний маханд чийг 66,4 хувь, үнс 1.6 хувь байх жишээтэй байна. Мөн тарган сэрх ямааны 1 кг махны илчит чанар 2557 ккал байдаг ажээ.

Ямааны гуравдахь ашигт шимт чанар нь монголчуудын хоол хүнсэндээ өргөн хэрэглэж ирсэн сүү юм. Ямааны сүүгээр тараг, аарц, цагаа, өрөм, ааруул, хурууд, эззгий, шар, цагаан тос зэрэг олон янзын цагаан идээ хийнэ. Ямаа цөөхөнтэй зарим нутагт хонь, ямааны сүүгээ холиод цагаан идээгээ хийдэг бол ямаа олонтой аймаг, сумдад дан ямаагаа саадаг айл хунар зөндөө байдаг.

Нутгийн монгол ямааны сүүний гарцын талаар гадаад, дотоодын судлаачид янз бүрийн он жилүүдэд судалгаа хийсэн, хэдэн янзаар сүү саалийн хэмжээг тогтоосон байдаг юм. Тухайлбал, Оросын судлаач ЮЛ.Горошенко 1936 оны үед хийсэн судалгаандаа монгол ямаанаас 3-4 сарын саалийн хугацаанд 75-90 литр сүү саадаг гэсэн байхад И.Ф.Шульженко гэдэг хүн 1954 онд монгол ямаанаас саалийн хугацаанд 56-60 литр сүү саана гэсэн байжээ.

Харин Монголын эрдэмтэн Д.Цэрэнсоном 1970-аад оны эхээр ямааны аж ахуйг судалсан бүтээлдээ ямааны сүүн ашиг шимийн талаар нилээд дэлгэрэнгүй тусгасан байдаг билээ. Түүний судалгаагаар говийн бүс нутагт ямааны саалийн хугацаа 225 хоног үргэлжилдэг бөгөөд 60-70 литр сүү саадаг хэмээн тогтоожээ. Ямааны сүүний гарц ид зуны буюу 6-7 дугаар саруудад хамгийн их хэмжээнд хүрдэг, Хоногийн сааль 110-412 г байдаг, зарим сүү сайтай ямаанаас өдөрт 2 удаагийн саамаар 800 г сүү гардаг байна. Ямааны сүү бас л тослог сайтай бөгөөд цаг улирлын байдлаас хамаарч 3.9-9.6 хувийн хэлбэлзэлтэй байдаг ажээ.

Намар оройхон ногоо ургамлын чийг багассан үед ямааны сүүний тослог 11-12.5 хувь хүрдэг байна.Нутгийн монгол ямааны дотор сүүний чиглэлийн тулман хөхт хэмээх ямааны сүүний гарц нь жирийн монгол ямааныхаас 2 дахин их, саалийн хугацаа нь 230-аад хоногт, 5.9 хувийн дундаж тослогтой 150 гаруй литр сүү сааж болдог ажээ. Тийм учраас төв суурин газарт хэдэн тулман хөхт ямаатай байх нь тэжээлийн шаардлага багатай тул үнээтэй байхаас ч илүү ашигтай гэж үздэг тал бий юм.

Ямааны сүүний найрлага бүтцийг эрдэмтэн Р.Индра судалж тогтоосон байна. Тэрээр говь нутгийн ямааны сүүнд хуурай бодис 15,4 хувь, тос 5.8 орчим хувь, үнс 0.89 хувь болохыг, мөн эдгээр үзүүлэлтээр монгол ямаа “дон” үүлдрийн ямаанаас давуутай гэдгийг тогтоожээ. Ямааны сүүнд уурагт бодис, амин хүчил, тосны хүчлүүд нх байдаг онцлогтой гэнэ. Мөн сүүнд кальц, фосфор, кобальт мэтийн бодисууд нилээд хэмжээтэй байдаг тул монгол ямааны сүү цагаан идээхүний биед сайн, ялангуяа нялх хүүхэд, настан буурлуудад сувилгаа арчилгааны тэжээл болох ач холбогдолтой байх ажээ.

Ямааны дөрөвдэх ашигтай зүйл бол дагалдан гардаг арьс юм. Ямааны арьсыг монголчууд элдэж боловсруулаад дах дэгтий хийдэг уламжлалт хэрэглээтэй байдаг билээ. Мөн үйлдвэрийн чухал хэрэгцээт түүхий эд, экспортын бүгээгдэхүүн болдог. Ямааны арьсыг боловсруулж шевро хэмээх арьсан эдлэлийн түүхий эд бэлтгээд, түүгээр гутал, хувцас, бээлий, янз бүрийн жижиг эдлэлүүд хийдэг. Ямааны арьс нь угаасаа харьцангуй нимгэн, уян зөөлөн, бөх бат байдаг тул гутал, хувцас хийхэд туйлын тохиромжтой байна. Монгол ямааны арьс нь нас, хүйсний ялгаанаас болж, жингийн хувьд 1.5-4 кг, талбай нь 60-80 дм² байдаг бөгөөд жигдхэн зузаантай байдаг ажээ.

3.3 Мал аж ахуйн үндсэн нэгж өрх гэр-хот айл

Монгол оронд бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг уламжлалт хэлбэр нь өрх гэрийн буюу ардын аж ахуй юм. Ардын аж ахуйтнууд хэд хэдээрээ нэгдэн иийлж аж ахуйгаа хамтын хүчээр эрхлэх арга хэлбэрийг хот айл хэмээн нэрлэдэг билээ. Мөн хот айл нь монголын малчин ардууд буюу хөдөөгийн хүн амын нутагшил байршлын эртний уламжлалт хэлбэр юм.

Эхлээд монгол хэлний айл, хот, хот айл хэмээх үг хэллэг, утга илэрхийллийн агуулагыг товч боловч тайлбарлан үзэх нь зүйтэй мэт санагдана. Монгол хэлнээ “хойноос ирээд хот манайх, хотонд ороод **хонь** минийх” гэх мэтийн мал маллагааны арга ажиллагааны хэллэг гарсан байдаг билээ.

Мөн хот гэдэг үгний энэхүү нэгдэх утгаас үүдэн гарсанутга нэг нутаг дээр айлсаж буусан хэдэн малчин айлыг дан үгээр хот айл гэдэг хос үгээр илэрхийлсэн агуулгатай ижил утгаар тэдний хотныхон, манайхны хот хэмээн хэлдэг. Хот хэмээх үгний орчин үеийн нэг утга нь олон хүн ард төвлөрсөний хэмжээний орон барилга, зам талбайтай, үйлдвэр, үйлчилгээ, соёл боловсролын болон засаг захиргааны төвлөсөн газрыг хот гэдэг болжээ. Орчин үеийн томоохон төв суурин газрын хот хэмээх нэршил мал сүрэг бөөгнөрсөн хэвтэр газар болон малчин айлуудын нэгдлийг илэрхийлсэн зэрэг ер нь төвлөрөл, бөөгнөрлийн утгатайч малчин хот хэмээх үгнээс шууд гаралтай болов уу.

Тийнхүү хэд хэдэн малчин өрх айлууд нэг нутаг айлсан мал сүргээ хамтран маллаж ирсэн уламжлалт арга хэлбэрийг айл хэмээн томъёолж заншсан билээ. Хот газрын нэг хашаа, гудамжны айлуудыг хот айл гэдэггүй билээ. Үүний шалтгаан нь малын хоттой, малаа хотлуулдаг малчин айлуудыг гагцхүү хот айл гэх бөгөөд цаад утгаараа мал аж ахуйн үндсэн хэлбэр буюу аж ахуйн анхдагч нэгж хэсэг юм.

3.3.1 Хот айлын үүсэл

Эрт цагт овгийн зохион байгуулалтын үед малчин айлууд нэгэн хүрээнд бөөнөөрөө аж ахуйгаа эрхэлдэг байсан ажээ. Нүүдлийн хүрээ хэлбэр гэдэг нь нэгэн хүрээнийхэн шинэ нутаг сэлгэж нүүж буухдаа өрх айлууд нь дугуй хүрээ хэлбэрээр тойрон буудаг, дотор талд нь овгийн ахлагчийн өргөө гэр байсан хэмээх ойлголт тогтсон байдаг билээ. Энэ талаар эрдэмтэн Б.Я.Владимирцов “Обществетн.ш . ч1”»» монголов” (Монголчуудын нийгмийн байгуулал) хэмээх номдоо дурджээ.

Монголын түүхийн эрт үед (XIV зуун хүртэл) монголчууд хэсэг бүлгээрээ, эсвэл 2-3 гэр бүлээр буюу айлаар нүүдэг нүүлийн! хоёр хэлбэр байв. Заримдаа хэдэн зуун гэрүүд нэг доор хүрээлж буусан байх нь тааралддаг байжээ. Тийм олон гэртэй хүрээ мал сүргийгхалдлагаас хамгаалахад ашигтай боловч мал маллахад тохиромж муутай байсан. Тийм учраас монголчууд нүүдлийн хоёр аргыг хослуулж, гадны аюул заналгүй нөхцөлд хоёр дахь хэлбэр рүү шилжиж Гжйсан ажээ. Тэгээд төр улсын хүчтэй засаглал тогтсоноор олон гоогоор буюу хүрээгээр нүүх шаардлага байхгүй болжээ хэмээн тэмдэглэсэн байдаг юм. Тэгээд хүрээний дотор зарим айл өрх нь олон малтай болохын хамт хүрээнээсээ салж мал сүргээ тусгаарлан маллах явдал бий болжээ.

Тийнхүү, монголчуудын хүрээгээр аж төрөх хэлбэрээс хот айл Гюлох үйл явц нь урт удаан хугацаанд алгуур явагдсан бололтой. Иэгдсэн монгол улс бүрэлдэн тогтсон XIII зууны эхээр хүрээ болон хот айлын хэлбэрийн аль аль нь байсан бөгөөд сүүлдээ хот айлаар мүүж аж төрөх хэлбэр нэгэнт зонхилох болсон байжээ. Тэгэхээр хот айл нь маш эртний үүсэлтэй бөгөөд нүүдлийн мал аж ахуй эрхлэх, малчдын амьдарч, аж төрөх хэлбэр бөгөөд малчин хүмүүсийн хоорондын хөдөлмөрийн харилцааг илэрхийлэн тусгадаг нийгмийн чухал үзэгдэл юм.

3.3.2 Хот айлын бүрдэл

Хэд хэдэн малчин айл-ардын аж ахуйтан гол төлөв уртхан хугацаагаар айлсан бууж хот айлыг бүрэлдүүлдэг юм. Тогтмол нэг хотонд байдаг айлууд байх боловч янз бүрийн шалтгаа- наар нэг хотны айлууд салж нүүх, шинээр нийлэх зэргээр бүтэц бүрдэл өөрчлөгдөх явдал зөндөө байна. Хот айлын бүрэлдэх үйл явц нь гол төлөв ардын аж ахуйтны эдийн засгийн тодорхой хүчин зүйлс, нөхцөл байдлаас шалтгаалдаг ажээ. Тэгэхээр хот айл бол тодорхой гооны ардын аж ахуйтнуудын эдийн засгийн нэгдэл-хэсэг хэмээн нэрлэж болмоор байгаа юм. Яагаад гэвэл ямар ч тохиолдолд хот айл бол ердөө л хэдэн гэр биш чухамдаа мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлдэг хэсэг аж ахуйтны бүрдэл мөн тул эдийн засгийн агуулгатай байна.

3.3.3 Хот айл, нутагшил

Монголын нүүдэлчин малчид ганц өрхөөр бус, хэд хэдэн айл гэрийн жижиг нэгдлээр тодорхой хэмжээний газар нутагт нүүдэллэн амьдарч байв. XI-XII зууны үед нэгэн овгийн гаралтай төрөл садангийн бөөгнөрлийг “айл” гэж байсан бол феодалын бутралын үед буюу түүнээс хойш мал аж ахуй эрхэлсэн аливаа хэдэн өрх гэрийн нэгдлийг “хот” гэж нэрлэх болжээ. Монголын нууц товчоонд “хот” гэдэг үг нэгд, айлын суурьшин нутаглаж байгаа малын хэвтэш өтөг бууцны нэрээр, хоёрт, хүн амын бөөгнөрсөн нэгэн зүйл зохион байгуулалтын утгаар тохиолдоно.

“Монгол, Ойрадын их цааз”, “Халх журам” зэрэг сурвалж бичигт “айлын ах” (1), хотын ахлагч (2) гэж тусгайлан заасан байдаг нь хот айл бүр ахлагчтай байсан бололтой. Монгол орон манжийн захиргаанд орохоос өмнөх үеийн хууль цаазны дурсгалд хотын дотор болсон хэрэг явдалтай холбогдуулан түүний ахлагчийг торгох зэргээр зааснаас үзэхэд тэр үед хот нь засаг захиргааны хамгийн анхан шатны нэгж болж, түүний ахлагч хууль ёсны эрхтэй байжээ гэж болох юм. Гэвч хот айлын ахлагчийн байдлыг улируулан үзвэл тэр нь тухайн айл гэрүүдийн дотроос ураг, садангийн талаар хамгийн ахмад буюу эсвэл нэр хүндтэй, амьдралын туршлагаар баян, хөрөнгө чинээгээр давуу эцэг хүн байх нь эцгийн эрхт ёсны хөршийн хүйн үлдэгдлийн бас нэгэн улбаа бололтой.



Хот айл. Архангай. Тариат сум.
1967 он. Зургийг Г.Цэрэнханд.

(55-р зураг)

Хошуу нутгийн доторхи баг, отгийн хязгаарын дагуу тогтсон бэлчээр нутгийг эдлэж эзэмшихэд эцэг, хүү, ах дүүсийн хоорондын холбоо нэгдэл нэлээд нөлөөтэй байж гэж хэлж болно. Гэрлэсэн хүү нь эцэг эхийн бууцыг өвлөх эсвэл эцэг эхийн зааснаар ойролцоо гол горхиор айл саахалт болж нутагладаг байжээ. Хэрэв нутаг давчуу болбол хошууны тамгийн газарт мэдэгдэж, тэндээс нутаг заалгуулж авдаг байв. Хүүгээ айл болгоод ойр явуулахыг эрхэмлэн үздэг тал байсан боловч их малтай болбол холдож нутаглахаас өөр аргагүй болдог байжээ.



Хот айл. Төв халх. Өвөрхангай. Төгрөг сум.
1965 он. Зургийг Г.Цэрэнханд

(56-р зураг)

Малчдын бэлчээрийг эзэмших, эдлэх нь нарийн дэг журамтай байсан тухай эх сурвалж бичиг хууль цаазны баримт сэлтэд тодорхой тусгагдсан байдаг. Тухайлбал, халхын зургаан хошууны цааз эрхэмжийн дурсгал бичигт: “Отог бүгдээр зөвлөлгүй салж нутаглаваас хошууны хоёр элчээр хураалгах тухай...”. Мөн мичин жилийн (1620 оны) их цаазанд хаан ахын зүүн, баруун жигүүр болж отоглосон хэдэн их бага ноёд отог сольж нутаглаваас тавин адуу, таван тэмээ ав. Тавнан шигэчин нар салж нутаглаваас гурван ес ав” (3, 91, 98) гэжээ. Мөн хүний эзэлсэн усыг булаалдаж хэрэлдвээс нэгэн морь ав... Хуурч услахуул хонь ав, ус буртаглахуул морь, үхэр хоёр ав, үзсэн гэрч үхэр ав хэмээжээ(4, 83). Үүнээс үзэхэд хошууны доторхи отог, нутаг хоёр салшгүй холбоотой байсан бөгөөд нутгийг эдлэж эзэмшихэд нийгмийн анги давхраа тус бүр өөрийн эрх мэдэлтэй, түүнийг зөрчвөл тогтоосон торгууль эдэлдэг байжээ. Сайн ноён хан аймгийн Далай вангийн хошуу ар хамжлагад (одоогийн Хөвсгөл аймгийн Жаргалант сум) ноёны сүрэгчин (идээ бэлтгэдэг) гэж тусгай заагдсан сайн өвс ургамалтай нутагт нутагладаг хүмүүс (дархан сүрэгчин ч гэж нэрлэнэ)-т нутгийн ядуувтар айлууд аж ахуйд нь туслах нэрийдлээр нутаг усны нь хавсраганд хамрагдан өөрсдийн хэдэн малаа хариулж малладаг байжээ.

Угсаатны зүйн хээрийн судалгааны материалыг үндэслэн үзэхэд халхчуудын дунд эцэг, хүүгийн болон садан төрлийн өрхүүд нэг хот айлыг үүсгэх явдал голдуу зонхилох төлөвтэй байсан боловч заавал ах дүүсээрээ хот болно гэх албагүй, амьдралын шаардлага, аж ахуйгаа хөтлөх арга ажиллагаанаас улбаалан хотлон айлсах явдал байжээ. Иймд нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг монголчуудын хот айлын үндэс нь эцэг талаар овоглох төрөл садангийн хүйг илэрхийлэх өмч хөрөнгийн нэгдлийн үлдэгдэл төдий бус юм. Чухамхүү киргиз, казахын “аул”, индиан кечуачуудын “айлью”-тай адилтгах тал байгаа ч гэсэн өөрийн өвөрмөц онцлогтой билээ.

Нүүдлийн мал аж ахуй эрхлэх өвөрмөц нөхцөлд хотлон айлсаж нутаглах явдал юуны өмнө бэлчээр нутгийг хамтран ашиглах, малаа ээлжлэн хариулах, хүнд хүчир ажлаа (нүүх, эсгий хийх, хангал сургах, ноос хяргах гэх мэт) хамт олноороо гүйцэтгэхэд оршиж байв. Хот айлын нэгдэлд зөвхөн өрхүүдийн хооронд хөдөлмөрийн хоршоолол чухлаас гадна эд материалын талаар харилцан туслалцах ба сэтгэл

санааны сонирхлын нийтлэг зорилго байсан нь эртний уламжлалтай юм. Малчин хүний улирлын чанартай мал аж ахуйн ажлын онцлог, түүний зан үйл болон айл саахалтаар тэмдэглэх аливаа ёслол (цагаан сар, хүүхдийн угаалга, үс авах, гүүний үрсгаргах, гэр махтараах) зэрэг нь айлсан нутаглах нэгдлийг илэрхийлдэг учир нэлээд тогтвортой бөгөөд салж нүүх явдлыг ёс горимын хувьд зохисгүй гэж үздэг үзэл тэдний дунд зонхилж байжээ.

Дээр дурдсан ар хамжлагын нутгийн Цагаан Хавчууд Дашравдан хиагаар ахлуулсан Дамбийравдан, Рагчаа, Лодой, Балжингийнх гэдэг таван айл, Долоотод Бавуу ахлагчтай Сайнтогтох, Хорлоо, Гомбожав, Балдоо, Нямжавын зургаан гэр тус тус өвөлжижбайжээ. Эднийхний нэгний нь хотонд 500-600 орчим хонь, ямаа дундчаар байж, ер нь хэдэн өрхөөр айлсах вэ? гэдэг бол хотын малын тооноос ихэвчлэн шалтгаалахаас өв хөрөнгө эзэмшихтэй төдий л холбоогүй байсан мэт. Дашравдангийн хотонд дан ах дүүс айлсаж байсан ба Бавуугийн хотыг авч үзвэл Сайнтогтох хотын ахлагч Бавуутай зээ нагац нар бөгөөд Гомбожавынх нь ядуу айл байжээ. Үүнээс үзсэн ч хотын бүрэлдэхүүнд садан төрөл, эцэг хөвгүүдийн хэлхээ холбоо илэрлээ олсон байна.

Хөршийн хүйн задралын үеийг илтгэж болохуйц хотлон айлсах өрхүүд аливаа ажилд харилцан бие биедээ туслах, нүүдэллэх зэрэг хүч шаардагдах ажлыг хамтран гүйцэтгэж цагийн бэрхшээлийг давж ирсэн заншил нь нүүдэл ахуйн нөхцөлд хөдөлмөрөө зохицуулах соёл болон үлджээ. Хотын ахлагч хүн нүүх буух чиглэл тогтоож газар үзэх, мал маллагааны арга ажиллагаанд тохирсон малын бэлчээр нутгийг сонгох чадвар бүхий нийт хотынхны ашиг сонирхлыг хөндсөн өдий төдий ажлыг зохицуулж өгдөг нийгмийн чухал үүрэг гүйцэтгэдэг байв.

Хот айлын бүрэлдэхүүний өрхийн тоо монгол орны байгаль, газар зүйн онцлогтой уялдан хангай, говийн бүсэнд харилцан адилгүй байжээ. Хангайд гол төлөв 3-5 гэрээр хотлож байхад говьд ганц гэрээр нүүдэллэн аж төрдөг нь нийтлэг үзэгдэл байв. Говьд бол хоёр юмуу гурван гэрээр айлсан явааг хот гэж нэрлээд худаг усны нэрээр (Энгэрийн улаан, Дэлийн ус гэх мэт) тэр худаг хүн цөөнтэй, ганц хот, хоёр хот суудаг гэнэлээ гэхчлэн ярьдаг. Хотын айлууд хөрөнгө тусдаа бөгөөд ажил, хүчээ хамтрах зорилго бүхий болно. Нэгэнт хот айлын малын тоо олширч бэлчээр

хүрэлцээгүй болбол хотын айлууд салж нутагладаг байв. Мөн улирлын байдлаар бэлчээр хөөж (хаварт ногоолох) цөөн гэрээр бууна.

Хот айлын бүрэлдэхүүнд хөрөнгө чинээний хувьд баян, ядуу эсвэл жирийн (дунд жирийн хөрөнгө малтай) өрхүүд нэгдэхээс баячууд хоорондоо хотлон айлсдаггүй байжээ. Баян айлууд нэг дор хотолбол мал олон болох учраас нэг хотонд буух боломжгүй. Хувийн аж ахуйтны үед нэг доор баян ядуугаараа хотлоход баян нь ядуугийнхаа хөдөлмөрийг завших хандлагабайсан нь бидний судалгааны хэрэглэгдэхүүнээр нотлогдож буй. Тэрчлэн хотлон айлсахын түүхэн хөгжил болон түүний мөн чанар хэрхэн яаж хувьсаж ирсэн тухай Зөвлөлт, Монголын түүхчдийн бүтээлүүдэд тусгагдсан байдаг юм (5).

Бэлчээр усны зохицолдоо, хот дахь нэг хэвтэш бүхий бог малын тоо толгой, улирлын онцлог зэрэгтэй уялдаж хотлон айлсах байдал харилцан ялгаатай, тогтмол бус байжээ.Хотоор айлсан нутаглахын гол агуулга нь хүмүүсийн хоорондын харилцаа, аж ахуйгаа хөтлөх дэг журам, арга ажиллагааг зохицуулан нүүдэлчдийн аж төрөх хэвшлийн нэгэн илэрхийлэл болдогт оршино.Бидний судалгаанд хамрагдсан халх монголчууд нь хангай, говь, талын бүсэнд голчлон нутаглах бөгөөд тэдний дунд эрхлэх аж ахуйн онцлогтой уялдан аж төрөхийн хэвшил, зан үйл бүрэлдэн тогтсон аж. Тухайлбал, Төв, баруун, өмнөд халх нутгийнхан өвлийн эхэн сард буюу зул сар гармагц өвөлжөөлдөг заншилтай байжээ (6). Өвөлжөөнд гурван сар орчим нутаглах ба гол төлөв жалгын цээж барьж уулын хяраар хадны нөмөр, цочмог овооны энгэр, хонхордуу газрыг бараадаж өглөөний нар гарахад сүүдэргүй, орой нар үзэгдэж шингэх наран ээвэр нутагт өвөлжөө бууцаа сонгож засч ирсэн уламжлалтай юм. Тухайлбал, Дайчин бэйсийн нутагт Хатрантай уулын өвөр талд 33 гаруй бууц өвөлжөө байжээ. Үүнд: Цагаан эрэг, Хүрэн ханан, Оорцог, Хүрэн овоо, Буйлсан, Үзүүр ханан, Өнгөт хүрэн, Түймэрт зараа, Ташаа зараа, Хөх дэл, Хэрээ, Зүүн цайр, Шар цайр, Чулуун хороот гэх мэт. Эдгээр нь овооны энгэрт байрлагдсан ба тухайн газрын янзаар нэрлэгдсэн байв. Мөн Өмнөговь аймгийн Сэврэй уулын хяраар нөмөрлөн өвөлжиж бэлээр нь хаварждаг юм. Говь-Алтай аймгийн Тонхил сумын нутагт бол Аргалант, Тахийн шар нуруу, Хөх өндрийн ар, Яргайтын эх, Хонин усны говь зэрэг наран ээвэр нутагт өвөлжиж, Алтайн нутгийнхан бол өвлийн улиралд

Алтай нурууны доод хаялгаар нутаглаж байсан бөгөөд тэднийхний өвөлжөө бууц гэхээс гадна газар нутгийн нэрээр хослон нэрлэгдэх нь хэвшил болсон үзэгдэл юм.



Хаваржааны нутаг. Говийн бүс.

(57-р зураг)

Өвөлжөө бууц нь үе дамжиж эзэмшигдэж ирсэн түүхтэй боловч өмчилсөн бууц гэж төдийлөн яригдахгүй аж. Нэг бууцанд олон жил өвөлжсөн бол тэднийхний өвөлжөө ч гэнэ. Жишээ нь дээр үеийн Буйлсангийн бууцанд Осор тойныхон 4-5 үед (Осор, Хайдав, Намхай, Намсрай), 5 үед (Балбар, Чойдог, Луузан, Амбаа, Зулзагынх гэх мэт) тус тус нутаглаж байжээ (7). Үүнээс гадна үе дамжаагүй өвөлжөө бууц байдаг байжээ. Ийм бууцанд дахин дахин буухгүй, тэр бууцанд тэднийхэн буух гэнэлээ гэвэл тэнд хэнийх ч буух ёсгүй. Ийм тохиолдолд их шар бууцанд уралдаж буудаг байжээ. Гэхдээ айлын гэрийн бууринд гэр барихыг цээрлэнэ. Мал хорогдох, өвчин зовлон зэрэг золгүй явдал тохиолдсон бууцанд дахин нутаглахыг төдийлөн хүсэхгүй байжээ.



Өвөлжөө нутгийн байдал

(58-р зураг)

Өвөлжөөнд бол хангайд модон хашаа, говьд хөрзөн ба чулуун хороо байжээ (8). Саравчгүй хороог хөрзөн ба чулуугаар барина. Доод талыг чулуугаар барьж, хөрзөнгөөр өндөрлөсөн хороо ч бас байв. Эдгээр нь говьд бол бог малд зориулагдсан хагас дугаргуй, саран хэлбэртэй байж. Хангай нутагт хөрзөн хороо байгаагүй ба шон зоосон үе хашааг дүгрэгбарьдаг. Үе хашааны ар талаар салхины нөмөр хийх ба үүнийг хунгар давахгүй бөгөөд гол төлөв хотруу жавар ирдэг талд үхрийн хашаа барина. Өвөлд шөнө нь адууг хашиж мичид голлож үүр хаяарахад бэлчээх заншилтай. Энэ бүгдээс үзсэн ч өвөлжөө бууц бол бусдаасаа тогтмол байсан нь илэрхий.

Өвөлжөөндөө шинэлж, шинийн гурванд шар бууцнаас гарна гэдэг байв. Жин үдэд гэрийн эзэн хүн нутаг харахаар явж, сонгосон газраа дугуй зураад өвс, чулуу тавьж, гэрийн “он” авдаг ёстой. Хаварт голдуу хоёр хот болон салж нутаглана. Энэ нь өвөлд мал аль хэр орсонтой холбоотой. Зутрангуй орсон бол малаа салгаж хаваржаанд бууна. Цагаан сараар хонь хургалж эхлэх ба хурга, ишгээгэртээ хөгнөдөг (9). Нэг хөгнөнд 20-30 хурга хөгнөгдөх ба гэрт 4-5 хөгнө татаж, нийтдээ 200-гад хурга гэртээ оруулж болдог байв.

Хаваржих нутаг бол тогтмол бус гэхдээ нутгийн тодорхой баримжаатай бөгөөд тэднийхний хаваржаа гэж өөр айл тэнд буудаггүй заншилтай байжээ. Хаваржаанд голдуу уулын бэл, нөмөр бараадсан жалгын ам сүүдрийн жавар тусахгүй нам дор хөх өтөг хорголтой бууц нутгийг сонгодог байв. Хаваржааны нутаг нь өвөлжөөнөөс төдийлөн холгүй, задгай устай, цасанд хучигдаж хоцорсон өвс сайтай, амтлаг ургамалтай, говьд бол агь их гардаг, сэрүүн өвстэй газрыг сонгох ба жавар багатай нөмөрлөг, уулын бэл өтөг бараадуулан, тэндээ хаврын сарыг дуустал нутаглаж малаа төллүүлж, бойжуулах ба хаваржаанд ногоо дагаж хэд хэдэн удаа нутаг сэлгэдэг байжээ. Тухайлбал, дээр дурдсан Ар хамжлагын нутагт Цагаан хавчууд өвөлждөг айлууд бэлрүүгээ нүүж цагаан хавчуудийн цайрт хаваржиж байжээ. Үүнтэй адил Нарийн хавчуугийнхан Цохиот толгойд, Хар хавчуугийнхан Хар толгойд, Битүүгийнхэн доод эрэгт, Баруун загалынхан Модот хонход, Бэлчирийнхэн Ар толгойд, Асгатынхан Жалмангийн аманд, Хүүшийнх Гууд, Даваагынх Ажигын аманд тус тус хаварждаг байжээ (10).

Хаврын улиралд өвсгүй бол бэлчээр дагаж бууц сэлгэх буюу ногоо хөөж нэг хотын айлууд салж буух нь элбэг үзэгдэл байж. Ийм учраас хаваржаанд айлууд цөөнөөр хотлон айлсана. Хаваржаалах үедээ хонины задгай, саравчгүй хашаа, чулуугаар барина. Хэрэв модоор хийсэн буюу авч явах боломжтой бол нүүхдээ ачиж явна. Мэр сэр төлний пүнзтэй байсан ба хөрзөнгөө ховхолж амжаагүй үедээ хониндоо хөрзөн хашлага хийдэг байв. Хаваржих нутгийн баримжаанаас шалтгаалан хотноос нэлээд зайдуу тугалдаа дөрвөл (дөрвөн тал) хашаа барьж дотор нь чагттай зэл хэд хэдийг зэрэгцүүлэн татаж тугалаа уях ба үхрийг дөрөлж уядаг. Морь барихад зориулалттай адуу хоргоох задгай хашаа бас байв.



Намаржаа нутагт байгаа айлууд. Говийн бүс.

(59-р зураг)

Хаврын адаг сарын хуучаар буюу зуны эхэн сарын шинийн наймнаас өмнө зусланд бууж, хонио (тогтоон) сааж эхлэнэ. Тэднийхний зуслан гээд тогтмол нэг газар байхгүй голын хөндийг бараадан, устай өндөрлөг сэрүүн нутгийг сонгож зусна. Ялангуяа, цэцэг, яргуй элбэгтэй нарийн ургамалтай газрыг эрхэмлэж, говьд бол цэлгэр тэлгэр, алс бараа харагдах нутгийг сонгоно. Өлөн, хөвд борогтой нутаг дургүй. Нэг нутагт удаан суухгүй нүүдэл голчлоно. Хавар тэнхрэлтэндээ, зун таргалалтандаа дээр гээд цөөн цөөнөөр голлон айлсана. Гэхдээ зуны улиралд хонь, хургаа саахлан маллаж хоорондоо километрээс холгүй зайд нутагладаг заншилтай. Хот айлууд хургаа саахлах тухайгаа эртнээс тохиролцож, саах тавих өдрөө товлож, тогтсон дэг ёс, зарчмын дагуу саахлан нутаглаж байжээ (11). Саахлах нь хотлон айлсахын бас нэг өвөрмөц хэлбэр юм. Далай вангийн хошууны нутагт саах тавих нь харьцангуй ховор байжээ. Хаваржаа зуслангийн нутаг хоорондоо арван км-ээс

дотогш байгаагүй ба зусах бууцанд хурга, тугалд болон хонинд сийргэр хашаа барьж бороо их орсон үед зайлуулдаг байв.



Зусланд байгаа айлууд. Хангайн бүс нутаг.

(60-р зураг)

Намаржаа бол сэрүүвтэр нутагт байна (12). Зунд авсан малын тарга хүчийг тогтоох явдал чухалучир намрын эхэн сард их нүүлгүй, малаа хайлж турахаас болгоомжлоно. Мал таргалуулахаар отроор явж өвөл, зунд мал хүрч идээгүй бэлчээрийг барж иддэг. Нэг дор олон хонь байвал турна гэж 200-300-аад хоньтой ч хотлоно. Чоно элбэг бол хонины хашаа барьдаг. Ер нь намаржаанд зэл татсан тугалын хашаа л байна. Намрын дунд сар хүргэж хотлон өвөлжих айлууд бөөндүү бууна. Намаржаанд арьс нэхий элдэх, гэрийн бүрээс шинэтгэх, сэлбэх, эсгий хийх зэрэг ажлыг голчлохоос гадна намрын сэрүүн ороход өвөлд бэлтгэх, унага тавих, цасны найр зэрэг улирлын чанартай баяр ёслол тэмдэглэгддэг.

Намаржааны нутаг нь голынхөндийгөөс гарч хаваржаалсаннутгийн ойролцоо уснаас зайдууговь хярын заагт угтаа өвөлжөө рүүгээ дөхөх хандлагатай болно. Ер нь зунд ус хөөж нүүдэг болнамарт бэлчээр хөөж нүүнэ. Жишээ нь: Цагаан хавчуугийн намаржаа нь өвөлжөө талдаа, хаваржаанаасаа 5-6 км-т байжээ. Мөн нарийн хавчууд өвөлждөг айлууд Эрдэнэ толгойд, Хар хавчуугийнхан Хар толгойн доод гууд, Баруун загалынхан Даваатын аманд, Бэлчээрийнхэн дээд Ар толгойд, Зүүн загалынхан Жалмангийн Ардөрөлж аманд, Асгатынхан Улаанүзүүрт, Имгэнтийнх доод ар толгойд, Бага булгийнхан Тэвхнийгууд, Хүүшийхэн Майхан толгойд тус тус намарждаг

байжээ. Иймэрхүү өвөл, хавар, намрын бууц нутаг ойр байхнөхцөлд хотлон айлсаж буусан айлууд нарийн дэг журмыг баримтлан бэлчээрээ хуваарьтай ашиглаж, нөөцөлдөг заншилтай байв. Бэлчээрийн төлөө маргаан гардаг ба дэл сул мал нутгийн нь бэлчээрт орвол хэрүүл болдог чудаа тохиолдоно. Үүний дараа “сэтгэлээ цайлгая” гэж хэн хэндээ юм бодолцохгүйгээр тамхи нэрдэг заншилтай байжээ. Бууцаа сонгож аваад буух газраа тэднийхийг тэнд, эднийхийг энд гэж шав чулуу, үхрийн баасаар буюу тэгэхдээ ахмад хүн буйраа үзэж, өвс, ус, хужир элбэгтэй өргөн дэлгэр нутгийг сонгон 3 чулуу хомоолын хамт тавьдаг. Тэр газар ямар ч айл буухгүй, хэн ч түүнийг хөдөлгөх ёсгүй ба энэ нь айлуудын бэлчээр эзэмшиж ашиглах эрхийг заасан хэв хууль болж заншсан юм.



Отрын шинэ нутагт буухаар нүүж яваа нь. Дорнодын тал хээрийн бүс.

(61-р зураг)

Жилийн аль ч улиралд айлууд шинэ нутагт нүүж буухдаа гэрээ зэрэгцүүлэхгүй хотоо тойрч дугуйрсан хэлбэрээр малаа хамгаалж барьдаг заншилтай байжээ. Үүнтэй уялдан хот айлын доторхи зохион байгуулалт нь эртнээс уламжлагдсан нарийн дэг ёсыг баримталдаг байв. Тухайлбал, хот айлын хүрээнд баруун ба баруун хойт зүг эрхэмд тооцогдоно. Нар эхлэж тусах баруун хойт зүгийг эр зүг гэж нэрлэх ажээ. Харин нар жаргах зүгийн эсрэг зүүн өмнөх зүг сайнд орохгүй. Иймд хотолж бууна гэхэд эцгийн буюу хотын ахлагчийн гэр хотынхоо баруун өмнө талд хүүгийн гэр зүүн талд тус тус баригддаг заншилтай байв. Өвөлжөөнд ганц гэрээр бол тэр нь голдуу хотны баруун захад байна. Хэрэв хоёр гэр байвал хонины хотны хоёр талд буюу хотны шанаагаар барихаас, хотын өмнө хойно голлож барих ёсгүй байв. Гэрийн үүдийг өмнө зүгт (чанх урагш) харуулж, алсын бараатай, налгар уулруу чиглүүлэн,

голын урсгал сөрсөн эх рүү нь маягтай барьдаг заншилтай. Харин гэрийн үүд уулын хөтөл, ам, цаад уулын шовх орой, усны тохой, урсгалын уруу чиглүүлэх болон зам голлуулахыг цээрлэж байв. Хотонд бог мал л нэгэн хэвтэртэй байж, түүгээр ч хот айл хэмээн нэрлэгдэх бөгөөд бусад мал тус тусдаа хэвтэш зэлтэй байдаг юм. Тухайлбал, өвөлд хонь, ямаагаа хотлуулж, үхэр, тэмээний хэвтшинд зэл татаж адууны зогсоолтой байх бөгөөд зуны улиралд гүүн зэл гэрийн эзний аль сайн зүгт гэх ба голдуу хотны өмнө татдаг ёстой байжээ. Мал сүргийн дотроос адууг эрхэмлэн хүндэтгэж ирсэнтэй уялдан хот айлд морины уяа салхины дээр хотны хойно эсвэл баруун ба баруун урьд чигт байна. Халхчуудын дунд гэрийн баруун талаас морь хавчуулдаг боловч, энэ нь төдий л дэлгэр бус юм. Морины уяаг гацуур модыг их төлөв 6 тал шовхолж 3 хэрчим гаргаж хийхээс биш хус модоор төдий л хийдэггүй байв. Уяаны хэрмийг баруун, зүүн тийш татдаг заншилтай. Айлд ирж буй гадны хүн нохой хорь гэж мэдээ өгөхдөө морины уяанд тулж ирсэн байх ёстой гэдэг байв. Урьд хот хамгаалах мануухай босгохын зэрэгцээгээр айл бүр 2-3 нохой заавал тэжээдэг байжээ.

-Гаргалгаа

Жилийн дөрвөн улиралд малын төрөл төрөлд тохирсон бэлчээр нутгийг сонгон нутагшиж ирсэн аж төрөх ёсны түүх бол монголын нүүдэлчдийн хотлон айлсах соёлыг бүтээжээ. Ялангуяа, байгалийн тодорхой бүсэд ямар малд ямар өвс ургамал тохирдог, нутагшлыг хэрхэн яаж сонгох дэг журам болон мал аж ахуйг хөтлөх нь үеэс үед уламжлан амьдралын туршлагаар баяжиж иржээ.

Айлсан нутагших тухай асуудлыг тухайлбал, хотны бүрэлдэхүүн садан төрлийн нэгдэл зонхилж, ахмад эрэгтэй хүн гол суурь эзэлж байсныг авч үзвэл нүүдлийн хөршийн хүйн үлдэгдлийг илтгэх зарим санаа дүгнэлтэнд хүрч болох боловч нүүдлийн мал аж ахуйн онцлогтой уялдан тэр нь эрт үед задарч хөгжлийн өвөрмөц хандлагыг агуулах болж хотлон айлсахын үндэс нь хөдөлмөр зохион байгуулалтын нэгэн хэлбэрт шилжсэн мэт. Энэ нь юуны өмнө байнгын ба улирлын чанартай хөдөлмөрөө зохицуулахдаа нутагшил нэгтэйн зэрэгцээгээр ёс суртахууны нэгэн хэв шинжинд тулгуурлаж байсанд оршино.

4. МОНГОЛ МАЛЧИН: ОДОО БА ИРЭЭДҮЙ

4.1 Мал аж ахуйн одоогийн байдлын товч тойм

Мал аж ахуйн салбар нь хүн амыг хүнсээр, боловсруулах үйлдвэрүүдийг түүхий эдээр хангах, үндсэн эх булаг байсаар ирсэн. Одоо ч энэ ач холбогдлоо алдаагүй байна. Өөрөөр хэлбэл, мал аж ахуйн хөгжлөөс манай орны эдийн засаг ихээхэн хамааралтай хэвээр байна.

Хөдөө аж ахуйн салбар, үүний дотор мал аж ахуй нь эдийн засаг, хөдөлмөр эрхлэлт, экспортын орлого, дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлд жинтэй байр суурь эзэлдэг. Улсын нийт ажиллагсдын 28 орчим хувь тухайн салбарт ажиллаж, мал аж ахуйн бүтээгдэхүүний борлуулалтын орлогоор амьжиргааныхаа үндсэн эх булгийг бүрдүүлж байна. Энэ салбараас хөдөө аж ахуйн нийт бүтээгдэхүүний 80 орчим хувийг үйлдвэрлэж, экспортын орлогын арав гаруй хувийг бүрдүүлж байна. Улсын нийт хүн амын гуравны нэг нь зөвхөн мал аж ахуйн орлогоор амьдардаг бөгөөд бүх хүн амыг шууд бус байдлаар хүнс, тэжээлээр хангадаг. 2015 оны эцэст малын тоо 55,9 саяд хүрч, малчин өрхийн тоо 153,1 мянга болж, өмнөх оныхоос 3,6 мянгаар буюу 2,2 хувиар өссөн бол, 2016 оны эцэст малын тоо 61,5 саяд хүрсэн байна.

Мал аж ахуйн салбар Монгол Улсын нийт бүтээгдэхүүнд сүүлийн дөрвөн жилийн байдлаар 16,1 хувь, ХАА, ой, ан агнуурын салбарын нийт бүтээгдэхүүний 78,7 хувийг үйлдвэрлэсэн байна. Тус улсад нутгийн шилмэл омгийн малыг өөр дотор нь шилэн сонгох, тохируулан сонгож үржүүлэх замаар гарган авсан хонины Орхон, Байдраг, Говь Алтай, Баяд, Сартуул, Үзэмчин, Керей, Дархад, Барга, Ерөө, Тамир, Сутай, Тал нутгийн цагаан, Алтанбулаг, Сүмбэр, Хангай, Хотонт, ямааны Эрчимийн хар, Уулын бор, Алтайн улаан, Залаа-Жинстийн цагаан, Баяндэлгэр, Өлгийн улаан, Говь гурван сайхан, Сэлэнгэ, Дорнод талын үхэр, Галшар, Тэс, Дархад адуу, Галбын говийн улаан, Ханын Хэцийн хүрэн, Төхөм тунгалагийн хүрэн тэмээ зэрэг 55 үүлдэр, омог, үржлийн хэсгийн, нутгийн шилмэл малыг өсгөн үржүүлж байна.

Хөвсгөлийн зарим сумдад цаа буга, Сэлэнгийн Шаамарт “Халиун” удмын зөгийн цөм сүрэг бий болж, одоо аймгийн 20 аж ахуйд дээрх удмын зөгийг үржүүлж байгаагийн зэрэгцээ олон газар гахай, шувууны аж ахуйг эрхлэж байна.

Нийт 170 гаруй мянган малчин өрхийн 30,7 хувийг 100 хүртэлх, 56,9 хувийг нь 200 хүртэл толгой малтай өрх эзэлж байгаа нь тэдэнд өргөтгөсөн нөхөн үйлдвэрлэл явуулах боломжгүй шахам, зөвхөн амиа аргацаасан аж ахуйн хэв шинжтэй байгаа нь ойлгомжтой. “Монголын нүүдэлчдийн амьжиргааны судалгаа”-ны тайланд “Малчин өрх одоогийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх орлого олохын тулд 200-гаас дээш малтай байх шаардлагатай, мөн 200-аас доош тооны малтай өрх орлогоороо зарлагаа нөхөж чадахгүй байна” гэжээ. Монгол улсын хүн ам нь хөгширч буй үндэстэн биш мөртлөө малчид нь хөгшрөх хандлагатай болжээ. Малчин өрхийн тоо цөөрч, мал сүргийн дийлэнх хэсэг нь цөөн тооны малчин өрхөд харьяалагдан шилжиж, малгүй буюу цөөн малтай өрхүүд хөдөөнөөс төв суурин руу шилжих шилжилт хөдөлгөөн эрчимтэй үргэлжлэх төлөвтэй байна.

Монгол орны бэлчээрийн мал аж ахуйг эргэн харахад түүний нүүдлийн хэв шинж ихээхэн өөрчлөгдөж, суурин буюу хагас суурин хэлбэрт шилжих хандлагатай болжээ. Энэ нь бэлчээрийн мал аж ахуйн оршин тогтнохын үндэс болсон бэлчээрийг дөрвөн улирлаар сэлгэн ашиглаж ирсэн уламжлал алдагдаж, бэлчээр талхлагдахад хүрэх гол шалтгаан болж байна. Манай малчид өдий хүртэл малынхаа тоо толгойг олшруулан, өсгөх замаар л амьдралынхаа хэрэгцээг хангаж, ашиг орлогоо нэмэгдүүлнэ гэж үзэж ирсэн. Гэтэл түүнд нь нөлөөлдөг хамгийн гол хүчин зүйл болох бэлчээрийн хэмжээ, бэлчээрийн ургамлын ургац жил ирэх тусам багасаж, харин малын тоо толгой өсөж, нэг малаас ашиглах ашиг шим тогтмол багасч, бүтээгдэхүүний зах зээлийн үнэ төдийлөн өөрчлөгдөхгүй, харин ч буурч, мал аж ахуйн уламжлалт технологи алдагдан, шинжлэх ухааны ололт, дэвшил нэвтрэхгүй, байгаль цаг уурын хүчин зүйлс ихээхэн сөрөг нөлөө үзүүлэх болсон нь үнэн.

Манай улсын бэлчээр, хадлангийн талбай одоогоор 113 сая га байгаа бөгөөд энэ нь 1964 оныхоос 7,5 хувь буюу 9,1 сая га-гаар багасчээ. Эрдэмтэн судлаачид бэлчээрийн даацанд тохирох малын тоог таван төрлийн малын биет тоо болон хонин толгойд шилжүүлсэн тоогоор тооцож, улсын хэмжээнд өнтэй жилд нийт мал өвөл, хаврын улиралд 37 сая, зун, намар 42 сая, хэвийн жилд 32-37 сая, ган, зудтай жилд бол 28-33 сая байвал зохино” гэж тодорхойлсон байдаг. Тэгвэл сүүлийн 66 жилийн 63,6 хувь нь хэвийн, 30,3 хувь нь гандуу буюу зудархуу, их ган, зудтай буюу 1945-

1946, 2000-2002, 2010 оных шиг онцгой хүнд жил 6,1 хувь тохиолдож байв. Малын хорогдлын хувь хэвийн жилд 3,5 хувь, гандуу, зудархаг жилд 7,5 хувь, их ган зудтай жилд 26,1 хувь байжээ. 1999-2002 оны гурван жил дараалсан ган, зудын нөлөөгөөр хорогдсон малыг тухайн үеийн зах зээлийн ханшаар тооцоход бараг 500 тэрбум төгрөгийн шууд хохирол учирчээ гэж эдийн засагчид тооцсон байдаг. Эдгээр зудын үед Засгийн Газар, олон улсын байгууллагын зүгээс үзүүлсэн тусламж, зарцуулсан мөнгөн болон мөнгөн бус хөрөнгийг нэмж тооцвол дээрх хохирол ихээхэн өснө. Зудын улмаас малчин өрхийн тоо 38 мянгаар буурч, малгүй болсон нь төв суурин бараадаж, ажилгүйчүүдийн зарим нь алтны “нинжа” нарын эгнээнд шилжжээ. Зөвхөн 2009-2010 оны ганцхан өвөл 11 сая малыг зуданд алдсан байдаг. Эдгээр баримтаас үзэхэд ган, зуд зэрэг гамшиг дахин тохиолдохгүй гэх ямар ч баталгаа байхгүй. Иймд юуны өмнө тухайн жилний цаг уурын нөхцөл байдалд нийцүүлэн өвөлжиж, хаваржих малын тоог бэлчээрийн даацанд тохируулж байх шаардлагатайг амьдрал харуулж байна. Ахмад туршлагатай малчдын халааг авч буй шинэ үеийн, шинэ зууны малчидыг төр засгийн бодлогоор олноор нь бэлтгэж, “малчин мэргэжил”-д жинхэнэ ёсоор мэргэшүүлэх шаардлагатай байна.

4.2 Мал аж ахуй ба зах зээл

Монголчуудын амьжиргааны үндэс нь бэлчээрийн мал аж ахуй байсаар ирсэн. Одоо ч манай малчин ардын аж амьдрал бэлчээрийн мал аж ахуй дээр тогтож байна.

Эрдэмтэн судлаачид XXI зууныг “Шинжлэх ухаан, технологи, мэдээллийн эрчимтэй хөгжлийн зуун” гэж тодорхойлж байна. Лавтайяа 5000-аад жилийн түүхтэй малчин амьдралын хэв маяг, соёл, мал аж ахуйн ажиллагааны технологид ихээхэн өөрчлөлт гарч, шинэчлэл хийгдэх нь тодорхой боллоо.

Өнөө цагт дэлхийн уур амьсгалын өөрчлөлтөөс хамааралтайгаар байгалийн тэнцвэр, зохилдлого алдагдаж хүлэмжийн хий (CO₂), нарны туяаны идэвхжил ихэсч озоны цоорхой үүссэн, мөнх цас, хойд туйлын мөс хайлж, далайн усны түвшин өөрчлөгдөж, агаар мандал, газрын гадарга ихээхэн халахад хүрч дулаарал үүссэнээс болж далайн хар шуурга, далай дорх газар хөдлөлт, цунами, үер, аадар, ган, зуд, элдэв халдварт өвчин зэрэг гамшигт үзэгдлүүд тохиолдох боллоо. Энэ бүгдээс хөдөө

аж ахуйн хортон шавьж, ялаа шумуулын нүүдэл ихсэж, урьд тун ховор гардаг, мөн огт гардаггүй байсан хүн, малын халдварт өвчнүүд олноороо гарч байгаа нь байгаль орчин, мал сүрэг, ер нь амьд бие махбодь, хүн төрөлхтөний аж амьдралд ихээхэн аюул занал учруулсаар байна.

Дулаарлаас болж ган болох давтамж илт ойртож, газрын хөрс хатаж, цөлжиж буйгаас биологийн амьд төрөл зүйл устаж, түүний дотор бэлчээрийн өвс ургамлын төрөл зүйл, ургац, шимт чанар ихээхэн буурах болов. Мөн уул уурхайн олборлох үйлдвэрүүдийн буруутай үйл ажиллагаа, гандалт, цөлжилтөөс шалтгаалж олон тооны цөөрөм, гол, горхи, булаг, харз ширгэв.

Гэвч манай мал аж ахуй ган, зуд, малын халдварт өвчин зэрэг эрсдэлээс хараат байдалтай хэвээрээ байгаа. Сүүлийн үед уламжлалт нүүдэл суудал алдагдсан, малын тооны хэт өсөлт зэргээс шалтгаалсан бэлчээрийн доройтол, түүнээс сэргийлэх, хамгаалах талаар тодорхой арга хэмжээ авахгүй цаг алдсанаас болж цаашдаа уламжлалт энэ салбар хэрхэн оршин тогтнох вэ? гэдэг нь ихээхэн бүдгэрсэн.

Мал сүргийг эрүүлжүүлэх талаар 1990-ээд оныг хүртэл олсон амжилт, хүрсэн үр дүнгээс ихээхэн ухарснаас мал, малын гаралтай бүтээгдэхүүний эрүүл ахуй, чанарын шаардлага нь өнөөгийн гадаад зах зээлийн шаардлагыг хангахгүй болсон. Ялангуяа махан дээр. Энэ шаардлагад нийцтэл малаа эрүүлжүүлэхэд төрөөс ч, эзэн малчнаас ч ихээхэн хүч хөдөлмөр, цаг хугацаа, хариуцлага шаардагдана. (Энэ талаар тусгайд нь өгүүлэх болно)

Хашир туршлагатай малчдын залгамж үе залуу малчид цөөрсөн. Малыг үржлийн ажил хүрсэн түвшингээсээ ихээхэн доош унасан тул нэг малаас ашиглах гол нэрийн ашиг шим, тэдгээрийн чанар зах зээлийн хэрэгцээ шаардлагыг хангахгүй болсон зэргийг дурдаж болно. Чанарын хувьд л гэхэд хэрвээ ноолуурын голчийг 0.1 микроноор нарийсгаж чадвал 50 центийн, 16 микроныг 15 микрон болгож чадвал 1 кг самнасан ноолуур тутмаас 5 ам.доллар буюу 10,000-12,000 төгрөг нэмж олох боломжтой. Нарийн, нарийвтар ноостой тусгайлан ялгаж суурилсан олон зуун мянган хонь өнөөдөр хаана, хэд байгааг тогтоох, тооцох аргагүй. Тийм ноосоор хийсэн

эцсийн бүтээгдэхүүн зах зээлд хавьгүй өндөр үнэ хүрдэг байсан үеийг сэргээхэд дор хаяад 10-20 жил шаардагдана.

Дэлхий дээр 2012 оны байдлаар нийтдээ 4,5 тэрбум толгой мал, үүнээс үхэр 1,5 тэрбум, хонь 1 тэрбум гаруй, ямаа 1 тэрбум шахам, адуу 60 сая, тэмээ 25 сая толгой байна. Дэлхийд АНУ 10 сая адуугаар, Энэтхэг 210 сая үхэр, мөн 950 сая ямаагаар, Сомали 7 сая тэмээгээр, Хятад 130 сая хониор тус тус тэргүүлж байна.

Дээрхээс харвал том гүрнүүд л олон тооны малтай байна. Энэ нь Монгол улсаас мал аж ахуйн гол бүтээгдэхүүн болох мах болон бусад зарим бүтээгдэхүүнийг экспортлох хэмжээг хязгаарлаж байна. Дэлхийн хүн амын 0.2 хувийг эзэлдэг Монголчууд дэлхийн нийт малын 3 шахам хувийг эзэлж, бөмбөрцгийн нэг хүнд нэг толгой мал чадан ядан ногдож байгаа бол манай Монголын нэг хүнд 25-30 орчим толгой мал ногдож байна.

Манай улсад мал аж ахуйгаас бэлтгэн нийлүүлж байгаа төрөл бүрийн бүтээгдэхүүн-түүхий эдээсээ мах, сүүг дотооддоо хэрэглэж, үлдсэн хэсгийг нь өмнөд хөршид, зарим нэгийг нь бусад орнуудад бараг түүхий эд чигээр нь маш хямдхан үнээр ачуулж, ойролцоогоор 300 орчим сая ам.доллар олж байна.

Сүүлийн хэдэн жилд тохиож буй цаг уурын тааламжтай нөхцөл, дээр нь бас ч гэж төр засгаас малчдыг дэмжих талаар авч буй арга хэмжээний үрээр мал сүрэг тооны хувьд бэлчээрийнхээ даацаас хэтэртлээ өсөв. Өнөөдөр захын малчин интернетэд холбогдон мотоциклоор малаа хариулж, арваадхан бог зараад л оюутан хүүхдийнхээ төлбөрийг төлөөд өндөр үнэтэй хурдан морь, хөөрөг, гаанс, эмээл, хазаар, машин, техник худалдан авдаг болсон нь үнэн. Урьд нь төлөвлөгөөтэйгээр өсгөн үржүүлж байсан нутгийн шилмэл үүлдэр омгийн мал, дээр нь сүүлийн үед гаднаас оруулж ирсэн өндөр ашиг шимт үүлдрийн мал тэднийдээр байна.

Энэ бүгд нь манай мал аж ахуйн салбарт дотоод төдийгүй гадаад зах зээлд өрсөлдөх асар их боломж байгааг гэрчилнэ.

Эрдэмтэд, холбогдох байгууллагуудаас гаргасан тооцоо, судалгаанаас үзэхэд хэрэв бид мал аж ахуйн түүхий эдээ дотооддоо боловсруулан эцсийн бүтээгдэхүүн

болгож экспортловол одоогийн уул уурхайгаас оруулж буй ашиг орлогоос ч илүүг олох боломжтой гэж үздэг.

Эцсийн бүтээгдэхүүн болгоод зөвхөн Европ, Зүүн Азийн зах зээлд нэвтэрч чадвал мал аж ахуйгаас олон тэрбум доллар өлхөн олно гэсэн тооцоо хийсэн судлаачид байна.

- Монгол хонины мах - Арабын ертөнцөд, үхрийн мах — төв Европт, адууны болон ямааны мах - Орос, Хятад, Японд, арьс ширэн эдлэл Европт гэх мэтээр манай аж ахуйн бүтээгдэхүүн гадны мөнгөтэй хүмүүсийн эрэлт хэрэгцээнд нийцнэ.Хятадулсад гэхэд л сүүлийн жилүүдэд бэлчээрийн малын махны хэрэглээ, энэ чиглэлийнхалуун тогоом хоолны тоо өсөн нэмэгдэж, Монгол Улсаас дулаан аргаар боловсруулсанмах экспортлохоор болсон байна. Тэдний дотоод зах зээлд л гэхэд хонины мах 30 орчим юань байсан бол одоо 66 юань болтлоо өссөн байна. Гэтэл тэднийхний хамгийн их хэрэглэдэг гахайн мах гэхэд 1 кг нь 10 гаруйхан юаны үнэтэй байгаа аж(Өдрийн сонин, 2015.04.21 №099/5051). Дулаан аргаар боловсруулна гэдэг нь нядалсан хонь,үхрийн махыг 80-90 градуст 10-20 минут усанд чанах, уураар болгох утах гэхмэт аргаар болгож боловсруулаад вакумдахыг хэлж байна. Ингэж эхний шатанд болгож чанан элдэв нян бактерийг нь устгадаг байна. АНУ мэтийн суурин мал аж ахуй эрчимтэйхөгжсөн орнуудад үхэр, гахай бусад мал амьтныг зохиомлоор өндөр ургацандхүргэж,хураан авсан эрдэнэ шишээр тэжээж, бордож байгаагаас тэдгээрийн маханд “Омега-6” их байдаг нь хүний биед элдэв үрэвсэл эмгэг согог үүсгэдэг нь нэгэнт тогтоогдож, жимсногоо илүү хэрэглэхийг эрдэмтэд зөвлөх болжээ. Гэтэл Монгол бэлчээрийн малд буй“Омега-3” нь тархи, зүрхний үйл ажиллагааг дэмждэг аж.
- Бидний зөвхөн ядуучуудын идэх ёстой мэтээр үздэг дотор мах л гэхэд өндөр хөгжилтэй орнуудад чанарлаг хүнс төдийгүй био бэлдмэл, эмийн чухал түүхий эдийн жагсаалтанд ордог. Хонь, ямааны өлөн гэдэс Германд хамгийн их үнэд хүрнэ. Малыг шулсан яс л гэхэд Хятад, Солонгос гэх мэт аль ч оронд эмийн, бордооны, тосны гэх мэт үйлдвэрлэлийн чухал түүхий эд бөгөөд өнөөдөр ясны хэрэгцээ улам бүр нэмэгдэж байна.

- Дэлхийн хүн амын 20 шахам хувь нь нефть, химийн үйлдвэрийн хаягдлаар хийсэн хувцас өмсөж байгаа нь элдэв харшлын өвчин үүсэх гол нэг шалтгаан болж байгаа тул Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, холбогдох эрдэмтэн судлаачид цэвэр ноосон даавуун хувнас өмсөхийг зөвлөж байна. Гэтэл хүн амын 30 хувь л тийм хувцас худалдан авах чадвартай аж. Дэлхийд цэвэр ноосон хувцасны зах зээл дээр 30 орчим тэрбум доллар эргэлддэг байна.

Манайд орон сууцны барилгын дулаалгыг хятад хөөсөнцрөөр хийж ирсэн. Гэтэл хонины ноос, түүн дотроо манайхны гологдмол-хаягдалд тооцдог шахам ноос дулааныг барьж, хадгалах чадвар нь хавьгүй илүү учир түүний зах зээлийн эрэлт хэрэгцээ ихсэж байна. Хөөсөнцөр гал түймэр гарах нэг шалтгаан болдог. Орост л гэхэд Сибирийн бүсэд дулаалганд хөөсөнцөр хэрэглэхийг хориглосон. Тэд Австрали хонины ноос ихээр оруулах шийдэлд хүрээд байгаа билээ.

- Монгол улс ямааны ноолуурынхаа хэмжээгээр дэлхийд 2 дугаарт ордог. Дээр нь сарлагийн хөөвөр, ботго, торомны болон тэмээний эм ноос нь ямааны ноолуураас дутахааргүй нарийн ширхэгтэй, тэдгээрээр хийсэн даавуу, хувцас, хөнжил зэрэг барааны зах зээлийн эрэлт хэрэгцээ эрс нэмэгдэв. Монгол эрдэмтэд малын бааснаас эрчим хүч ялгаруулах технологийг олон жилийн өмнө боловсруулсан бөгөөд түүнээс хийн түлш гаргаж авах бүрэн боломжтой. 50 сая малын баасаар баруун гурван аймгийн дулааныг хангах боломжтой гэсэн тооцоо дүгнэлт бэлэн байгаа.
- Ингэний сүү гэж дэлхийд ховор, хүний эрүүл мэндэд тустай энэ идээг насан туршдаа хэрэглэж ирсэн хүмүүс хортой, хоргүй хавдар, элэг цэсний өвчнөөр өвчилдөггүй зэрэг эмчилгээ, сувилгааны гайхамшигтай шинж чанарыг дотоод, гадаадад өргөн сурталчлан таниулах нь өнөөгийн зах зээлийн нэг шаардлага мөн. Ингэний сүү, цагаан идээгээр Монгол улс дэлхийн зах зээлд гарах бүрэн боломжтой юм. Мөн тэмээн уралдаан, тэмээн поло гэх мэтчилэн тэмээн спортыг хөгжүүлж, ингэний сүүний сувиллын аж ахуй байгуулах зэргээр орон нутагт зарим сайхан санаачилгууд гарч байгааг бүх талаар дэмжих хэрэгтэй байна.

Дээр дурдсанаас үндэслэн малын амьсгалаас бусдыг бүрэн ашиглаж, боловсруулж нэмүү өртөг шингээн эцсийн бүтээгдэхүүн болгон дотоод, гадаадын зах зээлд борлуулах бүрэн боломжтойг дахин тэмдэглэе. Гагцхүү манайд мал аж ахуйн

түүхий эдийг (мах, сүү, арьс шир, ноос, ноолуур, яс, өлөн гэдэс гэх мэт) боловсруулах, эцсийн бүтээгдэхүүн болгох үйлдвэрүүдийг олноор нь байгуулж байж л өндөр ашиг олно.

Дээр нь хэрвээ төр засгаас онцлон анхаарч дэлхийн хөгжилтэй орнуудад байдаг шиг “байгалийн”, “сүм хийдийн”, бүр ойрхон жишээ гэвэл Өвөр Монголын түүх, дурсгалын цогцолбор газруудтай төстэй Монгол мал, Монгол малчны, Нүүдлийн соёл иргэншил, түүх, өв уламжлал, ёс заншлыг харуулсан томоохон цогцолбор газруудыг бүс нутгуудад байгуулах юм бол гадна, дотны олон мянган жуулчид тэнд очиж, сонирхон алжаалаа тайлж хичнээн орлого орж ирэхийг урьдчилан таах аргагүй. Мөн ч их мөнгө орж ирнэ дээ. Өөрөөр хэлбэл, Нүүдлийн соёл иргэншил, уламжлалд суурилсан аялал жуулчлалыг малчидын амьдралд түшиглэн хөгжүүлэх шаардлагатай.

-Эртний хүмүүс адгуусан амьтадыг гаршуулж , гэршүүлэх явцад мал, амьтны биеийн бүтэц, эрхтэн тогтолцоо, тэдгээрийн үйл ажиллагааны талаар ихээхэн мэдлэг, дадлага, туршлага хуримтлуулсаны дүнд мал, амьтанд тохиолдох элдэв эмгэг согог, бэртэл гэмтэлийг засаж илааршуулах аргыг эрж олсоор, тэр нь цаашдаа улам боловсронгуй болж мал эмнэлэг, малын эмчийн мэргэжил буй болжээ. Өнөө цагт мал эмнэлэг, малын эмчийн ажлын цар хүрээ хот айл, баг, сумаас хальсаар бүс нутаг, тив, дэлхийг хамарч, хөгжих боллоо. Даяаршлын өнөө үед дэлхийн хүн ам, мал амьтны эрүүл мэндийн байгууллагуудын жишиг, шаардлага, шалгуурыг дагахаас өөр зам үгүй. Эс тэгэвээс мал аж ахуйгаас гаралтай бүтээгдэхүүнээ гадаад зах зээлд гаргаж чадахгүй агаад мөн тэндээс аюулгүй хүнс оруулж ирж чадахгүйд хүрнэ. Түүний сайн дурын хэрэг байсаар байх уу? Мал эрүүлжүүлэх ажилд малаа хугацаанд нь хамруулахгүй бол түүнд ямар хариуцлага хүлээлгэх вэ?

Хувийн мал эмнэлгийн эзэн улсын хөрөнгө оруулалтаар олгодог цөөн нэрийн вакциныг тарих төдийгөөр ажлаа хязгаарлаж болох уу? Зарим тариаг нь буруу хадгалж, тээвэрлэж, таривал зохих малын хагаст нь тариа хийлгүй орхивол яах вэ? Ер нь түүнд тариа хийхээс өөр ажил байна уу? Тэрээр улсын мал эмнэлгийн албаны ажилтан, мэргэжилтэн, төрийн төлөөлөл мөн үү? Тэр хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн эзэн биз дээ гэх мэтийн олон асуулт урган гарч байна.

Мал эмнэлгийн сайн засаглал бүрдүүлж, хууль эрх зүйн орчныг зөвтгөн сайжруулж, бодлого тодорхойлох, судлах, сургах, үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэх бүхий л субъектийн чадавхийг сайжруулж, олон улсын жишигт хүргэснээр мал, амьтны эрүүл мэнд, мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүний аюулгүй байдал, мал амьтан ба тэдгээрийн түүхий эд, бүтээгдэхүүнээр дамжин халдварладаг өвчнүүдээс нийтийн эрүүл мэндийг хамгаалах, гадаад, дотоод худалдааны зах зээлд баталгаа гаргах чадавх буй болгох нь энэ салбарын хөгжил, дэвшлийн гол цөм, тулгамдаж буй үндсэн зорилт мөн.

Энэ дурдсан бүхнийг бодит амьдралаас урган гарсан Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагын зөвлөмж, гадаад зах зээлийн шаардлагад нийцсэн, шинжлэх ухаанд тулгуурласан мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах шинэ хууль, тогтоомжоор л шийдвэрлэж чадах хуулийг нэн даруй гаргах шаардлагатай.

Мал эмнэлгийн талаар дор дурдсан асуудлыг нэн даруй шийдвэрлэх шаардлагатай байна. Үүнд:

- Хүрэлцэхүйц тооны эмч мэргэжилтэнтэй, хөрөнгө санхүүгийн эрх мэдэлтэй, өөрийн дотоодын хяналт шалгалттай, босоо удирдлагатай Монгол Улсын мал эмнэлгийн албыг бие даасан статустайгаар цоо шинээр байгуулах,
- Улсын хэмжээний мал сүргийг эрүүлжүүлэх, ялангуяа гоц халдварт өвчнүүдээс сэргийлэн хамгаалах, тэдгээр өвчний гаралтыг таслан зогсоох, бүрмөсөн устгах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан дээд шатны байгууллагаар хэлэлцүүлж, батлуулж, хэрэгжүүлэх
- Малын эмч нарын сургалт, шинжилгээ, судалгаа, малын эм бэлдмэл, ялангуяа вакцин, ийлдэс үйлдвэрлэлийн ажлыг шинэ шатанд гаргаж нэг эмчид ноогдох малын тоогцөөрүүлэх
- Мал эрүүлжүүлэх ажилд малын эмчээс гадна бүх шатны холбогдох төрийн байгууллагын ажилтан, малчид, мал бүхий иргэдийн хүлээх үүрэг хариуцлагыг эрс өндөржүүлэх
- Мал эмнэлгийн анхан шатны нэгж, сум, аймаг, улсын мал эмнэлгийг боловсон хүчин, лаборатори, унаа машин, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр ханган бэхжүүлэх асуудлыг дурдаж болно.

4.3 Бэлчээр ба зах зээл

“Байгалийн бэлчээр бол нүүдлийн мал аж ахуйн амин сүнс,

Малчдын амьдралын үндсэн эх сурвалж мөн”

“Мал бол хувирсан бэлчээр юм” (Ахмад малчдын үгнээс)

Байгалийн бэлчээр бол манай орны хувьд мал аж ахуйн орших, эс оршихуйг шийдвэрлэгч хүчин зүйл, малчин түмний амьдралын үндсэн эх сурвалж юм. Гэтэл бэлчээр хурдацтайгаар доройтож байгаа нь маргашгүй үнэн.

Бэлчээрийн төлөв байдал, чанарт мэргэжлийн байгууллагуудаас хийсэн хянан баталгаа (2010, 2012, 2014 он)-гаар улсын хэмжээнд 25,2 сая га бэлчээр талхлагдаж доройтсоны дотор малын хөлөөс чөлөөлж, нөхөн сэргээх шаардлагатай бэлчээр 9 орчим га байгааг тогтоожээ.

Эрдэмтэн Жигжидсүрэнгийн тодорхойлсноор “байдал ийнхүү цаашаа үргэлжилбэл бэлчээрийн мал аж ахуй, тэнд ажиллагсад, малчдын хувьд “Цунами” байтугай түүнээс долоон дор аюул учрах нь” нэгэнтээ тодорхой болжээ.

Төв, Булган, Орхон, Дундговь, Сэлэнгэ, Орхон, Өвөрхангай, Баянхонгор, Хөвсгөл, Архангай, Ховд аймгуудад бэлчээрийнх нь 43,2-21,6 хувь нь талхлагджээ. Улаанбаатар хот орчимын мал бэлчээх боломжтой нь тогтоогдсон бэлчээрийн 60 гаруй хувь талхлагдсан байна.

Бэлчээрийн төлөв байдлын 2014 оны тайлангаас үзэхэд нийт бэлчээрийн 65 хувьд нь унаган төлөв байдал өөрчлөгдөж доройтсон учир түүний 90 хувийг 10 хүртэл жилийн хугацаанд сэргээх боломжтой, харин үлдсэн хэсэг нь эргэн сэргэх чадвараа бүрэн алдаж, цөлжсөн байна. Сүүлийн 40 гаруй жилд бэлчээрийн ургац 20-30 хувиар буурчээ (Б.Эрдэнэцог, 2016, Өнөөдөр сонин).

Бэлчээрийн даацхэтэрч байгаагийн үндсэн шалтгаан нь бэлчээрийг талхалж, доройтуулсан хэн ч, ямар ч хариуцлага хүлээдэггүй, “нийтээр дундаа ашиглах” өнөөгийн тогтолцооны “гажиг” юм. Бэлчээрийг ашиглаж буй үндсэн нэгж бол хот айлууд өвөлжөө, хаваржааныхаа оногдсон бэлчээрийг зохих ёсоор харгалзан хамаарч, хавар, зун, намрын улиралд бол нэг гол усныхан тухайн газарт бөөнөөрөө

шавааралдан бууж, нэг газар олон хоног-сараар сууснаас шалтгаалж бэлчээр ийнхүү нөхөн сэргээгдэхгүй болтлоо доройтож байгаа билээ. Монгол улсын үндсэн хуульд “Бэлчээр төрийн өмч”, “Мал сүрэг төрийн хамгаалалтанд байна” гэж заасан. Харамсалтай нь төр засаг дээрх үүргээ огтхон ч биелүүлэхгүй, энэ чухал ажил-өмч хөрөнгийг эзэнгүйдүүлж, сул хаяснаас өнөөгийн энэхүү “гамшигт” байдал улам бүр ужигарч, даамжирч байна. Дээрх байдалд шинжлэх ухааны үндэслэлтэй, зах зээлийн баримжаатай оновчтой судалгаа дүгнэлт хийж, дор дурдсан асуудлыг хүлээгдэн буй “Бэлчээрийн тухай” хуульд тусгаж хэрэгжүүлэх шаардлагатай хэмээн үзэж байна.

Үүнд баг сум, аймгаасаа эхлэн бэлчээр ашиглах зохион байгуулалтын төлөвлөгөө, зураглал гарган малчид, хөдөлмөрчдөөр хэлэлцүүлэн, холбогдох төр, захиргааны байгууллагаас батламжилж мөрдөх энэхүү төлөвлөгөө зураглалд:

- Бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй эрхлэх, ашиглах гэсэн бэлчээрийн үндсэн 2 хэсэгт хувааж, хот айл, саахалт айл бүлгээр өвөлжөө, хаваржааг дагнан зуслан, намаржааг нийтээр эзэмшүүлэн ашиглах.
- Хол ойрын отор хийх, сум аймаг, улсын отрын бүс нутаг дамжин өнгөрүүл эх бэлчээр ашиглагдах гол ус, нуур цөөрөм, худаг, хужир мараа зэргийг нэр зааж, тэнд байх малын төрөл, тоог бэлчээрийн даацын боломжтой чадавхид тохируулан тогтоох.
- Бэлчээрийн тухай гарах холбогдох хууль, тогтоомжинд сум, орон нутгийн төрийн байгууллага-малчны хоорондын харилцах эрх-үүрэг-хариуцлагыг маш тодорхой, ил тод болгож заасан, бэлчээрийг урт, богино хугацаагаар эзэмшүүлэн ашиглуулах гэрээний хэлбэрийг сонгон нэвтрүүлж хэрэгжүүлэх.
- Одоогийн нөхцөл байдалтай нь уялдуулан бэлчээрийн даацын боломжит чадварыг хаа сайгүй дахин тодорхойлж, тэрхүү даах чадварт л тохируулан тэр нутаг бэлчээрт малын төрөл тоог тогтоож мөрдөхөөс өөр арга байхгүй бололтой.

Одоогоор манай улсад хаана ч гэсэн малчид, мал бүхий иргэд, байгууллага, тэр ч бүү хэл тавиул малын жинхэнэ эзэд (бүгдээрээ хотод амьдардаг) мал сүргээ ямар нэгэн төлбөргүйгээр төрийн өмч (нийт ард түмний өмч)-ийн нутаг бэлчээр, ус, хужирыг ашиглан мал аж ахуйгаа эрхэлж, ашиг орлогыг нь хүртэцгээж байна.

Үүнийг зах зээлийн гэх өнөөгийн нийгэмд төрийн өмч болох нутаг бэлчээрийн удирдлага-менежментийн зарчим “хэтэрхий” гэмээр алдагдаж, гажууджээ, Түүнээс нь болж байгалийн зүй тогтлоор болж байгаагаас бусад бүх зөрчил-дутагдал, хохирол үүсэж байна гэхээс өөр дүгнэлт гарахгүй байх. Энэ нь нөгөө төрийн өмчийн компаниудын ихэнхи нь алдагдалтай, ихэнх нь асар их өртэй, тэдгээрт “шахааны бизнес” хэвийн үзэгдэл болсон гэдэг шиг л юм болж байна. Эзэнгүйдсэн бэлчээр нутгийг хэн дуртай нь ямар ч хяналт шалгалтгүйгээр, хэв хэмжээгүйгээр ашиглаж ирснээс л бэлчээр талхлагдаж доройтсон гэдгийг хаана, хаанаа ойлгох цаг нь болжээ.

Нэгэнт тухайн бэлчээр нутагт тийм төрлийн, төдий тооны мал л багтах боломжгүй гэж төрийн холбогдох байгууллагаас тогтоосон бол тэр л тооны малыг тэнд адгуулан хадгалахаас өөр аргагүй. Өмнөх нийгмийн үед манай мал сүрэг хонины толгойд шилжүүлснээр 40 орчим саяд эргэлддэг, судалгаа шинжилгээний байгууллагуудаас хонинд шилжүүлснээр 70 сая мал бэлчих боломжтой гэж тогтоож байсан бол одоо манай улс 85 сая хоньтой тэнцэх мал сүрэгтэй болсон байна. Энэ нь бэлчээрийн даац 20 гаруй хувь буюу 15 сая малаар хэтэрчээ гэсэн үг. Дээрх 70 сая хоньтой тэнцэх мал бэлчих боломжтой гэдэг нь байгаль орчин, нутаг бэлчээр онгоноороо шахам байсан, дэлхийн дулаарал гээч үзэгдэл төдийлөн мэдрэгддэггүй байсан үеийн тооцоо гэдгийг ч анхаарч үзэх ёстой.

Малын тооны өсөлтөөс гадна нэг эмзэг асуудал бол сүргийн бүтцийн зохистой харьцаа ихээхэн алдагдаж, малын чанарын хувьд бод мал, ялангуяа хамгийн таваарлаг мал болох үхэр сүргийн тоо тун цөөхөн, ямаа нийт малд 46 хувийг дангаар эзэлж байна. Бэлчээрийн цөлжилтөнд ямаа ямар хор хүргэдэг тухай бид хангалттай шүүмжилсэн, гэвч эзэн малчны л сонирхол байгаа учраас л нөгөө ямаа ингэж их өсөж байна. Энэ нь дээр тэмдэглэсэн шиг тухайн өрх, хот айл эзэмшин ашиглаж буй бэлчээр, нутгаа хэрхэн хямгадаж хамгаалах вэ?, Бэлчээрийг хэдий хугацаагаар цааш үргэлжлүүлэн ашиглах вэ? гэдэгт хэрхэн хандахаас л шалтгаалж байгаа бололтой. Түр хугацаанд, ганц хоёр жилд өндөр ашиг олж л байвал боллоо, юуных нь бэлчээр хамгаалах гэж үзвэл ёстой “хоноцын” бөгөөд “тавиулын” сэтгэлээр хандсан хэрэг болно

Малын тооны огцом өсөлт, сүргийн бүтцийн зохистой харьцаа алдагдсан байдал нь байгаль орчин, бэлчээрээ хамгаалах-хайрлах талаас нь авч үзвэл Малын үүлдэр угсаа, таваарлаг чанарыг сайжруулахад онцлон анхаарахыг шаардаж байна.

Малын хөлийн татвар төлөх нь мал аж ахуйн нийтлэг, малчин хүний эрх ашигт бүрнээ нийцнэ. Энэ нь бэлчээрийн өвс ургамал, ус хужрыг үнэгүй ашигласны төлбөл зохих төлбөрийн өчүүхэн хэсэг буюу нэг ёсны “хураамж” төдий юм.

Хэн оногдсон эзэмшлийн бэлчээрийнхээ даацанд тохируулан чанар сайтай, цөөн, цөөвтөр малтай байна тэр бага, хэн бэлчээрээсээ хэтэрсэн олон малтай байна тэр илүү их татвар төлөх нь зүйд нийцнэ.

Отор нүүдэл хийж алсын ашиглалт багатай бэлчээр ашигласан, өөрсдийн санаачлага, хүч хөрөнгөөр бэлчээртээ хөрөнгө оруулсан (хашиж хамгаалах, олон наст тариалах, услах, бордох, бэлчээр ашиглах талаар бүлэг хоршоо байгуулах, олон удаа нүүж буурь бууц солих гэх мэт) малчинд хөнгөлөлт, урамшуулал үзүүлэх, бэлчээрээ сэлгэхгүй, нэг дор олон хоног сараар, олон малаар бэлчээрээ доройтуулсан бол малын хөлийн татварыг өсгөн нэмэгдүүлэх зэргээр хариуцлага тооцдог болох нь зүйтэй.

Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд эзэмшүүлснээс бусад бэлчээрийг төрийн эрх бүхий байгууллагын хяналт, зохицуулалгайгаар ашиглуулах, эрчимжсэн мал аж ахуйд тэжээл тариалах зориулалтаар тариалангийн газрыг ашиглуулж, отрын бүс нутаг, нөөц бэлчээрийг нэмэгдүүлэх шаардлагатай. Бэлчээрийг гэрээгээр ашиглуулж, малын тоо толгойг бэлчээрийн даацад нь тохируулан барьж чадваас манай малчид НҮБ-ын Суурь Конвенцын (2015, Парис) гэрээний дагуу нүүрс хүчлийн хийн шингээлтийн үр дүнгээр хөгжилтэй орнуудын шагнал урамшуулалд хамрагдах аж. Энэхүү Конвенцоор Монгол улс 2030 он хүртэл нүүрс хүчлийн шингээлтийг жил бүр 29 сая тоннд барих үүрэг хүлээсэн бөгөөд түүний гуравны нэг нь манай мал аж ахуйд оногдож байна.

4.4 Хоршоо бол бэлчээрийн мал аж ахуйн зохион байгуулалт, удирдлагын хамгийн оновчтой бүтэц, хэлбэр мөн

Одоогоор улсын хэмжээний малчин өрхийн 70 хувь нь 200-300 толгой малтай, жалгын нэг байгаа тэдний орлого нэмэгдүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, малын өвчин, ган зуд зэрэг эрсдэлээс хамгаалах нэг гол арга зам бол мал аж ахуйн шинэ маягийн хоршоо байгуулах явдал юм. Малчид хоршин нэгдэхгүйгээр отор нүүдэл хийх, хадлан тэжээл бэлтгэх, бэлчээр нутгийг оновчтой сэлгэн ашиглах, мал аж ахуйд шинжлэх ухааны ололт, дэвшилтэт технологи нэвтрүүлэх, мал аж ахуйн бүтээгдэхүүнээ зах зээлд борлуулах, өрсөлдөх ямар ч бололцоогүй байна. Эрдэмтдийн судалгаагаар малчин өрх дунджаар 300-500 малтай байж сая үр ашигтай ажиллах нөхцөл бүрдэх боломжтой гэж тогтоосныг өмнө нь дурдсан билээ,

Дэлхийд анх 1844 онд Англид “Рочдейлийн нийгэмлэг” нэртэй хоршоо байгуулагдсанаас хойш 160 гаруй жил өнгөрч, түүнийг үүсгэн байгуулагчдын боловсруулсан дүрэм, журам нь 1955 онд Английн Манчестр хотноо хуралдсан Олон улсын хоршоодын холбооны 100 жилийн ойн хурлаас баталсан, одоо газар бүрт мөрдөгдөж буй хоршооллын үндсэн долоон зарчмын үндсэн суурь болсон хэвээрээ байна.

Хоршооллын үндсэн зарчим нь,

- Сайн дурын, нээлттэй гишүүнчлэл (хоршооны дүрмийг зөвшөөрсөн бол хэн ч гишүүн байж болно)
- Гишүүдийн ардчилсан удирдлага, хяналт (бүх гишүүдийн хурал, тэндээс сонгогдсон дарга, хяналтын байгууллага)
- Гишүүдийн эдийн засгийн оролцоо (хөрөнгөө нийлүүлж, тэр хөрөнгө, өөрийн оролцсон байдал, үйлчилгээгээрээ хувь хүртэнэ)
- Бүрэн эрхт бие даасан байдал (бусдаас хараат бус, бие дааж үйл ажиллагаагаа явуулна)
- Боловсрол, мэдээлэл, сургалт
- Хоршоод хоорондоо хамтран ажиллах
- Нийтийн сайн сайхны төлөө санаа тавих зэрэг болно.

Дээрх үндсэн зарчмаас гадна хоршоо нь хэд, хэдэн үнэт зүйлийг өөртөө агуулдаг. Үүнд,

- Өөртөө туслах (өөрийнхөө төлөө хамгийн үнэнчээр зүтгэж, хувь заяагаа шийдвэрлэх, бусадтай хамтарснаар өөрийн хүч боломжоо нэмэгдүүлэх)
- Өөртөө хариуцлага хүлээх
- Үнэнч байдал, эв санааны нэгдэл
- Нээлттэй байх
- Нийгмийн хариуцлага... зэргийг нэрлэж болно.

4.4.1 Хоршооны өнгөрсөн түүхээс хийх дүгнэлт, сургамж ...

Монгол орны хувьд хоршоолол хөгжсөн 100 жилийн түүхтэй бөгөөд анх 1921 онд анхны хоршоо “Ардын харилцан туслалцах хоршоо” байгуулагджээ. ХАА-н нэгдэл 1920-оод онд үүссэн хоршооллын хөдөлгөөний биелэл байсан бөгөөд шинэ маягийн хоршооны үндэс суурь байв. 1930-аад онд лам нарыг нэгтгэж байгуулсан артель, дараа нь анхны ардын үйлдвэрлэлийн нэгдэл, нашид уг хөдөлгөөн ардын аж ахуйтнуудыг бүхэлд нь хамарсан билээ.

"Монгол оронд нэгдэлжих хөдөлгөөн ялсан нь 1921 оны ардын хувьсгалтай эн тэнцэхүйц үйл явдал болсон" хэмээн түүхэнд тэмдэглэгдэн үлджээ. ХАА-н нэгдэл нь хөдөөгийн ард иргэд, малчдын амьдралд асар их хөгжил дэвшил авч ирснийг хэн ч үгүйсгэж чадахгүй. Монголын хөдөө аж ахуйд төдийгүй улс эх орны хөгжилд олон чухал зүйл авч ирснийг ч үнэлж баршгүй. ХАА-н нэгдэл бол үе, үеийн олон зуун мянган гишүүдийнх нь хөлс, хүчээр бүтээн байгуулагдсан аж ахуйн төдийгүй нийгмийн олон талын ажил, үйлчилгээг хамарсан бүхэл бүтэн “цогцолбор” байлаа.

- Хөдөө нутгийн нүүр царайг өөрчлөн шинэчилж, соёл, боловсрол дэлгэрэх нэг нөхцөл бүрдүүлсэн юм.
- Ган, зуд зэрэгт урьд өмнө учирдаг байсан хохирлыг олон дахин багасгаж, хөдөөд хүн бүрийг ажлын байраар хангаж, ажилгүйдлийг арилгаж, цахилгаанжуулалт, механикжуулалт нэвтэрч, хашаа, худаг, өвс тэжээлийн хүрэлцээ, хангамж эрс сайжирч, газар тариалан эрхлэх, гахай, шувуу,

туулай үржүүлж, барилгын материал үйлдвэрлэх, малаас гарах түүхий эдийг боловсруулж, бүтээгдэхүүнээ зах зээлд борлуулж байв.

- Мал эрүүлжүүлэх, малын үржил селекцийн ажилд чанарын эрс өөрчлөлт дэвшил гарсан билээ.

Энэ бүхний дүнд дан “нүүдлийн” төрхтэй байсан мал аж ахуйг харьцангуй эрчимжилттэй, " хагас суурин" байдлын мал аж ахуй эрхлэх суурийг тавьсан.

Түүний сул тал нь,

- Төрийн оролцоо “хэт ихсэж” бүхнийг хөдөлшгүй төлөвлөгөө, хатуу тогтоосон хямд үнэ зэрэг олон дарамт бий болсон.
- Гишүүдийн нийлүүлсэн хөрөнгийн сан, тоо, хэмжээ тодорхойгүй, дундын шинжтэй “нийгмийн өмч” байсан.
- Гишүүдийн хөдөлмөрийн үр дүн, хувь хөрөнгөнд нь биш, дундын эзэмшилд шилждэг, ноогдол ашиг хүртээдэггүй, тал талын дарамтаас болж нэгдлийн малыг “ялтай мал” гэж үзэж, мал маллахаас зугтагсад олшрох болсон зэргийг хэлж болно.

Энэ бүгдийг тал бүрээс нь судлан шинжилж, оновчтой дүгнэлт хийсний дүндөөрчлөн шинэчилж, сайжруулах замаар захзээлд өрсөлдүүлэх ёстой байлаа ...

... 1990-ээд оны эхээр ХАА-н нэгдлийг ямар ч бодлогогүйгээр тарааж, устгасан нь Монголын мал аж ахуйн түүхэнд тэмдэглэгдэж үлдэх нэг “хар толбо” байв гэж хэлж болно. Нэгдэл тарснаар гарсан сөрөг үр дагаврын талаар номын бусад бүлэгг тодорхой дурдсан билээ.

Өнөөгийн ажилгүйдэл, ядуурал, хотыг чиглэсэн нүүдэл, шилжилт, хөдөлгөөн, гэмт хэргийн өсөлт, малын чанар доройтож, өвчин нэмэгдсэн нь дээрх үйл явдалтай шууд ба шууд бусаар холбогдоно.

Өнөөдрийн өндөрлөгөөс эргэн харахад,

- Ихэнх малчид зах зээлээс алслагдсан, дэд бүтэцгүй, бөглүү нугагт жалга, жалгаар тархай бутархай, хувь хувиа хичээсэн төрх
- Тэдний цаг агаар, ган, зудаас бүрэн хараат байдал

- Өдөр тутам өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээгээ зөвхөн өөрийнхөө цөөн хэдэн малын ашиг шимээр, гол төлөв ганзагын наймаачдаас (ченж) хангана гэж итгэж найдаж сууна.
- Энэхүү “хувиа борлуулж, довоо шарлуулсан” малчин өрхийн ам бүлийн эруул боловсрол, соёл, нийгмийн халамж, үйлчилгээ ямар ч баталгаагүй байгаа ёстой л “Дээшээ тэнгэр хол, доошоо газар хатуу” гэгчийг санагдуулна.

Энэ байдалд бодит дүгнэлт хийж, дэлхийн нэг тэрбум хоёр зуун сая хүнийг төлөөлсөн, 247 байгууллагыг нэгтгэсэн байгууллага болох Олон улсын хоршооллын “Альянс”-ийн гишүүн орны хувьд хүн төрөлхтөний хөгжил, дэвшлийн гарцаагүй зөв болох нь нэгэнт нотлогдож, батлагдсан хоршооллын замаар замнахаас өөр гарц олдохгүй гэдэг нь өдрөөс өдөрт улам бүр тодорхой болж байна.

4.4.2 Шинэ маягийн хоршоо

Өнөөдөр олон улсын хоршооллын хөдөлгөөн улам бүр эрчимжиж, үндэстэн дамнасан корпорациудаас ч олон буюу 100 гаруй сая ажлын байр бий болгож, зургаан хүний нэг нь аль нэг хоршооны гишүүн, хоёр хүний нэг нь хоршооны үр шимийг ямар нэг хэмжээгээр хүртэж байгаа аж. Дэлхийн эдийн засаг хямарсан (2009) үед ч хоршооны бүтэц, хөдөлгөөн хамгийн бага өртөж, сүүлийн 100 жилд давамгайлсан компанийн засаглал ганцхан зөв хэлбэр хараахан биш гэдгийг нотлон харуулжээ.

Компани нь үүсгэн байгуулагчид, хувь нийлүүлэгчдийн эрх ашигт голлон үйлчилдэг бол хоршоо нь хүнд, түүний итгэл зүтгэлд тулгуурладаг, тухайн газар нутагтаа хариуцлага хүлээх чадвартай.

Дэлхийн хүн ам эрчимтэй өсч, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл онцгой ач холбогдолтой болж, олон газарт хүнсний хомсдол, өлсгөлөн тохиолдсоор байна. Хүнсний бүтээгдэхүүний ихэнхийг нь бэлтгэн нийлүүлдэг үйлдвэрлэгчид нь ХАА-н болон хүнсний чиглэлийн хоршоо, тэдгээрийн гишүүн фермерүүд ажээ.

Хөрөнгө, хөдөлмөрөө хоршиж, хамтарч үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх нь бүтээмжийг өсгөх, илүү их баялаг бүтээх бололцоо олгож, нийгмийн баялгийг иргэдэд

тэгш хүртээж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, мөнгө санхүүгийн хомсдлыг даван туулах ач холбогдолтой,

Хоршоог хөгжүүлэх нь хүн ам цөөн, зах зээлийн багаамж бага, өргөн удам нутаг дэвсгэртэй, хөгжиж байгаа манай орны хувьд богино хугацаанд бага зардлаар ажлын байр бий болгох, үйлдвэрлэлийг өргөжүүлэх замаар ард иргэдийн орлогыг нэмэгдүүлэх боломж олгоно.

Өнөөдөр Монголын ХАА-н хоршоологчдын үндэсний холбоо нь хоршооллын хөдөлгөөнийг эрчимжүүлж, хоршооллуудын зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх нөхцөлийг буй болгоход чиглэгдсэн дотоод, гадаад олон талт үйл ажиллагаа явуулж байна. Аймаг бүрт, нийслэлд ХАА-н хоршоологчдын салбар холбоо, үндэсний хэмжээний найман аж ахуйн нэгж, найман дундын хоршоо, орон нутагт 400 орчим анхан шатны хоршоо 110 мянга гаруй гишүүнтэйгээр 300 мянган хүнд хамтын аж ахуйн үр шимийг хүртээж байна.

Говь-Алтай аймгийн Дарви сумын “Буян ундрал”, “Хужирт”, “Жавхлант”, Дорнод аймгийн “Дорнод галуут”, Ховдын “Үр жимс”, Дархан уул аймгийн “Баян зөгий” зэрэг улсын тэргүүний хоршоод нь Монгол орны хөдөө аж ахуйн хоршооллын нүүр царай, дууриал болон хөгжиж байна. “Зохион байгуулалт бол хүчийг арав дахин нэмэгдүүлдэг” гэсэн удирдлагын шинжлэх ухааны үндэслэгчдийн онч мэргэн сургаал байдаг. Тэгвэл Монголын бэлчээрийн мал аж ахуйн удирдлага, зохион байгуулалтын хувьд хамгийн оновчтой хувилбар нь хоршоогэдэгт огтхон ч эргэлзэхгүй байна. Үүний тулд,

- Хоршоо байгуулж, түүнийгээ зах зээлд өрсөлдөх чадвартай болгож, үйл ажиллагаагаа явуулахад нь төр засгаас банк-санхүүгийн дэмжлэг, тусалцаа үзүүлэх “хоршооны банк” байгуулах.
- Малчдын нийгмийн хамгааллын баталгааг сайжруулан, тэднийг нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд бүрэн хамруулахад хоршооны зохион байгуулалт л тус дэм болно.
- Малчдын хоршоо нь ганц айл, хот айлыг бодоход орчин үеийн шинжлэх ухааны ололт, дэвшилтэт техник технологи нэвтрүүлэх, хүнд хүчир ажлыг

механикжуулах, цахилгаанжуулах, мөн химижүүлэх, автоматжуулах өргөн боломж олгоно.

- Хоршоо олноор байгуулагдсанаар юуны өмнө бэлчээр хамгаалж, улирлаар сэлгэн ашиглах, алсын отор, нүүдэл хийх, өвс хадлан бэлтгэх, мал ноослох, эмнэг хангал сургах, арьс шир, ноос ноолуур, мах сүү зэрэгт анхан шатны боловсруулалт хийх, тэдгээрийг хадгалж, тээвэрлэж зах зээлд борлуулах зэрэг хүнд хэцүү ажилд хамтарсан хүчтэй, нэгдсэн удирдлагатай болж, хоршооны гишүүдийг тайван, тохитой, ажиллах амрах боломж олгоно.
- Ган, зуднаас хамгаалах, тэмцэхэд хоршоо хичнээн их давуу талтай болохыг ХАА-н нэгдлийн үеийн туршлага бэлхнээ харуулдаг. Ардын аж ахуйтны үед тохиолдож байсан зудын хохирлыг нэгдлийн үед хэдэн арав дахин багасгаж чадсан гэх зэргээр хоршооны ач тусыг хэлээд баршгүй.

4.4.3 ӨМӨЗО-ны хоршооны туршлагаас

Өмнөд хөршийн малчид хоршооны зохион байгуулалтад орж ажиллахыг ихээхэн чухалчилж, хамтын хүчний давуу талыг ашиглахад анхаарч, үр ашгийг нь хүртэж байна. Тухайлбал, 2015 оны 11 дүгээр сарын 25-27-ны хооронд Шанхай хотод болсон “Олон улсын махны үзэсгэлэн” худалдаанд Өвөр Монголын Зүүн үзэмчин хошууны Хүрээт нуур сумын Баянцагаан гацааны малчин Манлай оролцож, 1 сая 800 мянган юан буюу 540 сая төгрөгийн худалдаа хийсэн байна.

Манлай нь Зүүн үзэмчин хошууны “Баян хараа” хоршоог 2013 онд найз нөхөд, ах дүүстэйгээ нийлж байгуулсан бөгөөд анх зургаан гишүүн өрхтэй байсан хоршоо 2015 онд 340 гишүүнөртэй болж, малын тоо 150 мянга гаруй болжээ. Тэрээр хоршоондоо малыг өвчин эмгэгээс хамгаалах, санхүү-эдийн засгийн, машин техникийн, мэдээ-мэдээлэл түгээх, махыг худалдан борлуулах, түүхий эд боловсруулах зэрэг зургаан салбарыг байгуулж, малчид малаа өсгөж, хариулж л байвал бусад бүхий л ажлыг хоршооноос хийх тогтолцоог бий болгожээ.

Дээрх үзэсгэлэнгээс өмнө Бээжин, Нанжин, Бугат хотод болсон өөртөө засах орон, муж, хотын түвшний махны үзэсгэлэнд оролцож түншлэлийн хүрээгээ өргөтгөж иржээ. Махны худалдаа эрхлэгчдээс түүний онцлох чанар нь иж бүрэн хэрэглэлтэй монгол гэрийг үзэсгэлэнгийн талбайд барьж, махаа чанаж амталгаа хийн, үндэсний

хувцасаар гоёсон худалдагч нарыг ажиллуулж, Монголын ахуй амьдрал, нүүдлийн соёлыг харуулсан богино хэмжээний баримтат кино үзүүлэх, уртын дуу тавих зэргээр үйлчлүүлэгчдийн анхаарлыг татах сонирхолтой арга хэмжээг зохион байгуулж ажилласан явдал юм.

Үүний дүнд Шанхай хотын хоёр томоохон компани “Баян хараа” хоршооноос жин бүрийг нь 25 юан (1 жин 500 гр, 2 жин 1 кг болох бөгөөд 1 кг нь 50 юан)-аар тооцож 1 сая 800 мянган юаны хонины ястай мах худалдан авах гэрээ байгуулжээ. Энэ гэрээ зөвхөн туршилтын хугацааных бөгөөд цаашид үргэлжлүүлэн гэрээ байгуулан ажиллахаар тохирсон байна (Доктор Б.Лхагвадорж, Монголын хөдөө сонин, 2016).

4.5 Фермерийн аж ахуй

Фермерийн аж ахуй гэж өөрийн өмчлөл, эзэмшил гэрээ, түрээсийн эдэлбэр газартай, тэндээ үйлдвэрлэл эрхэлж, бүтээгдэхүүнээ зах зээлд нийлүүлдэг банк-санхүүгийн байгууллагатай бие даан харьцдаг хуулийн этгээд бөгөөд хөдөө аж ахуйн анхан шатны үйлдвэрлэл явуулдаг аж ахуй юм.

Манай улсад одоогоор саалийн үнээ, гахай, шувууны гээд 1000 гаруй фермерийн аж ахуй албан ёсоор бүртгэлтэйгээр ажиллаж байна. Сүүлийн үед фермерийн эзэд мэргэжилтэн бэлтгэх коллеж байгуулан, зарим дээд сургуульд мал аж ахуйн чиглэлийн фермерийн аж ахуйн анги нээгджээ. Мал аж ахуйн ферм нь хуучин тогтолцооны үед ч манай бэлчээрийн мал аж ахуйд хэвшмэл болсон мал аж ахуй эрхлэх нэг хэлбэрийн үндсэн нэгж байв. Тэдгээрийгсүүний үнээний ферм, саалийн ямааны ферм, хонины үржлийн ферм гэж нэрлэдэг байлаа. Зах зээлийн өнөөгийн нөхцөлд фермийн аж ахуйн тухай ихээхэн ярьж, ийм аж ахуйн эзэн, мэргэжилтэн бэлтгэх коллеж-Монгол фермерийн дээд сургууль хүртэл байгуулан ажиллаж байна. Хэд хэдэн их, дээд сургуульд фермийн мэргэжилтний анги (мал аж ахуй, газар тариалангийн чиглэлээр) нээгджээ. Ферм нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн гол нэгж, хөдөө II клон дахь мал аж ахуй эрхлэх хэлбэр гэдэг нь гадаад орнуудын туршлагаас илхэн байна.

Фермийн аж ахуй нь хувийн өмч “газар, малд” түшиглэсэн хөдөөгийн суурьшмал өрх айл юм. Фермийн аж ахуйг бүс нутгийн онцлог, мал, газар тариалангийн байрлал, чиглэл, жижиг, дунд үйлдвэр, тэдгээрийн уялдаа холбоо, өгөөж, нийцийг харгалзан өргөн утгаар нь авч үзэх хэрэгтэй.

Фермийн аж ахуйг лотор нь “мал аж ахуй”, “газар тариалангийн” гэж дагнасан, мөн хосолсон байдлаар, түүнчлэн газар тариаланд суурилсан эрчимжсэн мал аж ахуй “гахай, шувуу, туулай, сүү, махны үхэр, үржлийн мал” гэсэн хэлбэрээр байран буюу хагас байран, мөн бэлчээр голлосон хэлбэрээр эрхлэх боломж манай оронд байна.

Фермер буюу эзэн малчин нь “сайн удирдагч, эдийн засагч, инженер, менежер, малын эмч, зоо техникч, агрономич, малчин, ажилчин, жолооч, туслах ажилчин, цэвэрлэгч” гэх мэт тун олон мэргэжлийг хамарсан өндөр зэрэглэлийн мэргэжлийн төдийгүй тал бүрийн авъяастай хүн байх ёстой нь гадаад, дотоодын туршлага, амьдралаас тодорхой. Манайд ажиллаж буй мал аж ахуйн фермийн аж ахуйнуудаас ганц жишээ товч байдлаар дурдъя.

- Төв аймгийн Батсүмбэр суманд Америкийн иргэн Билл Ёодрын байгуулсан саалийн 20 үнээний ферм нь Америк фермерийн арга ухаан, аливаад эдийн засгийн тооцоо судалгаатай ханддаг чанар, энэ талын ажлын баялаг туршлага, нягт нямбай, ажилсаг, хариуцлагатай байдлаараа ойр орчны Монголчуудад үлгэр дууриалал болжээ.

Д.Отгонбаяр саалийн энэ фермийг байгуулах үеэс нь Биллтэй хамтран дагалдан ажиллаж байжээ. Одоо Билл нутагтаа буцаж, Д.Отгонбаяр энэ фермийг бие даан эрхэлж байна. “Саалиа бэлдэхээр, саваа бэлд” гэж монголчууд ярьдаг. Энэ фермийн 20 үнээний байр нь өмнө нь манайд баригдаж, ашиглаж байсан Орос загварын халаах зуух, тэжээл хадгалах, тарааж, түгээх, малын ялгадас цэвэрлэх, механикжсан дамжлага, гүний худаг, тэжээлийн цех зэрэг асар их хөрөнгө шаардсан нүсэр байгууламжаас зарчмын хувьд тэс өөр, тун энгийн, манай орны нөхцөлд зохицсон, байрны бичил уур амьсгалыг маш оновчтой шийдвэрлэсэнээрээ Монголчуудын саалийн үнээний байрнаас эрс ялгаатай байна.

Саалийн 20 үнээний байрны урт нь 19,5 м, өргөн нь 11 м, өндөр нь 2,2 м, ханыг 15 см дүнгээр барьж, гадна талаас 10 см-ийн зузаан хөөсөнцрөөр дулаалж, дээрээс нь нимгэн банзаар давхарлан хадсан байна. Таазыг 50 см зузаан үртсээр дулаалсан, ханын зузаан нь нийдээ 27,5 см байгаа нь дотроос дулаан алдахгүй, гаднаас хүйтэн агаар нэвтрэхгүй болгожээ. Энэ байрны ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг онцлон анхаарч салхивч, хэвтэр (зогсоолын цементэн шалан дээр резин дэвссэн) зогсоолд нэг үнээнд 1,2 м өргөн, 1,6 м урт талбай оногдохоор хийжээ. Үнээ шээж баахдаа биеэ хурааж, бөөцийж, сэрвээгээ өргөж босгодог онцлогтой. Энэ онцлогийг Билл сайтар мэдэрч, үнээ нэг бүрийн сэрвээний тус газар нарны зайн үүсгэврээс цэнэг авдаг цахилгаан гүйдэл бүхий төмөр цочроогчийг үнээний сэрвээний өндөрт тохируулан байрлуулсан байна. Үнээ шээж, баахаар сэрвээгээ өндийлгөхөд цахилгаан цочроогчийн гүйдэлд өртөж, хойшоо ухран ялгадасны суваг руу шээж баадаг байна. Энэ фермийн байрны бүх зүйлийг орон нутгийн материалаар хийж зөвхөн цахилгаан цочроогч, нарны илчээр ажилладаг зайг нутгаасаа авч ирсэн байна. Байрны дотор 4.5x3.5 м хэмжээтэй тусгай өрөө гаргаж тэнд 1.1x1.5 м-ийн амсартай, бм-ийн гүнтэй энгийн уурхайн худаг гариж, үнээ, тугапын болон аж ахуйнхаа усны хэрэгцээг шийдвэрлэжээ. Худагт байрлуулсан мнш жижиг шахуургаар ус татах, худгийн дэргэд тусгайлан байгуулсан 1.5x2.5 м-ийн харьцаатай ус нөөцлөх цементэн сав, мал услах онгоцуудыг усаар дүүргэдэг байна. Худгийн хүйтэн усанд зуны улиралд 40 л бидонтой сүүг хөргөж хадгалахаас гадна саванд хуримтлуулж, жаврыг нь гаргасан усыг өөрийн урсгалаар урсган үнээ малаа усалдаг байна. Усан сангийн усаа ялгадасны суваг руу үе үе урсган цэвэрлэж байхаар тохируулж, тусгай тохируулагч хаалт суурилуулжээ. Энэ ферм үнээний байрнаас гадна өсвөр үхрийн тэжээл бэлтгэх өрөө, агуулахын байртай. Тэнд Алатау үүлдрийн (сүү-махны) үнээтэй бөгөөд саалийн 20 үнээгээ суурин маллагаанд байлган маллаж байна.

Үнээний тэжээлийн жор нормыг үнээ нэг бүрээр сүүний гарцны байдлаас хамаарч зохиодог байна. Тэжээлд өвс, хошуу будаа, хүчит тэжээл (няцалсан улаан буудай, арп;ш хивэг), ногоон тэжээл (царгас), шүүст тэжээл (лууван), амин дэм, эрдэс бодис, бордоо зэргийг хэрэглэдэг. Үнээний сүүний гарц нэмэгдэх тутам өгөх хүчит тэжээлийг нэмж, харин өвсний хэмжээг зохих хэмжээгээр багасгадаг байна. Усыг үнээ өөрийн дураар ууна. Тэжээл өгөх, үнээ саах, байрны цэвэрлэгээ хийх гээд бүх

ажлыг маш нарийн хуваарьтай, нягт нямбай гүйцэтгэдэг бөгөөд энэ ажилд фермийн эзэн, эрхлэгчийн зүгээс хатуу хяналт тавьдаг байна “Үнээний сүү хэлэн дээрээ” гэдэг. Саах сүүний хэмжээ нь тэжээл, тэжээллэгээс шалтгаална. Найдвартай тэжээлийн бааз, байгалийн хадлан, таримал талбай, хадсан өвс, бэлтгэсэн тэжээл, тэжээллэгээс зуны улиралд үнээ малаа бэлчээх соргог бэлчээр нутаггүйгээр саалийн фермийг үр дүнтэй ажиллуулах боломжгүй гэдгийг тус фермийнхэн зөвлөдөг.

- Булган аймгийн Хутаг-Өндөр суманд нэгэн Канад иргэн тэндэхийн цаг уурын тааламжтай нөхцөл, газар тариалангийн боломжийг ашиглан үхрийн махны чиглэлийн эрчимжсэн фермерийн аж ахуйг нутгийн хүмүүстэй хамтран байгуулаад, үхрийн махаа хотын томоохон ресторанууд, мөн Оюу толгой мэтийн том хэмжээний компаниудад тогтмол нийлүүлдэг сүлжээтэй болсон байна. Гэтэл үе удмаараа мал малллаж ирсэн монголчууд бид яагаадбайгаль цаг уурын таатай, газар тариалан эрхэлдэг бүс нутагт, хот суурингийн ойролцоо мах, сүү, ноос, ноолуурын чиглэлийн өндөр ашиг шимтэй малын эрчимжсэн том, жижиг аж ахуйнуудыг байгуулж ажиллуулж чадахгүй гэж.

Хамгийн гол нь үхэр мал нь эрүүл, мах, сүү бусад бүтээгдэхүүн нь эрүүл ахуйн болоод бусад үзүүлэлтээрээ стандартын шаардлагыг хангасан байх ёстой. Мал сүргээ эрүүлжүүлэх арга хэмжээнд бүрэн хамруулсан байх шаардлагатай.

Гадаадын ихэнх улс оронд хүнсний бүтээгдэхүүний 70-аас доошгүй хувийг нь жижиг, дундбуюу фермийн аж ахуйнууд хангадаг байна. АНУ-д 40,000 ам.доллар хүртэл бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг аж ахуйг жижиг, 250 мянган ам.долларын бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг бол, дунд, түүнээс дээш бол том аж ахуй гэж үздэг байна. Эзэмшил газрын хувьд Европт фермийн аж ахуйнууд дунджаар 10-60 га газартай байхад АНУ, Канадад 185-200 га, Японд нэг га-д ч хүрдэггүй. Ажиллах хүчний хувьд гол төлөв гэр бүлийн 2-3 хүн, томоохон аж ахуй бол 2-4 хөлсний ажилчин нэмж ажиллуулдаг байна. Шведэд 100 мянга гаруй фермтэй бөгөөд тэнд нэг аж ахуй дунджаар 40 га газар, 25-38 сүүний үнээтэй, нэг үнээнээс 6500- 7000 л сүү саадаг. Финляндад нэг аж ахуйд 13 га эдэлбэр газар, 10 саалийн үнээ, эсвэл 10 мэгж, шахаж бордох 100 гахай байх жишээтэй. Мөн нэг аж ахуйд 1-2 трактор, хоёр аж ахуй дундаа

нэг комбайн, нэг өвс пресслэгчтэй. Гахайн фермерийн аж ахуй 10 га газартай, долоон га-д нь гахайн тэжээл тариалж, нэг трактор, нэг комбайныг хоёр аж ахуй дундаа эзэмшдэг байна. Польшид фермийн аж ахуй цөөн, 5,2 га газар эзэмшдэг жижиг аж ахуй дийлэнх нь байдаг. Голландын фермийн аж ахуйнууд дунджаар 16 га эзэмшил газартай, энэ орны фермийн аж ахуйнууд үр ашиг, бүтээгдэхүүн үйлдвэрлэлээрээ дэлхийн олон орны түвшнээс хол түрүүлжээ.

Монгол Улсад өнөөдрийг хүртэл хуримтлуулсан туршлага, мэдлэг, мэдээ мэдээлэлд тулгуурлан мал аж ахуйн салбарт **фермийн** аж ахуйг дараах чиглэлээр байгуулах нь зүйтэй. Үүнд:

- Нутгийн гойд ашиг шимт шилмэл үүлдэр, омгийн малаар сайн чанарын хээлтүүлэгч, хээлтэгч өсгөн бойжуулж борлуулах, мах, ноос, ноолуурын чиглэлээр бэлчээрийн маллагаа зонхилсон хэлбэрээр
- Зарим нутагшсан өндөр ашиг шимт, цэвэр үүлдрийн болон эрлийз үүлдрийн малаар мах, сүүний чиглэлээр бэлчээрийн болон байран маллагаа хосолсон, өөрөөр хэлбэл, хагас байран маллагааны технологи мөрдөх хэлбэрээр
- Өндөр ашиг шим бүхий цэвэр үүлдрийн болон сайн нутагшаагүй, шинэ тутам оруулж ирсэн эрлийз малаар мах, сүүний чиглэлээр байран маллагааны технологи мөрдөх хэлбэрээр
- Гахай, тахиа, туулай зэрэг мал, амьтны фермийг суурин буюу байран маллагааны чиглэлээр
- Өөрийн орны нөхцөлд тохирсон сорт бүхий ургамалтай хадгалах, боловсруулах технологи бүхий газар тариалангийн чиглэлийн фермерийн аж ахуй
- Дээрх аж ахуйнуудын хийж чадахгүй байгаа зүйлс, тухайлбал төрөл бүрийн тэжээл үйлдвэрлэх, борлуулах, хадгалах, үрээр хангах, тариалж хадаж өгөх, тээвэр, техникээр үйлчлэх зэрэг ажил эрхэлсэн фермерийн аж ахуйн төрөл, чиглэлээр байгуулж болох юм.
- Эдгээрийг байгуулахад хамгийн гол нь төр засгаас эдэлбэр газар олгох, мөнгө, санхүү, техник хэрэгсэл, тэжээл, үр, бордоогоор гаднаас шинэ технологи эзэмших зэрэгт нь туслах, дэмжих

- Энэ чиглэлийн ажил хариуцсан байгууллагуудаас бүх шатны сургалт зохион байгуулж, мэргэшүүлэх холбогдох ном, видео, CD), гарын авлага гаргаж, туршлага судлуулах
- Төр засгийн бодлогоор эхний ээлжинд аймаг, сум, бүс нутагт тодорхой тооны загвар аж ахуй бий болгож бусдад, сурталчлан таниулж, сургалт-сурталчилгааны суурь бааз бий болгох.
- Фермерийн аж ахуй байгуулахад шаардагдах хөрөнгийн 70-80 хувийг үндсэн хөрөнгө байр, хашаа, худаг зэргийг барихад, техник тоног төхөөрөмж худалдаж авахад, үлдэх 20-30 хувийг нь шаардагдах мал амьтан, үр, бордоо, тэжээл авахад зарцуулах.

4.6 XXI зууны монгол малчин

4.6.1 Шинэ зуунд манай орны мал аж ахуй бүтэц

- Уламжлалт нүүдлийн буюу бэлчээрийн мал аж ахуй (бүх нутгийг хамарсан, таван хошуу мал сүргээ эрхлэх уламжлалт мэдлэг)
- Хагас суурин мал аж ахуй (бэлчээр, тэжээл хосолсон). Ялангуяа нутгийн шилмэл омгийн малын фермерийн аж ахуй хамрагдана.
- Суурин буюу үйлдвэржсэн мал аж ахуй (нөхцөл нь бүрдсэн газарт фермерийн аж ахуй эрхлэх, өндөр ашиг шимтэй зарим цэвэр, эрлийз үүлдрийн мах, сүүний чиглэлийн мал, гахай, шувуу, туулай гэх мэт) эрхлэх гэсэн гурван чиглэлтэй байх бололцоотой.

4.6.2 Малчны төрөл зүйл

- Хоршооны малчин өрх
- Фермерийн аж ахуйн малчин (эзэн, туслах малчид)
- Хот айл, малчин өрх, гэсэн бүтэцтэйгээр мал аж ахуй эрхэлж байна.

4.6.3 Монгол малчны ирээдүйн тухай төсөөлөл

Судлаачдын санал, төсөөлөл Австрали, Африк, Ази, Европын малчдын өнөөгийн байдал, хөгжлийн чиг хандлагаас үзэхэд XXI зууны Монгол малчин, малчин өрх, хот айлын дараах загвартай байхаар төсөөлж байна. Үүнд:

- Малчид сансрын хиймэл дагуул ашигладаг зурагт радиотой, нар, салхи, усны хүч, биохий ашиглан гэрэл цахилгаанаар бүрэн хангагдаж, мал аж ахуйн бүтээгдэхүүнээ борлуулах, шаардлагатай зүйлс худалдан авах зах зээлтэй, интернетээр холбогдоно. Өөрсдийн цахилгааны эх үүсвэрээ хэрэгцээнийхээ хэрээр нэмэгдүүлж өрх, хот айл, жижиг, дунд үйлдвэрлэл явуулдаг болно.
- Юуны өмнө малынхаа ноосыг цахилгаан хайчаар авч, зарим цагаан идээ, тос, ясмэтийг орчин үеийн түвшинд цахилгаан тоног төхөөрөмжөөр үйлдвэрлэж, дараагийн шатанд махан бүтээгдэхүүн, хиам хийдэг болно. Яваандаа хот айлын түвшинд ноос ноолуур, арьс нэхийнд анхан шатны боловсруулалт хийнэ.
- Нүүдэлчин малчин өрх зах зээлд бүтээгдэхүүнээ борлуулах маш хялбархан сүлжээ бий болно. Худалдан авагчдаа бүтээгдэхүүн нийлүүлэх хугацааг цаг, минутаар тодорхой заасан гэрээ байгуулж, түүнийгээ ягштал хэрэгжүүлэгч болно. Үүргийн худалдааны сүлжээ бий болж, худалдааг интернэтээр хийнэ. Ингэснээр хот, хөдөөгийн амьдралын ялгаа багасч, төв рүү чиглэсэн нүүдэл багасах нь мэдээж.
- Газар, бэлчээр эзэмшихэд ихээхэн өөрчлөлт гарч, малчид алслагдсан зэлүүд, ашиглалт багатай нутаг бэлчээрийг ашиглах сонирхол нь улам бүр нэмэгдэж, мөн өөрсдийн эзэмшил нутагтай болж, түүнийгээ ариг гамтай сайжруулан ашиглахад их анхаарна. Эзэмшил нутгийнхаа гол горхи, цас, борооны усны нөөцийг бүрэн ашиглаххөдөлгөөн өрнөж, ус ашиглах бэсрэг байгууламж байгуулж (хаалт, хамгаалалт, далан, суваг, бороожуулагч) ашиглана.
- Бэлчээрийн улирлын хуваарилалт шинжлэх ухааны үндэслэлтэй болж, түүнийгээ хэрэгжүүлэх маш энгийн компьютерийн программ боловсруулж, түүнийг ашиглах хялбархан арга зүйг малчид эзэмшинэ. Бэлтгэлийн малыг богино хугацаанд шахаж бордох авсаархан талбай байгуулж ашиглана.
- Сүргийн бүтцэд өөрчлөлт гарч, арвин ашиг шимтэй мал, нутгийн шилмэл үүлдэр, омог, хэвшлийн малыг илүү сонирхож өсгөнө.
- Малчид үр хүүхэддээ боловсрол эзэмшүүлэх, соёлтой болгох орчин үеийн сонгодог арга өргөн хэрэглэж, дижитал номын сантай болж, интернэтээр ашиглана. Малчдын өөрсдийнх нь мэдлэг, боловсрол нэмэгдэж, шинжлэх ухаан, технологийн шилдэг аргуудыг ашиглах эрмэлзэл бий болно.

- Малчдын эрүүл мэнд, өвчний шинжилгээг цаг хугацаанд нь хамгийн сүүлийн үеийн цахимжсан багаж төхөөрөмжөөр хийж, оношийг нь хот хүрээний мэргэжлийн эмч нар тогтоон тодорхойлж, мэдээллийн шугамаар хэдхэн мөчийн дотор малчдад хариуг өгч, холбогдох эмчилгээ, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.
- Малчид малын үржил, селекцийн болон мал эмнэлгийн шинжлэх ухааны зохих түвшний мэдлэг, дадлага туршлагатай болж, мал сүрэгтээ тохируулан шилэн сонголт заазлалт, тарилга, туулга, угаалга, ариутгал халдваргүйжилт хийх ажлыг орчин үеийн эм хэрэгсэл, багаж төхөөрөмж ашиглан өөрсдөө хийнэ.
- Залуу малчдыг сургаж бэлтгэх курс, сургуулиуд нээгдэж, өнөөгийн малчид жинхэнээсээ “малчин” гэсэн мэргэжил эзэмшнэ.
- Ган, зуд, өвчин тахал мэт “гамшиг” өнөөгийн жалгын нэг тарсан малчдын нийгмийн асуудал, мал аж ахуйн бүтээгдэхүүнээ өндөр, үнээр борлуулах зэрэг хүчин зүйлс шаардагдахын эрхээр малчид хоршоо, компанид гишүүнээр элсэн, хамтын хүчний давуу талыг эдэлнэ.
- Өвөлжөө, хаваржаандаа тохилог орон сууцтай, гаднаа жимсний мод, зоорь, хүлэмж, бие чийрэгжүүлэх дасгал хийх талбай, спортын зарим хэрэглэлтэй болно.
- Малчид хамтарч төмс, хүнсний ногоо тариалж зохих тооны гахай, шувуу, зөгийн аж ахуй эрхэлнэ.
- Малчид хамтран хадлангийн болон бэлчээрийн зарим талбайг хашин хамгаалж, усалж бордон ургацыг ихээхэн нэмэгдүүлж, таримал хадлан, бэлчээртэй болж, хадлангийн ажилд өндөр бүгээмжтэй машин техник ашиглахын хамт ойр зуурын тээвэрт ердийн хөсөг өргөн ашиглана.
- Өөрийн орны болон дэлхийн гайхамшигт газруудаар аялан жуулчилж, юм үзэж, нүд тайлна.

Монгол малчидын мал маллах арга ухаан, эрдэм мэдлэг нь тэдний мал маллаж ирсэн мянга мянган жилийн дадлага, туршлагаар шалгагдан боловсорч, үеэс үед уламжлагдан ирсэний нэг хэсэг нь тухайн цаг үеийнхээ ном сударт, зарим нь ардын аман зохиолд тусгалаа олж, бидний үеийг хүрчээ. Монгол малчид мал сүрэг, мал маллагаа, ажил амьдралын талаарх онч мэргэн зүйр цэцэн үгс, ерөөл магтаал, дуу шүлэг өдий төдий билээ. Онч мэргэн, зүйр цэцэн үгс нь хэдийгээр хоёр гуравхан мөр холбоо үг мэт боловч монгол малчидын түүхэн урт хугацаанд мал маллаж ирсэн арга

туршлагаас гарсан дүгнэлт, санамж мөн тул нэг уншаад гайхаад өнгөрөх зүйл бус, дахин давтан үзэж, бас эргэцүүлэн бодож, судалж, цээжлэн тогтоож, өөрсдийн ажил төрөлд хэрэглэх, улмаар баяжуулах зүйл юм.

4.7 Мал аж ахуй ба орчин үе, шинжлэх ухааны дэвшил

Орчин үед малчны ажил мэргэжлийн тухай ойлголт ихээхэн нарийсан гүнзгийрч, ахмад малчидын уламжлалт арга арвин баялаг туршлагаас суралцаж бүтээлчээр хэрэгжүүлэхийн зэрэгцээ эрхлэн буй мал аж ахуй, малчин өрхийн орлогын гол эх үүсвэр болсон мал, тэдгээрээс гарах мах, сүү, ноос, ноолуур, арьс шир зэргийг гадаад, дотоодын зах зээлд худалдан борлуулахад тавигдаж буй хүнсний аюулгүй байдалтай холбоотой бүх шаардлагыг хангах, өрх айл, хэсэг бүлгээрээ үйлдвэрлэгч, борлуулагч байх зэрэгт шинэ мэдлэг арга ухаан шаардагдах болов.

Мал аж ахуй, малчин түмний өнөөгийн хөгжил дэвшил өөрчлөлт шинэчлэлийн талаарх жишээ баримтыг алс холоос, гадны улс орнуудаас эрж хайхгүйгээр өөрсдийнхөө амьдралаас авч үзэхэд манай малчин өрхийн аж амьдрал, ахуй орчин, цахилгаанжуулалт, холбоожилт, мэдээ мэдээлэл, техникжилт үнэнхүү “үсрэнгүй” гэмээр өөрчлөгдөн сайжирч байгааг бид харж байна. Манай малчид дэлхийн аль ч газартай хүссэн үедээ холбогдож шаардлагатай мэдээ мэдээллийг авдаг болов.

Даяаршин буй энэ эринд өөрчлөгдөж буй нөхцөл байдалтай уялдуулан төр засгаас мал аж ахуйн талаар баримтлах ойрын дунд хугацааны болон хэтийн бодлогыг маш оновчтой тодорхойлох, тухайлбал, мал аж ахуйн удирдлага зохион байгуулалтын хэлбэр бүтэц, малчдын хөдөлмөр, мал аж ахуйн мэргэжлийн байгууллагууд (мал эмнэлэг, үржлийн гэх мэт холбогдох газар)-ын ажлыг бүхэлд нь өнөөгийн түвшинд нийцүүлэн боловсронгуй болгохыг амьдрал шаардаж байна. Энэхүү өргөн хүрээтэй асуудлын дотроос бид зөвхөн шинэ зууны Монгол малчны ажил амьдралын талаар энд ярилцаж байна.

Эрдэмтэн судлаачид өнгөрсөн зууныг шинжлэх ухаан, техник технологийн үсрэнгүй хөгжлийн зуун гэж байсан бол XXI зуунд улс орон бүр шинжлэх ухаанд суурилсан нийгэм, мэдлэгт тулгуурласан эдийн засаг хөгжүүлэх бодлого үзэл

баримтлал дэвшүүлэн түүнийгээ хэрэгжүүлэхийн төлөө шаргуу тэмцэж өрсөлдөх боллоо. XXI зууныг эрдэм мэдлэгийн зуун, хүний хөгжлийн зуун гэх зэргээр нэрлэцгээж байна.

Шинжлэх ухааны хөгжил дэвшлийн талаар бидний эрхлэн буй мал аж ахуйтай холбогдсон ганц нэг жишээ дурдахад:

- Орчин үед микроскоп (томруулдаг дуран)-оор харан нээж гайхагдаж байсан нян, вирус, микоилазм, мөөгөнцөр, эс, эсийн доторхи бүрэлдэхүүн хэсэг, атом, молекул, ген, хромосом зэргийн нээлтийн үе аль хэдийнээ нэгэнт болоод өнгөрчээ. Харин биологийн шинжлэх ухаан түүний олон салбар шинжлэх ухаанууд улам гүнзгийрэн хөгжиж ДНХ, РНХ-ийн молекулын бүтэц бүрэлдэхүүн, орон зайн байгууламж, тэдгээр хүчин зүйлүүдийн мал амьтны удамшил дамжуулалт болон уургийн нийлэгжилт, генийн инженерчлэл, бичил биетний болон мал амьтны, ургамлын биотехнологи өнөөдөр нанометрийн (1 мм-ийг сая хуваасны нэгтэй тэнцэх) түвшинд хөгжиж байна. Үүнийг нанотехнологи гэж нэрлэдэг.
- Мал амьтны гаралтай хүнсний бүтээгдэхүүн, түүхий эдийн аюулгүй байдлыг шалган баталгаажуулах аргачлал, техникийн боломж эрс сайжирч, тэдгээрт буй малын эм, пестицидийн үлдэгдэл, химийн бодис зэргийг хамгийн орчин үеийн аргаар тодорхойлдог тоног төхөөрөмжүүд, хөдөлгөөнт лаборатори зэргийг ашигладаг боллоо.
- Өнөөдөр ДНХ-ийн эрлийзжүүлэлт, генийн инженерчлэл, ген шилжүүлэн суулгах, өндгөн эсийг (in vitro) өсгөвөрлөх аргаар шинээр мал амьтан бий болгох ажлууд зөвхөн мөрөөдөл биш жинхэнэ ажил болж байна. Удамшлын хувьд онцгой тэсвэртэй сүрэг бий болж ашиг шимээ өгч эхлэх ажил гарааныхаа өмнө ирээд байна Удамшлын хүчин зүйлийг хувилж олшруулах аргыг өргөн хэрэглэх болов. Нэг жишээ дурдахад: Тун саяхны мэдээгээр Тяньжин хотод Хятад, Өмнөд Солонгосын хамтарсан дэлхийд хамгийн том мал амьтны хувилах үйлдвэр байгуулах ажил аль хэдийн эхэлж, 2017 оны 6 дугаар сард ашиглалтад оруулжээ. Энэ үйлдвэр нь жилд ойролцоогоор нэг сая гаруй махны үхэр, мөн үнэрч ноход, ховор үүлдрийн гэрийн нохой, уралдааны морьд гарган авах, махны үхрийн 100 мянган үр хөврөл өсгөн бойжуулах чадвартай| тул дотоодын зах зээлд энэ төрлийн

махны дутагдлыг нөхөж чадна гэжээ/Э.Номин-Эрдэнэ, 2016, Өнөөдөр сонин). Энэ үйлдвэрийн бас нэг зорилго нь Биотехнологийн шинжлэх ухааны хөгжил дэвшлийг итгэн үнэмшүүлэхэд чиглэгджээ.

- Амьтдыг клонийн буюу эсийн аргаар хувиран үржүүлэх судалгаа, шинжилгээний ажил 1990-ээд оноос эхэлж, анх Шотландад “Долли” хэмээх хурга гарган авч, өсгөн бойжуулж байсны дээр олон улс оронд хулгана, ямаа, гахай, үхэр зэрэг сүүн тэжээлтэн нохой зэргийг гарган авч байв. Гэвч, Европ болон барууны ихэнх орнуудад амьтадыг клонийн аргаар хувиран олшруулахыг хуулиар хориглосон байдаг. Харин анагаах ухаан, эмчилгээний чиглэлээр хүний эд эрхтэнийг генийн инженерчлэлийн аргаар гарган авч, өмнө нь эмчлэх боломжгүй байсан өвчтэй хүмүүсийг эмчлэх болсон билээ.
- Мал амьтныг нэг бүрчлэн тарих аргаар эмийн бодис тарьдаг аргыг малын арьсан дээр дусаахад л асар богино хугацаанд шимэгдэж арьсан дор, тэр байтугай судсаар тарьсанаас ч дутахааргүй нөлөө үзүүлдэг бодисуудыг олоод байна.
- Бидний хэрэглэж дассан пенициллин, стрептомицин, саяхнаас хэрэглэж байгаа окситетрациклин, гентамицин, левозитросульфид гэх зэрэг антибиотикүүд хэрэглээнээс шахагдаж, хөгжилтэй орнууд гуравдах үеийн гэгдэх тилозин, апраменин зэрэг антибиотикүүдыг нээн илрүүлж мал амьтандаа өргөнөөр хэрэглэх болжээ. Энэ дашрамд нийтийн анхаарлыг татаж буй биотехнологийн шинжлэх ухааны хөгжил дэвшлийн талаар цухас дурдъя.

4.7.1 Биотехнологи бол мал аж ахуйг эрчимжүүлэх, шийдвэрлэх арга мөн

Биотехнологи нь бичил биетэн, мал амьтан, ургамлын амьдралын биологийн процессыг ашиглан, тэдгээр амьд биетүүдийг өсгөн үржүүлэх, удамшлын бус ашигтай шинэ шинжүүдийг бий болгох, өсгөвөрлөн, хувиран олшруулах, хүнсний, эмийн болон химийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний тоо хэмжээ, чанарыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн биологийн онцгой технологи юм. Биотехнологийг дотор нь уламжлалт (эртнээс хэрэглэж ирсэн тараг, айраг, дарс исгэх, шир, нэхий идээлэх зэрэг) болон орчин үеийн (шинэ) технологи мөн бичил биетийн, мал аж ахуйн ба ургамлын биотехнологи гэж ялган үздэг. Биотехнологи хэмээх биологийн салбар

шинжлэх ухааныг бий болгож, хөгжүүлж, бодит биелэл болгосон нь өнгөрсөн ХХ зууны шинжлэх ухааны үсрэнгүй хөгжил, дэвшлийн нэгээхэн баталгаа болсон билээ. Биотехнологи гэдгийг тун товчоор тодорхойлохыг оролдвол бичил биетэн, мал амьтан, ургамлын эс, эсийн бүтцээс ялган авсан биологийн биетүүдийг генийн ба эсийн инженерчлэлийн аргаар удирдан жолоодох замаар нэн хэрэгцээт бодис, бүтээгдэхүүн, өндөр ашиг шимт мал, амьтан, өндөр ургацын ургамал гарган авах биологийн арга юм.

4.7.2 Генийн инженерчлэл

Энэнь молекулын биологи, молекулын генетик, биохими, микробиологи зэрэг амьд байгалийн шинжлэх ухаануудын ололт-дэвшил дээр тулгуурласан, нэг махбодын тодорхой уураг, үйл ажиллагааг хариуцсан генийг нөгөө бие махбодод шилжүүлэн суулгаж, удамшлын мэдээллийг (ДНХ-дезоксирибонуклейны хүчил дэх) өөрчлөх замаар нэн хэрэгцээтэй биологийн идэвхит бодис болон бусад бодис, нийлүүлэгч эс, эд, бие махбод бий болгодог арга юм. Энэ аргыг дотор нь генийн болон эсийн инженерчлэлийн арга гэж ангилдаг.

Биотехнологийн процессууд нь эс, эсвэл тэдгээрээс ялгасан биологийн бүтэц, ялангуяа тэдгээрийн ферментийн үйлчлэл, үйл ажиллагаанд тулгуурлан явагддаг.

Генийн ба эсийн инженерчлэлийн аргаар гаргаж авсан биологийн агентууд ферментацийн процесс явуулж байх үед нь тэдгээрийн өсөлт, бодис солилцоог удирдах замаар гарган авах бүтээгдэхүүнийхээ гарцыг ихээхэн нэмэгдүүлэх боломжтой. Энэ л учраас биотехнологи нь амьд эс, түүний амьдралын процессыг залж удирдах хуулиар явагддаг.

Эсийн үндсэн бүрэлдэхүүнд:

- ДНХ - дезоксирибонуклейны хүчил
- РНХ - рибонуклейны хүчил
- Уургууд, лииидүүд, фосфагууд, нүүрс-ус зэрэг 30 шахам органелууд байдгийг тогтоон биотехнологид ашиглаж байна.

Өнөөдөр дэлхийн улс орнуудад биотехнологийн ололт нь хүн, мал эмнэлэг, мал аж ахуй, байгаль хамгаалал, хүнс, эм, химийн үйлдвэрлэлийн технологид өргөн нэвтэрч хүмүүсийн хэрэглээ болжээ. Тухайлбал, эсийн үржвэрийг ашиглан хүн, малын олон төрлийн халдварт өвчний эсрэг вакцин, эм тарилга, оношлуурын бэлдмэл гарган авч байна.

Мал аж ахуйд биотехнологийн арга нь арвин ашиг шимтэй шинэ үүлдрийн малыг богино хугацаанд олноор нь бий болгох боломжийг олгож байна. Энэ технологийн мөн чанар нь ашиг шим, амьдрах чадвараар нь сонгож шалгаруулсан малын үр хөврөл (зигот)-ийг тээгч- хээлтэгч малд шилжүүлэн суулгах арга ажиллагаа юм. Ингэхдээ өндөр ашиг шимтэй хээлтэгч малыг тодорхой төрлийн гормоноор үйлчлүүлж нэгэн зэрэг олон өндгөн эс боловсрох нөхцлийг бүрдүүлнэ. Ийм малыг хээлтүүлсэний (үр тогтоосны) дараа удалгүй үр тогтсон өндгөн эсүүдийг угаан авч урьдчилан тусгайлан бэлтгэсэн тээгч эх малд нэг нэгээр нь тараан суулгана. Жишээ нь энэ аргаар нэг үнээнээс жилд нэг биш хэдэн арван тугал бойжуулж авах боломжтой. Тухайлбал 2013 онд нэг донор үнээнээс дээрх аргаар АНУ-д 136, Францад 80, Германд 57, ОХУ-д 44 тугал бойжуулан авчээ. Манай улсад энэ аргыг туршиж үнээнээс 2,7-3,4 тугал авах боломжийг тогтоосон байдаг (П.Галрагчаа, 2000),

Монголд төдийгүй дэлхийд ховордсон хавтгай, говийн мазаалай, түүнчлэн сарлаг, үхэрзэргийг өсгөн олшруулахад манай судлаачид биотехнологийн аргыг ашиглах судалгаа эхэлжээ.

Манай орны хувьд ч биотехнологийн шинжлэх ухааны зарим ололт дэвшил мал аж ахуйд амжилттай нэвтэрч байна.

Сүүлийн үед монгол ямааны ноолуур дэлхийн зах зээл дээр өндөр үнэд хүрч, манай эрдэмтэд биотехнологийн аргаар 13-15 мм голчтой, сайн чанарын ноолууртай ямаагийн ноолууртай ухны үрээр, мөн тийм ноолууртай донор ямааг зохиомлоор хээлтүүлж, олон тооны үр тогтоож, улмаар тогтсон өндгөн эс-үр хөврөлийг угаан авч, өөр ямаанд шилжүүлэн суулгаж, ишиг гарган авч бойжуулах технологийг амжилттай хэрэгжүүлж байна. Үр хөврөл шилжүүлэн суулгасан ямааны 32,3 хувь ихэрлэж, нэг

ямаанаас нэг бэлгийн мөчлөгт дунджаар 5,5 ишиг, дээд тал нь 12-14 ишиг гарган авсан билээ.

Мөн Украин улсаас үрийг капсулд хөлдөөх технологи, НҮБ-ын шугамаар шилжүүлэн суулгах лаборатори, багаж хэрэгсэл, гуурсанд үр хөлдөөх Франц технологи авч ашиглах боллоо. Өндөр ашиг шимт “Хар тарлан” (ОХУ, Германаас), Талын улаан, Алатау(Киргиз, Швед үхрийн эрлийз), Шар тарлан, Казакын цагаан толгойт, Лимузин /Унгараас/, Герефорд зэрэг гадаадын үүлдрийн малыг өргөн үржүүлэх болов. Сүүлийн үед хурдан морины чиглэлээр Европоос янз бүрийн үүлдрийн азарга, гүүний “үр” авч ирэн ашиглах болов тус улсад өндөр ашиг шимт, саалийн үнээний, махны үхрийн, гахай, шувууны олоп үйлдвэр, фермерийн болон өрхийн аж ахуй шинээр байгуулагдан ажиллаж байна.

БНХАУ-аас Франц, Голланд угшилтай 305 хоногт 6000-8000 кг, 3,5-3,8 хувийн тослогтой сүү өгдөг Абоданс, Монтбилярд, Трантейз, Глоштин үүлдрийн бухны, мөн хоногт 1050 грамм жин нэмдэг Лимузин, Герефорд бухны, таван сарын настайдаа гулуузны жин 20 кг хүрдэг махны хэвшлийн хуцны, саалийн 270 хоногт 1050 л сүү өгдөг ямааны Занен, Тогтенбург, Альпин үүлдрийн ухны үрийг тус тус, Куба улсаас 6-7 кг нарийн ноос өгдөг хонины Австралийн Меринос үүлдрийн хуцны үрийг тус тус имортоор авч ашиглаж байна.

“Альпин” үүлдрийн өдөрт 5 л, жилдээ 1000 л сүү өгдөг ямааг Франц улсаас оруулж ирээд Өвөрхангайд тусгай ферм байгуулан 2013 оноос эхлэн үржүүлж байна. Уг ямааг вакум цонхтой, плитан болон цементэн шалтай, нартай дулаан байранд, ургаа өвс иддэггүй тул хэрчсэн ногоон өвс, үртариа (витамин, глюкозмэтийгхольсон), усыг хатуу тогтоосон цагийн хуваариар (өдөрт найман удаа) жор, нормын дагуу өгдөг байна. Ишгийг гарсан даруйд нь жигнэж, номер бүхий ээмэг зүүж, ургийн (гарвалын) бичиг хөтөлж эхэлдэг. Уг ямааг оруулж ирэлцсэн Франц эрдэмтэн монгол малчдыг малд нүдтэйг, мөн энэ олон малаа цус ойртуулахгүйгээр үржүүлж байгааг гайхан биширч байжээ. Мөн тэрээр Монгол малын хувьд тодорхой ашиг шимээр төрөлжөөгүй мах, сүү, ноос гэх мэтээр юм юмыг багтаасан өрх гэрийн аж ахуйг хангахад чиглэгджээ гэсэн дүгнэлт хийж, зах зээлийн өнөө цагт ашиг шимийн чиглэлээр төрөлжүүлэн үржүүлбэл зохилтой гэж зөвлөжээ.

Тэдгээр ямааг авч ирэх үед Франц мэргэжилтний франц хэлний командаар хөдөлдөг байсан бол одоо (нэг жилийн дараа) монгол хэл ойлгож, монгол малчны командаар хөтлүүлдэг болжээ. Анх ирэхдээ 3 сарын настай ишиг ирсэн тул шинэ нөхцөлд дасан зохицох илүү сайн, үүнтэй холбоотойгоор хялгас нь монгол малынхтай төстэй урт болж байгаа ажээ. "Альпин» ямаа том эвэртэй тул ишгийг 7 хоногийн настайд нь эврийг нь халуун төмрөөр хайрахаргаар мухар болгодог байна. Ишиг эхээс төрсний дараа нэг минут болоод хөл дээрээ босдог, хоёр минут болоод эхийгээ хөхөж амладаг, ердөө гуравхан хоногтойдоо тэжээл идэж эхэлдэг нь монгол малаас ялгаатай байна. Өвс тэжээл байнга иддэг боловч таргалах нь үгүй, харин бүх тэжээл нь сүү үүсгэхэд зориулагддаг, дэлэн нь асар том /10 литрийн бидон шиг/ явахад нь газар шүргэдэг байна.

Зохиомол хээлтүүлэг хийснээр 100 эхээс авах төлийн тоог ихээхэн нэмэгдүүлж, нэг бухын үрээр 640 үнээг, нэг хуцны үрээр 3160 хонь хээлтүүлсэн нь Монголд дээд амжилт байв. Орхон, Хангай, Ерөө, Сүмбэр, Байдраг хонь, Говь гурван сайхан ямаа, Сэлэнгэ үүлдрийн үхэр бий болоход зохиомол хээлтүүлэг чухал нөлөө үзүүлсэн билээ.

4.7.3 Нанотехнологи

Манай эрдэмтэн-судлаачид, мэргэжилтнүүд, бизнесменүүд сүүлийн үед инновацийн бүтээгдэхүүн гэгдэх **нанотехнологид** ихээхэн анхаарч эхэллээ.

- Ингэний сүүнээс чихрийн шижин (сахарын) өвчнийг анагаах бэлдмэл
- Тэмээнээс хорт хавдрыг дарах бодис
- Адууны яснаас яс төлжүүлж бэхжүүлэгч кальцийн бэлдмэл гаргаж аваад хэрэглээнд оруулжээ (ХАА-н маргааш сонин, 2016, №4)
- Хэдэн жилийн өмнө солонгосчуудтай хамтарсан компанид Монгол ямаанаас “хар ямааны бэлдмэл” хэмээх зургаан төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, эмчилгээ сувилгаанд хэрэглэж, улмаар экспортолж байгаа билээ.
- Саяхнаас солонгосчуудтай хамтарсан малын эм бэлдмэл, вакцин үйлдвэрлэх болон ургамлыг шавьжнаас хамгаалах далайн гаралтай

бүтээгдэхүүн, эрдсийн органик бордоо, хүнсний навчит ногоо үйлдвэрлэх чиглэлийн нанотехнологийн хоёр үйлдвэр байгуулагдаж ажил нь эхэлжээ. Энд тэрхүү навчит ногоогоо газар, хөрсөнд биш, агаар, усанд тарих бөгөөд хоногт 20-30 тонн навчит ногоо, экварин хэмээх бодис 3-4 тонныг үйлдвэрлэх аж.

Ер нь монголчууд өвөг дээдсийн үеэс уламжлан эмчилгээ-сувилгаанд хэрэглэсээр ирсэн малын гаралтай, юугаар ч орлуулшгүй эд эрхтэн, дайвар бүтээгдэхүүн, хоол хүнс өдий төдий байдаг бөгөөд эдгээр нь өнөөдөр дотоодын төдийгүй гадны судлаачдын анхаарлыг ихээхэн татаж байгааг тэмдэглэе. Эдгээрт үхрийн гиваан (цөсний чулуу), буурын бохь (булчирхайн шүүрэл), адууны живэр (үлдэгдэл гуурай), малын хатаасан уушиг, засаа, бодын чөмөг, гүүний айраг, ингэний хоормог, цагаан ямааны сүү, улаан үнээний сүү, сарлагийн гүзээлж хадгалсан тос, эззгий, цагаа, шар сүү, хонины битүү чанасан толгой зэрэг олон арван зүйлийг нэрлэж болно. Гагцхүү эдгээрийн эмчилгээ сувилгааны ач холбогдол, нууцыг улам нээн илрүүлж, үйлдвэрлэл, хэрэглээнд нэвтрүүлбэл ихээхэн ашиг орлого олох боломжтой.

МАН-н үйлдвэрлэлийг шинжлэх ухааны үндэслэлтэй, мэдлэгт суурилсан хөгжлийн чиг баримжаатай эрхэлж, инновацийг нэвтрүүлж, бүтээмжийг нэмэгдүүлэх замаар:

- Үхэр, хонины аж ахуйг махны чиглэлээр эрчимтэй хөгжүүлж, махны экспортын нөөцийг нэмэгдүүлэх,
- МАН эрхлэх уламжлалт хэв маяг, мэдлэгийг хадгалах, баяжуулах,
- Малын тоо, төрөл, сүргийн бүтцийн зохист харьцааг баримтлах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, эрсдэл даах чадавхыг бэхжүүлэх,
- Бүс нутгийн онцлогт тохирсон шинэ үүлдэр, омгийг бий болгож генийн санг хамгаалах, нөхөн үржүүлгийг сайжруулахад биотехнологийн ололтыг ашиглах зэрэгт хэрэгжүүлэх шаардлагатай байна.

-Гаргалгаа

Ерөнхийд нь авч үзвэл XXI зуунд Монгол улсад, Уламжлалт өв соёлыг хадгалсан, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон бэлчээрийн мал аж ахуйгаа эрхэлнэ. Харин хот суурин орчимд болон газартариалангийн бүс нутагт ашиг шимийн чиглэлээр төрөлжин эрчимжсэн МАА-г хөгжүүлэхээр төр засгийн холбогдох баримт бичгүүдэд тодорхойлсон билээ.

5. НҮҮДЭЛЧДИЙН УРТЫН ДУУ ДАХЬ БАЙГАЛЬ АРГАДАХ ЗАН ҮЙЛИЙН УЛАМЖЛАЛ

(уртын дууны жишээн дээр)

5.1 Зан үйлийн уртын дууны гарал, өнөөгийн үр өгөөж

Зан үйлийн уртын дуу болон эртний бөө мөргөлийн үзэл онолын харилцан шүтэлцээг түүхч, угсаатны зүйч, археологич, нэрт эрдэмтэн доктор (Sc.D), профессор, Шинжлэх Ухааны Гавъяат ажилтан А.Очир "Монголчуудын арван хоёр хийгээд арван гурав" өгүүлэлдээ дэлгэрэнгүй, гүнзгий тусгажээ. Тэрээр: "Аливаа биет бус зүйлийг ч арван хоёроор багцлан нэг бүхэл болгох явдал баруун халхчуудад байна. Уртын дууг арванхоёр айзам дуу хэмээн ялгаж ангилдаг. Одоо ч энэ хуваарь нь бүрмөсөн мартагдаагүй. Тэрхүү арвахоёр айзам дуу нь нэг багц арван хоёр дуунаас бүрддэг байсны заримыг нутгийн настан нар нэрээр нь хэлдэг байна. ...Ойрадад морины тухай багц багцаар тус бүр арван гурван дуу байдаг бол халхчуудад арван хоёр айзам дуунаас ганда бас арван гурван айзам дуу байдаг. Нэг багцад тус бүр арван хоёр хийгээд арван гурван дуу байдаг. Тийнхүү халхчууд уртын дуугаа арван хоёр болон арван гурваар багцлан хуваадаг байсан нь мэдэгдэж байна.

Дээр дурдаснаас гадна, халхчуудад гучин хоёр шашдир дуу, гучин гурван шашдир дуу гэж байдгийг судлаачид илрүүлэн мэдээлжээ. Энд тэмдэглэхэд, монголчууд өөрсдийн бэлгэдэлт сайн тоо арван хоёр, арван гурваар уртын дуугаа багцлан хуваадаг тэр жишгээрээ их төлөв шашин суртахууны холбогдолтой дуунуудыг бурханы шашны сайн тоо гучин хоёр, гучин гурваар төрөлжүүлэн ангилжээ. Тэгж гучин хоёр, гучин гурван шашдир дуу хэмээх нэр томъёо үүсчээ. Энэ явдал Монголд бурханы шашин дэлгэрсэний дараа болсон нь мэдээж. ...Монгол бөөгийн ёсонд, долоон муу ёрын тэнгэр гэж байдаг. Тэдгээр нь зүүний догшин тэнгэрүүд бөгөөд хилэгнүүлбэл, муу ёр удирдаж, хүн, амьтанд сөрөг үйлдэл үзүүлдэг хэмээнэ. Тэгээд монголчууд зүүний догшин тэнгэрүүдэд бор морь сэтэрлэн аргагддаг. Гэтэл баруун халхчуудын дунд "Долоон борын дуу" гэж байдаг. Тэр нь долоон бор морины тухай долоон уртын дуу аж. Долоон борын тухай долоон дуунд, "Хоёр бор", "Өндөр сайхан бор" гэх мэт дуу багтдаг. Алдарт дуучин Г.Поврон гуай долоон борын дууг маш сайхан дуулдаг байсан хэмээн настайчууд хуучилдаг. Тэгэхээр долоон

борын дуу нь хар зүгийн догшин тэнгэрүүд, түүний дотор долоон муу ёрын тэнгэрт сэтэрлэсэн унаа хүлгийг нь магтах байдлаар тэдгээрийг аргадан баясгадаг далд утга бүхүй дуу байлтай"⁷⁰гэжээ.

Хуучин халхын үед Түшээт ханы нутагт ихээхэн ган гачиг тохиолджээ. Энэ тухай сонссон Цэцэн хан "Өргөн үүл" хэмээх дуу дуулахыг сануулжээ. Мөн, бороо их орж Тэнгэр задарвал "Сэнсийн цагаан үүл"-ийг дуул гэжээ. Уг мэдээ "Өндөр гэгээн Занабазарын намтар"-ын архив дотор тааралдсан тухай Хэл Зохиолын хүрээлэнгийн судлаач, доктор (Ph.D) Д.Сумъяа сануулсан боловч сайх баримтыг мөхөс би олж үзэж амжилгүй удаж, тайлан тушаах цаг тулав.

Монгол хөгжмийн таванэгшигт (pentatonic scale)-ийн зарчмыг нээж боловсруулсан судалгааны үр дүнгүүд нь уртын дууны хөгжмийн талын бүтэц, зохиомжийг танихад ихээхэн өмөг түшиг үзүүлж, олон төрлийн өгөөжтэй байгаа юм. Жишээ нь, уртын дууг уламжлал-шинэчлэл хослуулж бүтээсэн орчин цагийн монгол хөгжмийн шинжлэх ухааны өвөрмөц арга барилын үүднээс судалж, уртын дууны хөгжмийн зүй тогтол балар эрт цагт бүрэлдсэн болохыг ахмад судлаач доктор (Ph.D), профессор Д.Оюунцэцэг бодит баримтаар илрүүлж, эцэст нь "Монгол уртын дуу 40 мянган жилийн настай өвөг хөгжим" [2018.148] гэж дүгнэжээ. Энэ үр дүн нь зан үйлийн уртын дууны гарвалзүйн тухай өмнө бидний төсөөлж байсан 3500-4000 орчим жилийг олон мянган жилээр холын үсрэлттэй урагшлуулсан үзэл санаа болж байна. Бидний бодоход, ахмад судлаачийн ажлын энэ үр дүн нь: балар эртний өвөг уртын дуу нэг үндэстний бус (тэр үед тус тусдаа бие даасан үндэстэн болж ялгараагүй, овгийн нийтлэг соёлтой байжээ), тухайн үеийн зүүн өмнөд сибирь, түүний өвөр дэх монголын тэгш өндөрлөг бүхий уул, талаар нутагтай, амьдралын нэг хэмнэлтэй, ахуй нөхцөл ижилтэй, нэгдмэл дом шившлэг, тотем-шүтлэг, бөө мөргөлтэй үеийн оршин суугчдын нийтлэг дуу хөгжмийн төрх өнөөгийн хүн төрөлхтний зарим хэсгийн ардын дуунд хадгалагдаж байгаагийн нэг жишээ бололтой байна. Тиймээс монгол уртын дууны язгуур эд эс 40,000 жилийн өмнө лавтай бүрэлдэн тогтсон байжээ гэж үзэх нь судлаачийн итгэл үнэмшил мөнөөс гадна Америкийн уугуул иргэдийн уриа дуудлагын дуу, өвөг Монголчуудын зан үйлийн уриа дуудлагын дуу хоёрын хөгжмийн зүй тогтол

⁷⁰Түүхийн судлал. Боть XLVIII. Эрхэлсэн Б.Пунсалдулам, Ч.Батдорж. УБ., 2019. Тал 45-53.

адилхан байгаа нь яах аргагүй сонирхолтой юм. Судалгааг цааш үргэлжлүүлэхдээ, "авиа дуурайх онол", "хүний өгүүлэхүйн эрхтний бүтэцзүй, хөгжил, хувьсал", "манж, түнгүс, түрэг удмынхны ардын дуу" г.мэтийг ч бас харгалзан баримжаалж, харьцуулах учиртай байх. Бас, шүтлэг, шашны соёлоос гадна газарзүйн орчны уртраг өргөргийн нөлөөг ч орхиж болохгүй биз ээ. Лавтай, өнөөгийн монголчууд бид Зүүн хойд Азийн балар эртний өвөг дээдсийнхээ соёлын болон биологийн удамзүйг олон хэлбэрээр хадгалж байгаа бөгөөд түүнийг гэрчлэх нэг баримт нь дэд эрдэмтэн Д.Оюунцэцэгийн судалгааны шинэ үр дүн, уртын дууны бүтэц зохиомжийн судалгаа болж байна.

Мөн Хүннү гүрний хааны үр удамтай холбоотойгоор уртын дуу үүссэн тухайн түүхийн мэдээ үлджээ. Эртний Хятадын Вэй улсын бичиг, Рү Рү Го ү нарын шасдирт бичсэнээр: Хүннүгийн Чан Иү (Шаньюй) хоёр хүүхэнтэй, өнгө зүс үзэсгэлэнтэй тул ард иргэд цөмөөрөө сахиулсан хэмээлдмой. Чан Иү өгүүлрүүн: “Би ийм хүүхнээ хэрхэн хүмүүн дор улаглан холбож болмой, тэнгэрт хариулсугай” хэмээв. Ийнхүү улсын умард дор хүн харгүй газар, өндөр төгт цогцлоог хоёр хүүхнээ дээр нь талбивай. Чан Иү “Хурмаст тэнгэр өөрсдөө богтлон буулгаж аваачигтун” хэмээжээ...хэдэн жил өнгөрсний дараа нэгэн хөгшин чоно өдөр шөнийн хувинд тагтыг сахин уливай. Тагтын угийг самардан маажилсаар нүхлэн үүр болгоод цаг ямагт салалгүй сахивай. Бага хүүхэн нь өгүүлрүүн: “Эцэг эх минь намайг энд талбисан нь тэнгэр дор богтлон өгөх хэмээсэн болой. Эдүгээ чоно ирсэн нь тэнгэрийн илгээсэн сахиулсан болой хэмээн тагтаас бууж биеэ тушаасугай” хэмээжээ. Эгч нь ихэл хэлмэж (уурлаж)өгүүлрүүн: “Энэ бол адгуусан болой, эцэг эхийн санааг бүү үтгээр (бузарла)” хэмээв. Охин дүү нь үл сонсон бууж очоод чонын гэргий болж хөвүүн төрөв. Хожим нь үржин олширсоор улс болов. Тэр улсын ард иргэд уртаар уянгалуулан дуулах нь чоно адил төстэй” гэжээ.

(匈奴单于生二女，容貌甚美，国人皆以为神，单于曰，吾有次女，安可配人，将以与天，乃于国北无人之地筑高台，置二女其上，曰，请天自迎之。。。夏一年，乃有一老狼昼夜守台嗥呼，因采穿台下为空穴，经时不去。其小女曰吾父处我于此，欲以与天，而今狼来，或

是神物，天使之然。将下就之。其姐打惊曰，此是畜生，无乃辱父母也，妹不从，下为狼妻，而产子。后遂滋繁成国)⁷¹。

Энэхүү түүхэн баримтыг Монголын түүхч, доктор (Sc.D), профессор Г.Сүхбаатар, ахмад хөгжим судлаач доктор (Ph.D), профессор Ж.Энэбиш нар бүтээлдээ тусгаснаас гадна, Оросын эрдэмтэн Н.И. Бичурин “Собрание о народах, обитавших в средней Азии в древние времена” (Т, II. М., 1950. с. 214-215) зохиолдоо дурджээ. Уг мэдээнд уртын дуугаар дамжуулж Хүннү гүрний төрийн эрх баригчдийн үр удам нь өнөөгийн монголчууд гэдгийг дам зааж байгаагаас гадна төрт ёсны шашин шүтлэг, зан үйлийн орчинд уртын дуу аль эрт дэвшин хөгжсөнийг илтгэх аж. Тиймээс монгол уртын дуу нэн эртний уг гарвалтай гэж үзэж болно. Магадгүй, хүн төрөлхтөний анхны дуу, хөгжмийн өвгөн, эмгэн сүнсийг хадгалсан монгол уртын дуу, Азийн өргөн уудам нутагт тархсан монгол угсаатны бүлэг бүрт олон төрөл зүйлээр хадгалагджээ. Уртын дуу монголчуудын өдөр тутмын аж ахуй амьдралаас өгсүүлээд төрт ёс, шашин шүтлэг, зан үйл хүртэл асар өргөн цар хүрээнд хэрэглэгдсээр иржээ. Тиймээс уртын дуу нь:

-Төрийн дуу;

-Айзам дуу (айзан, айдам, айдон);

-Шасдир дуу (үйзэн);

-Гүр дуу;

-Цоор дуу;

-Цээр дуу; (бэсрэг, шавшаа, гэгэлгэн) гэсэн ерөнхий төрлүүдэд хуваагдан хөгжиж, өнөө үед уламжлагдсныг монгол туургатны хэмжээнд бодитоор харж болно.

Монгол уртын дуу: Монгол Улсын нутаг дэвсгэр бүхлээрээ; ОХУ-ын Буриад, Халимаг, Тува; БНХАУ-ын Өвөр монголын ихэнх нутаг, Шинжианы Ховог Сайр, Борталын торгууд монголчууд, Цинхай буюу Хөх нуурын дээд монголчууд, Цастын монголчуудад их, бага хэмжээгээр тархан хадгалагдсан нь улам бодитой болсоор байна. Үүнийг тархацаар нь авч үзвэл Их газар (Азиевро тив)-ын асар өргөн уудам нутагт монгол уртын дуу амьдарч байна гэж үзэх үндэстэй юм.

⁷¹Зян Рун “Чоно тотем”. Лионингийн үндэсний хэвлэлийн хороо. 2006 он. Хятад хэлнээс орчуулсан Нарс, Ван Шү нар. Тал 10.

Монгол уртын дуу хүн төрөлхтөний төлөөлөх чанартай соёлын өв болж баталгаажсаны үнэ цэнэ, ач холбогдол нь гэвэл:

Нэгдүгээрт: уртын дуунд хүмүүний аж амьдрал, сав шим ертөнц, байгаль дэлхийн зүй тогтлыг ухааран танисан олон мянган жилийн туршлага, байгал (оршихуй)-ийг хүндэтгэн харьцах замаар хүн-байгаль хоёрын тэнцвэрт байдлыг хадгалах арвин мэдлэг агуулагдаж байна;

Хоёрдугаарт: хүний бие сэтгэл, оюун санааны цар хүрээ, дуу хоолойн ур чадварын өвөрмөц арга барил, өгүүлэхүйн эрхтний нөөцийн өргөн боломжийг нээснээрээ;

Гуравдугаарт: ард түмний амар амгалан амьдрал, эв найрамдалтай оршин байхын сүлд дуулал болдгоороо онцгой содон, олон төрлийн үр өгөөжтэй урлаг болой.

Нэг үгээр хэлбэл, эртний шүтлэгт өвөг монголчуудын бөө мөргөлийн уриа дуудлага дуу нь түүхийн урт хугацааны явцад эзэнт гүрэн, овог аймгуудын төрт ёсны зан үйл, соёл бүрэлдэхэд зүй ёсоор шургалан орж монгол урлагийн нэгэн содон төрөл "Уртын дуу" болжээ.

5.2 Зан үйлийн уртын дууны төрөл, зүйлийн тойм

Эртний монголчууд уртын дууг өдөр тутмын сэтгэл санааны хэрэглээнээс өгсүүлээд төрт ёс, шашины соёл, зан үйлд өргөн дэлгэр хэрэглэдэг байж. Тэдний хэрэглэдэг байсан уртын дуу нь өнөөгийн төрийн, айзам, шасдир, гүр, цоор уртын дуу л байсан байх боломжтой санагдана. Мөн сайн сайхны бэлгэдэлт зан үйлийн орчинд дуулахыг цээрлэдэг цээрийн дууны өв сан, бас ХХ зууны дунд үед бүрэлдсэн тайзны уртын дуу ч нэг төрлийн зан үйлийн шинж чанарыг агуулж байна. Монгол зан үйлийн уртын дууны эдгээр төрлүүдийг томъёолон харж болно.

5.2.1 Төрийн дуу

Монгол угсаатны бүлэг тус бүрдээ зан үйлийн айзам, шасдир, гүр, цоорын дууны урын сангаас шигшин авч бүрдүүлдэг төрлийг "Төрийн дуу" гэнэ. Төрийн дуу нь 3, 4, 5, 9 г.м тооны бэлгэдлийг хадгалсан болох нь одоогоор мэдэгдэж байна. Жишээ нь сартуулын "Төрийн гурван дуу", үзэмчиний "Төрийн гурван дуу", боржигины

"Төрийн дөрвөн дуу"⁷², цахарын "Төрийн дөрвөн дуу", ордосын "Төрийн таван дуу", ойрадын хошууд дээд монголчуудын "Төрийн таван дуу"⁷³г.м өдгөө ч хадгалагдаж буй. Бид орчин цагийн төрийн дууг халхчуудын айзам, шасдир, гүр дууны урын сангаас шигшин сонгож, 9-ийн тоонд багцлан сэргээнсэн билээ. Төрийн дууг төрт ёсны зан үйл, ёслол хүндэтгэлийн үйлд тэнгэр өөд өргөж уриа дуудан дуулдаг байж. Жишээ нь, Алашаа хошууд нарын төрийн дууны магнайд "Үрсийн дуу" гэж бий. Тэр дууг Хавт Хасарын удмын хошуудууд эрт цагт Алашаад дэвшүүлжээ. Тэдний Хасар Тэнгэр өөд уриа дуудан дуулдаг дуу нь энэ ажээ. Тиймээс "Өнө өргөн Алашаа" дууг тэд "Төрийн их дуу"⁷⁴хэмээдэг. Төрийн дууг аливаа зан үйлд дуулахдаа шүлгийг заавал бүрэн гүйцэд дуулж утгыг нь илэрхийлдэг уламжлалт дэгтэй. Эрт цагт төрийн дууны овоо буюу цагаан сүлдэт овоо түгээмэл байж. Харин одоо дээд монголчууд буюу ойрадын зарим хэсэгт уламжлагджээ. Төрийн дууны овооны цагаан сүлд нь амар амгалан, баяр цэнгэлийн бэлгэдэл болно. Энэ төрлийн овоо байгуулах нь уг агуулгаараа тухайн угсаатан, нутаг усанд уртын дуу, дуучин хоёр тасрахгүй байхыг бэлгэдсэн тэмдэг аж.



(62-р зураг.2013 онд Төрийн түүхийн музуйд цахим хэлбэрээр, Соёлын Өвийн Үндэсний Төвд эх хувилбараар хадгалуулсан "Монгол төрийн есөн уртын дуу" бүтээлийн шоголт эх. Уртын дуучин, судлаач М.Дорждагва, морин хуурч Б.Баттулга)

5.2.2 Айзам дуу


Орчин цагийн нүүдэлчин монголчуудад "Арванхоёр айзам", "Арвангурван айзам", бас "Долоон борын дуу" гэсэн багцууд хадгалагджээ. Тодруулбал, бидний судалгааны явцад халхчуудад арванхоёр хийгээд арвангурван айзам, ойрад монголчуудад арвангурван айдам (Арван гурван морины дуу), өвөр монголчуудад

⁷²М.Дорждагва. Халх монголчуудын уртын дуу зан үйл-I. УБ., 2018. Тал 40, 26

⁷³М.Дорждагва. Дээд монголчуудын уртын дууны өв. ШУ-ны Грантын тайлан. НСИСОУХ.,2018. Тал 8.

⁷⁴М.Дорждагва. Өвөр монголчуудын уртын дууны өв. УБ., 2019. Тал 35.

арванхоёр айзам дууны багц хадгалагдаж байна. Мөн Хангай нурууны бүс нутгийн халхчуудад долоон борын дуунаас хадгалагдаж байгаа нь хээрийн судалгаагаар мэдэгдэв. Дээр дурдсан багц уртын дуунуудын тооны бэлгэдэл нь нэн эртний бөө мөргөлийн үзэл онолтой холбоотой харагдана. Арван хоёр айзамыг "эхлэх айзам", "төрийн айзам", "дагах айзам" гэж ангилж байж⁷⁵. Жишээ нь, бэсүдийн угтах гурван айзам дуу өнөөдөр ч хадгалагдаж байна⁷⁶.



(63-р зураг, Арван гурван цацагт хиригсүүр. Ховд аймгийн Мөнххайрхан сум. Профессор Д.Эрдэнэбаатарын гар зураг)

(64-р зураг, Долоон цацагт хиригсүүр. Төв аймгийн Манзуширийн хийд. Судлаач Г.Мандахбаярын гар зураг)



(65-зураг. Завхан аймгийн Сонгино сум дахь "Ламын арвангурван овоо".
Зурагчин П.Баатарзоригт. 2019 он)

⁷⁵А.Алимаа. Уртын дууны тархалт, хувилбарын онцлог. УБ.,2012. Тал 69.

⁷⁶М.Дорждагва. Халх монголчуудын уртын дуу, зан үйл-I. УБ., 2018. Тал 32.

Бид бүхний үзэж байгаагаар, айзам уртын дуу анхлан өвөг монголчуудын бөө мөргөлийн үзэл онолд суурилжээ. Арванхоёр, арвангурав, долоо гэсэн тоонууд нь эртний тэнгэр шүтлэгт монголчуудын зан үйлийн тэмдэг болдог байжээ. Нэг үгээр хэлбэл, бөө мөргөлийн үзэл онол дахь зүг чигүүдийн эздэд үг, аялгуугаар уриа дуудлага тэмдэг дохио илгээдэг байснаар монгол уртын дууны урлагийн суурь тавигдсан бололтой. Тиймээс дээрх зүг чигийн тооны утга бэлгэдэлд өвөг буюу айзам уртын дуу багцлагджээ. Мөн айзам уртын дууны үзэл онол дараа дараачийн зан үйлийн дуунуудад нөлөөлжээ. Жишээ нь, ордосчуудад "Арвангурван гүр дуу" хадгалагдаж байна. Айзам уртын дуу нь ахуй, байгалийн нэг орчинд тасралтгүй олон мянган жил оршин тогтносоор XX зууны эхэнд үетэй золгож, нийгмийн салхинд өртөн хагасарсан ч угаас үр үндсэн гүнзгий тул гарал язгуураа чанад хадгалж XXI зуунд иржээ. Айзам дуу өвөг монголчуудын хүрээнд маш эрт цагт үүсээд Хүннү гүрний үед төрт ёсны соёл, зан үйлийн орчинд дэвшин гарч хөгжлийн шинэ үеийг олсон бололтой байна.

5.2.3 Шасдир дуу


Буддын шашин нийтийн хэрэглээнд гүнзгий шилжиж монголчуудын зан үйлийн уриа дуудлагад нэгэн шинэ төрөл үүсчээ. Тэр нь шасдир уртын дуу аж. Энэ төрлийн уртын дуу "Шасдир найман дуу", "Гучинхоёр шасдир", "Гучингурван шасдир" гэсэн тоогоор голлон багцлагджээ. Бидний судалгаагаар халхчуудад гучинхоёр, гучингурав, өвөр монголчуудад найм гэсэн тооны багцаар шасдир дуу дуулагддаг нь мэдэгдэж байна. Монгол улс дахь монголчуудын шасдир уртын дуу XX зууны эхэн үеэс нэлээд бүдгэрсэн ч үлдэгдэл нь одоо цагт нүүдэлчдийн ой санамж, ур чадварт хадгалагдаж байна. Харин өвөр монголчууд шасдир найман дуугаа зан үйлийн орчинд өргөн хэрэглэж байна. Энэ төрлийн уртын дуу Монголын Их Юань гүрний үеэс хойших түүхийн орон зайд үүсч хөгжсөн болов уу. Ялангуяа, 1572 онд Хутагтай сэцэн хунтайжийн зохиосон нэгэн хууль [Бира, 2017. 97-101]-ийн эрх зүй хүчтэй бэхжиж, богино хугацаанд өргөн дэлгэрсэнтэй холбоотойгоор монголчуудын буддын шашны зан үйлийн гучинхоёр, гучингурван шасдир уртын дуу үүсч хөгжих нөхцөл бүрдсэн баймаар бодогдоно. Шасдир дуу айзам дууны адил монгол үндэстний угсаатны бүлгүүдэд өргөн дэлгэрч байсан нь судалгаагаар мэдэгддэг. Энэ төрлийн уртын дууг нутаг нутгийн аман

уламжлалаар шашдир, шаштөр, шажнаан дуу гэж нэрлэсээр байна. Өнөөгийн алашаачууд төрийн дууны урын сангаа шасдир дуугаар бүрдүүлсэн байна. Шасдир дууг Өвөр монголын судлаач Г.Мун Мэй тусгайлан судалж 2011 онд дэд эрдэмтний зэрэг горилсон.

5.2.4.Гүр дуу

Доктор (Sc.D) Л.Эрдэнэчимэг зэрэг судлаачдийн үзэж байгаагаар 1766 оноос эхлэн монголчуудын зан үйлийн уртын дууны ай савд нэгэн шинэ төрөл мэндэлжээ [2015.13]. Түүнийг монголчууд "Гүр дуу" гэж нэрийдэн өнөө цагт ч монгол үндэстний зарим угсаатны бүлгийн шашны зан үйлд хэрэглэгдэж байна. Өвөр монгол дахь ордосчуудад "Арвангурван гүр дуу" хадгалагдаж байна. Мөн Тэлмэн нуур орчмын өвөр хотгойдуудад "Гүр таван дуу" байсан нь одоо бүдгэрсээр "Дуртмал сайхан" гэх дууны нэр үлджээ. Энэ төрлийн дууг хуучин айзам, шасдир уртын дууг бичгийн хэлбэрт буулгах замаар онол арга зүйг нь боловсруулжээ. Ингэхдээ дорно дахины шашны дуун ухааны ян-ег, дан-иг гэх бичгийн соёлыг ашиглажээ. Бидний бодоход, гүр дуу нь эртний нүүдэлчин монголчуудын зан үйлийн уртын дууны хамгийн сүүлчийн бүтээл туурвил байж. Бичиг сурвалжаас үзвэл, гүр дуу 5, 8, 13-аас гадна буддын шашны үзэл онол дахь 36, 64, 72, 86 г.м тоон бэлгэдэлд багцлагджээ. Харин ордосчуудын гүр дуу "арвангурав" гэсэн тоогоор багцлагдсан нь тэдний тахилга тайлгын тэнгэр шүтэх үзэлтэй холбоотой биз. Тиймээс эртний арвангурван айзам уртын дуу гүр дуунд нөлөөлсний нэгэн тэмдэг нь ордосчуудын "Арвангурван гүр дуу" байж болно. Гүр дуу айзам, шасдир уртын дууны адил нийт монгол туургатанд өргөн хүрээтэйгээр тархаж амжилгүй XX зууны эхэн үетэй золгосон бололтой. Одоогоор Баянхонгор аймаг, Завхан аймаг, Өвөр монголын ордосчуудад гүр дууны өв уламжлагдсан нь үүгээр мэдэгдэж байна.

Зураг № 25-28. Махагал залбирал



(66-р зураг. Л.Эрдэнэчимэг. 2015. 200)

5.1.5 Цоор дуу

Энэ төрөл өвөр монголчуудын зан үйлийн уртын дууны тулгуур хэсэг билээ. Цоор дуу халхчуудад нөлөөлж байсан шинж тэмдэг байдаг. Жишээ нь цоор хоолойт, эрүү нугалаат г.м нэршил ХХ зууны эхэн үе хүртэл хадгалагдаж байгаад бүдгэрчээ. Тодруулбал, Монгол Улс дахь цоор дуу, төдийгүй “эрүүний нугалаа” зонхилсон арга барилын ул мөрийг ХХ зууны алдарт уртын дуучин Сэлэнгэ аймгийн харъяат, хуучнаар Түшээт хан аймгийн Эрдэнэ вангийн хошууны удам дагасан төрийндуучин Ваанчигийн Пунцаг (1903-1968)-ийн дуулах аялгуу, арга барилаас мэдэж болно. Мөн хуучин Сайн ноён хан аймгийн Алдар хаан уулын хошуу буюу одоогийн Завхан аймгийн Алдархаан сумын нутагт төрийн дуучин “цоор” Цэгмидгэж байжээ. Тэрээр Ургамалын “онгой” хочит Адъяа, Шилүүстэйн “хол дуут” хочит Г.Поврон нартай Манжийн амбаны найранд уригдан дуулдаг байсан нь домогшиж үлдсэн юм. Гэвч Монгол Улсын нутаг дахь цоор дуу ХХ зууны эхэн үе гэхэд дан хоолойгоор дуулах хэлбэрт шилжсэн байжээ. Жишээлбэл, суурь эгшиг буюу хархираа хоолойгоор давхар дугаралт үүсгэдэг өвөрмөц барил ХХ зууны эхэн үе гэхэд халх уртын дуучдаас холджээ.

Цоор дуу эртний хорчин, зарууд, цахаруудын үр хойчист түгээмэл уламжлагдсан. Энэ төрөл нэг хэсэг бүдгэрэх эрсдэлд байсан боловч өвлөгчид нь цоордон дуулах аргыг өргөн хөгжүүлжээ. Уг төрлийн ХХ зууны онцгой төлөөлөгч нь Өвөр монголын алдарт уртын дуучин Лхажав, голлох судлаач нь түүний шавь Гэрэлтү билээ. Лхажавын дуулсан олон цоор дуу байдаг. Гэрэлт дэд эрдэмтний зэрэг горилохдоо цоор дуу дуулах арга барилд үндэслэсэн юм. Цахар орчмынхон төрийн дуугаа цоор дууны урын сангаас голлон бүрдүүлсэн байна.

Угтаа цоор дуу нь “уртын дууг цоордож дуулах” гэсэн дундад эртний оролдлогоос үүссэн байлтай. Нэг үгээр хэлбэл, эртний чийрэг бадриун баатар эрчүүд гоцлон дуулаачийн төрт ёсны дууг цээжний хөндийн булчин, өрцний тэлэлт, хэлний угийн авиажуулга, хөөмэйн хөндийн шахалтын хүчирхэг түлхэлтээр дуу үүсгэн түрдэг байжээ. Улмаар энэхүү барил нь монголчуудын уртын дууны содон, бие даасан дэг сургууль болж хөгжсөн бололтой байна. Нөгөө талаас, алтан ургийн болон бусад язгууртан монголчуудын зан үйлийн уртын дууны дэг сургуульд цоордох үзэгдэл

гүнзгий нэвтэрч чадаагүй юм. Хэрвээ гүн нэвтэрсэн бол өнөөгийн халх, ойрадын айзам дуу, шасдир дуу, гүр дуу, бас төрийн дууны өвд цоордон дуулах хэлбэр түгээмэл уламжлагдах учиртай билээ. Жишээлбэл, боржигин халхчуудын төрийн дөрвөн дуунд цоорын шинж илрэхгүй байгаа нь энэ бодлыг үнэмшилтэй болгох аж.

5.2.6 Цээр дуу

Аж байдлын дуу ч гэж нэрлэдэг энэ төрөл ямар нэг зан үйлийн оролцоогүй, төрт ёс, шашин шүтлэгийн зан үйлийн орчинд дуулахыг хориглодог цээрлэх ёсны уртын дуу юм. Хөхнуурын дээд монголчууд "нутаг ус, мал сүргийн дуу буюу морин дэл дээрх дуу", монголын ойрадууд "цээр дуу", халхчууд "цээр, бэсрэг, шавшаа, гэгэлгэн дуу" гэж нэрлэдэг уламжлалтай. Нутаг нутагт цээрийн дууны өв өргөн дэлгэр буй. Жишээ нь, бидний сайн мэдэх "Ар хөвчийн унага", "Нарийн сайхан хээр", "Хүрэн толгойн сүүдэр", "Эрдэнэ засгийн унага" г.м сайн сайхны бэлгэдэлт зан үйлийн толгой хэсэг (журамт найр)-т дуулахыг хатуу хориглодог олон арван уртын дуу цээрийн дуу мөн болой. Харин эдгээр дуу сайн эрс зэрэг нүүдэлчин малчдын морин дэл дээрх юм. Цээрийн дуунд бусад төрлийн уртын дууны адил тусгайлсан "түрлэг" гэж байхгүй. Түрлэг гэдэг нь зан үйлийн уртын дууны бадаг тус бүрийн дунд тусгай ая, эсвэл дууны төгсгөлийн тойрог(тухайлбар) аяас залгаж, мөн ямар нэг хүндтэй дууг бүрэн дуулж өндөрлөхөд нийтээрээ түрэн дуулдаг нэг төрлийн дэг горим, бас ёс, бэлгэдэл-тэмдэг дохио билээ. Томоохон хэмжээний зан үйлийн уртын дуу дуулахад түрлэг нь шүлгийн бадаг тус бүрийн дунд гоцлол дуучныг амраах, дараагийн бадагт бэлтгэх гол нөхцөл болж өгдөг.

5.2.7 Дуурьлаг дуу

Монголчуудын зан үйлийн уртын дуунаас зарим хэсэг нь шинэ цагийн тайзны урлагийн хязгаарлагдмал орчинд дэвшээд бараг 100 шахам жил болж байна. Өрнө дэхний хөгжмийн онолын үүднээс судлан, дуурийн дуулаачийн урлагтай зэрэгцэн нэг орчинд сурч, дуулж байгаа төрөл юм. Уг төрлийн дуулах ёс, дэг горим, дуучдынх нь ур чадварт дуурийн дуулаачийн урлагийн нөлөө туссаар байна. Угтаа, зан үйлийн уртын дууны энэ шинэ төрөл нь уламжлалт төрийн, айзам, шастир, гүр, цээрийндууны өвөөс бүрэлдсэн юм. Ингэхдээ, зонхилон хуучин халхын дөрвөн аймгийн уртын дууны дэг сургуулиар дамжин тайзаны орчинд гарсан билээ. Зан үйлийн уртын дууны

уг төрөл 1921 оноос 1950-иод оны хугацаанд орчин цагийн монголын тайзны урлагийн хязгаарлагдмал орчинд алгуурханаар гарч ирээд, бүрэлдэн тогтож байна. Тиймээс эртний монголчуудын зан үйлийн уртын дууны төрлүүдээс ялгаатай юм. Шинэ цагийн суурин амьдралтай монголчуудад тохирсон зан үйлийн уртын дууны шинэ төрөл, зүйл үүссэн энэ түүхэн үйл явдалд улс төрийн бодлого, зохион байгуулалтын талаас А.Амар (1886-1941), шинжлэх ухааны үндэслэлийн талаас М.Дугаржав (1893-1946) нар чухал үүрэг гүйцэтгэжээ.

XIX-XX зууны эхэн үе гэхэд эртний гаралтай төрийн, айзам, шасдир, гүр, цээрийн гэх уртын дууны нийтлэг төрлүүдэд суурилсан халх монголчуудын төв халх, боржигин, баянбараат, баруун аймгийн аялгуу, дэг сургууль бүрэлдэн төлөвшсөн байв. Улмаар соёл иргэншлийн шилжилт хөдөлгөөн (интеграци)-ий аясаар орчин цагийн тайзны урлагт зарим хэсгээс нь дэвшиж "Дуурьлаг уртын дуу"⁷⁷(Opera-Long Song) гэсэн нийлмэл (сентиз)шинжтэй шинэ төрлийг бүрэлдүүлсэн нь энэ билээ. Тэрхүү нийлмэл төрөл нь XX зууны дунд үеэс хойш системчлэгдэн тогтохыг шаардсаар, зарим талаараа цэгцэрч амжилгүй XXI зуунтай золгожээ. Дуурьлаг буюу тайзны уртын дуу нь дотроо дараах байдлаар хэлбэрчлэгдэн зүйлчлэгддэг. Үүнд:

1. Айзам уртын дуу;
2. Суман (жирийн) уртын дуу;
3. Бэсрэг уртын дуу; гэсэн үндсэн гурван хэлбэрийг ярьдаг.

Дуурьлаг-айзам уртын дуунд өрнө дэхний хөгжмийн хэлээр 2 наймц (октав)-аас дээш багтаамжтай уртын дуунуудыг нэрлэх аж. Суман жирийн уртын дуунуудад 2 наймц орчим цараатай дуунуудыг зааж байна. Бэсрэг уртын дуунд "Хөөрхөн халиун", "Олом нь үгүй далай" г.м эгшиг өргийн багтаамж бага, хөгжмийн жижиг хэлбэртэй дууг хамруулдаг⁷⁸. Мөн доктор (Ph.D) А.Алимаа зэрэг судлаачид "бэсрэг уртын дуу" гэдгийн "бэсрэг" нь урт, богино аяны холимог хэлбэрийг заасан нэр гэж тайлбарласан.

Бидний харахад, орчин цагийн монголчуудын зан үйлийн уртын дууны энэхүү дуурьлаг хэмээх шинэ төрөл, зүйлийн "Айзам" дотор нь уламжлалт төрийн, айзам,

⁷⁷"Cultural Diversity of Nomads". 6th-7th August, 2011. Ulaanbaatar. Тал 59-61.

⁷⁸Г.Ринчэнсамбуу. Монгол ардын уртын дууны туурвил зүйл, гоо сайхан. УБ.,2011. Тал 134.

шасдир, гүр болон цээрийн дуу ч багтаж. Суман, бэсрэг уртын дуу гэж нэршүүлж буй төрөлд ч мөн адилхан байна. Жишээ нь, утга агуулга, хэрэг үүргийн хувьд "Хөөрхөн халиун" (Нарийхан халиун) бэсрэг буюу цээрийн уртын дуу биш, харин барга нарын хуримын зан үйлийн айдон (айзам), "Олом нь үгүй далай" бэсүдийн "Гучин хоёр шасдир" дууны нэг мөн билээ.

Ийнхүү монголчуудын зан үйлийн уртын дууны үндсэн 7 төрлийг товч тайлбарлав. Зан үйлийн уртын дууны дээрх төрлүүд дотор задын дуу, овоо тахилгын буюу лус, хурын дуу, салхины эзнийг аргаддаг дуу, айж цочсон үедээ мориноосоо бууж аргал хомоол ууриулаад дуулж сүнсээ аргаддаг дуу, савдагт шинэ гэр даатгадаг дуу, төрийн дууны цагаан сүлд бүхий овоо г.м уртын дуу шүтлэгтэй холбоотой зүйлүүд өнөө хүртэл уламжлагдсан нь бодитоор мэдэгдэв. Монгол уламжлалт зан үйлийн уртын дууны дээрх төрөл, түүнийг бүрдүүлэгч зүйлүүд нь оюун санаагаараа байгаль, цаг агаартай дасан зохицох монгол хүний сэтгэл зүйн хэрэглүүр, бас байгаль хамгаалах уламжлалт нэгэн арга байжээ гэж үзэж болохоор байна.

5.3 Зад шүтлэг ба уртын дуу

<<Задлах зан үйлд дуу авианы нөлөөлөл>>⁷⁹чухал болохыг судлаач Ю.Болдбаатар тодруулан бичжээ. Ингэхдээ тэрбээр уруул амаас гаргах элдэв дуу чимээ, бөө мөргөлийн дуудлага, бурханы шашны тарни, тууль, дуулалт яруу найраг зэрэг мэдээ сэлтийг иш болгосон байна. Нөгөөтэйгүүр, ахмад эрдэмтэн доктор (Sc.D), профессор С.Дулам задын үүсэл, бэлгэдлийг гүнзгийрүүлэн тайлбарласны сацуу <<Уртын дууны үүсэл нь алс эрт цагийн сүлд шүтлэг, тэр дундаа чоноор сүлдэлсэн овог аймгийн дунд үүссэн нь хиад боржигин зэргийн чоно сүлд шүтээнтэй холбоотой, түүнийгээ дурсан санагалзаж, урин дуудсан ураа дуудлагын шинжтэй үүссэн бололтой. ...энэ нь дээд тэнгэр гарвалтны дохио тэмдэг болдог онцлогтой гэсэн дүгнэлт хийж болохоор байна>>⁸⁰гэжээ.

Задын шүтлэг, задын чулуу, задлахуй нь эртнээс Дорно, Өрнийн түүхчид, судлаачид, жуулчдийн анхаарлыг татсаар иржээ. “Монголын нууц товчоо”⁸¹, “Алтан

⁷⁹“Монгол нутаг дахь эртний нүүдэлчдийн задын шүтлэг” УБ.,2008. Тал 95-102.

⁸⁰Судлаачийн хувийн сан хөмрөгөөс.

⁸¹Монголын нууц товчоо. IV бүлэг. 143-р зүйл.Лувсанданзаны “Алтан товч”. Хэвлэлд бэлтгэсэн Ц.Шагдар,

товч”⁸²зэрэг сурвалжид задын тухай тэмдэглэгдсэн зүйл байна. Гэвч ихэвчлэн дайн байлдааны зориулалтаар зад барьж байсан тухай мэдээ агуулагджээ. Үүнээс гадна зад шүтлэг, задлахуй нь нүүдэлчдийн байгаль дэлхий, цаг агаартай сэтгэл зүйгээр зохицож, үр өгөөжийг нь зохистой хүртэхэд нөлөөлдөг гэсэн үзэл ойлголтоор хэрэглэгдэж ирсэн нь лавтай.

Задлахуй нь тэнгэрийн ааш аягад санаатайгаар нөлөөлөх хүний оюун санааны үйл ажиллагаа аж. Чингэхдээ, тэнгэрийн гарвалт буюу уул, уснаас олддог “задын чулуу”, малын гаралтай гэх үхэр, адууны гэдэс-цөснөөс олддог “гиван” /чулуу/, адгуус амьтнаас гаралтай буюу хандгай, тарваганы гэдэс, бор гөрөөс, барсын зүрх, хүдэр ба могойн тархи, гахайн толгой, гүрвэлийн сүүлнээс олдох “задын чулуу”, мөн шувуунаас гаралтай гэх /ангир нугасны толгойны, мөн ятууны гэдэснээс/ задын чулуу байдаг аж. Үүгээр ч үл барам загасны /тул, гутаараас гарна, хар цагаан өнгөтэй/ тархинаас задын чулууг гаргаж авдаг бөгөөд задын увидаст, зад барих ургамал /мэргэн гунж, алтан гагнуур, хунчир, заг, алтан харгана, сухай, яргай, хайлаас, хус/, зад барих хөөрөг /шүрэн, гартааман, цагаан, ногоон хаш, сүүжин хөөрөг/ болон голыг нь нүхэлж зассан чулуу зэрэг байгаль хийгээд ахуйн гаралтай зүйлсийг задын зэвсэг, хэрэглэгдэхүүн болгож ашигладаг ажээ⁸³.

Ийнхүү, задлахад дээр дурдсанчлан малын, зэрлэг амьтны, байгалийн, ахуйн гаралтай чулуу болон сумны зэв, өвс ургамал-мод бут, хөөрөг зэргийг хэрэглэдгээс гадна ардын дуу, түүний дотор уртын дуу хэрэглүүр болдог байсан нь судалгаагаар мэдэгдэв.

5.3.1 Задын дуу дуулж цаг агаартай дасан зохицох ёс

Эрт, эдүүгээгийн нүүдэлчин малчин монголчууд, бүс нутгийн эрс тэс уур амьсгал бүхий цаг агаартай сэтгэл зүйгээрээ дасан зохицох нэг арга нь уртын дуу дуулах зан үйл мөн аж. Бидний судалгааны явцад уртын дуу шүтлэгт үндэслэсэн цөөнгүй аман баримт, бодит өв өнөө цаг хүртэл оршин байгаа нь үүгээр мэдэгдэж байна. Энэ бүхний нэлээд хэсгээс тус тусын уламжлалт ёс, аргыг нь харгалзах

редактор Ц.Ишдорж. УБ., 1990 он. Тал 51.

⁸²Лувсанданзаны “Алтан товч”. Хэвлэлд бэлтгэсэн Ц.Шагдар, редактор Ц.Ишдорж. УБ., 1990 он. Тал 51.

⁸³Ю.Болдбаатар “Монгол нутаг дахь эртний нүүдэлчдийн задын шүтлэг”. УБ.,2008. Тал 46-49.

замаар дэд сэдэв өгч дараах байдлаар танилцуулахыг хичээв. Гэхдээ аль ч нутгийн хүрээнд дурдах дараах мэдээ баримтуудын ихэнх хувь нь зөвхөн өндөр настай уламжлалт уртын дуучдын ой санамжид үлдсэн байна. Зарим уртын дуу нь мартагдсан байна. Цөөнгүй дуу өнөө хэр дуулагдаж буй авч үндсэн зориулалтаар хэрэглэх дэг горим, цаг хугацаа, орон зайн нөхцөл боломж нь устжээ. Гэхдээ сэргээж болох боломж байгаа гэдэгт эргэлзэхгүй байна.

-Задын дуу "Иш гарьдын хур"

Хуучнаар Дөрвөд Далай ханы хошууны нутагт хамаагүй дуулах хориотой дуу буюу <<Задын дуу>> байсан нь өдгөө ч бидний үед уламжлагджээ. Энэ дууг "ИШ ГАРЬДААН ХУР" гэж нэрлэдэг. Ингээд дөрвөдийн алдарт зан үйлийн дуучин, монгол уртын дууны шилдэг өвлөн үалгамжлуулагч Т.Лхамжав гуайн яриаг товчлон сийрүүлэе: Т.Лхамжав гуайн ярианаас: <<Намар дуулдаг дуу гэж байсан үгүйг нь мэдэхгүй. Лавтай хавар дуулдаг "Иш гарьдаан хур" гэж нэг дуу бий. Хур дууддаг дуу. Ямар яриа байхав, яг л тэрийг дуулахаар хур ордог. Тэгээд л газар дэлхий дэлгэрдэг учиртай. Энэ дууг энгийн ч хүн дуулна, лам нар ч дуулна. Дээр үед хориотой дуу гээд дуулдаггүй байлаа. Яагаад хориотой гэхээр, энэ дууг дуулчихаар хур хэт их ордог. Хур дууддаг "Задын дуун" гэдэг юм. Мөн хур ороод тогтохгүй бол хариулдаг дуу гэж бас байсан юм гэнэ лээ шүү>> гэсэн билээ.



(67-р зураг. Увс аймгийн Түргэн сумын өндөр настан Торгоны Лхамжав.)

Дөрвөд нарын уртын дууны өв сан дотор хориотой дуу буюу <<Задын дуу>> гэж нэрлэдэг нэгэн дуу байгааг ингэж мэдсэн юм. Уг дууг хавар л дуулдаг, бусад улиралд дуулах хориотой аж. Мөн найр хуриманд ч дуулдахын цээрлэдэг уламжлал XX зууны дунд үе хүртэл байжээ. Энэ тухай Увс аймгийн Түргэн сумын өндөр настан Т.Лхамжав (1939 онд төрсөн) гуай хууч хөөрч, уг дууг дуулж судалгааны сан хөмрөгийг ийнхүү мялаасан билээ. Задын дууг хамаагүй дуулах хориотой байсан нь уг дуу цээрийн дууны нэг төрөлд ч багтаж байсныг илтгэж болно.

Давхар аятай⁸⁴ энэ дууны аялгуу нь өндөр хөгжсөн шуранхайн эртний хийц болох улин шуруулах, дээд эгшгээс уруудсан гулсалт /глессандо/-тай, эгшгийн хоорондын зай буюу интервал нь их хоёрц /их секунд/, бага гуравц /бага терц/, дөрөвц /кварт/, тавц /квинт/, зургаац /секст/ байх бөгөөд дууны аялгууг загварчлавал ерөнхий цараа нь нэгдүгээр наймцын /октавын/ до эгшгээс хоёрдугаар наймцын /октавын/ фа хүртэл тэлж байна. Иймээс энэ дууны аялгуу нь өрнийн хөгжмийн онолын талаас нь үзэхэд бэсрэг хэлбэртэй, зан үйлийн хэрэглээ талаасаа ойрадын айдам (арвангурван айдам), бас цээрийн уртын дууны төрөлд хамрагдах юм. Мөн таван эгшигтийн /пентатоник/ энгийн тогтолцоог хадгалжээ /энгийн тогтолцоо гэдэг нь эгшиг өргийн нэмэгдэлгүй, хөг сэлгээ буюу хөг хөрвүүлэг байхгүй, үндсэн таван эгшигтийн тогтонги зохион байгуулалттай/. Аялгууны ерөнхий зураглалыг нь төсөөлвөл уулынханы уртын дууны зонхилох хэлбэр гэгддэг орон зайн нам-дор түвшнээс уулын оройд хүчдэлт хөг эгшиглэгээний тэсрэлтээр хүрч, тэндээ хэсэг тогтон дуниарч уудам орон зайг эзэгнээд буцаж гулган бууж байна. Энэ нь Алтай чигийн урт дууны аялгууны нийтлэг хэв шинжийг илтгэнэ. Уртын дуучны хүчтэй тэсрэлттэй хоолойгоор эгшиг ойлгож цуурайтуулах, сөхөх, улин шургуулах, буулт хийж огцомдуу гусгах, дөрөвт(кварт)-ийн зайтай цохилт хийх г.м ур чадвар хадгалагдсан байна. Шүлэг нь дараах хувилбаруудтай байна. Үүнд:

Хувилбар №1⁸⁵

Ишээ гарь доон хур нь оо

⁸⁴Уртын дууны яруу найраг ихэвчлэн 4 шадаас 1 бадаг бүтдэг. Харин 1 бадаг буюу 4 шад шүлгийг хоёр хоёроор нь хуваан нэгэн аяар дуулахыг давхар аятай дуу гэж нэрлэдэг билээ. Нэг үгээр хэлбэл, 1 бадаг дуулахад үндсэн ая хоёр удаа давтагдана гэсэн үг.

⁸⁵Т.Лхамжав гуайн хэлж өгсөн үг.

Имэрэн түсэрч⁸⁶ ээ оруу нь ээ

Үүлэн-г-сөн зорчиодээ /үүлэнд зорчисон гэсэн санаа бололтой/

Үекэн ороод өнжөө үү вээ...

Мань гарьдаа хур нь

Манаран түсэрч орноо

Магдалж мордсон ах нар нь...

Хаш гарьдаа хур нь

Харлан түсэрч орно

Харинлаад мордсон ах нар нь

Харихаан уураад өнжив...

Хувилбар №2⁸⁷

Иш гарьдын хур нь

Имрэн түсрэн орно

Ирнээв гэсэн амраг

Ирэхээн уураад өнжив

Мань гарьдын хур нь

Манаран түсрэн орно

Магадлан ханилсан амраг

Ирэхээн өнжив

Хаш гарьдын хур

Харлан түсэрч орно

Хайрлан ханилсан амраг

Ирэхээн уураад өнжив...

Өтгөн дуутай хөхөө

Өдрийн турш донгодно

Өхөөрлөн ханилагсан амраг

Ирэхээн уураад өнжив.

⁸⁶Зүсэрч

⁸⁷“Урт сайхан хүрэн” (Увс аймгийн Сагил сум байгуулагдсаны 80 жилийн ойд зориулав). Эмхэтгэсэн И.Ганболд. УБ.,2005. Тал 26.

Шүлгийн хоёр хувилбарын ялгаа нь гэвэл Т.Лхамжав гуай 3 түрлэг буюу 3 бадаг хэлсэн бол, тухайн нутгийн зарим номод 4 бадаг тэмдэглэгдсэн байна. Нэгдүгээр хувилбарт зүсэрч задарч орсон их хур борооноор ах нар ньсаатаж байгаа бол, хоёрдугаар хувилбарт амраг хайрт нь саатах аж. Задын дуу нь өвөг монголчуудын тэнгэр шүтлэгийн зан үйлд уриа дуудлагаар хэрэглэгдэж байсан ул мөрөө хадгалж байгаа нь энэ аж. Малчин нүүдэлчин монголчуудын задын дуу нь эрс тэс уур амьсгалтай монгол нутгагт оюун санаагаараа дасан зохицох нэгэн хэрэглүүр байсаар иржээ.

-Задын дуу "Хүдрэн гарах үүл"

Архангай аймгийн Тариат орчимд 1924 оны үед нэгэн лам зад барьж "Хүдрэн гарах үүл" дууг дуулсан тухай ам дамжин яригдсаар байна. Уг дуу халхчуудын хүрээнд түгээмэл дэлгэрсэн байжээ. Тиймээс бага залуудаа Онгийн хийдийн унзад лам байсан, алдарт уртын дуучин, судлаач МУГЖ Жигзавын Дорждагва агсан нэг бадгийг дуулж үлдээсэн билээ.



(68-р зураг. Дундговь аймгийн Сайхан-овоо сумын Ж.Дорждагва, 1904-1991)

Энэ дууны нэг хувлбар нь "Дөрвөн улирал" нэртэй юм. Тодруулбал, Ж.Сүхбаатар, Ч.Мөнхтөр нарын эрхлэн хэвлүүлсэн "Говь нутгийн уртын дууны нэгэн гар бичмэл" номод "Дөрвөн улирал" нэрээр шүлэг нь нийтлэгджээ [2012. 48-49]. Үүнд:

Зээ: Хүдрэн гарагч үүлэн дундаас

Хүрхрэн байгч луугийн дуу

Хүсэж эргэдэг ч тэр тогос

Хөөрхий дурандаа бахтай лоо зээ

Хавар нь хаваржаандаа хагд нь халиураад

Харих шувууд нь хангинан донгодоод

Хамаг дэлхий дэлгэрэн хөхрөөд

Хаварын дохио л гэнэ зээ

Зун нь зунжаандаа зүлэг нь хөхрөөд

Зүйтэй сайхан солонго нь татаад

Зүстэй сонихон лянхуа нь дэлгэрээд

Зуны дохио л гэнэ зээ

Намар нь намаржаандаа навч нь дэлгэрээд

Нарийхан хонгор салхи нь салхилаад

Намигийн нь үзүүр найлзан хийсээд

Намрын дохиол гэнэ зээ

Өвөл нь өвөлжидөө өвс нь цайлзаад

Өндөр хангай нь будан татаад

Үүлний нь үзүүр үйлзэн хийсээд

Өвлийн дохиол гэнэ зээ

Ардайн байгч Алтай, Хангай

Аливаа амьтанд жимс намаг

Арга биш хүмүүний нутаг

Зуслан маань санагдав зээ

Өвөртөд байгч өргөн Хэрлэн

Өнгийн сайтар жимс намаг

Эрхбиш хүмүүний нутаг

Зуслан маань санагдав зээ

Түмэн наст богдын зарлиг

Төвшин сайдын гаргасан шүлэг

Түмнийхээ дунд шүлэглэн сууж

Төвшин сайхнаараа жаргая

(Энэ дөрвөн улирал).

5.3.2 Овоо тахилгын дуу дуулжцаг агаартай дасан зохицох ёс

Овоо тахилгад дуулдаг зан үйлийн уртын дуу монгол нутагт, угсаатны бүлэг тус бүрд арвин буй. Энэ тухай судлаач С.Дүүрэнжаргал "Монгол нутгийн тахилгат уул, ус" (2015) сэдэвт ном бичсэн билээ. Нутаг нутгийн томоохон уул хархад өөр өөрийн уртын дуутай байдаг. Жишээ нь Отгонтэнгэр хайрханы тахилгад "Оройн чимэг", Булган хангайн тахилгад "Их Булган хангай" дууг өргөдөг бол Бурхан халдунд "Эртний сайхан ерөөл"-ийг өргөдөг байсан болох нь улам тодорхой болж байгаа билээ. Маш эрт цагт нэр дурдагдсан зарим уртын дуу өнөө хэр хадгалагдаж, зан үйлийн ёс горим нь хүртэл аман хэлбэрээр үлдсэн байна. Түүний нэг жишээ бол Говь-Алтай аймгийн Төгрөг сумын нутагт уламжлагдсан хурын дуу юм.

-Хурын дуу "Өргөн үүл"

Одоогоос 100 хүрэхгүй жилийн өмнө энэ төрлийн уртын дууг дуулж, зан үйл гүцэтгэж байсан аман мэдээ олдov. Говь-Алтай аймгийн Төгрөг сумын малчин, уртын дууг өвлөн залгамжлуулагч Т. Цэвэл гуай энэ тухай дараах байдлаар дурссан юм. Үүнд: << Тэр хурын дуу! Яагаад хурын дуу гэж байгаан гэхдээр зэрэг намайг цэрэгт байх үед чинь лам, номтой улсуудыг жаахан гадуурхадаг. Нэг засгийн юутай

байлаа ш дээ. Лам нар чинь нэг дарамтанд байлаа ш дээ. Тэр үед энэ Ембүү лам ах гэж нэг хөгшин байсан. Тэр манай нутгийн көөн. Лам хүн! Тэгээд энэ Өгөөмөрийн эхний овоог тахиад тэр янзын гоё зун болсым гэнэлээ. Тэгээд тэр тахижаахад сүүлд нь хойшоо хараад зогсон энэ “Өргөн үүл”-ийг дуулжийм. Өнөөхийг манай нэг ангижав дооглоод гэрлүүгээ дуулж яваа байгаад хүрээд ирсэн чинь ээж нь: “Тэгэлгүй яахав хөөрхий. Овоо тахичихаад лусынхаа дууг дуулалгүй яахав” гэж байсан гэнэ. Лусын дуу гэж!. ...Энэ “Өргөн үүл”-ийг дуулж бороо оруулаад “Сэнсийн цагаан үүл”-ийг дуулж гийлгэж байсан юм гэнэлээ>>[М.Дорждагва. 2013. 240-249].



(69-р зураг. Говь-Алтай аймгийн Төгрөг сумын өндөр настан Туваанжавын Цэвэл)

Т.Цэвэл гуайн дуулж, хэлж өгсөн үг нь:

Өргөн үүл нь гарахад

Тогос шувуу баясана

Ойрхон энгэрт нь ээ суугаа

Оюун номин баясана

Хурын усаа буудах

Дэлхий ертөнц баясана

Хун галуу нь ирэхэд

Цэнгэж жаргана

Огторгуйн дээр.....

Ороо хураа

Орчлон мөнх боловч

Хөлбөрөх цаг түргэн

Цагаан хяруу буухад

Сэрүүсэхийн дохио болно оо

Цал буурал унахад

Өтлөхийн дохио болно оо

Нар буцахад

Намаршахын дохио болно

Нас өтөлсөхөд

Мөнх бусын дохио болно оо!

Бэсүд нарыг Атаа таван тэнгэр шүтэж ирснийг бид мэднэ. Тэгвэл тэд овоо тахиж байхдаа баруун хойд зүгт харж зогсоод(орчин цагийн баруун хойд зүг мөн ч угтаа зүүн хойд зүг аж. М.Д)“**Өргөн үүл**” хэмээх лус, хурын айзам уриа дуугаа ийнхүү дуулдаг байжээЭнэ нь бөөгийн шашны зүг чигийн онол дахь “нарт ертөнц” буюу “дунд тив”-д хур бороо буухыг урин залсан тэмдэг дохио мөн байлтай. Энэ аман баримтыг Говь-Алтай аймгийн Төгрөг сумын Бэсүд овогт Туваанжавын Цэвэл (1942 онд төрсөн)гуай тэмдэглүүлээд удаагүй байна. "Өргөн үүл" гэх дууг дуулж байна. . Харин

Тэнгэр хэт задгайрч бороо тогтохгүй бол "Сэнсийн цагаан үүл" гэдэг уртын дуу дуулдаг байж. "Сэнсийн цагаан үүл" дууны аялгуу нэлээд мартагдсан байна. Эдгээр дуунуудын зан үйлийг нь гүйцэлдүүлэлгүй маш уджээ.

Бас өнөөгийн Төв аймийн Сэргэлэн сумын өндөр настан, баянбараат уртын дууны өвлөн залгамжлуулагч Ц.Чунаг энэхүү "Өргөн үүл" дууг үлдээсэн билээ. Түүний аав Цэрэн энэ дууг гайхалтай сайхан дуулдаг байж гэнэ. Харин зан үйлийн үүрэг оролцооны талаар мэдээлэл хомч хоцорчээ. Тиймээс уг гарал нэг дуу учир мөн л өнөөгийн халх баргуудын өвөг дээдсийнх нь хурын дуу байсан биз ээ.



(70-р зураг. Төв аймгийн Сэргэлэн сумын Ц.Чунаг. 1929-2010 он)

-Лусын дуу "Уяхан замбуу тивийн нар"

Боржигинд "Уяхан замба тивийн наран" дууг өдөрт нэг л удаа дуулдаг дэгтэй аж. Тодруулбал, энэ дууг өдөрт нэгээс олон удаа дуулбал дуучин хүнд хүнддэнэ гэж үздэг. Өнөөгийн Дундговь аймгийн Дэрэн сум хавьд бороохур тасарч, ган гачиг учирвал "Уяхан замба тивийн нар"-ыг бүрэн эхээр нь дуулж хур дуудах тэмдэг дохио илгээж байна. Энэ мэдээ баримтыг Дэрэн сумын уугуул Гарамын Дадьсүрэн (1943 онд төрсөн) мэдээлсэн юм. Үүнээс гадна ган гачиг тохиолдвол овоон дээр гарч арц үнэртэн уугиулаад дуулдаг уламжлалтай, лусын дуу гэж өвөг дээдэс нь хэлдэг байжээ. Энэ уламжлалыг өнөөдөр Г.Дадьсүрэн гуай үргэлжлүүлсээр байна.



*(71-р зураг. Дундговь аймгийн Дэрэн сумын өндөр настан,
Соёлын гавъяат зүтгэлтэн Г.Дадьсүрэн)*

Халх хотгойдод “Уяхан замба тив” гэдэг дууг хошууны ноёны дуучин буюу төрийн дуучин хүн л дуулдаг байсан мэдээ бий. Тодруулбал, одоогийн Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сум, хуучин халхын Засагт хан аймгийн Эрдэнэ дүүрэгч вангийн хошууны төрт ёсны зан үйлд, уг нутгийн гарамгай дуучин Магсар “Уяхан замба тив”-ийг дуулдаг байсан нь домогшжээ. Энэ мэдээг Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын өндөр настан Дэмаажавын Пунцагдаржаа (Пунцагдаржаа 1917 онд төрсөн. Дууч Магсарын хүүхэд нь Лхамдуу, Лхамдуугийн охинтой Пунцагдаржаа ханилжээ. М.Д) тэмдэглүүлсэн юм.



(72-р зураг. Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын өндөр настан Д.Пунцагдаржаа. 2009 оны намар)

Энэхүү дууны шүлэг нь:
 Жаа, Энэ баяхан замбуу тивийн наран
 Илхэн дэлхий дээгүүрээ
 Гайхамшигтай дэлгэрч түгээд
 Мандан мандан мандагсаар л
 Жаа, байдаг билүү дээ та мину зээ
 Жаа, тэр лугаа адил
 Олон түмний минь өршөөл
 Үнэн сэтгэлтэй бүхнийг
 Ялгалгүй асарсаар л
 Жаа, байдаг билүү дээ та мину зээ
 Жаа, үүлэн чөлөөний наран мэт
 Өчүүхэн явах энэ насаа
 Үнэн мөнх дор барьж
 Үгүй муухайгаар хууртдаг
 Жаа, биш үү та мину зээ
 Жаа, идэр залуу цовоо сэргэлэн насандаа
 Эс сурсан эрдэм номыг
 Өтөлж харьсан хойноо
 Эргэж сурна гэдэг нь
 Жаа, бэрх биш үү та мину зээ.
 Хурай хурай хурай!.

5.4 Тэнгэр шүтлэг ба уртын дуу

Монголчууд Тэнгэр, түүний эздийн байрлах зүг чигт уртын дуу өргөж байгальтай сэтгэл зүйгээрээ дасан зохицдож аж. Энэ тухай мэдээ баримтууд өнөө хэр хадгалагдсан нь хээрийн судалгааны явцад мэдэгдэв.

5.4.1 Салхины эзэнд дуу өргөж цаг агаартай дасан зохицох ёс

Ахмад хөгжим судлаач доктор (Ph.D), профессор Д.Оюунцэцэг ""Монголчууд, Америк тивийн уугуул иргэдийн угсаа гарвалыг дуу хөгжмөөр мөшгөхүй" зохиолдоо Индеанчуудын Киова овгийн зан үйлийн дуу дотор "Wind Song" (Салхины дуу) байгааг мэдээлжээ [2018.42]. Тэгвэл тэдэнтэй эртний гарвал нэг байж болно гэж үздэг монголчуудын зан үйлийн уртын дуу дотор салхийг аргадаж дуулдаг нэгэн дуу байгааг бид илрүүлсэн юм.

-Салхи аргаддаг "Хуур магнай"

Тал нутаг буюу өнөөгийн Төв аймгийн Баян-Өнжүүл сум орчимд хурим нарын эхэнд "Хуур магнай" дууг баянбараат аялгуугаар 9 бадаг бүтнээр нь дуулдаг дэг байжээ. Уг нутгийн өндөр настан, уртын дуу өвлөн залгамжлуулагч Д.Ад-Зана гуай энэ тухай дараах байдлаар хэлж өгсөн юм. Үүнд: <<"Хуур магнай"-г дуулахад адуу урууддаггүй л гэж ярьдаг юм. ...Энэ хээрийн зэрлэг амьтан болохоор бас нэг өөр байдаг юм уу яад юм, одоо хэн мэдэхэв. Ардын дуунд ямар зохиосон ая байх биш. Тийм л нэг домог байдаг юм. Гэхдээ би ингэж боддог юмаа. Энэ найрлаж байгаа улсыг одоо "алив одоо өнөө хэдэн адуу салхи ,бороо, шороо юу болж байна. Уруудчих вий, яах вэ, ийх вий!" гэж сандруулахгүйн тулд одоо тайвшруулсан үг болов уу гэж боддог юм. Хоёрт гэвэл, нээрээ одоо найрлаж байгаа үед "заа, заа, заа одоо тэр гүүгээн тавьчих". Найраан яа (хийе), тэр адуу яах вэ уруудах биш" гэж байсан байж магадгүй. Адуу урууддаггүй л юм л даа. Манай нутгийн адуу уруудаад них хол явцан гэж л дуулддаггүй юм. Тийм л учиртай домогтой л юм байдаг юм>>гэсэн билээ.



(73-р зураг. Төв аймгийн Баян-Өнжүүл сумын өндөр настан Даваагийн Ад-Зана)

Одоогийн Төв аймгийн Баян-Өнжүүл сум орчимд “Хуур магнай” гэдэг дууг найрын эхэнд заавал дуулдаг дэг, ёс нь ийм учиртай аж. Ингэснээр аятай тухтай, удаан хугацаагаар найрлан жаргах нөхцөл бүрддэг. Тэдний “шуурганд адуугаа уруудуулахгүй” гэж уг дууг найр хуримын эхэнд бүрэн хэмжээгээр дуулдаг заншил нь энэ болой. Тодруулбал, “Хуур магнай” нь тал нутгийн “салхины эзэн тэнгэр”-ийг аргаддаг уриа дуу юмсанж. Үг нь:

Зээ, Хуур магнайн эгшгэнд

Хурсан бүгд даяараа

Ая түрлэгээ өргөж

Амар жаргалтай найрлая зээ

Зээ, Хэнтий ханы шилд нь

Халтар халиун буга

Намрын дунд сардаа

Нарийхан шингэнээр урамдана зээ

Зээ, Хангай ханы царманд нь

Хамаг өнгийн цэцэгс

Ишээ дүүрээд ганхах нь

Хавтай сонихончиг харагдана зээ

Зээ, Өгөөмөрийн өвөрт

Өнгө сайт замбага

Ишээ дүүрээд ганхах нь

Нээрэн зүйтэйчиг байдаг ло зээ

Зээ, Хилэн сайхан харыг

Хуртай тарган байхад

Хилхэн зантай чамайгаа

Хэнийгээ ч гэж мартах вэ зээ

Зээ, Алив хүслэн бүрдэгсэн

Амьтанаа туст хотол төгсгөсөн

Хуурын магнайг дуулж

Хувьтай сайхнаар жаргая зээ.

-Салхи догшируулдаг "Сэнсийн цагаан үүл"

Уг дуу халхчуудын хүрээнд өргөн дэлгэр хадгалагдаж байгаад XX зууны дунд үес мартагджээ. Энэ дууны зан үйлийн хэрэг үүрэг нь Өндөр Гэгээн Занабазарын цаг үед мэдэгдэж байгаа сурагтай. Мөн XX зууны эхэн өнөөгийн Говь-Алтай аймгийн Төгрөг сум орчимд салхи дэгдээж үүл задлан хөөж тэнгэр цэлмүүдэг ёс байсан нь дурсамж болон үлджээ. Энэ дууны үгийг Академич Х.Сампилдэндэв, К.Н.Яцковской нар "Монгол ардын уртын дуу" (1984) эмхэтгэл номын 149-өөс 150-р талд Архангайгаас олдсон 300 дууны бичмэл дэвтрээс татан оруулжээ. Үүнд:

Зээ Завсрын цагаан үүл нь

Суварган хэвтэй гарна

Захдаа салхи хүрэхүйд

Үелзэж тархана

Өргөн цагаан үүл нь

Өндөрзөж гарна

Үе үеийн салхинд

Үелзэж тархана

Таван өнгийн солонго
Огторгуй дүүртэл татна
Дэвэл болгон харахуна (харахад)
Түргэн зуур тархана
 Таван өнгийн цэцэг нь
 Талаа дүүрээд ургана
 Намрын цагаан хяруунд
 Хувирч одно
Бор талын богширго
Босон босон жиргэнэ
Бор тарал замдаа
 Шүүрээд очно
Эрлэг хааны яргачин
Түүн лүгээ адил
Түүгээр зүйрлэн санамаань
Ном буянаа хичээлтэй
 Жигүүртэйхэн эрвээхэй
 Харанхуй шөнийн зулыг
 Сайхан гэж хамсан
 Түүнд орж одов
Хөгшин залуу гэмтэн
Харанхуй шөнийн тамыг
Сайхан гэж хамсан
Түүнд орж одмуй
 Энэ дууг гаргагч
 Аралзавын гэгээн
 Амьтны тусад
 Шүлэг гэж дуулав.

5.4.2 Уулын савдагт уртын дуу өргөж шинэ гэрийг даатгах ёс

Нүүдэлчин монголчууд шинэ гэрийн бүрлэг хийж найр үүсгэхдээ уртын дуу дуулдаг заншилтай билээ. Нутаг нутаг ийм ёс өргөн дэлгэр буй. Гэвч яагаад шинэ гэрийн найр эхлэхэд уртын дууны нэр зааж дуулдаг тухайд тэр болгон тайлбарлах нь цөөн юм. Харин өнөөгийн Увс аймгийн элжигин халхчууд тэрхүү учир шалтгааныг өвөг дээдсээсээ уламжлан авчээ.

-Савдагийн дуу "Зээ Баян Хөхий"

Увс аймгийн Цагаан-Хайрхан сумын өндөр настан Г.Даваагомбо бидэнд олон уртын дуу залгамжлуулж байгаа бөгөөд зан үйлийн уртын дууны хэрэг үүргийг ч тайлбарлаж байна. Тэрээр "Зээ Баян Хөхий" дуу ямар учиртайг ийн тайлбарлав: "Энэ дуу болбол Хан Хөхий уулаа магтсан дуу юм. Тиймээс хөхөө шувуу, рашаан ус, цэцэг навч, ард түмэнтэй нь магтаж дуулсан дуу байдаг. Ялангуяа шинэ гэр бүрэхэд энэ дууг заавал дуулж Хан Хөхийн эзэн савдагт тэр шинэ гэрийг даатгаж, хүлээлгэж өгдөг учиртай. Гол утга учир нь үүнд оршдог юм" гэсэн билээ. Тэгвэл, "ЗээБаян Хөхий" дууг дуулдаг го учир нь тухайн шинэ гэрийг уул, усны эздэд даатгадаг дом шүтлэгийн бэлгэдэл юм. Монголчуудын энэ бэлгэдэл, үзэл санаа балар эрт цагаас нааш уртын дууны өв дотор нь хадгалагсаар XXI зуунтай золгосон байна.



(74-р зураг. Увс аймгийн Цагаанхайрхан сумын уртын дуу өвлөн залгамжлуулагч Г.Даваагомбо, О.Нямсүрэн, Ж.Жанчив нар)

Тухайн дууг Лу Жанжин Гүн Сэдбазарын Лувсандондов зохиосон ч гэж үзэх нь бий. Энэ дууны үг нь:

Зээ, Баян Хөхийн элэг дундаас

Бадрын рашаан ундарч

Учирсан хүртсэн бүгдийн

Өвчин түүтгэрийг арилгаж

Ашидын сайхны ерөөлөөр

Амар сайхан жаргатугай!

Зээ, Өнгийн олон цэцгэнд

Нүдний баясгалан ханаж

Үнэр сайтай арцанд

Хамрын бэрсүү арилаж

Хамаатан садан бүгдээрээ

Хамтран сууж найрлая

Зээ, Яруу дуутай шувуу нь

Чихний сонголыг баясгаж

Дэлгэж байгаа цэцэг шиг

Дэлхий даяар дэлгэртүгэй

Зээ, Балбарсан их жимс нь

Бал бурамын амтаар дүүрэн

Шимтэй зөөлөн жимсэнд нь

Дурлаад суух нь зохистой

Зээ, эдүгээ их насанд

Сэтгэлийн амгаланг эдэлж

Сэрүүн зөөлөн зүлгэнд

Тухлан суух жаргалтай!

Зээ, Одвоггүй их насандаа

Олон амьтдын тусын тулд

Оюун ухааныг тогтоож

Эцэс хойд төрөлдөө бурхан болох болтугай!

Зуны дэлхийн байдлаар

Бат дэлгэрч жаргатуйгай!
Жаргатугай!.

5.4.3 Долоон борын дуу дуулж Тэнгэртэй дасан зохицох ёс

Халхчууд дотор "долоон борын дуу" гэсэн зан үйлийн дууны тусгай багц байгааг илрүүлэн "Халх монголчуудын уртын дуу зан үйл" (2018) номод хэвлэсэн билээ. Харин тэрхүү мэдээ баримтад үндэслэн профессор А.Очир өөрийн өгүүлэлдээ чухал гаргалга хийснийг бид бичвэрийн эхэнд онцгойлон дурдсан. Долоон борын дууны багцад долоон бор морины сэдэвтэй 7 өөр дуу байж болох сэжим байгаагаас гадна нэг дуу дотор долоод бор морины тухай гарч байж болзошгүй байна. Ингэж үзвэл, догшин долоон Тэнгэрт борь морь сэтэрлэж тавихдаа 1 дуу дуулдаг байсан байж болно. Жишээ нь "Өндөр сайхан бор" дуунд долоон өөр морины тухай гардаг байжээ. Эсвэл 7 өөр бор морины дуу тус бүр дотроо 7 морь багтаасан байж ч болох мэт. Тэгвэл "Шарга агттан 8 морь" лугаа адил "Бор агттан 49 морь" энэ багцад багтдаг байсан юм биш биз.

-Хийморын дуу "Өндөр сайхан бор"

Долоон борын дууны гол цөм гэж бидний үзэж байгаа энэ дуу Завхан, Хөвсгөл аймгийн нутагт тархжээ. Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын малчин халх хотгойдын уртын дууг өвлөн залгамжлуулагч Дэмчигийн Цэрэнпэлдэр (1957 онд төрсөн) уг дууг ээжээсээ өвлөн авчээ. Тэрээр чухам уг дуу ямар учиртайг мартжээ. Харин хотгойдууд энэхүү дууг эрт цагт нэгэн хувилгаан зохиосон гэж үздэг билээ.



(75-р зураг. Д.Цэрэнпэлдэр. 2009 он)

Харин Завхан аймгийн Цагаанчулуут суманд энэ дуу эр хүний хийморын дуу гэх ухагдахуунаар өнөө хүртэл дуулагдаж байгааг судалгаагаар илрүүлсэн юм.

Уг нутгийн өндөр настан, харчин халхын уртын дууны өвлөн залгамжлуулагч Жамцын Равданжамц (1933 онд төрсөн) гуай сүлд дуу бол "Өндөр сайхан бор юм. Тэрээр яриахдаа: *"Манай нутагт "Өндөр сайхан бор" гэж эрхэмлэдэг дуу байсан. Өглөө эрт морь унаад, уулын толгойд нар тусч байхад "Өндөр сайхан бор"-ыг гурван бадаг дуулж байвал тэр хүний хийморь тэр өдөртөө сайн гэж үздэг. Энэ дуу 7 морины тухай дуу"* гэж мэдээлж, ханхайтал дуулж өгсөн юм.



(76-р зураг. Ж.Равданжамц. 2017 оны намар)

Тэрээр уг дууг дараах гурван бадгаар дуулав. Үүнд:

Өндөр сайхан бор оо

Өсөхийнхөө залимандарь (насан дор) сойно

Ам цагаан хулыгаа

Агсан сойж унана

Амрагийн жаахан хүүтэйгээ

Ханилан сууж жаргана

Хар сүүлт харыгаа

Хагсарган сойж унана

Хайртай хүүтэйгээ

Ханилан сууж жаргана...гэсэн билээ.

-Хүч цатгалан морины дуу "Хоёр бор"

Уг дуу ойрад, халх монголчуудад түгээмэл дэлгэрчээ. Тодруулбал, ойрадын торгууд, халхын сартуул, мөн өнөөгийн Хэнтий аймгийн Хэрлэн гол дагуух халхчууд дуулсаар байна. Нутаг нутагт чухам ямар зан үйлээн ороцоотой байсан нь мартагджээ. Халх сартуул нар:

Хоёр борыг тарганд нь

Намаржин сойж уналаа

Хоёр ноёны найранд нь

Намаржин сууж найрлалаа... гэдэг бол ойрадын торгууд нар:

Хоёр борын тарганыг яана билээ

Ховог сайрын арвиныг яана билээ

Дөрвөн нутгийн унага нь

Дөмүүхэн сайхан морь билээ дээ

Дөтхөн зантай түүнийхээ

Мэнд сайныг нь дуулаад буцна даа.. г.м үгээр дуулж байна.

-Энэрэл хайрын дуу "Сэвхэт бор"

Уг дуу баруун халхчуудаас дэлгэрч түгээмэл дуулагддаг билээ. Чухам долоон борын дууны багцад ордог байсан эсэх нь одоогоор баримтаар мэдэгдээгүй байна. Гэхдээ дороон бор дууны багцын тухай мэдээ хадгалагдаж буй баруун халхчуудад хамгийн түгээмэл дуулагддаг билээ. Үг нь:

Сэвхэт борыгоо унаарай

Сэтгэл нь байвал эргээрэй

Толбот борыгоо унаарай

Тоотой хоногтоо ирээрэй

Уулын толгой нартай байна

Учирсан намайгаа санаарай

Хөндий дунд манантай байна

Хөөрхий наддаа ирээрэй... гэж дуулдаг болой.

5.4.4 Төрийн дууны овоо шүтэж Тэнгэртэй дасан зохицох ёс

Монголчуудын овоо шүтлэгийн ёс гүн гүнзгий билээ. Тиймээс шашин шүтлэгийн зан үйлд зориулсан олон төрлийн овоо буй. Түүний нэг төрөл нь уртын дууны овоо ажээ. Халх монголчуудад энэ төрлийн овоо байсан тухай аман мэдээ олон дуулддаг боловч бодитоор уламжлагдсан нь одоогоор мэдэгдэхгүй байна. Харин ойрад монголчуудын салбар болох, Хавт Хасарын удмын дээд монголчуудад уг овоо өнөө болтол хадгалагдаж байгааг судалгаагаар илрүүлж мэдэв.

-Хавт Хасарынхны төрийн дууны овоо

Гималай нурууны бүс нутаг, Хатан голын эхэн урсгалд эрт цагаас амьдарсан дээд монгол (хошууд)-чууд хуучны нэгэн шүтлэгээ хадгалж байгаа нь хээрийн судалгааны явцад мэдэгдэв. Тэд уг шүтлэгээ "Төрийн дууны овоо" гэж нэрлэдэг. Дээд монголчууд энэхүү овоо шүтлэгийн төрлийг чухам хэдий үеэс эхэлсэн, ямар утга учиртай болохыг дэлгэрэнгүй тайлбарлаж мэдэхгүй ч дараах зүйлийг дурдаж байна. Энэ тухайн тэдний алдарт уртын дуучин Говь мэдээлсэн юм. Тэрээр: "Энэ овоондоо өдрийн сайныг сонгон мөргөж, идээ цагаагаа өргөж уртын дуу дуулдаг. Гаднаас очсон зочноор төрийн дуу дуулуулж овоогоо баясгадаг" гэх аж. Тиймээс судлаач, дуучин миний биеэр "Эртний сайхан"-ыг дуулуулахыг хүссэн тул ёсоор болгосон юм.



(77-р зураг. Дээд монголчуудын алдарт уртын дуучин Говь. 2017 он)



(78-р зураг. Дээд монголчуудын төрийн дууны овоо. 2017 он)

Тэдний төрийн дууны өв сан нь дараах байдалтай байна. Уг төрөл нь дээд монголчуудын сурвалжит удмаас улбаалсан нэлээд эртний дууны уламжлал бололтой. Тодруулбал, энэ төрлийн дууг төрийн өндөр зиндааныхан буюу ноёд, тайжуудын ёс, заншил, зан үйлийн орчинд дуулдаг байжээ. Харин одоо тэд төрийн дуугаа нутаг хошуу хамарсан томоохон төрт ёсны хурим найр, наадмын заншил, зан үйлийн эхлэл хэсэгт дуулж байна. Энэ төрлийн уртын дуу нийт монголчуудад түгээмэл дэлгэрч байсан нь судалгаанаас мэдэгддэг. Жишээ нь, Монгол Улсын Төв, Дундговь, Хэнтий, Дорноговь аймгийг дамнан суудаг боржигин халхчуудад “Төрийн дөрвөн дуу” байдаг. Түүнд “Хуур магнай”, “Түмний эх”, “Тэгш таван хүсэл”, “Уяхан замбуу тивийн нар” гэдэг дуунууд багтдаг. Халхын бусад угсаануудад энэ төрлийн дуу XX зууны 30-аас 40-өөд он хүртэл түгээмэл байсны ихэнхи нь сураг төдий бүдгэрсэн билээ. Харин дээд монголчуудын Төрийн дуунд “Тэнгэртэй адил”, “Эзэн хааны дэргэд”, “Өргөн их дэлхий”, “Тэнгэр хүмүүн”, “Тэнгэрийн наагуур татсан” гэдэг 5 уртын дуу багтаж байгаа нь энэ удаагийн судалгаагаар мэдэгдэв. Дээд монголчууд Төрийн таван дууныхаа аль нэгийг бүрэн дуулж өндөрлөхдөө зонхилон “Төр түвшин болтхай” гэдэг үгтэй түрлэгээр жаргааж байна.

5.5 Сүнс шүтлэг ба уртын дуу

Монголчуудын зан үйлийн уртын дууны үндэс нь балар эртний дом шившлэг, шүтлэг зэргээс үүдэлтэй гэж үзэж байгаа билээ. Тиймээс олон мянган жилийн турш байгалийн нэг орчин, ахуйн нөхцөлд тасралтгүй амьдарч байгаа нүүдэлчин монголчуудын зан үйлийн уртын дуу дотор сүнс шүтлэг (анамизм)-ийн ул мөр үлджээ.

5.5.1 Сүнс аргаддаг сангийн дуу "Хан уулын орой"

Өнөөгийн Ховд аймгийн Чандмань сумын нутагт ХХ зууны дунд үе хүртэл нэгэн домын ёс байжээ. Тэр дом бол уртын дуу дуулж өөрийн бие, сүнсээ тайвшруулан аргаддаг үйл аж. Энэ тухай уг сумын өндөр настан, барууну халхын уртын дуу өвлөн залгамжлуулагч Дүгэрийн Даржаа гуай юм. Түүний яриаг сийрүүлбэл: "Хөдөө хээр үдэш орой ганцаараа явж байгаад айж цочих үе их гардаг шүү дээ. Яг тэгсэн үед мориноороо бугаад аргал хомоолоор тойруулж уугиулаад "Хан уулын орой" гэдэг дууг дуулдаг гэж настайчууд хуучилдаг байсан юм" гэсэн мэдээ өгсөн юм.



(79-р зураг. Ховд аймгийн Чандмань сумын өндөр настан Д.Даржаа)

Энэ дуу монгол туургатны хэмжээнд өргөн тархсан нь судалгаагаар мэдэгддэг. Халх, ойрад монголчуудад "Хан уул", "Хан уулын орой", "Хутаг уул", бас "Богд нь уулын сүндэл" (сэндэм), "Богд уул", "Утаа сангийн орой" г.м нэрээр өргөн дэлгэсэн

бөгөөд ихэнхи нутагт "сангийн дуу" гэж үздэг юм. Өвөр монголын Ордос, Алашаа орчимд "Мони уулын орой", Шилийн гол орчимд "Хан уулын орой" г.м нэрээр тархжээ. Дээр дурдсан нэрнүүд нэг дуу болохыг тухайн дуунуудын шүлгийн утга, аялгууны бүтэц, зохиомжоос тодорхой мэдэж болно. Шүлэг нь:

Хан уулын оройд

Сангийн утаа манарна

Хашийн их дуганд

Зулын гэрэл тодорно

Алдалж барьсан хээ юу чинь

Алдын шар сүмүү дээ ээн

Аюул нүглээн арилгасан

Манай Богдын гэгээ

Хээлэж барьсан кээ юу чинь

Хийдийн шароо л сүмүү дээ

Хэлэнцэнг нүглээг арилгасан

Манай Богдын гэгээ

Сайн ламын шавь нар нь дээ

Найман усын гүцүүдээ /гүйцүүдээ/

Нарийн шар бийрээр

Номчийн цолыг олвуу даа

Сайн сайдын шавь нар нь дээ

Есөн ноосын гүцүүдээ /?/

Бийр янты нь баривал ч ээ

Бичээчийг цолыг олов уу доо

Хун цэнгийн дэгэдээхэй

Өд сөдөө гүйцүүчээг

Гадаад далайг гатлуу чиг

Жигүүртэн цолыг олов уу доо

Хулан тахийн унаган доо

Хумас туурай нь гүцүүвчээн /?/

Гурван говий нь гатлуучээ
 Хурданы шинийг бүрдүүлвээ
 Найрын чинээ сайхан чинь
 Архи дороос хоёрүүдээ /?/
 Наадмын чинь ээ сайхан чинь ээ
 Шагай, шатар хоёр үү дээ ээн
 Баруун гурван говиороо
 Бардамхан хулаараа туулана даа ээ
 Банчин далай лам нараасаа
 Бараалхаж нэг асуугаарай
 Өршөөтугай! (түрлэг).

5.5.2 Хиймор, сүнс доройтоход дуулдаг “Тэнгэрийн агаар”

Чандмань сумын Дүгэрийн Даржаа гуай бас нэг сонин мэдээ дуулгасан нь "Тэнгэрийн агаар" хэмээх уртын дууны тухай юм. Уг дууг хиймор сүлд нь доройтсон хүнд дуулж өгдөм домын ёс байсан гэнэ. Бас дашрамд дурдахад Арь гэгээн гэдэг хүн "Гүрвэн гүрэм" буусан айлд "Бор борын бялзуухай" гэдэг дууг дуулуулдаг байжээ. Арь гэгээн уртын дуучнаа дагуулаад явж байдаг байж гэнэ. Даржаа гуайн аав Дүгэрийг бага байхад нь Арь гэгээн нэгэн удаа сонгож дагуулан явж байсан тухай тэрээр дурссан юм. Даржаа гуайн хэлж өгсөн "Тэнгэрийн агаар"-ын шүлэг:

Тэнгэрийн агаарээ татгэсэн ай
 Тиймээ гоёхон ээ ла солонгоо
 Тэгшээ маныхоо нүдэн дор мэнэ
 Юутай гоёхон өнгө вэ гээ
 Уран төвдий мэнэ ээ
 Бүтээгсэн улоон шаргал аа хүж ээ
 Ухаан кийморийг мэнэ ээ сэргээсэн ай оо
 Юутай гоёхон ла үнэр вэ ээ
 Бээжэн хотынхоо хэв торго чинь ээ

Өнгөө өнгөндөө ла намирсан ай

Ямар гоёхон өнгө вэ ээ...

Хурцын өндөр уулан мэнэ ээ

Хурьгасан олон хөхид чинь

Өмнө хойноосоо ховшгэсэн?!/

Юутай гоёхон ээ дуу вэ гээ

Балган балган ай амталсан ай

Балоо бурмы минь ээ ла амтайхан ай

Юутай гоёхон ай амт вэ ээ

Шимэн шимэн ла амталсан

Чихэр бурмы мэнэ ээ амттайхан ээ

Ямар гоёхон амт вэ ээ гээ

Далай ламээнкоо айлдуурийгээ

Даяараа хамтдаа ла жаргатугай...тэгээд түрлэг нь" жаргатугай".

Энэ дуу ч "Хан уулын орой"-гийн адил өргөн тархжээ. Уг хоёр дуу ихэвчлэн шасдир уртын дууны урын сан дотор багтан яригддаг.

5.6 Дөрвөн улирал ба уртын дуу

Нүүдэлчин малчин монголчууд уул ус, нутаг бэлчээрээ эзэнтэй гэж үзээд тэднийг аргадаж, бас уур амьсгал, улирал цаг агаарт оюун санаагаараа дасан зохицох тогтсон ойлголттой байжээ. Энэ уламжлалт үзэл баримтлалд зан үйлийн уртын дууны өв чухал үүрэг гүйцэтгэдэг байсан нь сүүлийн үеийн судалгаагаар мэдэгдэж байна.

5.6.1 Дөрвөн улиралд зохицуулан уртын дуу дуулах ёс

Энэ тухай олон баримт буй бөгөөд бид "Ойрад монголчуудын уртын дуу, зан үйл, өвлөгчид" (2016), "Халх монголчуудын уртын дуу, зан үйл" (2018) номод тус тус хэвлэсэн юм. Ойрад монголчууд хаврын сүүл сар, зуны эхэнд сард найрлахдаа уртын дууг заавал бүрэн гүйцэд дуулахыг эрхэмлэдэг ажээ. Харин буцаж яваа цаг

буюу намрын сүүл, өвлийн эхэн үед ямар ч дууг гүйцээн дуулж болдоггүй, ган нэг бадаг дутуу орхидог дэгтэй. Учир нь урин дулаан, дэлгэр сайхан цагийг урт хугацаагаар үргэлжлэхийн бэлгэдэл болгож зан үйлийн уртын дуугаа заавал бүрэн гүйцэд дуулдаг бол хахир хатуу цаг улирлыг богино хугацаанд үргэлжлэхийг бэлгэдэж дутуу дуулж охидог байна. Үүнээс гадна хаваржаа, намаржаа, өвөлжөө, зуслангийн уул, ус, бэлчээр нутгаа зориудаар магтан дуулдаг уртын дуу ч бас байна.

5.6.2 Бэлчээрээ магтан аргадах дуу

"Сэрүүн сайхан хангай"

"Сэрүүн сайхан хангай" гэх дуу халхчуудын арван гурван айзам дуунд зүй ёсоор багтдаг билээ. Тиймээс маш өргөн тархалттай юм. Харин Завхан аймгийн Цагаанчулуут сумын өндөр настан Ж.Равданжавм гуай энэ дууны зан үйл, бэлгэдлийн талаар тайлбарлаж байна. Тэрээр: *"Энэ дуу бол нутаг орон, уул ус бэлчээрээ магтсан дуу юм. Миний дуулах дуртай дууны нэг. харин залуучууд сурч дуулахгүй байна"* гээд хэнхийтэл дуулж өгч судалгааны сан хөмрөг мялаасан билээ. Түүний дуулж, хэлж өгсөн үг нь:

Сэрүүн сайн хангай нь

Тунгалаг маань рашаантай хангай

Миний лаа борлог чинь

Магнай дундаа сартай.

Өвөлдөө өргөн түмэндээ

Өвөр дээрээ өвөлжөөтэй хангай

Хамаг олондоо

Хажуу дээрээ хаваржаатай хангай

Зулай дээрээ

Дуун түмэндээ зуслантай хангай

Нахиу тал дээрээ

Найман түмэндээ анмаржаатай хангай

Орой дээрээ

Олон түмэндээ овоотой хангай.

5.6.3 Намрын төгсгөлд дуулдаггүй "Өвгөн шувуу хоёр"

Халх сартуулууд уг дууг түгээмэл дуулдаг бөгөөд найрын эхэнд "Хуур магнай"-г дуулдаг байснаа ХХ зууны дунд үеэс хойш "Өвгөн шувуу хоёр"-ыг дуулдаг заншил тогтжээ. Эрдэнэ-Хайрхан сумын уугуул Ц.Бамбадорж гуай: *"Өвгөн шувуу хоёрыг намар орой дуулдаггүй гэж цээрлэдэг. Яагаав вэ гэхээр буцаж буй шувууд нас авч явдаг гэж хөгшчүүл хэлдэг байсан. Харин хавар усны шувууд ирэх үеэр угтаж дуулах нь сайн бэлгэдэл гэж үздэг байв"* гэж хэлээд, дуулж судалгааны хөмрөг мялаасан юм.



(80-р зураг. Ц.Бамбадорж. 1939 онд төрсөн)

Энэ дуу нийт монголчуудад өргөн тархсан байдаг. Ойрад монголчууд "Лам шувуу" нэрээр дуулж байгаад мартсан бол халхчууд "Жаргалтайн дэлгэр", "Өвгөн шувуу хоёр", "Хөх өндөрийн өвгөн шуу", өвөрмонголчууд "Өвгөн шувуу" нэрээр дуулдаг билээ. Уг дуу өвгөн, шувуу хоёрын харилцаа юм. Тиймээс өвгөний ая, шувууны ая гэсэн хоёр ханагар том аятай. Тэр нь өнөө үед уламжлагдсан билээ. Нийт гучин хоёр бадагтай. Халхчуудын гучинхоёр шасдир дууны урын санд зүй ёсоор багтдаг. Энэ дууг таслалгүй бүрэн гүйцэд дуулахад 3 цаг орчим хцгацаа шаардагддаг юм.

5.6.4 Намар цагт найр эхлүүлдэг "Тэнгэрийн агаар"

Уг дуу халхчуудад өргөн дэлгэр, харин ойрадын мянгадад бас тархжээ. Мянгадууд: "Намар цагт аливаа найр хийхдээ "Тэнгэрийн агаар" гэдэг дуугаар эхэлдэг бол, **зуны цагт найр хийхдээ "Зуны дэлгэр"**-ээр эхлэнэ" гэж үздэг билээ. Харин зуны цагт найр эхэлдэг "Зуны дэлгэр" гэх дуугаа мянгадууд мартжээ. Энэ

тухай өнөөгийн Ховд аймгийн Мянгад сумын өндөр настан Дарьжавын Түвшин гуай хуучилж,дуулж өгөв.



(81-р зураг. Д.Түвшин. 2017 он)

"Тэнгэрийн агаар"-ын мянгад хувилбарын шүлэг нь:

Тэнгэрийн агаарт татсан

Юуны сайхан солонго вэ

Тэгшийн магнай дэлгэрсэн

Юуны сайхан өнгө вэ

Хурцын өндөр ууланд

Хурсан сайхан хөхөө гэнэ

Өмнө хойноо донгодсон

Юуны сайхан хөхөө вэ

Ургамалын сайнаар бүтээсэн

Улаан шар хүж

Үнэр түүндээ зохисон

Юуны сайхан үнэр вэ

Цэцгийн сайнаар бүтээсэн

Шар улаан хүж

Үнэр түүндээ зохисон

Юуны сайхан үнэр вэ

Бага багаар амсахад

Бал бурмын амттай

Шимэн шимэн амсахад

Шихэр бурмын амттай.

Өнгө сайтай хэв торго

Өнгө өнгөөрөө намилзана

Өнгө түүндээ зохисон

Юуны сайхан өнгөн бэ.

5.7 Мал сүрэг, ан ав ба уртын дуу

Монголчууд таван хошуу малаа магтан дуулахаас гадна аргадан тайтгаруулах зан үйлд уртын дуугаа дуулсаар иржээ. Мөн ав гөрөөсийг дуурайн дугардаг мөртлөө уртын дуугаар урин дуудаж байжээ. Энэ тухай цөөнгүй аман баримт үлджээ.

5.7.1 Ботго авахуулахад дуулдаг "Өнчин цагаан ботго"

Энэ дуу монгол туургатанд өргөн дэлгэрсэн юм. Халхчуудад хэд хэдэн хувилбар аяар, буриадуудад "Өнчин цагаан ботго" нэрээр, өвөр монголчуудад "ирвэс цагаан ботго" нэрээр, харин Хөх нуурын дээд монголчуудад "Өнчин цагаан ботго" нэртэй дуу, морин хуурын татлага байсан нь 1950-иад оноош хойш мартагджээ.

Дээд монголчууд ингэн тэмээнд ботго авахуулахдаа "Өнчин цагаан ботго" дууг дуулж, икэл хуураараа хуурддаг зан үйлтэй байсан тухай тэдний нэртэй ахмад дуучин Жинхуйр мэдээлсэн юм.



(82-р зураг. Дээд монголчуудын уртын дууны нэрт төлөөлөгч, Жинхуйр ээж. 2017 он)

Энэ дуу дээд монголчуудад зан үйлтэйгээ хамт мартагдсан ч нийт монголчуудад өргөн дэлгэр дуулагдаж байна. Гэвч нийтдээ мөн л зан үйлийг нь мартан бүдгэрүүлжээ.

Уг дууг өнөөгийн Завхан аймгийн Ургамал сумын Хулж багийн малчин, баруун халхын алдарт уртын дуучин "онгой" хочит Адъяа гайхалтай дуулдаг байсан нь домогшин үлджээ. Увс, Завхан аймгийн халхчууд тэр тухай дурсан ярьж байна. Жишээлбэл, *"Онгой Адъяа гуайг "Өнчин цагаан ботго"дуулахаар гэрт хүмүүс багтахгүй хаалгаар цувалдана. Гадаа усны шувууд зэллэж суугаад ганганалддаг байсан гэж хөгшчүүл шагшран хэлдэг байв. Дуулаад эхлэхээр нь ширмэн тогоо ханхийгээд явчихдаг байсан гэдэг"* гэж түүнийг өндөр настай болсон байхад нь хүүхэд байсан шавь өдгөө 84 нас сүүдэртэй Д.Цэрэнхүү хуучилж, дуулж судалгааны хөмрөг мялаасан билээ.



(83-р зураг. Завхан аймгийн Ургамал сумын өндөр настан Дагвын Цэрэнхүү.

1936 онд төрсөн)

Тухайн дууны шүлэг нь:

Өнчин цагаан ботго нь

Өлсөхийн эрхэнд буйлна

Өл халзан ээжийгээ

Санахын эрхэнд буйлна

(Өл буурал хангайгаа

Ширтэн байж буйлна)

Ар шилний минь зогдор

Ургасан ч болоосой

Ар хангайн давааг

Алхуулсхийгээд давахсан

Өвдөг, шилбэний минь зогдор

Ургасан ч болоосой

Өвөр хангайн давааг

Өгсүүлсхийгээд давахсан... г.м нийт 20 орчим бадаг бий.

5.7.2 Бух догиоход дуулдаг "Нарийн саарал морь"

"Цагаан мод цохих", "Цүү хаях", "Бух догиох ёс" г.м нэн эртний уламжлалт нэршилтэй энэхүү зан үйл монголчуудад өргөн дэлгэр байсан нь өнөө цагт мартагдан бүдгэрсэн билээ. Тэгвэл, өнөөгийн Ховд аймгийн Мөнххайрхан сумын урианхай нарын ой санамж, зан үйлийн уртын дууны өв дотор уг ёс хадгалагдаж байна. Харин зан үйлийг гүйцэлдүүлэх арга хэмжээ тасраад уджээ.

Мөнххайрхан сумын өндөр настан, ойрадын уртын дууны нэрт өвлөн залгамжлагч С.Бүрнээ гуай тайлбарлан, дуулж өгсөн билээ. Тэрээр: *Манай урианхайчуудын дунд мартагдаж яваа нэгэн сайхан ёс байдаг. Үүнийг "Цагаан мод хаях" гэж нэрлэдэг. Бас "Бух догиох" ч гэж хэлдэг. Энэ бол нэгэн төрлийн тоглоом наадгай юм. Гэнэт нэг шөнө залуучууд мод булаацалдаж, шуугилдаж гүйлдэхдээ гол нь биш. Энэ тоглоомын ёсыг эрт цагт манай нутаг хошууны хөгшчүүд бүр зориудаар зохион байгуулдаг байсан байгаа юм. Яагаад вэ гэхээр, сарлагийн үнээ хээл авах нь жаахан удааширдаг жил байдаг. Нөгөө талаас, сарлагийн нас бие гүйцсэн бух цөөрдөгтэй холбоотой. Тийм болохоор залуу бух үнээн дээр "харайх" туршлага дутуу байдаг бололтой юм билээ. Тэгэхээр, гэнэт шөнө дунд хүмүүс хашгирч шуугихаар угаасаа сагсуу, хөөрүү төрлийн мал болох сарлагийн бухны зан ааш нь хөдөлдөг аж. Нэг үгээр хэлбэл, сарлагийн бухны сэтгэл нь хөдөлж байна гэсэн үг. Түүнийг сэрээж, сэрлийг нь хөдөлгөж байна гэсэн үг. Тэр сэтгэл*

хөдлөлдөө автаж үнээнүүдийг шуурхай хээлтүүлдэг юм байна л даа. Үндсэндээ бол, энэ нь малыг хээл авахуулах ёс юм.

Эхлээд зар тараадаг байжээ. Ингээд голын хөвөөн дээр гал асаагаад, хүмүүс гэр гэрээсээ архи дарс, тавагтай идээгээ авч ирээд, хөгшчүүд найрлаж суугаад, залуучууд нь тэр цагаан модоо хаяж хөгжилддөг. Шөнөөр хаясан тэр цагаан модыг олж авсан хүн найрлаж байгаа хөгшчүүд дээр хэнд ч баригдахгүй түрүүлж ирэх ёстой. Гэхдээ мод авсан хүн "Цагаан мод нь над!" гэж хэлчихээд зугтдаг. Тэгэхээр түүнийг бусад нь барьж авах гэж хөөцөлдөж, шуугилдаж элдвийн юм болно. "Тунгалаг тамир" кино дээр Итгэлт баян "аятайхан биетэй дамшиг" гэдэг шиг юм бас болно, тэнд. Ингээд хөгшчүүл минь "Цагаан модны дуу" гэж **"Нарийн саарал морин"** гэдэг дуугаа дуулдаг юм" гэж тэмдэглүүлсэн юм.



(84-р зураг. Урианхай овогт Сүрэнгийн Бүрнээ. 2016 он)

Энэхүү өвөрмөц заншлын уртын дууны үг нь:

Нарийн саарал морь нь

Говилтой тарган байна л

Насан болгосон ээждээ

Намрын сардаа золгоно

Хар саарал морь нь

Хавтай тарган байна л

Хар буурал ээждээ

Хаврын сардаа золгоно

Гурван жингийн харгай нь

Гуравхан болоод тоотой

Гуравхан хэлэгсэн үг чинь

Зүрхий эхэнд уялга⁸⁸.

Довон дээр нь гарахаар
 Довтлуулахын дур хүрнээ
 Дотоод хормой салбархаар
 Ээж минь санагдана

Хамар дээр нь гарахаар
 Хатируулахын дур нь хүрнээ
 Ханцуй, тохой элэгдэхээр

Ээж минь санагдана...юм. Уг дуу ойрад монголчуудад түгээмэл тархсан байна. Харин урианхайчуудад ийнхүү өвөрмөц ёс горимийн хэрэглүүр болдог ажээ.

5.7.3 Анчны дуу "Илийн шар тохой"

Нүүдэлчин, малчин, анчин монголчуудад ан авын сэдэвт уртын дуу цөөнгүй билээ. Жишээ нь, "Шалзат баахан шарга" (багахан) хэмээх эмгэнэл бүхий домогт дууг бид сайн мэддэг. Тэгвэл нутаг нутагт ийм сэдэвтэй дуу түгээмэл байжээ. Уг сэдвийг хадгалсан уртын дуу нь цээрийн дууны төрөлд багтдаг учир мартагдах эрсдэл өндөртэй байж. Тиймээс ая дан нь ихээхэн бүдгэрчээ.

Дөрвөдийн уртын дууны алдарт төлөөлөгч, өвлөн залгамжлуулагч Салхин овгийн Торгоны Лхамжав гуай маань бас нэгэн дууны тухай мэдээлсэн билээ. Тэрээр: *"Миний багад "Илийн шар тохой" гэж дуу анчин хүн дуулдаг гэлцдэг байсан юм. Би ан гөрөө хийдэггүй болохоороо дуулах гэж сонирхдоггүй байлаа. Одоо бодохнээ тэр нээрээ л анчин хүний дуу, эс гэвэл дутуу агнаад тэр шархадсан амьтанаа өрөвдөөд дуулсан байж болно. "Илийн шар тохой" гэж одоо манай нутагт байдаг юм л даа. Тэр их лут, хамаагүй хүн орж болдоггүй Түрэгний хавцал дотор байдаг. Тэгээд:*

*Илийн шар тохойд
 Ишигтэй марал идээшилнэ
 Иламгаа шиг зантай чамтайгаа
 Ирээд ирээд найрлана аа
 Шагшигийн шар тохойд*

⁸⁸Арван жин хүртэл дуулна.

Шархтай марал нь идээшилнэ

Шалмаг зантай чамтайгаа

Сэтгэлээрээ мордоод найрлана” гэж учир шалтгаан, үг шүлгийг нь хэлж өгсөн юм.

5.7.4 Буга дууддаг "Урьхан хонгор салхи"

Монголчууд уртын дууг ан авын уриа дуудлагад хэрэглэдэг байжээ. Лавтай XIX-XX зууны эхэн үед энэ ёс бодитоор оршиж байжээ. Энэ тухай Завхан аймгийн Эрдэнэ-Хайрхан сумын өндөр настан, Тайж овогт Ц.Бамбадорж гуай дурсан ярьж, халх сартуул аялгуугаар дуулж өгч судалгааны сан хөмрөгийг мялаав.

Түүний яриаг сийрүүлбэл: *"Манай нутагт Халтар, Гэндэн гэж ах дүү хоёр анчин байсан гэдэг. Тэр хоёр хүнтэй явдаггүй, хоёулхнаа явдаг. Яагаад ингэдэг юм бэ? Гэхээр "Та нар шуугиад л, дарвиад л, янз бүрийн шунаг сувдаг яриа хөөрөө хийгээд замбараа байхгүй шүү дээ" гээд хоёулханаа явчихдаг байж. Тэгээд яаж ан хийдэг юм бэ? гэхээр дуугай морио бөхөлчихөөд сууж бай! гээд модны ёроолд очоод "Урьхан хонгор" гэдэг дууг дуулсан гэнэ. Тэгсэн модон дотроос буга согоо цуваад гараад ирж гэнэ. Тэгээд "дуртайгаа бууд, нэг л хэрэгтэй. Би ингэж ан хийдэг юм. Хангай надад ингэж өгдөг юм. Та нар бол хашгирч гуугачаад, бодол яриа хоёр замбараа алга! Явж байгаа явдал чинь ч хэрэг алга. Хангайн амьтан үргээгээд хөөчих юм" гэж байсан аж. Нутаг нь бол Эрдэнэ-Хайрханаас наашаа Хар, Шар Ямаат, цаад тал нь Хаг нуур, хойшихноо болохоор Тээл тийшээ нутагладаг байжээ. Тэгэхээр "Халтар, Гэндэн хоёр өөр юм байна" гэдэг яриа гарч байсан гэж хөгшчүүл хөөрөлддөг байлаа. Ан гөрөө, дууны талаар бол ийм" гэж дурсан яриу.*

Тухайн дууг Данзанравжаа зохиосон гэж үзэх нь бий. Учир нь түүний гар бичмэлүүдэд уг дуу тэмдэглэгдсэн байдаг билээ. Бидний бодоход энэ дуу Гэгээнтнийг төрөхөөс ч өмнө байсан байж болзошгүй. Энэ дууг халхчуудаас гадна өвөр монголчууд өргөн дэлгэр дуулж байна. Дууны үг нь одоогоор гурван хувилбараар олдоод байна.:

Урьхан хонгор салхинд нь

Уулын мод ганхадаг билээ

Уяхан гол шиг хүүтэйгээ

Удам тусмаа дасдаг билээ зээ г.мэтээр дуулдаг билээ.

АШИГЛАСАН НОМ ХЭВЛЭЛ, ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ**Монгол хэл дээр:**

1. А.Амар. “Малын ажлыг сайжруулах зорилтын тухай” илтгэл. УБ., 1926.
2. Ү.Аварзэд, Т.Содной. “Монголын нүүдлийн соёл иргэншил бэлчээрийн мал аж ахуй”, УБ., 2006.
3. Ч.Авдай, М.Төмөржав, Ч.Сонгино, Б.Дорж, Ж.Цэвэгсүрэн, Н.Нацагдорж. “Монголын нүүдэлчдийн үндэсний уламжлалт технологи” (монограф), УБ., 2003.
4. Д.Адъяа. “Монгол ёс заншил ба домнох ёс”, УБ., 2006.
5. Ж.Арилдзэмбэ. “Ухаант амьтан - дэлхий уйлж байна”, УБ., 1997.
6. Ч.Аръяасүрэн, Х.Нямбуу. “Монгол ёс заншлын их тайлбар толь” I, II боть. УБ., 2000, 2001.
7. Н.Бадамжав. “Дэлхийн түүх ба Төв Азийн нүүдэлчдийн оруулсан хувь нэмэр”, УБ., 1998.
8. Баабар (Б.Бат Эрдэнэ). “XX зууны Монгол: Нүүдэл, суудал” УБ., 1996
9. Баабар (Б.Бат Эрдэнэ). “Монголын ирээдүйд хүрэх зам, байгалийн ашигт малтмал”, Өдрийн сонин, УБ., 2013.
10. Баабар (Б.Бат Эрдэнэ). “Шашныг өмөөрөхүй”, Өдрийн сонин. УБ., 2014.
11. Т.Баасансүрэн. “Хүн төрөлхтөний хөгжилд суут хүн Чингис хааны гүйцэтгэсэн үүрэг, түүхэнд түүний эзлэх байр суурь”, Өдрийн сонин. УБ., 2014.
12. Н.Багабанди. “Титэм үг”, УБ., 2012.
13. С.Бадамхатан ба бусад “БНМАУ-ын угсаатны зүй 3 боть зохиолын Мал аж ахуйн түүхтэй холбогдсон хэсгүүд”, УБ., 1987
14. Д.Базаргүр, Б.Чинбат, Н.Шийрэв, С.Адъяа. “БНМАУ-ын малчдын нүүдэл”, УБ., 1989
15. Д.Базаргүр. “Бэлчээрийн мал аж ахуйн газар зүй”. УБ., 1996
16. А.Бакей. “Бэлчээрийн менежментийн зарим асуудал”. УБ., 2013
17. Б.Балжинням. “Монголчуудын бүрэн түүхийн товчоон” (тэргүүн, дэд, гутгаар боть), УБ., 2004

- 18.Ц.Балхаажав, Б.Минжигдорж, Х.Цэвэлээ, О.Шагдарсүрэн, Г.Эрдэнэжав, Х.Чойжилжав нар “Монголын бэлчээрийн мал аж ахуй”. Цуврал бүтээл, УБ., 2008, 2009, 2010
- 19.Д.Балдандорж. “Бурханы шашныг шүтэхийн учир”, УБ., 2013
- 20.Д.Батаа. “МАН эрхэлж ирсэн монголчуудын уламжлалт арга”, УБ., 1998
- 21.А.Батболд. “Монгол угсаатны бага нэвтэрхий толь”, УБ., 1993
- 22.Ж.Бат-Ирээдүй, М.Давхарбаяр, Л.Доржсамбуу нарын “Хүрэн бэлчирийн товчоон”, УБ., 2014
- 23.Д.Батмөнх. “Хоршоо, түүний засаглал”, УБ., 2012
- 24.Ж.Батсуурь. “Монголчуудын өлгий нутаг, гарал үүслийг генетикийн аргаар мөшгисөн нь”, УБ., 1992
- 25.Х.Баттогтох. “Мөнх тэнгэр ба шинжлэх ухаан”, УБ., 2014
- 26.Д.Баяр. “Дундад зууны үеийн монгол хувцас”, ШУА сэтгүүл, #4,1986.
- 27.А.Баярмагнай. “Морин эрдэнийн дуулал”, УБ., 1989
- 28.Н.Баяртсайхан. “Монголын хөдөөгийн хөгжилд хоршооны гүйцэтгэх үүрэг”, УБ., 2000
- 29.Ш.Бираа. “Монголын нэгдсэн төр байгуулагдсан нь”, Монгол судлалын сэтгүүл, № 12 (17,18), УБ.,1999
- 30.Богд Зонхов, “Бодь мөрийн зэрэг”, УБ., 2004
- 31.Ж.Болдбаатар. “Дэлхий дахины соёлын түүхэнд Монголчуудын гүйцэтгэсэн үүрэг”. Эрдэм шинжилгээний хуралд тавьсан илтгэл, УБ., 2002
- 32.Б.Больхорлоо, Д.Чойжил, Д.Батаа, П.Дамдиндорж “Бэлчээрийн мал үржүүлэх арга ухаан”, УБ., 2004
- 33.Д.Буянхишиг. “Монгол тэмээ”, УБ., 2011
- 34.Б.Буянчуулган. “Цахарын мал аж ахуйн тэмдэглэл”, 1934.
- 35.Т.Булган. “Буддын философийн дэвтэр”, УБ., 2010
- 36.В.Бүнчин. “Уналга эдэлгээний малын тоног хэрэгсэл”, УБ., 1978
- 37.Б.Бямбаа. “Дэлхийн мал эмнэлгийн шинжлэх ухааны өнөө ба ирээдүй”, УБ., 2011
- 38.Б.Бямбаа. “Монголын мал эмнэлгийн шинжлэх ухааны одоогийн түвшин, ойрын ирээдүйн үндсэн чиглэлийн тухайд”. УБ., 2011

39. Д.Бямбасүрэн. “Монгол орны оршихын одоогийн төлөв”. УБ., 1997
40. Б.Винтов. “Дэлхийн адуу”, “Монгол адуу”, Эрдэнэт. 2012
41. Валпала Рахула. “Будда чухам юу сургав”, УБ., 2007
42. Т.Гаадамба. “Их хаан ба нүүдлийн соёл иргэншил”, ШУА-ийн сэтгүүл, № 3, УБ., 1992,
43. Т.Гаадамба. “Монголын нууц товчооны нууцаас”, УБ., 1971
44. Т.Галсан. “Төр улсын дор Гэр улс бат оршихуйн нууц”, УБ., 2014
45. Л.Ганбаатар “Хүн төрөлхтөний түүх бол их нүүдлийн түүх мөн”, Ням гариг сонин, №24 (120), 1996
46. Д.Ганбаатар. “Бурханы номын Монгол уншлагын судар”, УБ., 2010
47. Я.Ганболд. “Биотехнологи”. УБ., 2002
48. Г.Гомбо. “Монгол үндэстний хүнс, хоол”, УБ., 2002
49. Гэвш Майкл Роач. “Очироор огтлогч”. УБ., 2014
50. Д.Гончиг. “Үхрийн аж ахуй”. УБ., 1986
51. З.Гончигжав. “Хонины аж ахуй”. УБ., 2000
52. Гэвш Жамба Тинлей. “ Гэгээн гэрэл”. УБ., 2013
53. С.Галданжамц. “Мал маллах арга ухаан”. УБ., 1998
54. М.Ганболд. “Дээрхийн гэгээнтний айлдал, сургаал”. УБ., 2004
55. У.Гонгоржав. “Монголын эртний нүүдэлчин” (НТӨII мянганаас НТӨIII зуун), УБ., 1994.
56. У.Гонгоржав. “Монголчуудын эрдэм ухааны уламжлал”. УБ., 1994
57. Гильом-де-Рубрук. “Дорно этгээдэд зорчсон минь”. УБ., 1988
58. Д.Гонгор. “Халх товчоон”. I, II боть. УБ., 1970, 1978
59. Д.Н.Гумилёв, А.И.Курчкин. “Хар домог”, Москва. 1992, “Евро Азийн түүхээс”, Москва. 2000.
60. Д.Гүн-Үйлс, Н.Дугарсүрэн. “Монгол хаад” түүхэн шастир (II боть). УБ., 2011, 2012.
61. Д.Гүн Үйлс, Н.Дугарсүрэн. “Монголын найман Богд” тэргүүн дэвтэр. УБ., 2012
62. Ш.Даваасүрэн. “Монгол ухааны онол нууц”, ЗГ-ын мэдээ, № 74, 1996
63. Ч.Далай. “Хамаг Монгол улс 1101-1206”. УБ., 1996

64. Ч.Далай. “Юан улс 1260-1388”. УБ., 1992
65. А.Дамдинсүрэн. “Монголчуудын гурван их нээлт”, Үнэн, № 172. УБ., 1990
66. А.Дамдинсүрэн. “Монгол зэвсгийн товч түүх” (НТӨIII зуунаас 1916 он). УБ., 1990
67. Ц. Дамдинсүрэн. “Монголын нууц товчоо”. УБ., 1976
68. Б.Дорж. “Монголын газар тариалангийн үүх түүхээс”. УБ., 1998
69. Б.Дорж. “Малчнаа сануулах сэдэв”, 1936
70. Мө. Даш. “Монгол орны бэлчээрийн мал маллагааны арга туршлага”. УБ., 1966
71. Д.Даваа. “Төрийн билигдэл, төгс шинжит хүлэг”. УБ., 1994
72. Г.Дагва. “Малчин баатруудын хөдөлмөрийн алдраас”
73. XIV Далай лам Данзанжамц. “Бодь мөрийн зэрэг”-ийн 14 өдрийн айлдварын удиртгал хэсгүүд. УБ., 2011
74. XIV Далай лам Данзанжамц. “Сэтгэлийн амирлал”. УБ., 2003,
75. XIV Далай лам Данзанжамц. “Аз жаргалтай амьдрахуйн урлаг” (цуврал дэвтрүүд). УБ., 2007, 2008
76. XIV Далай лам Данзанжамц. “Шинэ мянганы ёс зүй”. УБ., 2011.
77. Ц.Дашзэвэг. “Монголын хоньчдын манлай”. УБ., 2013
78. Н.Жагварал, Р.Индра. “Монгол орноо хөдөө аж ахуйг хөгжүүлэх биологийн нөхцөл”. УБ., 1975
79. Жадо Ринбүүчий, “Бодь мөрийн зэргийн бясалгахуйн хөтөлбөр”. УБ., 2014, 2013
80. Ч.Жазаг. “Тэгээн судар”. УБ., 2010
81. С.Жамбалдорж. “Морин эрдэнэ”. УБ., 1996
82. Л.Жамсран. “Монголын түүхийн дээж бичиг” (III, IV). УБ., 1992
83. Ч.Жүгдэр. “Монголд феодализм тогтох үеийн нийгэм, улс төр, гүн ухааны сэтгэлгээ”. УБ., 1986
84. Р.Индра, С.Цэндсүрэн. “Монголын цагаан идээ исгэх технологийн онцлог”. УБ., 1989
85. Н.Ишжамц. “Монголд нэгдсэн төр байгуулагдсан, феодализм бүрэлдэн тогтсон нь”. УБ., 1974

86. Кэролин Хамфри, Дэвид Смит. “Нүүдэллэхүйн ёсон эцэслэхүй”. УБ., 2006
87. С.В.Киселёв. “Монгол орон эрт цагт”. Москва., 1997.
88. Оуэн Латимор. “Нүүдэлчид ба хувьсгалчид”. УБ., 1994.
89. Г.Лувсанцэрэн. “Буддын гүн ухааны сэтгэлгээ”. УБ сонин, №213,214.
90. Ц.Ломбо, Ц.Баттүвшин, Ц.Болд “Эрдэнийн чулууны ид шид гайхамшиг”. УБ., 2015.
91. Д.Лхаашид “Монголын нийгэм, төрийн аюулгүй байдал, Монгол хүнийг хөгжүүлэх философи”. УБ., 1996.
92. Н.Логи, Э.Алтанцэцэг. “Малчдын хоршоо-Монголын бэлчээрийн мал аж ахуйн тогтвортой хөгжлийн үндсэн нөхцөл”. УБ., 2005.
93. Марко Поло. “Хорвоогийн элдэв сонин”. УБ., 1959.
94. Ч.Мөнхбаяр, Н.Батжаргал. “Сүлд хийморийн Монгол домын гайхамшиг”. УБ., 2004.
95. Монголын Бурхан Шашинтны Нийгэмлэг, “Чойжид дагины тууж”. УБ., 2012
96. Л.Мөнхтөр. “Монгол адууны зүс, шинж заасан үгсийн утга бүтэц”. УБ., 2007 (Докторын зэрэг горилсон бүтээл)
97. Г.Мэнд-Ооёо. “Гэгээнтэн” роман. УБ., 2012.
98. Г.Мэнд-Ооёо. “Монгол бичгээс аялгуу сонсогдож байна гэж гадныхан дуу алдсим ярилцлага, Өнөөдөр сонин. УБ., 2014.
99. Б.Мягмаржав. “Дэлхийн нүүдлийн мал аж ахуй” (I, II дэвтэр). УБ., 2004, 2006
100. А.Мягмарсүрэн. “Оюуны хувьсгал хийх цаг нь болсон”, Сонины ярилцлага. УБ., 2004.
101. Д.Наваан. “Мянган дурсгалын орон”. УБ., 1970.
102. О.Намнандорж. “Монголын хурдан морины тухай”. УБ., 1969.
103. Ц.Насанбалжир. “Монголын мал аж ахуй хөтлөлтийн уламжлалт шинэтгэл” (XIX зууны эцэс XX зууны эхэн). УБ., 1978.
104. Ц.Нацагдорж. “Чингис хааны сургаалын товчоон”. УБ., 2006.
105. Ш.Нацагдорж. “Чингисийн цадиг”. УБ., 1991.
106. А.Осор. “Хоточ нохой”. УБ., 1988.
107. А.Очир. “Монголын Ойрадуудын түүхийн товч”. УБ., 1993.
108. А.Очир, Ж.Сэржээ “Монголчуудын овгийн лавлах”. УБ., 1998.

109. А.Очир. “Монголын түүхийн судлал” I, II, III боть. УБ., 2011.
110. Ц.Өлзийтогтох, Н.Хүрэлбаатар. “Монголын мал эмнэлэг 90 жилд”. УБ., 2013.
111. Д.Ж.Плано Карпини. “Монголчуудын түүх”. УБ., 2004.
112. С.Пүрэвжав. “Монгол дахь шарын шашны хураангуй түүх”. УБ., 1978.
113. С.Пүрэвжав, Д.Дашжамц “БНМАУ-ын сүм хийд, лам нарын асуудлыг шийдвэрлэсэн нь”. УБ., 1965.
114. Х.Пэрлээ. “Монгол түмний гарлыг тамгаар хайж судлах нь”. УБ., 1956.
115. Ц.Пүрэвсүрэн. “Цагаан зүгийн эхэн”. УБ., 2009.
116. Ж.Раднаабазар. “Угийн бичиг”. УБ., 1992.
117. Б.Саарал. “Хурдны шинж бүрдэхүйн учир”. УБ., 2011.
118. Ж.Самбуу. “Ардын нүүдлийн мал аж ахуйг сайжруулан хөгжүүлэх арга маягийн сэдэв”. УБ., 1953.
119. Ж.Самбуу. “Мал аж ахуй дээрээ яаж ажиллах талаар ардад өгөх сануулга сургаал”. УБ., 1945.
120. Ж.Самбуу. “Малчдад өгөх зөвөлгөө”. УБ., 1956.
121. Ж.Самбуу. “Монгол орны бэлчээрийн мал аж ахуйн арга туршлага”. УБ., 1966.
122. Д.Самданжамц. “Монгол адуу”. УБ., 2012.
123. Д.Самданжамц. “Морь уях эрдэм”. УБ., 2014.
124. Д.Самданжамц. “Зуун жилийн айраг, түрүү”. УБ., 2006.
125. Д.Самданжамц. “Манай адуу”. УБ., 2015.
126. Д.Самданжамц. “Монголд үржүүлж буй баталгаажсан үүлдэр омгийн мал”. УБ., 2017.
127. Х.Сампилдэндэв. “Малчин ардын зан үйлийн уламжлал”. УБ., 1985.
128. Т.Содной. “Экологийн шинжлэх ухаан, мал аж ахуй”. УБ., 1981.
129. Т.Содной. “Чингис хааны Гүр улсын мал аж ахуй”. УБ., 2001.
130. Н.Содномдаржаа. “Монгол үндэсний цагаан идээний соёл”. Хөх хот. 1997.
131. Ч.Сонгино. “Таван эрдэнэ танин зүсэлдэг ардын уламжлал”. УБ., 1994.
132. Г.Сүхбаатар. “Монгол Нирун улс”. УБ., 1992.

133. Г.Сүхбаатар. “Монголын сонгодог хэлбэрийн нүүдлийн мал аж ахуй”. УБ., 1989.
134. Д.Сосорбарам, Д.Эрдэнэбаатар “Гамшгийн менежмент”. УБ., 2011.
135. Б.Сэмбээжав. “Малын биологи, аж ахуйн онцлог”. УБ., 2010.
136. Ш.Сүхбат. “Монголчуудын нүүдэллэх соёл”. УБ., 2008.
137. Ж.Тогтох. “Эсгий туургатны түүх”, Дээд, доод дэвтэр, Хөх хот. 1992.
138. То Ван (Тогтохтөр) “Хэбэй вангийн аж төрөхүйг заасан сургаал болой” (Төмөртогоогийн бэлтгэсэн), 1990.
139. М.Төмөржав. “Бэлчээрийн монгол мал”. УБ., 1989.
140. М.Төмөржав. “Малчдын сэтгэл зүй, ёс суртахууны уламжлал”. УБ., 1989.
141. М.Төмөржав. “Малын генетик”. УБ., 1968, 2006
142. М.Төмөржав. “Монголын нүүдэлчид, нүүдлийн мал аж ахуй”. УБ., 1992.
143. М.Төмөржав. “Нүүдэлчин: нүүдэл-иргэншил”. УБ., 1992.
144. М.Төмөржав. “Нүүдэлчин: арга ухаан, нутгийн мал”. УБ., 1993.
145. М.Төмөржав. “Нүүдэлчин: байгаль, хүн, мал гурвын битүү холбоо”. УБ., 1994.
146. М.Төмөржав. “Монголын бэлчээрийн мал аж ахуй (уламжлал, шинэчлэл, эрчимжүүлэлт)”. УБ., 2004.
147. М.Төмөржав. “Баяд хонь: малчин зах зээл”. УБ., 2007.
148. М.Төмөржав. “Монгол малчны мал аж ахуйгаа эрхлэх арга ухаан, түүний уламжлал”. УБ., 1997.
149. М.Төмөржав. “Эрдмийн гайхамшгаас”. УБ., 2009.
150. М.Төмөржав. “Хувь тавилан”. УБ., 2010.
151. М.Төмөржав. “Монголын нүүдэлчдийн буй болгосон нутгийн мал, Төв Азийн байгаль, цаг уур, экологийн нөхцөлд дасан зохицсон байдал”. УБ., 1997.
152. М.Төмөржав. “То Вангийн сургаал ба Монголын нүүдлийн мал аж ахуй”. УБ., 1998.
153. М.Төмөржав. “Мэлмий”. УБ., 2013.
154. М.Төмөржав, Н.Эрдэнэцогт. “Монголын нүүдлийн мал аж ахуй”. УБ., 1999.

155. М.Төмөржав, С.Цэрэндаш, Ч.Гомбосүрэн. “Газар-бэлчээр-мал”. УБ., 2003.
156. М.Төмөржав, С.Оюунгэрэл. “Мал аж ахуйн биотехнологи ба молекулын биологи”. УБ., 2003.
157. Д.Төмөртоогоо. “Монголын эдийн засгийн сэтгэлгээний түүх”. УБ., 2006.
158. Г.Төмөрхадуур. “Монгол малын хувь заяа”. УБ., 2010.
159. Ц.Төрбилиг. “Байгаль орчноо хайрлах Монгол хүний сэтгэл зүйн онцлог”. УБ., 1991.
160. Г.Туваансүрэн, С.Сангидансранжав, Б.Данзаням. “Бэлчээрийн мал аж ахуйн цаг уурын нөхцөл”. УБ., 1996.
161. Л.Түдэв. “Монголоо алдаж болох арван хар нүгэл”. УБ., 1999.
162. Л.Түдэв. “Элгэн садан маань энэхэн хорвоогийн хаана явна вэ?”, Дал сонин, № 168. УБ., 1998.
163. Л.Түдэв. “Далны хуудас”, Дугаар: 10.11 (2000), 13.15 (2001), 26.27 (2004), 29, 30 (2005), 34,36 (2006), 42.44 (2008), УБ.
164. Төвдэн ешэ лам. “Бурханы шашны охь шим”. УБ., 2007.
165. Л.Тэрбиш. “Одон зурхайн дөрвөн хувилбар”. УБ., 1997.
166. Л.Тэрбиш, Л.Баясгалан. “Монгол оронд одон зурхай үүсч хөгжсөн нь”. УБ., 1978.
167. Н.Хавх. “Монголчуудын соёл иргэншлийн гүн ухаан”. УБ., 1995. Хүнс, Хөдөө аж ахуйн Яам, Хүнс ХАА-н салбарын танилцуулга. УБ., 2016.
168. Б.Цэвээн. “Жинчин”. УБ., 1983.
169. Д.Цэвээндорж. “Монголын мал аж ахуйн гарал үүслийн асуудлыг хадны зургаар судлах нь”. УБ., 1992.
170. Д.Цэвээнжав. “Монгол Улсын мал аж ахуйн түүхийн зарим асуудал”. УБ., 1996.
171. Д.Цэгмэд, Д. Даваажанцан. “Морин эрдэнэ”. Өндөрхаан хот. 1994
172. Д.Цэдэнсодном. “Өв соёл”, Соёмбо үсэг”. УБ., 1972.
173. С.Цэрэндаш. “Бэлчээрийн хагд өвс”, Хөдөө аж ахуй сэтгүүл. №1,1981

174. С.Цэрэндаш, Р.Цэрэндулам ба бусад “Монгол орны бэлчээрийн экологи, чанарын үнэлгээ”, Эрдэм шинжилгээ-технологийн төслийн 1999-2000 оны нэгдсэн тайлан. УБ.,2000.
175. С.Цэрэндаш.“Бэлчээр ашиглах онолын үндэс” (тэргүүн дэвтэр). УБ., 2006
176. А.Цанжид. “Улс төрийн шинжлэх ухаан”. УБ., 1999
177. А.Цанжид. “Монгол соёл иргэншил”. УБ., 2005
178. А.Цанжид. “Төрийн захиргаа”. УБ., 2009.
179. А.Цанжид. “Хөгжлийн стратегийн эргэцүүлэл”. УБ., 2008.
180. А.Цанжид. “Монголын нууц товчооны нууцыг мушгих”. УБ., 2016.
181. Г.Чадраабал. “Хүрээ нэгдлээс фермерийн аж ахуй хүртэл”. УБ., 2003.
182. Х.Чойжилжав, Ж.Батаа “Малын өвчнийг анагаах уламжлалт арга”, УБ. 2009.
183. Ш.Чоймаа. “Монгол бичиг”. УБ., 1995.
184. Д.Чойжамц. “Улс үндэстний ёс суртахууны үндэс нь шашин суртал байдаг” ярилцлага. Өдрийн сонин, 2014.
185. Г.Чулуунбаатар. “Нүүдлийн соёл иргэншлийн Монгол хэв шинжийн тогтолцоо ба улс төрийн сэтгэлгээний хөгжил” (НТӨIII - МЭ ХХ зуун II боть). УБ., 1995.
186. Г.Чулуунбаатар. “Нүүдэлчин Монголчуудын бичиг үсгийн соёл”. УБ., 2002.
187. О.Шагдарсүрэн. “Байгалийн шалгарал ба бэлчээрийн мал аж ахуй”. УБ., 1969.
188. О.Шагдарсүрэн. “Монголын бэлчээрийн малын биологи ба нүүдлийн мал аж ахуйн онцлог”. УБ., 2005.
189. Д.Шарав. “Таны эзэн та өөрөө”. УБ., 2010
190. Н.Эрдэнэцогт. “Монголын нүүдлийн мал аж ахуйг эрхлэн хөтлөх арга ухааны биологи, экологи, аж ахуйн үндэс, хөгжлийн зүй тогтол”. УБ., 1996
191. Н.Эрдэнэцогт. “Монголын нүүдлийн аж ахуй”. УБ., 1996
192. Н.Эрдэнэцогт. “Малын зан араншин”. УБ., 2011
193. Н.Эрдэнэцогт. “Монголын бэлчээрийн сонгодог мал аж ахуй”. УБ., 1990

194. Д.Эрэгдэндагва. “Монгол орны чоно”. УБ., 2010
195. Мал эмнэлэг, зоотехникийн албаны түүх, улсын сайн малчдын болон малын эмч, мал зүйчдийн улсын зөвлөгөөний материал. УБ., 1945-2013
196. БНМАУ-ын түүх: тэргүүн, дэд, гутгаар боть. УБ., 1966,1968,1969
197. “Монгол Улсын түүх” 5 боть зохиол. УБ., 2004

Орос хэл дээр:

198. С.Н.Боголюбский. “Происхождение и преобразование домашних животных”. Москва, 1954
199. Б.Большорлоо. “Биология воспроизведения основных видов Монгольских пород”, Автореферат доктор. Дисс., Москва. 1975
200. Б.Я.Владимирцов. “Общественный строй Монголов, Монгольский кочевой феодализм”, Ленинград, 1934
201. Ш.Ганхуяг. “Философское исследование взаимовлияний кочевой и оседлой цивилизации”(на примере Монголии), УБ. 1998
202. В.В.Грайворонский. “От кочевого образа жизни к оседлости” (на опыте МНР), Москва. 1979
203. В.В.Грайворонский. “Современное аратство Монголии” (социальные проблемы переходного периода 1989-1995), Москва. 1997
204. Л.Н.Гумилёв. “В поисках вымышленного царства”, Москва. 1989
205. Л.Н.Гумилёв. “Древняя Русь и великая степь”, Москва. 1989
206. Л.Н.Гумилёв. “Хүннү”. Москва, 1960
207. Н.И.Денисов “Животноводство МНР”. УБ.,1968
208. Д.Дорж, ЭА.Новгородова “Петроглиф Монголии”. УБ., 1975
209. А.А.Дудукалов “Основные мероприятия к развитию и улучшению животноводства в Монголии”. 1926.
210. А.А.Дудукалов “Состояние животноводства МНР”. Москва, 1926
211. Д.М.Еремеев “Кочевники в мировой истории”, Журнал Азия и Африка сегодня, №2. Москва, 1980
212. Н.Жагварал “Аратство и аратское хозяйство”. УБ., 1974.

213. А.Жеврак “Пути и методы интенсификации кочевого животноводства МНР”, Совр. Монголия, № 3. УБ., 1933
214. Р.Индра “Монгольский бактрион”. УБ., 2008
215. С.Лебединский “Очерки природных условий монгольского скотоводства”, Сов. Монголия, № 1. УБ., 1934
216. М.Е.Лобашев “Очерки по истории русского животноводства”. Москва, 1954
217. Я.Я.Лус, Н.Н.Колесник “Домашние животные Монголии”. Москва, 1936
218. Д.Майдар. “Памятники история и культуры Монголии”, Москва. 1976.
219. И.И.Майский. “Современная Монголия”, Иркутск. 1921.
220. И.И.Майский. “Монголия на кануне революции”, Москва. 1959 год.
221. А.П.Окладников. “Петроглифы Монголии”, Ленинград. 1981 год.
222. А.П.Окладников. “Из области духовной культуры Неолитических племен Керулси ритуальные захоронения остатков животных”, Новосибирск. 1978
223. А.М.Позднеев. “Монголия и Монголы”(результаты поездки 1892-1893), Петербург. СССР, 1898.
224. Г.Н.Потанин. “Иутешествие по Монголии”, Москва. 1948
225. Рашид Ад Дин. “Сборник летописей”, Москва. 1960
226. А.Д.Симуков. “Монгольские кочевники”, УБ. 1945
227. Т.Трофимов. “Хангайские кочевья”, Журнал Сов. Монголия, #1,1934
228. “Кочевые скотоводческие хозяйства”, Журнал Сов. Монголия, #2,1934
229. М.Тимуржав. “Сравнительное исследование кожной гистологии и волосяны фолликул монгольского овца”, Москва. 1964
230. М.Тимуржав. “Традиционные виды домашних животных Монголии, их биологические и хозяйственные особенности труда, Стабилизация сельскохозяйственного производства Монголии”, Новосибирск. 1999
231. М.Тимуржав. “Морфологические особенности и доместикационные преобразования кожного покрова овец и коз Монголии”(Докторская диссертация), Москва. 1977
232. Д.Түмэн. “Антропологическая характеристика кочевников ранней средневековой Монголии”. Москва, 1991

233. И.А.Цаценкин, А.А.Юнатов. “Естественные кормовые ресурсы МНР”. Москва, 1961
234. Цэвэл. Я. “Кочевники”, УБ. 1933
235. И.Ф.Шульженко “Мясное хозяйство Монголии”. Москва, 1933
236. И.Ф.Шульженко “Животноводство МНР”. 1954
237. И.Ф.Шульженко, Н.А.Колесник “Домашние животные Монголии”. Москва, 1936
238. Эдуард Тейлор, “Первобытная культура”. Москва, 1939
239. Н.Эрдэнэцогт “Биолого-экономические и хозяйственные основы технологии ведения кочевого животноводства Монголии и закономерности его развития”, Автор. дисс, соис. учен. степи. докторантура биол. наук.
240. А.А.Юнатов “Кормовые растения иастбищ и сенокосов МНР”. Москва, 1954.

Англи хэл дээр:

241. Improvement of nomadic and transhumance animal production Systems. Fao, Аса/Мисс /74/ 3, pp.1-46.
242. A.S. Demiruren. Migratory /Transhumance/ Systems, Chapter 23, World animal Science Amsterdam-Oxford-New-York. 1982.
243. Khouch Kin Yuri. Mongolia. Encyclopedia. Ulaanbaatar-Seoul. 1998.
244. C.Oxby. Pastoral Nomads and Development, International African Institute. 1975.
245. D.L.London. Johnson. The Nature of Nomadism. A Comparative Study of Pastoral Migration in Southern Asia and North Africa. Univ.Chicago. Dept.Georg. 118. 1969.
246. B.Spooner. The Cultural Ecology of Pastoral Nomads. Addison-Wesley Module in Anthropology. 45. 1973.
247. M.I.Western. The Environment and Ecology of Pastoralism and Arid Savannas. Paper read at SSRS. Symposium of Traditional Primitive Societies. Cambridge. 1978.
248. M.I.Abdallah. The Nomadic Pastoral System and its Implications in the Near East. FAK, WCARRD, RNEA Paper 3. 1978.

ХАВСРАЛТ

Хавсралт-1: ШУССТөслийн үндсэн даалгавар

“Цаг уурын өөрчлөлтөд дасан зохицох нүүдэлчдийн уламжлалт мэдлэг” нэртэй суурь судалгааны төсөл хэрэгжүүлэх, санхүүжүүлэх 2012 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн ШУССТ. 2.0.11/33 дугаар гэрээний 1 дүгээр хавсралт

ТӨСЛИЙН ҮР ДҮНГИЙН ДААЛГАВАР
/Техникийн даалгавар/

Д.д	Сэдэвт ажлаар бий болох үр дүн	Тоо хэмжээ	Үр дүнгийн үзүүлэлт	Үр дүнг хүлээлгэн өгөх хугацаа (он, сар)
1	“Цаг уурын өөрчлөлт ба нүүдэлчний арга ухаан” хамтын бүтээл туурвих. Ерөнхий бүтэц: 1. Сүргийн бүтэц, малын тоо толгойг газар нутгийнхаа онцлогт тохируулж ирсэн нүүдэлчдийн уламжлалт мэдлэг 2. Бэлчээрийг хамгаалж, нөхөж сэргээж ирсэн нүүдэлчдийн уламжлалт мэдлэг 3. Дөрвөн улирлын нүүдэл ба отор: уламжлал, шинэчлэл 4. Монгол малчин: одоо ба ирээдүй	25 х.х Нийт 300 ш.	Нүүдэлчдийн цаг уурын өөрчлөлттэй тэмцэж ирсэн уламжлалт аргуудыг судалснаар цаашид Ногоон хөгжлийн чиг баримжаа болох үндэслэлийг боловсруулна. Монгол малчны өмнө одоо тулгарч буй асуудлын талаарх нарийвчилсан судалгаа байна.	2019.12.10 багтааня.
2	Зөвлөмж /Экологийн соёлд суурилсан хөгжлийн бодлогыг годорхойлоход чиглэгдэнэ./	1.5 хх. нийт 100 ш.	3-аас доошгүй бодлогын яам, агентлаг, Ерөнхийлөгчийн тамгын газар, 21 аймагт хүргүүлж, санал авсан байх	2019-8 сар
3	Орон нутагт тулгамдаж буй экологийн өөрчлөлтийн цогц мэдээллээр видео болон аудио бичлэгийн сан бүрдүүлэх	40 орчим цагийн бичлэгээр нэмж баяжуулан бүрэн мэдээллийн санг захиалагчид хүлээлгэн өгөх	Орон нутагт тулгамдаж буй экологийн өөрчлөлтийн цогц мэдээлэл байна. Санг баяжуулж бүрэн мэдээллийн санг захиалагч талд хүлээлгэж өгнө. Үүнд: Дундговь, Говь-Алтай, Дорнод, Архангай аймгийн тус бүр 2 сумын экологийн өөрчлөлт /гол ус, бэлчээрийн ургамлын бүтцэд гарч буй өөрчлөлт, бэлчээр доройтолт, цөлжилтийн түвшин/-ийг малчидтай хамтран бүрдүүлнэ.	2018 оны 12 сар
4	“Монголчуудын мал маллах ухаан:бэлчээрийн даац ба сүргийн бүтэц”-гарын авлага бэлтгэн хэвлүүлж, Дундговь, Говь-Алтай, Дорнод, Архангай аймгийн судалгаа хийсэн сумдын малчдад тараах ажлыг зохион байгуулах	3 хх. нийт 200 ш.	Уг гарын авлага нь хашир туршлагатай малчид болон эрдэмтэн судлаачдын зөвлөгөөнөөс бүрдэх бөгөөд мэдээллийн сангаас авсан бэлчээрийг хамгаалах, нөхөн сэргээх, сүргийн бүтцийг зохицуулах аргачлал бүхий CD дагалдуулна.	2018 оны 8 сар

(85-р зураг)

Хавсралт-2: ШУССТөслийн үр дүнгийн биелэлт

1. Номын зориулалтаар эрдэм шинжилгээний зохих тайлан бичсэн, одоогоорхэвлэгдээгүй.
2. Зөвлөмж. Үүнийг2018.10.28-нд 19/46 албан тоотоор даалгаврын дагуу бичиж, албан байгууллага, аймгууд руу илгээсэн. Хариу санал ирсээр байна.
3. Орон нутагт тулгамдаж буй экологийн өөрчлөлтийн цогц мэдээллийн видео болон аудио бичлэгийн сан бүрдүүлэх ажлын хүрээнд нийт **85**цагийн, 162MEGABIT дуу бичлэг (Audio) цуглуулж CD-гээр дагалдуулав.
4. “Монголчуудын мал маллах эрдэм: бэлчээрийн даац ба сүргийн бүтэц”-гарын авлага бэлтгэсэн. Архангай, Завхан, Говь-Алтай, Дорнод, Сүхбаатар аймагт хээрийн судалгаа, НСИСОУХ-ийн сан хөмрөгт суурин судалгаа гүйцэтгэж, уг гарын авлагыг хэвлэлд бэлтгэсэн.

Хавсралт-3: Боловсруулж тараасан ЗӨВЛӨМЖ



НҮҮДЛИЙН СОЁЛ ИРГЭНШЛИЙГ СУДЛАХ ОЛОН УЛСЫН ХҮРЭЭЛЭН

210620A, Sukhbaatar Square 3,
Ulaanbaatar 11, Mongolia
Tel: (976-11) 329624 Fax: (976-11) 329624
E-mail: nomciv@magicnet.mn
http://www.nomadic.mn

2019.10.27 № 19/46
танай _____-ны № _____-т

Зөвлөмж хүргүүлэх тухай

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ТАМГЫН ГАЗАРТ

Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэнгийн судалгааны баг Монгол улсын БСШУСЯ-ны стратеги болон Монгол улс 2006 онд нэгдэн орсон ЮНЕСКО-ийн "Соёлын илэрхийллийн олон талт байдлыг хамгаалах болон хөхиүлэн дэмжих" (2005) конвенцийн хэрэгжилтийг хангах үүднээс Монгол улсын ШУСс_2017/38 тоот гэрээний санхүүжилтээр "Цаг уурын өөрчлөлтөд дасан зохицох нүүдэлчдийн уламжлалт мэдлэг" нэртэй суурь судалгааны төслийг хэрэгжүүлж байна.

Уг судалгааны үр дүнд "Байгаль экологийн өөрчлөлтөд дасан зохицох асуудалд" сэдэвт Зөвлөмж боловсруулсныг хүргүүлж байна.

ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



А.ОЧИР

(86-р зураг)



Албан тоот хавсралт

Байгаль экологийн өөрчлөлтөд дасан зохицох асуудалд

Монголын нүүдэлчдийн биет бус соёлын өвийн нэг хэсэг нь оюун санаа, сэтгэл зүйгээр байгаль цаг агаартай дасан зохицох уламжлалт мэдлэг юм. Уг мэдлэг нь мухар сүсэг төдий бус монголчуудын олон мянган жил туулсан амьдралын туршлага, шашин соёлын үзэл онолд суурилжээ. Тиймээс энэ төрлийн уламжлалт мэдлэг нь монгол үндэстний олон угсаатны бүлэг тус бүрийн зан үйл, бэлгэдэл, цээрийн ёс, урлагийн өргөн агуулгаар дамжин илэрсээр ирсэн байна. Монголын нүүдэлчдийн энэхүү уламжлалт мэдлэг орчин үед залгамж чанараа алдан бүдгэрч байгаа нь судалгаагаар мэдэгдэв. Үүнийг үндэсний соёлын аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны хүрээнд ард нийтэд сурталчлан таниулах, байгаль экологийн салбарын гадаад, дотоодын хамтарсан ажилд зарчимлан баримтлах, энэ чиглэлийн хууль, дүрэм журамд тодорхой тусгах замаар баталгаажуулах хэрэгцээ байна. Үүнд:

1. Уул хайрхан, гол мөрөн, малын бэлчээр зэрэг байгалийн заяагдмал бүрэн бүтэн тогтоцтой олдмол хэлбэрээр харьцахдаа үндэсний уламжлалт соёлын ёс суртахууныг гол зарчмаа болгох цаг болсныг төрийн дээд түвшинд хүлээн зөвшөөрч албан ёсоор тунхаглах;
2. Монгол хүн болон төлөвшиж буй өсвөр насныханд гэрийн хүмүүжил болон боловсролын системээр дамжуулан цаг уурын өөрчлөлт, байгалийн гэнэтийн үзэгдэлд дасан зохицох уламжлалт соёлын ёс суртахууныг эзэмшүүлэх;
3. Аймаг, сумдын нутагт амьдарч буй ард иргэдээс биет бус соёлын уламжлалт ёс суртахууны өвлөн залгамжлагчдыг тодруулан урамшуулж, тэднийг орон нутгийн ардын мэргэжилтнээр өргөмжлөн баталгаажуулж сургалт, семинарын багшаар ажиллуулах;
4. Ерөнхий арга зүйн сургалт, семинар зохион байгуулж, хамтран ажиллахад бэлэн байна.

Зөвлөмж гаргасан: М.Дорждагва

Гар утас: 88086854

Цахим хаяг: d_tenger@yahoo.com

(87-р зураг)

Хавсралт-4: Зөвлөмжийн хариу хүсэлт
**ДОРНОГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум, 3 дугаар баг,
Нутгийн удирдлагын ордон, Утас: 7052 2533,
Факс: (976) 7052 2530, И-мэйл: zdtg@dornogovi.gov.mn,
Вэбсайт: domogovi.gov.mn

2019.12.12 № *2/457*


танай _____-ны № _____-т

**НҮҮДЛИЙН СОЁЛ ИРГЭНШЛИЙГ СУДЛАХ
ОЛОН УЛСЫН ХҮРЭЭЛЭНГИЙН ДАРГЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ А.ОЧИР
ТАНАА**

Танай байгууллагаас ирүүлсэн “Цаг уурын өөрчлөлтөд дасан зохицох нүүдэлчдийн уламжлалт мэдлэг” суурь судалгааны төслийн үр дүнд гаргасан “Байгаль экологийн өөрчлөлтөд дасан зохицох асуудалд” сэдэвт зөвлөмжийг хүлээн авч танилцлаа.

Зөвлөмжид тусгасан арга хэмжээг бодлогын баримт бичгүүдэд тусган олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, сургалт сурталчилгааг хэрэгжүүлэн ажиллах бөгөөд арга зүйн зөвлөгөө, сургалт, семинарыг танай байгууллагатай хамтран зохион байгуулах хүсэлтэй байна.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ *А.Очир* ЭРДЭНЭЦЭЦЭГ



44 6192690

(88-р зураг)

Хавсралт-5: Улсын төсвөөс санхүүжүүлэн хэрэгжүүлж 2017-2019 онд дуусгасан зардлын зарцуулалт

НХМаягт Т-2

Сангийн сайдын 2017 оны
347 дугаар тушаалын хавср

Мөнгөн урьдчилгааны тайлан

Байгууллагын нэр: Нүүдлийн Соёл Иргэншлийг Судлах ОУХүрээлэн 2019 оны 12 с

Урьдчилгаа авагч: НСИСОУХүрээлэн
 Овог нэр: Гэрээт ажилтан
 Албан тушаал: "Цаг уурын өөрчлөлтөд пасан зохицох нүү дэлчдийн уламжлалт мэдлэг судалгаа
 Судалгааны ажлын нэр: судалгаа
 Судалгааны ажлын төрөл: Суурь судалгаа
 Гэрээний дугаар:

№	Урьдчилгааны зориулалт	Олгосон урьдчилгаа	Гүйцэтгэл	Хянасан		
				дүн	илүү	дутуу
1	Гэрээт ажлын цалин	2 900 000,0	2 823 500,0	-	-	-
2	Томилолт	2 900 000,0	2 900 000,0	-	-	-
3	ЭШЗардал	19 910 000,0	19 986 500,0	-	-	-
4	Орчуулга	3 000 000,0	3 000 000,0	-	-	-
5				-	-	-
6	Төслийн явц, үр дүн 1%	290 000,00	290 000,00	-	-	-
7		-	-	-	-	-
8		-	-	-	-	-
9		-	-	-	-	-
10		-	-	-	-	-
11		-	-	-	-	-
12		-	-	-	-	-
13		-	-	-	-	-
14		-	-	-	-	-
15		-	-	-	-	-
	Дүн	29 000 000,00	29 000 000,00	-	-	-

Тайлан гаргасан:..... /
(гарын үсэг)Үлдэгдэл буюу илүү зарцуулсан дүнгийн талаар гаргасан шийдвэр
.....

Тэмдэг Ерөнхий нягтлан бодогч:..... /

Нягтлан бодогч:..... /
2019 оны 12 сарын 31... өдөр

Хүлээн авсан: /

(89-р зураг)

Хавсралт-6: Малчдаас сурвалжилсан дуу бичлэг-сангийн тоон дүн

БҮС НУТАГ, АЙМАГ	СУМДЫН НЭР, ТОО	ВИДЕО БИЧЛЭГИЙН ХЭМЖЭЭ (ЦАГ, GB-ААР)
Архангай аймаг	1. Батцэнгэл сум 2. Өгий нуур сум 3. Өлзийт сум	Нийт 19 ширхэг, 85 цагийн, 162MEGABIT дуу бичлэг (Audio).
Говь-Алтай аймаг	1. Шарга сум	
Дорнод аймаг	1. Хөлөнбуйр сум	
Сүхбаатар аймаг	1. Түмэнцогт сум	
Нийт 4 аймаг	Нийт 6 сум	

(8-р хүснэгт)

Хавсралт-7: НСИСОУХ-ийн Эрдмийн Зөвлөлийн тайлан эцэслэх ТОГТООЛ



НҮҮДЛИЙН СОЁЛ ИРГЭНШЛИЙГ СУДЛАХ ОЛОН УЛСЫН ХҮРЭЭЛЭНГИЙН ЭРДМИЙН ЗӨВЛӨЛ

2019 оны 12 сарын 23 өдөр

Дугаар 05.

Улаанбаатар хот

Эрдмийн зөвлөлийн хурлын тогтоол

Тус хүрээлэнд хэрэгжсэн “Цаг уурын өөрчлөлтөд дасан зохицох нүүдэлчдийн уламжлалт мэдлэг” ШуСс_2017/38 гэрээ бүхий суурь судалгааны төслийн үр дүнгийн танилцуулга, баталгаажуулалтыг сонсож хэлэлцээд эрдмийн зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Цаг уурын өөрчлөлтөд дасан зохицох нүүдэлчдийн уламжлалт мэдлэг” суурь судалгааны төслийг хүлээж авах нь зүйтэй гэж үзсүгэй.
2. Төслийн тайланг холбогдох байгууллагуудад хүргүүлэхийг эрдмийн зөвлөлийн дарга, орлогч дарга нарт үүрэг болгосугай.

ЭРДМИЙН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА, ПРОФЕССОР

А.ОЧИР

ЭРДМИЙН ЗӨВЛӨЛИЙН ОРЛОГЧ ДАРГА, ДОКТОР

Ц.ЦЭРЭНДОРЖ

(90-зураг)

Хавсралт-8: ШУА-ийн бага чуулганы хурлын ТЭМДЭГЛЭЛ, ШИЙДВЭР**Хурлын тэмдэглэлээс**

ШУА-ийн Нийгмийн ухааны Салбарын Бага Чуулганы хуралдаан 2020 оны 5 дугаар сарын 8-ны өдөр 09:00 цагаас 13:40 цагийн хооронд ШУА-ийн Тэргүүлэгчдийн газрын 3 болон 6 давхрын хурлын танхимд болов.

Хуралдаан гишүүдийн 96 хувийн ирцтэй ажлаа эхлэв. Хуралдаанд оролцох ёстой гишүүдээс ирсэн 27, хөдөө 1, чөлөөтэй 5 байна.

Хуралдааныг салбарын Бага чуулганы дарга, академич Н.Бэгз, салбарын Бага чуулганы эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор Ц.Энхчимэг нар удирдан явуулав.

Хурлын дарга, академич Н.Бэгз хэлэлцэх асуудал, хурлын дэгийг танилцуулж батлуулав.

Хэлэлцсэн нь:

Нийгмийн ухааны салбарт 2017-2019 онд хэрэгжүүлсэн 9 суурь судалгааны төслийн тайлан

Тэмдэглэсэн нь:

Хурлын дэгийн дагуу хэлэлцсэн 9 дэх асуулт: Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэнгээс 2017-2019 онд хэрэгжүүлсэн “Цаг уурын өөрчлөлтөд дасан зохицох нүүдэлчдийн уламжлалт мэдлэг” суурь судалгааны төсөл. Төслийн удирдагч, доктор **Д.Пүрэвжав** төсөл хэрэгжүүлэх явцад мөнх бусыг үзүүлсэн боловч төслийн гүйцэтгэгчид судалгааны ажлаа хийж дуусгажээ. Төслийн үр дүнгийн товч мэдээллийг уг төслийн гүйцэтгэгч, судлаач М.Дорждагва хийв.

Үүний дараагаар тус тайланд экспертийн дүгнэлт хийсэн доктор (Sc.D) Ч.Энхбаатар, доктор С.Цэдэндамба нар дүгнэлтээ танилцуулав. /Дүгнэлтийг хавсаргав/. “Цаг уурын өөрчлөлтөд дасан зохицох нүүдэлчдийн уламжлалт мэдлэг” гэсэн суурь судалгааны ажил нь төслийн зорилгыг бүрэн биелүүлсэн тул тайланг хүлээж авах саналыг хоёр шинжээч дэвшүүлэв.



Шийдвэрлэсэн нь:

Бага чуулганы хоёр итгэмжлэгдсэн шинжээчийн саналыг үндэслэн Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэнгээс 2017-2019 онд хэрэгжүүлсэн “Цаг уурын өөрчлөлтөд дасан зохицох нүүдэлчдийн уламжлалт мэдлэг” суурь судалгааны төсөл нь зорилго, зорилтоо бүрэн ханган биелүүлсэн тул **үг сүүрб судалгааны төслийг захиалагч байгууллагад хүлээлгэн өгөх нь зүйтэй гэж тогтов.**

Үүгээр салбарын Бага чуулганы хуралдаан мөн өдрийн 12:40 цагт ажлаа дуусгалаа.

ДОКТОР, ПРОФ.

ТЭМДЭГДЭЛ ХӨТӨЛСӨН:

Ц.ЭНХЧИМЭГ

(91-зураг)

Хавсралт-9: Бага чуулганы итгэмжлэгдсэн шинжээчдийн САНАЛ, ДҮГНЭЛТ

Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэн

**ЦАГ УУРЫН ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ НҮҮДЭЛЧДИЙН УЛАМЖЛАЛТ
МЭДЛЭГ СУУР СУДАЛГААНЫ ТАЙЛАН 2017 – 2019 он**

I боть /341 тал бүтээлд өгөх санал/

Энэхүү бүтээлийг Д.Пүрэвжавын удирдлагаар М.Дорждагва, Н.Хатанбаатар, Г.Мандах-баяр нар гүйцэтгэжээ.

Бэлчээрийн өнөөх үеийн байдлыг Архангай, Дорнод, Сүхбаатар, Завхан, Говь-Алтай аймгуудад судалгаа явуулж, бэлчээрийн тухай нүүдэлчдийн уламжлалт ойлголтыг бодит байдлаар ул суурьтай гаргаж өгсөн байна.

Бэлчээрийн байдал, малын тоо толгой, бэлчээр ашиглаж буй байдлыг Архангай аймгийн Өгийнуур сумын малчин Н.Жагардамба, Д.Нэргүй, Д.Ганбаатар, Өлзийт сумын П.Анхболд, Батцэнгэл сумын Ц.Доржсүрэн, А.Батболд, Г.Энхбаатар, О.Гансүх, И.Чингэлтэй, Өлзийт сумын Норовсүрэн, Батцэнгэл сумын Л. Золжаргал

Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын малчин Д.Даваа, Д.Энхтуяа, Б.Санчирынхан, П.Батдорж

Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын Ц.Оёо

Завхан аймгийн Ургамал сумын М.Сүхгэрэл

Говь-Алтай аймгийн Шарга сумын З.Дамдиндорж нарын ахмад болон залуу малчдын үйл ажилгаанд судалгаа хийж, бэлчээрийн даац, нүүдэл, нутагшил, зуслан, өвөлжөө, хаваржааны талаар тун нарийн чамбай судалсан нь амжилттай ажил болжээ.

Харин өвөлжөө, хаваржааны сэлгэлтийн талаар Архангай аймгийн Батцэнгэл сумын Н.Чингэлтэйн жишээн дээр авч үзсэн байна. Харин энэхүү бэлчээр сэлгэлт – нүүдлийн талаар Дорнод, Сүхбаатар, Завхан, Говь-Алтай аймгийн малчдын үйл ажиллагаан дээр мөн адил авч үзсэн бол судалгааныхаа үр дүнгээ илүү өргөн цар хүрээтэй болгох боломж байжээ.

Зохиолчид бэлчээрийг хамгаалж, нөхөн сэргээж ирсэн уламжлал хэмээх дэд бүлэгтээ ган, зуд, цасан шуурга, бороо, салхи зэрэг байгаль цаг уурын өөрчлөлтүүд, гамшиг болон хүний хайхрамжгүй үйл ажиллагаанаас үүдэн гардаг түймэрийн тухай ерөнхий ойлголтуудыг тодруулан судалсан байна. Тэдгээр үзэгдлүүдтэй хэрхэн тэмцэх асуудлыг төр засгаас зохион байгуулж буй болон ард иргэд ямар үүрэг хариуцлагатай байх тухай асуудлыг авч үзжээ. Гэвч монголчуудын эдгээр үзэгдэлүүдтэй хэрхэн тэмцэж ирсэнийг эртний түүхэн сурвалжийн мэдээтэй харьцуулан судалбал, ~~бол~~ илүү шинжлэх ухаанч бөгөөд сургамжтай болох байжээ. Тухайлбал, малчдын гал түймэртэй тэмцэж ирсэн нэн чухал түүхэн баримт, ам мэдээ байдаг.

Мал сүргийн усан хангамжийн, хадлан тэжээл бэлтгэх өнөөгийн болон уламжлалт аргыг нэлээд нягт судалжээ.

Харин жишээ болгон говийнханы “худаг хорхолох” зэрэг энгийн боловч сонирхолтой аргуудыг авч үзвэл бүүр ч сургамжтай санагдана.

Ердийн нүүдэл, отор нүүдэл нутагшлыг бүсчлэн авч үзсэн нь зүйтэй юм.

Мал сүргийн ашиг шимийг ашгилах талаар малын 5 төрлөөр нэг бүрчлэн авч үзсэн нь сайшаалтай.

Таван хошуу малнаас адуу, үхэр, тэмээ зэрэг бод малыг эртний хүмүүс хад цохиондоо дүрсэлсэн зураг цөөнгүй байдаг. Хадны зураг нь бичиг үсэг үүсэхээс өмнөх үеийн археологи, түүхийн үнэт сурвалжийн нэг бөгөөд энэ талаар манай археологчидын бичиж тууривсан цөөхөн боловч чамлахааргүй өгүүллэг, бүтээл байдагийг гадаад дотоодын эрдэмтэд анхаарч үздэг билээ.

Увс аймгийн Сагил сумын нутаг “Можоо” гэдэг газрын хаданд зурсан үхэрийн зургийг гол тусгуур хэрэглэгдэхүүн болгон авч бусад баримтуудыг холбон судлаж, үхрийг гаршуулсан асуудлыг авч үзээд улмаар “Монгол орон бол мал аж ахуй бие дааж үүссэн дэлхийн гурван том голомтын нэг” болох тухай археологчидын саналыг Италийн Том, Унгарын Эрдели Иштвал, Монголын Төмөржав зэрэг эрдэмтэд анхаарч үзэж хүлээн зөвшөөрсөн байдаг.

Янгирыг хад цохионоо газар бүрт маш өргөн дэлгэр дүрсэлсэн байдаг авч харин гэрийн ямаанаас ялгахад хэцүү юм. Монголын малчид зөвхөн гэрийн ямаа төдийгүй онцгой нөхцөлд зэрлэг янгирын хээлтэх, үржилтийг шийдэж байсан нэн сонирхолтой баримт байдаг юм (А.Очир).

Энэхүү бүтээлд мал аж ахуй үндсэн нэгж өрх-гэр хот айлын үүсэл хөгжил, болон малчдын одоо ба ирээдүйн тухай олон асуудлыг түүхэн уламжлал, орчин үеийн шинжлэх ухааны үүднээс царатай авч үзсэн байна. Мал сүргийн тухай утга зохиол, урлагийн дүр зэрэг оюуны бүтээлд хэрхэн тусгалаа олсныг ч мөн тодорхой тусгажээ.

Монгол малчдын өвөг дээдэс хүрэл зэвсгийн үед болон Хүннү гүрний үед эсгий хийж, эсгийгээр хувцас, гутал, дэвсгэр зэрэг урлаж ирсэн олдвор хэрэглэгдэхүүн олоод буйг биечлэн үзэж, судалгаандаа ашгилаваас та бүхний бүтээл илүү сонирхолтой, ашиг тустай болох байх.

“Цаг уурын өөрчлөлтөд дасан зохицох нүүдэлчдийн удламжлалт мэдлэг” хэмээх суурь судалгааны ажил нь төслийн зорилгыг бүрэн биелүүлсэн байна. Иймээс тус төслийн ажлыг амжилттай гүйцэтгэсэн гэж үзнэ.

Энэхүү бүтээлийг хэвлэн нийтэлсэн нь эрдэм шинжилгээний төдийгүй малчидын аж ахуйгаа хөтлөн явуулахад зохих ашиг тусаа өгөх нь дамжиггүй.

Монгол улсын Шинжлэх ухааны
Академийн гишүүн

Д. Цэвээндорж



2020.03.28.

**НҮҮДЛИЙН СОЁЛ ИРГЭНШЛИЙГ СУДЛАХ ОЛОН УЛСЫН ХҮРЭЭЛЭНД
ГҮЙЦЭТГЭСЭН “ЦАГ УУРЫН ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ
НҮҮДЭЛЧДИЙН УЛАМЖЛАЛТ МЭДЛЭГ”
СУУРЬ СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮНД ӨГӨХ ШҮҮМЖ**

2020 оны 03 дугаар сарын 25

Улаанбаатар хот

ШУА-ийн Нийгмийн ухааны Бага чуулганы гишүүн доктор, дэд профессор Ц.Цэцэнбилэг Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэнд 2017-2019 онд гүйцэтгэсэн “Цаг уурын өөрчлөлтөд дасан зохицох нүүдэлчдийн уламжлалт мэдлэг” ШУСс 2017/38 дугаартай суурь судалгааны ажлын үр, үр дүнгийн тухай тайлантай танилцаад дараах шүүмж, дүгнэлтийг хийлээ.

Нэг. Суурь судалгааны ерөнхий шинж байдлын талаар:

Энэхүү суурь судалгааг Д.Пүрэвжав удирдаж, Г.Мандахбаяр, М.Дорждагва, Н.Хатанбаатар нар гүйцэтгэсэн байна.

Суурь судалгааны үр дүнг 1 хамтын бүтээл, 1 гарын авлага, 2 эрдэм шинжилгээний өгүүлэл (англи хэл дээр), зөвлөмж, аудио-дуу бичлэгийн сан ээрэгт тусгасан байна.

Суурь судалгааны даалгавар ёсоор: Монгол нүүдэлчдийн байгаль, цаг агаартай дасан зохицох олон мянган жилийн туршлагыг түүхэн сурвалж болон өнөөгийн малчдын аман баримтаас судлан цуглуулж, мэдээллийн нэгдсэн сан хөмрөг бүрдүүлж, дүгнэх зорилго тавьсан байв. Олон шинжлэх ухааны заагт хийгдэх энэхүү суурь судалгааны сэдэв манай орны хувьд өндөр ач холбогдолтой аж.

Төслийн үр дүнгийн даалгаварт “Цаг уурын өөрчлөлт ба нүүдэлчдийн арга ухаан”, сэдэвт 2 хамтын бүтээл туурвих, зөвлөмж, видео болон аудио бичлэгийн сан бүрдүүлэх, “Монголчуудын мал маллах ухаан: бэлчээрийн даац ба сүргийн бүтэц” гарын авлага бэлтгэн хэвлүүлэх байжээ. Суурь судалгааны төслийн удирдагч Д.Пүрэвжав 2018 эхээр зуурдар таалал төгссөн боловч Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэнгийн судлаачдын баг ажлыг эцэслэн гэрээлсэн үр дүнгийн даалгаварыг биеэжүүлжээ.

Хоёр. Судалгааны ажлын үр дүнгийн талаар:

Суурь судалгааны ажлын үр дүн нь ажлын даалгавартай нийцсэн байна. Судалгааны ажлыг 5 аймгийн 7 сумын 25 малчдын дунд явуулж Дундговь, Говь-Алтай, Дорнод, Архангай зэрэг аймгийн экологийн өөрчлөлт (гол ус, бэлчээрийн ургамлын бүтцэд гарч буй өөрчлөлт, бэлчээрийн доройтолт, цөлжилтийн түвшин)-ийн талаарх мэдээллийг цуглуулж үр дүнд нь судалгааны тайлан боловсруулав. Уг судалгааны тайлан номын эх хэрэглэдэхүүний суурь болжээ. Хамтын бүтээл нь дараах бүтэцтэй юм. Үүнд: 1. Сүргийн бүтэц, малын тоо толгойг газар нутгийн онцлогт тохируулж ирсэн нүүдэлчдийн уламжлалт мэдлэг; 2.Бэлчээрийг хамгаалж, нөхөн сэргээж ирсэн нүүдэлчдийн уламжлалт мэдлэг; 3. Дөрвөн улирлын нүүдэл ба отор: Уламжлал, шинэчлэл; 4. Монгол малчин: Одоо ба ирээдүй. Эдгээр хэсгийн товч үр дүнг дараах байдлаар тодорхойлов. Сүргийн бүтэц, малын тоо толгой талаарх ойлголт, зохистой тоо толгойг орчин цагийн монгол малчид 1000-аас дотогш толгой малтай байвал бэлчээрийн даац болон өрхийн амьжиргаанд элбэг хүрэлцээтэй гэв. Малчид эхлээд малын тоо толгойг ихэсгэж хөрөнгөжиж дараа нь багасгадаг нь түгээмэл арга болон тогтжээ. Бэлчээрийн доройтол, ган, зуд нүүрлэхээс хамгаалах хамгийн оновчтой уламжлал нь отор нүүдэл хийх, мал сүргийн бүтэц тоо толгойг тохируулах, байгальтай зүй бусаар харьцахгүй, хүн-байгаль-мал гуравын харилцан шүтэлцээ, тэнцвэрт байдлыг алдагдуулахгүй байхад чиглэсэн сэтгэлзүй, үзэл онол бүхий шашин шүтлэгийн зан үйл байжээ.

Гурав. Судалгааны ажлын үр дүн дэх ололттой, сайн тал:

Нэгд, суурь судалгааны дагаврыг биелүүлж нийгэм, хүмүүнлэгийн ухаан, угсаатан, соёл иргэншил, урлагийн зан үйл судлал зэрэг олон ухааны арга зүй, судалгааны арга зүйг ашигласан;

Хоёрт, түүхэн эх сурвалж, статистик тоо баримт, экологийн зураглал, олон улсын болон манай орны шилдэг туршлагын шинжилгээг хийсэн.

Гуравт, бэлчээрийн доройтол, ган, зуд нүүрлэхээс хамгаалах хүн-байгаль-мал гуравын харилцан шүтэлцээ, тэнцвэрт байдлыг алдагдуулахгүй байхад чиглэсэн сэтгэлзүй, үзэл онол бүхий шашин шүтлэгийн зан үйл байсанг баталж задын дуу, овоо тахилгын дуу, луусын дуу, салхи аргаддаг дуу, уул савдагт өргөх дуу, сүнс аргаддаг сангийн дуу зэрэг дууны төрлийг нарийн гаргасан нь энэ ажлын шинэлэг тал байв.

Дөрөвт, судалгааны багийхан үр дүнгээ зөвлөмж болгон 21 аймаг, МУ Ерөнхийлөгчийн тамгын газар, 3 яаманд албан бичгээр хүргүүлж, малчдад зориулсан

гарын авлага зэргийг хэвлэж олны хүртээл болгохын зэрэгцээ эрдэмтэн судлаачидад хүртээх үүднээс олон улсын сэтгүүлд англи хэлдээр хэвлүүлжээ.

Тавт, суурь судалгааны тайланг стандартын дагуу маш сайн боловсруулсан нь сайшаалтай байна.

Дөрөв. Судалгааны ажлын үр дүн дэх дутагдалтай тал:

Нэгд, Судалгааны өргөн мэдээлэл цуглуулсан боловч түүний боловсруулалт, шинжилгээ арай дутмаг байна.

Гэвч дээр дурдсан дутагдалтай тал нь энэхүү суурь судалгааны ажлын шинжлэх ухааны ач холбогдол, судалгаа шинжилгээний ажлыг явуулсан арга зүйг няцаах үндэслэл болохгүй болно.

Тав. Судалгааны ажлын үр дүнгийн талаарх дүгнэлт:

1. Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэнд гүйцэтгэсэн “Цаг уурын өөрчлөлтөд дасан зохицох нүүдэлчдийн уламжлалт мэдлэг” суурь судалгааны ажлын үр дүнг хүлээн авч Нийгмийн ухааны Бага чуулганаар хэлэлцэх боломжтой гэж үзэж байна.

Шинжээч:

Доктор

/Ц.Цэцэнбилэг/